

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



ТОЙМ АГУУЛГА

- ◇ Эдийн засгийн бодлого
- ◇ Нийгмийн бодлого
- ◇ Эрх зүй, төрийн байгуулал

“Судалгааны эмхэтгэл” (XXIII боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Норовдондог (PhD)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Сугарсүрэн

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 1.1 Үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйлдвэрлэлийн суурь зардлын үнэ тарифын зохицуулалт болон гадаадын зарим орны туршлага 6
*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа,
Ч.Онончимэг, Д.Халиун*
- 1.2 Гадаадын зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хангах тогтолцоо 71
Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл
- 1.3 Арьс ширний үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримталж буй бодлого, гадаадын зарим орны туршлага 92
*Ц.Болормаа, Ч.Онончимэг,
Д.Халиун, Д.Саулегүл*
- 1.4 Газар өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, дундын өмчлөлийн газартай холбогдох эрх зүйн зохицуулалт, бусад орны туршлага 149
*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа,
Ч.Онончимэг, Д.Халиун*
- 1.5 Монгол улсын газрын нэгдмэл сан ба газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл лавлагаа 164
Ч.Онончимэг, Д.Халиун
- 1.6 Ногдол ашиг хуваарилалтын онол, арга зүйн асуудлаарх лавлагаа мэдээлэл 178
Г.Алтан-Оч (PhD)
- 1.7 Монгол улсын хууль тогтоомжоор журамлан зохицуулахаар заасан бизнес-эдийн засгийн харилцааг зохицуулж буй хуульчилсан актуудын талаарх лавлагаа мэдээлэл 185
*Ч.Онончимэг, Д.Халиун, Б.Нандингэрэл
Т.Саулегүл, И.Жаргалзаяабямба*

II БҮЛЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

- 2.1 Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөр, төлбөр тогтоох үндэслэл, сургалтын дэмжлэгийн талаарх Монгол Улсын болон гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт 219
*Ө.Мөнхтунгалаг, Б.Нандингэрэл,
О.Нарантуяа, И.Жаргалзаяабямба*

2.2	Монгол Улсын төрөх болон хүүхдийн эмнэлгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, олон улсын жишиг	247
	<i>И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, О.Нарантуяа,</i>	
2.3	“Мүүн”-ий талаарх ойлголт, гадаадын улс орнуудын хандлага	269
	<i>Д.Жигваагүнсэл, Д.Онончимэг, Д.Халиун</i>	

III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

3.1	Олон нийтэд төрийн бодлого шийдвэрийг хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцоо, гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт	282
	<i>Ө.Мөнхтунгалаг, Б.Нандингэрэл, Т.Саулегүл, И.Жаргалзаяабямба</i>	
3.2	Парламентын судалгааны албанаас гүйцэтгэсэн судалгааны бүтээгдэхүүнийг хэвлэн нийтлүүлэх, олон нийтэд түгээдэг эсэх талаарх гадаадын зарим орны туршлага	298
	<i>Г.Алтан-Оч (PhD), А.Пагма, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, Т.Саулегүл</i>	
3.3	Дэлхийн зарим орны парламентын сонгуулийн тов тогтоодог хугацааны талаарх мэдээлэл лавлагаа	306
	<i>Б.Нандингэрэл, О.Нарантуяа</i>	
3.4	Парламентын хуралдааны дэгийг хэрхэн тогтоодог талаарх бусад орнуудын туршлага	310
	<i>Ч.Онончимэг Д.Халиун</i>	
3.5	Парламентын гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, түүний зохион байгуулалтын талаарх бусад орнуудын туршлага	317
	<i>Ц.Норовдондог (PhD), Ч.Онончимэг Ц.Болормаа Д.Халиун</i>	
3.6	Парламентын хуралдааны үйл ажиллагааг телевиз, радиогоор нэвтрүүлдэг эсэх талаарх бусад орнуудын туршлага	337
	<i>А.Пагма, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Т.Саулегүл</i>	

1

БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУУРЬ
ЗАРДЛЫН ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ
ОРНЫ ТУРШЛАГА**

*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа
Ч.Онончимэг, Д.Халиун*

АГУУЛГА

- НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУУРЬ ЗАРДЛЫН ҮНЭ ТАРИФЫН
ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 1.1 Үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд төрөөс хэрэгжүүлж
буй бодлого
- 1.2 Монгол Улсын үйлдвэрлэлийн суурь зардлын үнэ
тарифын зохицуулалт, өнөөгийн байдал ба 2010-2015
оны статистик мэдээлэл
- ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУУРЬ ЗАРДЛЫН
ҮНЭ ТАРИФЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО,
СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ
- 2.1 БНХАУ
- 2.2 БНСУ
- 2.3 БНЭУ
- 2.4 Тайвань Улс
- ХАВСРАЛТ-1 Үйлдвэрлэлийн дэмжих хүрээнд Улсын Их Хурал,
Засгийн газраас баталсан бодлогын баримт бичиг,
хөтөлбөрийн жагсаалт
- ХАВСРАЛТ-2 Монгол Улсын дулаан, цахилгаан эрчим хүчний үнэ
тарифын 2010-2015 оны статистик мэдээлэл
- ХАВСРАЛТ-3 Монгол Улсын шатахууны жижиглэнгийн үнэ болон
үйлдвэр, аж ахуйн нэгжийн усны үнэ тарифын талаарх
статистик мэдээлэл
- ХАВСРАЛТ-4 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Усны нөөц
ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх
тухай” 326 дугаар тогтоол

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлдвэрлэлд ашиглагдаж буй цахилгаан, дулаан, ус, ус бохирдуулсны төлбөр, уур, шатахуун зэрэг суурь зардлуудын нэр төрөл, үнэ өртөг, сүүлийн жилүүдийн өөрчлөлт, цаашдын хандлага, үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд эдгээр суурь үнийг хэрхэн тогтоодог талаар судаллаа. Тайланд Эрчим хүчний зохицуулах хороо, Газрын тосны газар, Ус сувгийн удирдах газар зэрэг төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, Эрчим хүчний хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах төслийн тайлан, БНХАУ, БНСУ, БНЭУ, Тайвань зэрэг орнуудын үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд суурь зардлуудын үнэ тарифын талаар баримталж буй бодлого, статистик мэдээллийг ашигласан болно.

Судалгааны хураангуй:

Нэгдүгээр бүлэг: Судалгааны нэгдүгээр бүлэгт Монгол Улсын үйлдвэрлэлийн суурь зардалд хамаарах цахилгаан, дулаан, ус, ус бохирдуулсны төлбөр, түлшний үнэ тариф, тэдгээрийн сүүлийн жилүүдийн өөрчлөлт болон үнэ тариф тогтоох зарчим, үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн талаар судалсан болно.

Нэгдүгээр бүлгийг *үйлдвэрлэлийн салбарт төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн талаар болон мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн статистик мэдээлэлд үндэслэсэн үйлдвэрлэлийн суурь зардлын үнийн судалгаа* гэсэн хоёр хэсэгт авч үзэв.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсын үйлдвэрлэлийн суурь зардалд хамаарах цахилгаан эрчим хүч, ус зэргийг бусад оронтой харьцуулахад харьцангуй хямд зардалтай байна.

Тухайлбал, Монгол Улсын үйлдвэр, ААН-ийн цахилгаан эрчим хүчний үнэ 1кВц нь 6.64 цент байх ба дэлхийн хэмжээнд цахилгааны эрчим хүч хамгийн бага гэгддэг БНХАУ, Энэтхэг улсад тус тус 8 цент, БНХАУ-ын хойд бүсэд 10.7 цент, Тайваньд 1кВц нь 9 цент, БНСУ хувьд 1кВц нь хэрэглээний хүчин чадлаасаа хамааран 7.9-13.45 цент байгаагаас үзэхэд судалгаанд хамрагдсан орнуудаас манай улсын цахилгаан эрчим хүчний үнэ 1.36-6.81 центээр бага байна. Үйлдвэрлэлийн салбар дахь цахилгааны үнэ Дани улсад хамгийн үнэтэй буюу 1кВц нь 41 цент байна.

Түүнчлэн, цэвэр ус ашигласны болон бохир ус зайлуулах үйлчилгээний үндсэн тариф, ус бохирдуулсны суурь хураамж нь судалгаанд хамруулсан бусад оронтой харьцуулахад харьцангуй бага үнэтэй болох нь харагдаж байна. Тухайлбал, Монгол Улсад үйлдвэрлэлийн салбарт цэвэр ус ашигласны төлбөр нь 1м³ нь 950-1250 төгрөг байгаа бол БНХАУ-д үйлдвэрлэлийн салбарт ашиглаж буй ус нь 1м³ нь 1500-3050 төгрөгийн хооронд, Энэтхэг улсын үйлдвэрлэлийн салбар дахь усны үнэ 1 килолитр тутамд (1000л) 4000 төг, тэр дундаа усанд суурилсан үйлдвэрлэлийн усны үнэ 1 килолитр тутамд 8000 төгрөг буюу 4 USD-тэй тэнцэж байгаа юм.

УСУГ-аас ирүүлсэн статистик мэдээллийг үзэхэд үйлдвэрлэлийн салбар дахь цэвэр ус түгээх үйлчилгээний үнэ 2012-2015 оны хооронд үйлдвэрлэлийн салбараасаа шалтгаалан 4.2-4.4%-ийн өсөлттэй байгаа дүн гарсан байна.

Мөн Монгол Улсад үйлдвэрлэлийн салбар дахь усны үнэ болон бохир ус зайлуулах үйлчилгээний үнэ тарифыг тогтоохдоо:

- Спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга;
- Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр гэж ангилан ялгавартайгаар тогтоож байна.

Түүнчлэн, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг гүний болон гадаргын аль эх үүсвэрээс ашигласнаас шалтгаалан харилцан адилгүй байгааг схемлэн үзүүлсэн болно.

Шатахууны хувьд манай улс нь импортоос хараат байдалтай байх бөгөөд шатахууны үнийг төрөөс тогтоох боломжгүй байдаг. Зах зээлийн зарчмаар тогтоогдох шатахууны үнэд хилийн үнийн өсөлт, импортын татвар, төгрөгийн ам.доллартай харьцах ханш зэрэг олон зүйлс нөлөөлдөг. Гэсэн хэдий ч төрийн зүгээс шатахууны үнийг тогтворжуулах, шатахуун импортлогч аж ахуйн нэгжтэй зөвшилцөх замаар сүүлийн жилүүдэд шатахууны жижиглэнгийн үнийг буулгах арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Шатахууны үнийн өөрчлөлтийг авч үзвэл А-80 шатахууны хувьд 2012 онд литр нь 1480 төгрөг байсан бол 2014-2015 онд 1550 төгрөг буюу 4.5 хувиар, АИ-92 шатахууны хувьд 2012 онд 1570 төгрөг байсан бол 2015 онд 1660 төгрөг буюу 5.4 хувиар, ДТ 2012 онд 1700 төгрөг байсан бол 2015 онд 1790 төгрөг буюу 5.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Түүнчлэн нарны, салхин болон усны эх үүсвэр бүхий сэргээгдэх эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдал, нөөц хийгээд цаашдын чиг хандлагын талаар товч судалсан болно.

Хоёрдугаар бүлэг: Судалгааны хоёрдугаар бүлэгт БНХАУ, БНСУ, БНЭУ, Тайвань зэрэг орнуудад үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд цахилгаан эрчим хүч, дулаан, ус, байгалийн хий, шатахуун зэрэг суурь зардлуудын үнэ тарифыг тогтооход баримталж буй төрийн бодлого, статистик мэдээлэл, цаашдын чиг хандлагын талаар харьцуулан судлав.

БНХАУ-ын хувьд: суурь хэрэглэгдэхүүний үнэ тариф (цахилгаан, байгалийн хий, ус зэрэг)-ыг Засгийн газраас баримталж буй бодлогод тулгуурлан муж, хэрэглэгчийн ангилал тус бүрээр Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны (ҮХШХ) Үнийн хэлтсээс тогтоодог байна.

2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлсэн үнийн шинэчилсэн бодлого нь Шеньжень хотоос эхлэн 2015 онд 1 кв.ц нь 0.1435 юань /2014 онд 0.1558 юань/, 2017 онд 0.1433 юань, 2018 онд 0.1428 юань байхаар тогтоосон байна. Энэхүү тогтолцоогоо улс орон даяар нэвтрүүлэхээс өмнө Өвөр Монголд туршилтын журмаар нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Шинэчилсэн бодлогын хүрээнд цахилгаан дамжуулах болон түгээх тариф, айл өрхийн цахилгааны тарифаас бусад цахилгаан үйлдвэрлэх болон жижиглэнгийн үнийг чөлөөлөх юм.

Хятадад цахилгаан эрчим хүчний компаниудад 25%-ийн ААНОАТ ногдуулдаг бөгөөд баруун Хятадын нутаг дэвсгэрт байрлах усан цахилгаан станц, атомын цахилгаан станц болон шинэ эрчим хүчний цахилгаан станц барих, үйл ажиллагаа явуулах зэрэгт дээрх татварыг 15% болгон хөнгөлжээ.

Хятадын усны үнэ тарифын хувьд холбогдох хууль тогтоомжид зардлаа нөхөх хэмжээнд байна гэж заасан байдаг ч маш хямд байсаар ирсэн бөгөөд Хятадын усны салбарыг төр засгийн татаасаас ихээхэн хамааралтай болгож байна. Хот суурингийн өрхийн усны үнэ тариф 2001-2007 оны хооронд огцом өссөн бол түүнээс хойш харьцангуй тогтмол буюу 1 м³-д 3 юань, үүнээс 0.81 юань бохир усны төлбөрт тооцогдож байгаа нь олон улсын түвшний зөвхөн 20%-тай тэнцэж, өрхийн орлогын 1 хувиас бага байгаа нь усны ядууралд тооцогдох 5%-иас хамаагүй бага үзүүлэлт юм. Хот суурин газруудын хувьд усны тарифыг өсөн нэмэгдүүлж ирсэн бөгөөд үнэ тарифын хэмжээний хувьд айл өрх, ААН, үйлчилгээний салбар, үйлдвэрлэлийн салбар, аялал жуулчлал гэх дарааллаар нэмэгддэг бөгөөд айл өрхийн тариф нь хамгийн өндөр тарифынхаа 25%-тай тэнцэж байна.

Сүүлийн жилүүдэд усны үнэ тарифыг шат дараатайгаар нэмж байгаа бөгөөд цаашид мөн нэмэх төлөвтэй байна. 2012-2014 онд боловсруулсан баримт бичгүүдэд усны нөөц ашигласны төлбөрийг нэмэхээр тусгасан бөгөөд гүний болон гадаргуйн усны хувьд ялгаатай тариф тогтоох, гүний усыг хэмнэх зэрэг бодлогууд тусгагдсан байна. Түүнчлэн, Хойд бүс зэрэг усны хомсдолтой бүсэд усны тарифыг өндөр тогтоохоор шийдвэрлэсэн байна. /Бээжингийн гадаргуйн болон гүний усны тарифыг 1 м³-д 1.6, 4 юань болгон тус тус нэмсэн бол ядуу болон усны нөөц ихтэй бүсүүдэд 1 м³-д 0.1-0.2 юань байна./

БНСУ-ЫН ХУВЬД: Эцсийн хэрэглэгчид хүрэх цахилгааны үнэ 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд: суурь үнэ ба хөдөлмөрийн үнэ (хэрэглээний хэмжээнд суурилсан). Эрчим хүчний зардлыг KOREC баталж өгдөг бол түлшний зардал нь дэлхийн зах зээлийн үнээс хамааран 2 сар тутам автоматаар өөрчлөгдөж байдаг.

Цахилгааны үнэ нь хэрэглээ ба суурь үнээс бүрдэнэ. Суурь үнэ нь эрчим хүчний хангамжийн хэрэглээний бүлэг болон хүчдэлийн түвшин, улирлаас хамаардаг. 300 кВт хүртэл хүчин чадалтай хэрэглэгчийн ажлын үнэ 4.4 цент/кВтц (шилжилтийн улирал) буюу 7.9 цент/кВтц (зун) байдаг. 300 кВт-аас илүү хэрэглэгчийн хувьд 3.6 цент/кВтц (зун болон шилжилтийн улирал, оргил бус үе)-13.45 цент/кВтц (зуны оргил үе) хооронд байдаг. Холбосон хүчин чадал болон хүчдэлийн түвшнээс хамааран суурь үнэ нь 4.9-6.7 евро/кВт хооронд байна.

Татварын хувьд Солонгосын засгийн газар нь эрдэм шинжилгээ ажил, эрчим хүч хэмнэлтийн арга аргачлал, сэргээгдэх эрчим хүчний дэмжлэгийн тариф болон салбарын бусад бодлогыг санхүүжүүлэхийн тулд "EPDIF" хэмээх нэмэлт төлбөрийг бий болгосон. Энэ нь бүх хэрэглэгч цахилгааны үнийн дүнгийн 3.7%-тай тэнцэх нэмэлт төлбөрийг төлдөг. Хөнгөлөлт чөлөөлөлт байхгүй. НӨАТ-ийн хэмжээ нь цахилгааны тарифын 10%-тай тэнцэнэ. Мөн хөнгөлөлт чөлөөлөлт үгүй.

Энэтхэг Улсын хувьд: Цахилгаан, эрчим хүч болон ус, ус бохирдуулсны төлбөрийг төрөөс тогтооно. Ингэхдээ үйлдвэрлэлийн салбар дахь цахилгаан эрчим хүчний үнэ нь үйлчилгээний салбарын эрчим хүчний үнэ тарифаас бага байх бөгөөд үйлдвэрлэлийн салбар дотроо ХАА-н үйлдвэрлэл хамгийн бага үнэ тарифтай байна. ХАА-н үйлдвэрлэлийн үнэ тарифаас түгээгч компаниудад учирч буй алдагдлыг ХАА-н салбарын цахилгаан

эрчим хүчинд татаас өгөх замаар бууруулж байна. Түүнчлэн нарны эрчим хүчинд Энэтхэгийн засгийн газраас их хэмжээний татаас олгож буй бөгөөд тус хөтөлбөр нь 2018 он хүртэл хэрэгжих бөгөөд ингэснээр цаашид үнийг тогтвортой байлгах боломж бүрдэж байна.

Тус улсын эрчим хүчний салбар дахь цаашдын чиг хандлагын хувьд сэргээгдэх эрчим хүчний үнийг хямд, тогтвортой барих бөгөөд импортын нүүрснээс нийлүүлж буй эрчим хүчийг шат дараатайгаар нэмэх хандлагатай байна.

Усны үнэ тарифын хувьд үйлдвэрлэлийн салбар дахь усны үнэ нь хэрэглээ болон нутаг дэвсгэрээс шалтгаалан харилцан адилгүй байна. Тухайлбал, үйлдвэрлэлийн салбар дахь ус нь 1 килолитр тутам 50-120 рупи байх бөгөөд үүн дээр ус дамжуулах хоолой ашигласны 35 хувийн татвар төлж байгаатай харьцуулахад Монгол Улс дахь үйлдвэрлэлийн салбарын усны үйлчилгээний үнэ хямд байгаа нь харагдана.

Түүнчлэн, усанд суурилсан аж үйлдвэрийн хувьд 1 килолитр буюу 1000 литр нь 200-240 рупи байгаа нь төгрөгт шилжүүлбэл 8000 төгрөг бөгөөд 35%-ийн нэмэлт татвар төлнө. Үйлдвэрлэлийн салбар дахь усны хэрэглээний цаашдын чиг хандлагад Энэтхэгийн усны салбарынхан шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд 2014 онд Үндэсний Усны Бодлогыг шинэчлэн баталснаар цаашид усыг дахин ашиглах чиглэлд түлхүү ажиллаж байна.

Мөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжих бодлогын хүрээнд олон тооны татаасын болон хөнгөлөлтийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- *Тээврийн татаасын хөтөлбөр:* Уулархаг, орж гарахад төвөгтэй газар нутгууд дахь үйлдвэр, аж ахуйн нэгжийн тээврийн зардалд татаас өгөх замаар газарзүйн хувьд илүү сайн нөхцөлтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг ижил төрлийн үйлдвэрүүдтэй өрсөлдөхүйц болгоход чиглэсэн. Татаасын хувь хэмжээ нь үйлдвэрийн газар болон нэрлэсэн төмөр замын өртөө хооронд түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн зардлын 50%-90%-ийн хооронд байна.
- *Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын татаасын хөтөлбөр:* Үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын 30%-д татаас олгох бөгөөд шинээр үйлдвэр байгуулах болон биетээр өргөтгөл хийхэд шаардагдах хөрөнгө оруулалтад хамаарах ба татаасын дээд хэмжээ нь аж үйлдвэрийн салбарт 30 сая, үйлчилгээний салбарт 15 сая рупи байна.
- *Үндсэн хүүгийн татаасын хөтөлбөр:* Үндсэн хөрөнгийн зээлийн 3%-д хүүгийн татаас олгодог бөгөөд тухайн аж ахуйн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ эхэлснээс хойш 10 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.
- *Бүх талын даатгалын хөтөлбөр:* ААН-ийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ эхэлснээс хойших 10 хүртэлх жилийн хугацаанд даатгалын нөхөн олговрыг 100 хувь төлөх хөтөлбөр.

Тайвань улсын хувьд: Тайвань нь эрчим хүчний нөөцгүйн улмаас эрчим хүчний хувьд импортоос шууд хамааралтай байдаг. 2008 оны

байдлаар эрчим хүчнийхээ 99.23%-ийг импортоор авч байгаа нь тус арлыг эрчим хүчнийг гадаад орчноос шууд хамааралтай болгож байна.

Эрчим хүч үйлдвэрлэх өртөг нь 7.0 цент/кВ байгаа бөгөөд үүний 1.9 цент/кВ нь цөмийн эрчим хүч, 5.8 цент/кВ нь нүүрс, 11.25 цент/кВ нь байгалийн хий эзэлж байна. Эдийн Засгийн Яамнаас цахилгаан эрчим хүчний үнийг бууруулах төлөвлөгөөг баталсан бөгөөд 2015 оны 4-р сарын 1-нээс эхлэн цахилгааны дундаж үнийг айл өрхийн хувьд 7.55 хувь, үйлдвэрлэлийн хувьд 7.31 хувь, аж ахуйн нэгжийн хувьд 7,36 хувиар тус тус бууруулсан байна.

Шинэ үнэ нь дунджаар 1кВт тутамд 2.8852 тайвань доллар (0.09 ам.доллар) болсон нь өмнөх 3.1139 тайвань доллар (0.10 ам.доллар)-аас 7.34%-аар буурсан байна. Сард 330 кВт.ц болон түүнээс доош жижиг аж ахуйн нэгжүүд хөнгөлөлт эдлэх боломжтой бол 1501 кВт.ц дээш хэрэглээтэй үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хөнгөлөлт эдэлдэггүй байна.

Судалгаанаас үзэхэд манай улсын үйлдвэрлэлийн салбарт ашиглаж буй цахилгаан эрчим хүч, ус болон ус бохирдуулсаны төлбөр, байгалийн хий, шатахуун зэрэг суурь зардлуудын үнэ тарифын хувьд судалгаанд хамрагдсан орнуудтай харьцуулахад хамгийн бага өртөгтэй байна.

/Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны үндсэн тайлангийн хэсгээс үзнэ үү/

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУУРЬ ЗАРДЛЫН ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн” гэж тодорхойлсон байдаг. Үүний дагуу эдийн засгийн аюулгүй байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан, үнэлгээ хийсэн бөгөөд Хүснэгт 1-д эдийн засгийн аюулгүй байдлын босгын шаардлагыг хангаагүй зарим үзүүлэлтийг харууллаа. Үүнээс үзэхэд:

1. Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх жин 21.2%-34.4% байгаа нь 60%-аас доошгүй байх босгын шаардлагыг хангахгүй байна.
2. Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин 30%-аас бага байх ёстой боловч 90% орчим байгаа нь манай улс гадаад улсын түүхий эдийн нийлүүлэгч, хавсарга эдийн засгийн бүтэцтэй болсныг илтгэж байна.
3. ДНБ-д импортын эзлэх жин 30%-аас бага байхаас хэтэрч байсан бөгөөд 2011 онд 77.1% байсан бол 2015 онд 32.8% болж буурчээ. Энэ хэмжээгээр манай улсын эдийн засагт гадаад орны нөлөө буурч буй боловч хараат байдал хэвээр байна.
4. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин 100% байх босгонд хүрэхгүй, нийт хэрэглээнд дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх жин 2011-2015 онд 93%-аас 77% болж буурсан үзүүлэлт гарсан байна.

Эдгээрээс эхний 2 шалгуур үзүүлэлт нь “аюултай” гэж үзэх түвшинд байгааг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүд

№	Шалгуур үзүүлэлт	Босго утга	2011	2013	2014	2015
1	Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрийн эзлэх жин [%]	60	31.2	34.4	23.0	21.2
2	Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин [%]	30	89.2	81.9	88.5	91.1
3	ДНБ-д импортын эзлэх жин [%]	30	77.1	55.3	45.2	32.8
4	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин [%]	100	93.4	78.3	77.4	77.5

Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн дээрх хүснэгтэд манай улсын үндэсний үйлдвэрлэлийн түвшин, хөрөнгө оруулалт, цаашид үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх төрийн бодлого, үйлдвэрлэл эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, бараа бүтээгдэхүүний чанар, үнэ өртөг гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн зүгээс гол тулгарч буй бэрхшээлийг “бараа бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлдөг үйлдвэрлэлийн суурь зардал манай улсад нэлээд өндөр байна” гэж үздэг.

Иймээс судалгааны энэ бүлэгт үйлдвэрлэлийн суурь зардалд тооцох цахилгаан, дулаан, ус, уур, ус бохирдуулсны төлбөр, шатахууны үнийг манай улсын хувьд хэрхэн зохицуулж байгааг судлан үзлээ.

1.1 Үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого

Улсын Их Хурал, Засгийн газраас үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд бодлогын баримт бичгийг шат дараатайгаар батлан, авч хэрэгжүүлсээр ирсэн.

Монгол Улсад өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах “*Үйлдвэрлэлийг дэмжих тухай*” хуулийг Улсын Их Хурлаас 2015 оны 7 сарын 9-ний өдөр батлан, хэрэгжүүлж байна. Энэ хуулиар төрөөс үйлдвэрлэлийг дараах хэлбэрээр дэмжихээр зохицуулсан. Үүнд:

1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох;
2. Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон, нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгох;
3. Экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжих.

Түүнчлэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлээс мэдлэг, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэн, бүтээмжийг дээшлүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн цогц зорилтыг тодорхойлон, 2015-2030 он хүртэл гурван үе шаттайгаар авч хэрэгжүүлэх “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг УИХ-ын 2016 оны 62 дугаар тогтоолоор баталсан.

Ийнхүү үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд тусгайлан зохицуулсан хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичиг батлан хэрэгжүүлэхээс гадна татварын бодлогоор /зарим нэр төрлийн үйлдвэрлэл, экспортонд гаргах бараа бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх, хөнгөлөх гэх мэт/, үйлдвэрлэлийн суурь зардал болох цахилгаан, дулаан, ус зэргийн үнэ тарифыг төрөөс тогтоох зэргээр бусад хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Тухайлбал, Эрчим хүчний салбар нь бүхэлдээ улсын мэдэлд байдаг олон орнуудын нэгэн адил Монгол Улсад цахилгаан, дулааны үнэ тарифыг удаан хугацаанд төрөөс тогтоосоор ирсэн.

Цахилгаан эрчим хүчний салбарын үнэ тарифыг 2001 онд батлагдсан “Эрчим хүчний тухай” хуулийн “Үнэ тариф” гэсэн 4-р бүлэгт “тарифыг цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх болон хангах үйл ажиллагаа тус бүрээр нарийвчлан тогтоох” бөгөөд Эрчим хүчний Зохицуулах Газар (ЭХЗГ) үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

“Сэргээгдэх эрчим хүчний тухай” хуулийг 2007 онд батлан, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчээс нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг дамжуулагч нь ЭХЗХ-оос дор дурьдсан үнэ тарифын хязгаарын хүрээнд худалдахаар зохицуулсан байна. Үүнд:

1. салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.08-0.095 ам. доллар;
2. 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам. доллар;
3. нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.15-0.18 ам. доллар.

Харин бие даасан үүсгүүрээр үйлдвэрлэн нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь дараах хязгаарын хүрээнд тогтооно:

1. салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.10-0.15 ам. доллар;
2. 500 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.08-0.10 ам. доллар;
3. 501-2000 кВт хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.05-0.06 ам.доллар;
4. 2001-5000 кВт хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.05 ам.доллар;
5. нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.2-0.3 ам.доллар.

Хуульд заасан үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгохоор уг хуулиар зохицуулсан байна.

Улсын Их Хурал болон Засгийн газраас үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд баталсан бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Хавсралт 1-т хавсаргасан болно.

1.2 Монгол Улсын үйлдвэрлэлийн суурь зардлын үнэ тарифын зохицуулалт, өнөөгийн байдал ба 2010-2015 оны статистик мэдээлэл

Судалгаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс хамаарах хувьсах зардал болох (үйлдвэрлэлийн суурь зардал) дулаан, уур, цахилгаан, ус, ус бохирдуулсны төлбөр, шатахууны үнэ тарифын өөрчлөлтийг 2010-2015 оны статистик мэдээллийг ашиглан харьцуулан судлав.

Эрчим хүч- Цахилгаан, дулаан, уур:

Эрчим хүчний тогтвортой хөгжлийг хангах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах таатай орчин бий болгоход зах зээлийн зарчимд нийцсэн үнэ тарифын зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Эрчим хүчний салбар нь бусад салбарт тэр бүр байдаггүй ярвигтай асуудлын нэг нь эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт байдаг.

Харилцан адилгүй хэрэглээний горимтой төрөл бүрийн хэрэглэгчдийн ангилал байдаг тул үнэ тарифын тогтолцоо нь зөвхөн кВтц болон Гкал-аар илэрхийлсэн нэгдсэн нэг үнэ тогтоох боломжгүй юм.

Өнөөгийн байдлаар манай улс хөрш орнуудаас нийт 14 чиглэлээр 10-220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч импортолж байгаа ба үүнээс үндсэн гол хэрэглээг Төвийн Эрчим Хүчний Систем болон Баруун Бүсийн Эрчим Хүчний Систем ОХУ-аас, Оюутолгой компани БНХАУ-аас авч байна.

Эрчим хүч, дулааны тарифыг ЭХЗХ-ны 2011 оны 188 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”-ын дагуу тогтоох бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчилсэн байдлаар /төвийн бүс, баруун бүс, зүүн бүс, Алтай–Улиастайн нэгдсэн сүлжээ/ харилцан адилгүйгээр тогтоодог байна.

Түүнчлэн эрчим хүчний үнэ тарифыг тогтоохдоо олон улсын стандарт, зарчмыг баримтлахаас гадна хэрэглэгчдийн ангилал, зэрэглэл, цахилгаан, дулааны үүсгүүр зэргээс хамааран хэд хэдэн ангилал, төрлөөр үнэ тарифыг тогтоодог байна.

Манай улсын хувьд цахилгаан, дулааны үнэ тариф тогтоох зарчмуудыг 2001 онд батлагдсан “Эрчим хүчний тухай” Монгол Улсын хуулиар хуульчилсан. Үүнд:

1. Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;
2. Цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн зэрэглэл тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;
3. Эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;

4. Үнийн тогтвортой байдлыг хангах;
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхийг хэвийн байлгахуйц хэмжээнд байх;
6. Цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн байх зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагаанд нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;
7. Өртөг нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх бөгөөд зардлын бүтцэд ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардалд бодогдох элэгдэл, хорогдлыг оруулахгүй байх зарчимтай.

Цахилгаан эрчим хүч, дулааны үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ тарифын өөрчлөлт тус бүрээр авч үзвэл:

- Цахилгаан

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 5542 сая. кВт.ц болж өнгөрсөн оны мөн үеэс 2.8%-аар өссөн бөгөөд нийт үйлдвэрлэсэн цахилгааны 96.1%-ийг дулааны цахилгаан станцаар, 1.1%-ийг усан цахилгаан станцаар, 2.8%-ийг нар, салхины эх үүсвэрээр, 0.1%-ийг дизель станцаар тус тус үйлдвэрлэсэн байна.

Төвийн бүсийн хувьд 2015 онд 5377.9 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, 4425.5 сая.кВт.ц цахилгааныг түгээсэн нь өмнөх онтой харьцуулахад 0.4%-аар,

Баруун бүсийн хувьд 143.1 сая кВт.ц болж өмнөх оноос 1.4%-аар буурсан ба нийт хэрэглээний 22%-ийг Дөргөний УЦС үйлдвэрлэж, 78%-ийг ОХУ болон БНХАУ-аас цахилгаан импортолж хангасан байна.

Зүүн бүсийн хувьд цахилгааны хэрэглээ 2015 онд 6.8 сая.кВт.ц буюу 3.8 хувиар өссөн байна. Дорнодын дулааны цахилгаан станц нь 2015 онд 185 сая кВт.ц цахилгаан түгээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 өссөн байна.

Алтай Улиастайн бүсийн хувьд цахилгааны хэрэглээ 2015 онд 63.3 кВт.ц болж өмнөх онохоос 0.4 хувиар буурсан бол уг системийн нийт хэрэглээнийхээ 49 хувийг сэргээгдэх эх үүсгүүрүүд, дизель станц болон Тайширын УЦС үйлдвэрлэж 51 хувийг ТЭХС болон ББЭХС-ээс худалдан авсан байна.

Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын хувьд Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр болон бусад үйлдвэр аж ахуйн нэгж, айл өрх гэсэн ангилалаар, энгийн болон 3 тарифт тоолуураар гэсэн ялгамжтай байдлаар тогтоодог байна.

2010 онд Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр болон бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагын энгийн тоолуурт цахилгааны тариф кВт.ц 79.80 төгрөг байсан бол 2011 оноос Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийн цахилгааны энгийн тарифыг 100 төгрөг, бусад үйлдвэр аж ахуйн нэгж 88 төгрөг болгон ялгамжтай тогтоож эхэлсэн байна.

Харин 2015 оны байдлаар Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийн цахилгааны энгийн тарифыг 155.90 төгрөг, бусад үйлдвэр

аж ахуйн нэгж 128.50 төгрөг болж 2010 онтой харьцуулахад уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийн цахилгааны тариф 49 хувиар, бусад үйлдвэр аж ахуйн нэгжийн тариф 38 хувиар нэмэгдсэн байна.


Мөн түүнчлэн үйлдвэр аж ахуйн нэгжид борлуулж байгаа цахилгааны 3 тарифт тоолуурын хувьд өдөр /06.00 цагаас 17.00/, оройн /17.00 цагаас 22.00/, шөнө /22.00 цагаас 0.00/ гэсэн хэрэглээнээс хамаарсан өөр өөр ялгамжтай үнийн тарифыг тогтоодог.

Хавсралт 2-т Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр болон бусад үйлдвэр аж ахуйн нэгжид борлуулах цахилгааны тарифыг энгийн болон 3 тарифт тоолуураар ялгамжтай тогтоосонг дэлгэрэнгүй хүснэгтээр хавсаргав.


Монгол Улсын цахилгааны 2015 оны үнэ тарифыг бусад орнуудын цахилгааны тарифтай харьцууланг Зурагт харуулсан бөгөөд манай улсын үйлдвэр аж ахуйн нэгжийн хувьд айл өрхийн хэрэглэгчээс илүү өртгөөр, харин нийт цахилгааны үнэ тарифын хувьд харьцангуй бага өртөгтэй байна.

ЭХЗХ-ноос гаргасан Гадаадын зарим орны хэрэглэгчдийн цахилгааны үнийн харьцуулалт 2015 он /цент/кВт.ц /¹

а. Азийн зарим орнуудын хэрэглэгчид




б. Өндөр хөгжилтэй зарим орнуудын хэрэглэгчид



¹ 1 ам.долларыг 1995.51 төгрөгөөр тооцов

в. Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн нийгэмлэгийн гишүүн орнуудын хэрэглэгчид



• Дулаан, уур


Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл 2015 онд 7747.7 мян.Гкал байгаа нь өмнөх оны мөн үеэс 426.мян.Гкал буюу 5.8%-аар өссөн байна. Төвийн бүсийн хувьд дулааны үйлдвэрлэл 7041.3 мян.Гкал болж 4.1%-аар өссөн байна.

Үнэ тарифын хувьд бүсчилсэн байдлаар үйлдвэр, аж ахуйн нэгжид борлуулах болон айл өрхөд борлуулах тариф гэсэн ангилалаар гаргана.

Үйлдвэр, аж ахуйн нэгжид борлуулах дулааны тарифид Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт, хэмжүүрээр тооцох дулаан, технологийн халуун ус, салхилуулга, албан байгууллагын ХХУ халаасан дулаан, буцаагүй конденсат, уур зэргийн үнэ тариф хамаарна. *Үйлдвэр аж ахуйн нэгжид борлуулах төвийн бүсийн дулааны тарифыг Хавсралт 2-оос үзнэ үү.*

Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт м3 нь 2002-2004 онд 170 төгрөг байсан бол 2005 онд 203 төгрөг, 2009-2013 онд 303 төгрөг болж 2014 онд 330 төгрөг, 2015 оны 6 сараас 429 төгрөг болж өссөн байна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжид борлуулж буй дулааны тариф
/2002-2015 он/



Усны болон ус бохирдуулсны төлбөр:

Усны тухай хууль заасны дагуу усны хэрэглээг зориулалтаар нь **“Ус ашиглагч”** буюу ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг; **“Ус хэрэглэгч”** буюу ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгч гэж хоёр ангилж байна. Ус хэрэглэгчид нь усны **үйлчилгээний** төлбөр, ус ашиглагчид нь усны **нөөц ашигласны** төлбөр төлдөг.

Усны нөөц ашигласны төлбөрийг дараах тогтоолуудыг үндэслэн ногдуулж байна. Үүнд: Байгаль орчны Сайдын 1995 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах ус хэрэглээний түр норм”-ыг үндэслэн тухайн байгууллагын хоногийн усны хэрэглээг тооцож,

- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 302 дугаар тогтоол;
- 2013 оны “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар тогтоол;
- 2013 оны “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг өөрчлөн батлах тухай” 327 дугаар тогтоол зэрэг болно.

Тухайн ногдуулсан төлбөрийг Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны нөөцийн төлбөрийг аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлдэг. Төвлөрсөн төлбөрийн орлогын 55 хувийг “Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу ус рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, талаар тусгагдсан зорилт, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан улсын төсвөөс нэгдсэн журмаар зарцуулна.

Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг үйлдвэрийн салбар болон усны нөөцийн эх үүсвэрээс хамааран ялгаатай тогтоож байна. Гадаргын усны хувьд ихэвчлэн 10 хувь байгаа бол газрын доорх усны хувьд 10-20 хувьтэй тэнцэж байна.

- Усны үйлчилгээний үнэ тариф тогтоох зарчим

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуульд заасны дагуу Монгол Улсын усны үйлчилгээний тарифын тогтолцоог шинэчлэн, үнэ тарифын талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, усны үйлчилгээний үнэ тариф тооцох аргачлал боловсруулах, батлуулах зэрэг чиг үүргийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ. Усны үйлчилгээний үнэ тарифыг тооцохдоо “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн **10.2-т заасан дараах зарчмуудыг баримтална. Үүнд:**

- цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, зөөвөрлөн түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;
 - тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон байх;
 - тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;
 - “Өрсөлдөөний тухай хууль”-ийн 5 дугаар зүйл, 6.1-д заасны дагуу үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах.
- Ус бохирдуулсны төлбөр

Усны тухай хуульд заасны дагуу “ус бохирдуулагч” буюу ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, хаягдал ус гаргаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус бохирдуулсны төлбөр, хаягдал усны стандартаас хэтэрсэн агууламж бүхий ус зайлуулсан, хаясан тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөр төлөх юм. Төлбөрийн орлогыг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэн, усыг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна.

2012 оны “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуульд заасны дагуу дараах хаягдал усанд ус бохирдуулсны төлбөр ногдуулна:

- хаягдал усны стандартад нийцүүлэн зөвшөөрсөн хязгаарын дотор байгальд шууд нийлүүлж байгаа хаягдал ус;
- ариутгах татуургад нийлүүлэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх

дээд агууламжийн стандартад нийцүүлэн ариутгах татуургад нийлүүлж байгаа хаягдал ус.

Ус бохирдуулсны төлбөр тооцох үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно:

- хоногт 50 шоо метрээс их хаягдал ус гаргадаг, эсхүл аюултай бохирдуулах бодис гаргадаг ус бохирдуулагчийн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг килограммаар;
- хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгж, хүн амын ахуйн хэрэглээнээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр үнэлэн килограммаар;
- хаягдал усан дахь аюултай бохирдуулах бодисын хэмжээг граммаар;
- хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горимыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

Төлбөрийн хэмжээг дараах хязгаарт багтаан тогтооно:

Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/	
		доод	дээд
Жинлэгдэх бодис	килограмм	100	500
Органик бодис	килограмм	100	500
Эрдэс бодис	килограмм	50	200
Хүнд металл	килограмм	1000	5000
Аюултай бохирдуулах бодис	грамм	1000	5000

- Усны үнэ тариф

Судалгааны ажилд зориулан УСУГ-аас ирүүлсэн үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагын усны үнэ тариф, түүний төрөлтэй холбоотой нарийвчилсан статистик мэдээллээс үзэхэд усны үнийг:

1. Цэвэр усны;
2. Бохир усны;
3. Зөөврийн цэвэр ус түгээхийн;
4. Зөөврөөр бохир ус зайлуулахын.

Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын усны үйлчилгээний суурь хураамжийн тариф гэж үйлчилгээний төрлөөр нь ангилан үнэ тариф тогтоодог байна. Түүнчлэн цэвэр, бохир ус болон зөөврөөр цэвэр ус түгээх, зөөврөөр бохир ус зайлуулах үйлчилгээний үнэ тарифыг:

- Улаанбаатар хот
- Налайх дүүрэг
- Багануур дүүрэг

Төв аймаг гэж бүсчлэн ялгавартай тогтоосноос гадна тоолууртай болон тоолуургүй тариф нь мөн харилцан адилгүй байна. Үүнээс Улаанбаатар хот дахь үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр бохир усны тарифыг үйлдвэрлэлийн төрлөөс шалтгаалан хэрхэн тогтоосныг авч үзье.

**Улаанбаатар хот дахь үйлдвэр аж ахуйн нэгжийн байгууллагаас авах
усны тариф (төгрөг/ шоо метр) НӨАТ-гүй**

	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф (нөат-гүй)
ЦЭВЭР УС	Үйлдвэр ААН, Албан газар	1м3 (1000литр)	950
	Үүнээс: Спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	1м3 (1000литр)	1250
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	1м3 (1000литр)	950
БОХИР УС	Үйлдвэр ААН, Албан газар	1м3 (1000литр)	750
	Үүнээс: Спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	1м3 (1000литр)	960
	Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	1м3 (1000литр)	1500

Эх сурвалж: УСУГ-ын газраас ирүүлсэн 2015 оны тоон мэдээлэл

Хүснэгтээс үзэхэд цэвэр усны хэрэглээний үнэ спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалгын салбарт 1м3 нь 1250 төгрөг байхад ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэрүүдэд 950 төгрөг байгаа нь үнийн уян хатан бодлогын илэрхийлэл болохоос гадна судалгаанд хамруулсан бусад орны үйлдвэрлэлийн усны үнэ тарифтай харьцуулахад харьцангуй хямд байна.

Тухайлбал, БНХАУ-д үйлдвэрлэлийн салбарт ашиглаж буй ус нь 1м3 нь 1500-3050 төгрөгний хооронд байгаа бол Энэтхэг улсын үйлдвэрлэлийн салбар дахь усны үнэ 1 килолитр тутамд (1000л) 4000 төг, тэр дундаа усанд суурилсан үйлдвэрлэлийн усны үнэ 1 килолитр тутамд 8000 төгрөг буюу 4 USD-тэй тэнцэж байгаа юм.

Түүнчлэн, бохир усны үнэ нь спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалгын салбарт 1м3 нь 960 төгрөг байхад ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэрүүдэд 1м3 нь 1500 төгрөг байгаа нь үйлдвэрлэлийн процессийн явцад үүсч буй усны бохирдлын хэмжээнээс шалтгаалан үнэ тогтоож байгаа хандлага ажиглагдаж байна.

Харин Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн хувьд цэвэр, бохир усны үнэ тарифаас гадна зөөврийн цэвэр ус түгээх, зөөврийн бохир ус зайлуулах үйлчилгээний төрөл нэмэгдэх бөгөөд зөөврийн усны үнийг цэвэр болон бохир уснаас шалтгаалан тодорхой км-ээр үечлэн тогтоосон байна. Тухайлбал, зөөврөөр цэвэр усыг түгээх үйлчилгээг км-ээс шалтгаалан 7 үечлэлтэй тариф гаргасан бол, зөөврөөр бохир ус татан зайлуулах үйлчилгээг км-ээс шалтгаалан 5 үечлэл бүхий тариф тогтоосныг Хавсралт 4-өөс нарийвчлан үзнэ үү.

Налайх, Багануур дүүрэг, Төв аймгийн хувьд цэвэр, бохир болон зөөврийн усны үнэ дараах байдалтай байна. Үүнд:

**Налайх, Багануур дүүрэг болон Төв аймаг дахь Үйлдвэр
ААН-ийн усны хэрэглээний үнэ тариф
(төгрөг/шоо метр) НӨАТ-гүй**

	Цэвэр ус		Бохир ус		Зөвөрийн цэвэр ус	Зөвөрийн бохир ус
	тоолууртай	тоолуургүй	тоолууртай	тоолуургүй		
Налайх	1670	1800	1200	1300	1200	1000
Багануур	1150	1200	1150	1200	4410	-
Төв аймаг	2280	2280	1183	1183	-	450

Харин үйлдвэр, ААН, байгууллагын усны үйлчилгээний суурь хураамжийн хувьд тоолуур суурилагдсан усны оролтын шугамын голчийн өргөнөөс хамааран 15 шатлал бүхий үнэ байх бөгөөд энэ нь Улаанбаатар хот болон Налайх, Багануур дүүрэг, Төв аймагт харилцан адилгүй байна. Тухайлбал, 15 мм-ийн голчтой шугамд Улаанбаатарт-4400 төг байхад, Налайх, Багануур, Төв аймагт-3600 төг, 20 мм-ийн голчтой шугамд Улаанбаатарт-6000 төг байхад Налайх, Багануур, Төв аймагт-4960 төг гэсээр 400мм болон түүнээс дээш өргөнтэй шугамын голчоос Улаанбаатар, Налайх, Багануур, Төв аймагт адилхан 384.000 төгрөгний суурь хураамж авдаг байна.

Мөн УСУГ-аас ирүүлсэн 1985 оны 01-р сарын 01-ээс 2015 оны 09-р сарын 01-ыг хүртэлх усны үнийн судалгаанаас үзэхэд Үйлдвэр аж ахуйн байгууллага түүн дотроо “Спирт, архи пиво, ундаа, усны” болон “Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр”-ийн цэвэр ус ашиглалтын үнийн статистикийг 2012 оноос, бохир ус татан зайлуулах үйлчилгээний үнийг 2014 оноос тус тус гаргасан бөгөөд өсөлтийн хувь хэмжээг доор хүснэгтээр үзүүлье.

**Үйлдвэрлэлийн салбар дахь усны үнэ тарифын өөрчлөлт, өсөлтийн
хувь хэмжээ (төгрөг/тонн) НӨАТ-гүй**

	Цэвэр			Өсөлт		Бохир		Өсөлт	
	2012	2014	2015	төг	хувь	2014	2015	төг	хувь
САПУУ*	554.55	1200	1250	50	4.2%	800	960	160	20%
ННАШӨГБ**	554.55	910	950	40	4.4%	1500	1500	0	0

*-Спирт, архи пиво, ундаа, усны үйлдвэр

**- Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр

Шатахуун:

Манай улсын хувьд шатахууны импортоос хараат байдалтай байх бөгөөд шатахууны үнийг төрөөс тогтоох боломжгүй байдаг. Зах зээлийн зарчмаар тогтоогдох шатахууны үнэд хилийн үнийн өсөлт, импортын татвар, төгрөгийн ам.доллартай харьцах ханш зэрэг олон зүйлс нөлөөлдөг.


Засгийн газраас шатахууны импортын татваруудыг өөрчлөх замаар дотоодын борлуулалтын үнийг тогтворжуулах арга хэмжээг авч ирсэн хэдий ч, хилийн үнэ, валютын ханшийн огцом өсөлтөөс шалтгаалан 2012 оны 1 дүгээр сард шатахууны үнэ литр тутамдаа 220-280 төгрөгөөр нэмэгдэж байсан.

2012 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж буй “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд шатахуун импортлогч аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгон зарим татваруудаас чөлөөлөх, ханшийн эрсдэлийг бууруулах зэрэг арга хэмжээ авч, үнийг тогтворжуулан, шатахууны нөөцийг нэмэгдүүлэх зэргээр арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Засгийн газрын 2015 оны 18 дугаар тогтоолоор алслагдсан бүс нутгаас бусад төвийн бүсээр импортлогдож буй шатахууны онцгой албан татварыг тонн тутамд 252,000-265,000 төгрөг байхаар тогтоосон. Мөн Засгийн газрын 2015 оны 65 дугаар тогтоолоор шатахууны гаалийн татварыг 5 хувь болгож нэмэгдүүлсэн. Улмаар Засгийн газрын 2015 оны 438 дугаар тогтоолоор шатахууны онцгой албан татварыг Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг боомтуудаар автобензид тонн тутамд 400,000 төгрөг, дизель түлшинд 520,000 төгрөг, Эрэнцав боомтоор автобензид 270,000 төгрөг, дизель түлшинд 290,000 төгрөг байхаар тус тус нэмэгдүүлсэн. Гэсэн хэдий ч “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан зөвлөл” дээр хэлэлцэн шатахууны хангалт болон жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах, улмаар үнийг бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн билээ².

2015 оны 12 дугаар сараас шатахууны жижиглэнгийн үнийг Баруун бүсэд 80-400 төгрөгөөр, зүүн бүсэд 10-230 төгрөгөөр тус тус бууруулснаар баруун болон зүүн хязгаар нутгийн үнэ төвийн бүсийн үнийн түвшинд ирээд байна.

Шатахууны үнийн өсөлт
2012-1015 оноор



А-80 шатахууны хувьд 2012 онд литр нь 1480 төгрөг байсан бол 2014-2015 онд 1550 төгрөг буюу 4.5 хувиар, АИ-92 шатахууны хувьд 2012 онд 1570 төгрөг байсан бол 2015 онд 1660 төгрөг буюу 5.4 хувиар, ДТ 2012 онд 1700 төгрөг байсан бол 2015 онд 1790 төгрөг буюу 5.0 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Дараах хүснэгтээр 2012-2015 оны шатахуун /А-80, АИ-92, ДТ/-ын үнийг сар бүрийн өөрчлөлтөөр авч үзвэл:

² <http://www.mm.gov.mn>

Шатахууны үнэ /2012-2015 он/

Сар	2012 он			2013 он			2014 он			2015 он		
	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т
1	1500	1800	1850	1580	1620	1750	1530	1620	1750	1550	1660	1790
2	1430	1730	1780	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
3	1430	1680	1780	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
4	1430	1570	1700	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
5	1480	1570	1700	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
6	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
7	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
8	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
9	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
10	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
11	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
12	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790

Эх сурвалж: Газрын тосны газар

Сэргээгдэх эрчим хүч:

- Салхины эрчим хүчний нөөц

Манай орны нийт нутаг дэвсгэрийн 160 000 км² талбай нь салхины эрчим хүчийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нөөцтэй гэж тогтоогдсон.

Салхины эрчим хүчний нөөц сайтай бүс нутаг нийт нутаг дэвсгэрийн (1,565,000 км²) 10 хувийг эзэлж байна.


Салхины эрчим хүчний нөөц сайтай бүс нутагт нэг км/кв талбайгаас хамгийн багаар тооцоход 7 мегаватт (МВт) эрчим хүч үйлдвэрлэх боломжтой. Үүнийг салхин станцын суурилуулсан хүчин чадлаар илэрхийлбэл 1,100,000 гаруй МВт ба жилд 2.5 триллион киловатт/цаг (кВт/ц) эрчим хүч үйлдвэрлэх боломжтой гэсэн үг юм.

Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Төв нь “Монголын Салхины Эрчим Хүчний Нөөцийн Газрын Зураг”-ийг Америкийн Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Лаборатортой хамтран 2011 онд гаргасан бөгөөд Монголын салхины эрчим хүчний нөөцийг 2,550 тераВатт хэмээн тогтоосон. Монголын салхины эрчим хүч нь дангаараа Хятадын өнөөгийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангаж чадахуйц хэмжээтэй.³

Манай орны зүүн, өмнөд болон баруун өмнөд хэсэгт нар, салхины эрчим хүчийг ашиглах асар их нөөц байгааг харгалзан томоохон хүчин чадалтай салхин парк, нарны цахилгаан станцуудыг энэ бүс нутагт байгуулах саналыг төрийн бодлогын хэмжээнд авч үзвэл Төв азийн бүс нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад чухал алхам болно.

³ <http://energy.gov.mn/c/68>

Салхины эрчим хүчний нөөцийн зураг




- Нарны эрчим хүчний нөөц

Манай улсын нэг км² талбайд харгалзах нарны нийлбэр цацрагийн хэмжээ жилд 1200-1600 кВт*ц/м² хүрдэг ба нийт нутгийн хэмжээгээр жилд ирэх нийлбэр цацрагийн хэмжээ 2.2*10¹² МВт-аар үнэлэгдэж байна.

Монгол орны нарны эрчмийн нөөц

МОНГОЛ ОРНЫ НАРНЫ ЭРЧМИЙН НӨӨЦ



Нарны гийгүүлэх хугацаа Монгол орны төв, хойд хэсэгт жилд 2600 цагаас багагүй бөгөөд нэг км² талбайд харгалзах нарны эрчмийн хэмжээ өдөрт 4.5 кВтц/м².

Харин манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг хамарсан говь, тал хээр, цөлийн бүсэд нарны гийгүүлэх хугацаа 2900-3000 цаг бөгөөд нэг ам метр нэгж талбайд харгалзах нарны эрчмийн хэмжээ өдөрт 5.5-6.0 кВтц/м² байна.

- Усны эрчим хүчний нөөц⁴

Сэргээгдэх эрчим хүчний дундаас уснаас гарган авах эрчим хүч нь хямд өртөгтэй учраас хамгийн өргөн хэрэглэгддэг. Цаг уурын өөрчлөлт, байгаль орчны бохирдол, түлш шатахууны үнийн өсөлт зэрэг тулгамдаж буй асуудал нь сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэх, хэрэглэх шаардлага бий болоод байгааг харуулж байна.

Судлаачдын⁵ үзэж байгаагаар дэлхий нийт 40500 тэрбум кВтц усны эрчим хүчний нөөцтэй бөгөөд харин усан цахилгаан станцуудын нийт суурилагдсан хүчин чадал нь 800 мянган мВт бөгөөд жилдээ 2,7 тэрбум кВтц цахилгаан үйлдвэрлэдэг байна. Дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээнийхээ 20 хувийг, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс, 92 хувийг усан цахилгаан станцаас хангадаг гэсэн статистик мэдээ бий.

Манай улсын хувьд том, жижиг нийт 3800 гаруй гол мөрөн байдаг бөгөөд тэдгээрийн эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашиглах нөөц нь 6417.7 мВт буюу жилдээ 56.2 тэрбум кВтц цахилгаан гаргах нөөцтэй гэж үнэлэгдсэн байдаг.

Одоогоор усан цахилгаан станцаар жилдээ 75 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай болоод байгаа нь дээр дурдсан нийт нөөцийн зөвхөн 1 орчим хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын усны эрчим хүчний бүх нөөцийн ойролцоогоор 70% нь баруун бүсэд Ховд гол, төвийн бүсэд Сэлэнгэ мөрөн болон бүх цутгал голууд, зүүн бүсэд Онон, Хэрлэн голуудаас бүрддэг.

Дээр дурдсан усны эрчим хүчний нөөцийн хувьд Сэлэнгэ мөрөн бол манай орны усны эрчим хүчний баялаг нөөцтэй хамгийн том гол юм. Дэлгэрмөрөн, Чулуут, Идэр голын бэлчрээс эхлэн Сэлэнгэ мөрөн хэмээн нэрлэгдэнэ. Сэлэнгэ мөрөнд Хойд мөсөн далайн ай савд хамаарагдах Монгол орны томоохон голууд болох Эг, Орхон, Хараа, Ерөө голууд цутгана. Сэлэнгэ мөрөн 425245км² ус хурах талбайтай үүнээс 282154.1км² буюу 66 хувь нь Монголын нутагт оршино. Сэлэнгэ мөрөн Монгол Улсын хилээр гарахдаа жилийн дунджаар 350м³/с урсацтай байна.

⁴ B.Boldbaatar. "Hydro Energy Resource in Mongolia" 2006. Thesis. Proceedings of the 1st Annual Mongolia-Korea Joint Symposium on Energy Technologies. Ulaanbaatar, Mongolia.

⁵ <http://www.mongolianminingjournal.com/content/48160.shtml>

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ СУУРЬ ҮНИЙГ ХЭРХЭН ТОГТООДОГ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

2.1 БНХАУ-ЫН ТУРШЛАГА

БНХАУ нь 2011 онд эрчим хүчний хэрэглээгээрээ дэлхийд 1-т, газрын тосны хэрэглээгээр АНУ-ын дараа 2-т, 2009 онд газрын тос болон түлшний импортоор 2-т орж байсан бол 2013 онд түлш болон бусад шингэний импортоор дэлхийд тэргүүлэх байрыг эзэлж байсан. 2014 оны байдлаар дэлхийн газрын тосны хэрэглээний өсөлтийн 43%-г дангаараа эзэлсэн. Хятад нь нүүрсний үйлдвэрлэл, хэрэглээ болон импортоор дэлхийд 1-т буюу дэлхийн нүүрсний хэрэглээний тал хувийг дангаараа эзэлж байна.

Хятадад 2012 онд эрчим хүчний хэрэглээний 66%-ийг нүүрс эзэлж байсан бол хоёр дахь том эх үүсвэр нь түлш болон бусад шингэн 20%-ийг эзэлжээ. Засгийн газар нь 2020 он гэхэд эрчим хүчний нийт хэрэглээн дэх нүүрсний эзлэх хувийг 62% дотор барих төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд чулуужсан түлшний эрчим хүчний хэрэглээг 2020 он гэхэд 15%, 2030 он гэхэд 20%-аар тус тус буулгахаар төлөвлөсөн байна. Одоогийн байдлаар нүүрс болон газрын тосыг байгалийн хийгээр орлуулах, 2020 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээний 10%-д хүргэх зорилтыг дэвшүүлсэн байна.

БНХАУ-ын хувьд суурь хэрэглэгдэхүүний үнэ тариф (цахилгаан, байгалийн хий, ус зэрэг)-ыг Засгийн газраас баримталж буй бодлогод тулгуурлан муж, хэрэглэгчийн ангилал тус бүрээр тогтоодог байна. Муж болон орон нутгийн эрх барих байгууллагууд нь суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифт нөлөөлж, өөрсдийн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, компаниудыг татах зэрэг таатай орчин бүрдүүлэх боломжтой байдаг байна. Хятадын эрчим хүчний үнэ нь зах зээлийн үнээс ялимгүй доогуур байдаг ба Засгийн газар нь суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифын бодлогоор дамжуулан тодорхой аж үйлдвэрүүдийг дэмжих, эсхүл хязгаарлах, мөн сүүлийн жилүүдээс эрчим хүч болон байгалийн нөөц баялгийг хэмнэхэд чиглүүлж байна.

Суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифыг төрөөс тогтоох/тохируулах нь дэлхийд түгээмэл тархсан практик юм. Хэдийгээр улс бүр төдийгүй нэг улс дотроо үнэ, тариф тогтоох аргачлал нь ялгаатай байдаг боловч зохицуулагч байгууллагууд нь суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифыг тогтоохдоо түгээгч компаниудад алдагдалгүй, эцсийн хэрэглэгчдэд хэт өндөр буюу дарамтгүй байх гол зарчмыг баримталж байна.

Хятадын суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны (ҮХШХ) Үнийн хэлтсээс (National Development and Reform Commission, Price Department) муж болон эцсийн хэрэглэгчдийн ангилалд тохируулан тогтоодог байна. Түүнчлэн төв, муж болон орон нутгийн байгууллагууд, үүнд Улсын эрчим хүчний зохицуулах хороо, орон нутгийн үнийн хороод нь ҮХШХ-д үнийн асуудлаар зөвлөх эрхтэй байна.

Баримталж буй бодлого	Хэрэгжих түвшин	Хууль, эрх зүйн акт
Суурь хэрэглэгдэхүүний үнэ тариф		
ҮХШХ-ны Үнийн хэлтэс нь	Төв Засгийн газар, муж болон орон нутгийн удирдлагууд нь үнэ тогтоох эрхтэй	1996 Цахилгаан эрчим хүчний тухай хууль
Цахилгаан		
Өөрсдийн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэл хөгжүүлэх, татах зорилгоор орон нутгийн удирдлагууд ялгавартай, эсхүл харилцан тохиролцон цахилгааны үнэ тарифыг тогтоодог	Муж, орон нутгийн удирдлагууд	Албан ёсны бодлого байхгүй, хөнгөлөлт, дэмжлэгийг харилцан тохиролцсоны үндсэн дээр үзүүлдэг
Зарим үйлдвэрлэлийг хязгаарлах хүрээнд суурь хэрэглэгдэхүүний үнэ тарифыг нэмэгдүүлсэн	Төв Засгийн газар	2004 оны эрчим хүч их зарцуулдаг үйлдвэрлэлд эрчим хүчний үнэ тарифыг ялгавартай тогтоох тухай
Ус		
Үйлдвэрлэгч компаниуд ус болон цахилгааны үнэ тариф, хөдөө аж ахуйн хэрэгцээний усны үнэ тарифыг ялгавартай тогтоосон	Муж, орон нутгийн удирдлагууд	2002 Усны тухай хууль
Бусад салбарт чиглэсэн бодлогууд		
ҮХШХ-ны Үнийн хэлтсээс эцсийн хэрэглэгч нарт хүрэх үнэ тарифыг байгалийн хий, түлш зэрэг бусад байгалийн нөөц, түүхий эдийн үнэд үндэслэн тогтооно	Төв Засгийн газар	Байгалийн хийг ҮХШХ-ны эрчим хүч хариуцсан байгууллага хариуцна
Үйлдвэрлэгч компаниуд ус болон цахилгааны үнэ тарифыг ялгавартай тогтоосон, хөдөө аж үйлдвэрийн хэрэгцээний усны үнэ тарифыг ялгавартай тогтоосон	Ихэвчлэн орон нутгийн удирдлагууд	Ихэвчлэн албан ёсны баримталж буй бодлого байхгүй, голчлон харилцан тохиролцсоны үндсэн дээр хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ

Эх сурвалж: ЭЗХАХБ, ОУЭХА

Цахилгаан:

ҮХШХ-ны харьяа Үнийн хэлтэс нь үйлдвэрлэл болон өрхийн хэрэглээний эрчим хүчний үнэ тарифыг тогтоодог бол, муж болон орон нутгийн байгууллагууд нь мөн үнийн бодлогод нөлөөлдөг байна. ҮХШХ болон Үндэсний Эрчим хүчний Газар⁶ нь улсын эрчим хүчний болон үйлдвэрлэлийн бодлогыг тодорхойлж, цахилгааны үнийг тогтоож, ҮХШХ-ны Үнийн хяналтын хэлтэс нь Хятадын үнийн бодлогод хяналт тавих үүрэгтэй.

2008 онд улсын хэмжээнд эрчим хүчний нэгдсэн бодлогоор хангах зорилго бүхий Үндэсний Эрчим хүчний Агентлаг байгуулагдсан бөгөөд эрчим хүчний хөгжлийн төсөл мөн үйлдвэрлэлийн бодлого боловсруулах, эрчим хүчний

⁶ http://en.ndrc.gov.cn/mfod/200812/120081218_252224.html

салбарын бүтцийн шинэтгэл, эрчим хүчний салбарын удирдлага, үүнд /нүүрс, газрын тос, байгалийн хий, эрчим хүч цөмийн эрчим хүч гм/ шинэ сэргээгдэх эрчим хүч, эрчим хүч хэмнэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 2003 онд байгуулагдсан цахилгаан эрчим хүчний салбарыг хянах зорилго бүхий бие даасан зохицуулах агентлагийн статустай Улсын Эрчим хүчний зохицуулах хороо /УЭХЗХ/-г 2013 онд ҮЭХА-тай нэгтгэх шийдвэр гаргасан.

БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний салбар нь Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаас баталсан 12 дахь 5 жилийн төлөвлөгөөнд заасны дагуу эрчим хүчний цэвэр эх үүсвэрийн тогтвортой өсөлтөд чиглэгдэж байна. Эрчим хүчний салбарт хамаарах стратегийн хөрөнгө оруулалтын 7 чиглэлийн 3-т нь цэвэр эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт болон цахилгаан авто машины үйлдвэрлэл орсон байна.


2013 оны Хятадын эрчим хүчний тайланд хятадын эрчим хүч дараах эх үүсвэртэй гэж дурджээ. Үүнд:

- Чулуужсан түлш: 78% (Үүнд нүүрс, газрын тос болон байгалийн хийн эрчим хүч орж байна.)
- Цөмийн эрчим хүч: 2%
- Сэргээгдэх эрчим хүч: 20% (Үүнд салхи, нар, ус болон биомассын эрчим хүч орж байна.)
- Цахилгааны үнэ, тариф

БНХАУ-ын 1996 оны Цахилгаан эрчим хүчний тухай хуульд цахилгааны үнийг төрөөс тогтоох, цахилгаан үйлдвэрлэгч нарт алдагдалгүй байх, зардлаа нөхдөг байх зэрэг зарчмыг баримтлан цахилгааны үнэ тарифыг тогтоохоор тусгасан байна. Хятадын цахилгааны үйлдвэрлэл нь таван том төрийн мэдлийн цахилгаан үйлдвэрлэгч компани болон олон тооны хувийн хэвшлийн цахилгаан үйлдвэрлэгч нараас бүрдэж байна. Цахилгаан дамжуулах болон түгээх асуудлыг улс орны хэмжээнд Улсын Цахилгаан дамжуулах компани хариуцдаг бол Хятадын Өмнөдийн Цахилгаан дамжуулах компани нь өмнөдийн 5 мужийн цахилгаан хангамжийг хариуцдаг байна.

Эцсийн хэрэглэгч нарт хүрэх үнийг 1960-аад онд боловсруулсан аргачлал ашиглан тооцдог бөгөөд тус тогтолцоонд 8 ангиллын эцсийн хэрэглэгч байх бөгөөд ангилал тус бүр 3 хэрэглээний хэмжээтэй, ингэснээр нийт 24 эцсийн хэрэглэгчтэй байна. 2005 онд ҮХШХ-ноос гаргасан бодлогын өөрчлөлтийн хүрээнд цахилгааны үнэ, тарифыг түүхий эдийн үнэтэй уялдуулан тогтоохоор заажээ. /Үүнд зөвхөн нүүрс хамаарна./


Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж буй нүүрсний дундаж үнэ
юань/тонн



----- Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж буй нүүрсний гэрээний үнэ

— Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж буй нүүрсний зах зээлийн үнэ

Цахилгааны жижиглэнгийн дундаж үнэ (1980-2010)
юань/кВ



— Цахилгааны жижиглэнгийн дундаж үнэ / юань/


— Цахилгааны жижиглэнгийн дундаж үнэ /2005 юань/

- Цахилгааны үнэ, тарифын цаашдын төлөв хандлага

2015 оны 3-р сараас эхлэн Хятад Улс эрчим хүчний салбараа шинэчлэх бодлого боловсруулж Бодлогын баримт бичиг №9-ийг танилцуулсан. Тус бодлогын хүрээнд цахилгааны үнэ тогтоох, дамжуулах, түгээх, цахилгааны худалдаа болон холбогдох салбарын 4 дахь удаагийн шинэтгэл явагдсан. Бодлогын баримт бичиг №9-д дамжуулах болон түгээлтийн үнэ тарифыг ялгаатай тогтоох бөгөөд мөн жижиглэнгийн үнэ тогтоохдоо “өртөг дээр нэмэх нь боломжит ашиг” гэх зарчмыг баримтлах юм.

2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн БНХАУ цахилгааны үнэ тооцох шинэ тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд тус бодлогын хүрээнд Шеньжень хотоос эхлэн 2015 онд 1 кВ.ц нь 0.1435 юань /2014 онд 0.1558 юань/, 2017 онд 0.1433 юань, 2018 онд 0.1428 юань байхаар тогтоосон байна. Энэхүү тогтолцоогоо улс орон даяар нэвтрүүлэхээс өмнө Өвөр Монголд туршилтын журмаар нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Харин Бодлогын баримт бичиг батлагдсанаар дээрх туршилтын тогтолцооны хамрах хүрээг өргөжүүлж Аньхуй, Хүбей, Ниншя болон Юннань мужуудыг нэмж, туршилтад хамрагдах нийт мужийн тоог 6 болгосон байна.



Шинэчилсэн бодлогын хүрээнд цахилгаан дамжуулах болон түгээх тариф, айл өрхийн цахилгааны тарифаас бусад цахилгаан үйлдвэрлэх болон жижиглэнгийн үнийг чөлөөлөх юм. Цахилгаан үйлдвэрлэгчид нь томоохон хэрэглэгч болон борлуулагч нартай гэрээ байгуулан, зах зээлийн өрсөлдөөний журмаар үнэ тогтоох эрхтэй болох юм. Түүнчлэн, тус шинэтгэлийн хүрээнд хэрэглэгчдийн ангилалд үзүүлдэг хөнгөлөлтийг аажмаар шинэчлэн тогтоох юм.

Шинэтгэлийн хүрээнд чулуужсан түлшнээс аажмаар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр лүү шилжих бодлогыг баримталж байгаа бөгөөд 2013 оноос хойш ҮХШХ-ноос баталсан “Нарны эрчим хүчний үйлдвэрлэлд олгох хөнгөлөлт”-ийг нэг кВ.ц-т 0.42 юань байхаар тогтоосон бөгөөд орон нутгийн хэмжээнд хөнгөлөлтийн төлөвлөгөөнүүд боловсруулан хэрэгжүүлсэн байна.

- Татвар

Хятадад цахилгаан эрчим хүчний компаниудад 25%-ийн ААНОАТ ногдуулдаг. Баруун Хятадын нутаг дэвсгэрт байрлах усан цахилгаан станц, атомын цахилгаан станц болон шинэ эрчим хүчний цахилгаан станц барих, үйл ажиллагаа явуулах зэрэгт дээрх татварыг 15% болгон хөнгөлжээ.

Энгийн НӨАТ төлөгч статустай цахилгаан эрчим хүчний компаниудад 17%-ийн НӨАТ ногдуулдаг. Байгальд ээлтэй цахилгаан эрчим хүчний компаниуд, түүнчлэн эрчим хүчний хэмнэлттэй компаниудад НӨАТ-ын буцаан олголт олгоно. Хог хаягдал шатааж эрчим хүч үйлдвэрлэгчдэд татварын бүрэн буцаалт олгоно. Нүүрс, нүүрсний шлам, шатдаг занар, болон салхи зэргээс гаргаж авсан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгчид үйл ажиллагаа явуулж эхэлсэн сараас эхлэн 15 жилийн хугацаанд НӨАТ-ын 50 хувийн буцаан олголтыг олгоно.

Байгалийн хийн үнэ тариф
(2011 оны байдлаар)

Хот	Муж	Арилжааны		Үйлдвэрлэлийн	
		2011 юань/ м3	2011 юань/ кг нүүрсэнд ногдох үнэ	2011 юань/ м3	2011 юань/ кг нүүрсэнд ногдох үнэ
Бээжин	-	2.84	2.14	2.84	2.14
Тяньжинь	-	2.80	2.11	2.80	2.11
Шижяжуан	Хөбэй	2.95	2.22	2.95	2.22
Хөх хот	Өвөр Монгол	3.56	2.68	2.00	1.50
Шеньян	Ляонин	3.90	2.93	3.90	2.93
Чангчүнь	Гирин	3.20	2.41	3.20	2.41
Харбин	Хармөрөн	3.00	2.26	2.90	2.18
Шанхай	-	3.69	2.77	3.29	2.47
Наньжин	Жянсү	2.95	2.22	2.95	2.22
Ханжоу	Жөжян	3.50	2.63	3.50	2.63
Нинбо	Жөжян	3.40	2.56	3.40	2.56
Хөфей	Аньхуй	3.58	2.69	2.48	1.86
Шиамэн	Фүжань	4.20	3.16	3.81	2.86
Жинань	Шаньдун	3.61	2.71	3.61	2.71
Чиндао	Шаньдун	3.60	2.71	3.60	2.71
Жөнжоу	Хөнань	3.16	2.38	2.86	2.15
Үхань	Хүбей	3.68	2.77	3.00	2.26
Чанша	Хүнань	3.00	2.26	3.00	2.26
Наньнин	Гуанши	5.73	4.31	4.60	3.46
Хайкоу	Хайнан	3.73	2.80	3.30	2.48
Чунчин	-	2.29	1.72	2.24	1.68
Чөндү	Сычуань	2.20	1.65	2.20	1.65
Шиань	Шэньси	2.60	1.73	2.30	1.73
Ланьжоу	Ганьсү	2.17	1.63	1.90	1.43
Шинин	Хөхнуур	2.07	1.56	1.70	1.28
Юнчуан	Хөхнуур	1.98	1.49	1.38	1.04
Өрөмч	Шиньжян	2.11	1.59	2.11	1.59

*Томоохон муж болон хотууд дахь бензин болон дизель түлшний үнийн
дээд хэмжээ
(2012 оны байдлаар)*


Муж	Бензин 90		Дизель	
	Юань/ тонн	Юань/ тонн нүүрсэнд ногдох үнэ	Юань/тонн	Юань/ тонн нүүрсэнд ногдох үнэ
Бээжин	-	-	9,600	6,588
Тяньжинь	9,935	6,752	9,085	6,235
Хөбей	9,935	6,752	9,085	6,235
Шаньси	10,005	6,800	9,140	6,273
Ляонин	9,935	6,752	9,085	6,235
Гирин	9,935	6,752	9,085	6,235
Хармөрөн	9,935	6,752	9,085	6,235
Шанхай	-	-	9,570	6,568
Жянсү	9,990	6,789	9,125	6,262
Жөжян	9,990	6,789	9,140	6,273
Аньхуй	9,985	6,786	9,135	6,269
Шаньдун	9,945	6,759	9,095	6,242
Хүбэй	9,960	6,769	9,110	6,252
Хунань	10,000	6,796	9,170	6,293
Хөнань	9,955	6,766	9,105	6,249
Хайнань	10,080	6,851	9,220	6,328
Чунчин	10,150	6,898	9,295	6,379
Гуандун	10,015	6,806	9,155	6,283
Гуаньши	10,080	6,851	9,220	6,328
Ниншя	9,940	6,755	9,085	6,235
Ганьсү	9,920	6,742	9,105	6,249
Шиньжань	9,715	6,603	8,980	6,163
Хот	Бензин		Дизель	
	Юань/ тонн	Юань/ тонн нүүрсэнд ногдох үнэ	Юань/тонн	Юань/ тонн нүүрсэнд ногдох үнэ
Хөх хот	9,950	6,762	9,100	6,245
Фүжоу	9,950	6,789	9,130	6,266
Наньчан	9,955	6,766	9,105	6,249
Чөндү	10,155	6,902	9,320	6,396
Гүйян	10,115	6,874	9,245	6,345
Куньмин	10,145	6,895	9,275	6,365
Шиань	9,920	6,742	9,095	6,242
Шинин	9,900	6,728	9,130	6,266

Усан хангамж:

БНХАУ-д усны салбартай хамаарал бүхий төрийн байгууллагууд нь дараах чиг үүрэгтэй оролцож байна.

Төрийн зөвлөл	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, яам агентлагуудын хоорондын уялдаа холбоог хангах
Усны нөөцийн яам	Усны нөөц, усны нөөцийн хамгааллын бодлого, усны зориулалтын бүсчлэл, гол, мөрөн, нуурын усны чанарт хяналт тавих, ус олборлох зөвшөөрөл олгох, усны үнэ тарифын санал гаргана
Байгаль орчин хамгааллын яам	Усны бохирдлын тухай хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, хяналт, усны бүсчлэл, усны чанарын хяналт
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо	Орчны бохирдлын менежмент, бохир ус цэвэрлэх үнэ тарифын бодлого, усны үнэ тарифын бодлого, бохир усны гарц болон цэвэрлэгээнд нөлөөлөх аж үйлдвэрийн бодлого
Сангийн яам	Орчны бохирдлын менежмент, бохир ус цэвэрлэх үнэ тариф, усны нөөцийн үнэ тарифын бодлого
Орон сууц, хот болон хөдөөгийн хөгжлийн яам	Хот суурингийн усан хангамж, бохир ус цэвэрлэгээ
Хөдөө аж ахуйн яам	Хөдөө орон нутаг болон хөдөө аж ахуйн усны хэрэглээ, хөдөө аж ахуйн химийн бодисоос үүдэлтэй бохирдол
Газар болон нөөц баялгийн яам	Байгалийн нөөц, газар ашиглалтын төлөвлөгөө
Төрийн ойн газар	Ойн нөөц ашиглан усны нөөц бүрдүүлэх
Тээврийн яам	Усан тээвэр болон усны бохирдлын хяналт
Улсын далайн газар	Далай орчмын ашиглалтын удирдлага, далайн экосистемийн хамгаалал
БХАТИХ	Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, хяналт тавих

Усны нөөцийн хэрэглээ
(усны сав газар, салбар, эх үүсвэрээр)



- Бодлого, хууль эрх зүйн орчин

Хятадын усны аюулгүй байдал, усны хомсдол, усны бохирдол болон үерийн асуудал зэрэг нь сүүлийн жилүүдэд улс орны хэмжээнд томоохон асуудлын нэг болж байгаа. Цэвэр ус нь Хятадын тогтвортой хөгжлийг хангах гол нөөцийн нэгээр зүй ёсоор тооцогдож байгаа боловч өсөн нэмэгдэж буй эрэлт, бохирдол зэргээс үүдэн хомсдож, эдийн засаг болон экологийн үүднээс усны нөөцөө зүй зохистой хэрэглэх шаардлагыг бий болгож байна. Засгийн газар нь усны дэд бүтцийг хөгжүүлэх, усны хэрэглээ болон усны хангамж зэрэг асуудлаар тодорхой бодлого, хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах зэргээр ажиллаж байна.

Дээрх бодлогын хүрээнд хувийн секторын хөрөнгө оруулалтыг байгаль орчин, хөдөө аж ахуй, хот болон үйлдвэрлэлийн усны хангамж зэрэг усны дэд бүтцийн хөгжилд төвлөрүүлэхээр зорьж байна.

2011 оны 11-р сард Төрийн зөвлөлөөс Усны нөөцийн шинэтгэл болон хөгжлийн бодлогын баримт бичиг №1-ийг баталсан. Энэхүү бодлого нь усны нөөцийн шинэтгэл болон хөрөнгө оруулалт, үерээс хамгаалах дэд бүтэц, усны үнэ тариф болон институцийн шинэтгэл зэргийн 10 жилийн хөтөлбөрт тусгагдсан байна. 2011 оноос хойш тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдамж болон тогтоол журмуудыг боловсруулж баталсан бөгөөд тэдгээр нь 12 дахь 5 жилийн төлөвлөгөөнд орсон байна.

2011-2016 онд хэрэгжих 12 дахь 5 жилийн төлөвлөгөөнд Засгийн газар нь агаар болон усны бохирдолд 3.7 их наяд юань (447 тэрбум евро), эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүчид 4.1 их наяд юань (497 тэрбум евро) зарцуулахаар тус тус төсөвлөсөн байна.

Далайн эргийн бүсэд байрлах болон нэгдүгээр шатлалын /Бээжин, Шанхай, Гуанжоу, Шеньжень/ хотуудад байрлах үйлдвэрүүдийг нүүлгэх, мөн шинээр байгуулагдах үйлдвэрүүдэд хийх байгаль орчны нөлөөллийн шинжилгээ нь одоо мөрдөгдөж байгаасаа хүндрэх хандлагатай байна.

12 дахь 5 жилийн төлөвлөгөөнд усны асуудал нь “2011-2015 онд Хятадын Усны төлөвлөгөө” гэж анх удаагаа тусдаа бүлэг болон орсон байна. Тус төлөвлөгөөний дагуу 2015 он гэхэд дараах голлох үр дүнд хүрсэн байна:

- Төвлөрсөн усан хангамжид холбогдсон хөдөөгийн хүн амыг 64%-аас 80% болгон нэмэгдүүлэх, хөдөө орон нутгийн 300 сая иргэдийн усны аюулгүй байдлыг хангах.
- Төвлөрсөн усан хангамжид холбогдсон хот суурин газрын хүн ам 95%-аас багагүй байх.
- 635 км дотор улсын усны хэрэглээг хянах.
- ДНБ-ний нэгжид ногдох үйлдвэрийн усны хэрэглээг 2010 онтой харьцуулахад 30%-аар бууруулах.
- Хот суурин газрын бохир усны 85%-ийг цэвэрлэх бөгөөд цэвэрлэсэн усны 20%-ийг дахин хэрэглэнэ.
- 12-р 5 жилийн төлөвлөгөөнд бохир ус цэвэрлэх, усны хангамж болон ус давсгүйжүүлэх дэд бүтэц, ус болон бохир ус цэвэрлэх шинэ технологийг дэмжиж ажиллахад чиглэгдэж байна.

- Усны үнэ тариф

Хятадын усны үнэ тарифыг холбогдох хууль тогтоомжид зардлаа нөхөх хэмжээнд байна гэж заасан байдаг ч маш хямд байсаар ирсэн. Мөрдөгдөж буй үнэ тариф нь усан хангамж, ариутгах болон байгаль орчин хамгаалах дэд бүтцээр хангахад хүрэлцэхгүй байгаа нь Хятадын усны салбарыг төр засгийн татаасаас ихээхэн хамааралтай болгож байна.

Усны үнэ тариф нь усан хангамжийн төлбөр, бохир усны төлбөр болон усны нөөц ашигласны төлбөр гэх гурван бүрэлдэхүүнтэй. Бохир усны төлбөрийг үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг бий болгохын тулд ямарваа нэгэн цэвэрлэх үйлчилгээ үзүүлээгүй байсан ч ногдуулдаг.

Хот суурингийн өрхийн усны үнэ тариф 2001-2007 оны хооронд огцом өссөн бол түүнээс хойш харьцангуй тогтмол буюу 1 м³-д 3 юань, үүнээс 0.81 юань бохир усны төлбөрт тооцогдож байгаа нь олон улсын түвшний зөвхөн 20%-тай тэнцэж, өрхийн орлогын 1%-аас бага байгаа нь усны ядууралд тооцогдох 5%-аас хамаагүй бага үзүүлэлт юм.

Хот суурин газруудын хувьд усны тарифыг өсөн нэмэгдүүлж ирсэн бөгөөд үнэ тарифын хэмжээний хувьд айл өрх, ААН, үйлчилгээний салбар, үйлдвэрлэлийн салбар, аялал жуулчлал гэх дарааллаар нэмэгддэг бөгөөд айл өрхийн тариф нь хамгийн өндөр тарифынхаа 25%-тай тэнцэж байна. Үйлдвэрлэлийн хэрэглэгч нар нь 1 м³-д 5-10 юань төлж байгаа боловч томоохон хэрэглэгчид нийлүүлэгчтэйгээ харилцан тохиролцож түүнээс бага үнээр худалдан авах боломжтой байдаг.

Сүүлийн жилүүдэд усны үнэ тарифыг шат дараатайгаар нэмж байгаа бөгөөд цаашид мөн нэмэх төлөвтэй байна. 2012-2014 онд боловсруулсан баримт бичгүүдэд усны нөөц ашигласны төлбөрийг нэмэхээр тусгасан бөгөөд гүний болон гадаргуун усны хувьд ялгаатай тариф тогтоох, гүний усыг хэмнэх зэрэг бодлогууд тусгагдсан байна. Түүнчлэн, хойд бүс зэрэг усны хомсдолтой бүсэд усны тарифыг өндөр тогтоохоор шийдвэрлэсэн байна. /Бээжингийн гадаргуун болон гүний усны тарифыг 1 м³-д 1.6, 4 юань болгон тус тус нэмсэн бол ядуу болон усны нөөц ихтэй бүсүүдэд 1 м³-д 0.1 -0.2 юань байна./

2.2 БНСУ-ЫН ТУРШЛАГА

- Эрчим хүчний эх үүсвэр, зах зээлийн бүтэц

Солонгос Улс ашигт малтмалын бараг нөөцгүй орон бөгөөд хэрэгцээт чулуужсан түлшээ (нүүрс, газрын тос болон байгалийн хий) бараг бүгдийг (99%) нь импортолдог.⁷ Тус улс хийн импортлогчоор дэлхийд 2 дугаарт, газрын тосны импортоор 5 дугаарт жагсдаг.

Солонгос Улс үндсэндээ чулуужсан түлшний эрчим хүчээс хамааралтай бөгөөд нийт энергийн хэрэгцээний 37%-ийг нефтис, 29%-ийг нүүрснээс, 17%-ийг байгалийн хийнээс гарган авч байна. Цөмийн эрчим хүч 15%-ийг эзэлдэг бол үлдсэн 2%-ийг сэргээгдэх эрчим хүч эзэлдэг.

⁷ Солонгос: Улсын ерөнхий байдал-KOREA: COUNTRY OVERVIEW [ftp://ftp.oecd.org/FFS2015/KOR_country%20overview.pdf](http://ftp.oecd.org/FFS2015/KOR_country%20overview.pdf)

Солонгост эрчим хүчний аж үйлдвэрийн дийлэнх нь төрийн өмчлөлд байдаг бол газрын тосны олборлолт болон нүүрсний уурхайн ихэнх нь хувьчлагдсан байдаг. Харин хий, цахилгаан болон дүүргийн дулаан хангамж үндсэндээ нийтийн өмч юм. Төрийн өмчийн KNOG (Korea National Oil Corporation) корпораци нь Солонгосын нефтийн стратегийн ордуудыг өмчлөн газрын тос болон байгалийн хийн эрэл хайгуул, олборлолт, ашиглалтыг өөрийн нутаг болон гадаад улс оронд хариуцдаг. Харин хувийн компаниуд нь баяжуулах, бөөний импорт, түгээх болон жижиглэн худалдаалахад давамгайлдаг. Том компаниуд гэвэл SK, GS Caltex, S-Oil, Hyundai Oil Bank зэргийг нэрлэж болно.

Чулуун нүүрсний 8 уурхайн 5 нь хувийн өмчийнх бол гурав нь төрийн өмчтэй KCC (Korea Coal Corporation)-ийн мэдэлд байдаг. Хувийн хэвшил болон бусад төрийн өмчтэй компаниуд дэлхийн зах зээл дээрээс хэрэгцээт нүүрсийг импортлох ажил эрхэлдэг. Ингэхдээ ихэвчлэн дунд болон урт хугацааны гэрээг ашигладаг.

Төрийн өмчийн болон удирдлага бүхий KOGAS (Korea Gas Corporation) нь байгалийн хийн импортод монополий байдалтай бөгөөд дамжуулах болон бөөний худалдаагаар хангадаг. Жижиглэнгийн худалдааг нь 30 гаруй хотын компаниуд хариуцдаг байна.

Солонгосын цахилгааны аж үйлдвэрийн салбарт 50%-ийн төрийн өмчлөл бүхий KEPCO (Korea Electric Power Corporation) давамгайлдаг. 2001 онд KEPCO-г 6 тусдаа цахилгаан станц болгон шинээр зохион байгуулсан байдаг. KHNP (Korea Hydro and Nuclear Power) нь улсынхаа АЦС (Атомын цахилгаан станц) болон УЦС (Усан цахилгаан станц)-уудыг эзэмшдэг бол бусад 5 нь ДЦС (Дулааны цахилгаан станц)-ууд юм. KEPCO нь мөн үндэсний хэмжээнд дамжуулах болон түгээх сүлжээг хариуцдаг. Түүнтэй зэрэгцүүлэн эрчим хүчний зах зээл буюу төрийн өмчийн KPX (Korea Power Exchange)-ийг байгуулсан байдаг.

Одоогийн байдлаар энэхүү 6 ЦС нь Солонгосын нийт эрчим хүчний хүчин чадлын 4/5-ийг гаргадаг бөгөөд үйлдвэрлэсэн эрчим хүчээ дан ганц KEPCO-д худалддаг байна. 5 ДЦС-ийг хувьчлах асуудал анх 2000-аад оны эхээр тавигдсан боловч одоо болтол шийдэгдээгүй хойшлогдсоор байна. KDHC (Korea District Heating Corporation) корпораци нь Солонгосын дулааны зах зээлийн 60% орчмыг хангадаг бол үлдсэн зах зээлийг 20 гаруй компани, түүний 15% орчим нь хувьчлагдсан, хангадаг.

- Үнэ, татвар болон дэмжлэг

Газрын тос болон битум нүүрсний бөөний худалдаа болон жижиглэнгийн үнэ үндсэндээ зохицуулалтгүй. Дотоодын үйлдвэрийн чулуун нүүрс болон шахмал түлшний бөөний үнийг Засгийн газар тогтоох ба ингэхдээ үр ашиггүй нүүрсний уурхайд дэмжлэг үзүүлж буй нөхөн олговор (субсид)-ын нэг хэлбэр юм. Хий болон дулааны үнийг MOCIE (Ministry of Commerce, Industry and Energy) яам шууд хянаж байдаг. MOCIE дотор бараг биеэ даасан KOREC (Korea Electricity Commission) хороо нь KPX-ийг зохицуулдаг бөгөөд цахилгааны эцсийн үнийг тогтоодог.

Солонгос нь түүхий нефть болон баяжуулсан бүтээгдэхүүнд импортын гаалийн татвар ногдуулдаг. Баяжуулсан бүтээгдэхүүний татварыг өндөр

байлгаж, Солонгосын дотоодын энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг импортлогчдоос хамгаалдаг. Битум нүүрсний импорт мөн татвартай. Түлш болон эрчим хүчний үйлчилгээний борлуулалтанд жигд 10%-ийн НӨАТ (Нэмэгдсэн өртгийн албан татвар) ногдуулдаг. Нефтийн бүтээгдэхүүн болон хийн борлуулалтанд орон сууц ч бай, албан байгууллага ч бай ялгалгүй онцгой (акциз) албан татвар ногдуулдаг; түлш тээвэрлэхэд ч мөн нэмэлт татвар (үүнд боловсролын татвар болон тээврийн бүлэг татвар-замын, эрчим хүчний, байгаль орчны г.м) ногдуулдаг.

Чулуужсан түлшний эрчим хүчний үйлдвэрлэлд засгийн газраас үзүүлдэг дэмжлэг нь голчлон нүүрсэнд хамаарна. Олон арван жилийн туршид чулуун нүүрс үйлдвэрлэгчдийг үнийн дэмжлэг, үндсэн хөрөнгө худалдан авалтын нөхөн олговор, эрэл хайгуулын нөхөн олговор болон ерөнхий шинжтэй дэмжлэгээр дэмжиж иржээ. Үнийн дэмжлэгийн бүтцийг 2010 онд шинэчлэн тогтоосон. Засгийн газар нь чулуун нүүрсний шахмал түлшний хувьд өөрийн өртгөөс доогуур үнийг тогтоож, үйлдвэрлэгчид зөрүүг нь олгох маягаар бага орлоготой иргэдээ хамгаалах бодлогыг хэрэгжүүлдэг байна.

Хэрэглэгчийг хамгаалах бодлого нь тодорхой хэрэглэгчийн хувьд төрөл бүрийн түлшний онцгой албан татварыг чөлөөлөх хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл, фермер, загасчлалын завь болон зарим төрлийн эргийн хүн тээврийн усан онгоцны хувьд нефтийн бүтээгдэхүүний борлуулалтанд ногдуулдаг олон албан татваруудаас чөлөөлдөг байна. Мөн чулуун нүүрс болон шахмал түлшний борлуулалтанд оногдуулдаг НӨАТ-аас чөлөөлдөг.

- Цахилгаан эрчим хүчний эрэлт, нийлүүлэлт

Солонгосын эрчим хүчний эх үүсвэрийг 2015 оны байдлаар ерөнхийдөө 3 хэсэгт хувааж болно.⁸ Үүнд:

- Нүүрс (39%, 205 Твтц)
- АТС (30%, 154 Твтц)
- Хий (22%, 115 Твтц)

Нүүрс, байгалийн хийн цахилгаан үйлдвэрлэлт 2005 онтой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн байна.

- Цахилгааны зах зээл

Жижиглэнгийн зах зээлд КЕРСО нь цорын ганц цахилгааны нийлүүлэгч юм. Эцсийн хэрэглэгчид хүрэх цахилгааны үнэ 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд: суурь үнэ (айл өрх тус бүрт оролтын тоо юм уу хүчин чадлаар) ба хөдөлмөрийн үнэ (хэрэглээний хэмжээнд суурилсан).

КЕРСО корпорацийн салбаруудын жижиглэнгийн үнэ мөн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд: эрчим хүчний зардал (түлшний зардал багтаагүй эрчим хүчний тогтмол болон хувьсах зардал) ба түлшний зардал. Эрчим хүчний зардлыг KOREC баталж өгдөг бол түлшний зардал нь дэлхийн зах зээлийн үнээс хамааран 2 сар тутам автоматаар өөрчлөгдөж байдаг. Гэвч КЕРСО болон түүний салбар компаниуд түлшний зардлаа төлж чадахгүй байсан учир засгийн газар энэхүү

⁸ Цахилгааны эрчимт аж үйлдвэрийн эрчим хүчний зардал: Олон улсын харьцуулалт-Electricity Costs of Energy Intensive Industries: An International Comparison, 2015, Fraunhofer ISI <http://www.ecofys.com/files/files/ecofys-fraunhoferisi-2015-electricity-costs-of-energy-intensive-industries.pdf>

зохицуулалтаа цуцлахад хүрсэн. Гео-улстөрийн шалтгаанаар Солонгос нь бусад орны эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй болно.

- Цахилгаан борлуулах үнэ

Солонгосын цахилгааны зах зээл нь маш бага либералчлагдсан. Засгийн газар цахилгааны үнийг доогуур түвшинд тогтмол барьж, бүх хэрэглэгчийг цахилгаанаар жигд хангах бодлогыг баримталдаг. Үнэ өсгөх асуудлыг яамны түвшинд шийдвэрлэдэг. Гэвч энэ нь баталгаатай биш. Цахилгаан үйлдвэрлэх зардал өслөө гэхэд энэ нь эцсийн хэрэглэгчид шууд хүрдэггүй, харин засгийн газрын агентлагийн төсөвт тусгалаа олдог.

Аж ахуйн нэгж болон үйлчилгээний байгууллагууд (жигжиг дунд үйлдвэр), түүнчлэн аж үйлдвэрийн хувьд цахилгааны борлуулалтын үнэ ялгаатай шатлалтай байдаг. 2012 онд “жигжиг бизнес ба үйлчилгээ” (ЖБҮ)-ний салбар болон аж үйлдвэрийн газрын цахилгааны үнэ ялгаатай байсан бол 2013 оноос ижил болсон.

Цахилгааны үнэ нь хэрэглээ ба суурь үнээс бүрдэнэ. Суурь үнэ нь эрчим хүчний хангамжийн хэрэглээний бүлэг болон хүчдэлийн түвшин, улирлаас хамаардаг. 300 кВт хүртэл хүчин чадалтай хэрэглэгчийн ажлын үнэ 4.4 цент/кВтц (шилжилтийн улирал) буюу 7.9 цент/кВтц (зун) байдаг. 300 кВт-аас илүү хэрэглэгчийн хувьд 3.6 цент/кВтц (зун болон шилжилтийн улирал, оргил бус үе)-13.45 цент/кВтц (зуны оргил үе) хооронд байдаг. Холбосон хүчин чадал болон хүчдэлийн түвшингээс хамааран суурь үнэ нь 4.9-6.7 евро/кВт хооронд байна.

- Дамжуулах системийн зардал

Солонгосын цахилгааны зах зээл бага либералчлагдсан учир нийтийн аж ахуй ба шугам сүлжээний операторууд нь багцлагдсан байдаг. Шугам сүлжээний зардлыг цахилгааны тарифт багтаасан байдаг бөгөөд тусад нь жагсаадаггүй.

- Татвар шимтгэл

Солонгосын Засгийн газар нь эрдэм шинжилгээний ажил, эрчим хүч хэмнэлтийн арга аргачлал, сэргээгдэх эрчим хүчний дэмжлэгийн тариф болон салбарын бусад бодлогыг санхүүжүүлэхийн тулд “EPDIF” хэмээх нэмэлт төлбөрийг бий болгосон. Бүх хэрэглэгч цахилгааны үнийн дүнгийн 3.7%-тай тэнцэх энэхүү нэмэлт төлбөрийг төлдөг. Хөнгөлөлт чөлөөлөлт байхгүй. НӨАТ-ийн хэмжээ нь цахилгааны тарифийн 10%-тай тэнцэнэ. Мөн хөнгөлөлт чөлөөлөлт үгүй.

- Жижиглэнгийн тариф ба солбилцсон нөхөн олговор (субсид)

Ерөнхийдөө Солонгост хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбар нь өөрийн өртгөөс доогуур үнээр цахилгаан хэрэглэдэг бол бусад хэрэглэгчид нь өртгөөс илүү үнэтэй цахилгаанаар хангагдана.⁹ Мөн шөнийн хэрэглээний тусгай хямдруулсан үнэ гэж бий. Энэ тариф нь цөмийн эрчим хүчний үйлдвэрлэж буй эрчим хүчний өртгийн түвшингээр хэмжигдэх ба шөнө дунд АЦС-ийн гаргаж буй цахилгааныг амины хэрэглээнд ашиглахыг дэмжих зорилготой юм.

⁹ Солонгосын цахилгаан эрчим хүч: Тайлан-Electricity in Korea: Paper 2011/SOM2/SYM/009 APEC, Seoul National University, 2011 http://mddb.apec.org/Documents/2011/SOM/SYM/11_som_sym1_009.pdf

Table 15.1: Trends in average prices (KRW) per kWh.

Year	Residential	Industrial	Agricultural	Total
1994	85.95	46.14	34.59	59.39
1995	86.47	47.14	36.17	61.28
1996	88.95	48.37	37.11	62.99
1997	92.05	49.86	38.96	65.26
1998	96.60	55.01	44.31	72.08
1999	96.41	54.78	44.04	71.59
2000	94.72	58.30	43.04	74.65
2001	91.57	61.56	43.51	77.06
2002	87.01	59.02	42.37	73.88
2003	88.00	60.30	43.45	74.68
2004	90.94	60.23	41.95	74.58
2005	91.07	60.25	41.67	74.46
2006	93.70	61.92	42.96	76.43
2007	94.78	64.56	42.45	77.85
2008	97.58	66.24	42.38	78.76

Source: KEPCO statistics 2010.

байгаа нь зардал мөн өссөнийг илтгэнэ. 2008 онд гэхэд KEPCO корпораци нь түлшний үнийн өсөлтөөс шалтгаалан 1 их наяд воны алдагдал хүлээсэн байдаг.

Энэхүү тарифын бүтэц нь Солонгосын хэмжээнд хэрэглээнээс хамаарсан солбицсон нөхөн олговрын системийг бий болгоход хүргэдэг.

Нэгдүгээрт, ахуйн болон аж ахуйн нэгжийн хэрэглэгчид нь хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарт субсид хийх бололцоо олгохын тулд илүү их үнэ төлдөг. Аж үйлдвэрийн хэрэглэгчид дангаар Солонгосын нийт цахилгааны хэрэглээний тэн хагасыг төлөөлдөг. Энэхүү солбицсон нөхөн олговрын тогтолцоо нь аж үйлдвэрийн салбарын цахилгааны хэрэглээг нэмэгдүүлэхэд урамшуулдаг бол бусад эдийн засгийн салбаруудыг эрчим хүч хэмнэх чиглэлд түлхэц үзүүлдэг. Энэ нь тус улсын экспортод чиглэсэн бодлогын үр дүн юм.

Хямд эрчим хүч Солонгосын экспорт давамгайлсан эдийн засагт мэдэгдэхүйц тус нэмэр болох нь дамжиггүй. Гэсэн хэдий ч зардлаа нөхөн төлөх чадваргүй үнэ бүхий хэт их эрчим хүч хэрэглэсэн аж үйлдвэрийг үржүүлэн олшруулах муу талтай.

Хоёрдугаарт, хотын хэрэглэгчид оролцуулсан зардлаасаа маш өндөр үнэ төлөхөд хүргэсэн. Энэ нь алслагдсан уулын бүс болон тусгаарлагдсан арал дээр оршин суугчид хотын хэрэглэгчтэй ижил үнэ төлөх боломжийг хангаж байгаа юм. Энд сонирхуулж тэмдэглэхэд, цахилгаанаас дутахгүй ач холбогдол бүхий цэвэр ус гэхэд бүс бүсээр ялгаатай үнэтэй байдаг. Энэ нь эрчим хүчний хангамж монополь байдаг бол усны хамгамж тусдаа орон нутгийн зохицуулалттай байдагтай ч холбоотой байж болох юм.

Гуравдугаарт, шөнийн хямдралтай тариф нь зөвхөн зөвшөөрөгдсөн халаалтын болон хөргөлтийн тоног төхөөрөмжид хамаардаг. Энэ хөтөлбөр нь АЦС-ийн үүсгэсэн шөнийн илүүдэл эрчим хүчийг ашиглах зорилготой юм. Тэрээр маш үр дүнтэй болох нь харагдсан.

Хүснэгтээр¹⁰ цахилгааны үнийн хандлагыг хэрэглээний бүлэг бүрээр харуулав. Жижиглэнгийн тариф нь хөрөнгө оруулалтын өгөөжиднийцүүлэн зохицуулагдсан бөгөөд өсөх хандлагатай байгаа нь ажиглагдана.

Хүснэгтэд агуулагдсан тоонууд нь зах зээлийн үнэ биш бөгөөд зохицуулагдсан тариф юм.

Тиймээс зах зээлд хийсэн шинэчлэл, өөрчлөлтийн үр дүн харагдахгүй. Үнэ тогтмол өссөн

¹⁰ Paper 2011/SOM2/SYM009 APEC, Seoul National University, 201

2.3 ЭНЭТХЭГ УЛСЫН ТУРШЛАГА

Энэтхэг улс нь 1951 онд Анхны таван жилийн төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлсэн бөгөөд өдгөө 12 дахь таван жилийн төлөвлөгөөг 2012-2017 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус таван жилийн төлөвлөгөөнөөс Энэтхэг улс үйлдвэрлэлийн салбарт ямар бодлого баримталж байгаа болон цаашдын чиг хандлага зэргийг судлан үзэв.

Тус улс сүүлийн хорин жилийн хугацаанд дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй эдийн засагтай орнуудын нэгт зүй ёсоор орох бөгөөд үүнд эдийн засгийн шинэчлэлийн бодлого ихээхэн нөлөөлж байна гэж тус баримт бичигт тусгажээ.¹¹

- Энэтхэгийн аж үйлдвэрийн бодлогын ерөнхий байдал:

“Үйлдвэрлэлийн бодлого”-ын үзэл баримтлал нь улс орон бүрт цаг хугацаа, нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байна. Энэтхэг улсын хувьд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний квот, тусгай зөвшөөрөлд хяналт тавих нь үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулж байна гэж үзэн 12 дахь таван жилийн төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн салбар дахь татаас, дэмжлэгийн хөтөлбөрөөс гадна бодлогын дэмжлэг үзүүлэхийг тэргүүнд тавьсан байна.

1950-1980 онуудад Энэтхэг нь үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөлтийг 5 жилийн төлөвлөгөөний хүрээнд тодорхойлон, хэрэгжүүлж ирсэн. 1980-аад оноос энэхүү загвар өөрчлөгдөж, үйлдвэрлэлийн бодлого нь илүү прагматик шинжтэй болсон. Үндсэндээ үйлдвэр, аж ахуйн нэгж болгоноор орц, гарцыг төлөвлөдөг байсны оронд Засгийн газар үзүүлэлтүүдийг төлөвлөдөг болсон. Гэсэн хэдий ч, олон улсын стандартуудаар тогтоогддог маш өндөр тарифууд гэх мэт үйлдвэрлэлийн бодлогын хэрэглүүрүүд, портфайлын болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хязгаарлалтуудыг үл орхин, төрийн бодлогодоо тусгасан. 1991 оны хямралаас үүдэлтэйгээр энэ загвар үндсээрээ өөрчлөгдсөн.

1991 оноос Энэтхэгийн эдийн засгийн хөгжил уламжлалт үйлдвэрлэлийн бодлогоос зах зээлийн баримжаатай, чөлөөт эдийн засгийн бодлогод шилжсэн. 1991 онд парламентаас “Үйлдвэрлэлийн бодлогын тунхаг”-ийг тогтоолоор батлан гаргасан бөгөөд уг бодлогын баримт бичигт засгийн газрын зүгээс үйлдвэрлэлийн салбарыг чөлөөлөх, дэмжих шат дараалсан арга хэмжээнүүдийг авахаар тусгасан. Ийнхүү үйлдвэрлэлийн салбарын бодлогогүй байх, зах зээлийн механизмд бүрэн хариуцуулан үлдээх болсон нь неолиберал нөлөөллийн улмаас ихээхэн шүүмжлэлтэй тулгарсан.

Тиймээс төрөөс аж үйлдвэрлэлийн чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогыг “дахин бодож үзэж”, улмаар 2011 онд Энэтхэгийн Засгийн газраас Үндэсний аж үйлдвэрийн бодлогыг баталсан ба уг бодлогын баримт бичигт ДНБ-нд “аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 25 хувьд хүргэх, мөн 2022 он гэхэд аж үйлдвэрийн салбарт 100 сая ажлын байрыг бий болгох” зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү бодлогын хүрээнд Үндэсний хөрөнгө оруулалт болон Аж үйлдвэрийн бүсүүдийг дэмжих, хөгжүүлэх чиглэл барьж байна.

¹¹ Twelfth Five Year Plan (2012–2017) Economic Sectors, Volume II

- Үйлдвэрлэлийн чиглэлээр баримталж буй өнөөгийн бодлого:
- Үндэсний аж үйлдвэрийн бодлого 2011¹²: Үндэсний аж үйлдвэрийн бодлого /*National Manufacturing Policy (NMP)*/ нь аж үйлдвэрийн салбарт тоон болон чанарын өөрчлөлтийг хийхэд чиглэсэн. Бодлого нь төрийн оролцоо, түншлэлд тулгуурлан аж үйлдвэрийн өсөлтийг хангах гол зарчмыг агуулсан байна. Төв засгийн газрын зүгээс бодлогын хүрээг тодорхойлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан санхүүгийн хэрэглүүрийг ашиглан аж үйлдвэрлэлийн хөгжлийг хангах чиглэлд түлхүү ажиллана.

Тус бодлогын баримт бичигт тусгаснаар үндэсний хөрөнгө оруулалт болон аж үйлдвэрийн бүсүүд нь бодлогын чухал арга хэрэгсэл, хэрэглүүр болох юм. Өөрөөр хэлбэл эдгээр бүсүүд нь том хэмжээний аж үйлдвэрийн хотхонууд байх бөгөөд дэд бүтцийг шийдвэрлэх, бүсийн газар ашиглалт, зохицуулалтыг хариуцах, цэвэрлэх байгууламж барих, эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх, шаардлагатай нийгмийн дэд бүтцийг бий болгох, бүсүүдийг хөгжүүлэх зэрэг асуудлыг төрөөс хариуцан хэрэгжүүлж, аж үйлдвэрлэлийн таатай орчин нөхцлийг бий болгох юм. Түүнчлэн аж үйлдвэрлэлийн корридорыг бий болгох төслүүдийг энэхүү бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгажээ.

Үндэсний аж үйлдвэрлэлийн бодлогод төлөвлөсний дагуу Засгийн газраас 2015 оны 11 дүгээр сарын 18-нд “Технологийн эзэмшил, хөгжлийн сан”-г /*Technology Acquisition and Development Fund (TADF)*/ байгуулсан ба цэвэр, ногоон технологийг худалдан авах, эзэмших, хөгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийг дэмжихээр тусгажээ. Тус сангаас байгаль орчны бохирдлыг багасгах, эрчим хүчний хэрэглээг бууруулах, ус хамгаалах, хэмнэлттэй зарцуулалт бүхий аж үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /машин/ багаж хэрэгслийг төрөөс бодлогоор дэмжин, зохих хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр тусгасан ажээ.

- Үйлдвэрлэлийн дэд бүтцийн хөтөлбөрүүд: 2003 онд төр хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан сонгогдсон кластер/байршлуудад чанартай дэд бүтцийг бий болгох замаар дотоодын үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн Үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах төлөвлөгөөг /*Industrial Infrastructure Upgradation Scheme (IIUS)*/ баталж хэрэгжүүлсэн байна. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлсэнээс хойш 8 жилийн дараа буюу 2011 онд төлөвлөгөөнд үнэлгээ хийж, 2013 онд “Шинэчлэгдсэн Үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах төлөвлөгөө”-г /*Modified Industrial Infrastructure Upgradation Scheme (MIIUS)*/ баталсан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд Аж үйлдвэрийн парк, бүсүүд дэх үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр 8 үндсэн чиг үүрэг, функцийг хэрэгжүүлэх юм. Төлөвлөгөөний төслүүдийг мужийн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэрэгжүүлэх юм.
- Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс: Энэтхэгийн Үйлдвэрлэлийн бодлогын үндсэн зорилтуудын нэг нь улс даяар тэнцвэртэй

¹² National Manufacturing Policy (NMP)

үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих юм. Аж үйлдвэрлэлийн хөгжлийг урамшуулах үүднээс Төв засгийн газрын зүгээс олон төрлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг нэмэлтээр хэрэгжүүлсээр ирсэн. Энэтхэгийн Үйлдвэрлэлийн бодлогын өөр нэг зорилтот чиглэл бол дотоодын үйлдвэрлэлийн олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн чанартай дэд бүтцийг хөгжүүлэх юм. Эдгээрт чиглэсэн бодлого /төлөвлөгөө/ хөтөлбөрүүдээс дор оруулав. Үүнд:

- *Тээврийн татаасын хөтөлбөр “TSS” 1971-2013/“FSS” 2013:* Тус хөтөлбөрийг 1971 оны 7 сарын 23-нд танилцуулсан бөгөөд уулархаг, орж гарахад төвөгтэй газар нутгууд дахь үйлдвэр, аж ахуйн нэгжийн тээврийн зардалд татаас өгөх замаар газар зүйн хувьд илүү сайн нөхцөлтэй газар нутагт үйл ажиллагаа явуулдаг ижил төрлийн үйлдвэрүүдтэй өрсөлдөхүйц болгоход чиглэсэн юм. Энэхүү хөтөлбөр /Transport Subsidy Scheme/TSS/ нь 2013 оны 01 сарын 22-нд дууссан бөгөөд 2013 онд өөрчлөгдөн “Freight Subsidy Scheme (FSS)” нэртэйгээр батлагдсан байна.

Татаасын хувь хэмжээ нь үйлдвэрийн газар болон нэрлэсэн төмөр замын өртөө хооронд түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүн тээвэрлэх тээврийн зардлын 50% -аас 90%-ийн хооронд байна. Зүүн хойд мужуудад 90%, Баруун Бенгалийн Uttarakhand болон Darjeeling дүүргүүдэд 75, Зүүн хойд бүсэд 50% байна. Аж ахуйн нэгжүүд татаас авах хугацаа нь үйлдвэрлэл эхэлснээс хойш 5 жил хүртэл байна. Тээврийн татаасын хөтөлбөрийн хүрээнд 1971 оноос хойш ойролцоогоор 34,1 тэрбум рупигийн татаасыг олгоод байна. Үүнд 2013 оноос хойш олгосон 3,5 тэрбум рупигийн татаас мөн орж байгаа юм.

- *Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын татаасын хөтөлбөр, 2007:* Тус хөтөлбөр нь үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын 30%-д татаас олгох бөгөөд шинээр үйлдвэр байгуулах болон биетээр өргөтгөл хийхэд шаардагдах хөрөнгө оруулалтанд хамаарах юм. Энэ нь мөн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр юм. Татаасын дээд хэмжээ нь аж үйлдвэрийн салбарт 30 сая, үйлчилгээний салбарт 15 сая рупи байна.
- *Үндсэн хүүгийн татаасын хөтөлбөр:* Энэхүү хөтөлбөр нь үндсэн хөрөнгийн зээлийн 3%-д хүүгийн татаас олгодог бөгөөд тухайн аж ахуйн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ эхэлснээс хойш 10 хүртэл жилийн хугацаатайгаар олгодог байна.
- *Бүх талын даатгалын хөтөлбөр:* Энэхүү хөтөлбөр нь аж ахуйн нэгжийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ эхэлснээс хойших 10 хүртэл жилийн хугацаанд даатгалын нөхөн олговрыг 100 хувь төлөх хөтөлбөр юм.

Энэтхэг улс дахь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьсах (суурь) зардлын үнэ:


Судалгаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглагдаж буй үйлдвэрлэлийн хувьсах зардалд хамаарах цахилгаан, ус, түлш, шатахууны үнэ, түүний

сүүлийн жилүүдийн өсөлт бууралтыг харуулах албан ёсны статистик мэдээллийг Үндэсний статистикийн байгууллагын харьяа Статистикийн төв албанаас 2015 онд гаргасан “Эрчим хүчний тайлан”, Засгийн газрын харьяа Төлөвлөлтийн Хорооны 2014 оны “Төрийн эрчим хүч, нийтийн үйлчилгээний тайлан”, “Энэтхэгийн эрчим хүчний үнэ”-ийн IEEFA-ийн тайлан, “Байгалийн хийн үнийн судалгаа”, “Хийн үнийн шинэчлэлийн бодлого” судалгааны тайлан, “Үйлдвэрлэлийн салбарын усны бодлого, үнэ” судалгааны тайлан зэрэг мэдээллийн эх сурвалжаас холбогдох мэдээллийг түүвэрлэн боловсруулав.

- Цахилгаан, эрчим хүч:

Энэтхэг улс бол эрчим хүчний жижиглэнгийн үнийн хувьд дэлхийн хамгийн бага үнэ бүхий орны нэг бөгөөд 2011 оны хувьд 1 кВц эрчим хүчний үнэ 8 цент (USc) байгаа нь Европын хамгийн бага эрчим хүчний үнэ бүхий улстай харьцуулахад 50 хувиар бага байна. Үүнийг доорх зургаас харна уу.

Энэтхэгийн үндэсний эрчим хүчний үнийг дэлхийн дундаж үнэтэй харьцуулсан байдал 2011 он, (US цент/кВц)



Data: average prices from 2011 converted at mean exchange rate for that year

Эх сурвалж: IEA, EIA, National Electricity Boards, OANDA¹³

Судалгааны захиалгад дурдахдаа “бараа бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлдөг үйлдвэрлэлийн суурь зардал манай улсад нэлээд өндөр байгааг анхаарч, шийдвэрлэж өгөхийг төр засгаас хүсч байгаа”-г дурьдсан бөгөөд судалгаанд хамрагдсан улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын цахилгааны үнэ үйлдвэр, аж ахуйн нэгжид кВц тутамд 6.64 цент байгаа нь дэлхийн хэмжээнд эрчим хүчний үнэ хамгийн бага гэгдэж буй Энэтхэг, БНХАУ-тай харьцуулахад 1.36 центээр хямд үнэтэй байна.

Түүнчлэн Энэтхэгийн нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний 1/3-ийг Хөдөө аж ахуйн салбар болон айл өрх хэрэглэх бөгөөд хөдөө аж ахуйн салбар, өрхийн хэрэглээний цахилгааны үнэ нь үйлдвэрлэлийн ба худалдааны салбарын цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн төлдөг үнээс 2 дахин бага байна.

Тухайлбал, 2013-2014 онд Хөдөө аж ахуйн салбарын эрчим хүчний жижиглэнгийн үнэ 2.6 рупи, өрхийн хэрэглээний эрчим хүчний жижиглэнгийн

¹³ “Briefing Note: Indian power prices”, May 6 2014, Institute for Energy Economics and Financial Analysis

үнэ 3.9 рупи, хүчин чадлаасаа үл хамааран үйлдвэрлэлийн салбарын эрчим хүчний жижиглэнгийн үнэ 5.9 рупи, худалдааны салбарын эрчим хүчний жижиглэнгийн үнэ 6.3 рупи байна. Үүнийг доорх графикаас үзнэ үү.

Зураг 9. Энэтхэгийн цахилгааны жижиглэнгийн үнэ салбараар



Графикаас үзэхэд Энэтхэгийн аж ахуйн нэгжийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний үнэ дотроо бага болон өндөр хүчин чадалтай үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчний үнэ 0.4 рупигээр хямд байна.

Харин үйлдвэрлэлийн салбарт харьяалагдах хөдөө аж ахуйн салбарын цахилгааны үнэ үйлдвэрлэлийн бусад салбараас 3.3 рупигээр хямд байгаа нь үйлдвэрлэлийн салбарын цахилгааны үнээс 56 хувиар хямд гэсэн үзүүлэлтийг харуулж байна. Энэхүү графикаас үзэхэд Энэтхэг улс үйлдвэрлэлийн салбар тэр дундаа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж буй нь харагдана.

Хөдөө аж ахуйн болон өрхийн хэрэглээний цахилгаан, эрчим хүчний үнээс шалтгаалан цахилгаан эрчим хүч түгээлтийн компаниудад учирч буй алдагдлыг Засгийн газрын зүгээс тус компаниудад **хөдөө аж ахуйн болон өрхийн хэрэглээний цахилгааны үнийн татаас** өгөх замаар бууруулж байна.

Түүнчлэн цахилгааны эцсийн хэрэглэгчид хүрч буй дундаж тарифыг салбараар нь ангилбал хамгийн хямд үнэтэй цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь аж ахуйн нэгжийн хувьд хөдөө аж ахуйн салбар болон үйлдвэрлэлийн салбар хэвээр байх бөгөөд хөдөө аж ахуйн салбарын цахилгааны дундаж тариф 5 жилийн хугацаанд 1 кВц нь 78 пайсаас 153 пайса¹⁴ хүртэл бага хэмжээгээр тогтмол өсч, үйлдвэрлэлийн салбарын хэрэглэгчид очих цахилгааны дундаж тариф нь 1 кВц-т 420-492 пайса хүртэл мөн л бага хэмжээгээр тогтмол өссөн үзүүлэлт гарч байна.


Доорх зургаас харахад 5 жилийн хугацаанд тогтмол бага хэмжээний өсөлттэй үнийн бодлогодоо хөдөө аж ахуйн болон үйлдвэрлэлийн салбарын цахилгаан эрчим хүчний тарифыг төрөөс тогтмол барих бодлого баримталж байсан нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнэ болон тухайн жилийн инфляцийн өсөлтөөс хамааран цахилгаан эрчим хүчний үнийн дундаж тарифыг бага хэмжээгээр

¹⁴ Paisa буюу Энэтхэгийн мөнгөний нэгж.

жилээс жилд тогтмол өсгөхдөө үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн салбарын цахилгааны дундаж тарифыг бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх салбартай харьцуулахад бага үнэд барих бодлогоо урт хугацаанд баримталсан нь харагдаж байна.

Цахилгааны хэрэглэгчийн тариф ангилалаар (пайса/кВтц)
2007-2011 оны байдлаар



Эх сурвалж: Энэтхэгийн засгийн газар, Төлөвлөлтийн Хорооны 2011/12 оны тайлангаас

Цахилгаан эрчим хүчний алдагдал:

Энэтхэг улсын хувьд бусад орны адилаар эрчим хүчний үнийг тогтвортой барих төрийн бодлогоос үүдэлтэй эрчим хүч үйлдвэрлэж байгаа зардал болон эцсийн хэрэглэгчид худалдан борлуулж буй үнийн зөрүүнээс шалтгаалан эрчим хүч үйлдвэрлэх салбарт тодорхой хэмжээний алдагдал тогтмол үүсч байдаг.

Үнийг 2003-2010 хүртэлх 8 жилийн хугацаанд эрчим хүч үйлдвэрлэсэн зардал, худалдан борлуулсан үнийн дундаж харьцаанаас үзэхэд эрчим хүч үйлдвэрлэгч нь 15-25 хувийн алдагдал үүрч байгааг доорх хүснэгтэд үзүүлснийг судалгаанд хавсаргав.

Тухайлбал, 2003 онд эрчим хүч үйлдвэрлэсэн зардал нь кВтц нь 2.39 рупи байсан бөгөөд үйлдвэрлэсэн эрчим хүчээ борлуулсан дундаж үнэ нь 2.03 рупи байгаа нь эрчим хүч үйлдвэрлэгчдийн алдагдал 15 хувь байсан байна. Статистик мэдээллээс үзэхэд 2008 ба 2009 онуудад эрчим хүчний үйлдвэрлэлийн алдагдал харьцангуй өндөр байна. Өөрөөр хэлбэл, 2008 онд эрчим хүч үйлдвэрлэсэн зардал нь кВтц нь 3.40 рупи байж, харин худалдан борлуулсан дундаж үнэ нь 1 кВтц нь 2.63 рупи байснаар алдагдал 23%-д хүрсэн байна.

2009 онд эрчим хүч үйлдвэрлэсэн зардал нь 3.55 рупи байж, борлуулсан дундаж үнэ нь 2.68 рупи байснаар алдагдал нь 25% байсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээс үзнэ үү.

*Энэтхэгийн эрчим хүчний хангамжийн дундаж зардал болон
борлуулалтын дундаж үнийн харьцаа (рупигээр)¹⁵*

(Рупи/кВц) Жил	2003/4	2004/5	2005/6	2006/7	2007/8	2008/9	2009/10	2010/11
Эрчим хүчний хангамжийн зардал	2.39	2.54	2.60	2.76	2.93	3.40	3.55	3.78
Борлуулалтын дундаж үнэ	2.03	2.09	2.21	2.27	2.39	2.63	2.68	3.01
Эрчим хүчний зардалд борлуулалтын дундаж үнийн эзлэх хувь	85%	82%	85%	82%	82%	77%	75%	80%
Эрчим хүч үйлдвэрлэгчдийн алдагдал	15%	18%	15%	18%	18%	23%	25%	20%

Цаашдын чиг хандлага:

Эрчим хүчний салбар, тэр дундаа эрчим хүчний үнийн бодлогын хувьд импортын нүүрсний цахилгааны бөөний үнийг 2018 он хүртэл 1 кВц тутамд 5.41 рупигээс 5.73 рупид барих ерөнхий төлөв байгаа аж. Харин 2030 он хүртэл цахилгаан эрчим хүчний салбарт эх үүсвэрээс нь хамааран үнийн харилцан адилгүй бодлого баримталж байгааг дараах хүснэгтээс үзнэ үү.

Тариф (кВц тутамд Рупигээр)	2018	2020	2025	2030
Самичаел нүүрс ашиглан нийлүүлсэн	5.73	5.99	6.85	8.31
Альфа нүүрс ашиглан нийлүүлсэн	5.41	5.62	6.37	7.68
Салхин эрчим хүч	4.60	4.60	4.60	4.60
Нарны эрчим хүч*2015 ашиглалтад орсон	5.50	5.50	5.50	5.50
Нарны эрчим хүч**2018 ашиглалтад орно	4.00	4.00	4.00	4.00
Тарифын инфляци (жилээс жилд)				
Самичаел нүүрс ашиглан нийлүүлсэн	6.0%	2.3%	3.1%	4.9%
Альфа нүүрс ашиглан нийлүүлсэн	6.0%	2.0%	2.9%	4.8%
Нарны эрчим хүч-дефляцийн таамаг	10.0%			
Импортын нүүрсний зардал болон сэргээгдэх эрчим хүчний зардлын хамаарал				
Салхин ЭХ болон Импортын нүүрс	80%	77%	67%	55%
Нарны ЭХ болон Импортын нүүрс 2015	96%	92%	80%	66%
Нарны ЭХ болон Импортын нүүрс 2018	70%	67%	58%	48%

Хүснэгтээс үзэхэд Сэргээгдэх эрчим хүчний тарифыг 2030 он хүртэл тогтмол байхаар Энэтхэгийн Засгийн газраас тооцоолсон бөгөөд импортын нүүрс ашиглан нийлүүлсэн цахилгааны үнийг 2030 он гэхэд 7.68-8.31 рупи байхаар тооцоолсон байна. Түүнчлэн 2018 он хүртэл нарны эрчим хүчний суурилуулалтын зардалд олгох 30%-ийн дэмжлэгийн үр дүнд 2018 онд ашиглалтад орох нарны эрчим хүчний тарифыг 1кВц нь 4.00 рупи байхаар тооцоолсон байна.

¹⁵ "Briefing Note: Indian power prices", May 6 2014, Institute for Energy Economics and Financial Analysis

* -Нарны эрчим хүч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын зээлийн урьдчилгаа 30%-ийг Энэтхэгийн Нарны Эрчим хүчний Корпорациас дэмжлэг олгон 2015 онд ашиглалтад орсон.

** Нарны эрчим хүч үйлдвэрлэх салбарт Энэтхэгийн Нарны Эрчим хүчний Корпорациас хөрөнгө оруулалтын 30%-ийн дэмжлэгээр 2018 онд ашиглалтад орно.

Мөн Энэтхэг нүүрсний хэрэгцээгээ дотоодоос хангаж чадахгүй байгаагаас шалтгаалан Австралийн Квийнсланд мужаас нүүрсний хэрэгцээнийхээ дийлэнх хувийг импортолдог бөгөөд нарны эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэнээр импортын нүүрсээр нийлүүлсэн эрчим хүчний зардлыг 30 хувиар багасна гэж төлөвлөсөн байна.

Тус улсын хувьд эрчим хүчний салбарт баримталж буй бодлогын хэтийн төлөв, цаашдын чиг хандлага нь сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг эрчимтэйгээр нэмэх, импортын нүүрсний хэмжээг бууруулахад чиглэж байна. Энэтхэгийн Засгийн газраас нарны эрчим хүчний үйлдвэрлэлд зориулж анхны суурилуулалтын зардлын 30%-ийг хөрөнгө оруулалтын дэмжлэг болгон олгосноор 2015 онд ашиглалтад орсон нарны эрчим хүчний үнийг 1кВц нь 5.50 рупигээр тогтоож чадсан байна.

Энэтхэгийн Засгийн газраас нарны эх үүсгэвэрээс гарган авч буй сэргээгдэх эрчим хүчний салбарт олгох 30% татаасыг 2020 он хүртэл олгосноор нарны эрчим хүчний салбар цаашдаа урт хугацаанд татаасгүйгээр ашигтай ажиллах боломжтой гэж тооцоолжээ. Нарны эрчим хүчний анхны суурилуулалтын зардлын 30%-д дэмжлэг олгох тус бодлогын үр дүнд сүүлийн 3 жилд нарны эрчим хүчний зардал 65%-аар буурсан байна.

Энэ бүхнээс үзэхэд Энэтхэг улсад цахилгаан, эрчим хүчний салбарт Засгийн газрын зүгээс:

- ХАА салбар болон өрхийн хэрэглээний цахилгааны татаасыг эрчим хүч түгээгчид Сэргээгдэх эрчим хүчний салбарын ашигтай ажиллагааг нэмэгдүүлж байна.
- Нарны эрчим хүчний суурилуулатын зардлын 30% үйлдвэрлэгчдэд дэмжлэг татаас олгох замаар цахилгаан, эрчим хүчний салбарын алдагдлыг бууруулж, улмаар сэргээгдэх эрчим хүчний салбарын ашигтай ажиллагааг нэмэгдүүлж байна.

Үйлдвэрлэлийн салбар дахь усны бодлого:

Энэтхэгийн үйлдвэрлэлийн салбар нь усны хоёр дахь том хэрэглэгч юм. Үйлдвэрлэлийн салбарт хэрэглэж буй усны гол эх үүсвэр нь гүний болон гадаргын ус байна. Усны үнийн хувьд аль эх үүсвэрээс усны хэрэглээг хангаж байгаагаас шалтгаалан харилцан адилгүй бөгөөд энэ нь усны хүрэлцээ, хангамжийн асуудалтай шууд хамаарна.

Үйлдвэрлэлийн процесст ус ашиглаж буй үйлдвэрлэгч нь гадаргын усны урсгал зардлыг ихэвчлэн ус нийлүүлж буй хотын захиргаанд төлдөг бол, гүний усны зардал нь олборлолтын эрчим хүчний зардлаар тооцогддог. Ус, цахилгаан, шатахуун зэрэг бүхий л орцын үнийг Засгийн газраас удирдаж, зохицуулдаг бөгөөд ингэснээр усны үр ашиггүй зарцуулалт хэвийн хэмжээнд хадгалагдах болсон байна.

Түүнчлэн Энэтхэгт хотын захиргааны зүгээс нийлүүлдэг гадаргын ус хангалтгүйгээс үйлдвэр аж ахуйн нэгжүүд гүний уснаас хамааралтай байх хандлагатай болжээ. Тус улсад үйлдвэрлэлийн салбар хөгжихийн хэрээр үйлдвэрлэлийн усны эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна.

- Тоон үзүүлэлт:

Энэтхэгт үйлдвэрлэлийн салбар дахь усны хэрэглээг нарийн тооцсон тоон үзүүлэлт ховор бөгөөд чиглэл чиглэлийн агентлагууд нь өөр өөрсдийн чиглэлээр үйлдвэрлэлийн салбар дахь ус ашиглалтын талаарх ялгаатай тайлангуудыг гаргадаг байна. Жишээ нь, *Усны Нөөцийн Яамны* мэдээллээр “Цэвэр усны нийт нөөцийн 6 хувийг үйлдвэрлэлийн салбарт зарцуулсан” гэж үзэж байгаа гэж бол, *Бохирдлын Хяналтын Төв Зөвлөлийн (СРСВ)* тайланд энэ үзүүлэлтийг 8 хувь гэсэн байна.

Харин Дэлхийн банкны зүгээс Энэтхэгийн үйлдвэрлэлийн салбар дахь ус ашиглалтыг тооцоолсноор, Энэтхэг улсын цэвэр усны нийт нөөцийн 13 хувийг үйлдвэрлэлийн салбарт зарцуулсан бөгөөд энэхүү хэрэглээ цаашид жил тутамд 4.2 хувиар өсч, 1999 онд 67 тэрбум м³ байсан хэрэглээ 2025 он гэхэд 228 тэрбум м³ болно гэжээ. Эдгээр бүх тооцооллоос харахад Энэтхэгийн үйлдвэрлэлийн салбарын усны хэрэгцээ тийм ч бага биш бөгөөд цаашид ч хурдацтай нэмэгдэх хандлагатай байна.

- Чанарын үзүүлэлт:

Үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн процесст усыг ашиглаад зогсохгүй, мөн бохирдуулдаг. Дэлхийн банкны 2003 оны тайлангаар, хөгжиж буй орнуудад, үйлдвэрийн бохирдолын 70 хувийг боловсруулж, цэвэршүүлэлгүй хаядаг ба үүнээс шалтгаалан ашиглаж болохуйц ус ихээр бохирлогдон хаягддаг байна.

Үйлдвэрлэлийн салбар дахь усны хэрэглээ нь бусад салбаруудын усны хэрэглээ ашиглалттай огтхон ч адилгүй бөгөөд, усны нөөцийн маш том хэсгийг үйлдвэрлэлд ашиглаж, тэр хэрээрээ буцаад усны бохирдлыг ч нэмдэг байна. *Шинжлэх Ухаан, Хүрээлэн буй Орчны Төв-ийн (CSE)* тайланд дурдсанаар 1 литр ашигласан ус нь дунджаар 5-8 литр цэвэр усыг бохирдуулдаг ба энэ нь үйлдвэрлэлийн салбарын ус ашиглалт нь нийт ашигласан усны хэмжээнд эзлэх хувийг 35-50 хувь хүртэл өсгөж байна гэж үзжээ.

Энэ нь үйлдвэрлэлийн салбар дахь ус ашиглалтын хэмжээг тооцоолохдоо зөвхөн усны хэрэглээг тооцоод зогсохгүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, ундны болон бусад чиглэлээр ашиглах боломжгүй болсон усыг оруулан тооцох нь зүйтэй гэж үзэхэд хүргэжээ.

Үйлдвэрийн хаягдал нь цэвэр болон дахин ашиглах боломжтой усыг бохирдуулж байгаа нь усны бусад хэрэглээг хязгаарлахын зэрэгцээ усны үр ашигтай хэрэглээг улам бүр бууруулсаар байгаа нь Энэтхэг улс үйлдвэрлэлийн усны бүтээмжийн үзүүлэлтээр дэлхийд хамгийн доогуур түвшинд буюу 1м³ усны бүтээмж 3.42 ам.доллар байна.

- Энэтхэгийн үйлдвэрлэлийн усны үнийн шинэтгэлийн бодлого:

Ус нь үйлдвэрлэлийн бүхий л салбарт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орц байдлаар ашиглагддаг. Үйлдвэрлэлийн орц болон эцсийн бүтээгдэхүүн хоорондын хамаарлыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эдийн засгийн онолоор тайлбарлана. Үүнээс үйлдвэрлэлийн ус ашиглалт, эрэлтийн үнийн мэдрэмж, түүний уян хатан байдал зэргийг тооцдог.

Үйлдвэрлэлийн салбар нь ахуйн хэрэглээг бодвол ямар ч чанарын усыг ашиглах боломж, сонголт ихтэй байдаг ба хуримтлуулсан ус, цэвэршүүлсэн ус, дахин боловсруулсан ус зэргийг ашиглах боломжтой юм. Гэсэн хэдий ч, үйлдвэрийн газруудын төлж буй усны үнэ нь эрэлт ихэсэхэд их хэмжээгээр нөлөөлдөг байна.

Энэтхэгт усны зардал дараах 3 бүрдэл хэсгүүдээс тогтдог. Үүнд:

- Бохирдлын Хяналтын Зөвлөлд төлдөг Усны орон нутгийн татвар;
- Ус нийлүүлэгчид буюу орон нутгийн Захиргаанаас ус худалдан авах зардал;
- Гол мөрөн болон газрын гүнээс ус олборлох зардал зэрэг орно.

Усны орон нутгийн татварын тухай¹⁶ хуулиар үйлдвэрлэлийн салбар нь ус ашигласны төлбөр төлөх ёстойг заасан байдаг. Тухайлбал, үйлдвэрлэлийн усны хэрэглээгээр хамгийн их хувийг эзэлдэг голлох 2 салбар болох цаас, цаасан бүтээгдэхүүний болон ган, төмрийн үйлдвэрлэлд 2004 онд усны орон нутгийн татварыг шинээр тогтоосон нь 0.1-0.2 хувь бөгөөд энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нийт өртгийн 0.02-0.05 хувьтай тэнцэж байсан нь “усны үнийн бодлого маш муу байна” гэж дүгнэхэд хүрчээ.

Усны үнийн бодлого маш муу байгаа нь үйлдвэрлэлийн салбарт усыг үр ашиггүй зарцуулах гол шалтгааны нэг болж байна гэж үзэн 2012 онд Энэтхэгийн Усны Нөөцийн Яамнаас “Үндэсний усны бодлого”-ыг батлуулсан бөгөөд тус бодлогын баримт бичгийн 7-д усны үнийг тогтооход баримтлах бодлогыг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

7.1. Усны үнийг тогтооходоо усыг үр ашигтай, аривч хямагч ашиглахыг урамшуулан дэмжих зарчмаар тогтооно. Ундны ус болон ариутгалын зориулалтаар ашиглах ус, Хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрлэлийн салбарын усны үнийг тогтооходоо бүх оролцогч талууд, муж бүрийн төлөөлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Усны Зохицуулах Газарт ирүүлсэн саналыг үндэслэн тогтооно.

гэж заасан байна. Энэ зарчимд үндэслэн тогтоосон усны үнэ тариф нь 2014 оны байдлаар:

<i>Усны тариф ангилалаар (Рупи/Килолитр*)</i>	
<i>Худалдааны салбар</i>	0-15 кл хэрэглээнд 1 кл тутамд 40 рупи
	16-100 кл хэрэглээнд 1кл тутамд 70 рупи
	101-200 кл хэрэглээнд 1 кл тутамд 100 рупи (ус зайлуулах хоолойны 35%-ийн татваргүйгээр)
<i>Үйлдвэрлэлийн салбар</i>	0-15 кл хэрэглээнд кл тутамд 50 рупи + 35% татвар**
	16-100 кл хэрэглээнд кл тутамд 80 рупи + 35% татвар
	101-200 кл хэрэглээнд кл тутамд 120 рупи + 35% татвар
<i>Усанд суурилсан аж үйлдвэр</i>	GHMC-ээс гадна бүсэд кл тутам 200 рупи + 35% татвар
	GHMC бүсэд кл тутамд 240 рупи 35% татваргүй

*-1кило литр нь 1000 литртэй тэнцэнэ.

** - 35% татвар нь ус зайлуулах хоолойны татвар

Түүнчлэн Энэтхэгийн усны салбарын судлаач Kumar (2006) өөрийн судалгаагаар, Энэтхэгийн голлох ус бохирдуулагч үйлдвэрлэлийн

¹⁶ Water Cess Act, 1977 (Prevention and Control of Pollution)

салбаруудад ашиглагдсан усны сүүдрийн үнийг (*shadow price*) тооцох замаар усны боломжит өртгийг тооцсон байна¹⁷.

Сүүдрийн үнэ нь ус гэх мэт хязгаарлагдмал нөөцийн ашиглалтанд үйлдвэрийн газруудаас төлөх хамгийн дээд үнэ юм. Сүүдрийн үнийг тооцохоор, үйлдвэрийн газруудын төлж байгаа усны үнэ болон төлбөл зохих усны үнэ хоёрын хооронд зөрүү их байгааг тогтоосон.

Сүүдрийн үнэ нь үйлдвэрлэлийн салбаруудаас шалтгаалан кл тутамд 1.16-30.53 рупигийн хооронд хэлбэлзэлтэй байхаар байгааг тогтоосон байна. Энэхүү хэлбэлзэл нь үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүний борлуулалтын үнэд эзлэх ус ашиглалтын түвшний ялгаагаар буюу усны хүчин чадлын хэмжээгээр тодорхойлогдсон байна. Сүүдрийн үнэ болон усны хүчин чадлын хоорондын хамаарлын коэффициент 0.32 байгаа ба усны хүчин чадлын үзүүлэлт кл/гарцын нэгж (сая рупи) нь 1-ээс илүү байх үйлдвэрүүдэд энэхүү хамаарлын коэффициент 0.68, усны хүчин чадлын үзүүлэлт кл/гарцын нэгж (сая рупи) нь 1-ээс бага байх үйлдвэрүүдэд энэхүү хамаарлын коэффициент 0.14 байна. Энэ нь усны хүчин чадал өндөр бол сүүдрийн үнэ өндөр болохыг илэрхийлж байна. Түүнчлэн, үйлдвэрлэл дэх усны хомсдол нь үйлдвэрлэлийн гарцын алдагдлаас хамаарсан бүтээгдэхүүний өртгийг тогтоодог болохыг илэрхийлж байна.

- Үйлдвэрлэлийн усны бодлого зохицуулалт, сорилт:

Үйлдвэрлэлийн усны менежмент дахь асуудлууд нь: *Нэгдүгээрт*: Үр нөлөө бүхий бодлого, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй бөгөөд дутагдалтай. *Хоёрдугаарт*: Үйлдвэрийн газруудад усыг үр ашигтай ашиглахад чиглэсэн урамшуулал бага.

Усны тариф маш бага, энэхүү тарифт олон хүчин зүйлүүдийг орхигдуулан тооцсон байдаг. Үр дүнд нь, үйлдвэрийн газрууд болон орон нутгийн бусад хэрэглэгчдийн хооронд усны хүртээмж, хуваарилалт, ус бохирдуулахтай холбоотой зөрчилдөөн үүсдэг.

Үүнд үйлдвэрлэлийн ашиглалтаас шалтгаалсан гүний усны нөөц хомсдож байгаа асуудал, Засгийн газрын зүгээс үйлдвэрийн газруудад давуу эрх олгосон хандлага зэрэг нь ус ашиглалттай холбоотой зөрчлүүдийн үндсэн шалтгаан болдог байна. Энэтхэгт эдийн засгийн салбар бүр хурдацтай хөгжиж байгаа нь дотоодын, хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн салбарын усны хэрэгцээг ихэсгэж байна.

Энэтхэгт харилцан адилгүй чиг үүрэг бүхий олон байгууллагууд, яамдууд усны бодлого зохицуулалтанд оролцдог. Жишээ нь, Усны нөөцийн яам нь Энэтхэгийн усны бодлогод үндсэн үүргийг хүлээдэг гол байгууллага нь хэдий ч усны бохирдлын асуудал, үйлдвэрлэлийн усны ашиглалтын асуудал чиг үүрэгт нь хамаардаггүй байна. Мөн Үйлдвэрийн Яам нь үйлдвэрлэлийн салбар дахь ус ашиглалтын төлөвлөгөө, хэрэгжүүлэлтийг хариуцан ажилладаг ч, мөн л үйлдвэрлэлийн ус ашиглалтанд хяналт тавих, зохицуулалт хийх чиг үүргийг хүлээдэггүй. Гүний Усны Төв Зөвлөл нь улсын хэмжээнд гүний усны чанар, хэмжээнд зохицуулалт хийдэг ч, мөн л үйлдвэрлэлийн салбар дахь гүний усны зохицуулалтыг хариуцдаггүй байна. Бохирдлын хяналтын төв зөвлөл

¹⁷ Kumar (2006) өөрийн судалгаандаа Эдийн засгийн өсөлтийн хүрээлэнгээс гаргасан ус бохирдуулагч үйлдвэрүүдийн жишээг ашиглан мэдээлэл цуглуулсан. Murty and Kumar (2004).

болон мужийн зөвлөлүүд нь үйлдвэрлэлийн усны бохирдолд зохицуулалт хийж, усны орон нутгийн төлбөрийг авдаг боловч усны эх үүсвэрийн хяналт зохицуулалтанд эрх үүрэг хүлээдэггүй байна. Үр дүнд нь, ус хамгаалал болон усны бохирдлын хяналтын тогтолцоо нь тодорхой үр дүнтэй байж чадахгүй байна.

- Гүний усны бодлого зохицуулалт:

Энэтхэгт одоогоор үйлдвэрлэлийн ялгаатай салбарууд дахь усны хэрэгцээг тодорхойлсон, зохицуулсан хууль байхгүй байна. Бохирдлын Хяналтын Төв Зөвлөлөөр зарим үйлдвэрийн салбаруудын усны хэрэглээний түвшинг тогтоодог бөгөөд энэ нь хуулийн адил хүчин чадалтай байж чаддаггүй, мөн гүний усны олборлолттой холбогдох хуулиуд нь шаардлага хангахгүй байгаа талаар салбарын судалгаанд дурьдсан байна. Уг хуулийн дагуу, газар өмчилж буй хүн тухайн газрын доорх гүний усыг мөн өмчлөх эрхтэй байхаар заасан байна. Энэ хуульд үндэсний хэмжээний гүний усны ашиглалтанд хамааралтай зарим заалтууд байдаг ч үйлдвэрлэлийн болон арилжааны ус ашиглалттай логик хамаарал багатай байна. Энэ мэт хууль эрх зүйн хангалтгүй зохицуулалтаас улбаалан, үйлдвэрлэлийн салбар дахь гүний усны ашиглалтын асуудал хуулийн зохицуулалтгүй, өртөг тооцох боломжгүй байдаг.

- Үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт:

Үйлдвэрээс гол руу бохир усаа шууд нийлүүлж буй нь хүн амын эрүүл мэндийн олон асуудлын шалтгаан болж байгаагийн дээр голын дагуу ажиллаж амьдарч буй ХАА-н үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний алдагдлын үндсэн шалтгаан болдог байна. Үйлдвэрүүд хаягдлын хяналтын тоног төхөөрөмжинд хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай байна. Үйлдвэрүүдийг өөрсдийн усны хэрэглээгээ бууруулахад нь хууль эрх зүйн зохицуулалт, Засгийн газрын санаачилга ихээхэн нөлөө үзүүлэх юм. Үйлдвэрлэл дэх ус ашиглалт болон усны бохирдлыг усны үнийн зөв бодлогоор дамжуулан буулгах боломжтой юм. Байгалийн нөөцийн зохистой үнийн бодлого, зохистой удирдлагыг бий болгох нь усны менежментийн үр нөлөөг бий болгоход шууд нөлөөтэй юм.

- Үйлдвэрлэлийн хаягдал усны менежмент:

Дийлэнхдээ үйлдвэрлэлээс гарч буй хаягдал усыг боловсруулах систем нь холбогдох норм стандартад үндэслэгдсэн ба усны хэмжээнд агуулагдах бохирдлын эзлэх хувиар нь тооцдог байна. Иймээс үйлдвэрийн газрууд хаягдал усны стандартыг хангахын тулд үйлдвэрийн бохир усандаа цэвэр усыг хольж, бохирдлын эзлэх хувийг бууруулах аргыг хэрэглэдэг байна. Усны үнэ маш бага учраас эдийн засгийн хувьд үйлдвэрийн бохир усанд цэвэр усыг холих нь үйлдвэрлэлийн бохир усыг дахин боловсруулах, улмаар үйлдвэрлэлд дахин боловсруулсан цэвэр ус ашиглахаас илүү хямд тусдаг байна. Үйлдвэрүүд хаягдал усыг дахин боловсруулах, дахин ашиглах талаар санаачилга гаргадаггүй бөгөөд хаягдал усыг дахин ашиглах боломжтой байсан ч ашиглалгүйгээр, усыг нэг л удаа ашигладаг байна. Эдгээрийн үр дүнд үйлдвэрлэлд огт ашиглагдаагүй, бохирдоогүй цэвэр усыг үйлдвэрлэлийн бохир устай холих маягаар үр ашиггүй зарцуулж, усны нөөцийг хий дэмий үрсээр байна.

Энэтхэгийн үйлдвэрлэлийн салбар дахь усны эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байна. Түүнчлэн, үйлдвэрлэлийн салбар дахь ус ашиглалтын хоцрогдсон технологи, ашигласан усыг дахин боловсруулах, дахин ашиглах туршлага дутмагаас шалтгаалан үйлдвэрлэлийн салбар дахь усны хэрэглээ тулгамдсан асуудал болж байгаа аж. Үйлдвэрлэлийн салбар дахь хаягдал усыг дахин боловсруулах хэрэгцээ шаардлага, үүнээс урган гарч буй асуудлуудын талаарх мэдлэг мэдээлэл хангалтгүй байна. Усны нөөцийг хадгалах, хамгаалах, үүнтэй холбоотой хариуцлагыг өндөржүүлэх, бохирдлыг зөв тооцоолох, усны алдагдлыг хамгийн бага түвшинд хүртэл бууруулах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үздэг байна.

- Үйлдвэрлэлийн усны бодлогын цаашдын чиг хандлага:

Үйлдвэрлэлийн усны бодлоготой холбогдох зарим асуудлуудыг Үндэсний Усны Бодлогын (*National Water Policy (NWP) 2012*) баримт бичигт тусгасан бөгөөд усны нөөцийн үр ашигтай удирдлага, технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хаягдлыг дахин боловсруулах, усыг нэг удаа ашиглахаас илүүтэй боловсруулсан усыг дахин ашиглах, боловсруулсан усны ашиглалтын эргэлтийн тоог нэмэгдүүлэх, борооны усыг хуримтлуулах, хаягдлыг хамгийн бага түвшинд байлгах замаар зохицуулна гэжээ.

Байгалийн хий:

Энэтхэг улсын хувьд байгалийн хийн нийт хэрэглээний 35.2%-ийг эрчим хүчний салбарт, 35.9% -ийг өтөг бордооны салбарт, 7.7%-ийг хотын хэрэглээнд, 2.8% жижиг хэрэглэгчид, 1.3%-ийг төмөр болон гангийн үйлдвэрлэлд, 4.1%-ийг петрохимийн үйлдвэрлэл, 13 %-ийг бусад салбарт хэрэглэж байна. Байгалийн хийн үнийн бодлогын хувьд үнийн бодлогын дэглэмээс хамааран харилцан адилгүй байх бөгөөд 2014 оны Энэтхэгийн Засгийн газрын тайланд дурьдсныг хүснэгтээр үзүүлэв.

Өөр өөр дэглэм дэх Байгалийн хийн үнэ
(US\$/MMBtu)

Үнийн дэглэм	Үнэ
Nomination Regime (APM)	\$4.20
Discovered Fields (Pre NELP) Regime	\$3.50 – \$5.73
NELP Regime	\$4.20
LNG Spot	\$12.52 - \$17.44
LNG Үрт хvгацааны гэрээ	\$6.97 - \$9.06

$$\text{Domestic Gas Price} = \frac{V_{HH} * P_{HH} + V_{AC} * P_{AC} + V_{NBP} * P_{NBP} + V_R * P_R}{V_{HH} + V_{AC} + V_{NBP} + V_R}$$


- Байгалийн хийн үнийн шинэчилсэн бодлого:

2014 оны 10-р сарын 18-нд Энэтхэгийн Засгийн газраас байгалийн хийн үнийн бодлогод шинэчлэл хийсэн бөгөөд ингэхдээ “Rangarajan”-ны томъёонд тулгуурлан нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэсэн хэдий ч 2015 оны байдлаар дээр дээр дурьдсан үнэ үйлчилсэн хэвээр байсан байна.

Шинэчилсэн томъёо нь:

- VNH - АНУ, Мексик хэрэглэдэг байгалийн хийн жилийн нийт хэмжээ
- VAC - Канад улсад хэрэглэдэг байгалийн хийн жилийн нийт хэмжээ
- VNBP - Европын холбоо болон FSU хэрэглэдэг байгалийн хийн жилийн нийт хэмжээ, ОХУ-ын гаргасан
- VR - ОХУ-д хэрэглэдэг байгалийн хийн жилийн нийт хэмжээ
- PNH ба PNBP - НН болон NBP дэх өдөр тутмын үнийн жилийн дунджийг илэрхийлнэ.

Энэтхэгийн байгалийн хийн үнэ ба олон улсын байгалийн хийн үнэ




USD/MMBtu (1997-2014)

Зургаас харахад Энэтхэгийн байгалийн хийн үнэ бусад улсын байгалийн хийн үнэтэй харьцуулахад харьцангуй тогтвортой бөгөөд 1997 оноос 2007 он хүртэл 1.8-2 USD-ийн хооронд тогтвортой байсан бөгөөд 2009-2010 онд 4 USD болж огцом өсч, улмаар 2010-2013 онд хүртэл үнэ тогтмол 4USD байсан байна. Харин 2013-2014 онд 5USD рүү өссөн дүн гарчээ.

2.4 ТАЙВАНЬ УЛСЫН ТУРШЛАГА

Тайвань нь эрчим хүчний нөөцгүйн улмаас импортоос шууд хамааралтай байдаг. Иймд Засгийн газраас цэвэр, тогтвортой мөн бие даасан эрчим хүчийг бий болгох, эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчин хамгаалал, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар мөн нүүрс хүчлийн хийг бууруулах зэргийн тэнцвэр уялдаа холбоог тодорхой хөтөлбөр, стратегийн хүрээнд хангахыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон байна.

Зураг: Эрчим хүчний аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт 2014 он
Импортын эрчим хүчнээс хамаарах хамаарал



Ойрхи дорнодын импортын газрын тосноос хамаарах хамаарал (%)


(Эх үүсвэр: Эрчим хүчний статистик 2014, Эрчим хүчний Хороо, Тайвань)

2008 оны байдлаар Тайвань нь эрчим хүчнийхээ 99.23%-ийг импортоор авч байгаа нь тус арлын эрчим хүчийг гадаад орчноос шууд хамааралтай болгож байна. Энэхүү хамаарлыг бууруулах зорилгоор Эдийн засгийн яамны харья Эрчим хүчний хороо нь 1990-ээд оноос хойш хэд хэдэн их сургуулиудад эрчим хүчний суурь судалгаануудыг хийлгэж ирсэн байна.

• Эрчим хүчний эх үүсвэрийн бүтэц:

2014 оны байдлаар Тайванийн нийт эрчим хүчний 48.5%-ийг газрын тос, 29.2%-ийг нүүрс, байгалийн хий 12.2%, цөмийн эрчим хүч 8.3%, биомасс болон хаягдал 1.2%, бусад сэргээгдэх эрчим хүч 0.5%-ийг тус тус эзэлж байна. Тайвань нь 6 атомын цахилгаан станцтай.

Тайванийн эрчим хүчний эх үүсвэрийн бүтэц
(2014 оны байдлаар)



Эрчим хүч үйлдвэрлэх өртөг нь 7.0 цент/кВ байгаа бөгөөд үүний 1.9 цент/кВ нь цөмийн эрчим хүч, 5.8 цент/кВ нь нүүрс, 11.25 цент/кВ нь байгалийн хий эзэлж байна.

• Цахилгааны үнэ, тариф

Эдийн засгийн яам нь Тайвань Power Co. (Taipower)-аас гаргасан улсын цахилгаан эрчим хүчний үнийг бууруулах төлөвлөгөөг баталсан байна. 2015 оны 4-р сарын 1-нээс эхлэн цахилгааны дундаж үнийг айл өрхийн хувьд 7.55 хувь, үйлдвэрлэлийн хувьд 7.31 хувь, аж ахуйн нэгжийн хувьд 7,36 хувиар тус тус бууруулсан байна.

Шинэ үнэ нь дунджаар киловатт-цаг тутамд 2.8852 тайвань доллар (0.09 ам.доллар), өмнөх үнэ 3.1139 тайвань доллар (0.10 ам.доллар)-аас 7.34%-р буурсан байна. Сард 330 кВт.ц болон түүнээс доош хэрэглээтэй айл өрх, жижиг аж ахуйн нэгжүүд хөнгөлөлт эдлэх боломжтой бол 1001 кВт.ц дээш хэрэглээтэй айл өрх болон 1501 кВт.ц дээш хэрэглээтэй үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хөнгөлөлт эдлэхгүй юм.

*Нефтийн бүтээгдэхүүний үнэ
(2015 оны 5-р сарын байдлаар, тайвань доллар)*

品名 Item	單位 Unit	售價 (含營業稅 5 %) Sales Prices (including business tax)	備註 Notes	
液化石油氣 LPG	家庭用散裝 For Household, in Bulk	公斤 (kg)	24.96	
98無鉛汽油 Unleaded Gasoline #98	批發 Wholesale	公升 (l)	27.02	
95無鉛汽油 Unleaded Gasoline #95	批發 Wholesale	公升 (l)	25.22	
92無鉛汽油 Unleaded Gasoline #92	批發 Wholesale	公升 (l)	23.72	
酒精汽油 Gasohol	批發 Wholesale	公升 (l)	25.22	
煤油 Kerosene	散裝 In Bulk	公升 (l)	31.50	
超級柴油 Super Diesel Oil	批發 Wholesale	公升 (l)	23.02	
甲種漁船用油 Fishing Boat Fuel Oil (A)	散裝 In Bulk	公秉 (kl)	17,193	供漁船
			16,540	供民營漁船站
乙種漁船用油 Fishing Boat Fuel Oil (B)	散裝 In Bulk	公秉 (kl)	12,278	供漁船
			11,625	供民營漁船站
甲種低硫燃料油 (S : 0.5%) Low Sulphur Light Fuel Oil	散裝 In Bulk	公秉 (kl)	16,679	
低硫燃料油 (S : 0.5%) Low Sulphur Fuel Oil	散裝 In Bulk	公秉 (kl)	15,426	

Эрчим хүчний тариф, татварын хувь хэмжээ

項目 Item	進口稅 Import Tariff			推廣費 服務費 Tende Promotion Service Fee	貨物稅 Excise Tax	石油基金 Petroleum Fund	土壤地下水 污染費 Soil and Groundwater Pollution Remediation Fee	空氣污染 控制費 Air Pollution Control Fee	加價稅 附加稅 Value Added Tax
	第一欄 Column I	第二欄 Column II	第三欄 Column III						
原油 Crude Oil	0%	0%	2.5%	0.04%	免稅 (Free)	109 NT\$/KL	0 NT\$/T	-	5%
燃料油 Fuel Oil	5%	0%	5%	0.04%	0.11 NT\$/L	137 NT\$/KL	10 NT\$/T	-	5%
煤油 Kerosene	0%	0%	15%	0.04%	4.25 NT\$/L	133 NT\$/KL	0 NT\$/T	-	5%
航空煤油-煤油型 Kerosene Type Jet Fuel	0%	0%	15%	0.04%	0.61 NT\$/L	133 NT\$/KL	0 NT\$/T	-	5%
液化石油氣 LPG	0%	0%	7.5%	0.04%	0.69 NT\$/KG	151 NT\$/T	(丁烷 Butane)/10 NT\$/T	-	5%
汽油 Gasoline	0%	0%	15%	0.04%	6.83 NT\$/L	169 NT\$/KL	12 NT\$/T	0.2 NT\$/T	5%
柴油 Diesel Oil	0%	0%	15%	0.04%	3.99 NT\$/L	144 NT\$/KL	12 NT\$/T	0.2 NT\$/T	5%
天然氣 Natural Gas	0%	0%	7.5%	0.04%	-	-	-	0 NT \$	5%
燃料煤 Steam Coal	0%	0%	0%	0.04%	-	-	-	-	5%
原料煤 Coking Coal	0%	0%	0%	0.04%	-	-	-	-	5%
電力 Electricity	-	-	-	-	-	-	-	-	5%

Нефтийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт
(2008-2014 тайвань доллар)

品名 Item	單位	民國97年 2008	民國98年 2009	民國99年 2010	民國100年 2011	民國101年 2012	民國102年 2013	民國103年 2014
液化石油氣 LPG	公斤 (kg)	16.46	24.46	28.46	27.86	30.06	34.91	28.46
98無鉛汽油 Unleaded Gasoline #98	公升 (l)	22.60	31.40	33.00	32.80	36.80	37.80	28.50
95無鉛汽油 Unleaded Gasoline #95	公升 (l)	21.10	29.90	31.50	31.30	34.80	35.80	26.50
92無鉛汽油 Unleaded Gasoline #92	公升 (l)	20.40	29.20	30.80	30.60	33.30	34.30	25.00
酒精汽油 Gasohol	公升 (l)	21.10	29.90	31.50	31.30	34.80	35.80	26.50
煤油 Kerosene	公升 (l)	29.50	36.50	39.00	41.50	41.50	41.80	29.50
超級柴油 Super Diesel Oil	公升 (l)	17.10	26.80	28.60	28.80	32.10	33.20	23.00
高級柴油 Premium Diesel Oil	公升 (l)	17.10	26.80	28.60	28.80	32.10	33.20	23.00
甲種漁船用油 Fishing Boat Fuel Oil (A)	公秉 (kl)	9,893	19,593	21,393	21,593	24,893	25,993	15,793
乙種漁船用油 Fishing Boat Fuel Oil (B)	公秉 (kl)	4,978	14,678	16,478	16,678	19,978	21,078	10,878
甲種低硫燃料油 Low Sulphur Light Fuel Oil	公秉 (kl)	11,092	18,031	19,044	21,562	22,559	22,539	21,532
低硫燃料油 Low Sulphur Fuel Oil	公秉 (kl)	9,595	16,443	17,778	20,653	20,874	20,852	20,010

Цахилгааны үнэ, тарифын өөрчлөлт
(1994-2014 тайвань доллар/кВ.ц)

Year	Lighting	Power	Average
1994	2.5180	2.0149	2.1851
1995	2.5356	2.0010	2.1859
1996	2.5481	1.9969	2.1905
1997	2.5421	1.9606	2.1575
1998	2.5830	1.9311	2.1605
1999	2.5341	1.8865	2.1071
2000	2.5541	1.8918	2.1133
2001	2.5699	1.8915	2.1221
2002	2.5801	1.8491	2.0945
2003	2.5443	1.8287	2.0682
2004	2.5319	1.8225	2.0520
2005	2.5283	1.8205	2.0533
2006	2.5933	1.8753	2.1046
2007	2.6286	1.9280	2.1484
2008	2.7008	2.1198	2.3010
2009	2.9100	2.4625	2.6070
2010	2.9532	2.4583	2.6098
2011	2.9428	2.4500	2.6001
2012	2.9673	2.6178	2.7222
2013	3.1165	2.8020	2.8945
2014	3.1710	3.0279	3.0705

Байгалийн хийн борлуулалтын үнэ
(2015 оны 2-р сарын байдлаар, тайвань доллар/м3)

Company	Selling price	Company	Selling price
欣隆 Shinglung	16.73	欣林 Shinlin	17.77
大台北 The Great Taipei	15.96	欣桃 Shintao (液化天然氣)	17.40
陽明山 Yangmingshan	16.76	欣彰 Shinchang (液化天然氣)	19.23
欣欣 Shinshin	16.96	裕苗 Yumiao (液化天然氣)	18.00
欣湖 Shinhu	16.63	竹名 Chuming (液化天然氣環線)	19.47
新海 Hsinhai	17.13	欣雲 Shinyun (液化天然氣)	19.01
欣泰 Shintai	17.06	欣嘉 Shinchia (液化天然氣)	19.32
欣芝 Shinchi	17.35	大台南 The Great Tainan (液化天然氣)	18.97
欣桃 Shintao	15.92	欣南 Shinnan (液化天然氣)	19.22
新竹 Hsinchu	16.50	欣雄 Shinsung (液化天然氣)	19.11
竹建 Chunan	16.21	欣高 Shinkao (液化天然氣)	18.76
裕苗 Yumiao	16.51	欣屏 Shiping (液化天然氣)	19.02
欣中 Shinchung	17.25	南靖 Nanchen (液化天然氣)	18.78
欣彰 Shinchang	17.48		

Усан хангамж:

Тайванийн Засгийн газар нь сүүлийн 70 жилд гарсан хамгийн хүнд байгалийн гамшгийн дараа 2015 онд Бохир ус дахин ашиглахыг хөгжүүлэх тухай хуулийг баталсан. Тус хуулийн хүрээнд 2031 он гэхэд усан хангамжийн 10 хувийг дахин ашигласан усны эх үүсвэрээр бүрдүүлэхээр заажээ.

Тайванийн хувьд хур тундасын хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг бол тус эх үүсвэрээ төдийлөн ашигладаггүй юм. 2015 оны эхээр ган гачигт хүчтэй нэрвэгдсэний улмаас үйлдвэрлэгчид Засгийн газрыг усны нөөцөөр тогтвортой хангахыг шаардсан. Иймд айл өрх, үйлдвэрлэлийн усан хангамжид зориулан давсгүйжүүлэх байгууламжууд барьж байгуулахаас гадна 2016-2021 оны хооронд 6 бохир ус дахин ашиглах станц барихад 15.2 тэрбум тайвань доллар (465.8 сая ам.доллар) зарцуулахаар төлөвлөсөн байна.

Усны үнэ тарифыг сүүлийн 20 жилд харьцангуй тогтмол барьж ирсэн, үйлдвэрлэлийн усны үнэ хямд байдаг нь дахин боловсруулсан ус худалдан авахад саад болно гэж Тайванийн Усны Корпораци үзсэн байна. 2014 онд Олон улсын усны холбооноос гаргасан судалгаанд Тайванийн усны үнэ судалгаанд хамрагдсан 29 орноос хамгийн хямд үнэ тарифтай орны 3-т орсон байна. Холбогдох яамны тооцоолсноор үйлдвэрлэлийн 1 тонн усны үнэ ойролцоогоор 11 тайвань доллар байгаа юм. Ус зөөлрүүлэх, шүүх зэргийг тооцвол 1 тонн ус 30 тайвань долларт хүрэх юм.

Айл өрхийн усны үнэ тариф мөн адил хямд байсаар ирсэн бол 2016 оны 3-р сарын 1-нээс эхлэн сард 20 м3-с дээш хэрэглээтэй айл өрх 1м3 усанд 9.47 Тайвань доллар (0.28 ам. доллар) төлдөг байсан бол 12.14 тайвань доллар төлөх юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.energyglobal.com/downstream/gas-processing/18052015/Chinese-energy-overview/>
- <http://en.cnesa.org/featured-stories/2015/8/4/chinas-new-electric-system-reforms>
- http://www.rfa.org/english/commentaries/energy_watch/china-coal-04272015103208.html
- <https://china.lbl.gov/sites/all/files/key-china-energy-statistics-2012-june-2012.pdf>
- <http://uk.practicallaw.com/1-524-4813#a539569>
- <https://www.kpmg.de/docs/Water-in-China-201202.pdf>
- <http://www.reuters.com/article/china-environment-water-idUSL3N0NL3ZN20140429>
- <http://webcache.googleusercontent.com/search?q=cache:4PUlPvRltGcJ:www.mdpi.com/2073-4441/7/7/3431/pdf+&cd=52&hl=en&ct=clnk&client=ubuntu>
- <https://www.pwc.com/gx/en/capital-projects-infrastructure/assets/chinas-war-on-water-scarcity.pdf>
- http://fca.be/sites/fca.be/files/images/EU%20SME%20Centre%20Sector%20Report_Water.pdf
- https://books.google.mn/books?id=ZdvwaTjsT8MC&pg=PA52&lpg=PA52&dq=china+influence+of+utility+price+on+industry&source=bl&ots=Xg2ogCW0QM&sig=h-eRXJq-AMVtX1yLqxnsx-8OLVA&hl=en&sa=X&redir_esc=y#v=onepage&q=china%20influence%20of%20utility%20price%20on%20industry&f=false
- <http://en.ndrc.gov.cn/>
- https://www.eia.gov/beta/international/analysis_includes/countries_long/China/china.pdf
- https://www.tillvaxtanalys.se/download/18.5d9caa4d14d0347533bb2460/1430822528247/direct_response_2014_11_China%E2%80%99s%2BNational%2BEnergy%2BAdministration.pdf
- http://eeas.europa.eu/china/docs/division_ecran/ecran_is103_paper_81_chinas_industrial_policy_jean-christophe_defraigne_en.pdf
- <http://www.chinabusinessreview.com/coming-to-terms-with-industrial-policy/>
- http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---inst/documents/publication/wcms_315676.pdf
- https://www.academia.edu/7388177/Chinas_Power_Sector_Restructuring_and_Electricity_Prices_Reforms?auto=download
- <https://www.gov.uk/government/statistical-data-sets/international-industrial-energy-prices>
- http://news.xinhuanet.com/english/china/2015-01/15/c_133922179.htm
- http://fca.be/sites/fca.be/files/images/EU%20SME%20Centre%20Sector%20Report_Water.pdf
- https://web3.moeaboe.gov.tw/ECW/english/content/SubMenu.aspx?menu_id=1537
- <http://www.ipcbee.com/vol66/030-IEEA2014-A2015.pdf>
- <http://english.water.gov.taipei/ct.asp?xItem=994144&CtNode=23944&mp=114012>
- http://www.ey.gov.tw/en/link_Content.aspx?n=E8596CCA0ACD122A&s=034A33062CEE371E
- <https://www.rwlwater.com/reclaimed-water-will-help-meet-taiwans-industrial-needs/>
- <http://www.chinapost.com.tw/taiwan/business/2015/05/20/436453/Industrial-users.htm>

ХАВСРАЛТ 1

Үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газраас батласан бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн жагсаалт

- “Автобензин, түлшний үнийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2012 оны 11-р тогтоол
- “Монгол Улсын үйлдвэржүүлэх хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2009 оны 299-р тогтоол
- “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)” Засгийн газрын 2014 оны 278-р тогтоол
- “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2012 оны 171-р тогтоол
- “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 224-р тогтоол
- “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 66-р тогтоол
- “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тухай” Засгийн газрын 2016 оны 113-р тогтоол
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хөтөлбөрийн тухай УИХ-ын 2014 оны 16-р тогтоол,
- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2012 оны 74-р тогтоол,
- “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” УИХ-ын 2015 оны 62-р тогтоол,
- “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” УИХ-ын 2015 оны 63-р тогтоол,
- “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2009 оны 64-р тогтоол,
- “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2010 оны 34-р тогтоол,
- “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2015 оны 104-р тогтоол,
- “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2003 оны 54-р тогтоол,
- “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 30-р тогтоол болон “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Буман нарны гэрэл хөтөлбөр” зэргийг батласаны зэрэгцээ “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар ойрын болон урт хугацааны стратегийг тодорхой тусгасан байдаг.

ХАВСРАЛТ 2

**Монгол Улсын дулаан, цахилгаан эрчим хүчний үнэ тарифын
2010-2015 оны статистик мэдээлэл**

Хүснэгт 1. Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифын өөрчлөлт

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Улаанбаатар хотын хэрэглэгчдэд борлуулах																									
			2002 VII/10	2002 VI/28	2004 V/06	2005 I/07	2005 XII/13	2008 VI/30	2009 XII/28	2011 IV/12	2013 VII/05	2014 VIII/15	2015 XI/19	2015 VII/06	2002 VII/01	2002 VI/01	2004 V/15	2005 II/14	2005 I/01	2008 VII/15	2010 I/15	2011 V/01	2013 VIII/05	2014 IX/15	2015 XII/05	2015 VII/25		
	Тогтоол баталсан огноо		74	64	27	6	119	98	63	15	70	118	194	204														
	Мөрдөж эхэлсэн огноо																											
	Тогтоолын дугаар																											
	Үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагад																											
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м3	170	170	170	203	-	282	323	323	323	330	373	429														
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/Гкал	11000	11000	11000	13123	-	18241	20886	20886	20886	21310	24080	27692														
		Төг/ГДж	-	-	-	-	-	-	-	4989	4989	5090	5752	6615														
3	Салхилуулга	Төг/Гкал	5000	5000	5000	5965	-	8291	9493	10632	10632	10842	12255	14093														
		Төг/ГДж	-	-	-	-	-	-	-	2539	2539	2590	2927	3366														
4	Албан байгууллагын ХХУ халаасан дулаан	Төг/хүн	1920	1920	1920	2291	-	3184	3646	4084	4084	4166	4708	5414														
		Төг/м3	-	-	-	-	-	-	-	-	-	1326	1498	1873														
5	Технологийн халуун ус	Төг/Гкал	5000	5000	5000	5964	-	8291	9493	10632	10632	10845	12255	14093														
		Төг/ГДж	-	-	-	-	-	-	-	2539	2539	2590	2927	3366														

Эх сурвалж: Эрчим Хүчний Зохицуулах Хороо

Хүснэгт 2. Дархан Уул аймгийн Дархан сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифын өөрчлөлт

Хэрэглэгчдийн ангилал		Дархан Уул аймгийн Дархан сумын хэрэглэгчдэд борлуулах														
/хэмжих нэгж		2002	2005	2007	2008	2009	2011	2013	2014	2015	2015	2015	2015	2015	2015	
		VI/28	I/07	XI/13	VI/30	XII/28	IV/12	VII/05	VIII/15	XI/19	XI/19	XI/19	XI/19	XI/19	XI/19	
Тогтоол баталсан огноо		2002	2005	2007	2008	2009	2011	2013	2014	2015	2015	2015	2015	2015	2015	
Мөрдөж эхэлсэн огноо		VII/01	II/14	XII/01	VII/15	I/15	V/01	VIII/05	IX/15	XII/05	XII/05	XII/05	XII/05	XII/05	XII/05	
Тогтоолын дугаар		65	7	116	99	64	16	71	119	195	195	195	195	195	205	
Аж ахуй нэгж байгууллагад																
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м3	182	217	-	298	298	298	304	373	373	373	373	373	373	429
2	Хэмжүүрээр тооцох дулаан	Төг/гал	9529	11368	14500	-	16600	16600	16932	20318	20318	20318	20318	20318	20318	23366
		Төг/Дж	-	-	-	-	3965	3965	4045	4854	4854	4854	4854	4854	4854	5582
3	Технологийн халуун ус	Төг/гал	5000	5965	7158	-	9180	9180	9364	11237	11237	11237	11237	11237	11237	12923
		Төг/Дж	-	-	-	-	2192	2192	2236	2683	2683	2683	2683	2683	2683	3085
4	Салхилуулга	Төг/гал	5000	5965	7158	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
		Төг/хүн	2054	2450	2450	-	3142	3142	3205	3846	3846	3846	3846	3846	3846	4423
5	Албан байгууллагын XXУ халаасан дулаан	Төг/тн	546	652	815	-	1045	1045	1066	1279	1279	1279	1279	1279	1279	1599
		Төг/гал	3730	4450	5340	-	6848	6848	6985	8382	8382	8382	8382	8382	8382	9639
		Төг/Дж	-	-	-	-	1636	1636	1669	2003	2003	2003	2003	2003	2003	2303
6	Буцаагүй конденсат	Төг/гал	907	1082	1298	-	1664	1664	-	-	-	-	-	-	-	-
		Төг/Дж	-	-	-	-	398	398	-	-	-	-	-	-	-	-
7	Уур 0.8-1.3 МПа	Төг/гал	9256	11043	14210	-	18222	20000	20400	23052	23052	23052	23052	23052	23052	26510
		Төг/Дж	-	-	-	-	4352	4777	4873	5506	5506	5506	5506	5506	5506	6332
8	Уур 2.0 Мпа	Төг/гал	10237	12213	14656	-	18794	24500	24990	28239	28239	28239	28239	28239	28239	32475
		Төг/Дж	-	-	-	-	4489	5852	5969	6745	6745	6745	6745	6745	6745	7757

Хүснэгт 3. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф /НӨАТ-гүй, төг/кВт.ц

	Хэрэглэгчдийн ангилал	2010	2011	2013	2014	2014	2014	2014	2015	2015	2015	
		I/15	V/01	VIII/05	VIII/10	IX/15	XII/19	VII/25	VII/25	VII/25	VII/25	
Мөрдөгдөж эхэлсэн огноо												
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр											
1.1	Энгийн тоолууртай	79.80	100.00	130.00	135.00	138.00	151.60	159.90	159.90	159.90	155.90	
1.2	3 тарифт тоолууртай											
а	Өдөр /06.00 цагаас 17.00/	79.80	100.00	130.00	135.00	138.00	151.60	159.90	159.90	-	155.90	
б	Оройн /17.00 цагаас 22.00/	133.90	179.40	234.00	239.00	244.00	271.70	280.00	280.00	-	276.00	
в	Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 0.00/	46.00	46.00	60.00	65.00	66.30	72.80	81.10	81.10	-	77.10	
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага											
2.1	Энгийн тоолууртай	79.80	88.00	105.60	110.60	113.00	124.20	132.50	132.50	132.50	128.50	
2.2	3 тарифт тоолууртай											
а	Өдөр /06.00 цагаас 17.00/	79.80	88.00	105.60	110.60	113.00	124.20	132.50	132.50	-	128.50	
б	Оройн /17.00 цагаас 22.00/	133.90	155.20	178.60	183.00	187.00	205.50	213.80	213.80	-	209.80	
в	Шөнийн хэрэглээ /22.00 цагаас 0.00/	46.00	46.00	60.00	65.00	66.30	72.80	81.10	81.10	-	77.10	
2.3	"Цахилгаан тээвэр" ХК	49.20	49.20	60.00	65.00	66.30	72.80	81.10	81.10	-	77.10	

Хүснэгт 4. Эрчим хүчний зориулалт бүхий нүүрсний
үнийн өөрчлөлт /төгрөгөөр/

Он	Багануур	Шарын гол	Шивээ-Овоо	Адуунчулуун
2000	8050	8500	5500	3200
2001	9000	9500	5800	3200
2002	9250	10000	5800	3750
2003	9250	10000	5800	3750
2004	9250 / 10730	1000/12000	6000/7200	3750
2005	11500	13600	7500	4800
2006	11500	13600	7500	5100
2007	12500	16600	8500	5100/6100
2008	16200	21400	11400	7500
2009	16200	21400	11400	7500
2010	18200	22680/26275	13960	8584/9600
2011	18200/20500	26275	13960/15560	9600
2012	20500	26275	15560	9600
2013	22500	26275	18050	9600
2014	25500	30000	21060	12600
2015	25500	30000	21060	12600
2016	27500	36500	23060	12600

ХАВСРАЛТ 3

**Монгол Улсын шатахууны жижиглэнгийн үнэ болон үйлдвэр, аж ахуйн
нэгжийн усны үнэ тарифын статистик мэдээлэл**

Хүснэгт 5. Шатахууны үнэ /2012-2015 он/

Сар	2012 он			2013 он			2014 он			2015 он		
	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т	А-80	АИ-92	Д/Т
1	1500	1800	1850	1580	1620	1750	1530	1620	1750	1550	1660	1790
2	1430	1730	1780	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
3	1430	1680	1780	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
4	1430	1570	1700	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
5	1480	1570	1700	1580	1670	1800	1550	1660	1790	1550	1660	1790
6	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
7	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
8	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
9	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
10	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
11	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790
12	1480	1570	1700	1530	1620	1750	1550	1660	1790	1550	1660	1790

Хүснэгт 6. Шатахууны үнийн өөрчлөлт /2015 оны 12 сараас 2016 оны 2 сар/

№	Бүсийн нэр	Тулгуур төв	Аймаг, хотын нэр	А-80 /литр/			АИ-92 /литр/			АИ-95 /литр/			ДТ /литр/				
				өмнөх үнэ	өөрчлөлт	ээрш үнэ	өмнөх үнэ	өөрчлөлт	ээрш үнэ	өмнөх үнэ	өөрчлөлт	ээрш үнэ	өмнөх үнэ	өөрчлөлт	ээрш үнэ		
1	Баруун бүс	Ховд, Улиастай	Баян-Өлгий	өмнөх үнэ	1600	1530	-70	1900	1660	-240	1890	1790	-100	өмнөх үнэ	1890	1790	-100
				ээрш үнэ	1690	1670	-20	2040	1780	-260	2040	1910	-130	өмнөх үнэ	2040	1910	-130
				өөрчлөлт	1690	1650	-40	2010	1760	-250	2010	1890	-120	өмнөх үнэ	2010	1890	-120
				зөрүү	1670	1550	-120	1940	1660	-280	1940	1790	-150	өмнөх үнэ	1940	1790	-150
2	Хангайн бүс	Хархорин, Эрдэнэт	Архангай	өмнөх үнэ	1760	1580	-180	2090	1690	-400	2090	1820	-270	өмнөх үнэ	2090	1820	-270
				ээрш үнэ	1610	1530	-80	1790	1690	-100	1870	1770	-140	өмнөх үнэ	1870	1770	-140
				өөрчлөлт	1620	1570	-50	1810	1710	-100	1890	1790	-110	өмнөх үнэ	1890	1790	-110
				зөрүү	1540	1480	-60	1710	1590	-120	1890	1690	-110	өмнөх үнэ	1800	1690	-110
3	Төвийн бүс	Зуунмод, Дархан	Өвөрхангай	өмнөх үнэ	1590	1500	-90	1740	1660	-80	1890	1760	-130	өмнөх үнэ	1890	1760	-130
				ээрш үнэ	1560	1480	-80	1660	1590	-70	1890	1760	-130	өмнөх үнэ	1790	1690	-100
				өөрчлөлт	1560	1470	-90	1690	1580	-110	1820	1690	-130	өмнөх үнэ	1820	1690	-130
				зөрүү	1670	1570	-100	1940	1780	-160	2040	1940	-150	өмнөх үнэ	1990	1840	-150
4	Зүүн бүс	Чойбалсан, Өндөрхаан	Сүхбаатар	өмнөх үнэ	1550	1470	-80	1690	1600	-90	1890	1750	-140	өмнөх үнэ	1890	1750	-140
				ээрш үнэ	1570	1490	-80	1750	1620	-130	1890	1750	-120	өмнөх үнэ	1830	1710	-120
				өөрчлөлт	1550	1500	-50	1800	1680	-120	1840	1770	-110	өмнөх үнэ	1880	1770	-110
				зөрүү	1520	1470	-50	1790	1650	-140	1880	1720	-160	өмнөх үнэ	1880	1720	-160
			Өмнөговь	өмнөх үнэ	1650	1550	-100	1890	1730	-160	1910	1780	-130	өмнөх үнэ	1910	1780	-130
				ээрш үнэ	1630	1550	-80	1880	1660	-220	1930	1790	-140	өмнөх үнэ	1930	1790	-140
				өөрчлөлт	1660	1580	-80	1920	1690	-230	1920	1830	-130	өмнөх үнэ	1950	1820	-130
				зөрүү	1590	1580	-10	1840	1690	-150	1940	1820	-80	өмнөх үнэ	1900	1820	-80

Хүснэгт 7. Улаанбаатар хотын УСУГ-ын үнийн судалгаа

Үйлчилгээний төрөл	ХЭМЖИХ НЭГЖ	Өсөлт										НӨАТ-тай үнэ				
		2005.09.01	2007.01.12	2008.08.19	2011.05.03	2011.07.09	2012.01.13	2012.02.07	2014.07.15	2015.09.01	Төг	Хувь	2011.05.03	2016.12.10	2012.02.07	2014.07.15
Төвлөрсөн системээр цэвэр ус түгээх																
а. Үйлдвэр аж ахуйн байгууллагад	тонн	315	329.3	550	554.6	910	950	40	4.4%					610	1001	1045
б. Төсөвт байгууллагад	тонн	315	329.3	550	554.6	910	950	40	4.4%					610	1001	1045
в. Спирт, архи, пиво, ундаа, ус	тонн				554.6	1200	1250	50	4.2%					610	1320	1375
г. Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	тонн				554.6	910	950	40	4.4%					610	1001	1045
Төвлөрсөн системээр бохир ус татан зайлуулах																
а. Үйлдвэр аж ахуйн байгууллагад	тонн	170		300		600	720	120	20.0%					330	660	792
б. Төсөвт байгууллагад	тонн	170		300		600	720	120	20.0%					330	660	792
в. Спирт, архи, пиво, ундаа, ус	тонн			300		800	960	160	20.0%					330	880	1056
г. Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	тонн			600		1500	1500	0	0.0%					660	1650	1650
Зөвөрөөр цэвэр ус түгээх																

ХАВСРАЛТ 4

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны
“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь
хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”
326 дугаар тогтоол

Хүснэгт 8. Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

№	Төлбөр ногдох ус	Төлбөрийн хувь хэмжээ (экологийн засгийн үнэлгээний хувиар)	
		Гадаргын усанд	Газрын доорх усанд
1.	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	-	-
2.	Хүнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	20
3.	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	20
4.	Авто зам, засварт ашигласан усны шоометр тутамд	10	20
5.	Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	10
6.	Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:		
	а) архи, пиво, согтууруулах ундаа	10	20
	б) ундаа, цэвэр ус	10	10
	в) талх, чихэр, нарийн боов, бусад	1	1
7.	Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:		
	а) ашигт малтмал олборлох, баяжуулах	10	20
	б) зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	10	20
	в) усыг шавхан зайлуулах	10	15
	г) эрэл, хайгуулын өрөмдлөг хийх	10	20
8.	Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	10	15
9.	Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд	1	10
10.	Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны шоометр тутамд	10	15
	Төлбөр ногдох ус	Үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс тооцох төлбөрийн хязгаар (хувиар)	
		Гадаргын усанд	
11.	Усан цахилгаан станц, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх	5	
12.	Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал зугаалга, усан спортын байгууламж	1	

Тайлбар: 1. Барилгын суурийн хөрсний усыг шавхан зайлуулсан тохиолдолд хүснэгтийн 7в-тэй адил тооцно.

2. Энэхүү хавсралтын 10-т заасан ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны төлбөрийг усаар хангагч байгууллага тооцож авна.

Хүснэгт 9. Усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь, хэмжээ

Ус ашиглах зориулалт		Усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь	
		Усны эх үүсвэр	
		Гадаргын ус	Газрын доорх ус
1	Унд, ахуйн зориулалтаар усны эрдэсжилт, хатуулгыг нь цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан	100	100
2	Ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх	99	99
3	Хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашиглах тохиолдолд тухайн хэмжээгээр	эргүүлэн ашигласан хэмжээгээр	
4	Цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан	99	-

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТЫГ ХАНГАХ ТОГТОЛЦОО

*Р.Хатанбаатар, А.Пагма
Д.Жигваагүнсэл*

Малайз Улс 1950-аад оноос хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж эхэлжээ.

Малайзийн Засгийн газар улсын Нэгдүгээр таван жилийн хөгжлийн төлөвлөгөөг (*First Malaya Plan 1956-1960*) хэрэгжүүлж эхэлсэн үеэс эхлэн хөгжлийг төлөвлөх, салбар хоорондын төлөвлөлт, хяналтын механизмыг бий болгох чиг үүрэг бүхий Эдийн засгийн төлөвлөлтийн товчоог (*Economic Planning Unit EPU*) Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллаж байна.

Малайз улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн үндсэн баримт бичгүүд нь:

- Урт хугацааны төлөвлөлт
 - Малайзийн хөгжлийн үзэл баримтлал 2020
 - Нэгдүгээр Хэтийн төлөвлөгөө, 1971-1990
 - Хоёрдугаар Хэтийн төлөвлөгөө, 1911-2000
 - Гуравдугаар Хэтийн төлөвлөгөө, 2001-2010
- Дунд хугацааны төлөвлөлт
 - Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө
 - Богино хугацааны төлөвлөлт
 - Жилийн төсөв

зэргээс бүрдэж байна.

Нэг. 1991 онд Малайзийн Засгийн газраас батлан гаргасан “Малайзийн хөгжлийн үзэл баримтлал 2020” –даа 2020 он гэхэд хөгжингүй орон болон хөгжсөн байх нь нийт үндэстний зорилго мөн гэж тунхагласан юм. Үзэл баримтлалд эдийн засаг, түүний дотор аж үйлдвэрт бүтцийн өөрчлөлт хийж, эдийн засгийн тогтвортой хөгжлийн ханган, жилийн дундаж өсөлтийг 7 хувьтай байлгаснаар Малайз улс аж үйлдвэржсэн, бүх талаар хөгжингүй улс болно гэж үзжээ.

Хоёр. Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх алхам болгон 5 жилийн хугацаатай дунд хугацааны төлөвлөлтийг хийнэ. Энэ төлөвлөлтөөр макро эдийн засгийн зорилтууд, салбарын хөгжлийн чиглэл, хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлно. Тухайн 5 жилийн хугацааны дундуур төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг явуулж, шаардлагатай бол макро эдийн засаг болон хөрөнгө оруулалтын бодлого, салбарын хөгжлийн зорилтуудад засвар хийдэг.

Гурав. Богино хугацааны төлөвлөлт-жилийн төсвийг Сангийн яам боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, Төв банк санхүү, мөнгөний бодлогыг тодорхойлоход тус тус оролцоно.

Малайзид эдийн засаг, нийгмийн асуудлаар шийдвэр гаргах хамгийн дээд түвшний байгууллага бол Үндэсний төлөвлөлтийн зөвлөл (*National Planning Council NPC*) юм. Тус Зөвлөлийн гишүүд нь сангийн; олон улсын худалдаа, аж үйлдвэрийн; дотоод худалдааны; бизнесийн хөгжлийн; болон бараа таваар,

хөдөө аж ахуйн сайд зэрэг эдийн засгийн гол салбарын сайд нар байна. Мөн бусад сайд нараас бүрдсэн, хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн асуудлыг хариуцсан Үндэсний хөгжлийн зөвлөл (*National Development Council NDC*) болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (*National Security Council NSC*) ажилладаг. Энэ 3 зөвлөлийг Ерөнхий сайд ахална.

Зураг 1: Хөгжлийн төлөвлөлт, зохицуулалт, хэрэгжилтийг удирдах тогтолцоо




Хөгжлийн төлөвлөлтийн бодлогыг тодорхойлох, нарийвчлан хэлэлцэх дээд байгууллага нь Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо (*National Development Planning Committee NDPC*) юм. Уг хороо Засгийн газрын ахлах албан тушаалтнуудаас бүрдэх бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга тэргүүлнэ. Эдийн засгийн хөгжлийн чиглэлийн бүх яамдын сайд нар болон Төв банкны ерөнхийлөгч нар энэ хорооны гишүүд байна.

Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо нь үндэсний хөгжлийн бүх төлөвлөлтийг хийх, төлөвлөлтийг дахин хянаж, тодруулах чиг үүрэгтэй бөгөөд нөөцийг хуваарилах талаар зөвлөмж гаргана. Мөн уг хороо үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хэрэгжилтэнд хяналт тавина.

Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо (*Economic Planning Unit EPU*), Сангийн яам болон Төв банк Холбооны түвшинд хөгжлийн төлөвлөлтийг хийх бөгөөд бусад яамд, агентлагуудын төлөвлөлтийн нэгжүүдийг оролцуулна. Эдийн засгийн төлөвлөлтийн товчооны үйл ажиллагааг Ерөнхий сайдын дэргэдэх Хэрэгжилт, зохицуулалтын нэгж (*Implementation and Coordination Unit ICU*) болон Малайзийн засаг захиргаа, шинэчлэлийн нэгж (*Malaysian Administrative and Modernization Planning Unit MAMPU*) гэсэн 2 төв агентлаг дэмжин ажилладаг. Эдгээр 3 агентлаг Ерөнхий сайдын дэргэд ажилладаг нь агентлагуудын нэр хүнд, тэдэнд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг бөгөөд эргээд үйл ажиллагаа нь үр дүнтэй байхад сайнаар нөлөөлдөг байна.

Төлөвлөлтийн процесс хувийн сектор болон иргэний нийгэмтэй байнгын, тогтмол зөвшилцөл, тэдний зохих оролцооны үндсэн дээр явагддаг.

Зураг 2: Малайз улсын төлөвлөлтийн тогтолцоо



Эдийн засгийн төлөвлөлтийн товчооны (*Economic Planning Unit EPU*) төлөвлөлтийн олон талт чиг үүрэг, бүтцийг Үндэсний Эрхэм зорилгын таван тулгуурт (*five Thrusts in the National Mission*¹⁸) суурилан тогтоожээ. Энэ нь Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо илүү өргөн хүрээнд бодож төлөвлөх, Үндэсний Эрхэм зорилгод төвлөрөх боломжийг олгодог ажээ.

Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо нь Ерөнхий сайдын өмнө ажлаа шууд хариуцан тайлагнах ба Товчоог ерөнхий захирал толгойлж, ерөнхий захирлын 3 орлогч болон Малайзийн хөгжлийн хүрээлэнгийн (*Malaysian Development Institute*) захирал удирдлагад нь ажиллана.

Эдийн засгийн төлөвлөлтийн товчооны үндсэн чиг үүрэг нь:

- 1) Төлөвлөлт
 - a) Нийгэм- эдийн засгийн судалгаа, анализ
 - b) Хөгжлийн бодлого
 - c) Макро эдийн засгийн загварчлал, тогтолцоо
 - d) Хөгжлийн төлөвлөгөө
- 2) Нөөцийн хуваарилалт
 - Төсвийн удирдлага, төслийн үнэлгээ

¹⁸ Five Thrusts in the National Mission
 Thrust1: Value chain & Competitiveness
 Thrust2: Knowledge & Innovation
 Thrust3: Growth & Distribution
 Thrust4: Sustainability Of Quality Of Life
 Thrust5: Implementation Capacity


- 3) Хяналт-шинжилгээ
 - а) Үндэсний хөтөлбөрүүдийн хяналт-шинжилгээ
 - б) Санал, санаачлагын хяналт-үнэлгээ
 - с) Төслийн хяналт-үнэлгээ
- 4) Үйл ажиллагааны дэмжлэг
 - а) Нарийн бичгийн даргын газар:
 - Эдийн засгийн Зөвлөл (*Economic Council EC*)
 - Үндэсний хөгжлийн төлөвлөлтийн хороо
 - б) Feedback Management

Энэхүү үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Эдийн засгийн төлөвлөлтийн товчоо дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг байна:

- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийг томъёолох;
- Дунд болон урт хугацааны төлөвлөгөөг бэлтгэх;
- Хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн төсвийг бэлтгэх;
- Хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ хийх;
- Засгийн газарт эдийн засгийн асуудлаар зөвлөлгөө өгөх;
- Шаардлагатай эдийн засгийн судалгааны ажлыг санаачлах, гүйцэтгэх;
- Хувьчлалын хөтөлбөрүүдийг төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтэнд нь үнэлгээ хийх;
- Гурван талт хөгжлийн хөтөлбөр¹⁹ дэх Малайзийн оролцоог зохицуулах
 - Төрийн байгууллагын хүнд суртал-6 буюу нийт судалгааны хамрагдагсдын 30%
 - Хоёр талт болон олон талын хамтын ажиллагааг санаачлах, зохицуулах
 - Малайзийн техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг удирдах
 - Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх.

¹⁹ The Indonesia-Malaysia-Thailand Growth Triangle subregional program

Зураг 3: Эдийн засгийн төлөвлөлтийн товчооны зохион байгуулалт



Бүгд Найрамдах Солонгос Улс²⁰

Солонгос Улс 1961 онд Эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулж, улс орноо тав, таван жилээр хөгжүүлэх анхдугаар 5 жилийн төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж эхэллээ. Энэ нь цааш боловсронгуй болж, өргөжин тэлсээр 1992 онд Улсын тогтвортой хөгжлийн бодлого “Төлөвлөгөө 21” (Rio Agenda 21)-ийг боловсруулсан байна. Засгийн газраас үүнийг хэрэгжүүлэх “Улсын Үйл ажиллагааны Төлөвлөгөө” боловсруулан улмаар 15 дахь Ерөнхийлөгч Ким Дае-Жун 2000 оны “Дэлхийн байгаль орчны өдөр” шинэ мянганы хүрээлэн буй орчны хөгжлийн зорилгоо тунхаглаж, Ерөнхийлөгчийн дэргэдэх **Тогтвортой Хөгжлийн Комисс** (Presidential Commission on Sustainable Development (PCSD)) үүсгэн байгуулсан тухайгаа зарласны дараа мөн оны 9-р сараас энэ комисс нь өөрийн үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлж, Улсын Тогтвортой Хөгжлийн Бодлого боловсруулах ажлыг өөрийн гол зорилго болгон дэвшүүлсэн байдаг. Тус **Комисс нь** байгуулагдсан цагаасаа эхлэн олон салбарт (эрчим хүч, ус, далайн эрэг орчмын ус, газар, цаг агаарын өөрчлөлт, тээвэр, зөрчлийн менежмент гэх зэрэг) суурилсан тогтвортой хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, улмаар эдгээр салбар тус бүрт өөр өөр салбар, газруудын хооронд үр дүнтэй зохицуулалт, уялдаа холбоог бий болгох замаар нэгтгэх ажлыг хийж иржээ.

Солонгос Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд нь:


- Урт хугацааны төлөвлөлт
 - Алсын хараа 2025 /Vision 2025/
- Дунд хугацааны төлөвлөлт
 - Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө
 - Богино хугацааны төлөвлөлт
- Жилийн төсөв зэргээс бүрдэж байна.

Улсын тогтвортой хөгжлийн бодлогын таван үндсэн чиглэл, хэрэгжүүлэх 48 зорилт, 224 тухайлсан зорилт бүхий бодлогыг боловсруулахад Засгийн газрын 22 яам ба газрууд оролцсон байна. Хөгжлийн бодлого, зорилтуудыг боловсруулах үйл явц нь 2 үе шаттай байна. Нэгдүгээрт, 2002 оны дэлхийн тогтвортой хөгжлийн хурлын хэрэгжүүлэх зорилтуудаас сонгож, улмаар өөрийн улсын тогтвортой хөгжлийн алсын хараанд оруулсан. Хоёрдугаарт, тэдгээрийг Солонгосын ахуй нөхцөлд тохируулан боловсруулсан байна. /Схем 1/

16-р Ерөнхийлөгч Ро Му-Хюн нь “Солонгосын Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг тус улсын хөгжил дэвшлийг үргэлжлүүлж “эдийн засаг, нийгэм ба хүрээлэн буй байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангасан өндөр хөгжилтэй орон болох” хэмээн тунхагласан нь Улсын тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажилд Засгийн газрын албадуудыг татан оролцуулах, хэрэгжүүлэх төлөвлөлтийг боловсруулах ажлын гол хөдөлгөгч хүчин зүйл болсон байна.


²⁰ The Korean National Strategy for Sustainable Development, 2006, sustainabledevelopment.un.org/content/documents/1394backgroundReport.pdf

Зураг 4: Бүгд Найрамдах Солонгос Улсын Тогтвортой Хөгжлийн Бодлого, Алсын хараа



Тогтвортой хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, зохион байгуулалт: Солонгосын тогтвортой хөгжлийн төлөвлөлтийг Засгийн газар, харьяа яам, агентлагууд өөрсдийн салбар чиглэлээр боловсруулан хэрэгжүүлж байна. Харин Тогтвортой хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, удирдан зохион байгуулах ажлыг Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн комисс хариуцан ажилладаг. Тус комисс нь 2000 онд Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан.

Зураг 5. Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн Комисс (PCSD)-ийн бүтэц



- *Удирдах Хороо* - нь 35 гишүүнтэй. Мэргэжлийн Хороо болон судалгааны багуудын бодлогын саналыг нягтлан үзэж, Ерөнхийлөгчид зөвлөх үүрэгтэй.
- *Зөрчлийг зохицуулах тусгай хороо* - 50 гишүүнтэй. Үүнд: Удирдах Хорооноос томилогдсон болон муж улсууд, ТББ-уудаас санал болгосон бусад гишүүд багтана. Зөрчлийн менежмент ба урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсруулан хөгжүүлж, Удирдах Хорооноос цаг үеийн олон нийтийн зөрчлийн асуудлаар өгсөн даалгаварын дагуу Ерөнхийлөгчид зөвлөнө.
- *Мэргэжлийн хороо*-нь Удирдах Хорооны тодорхой хувь болон холбогдох мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн хэд хэдэн судалгааны багуудыг ажиллуулна. Салбар судлагдахуун тус бүр дээр бодлогын санал боловсруулж, нягтлан үзнэ.
- *Төлөвлөлтийн менежментийн газар*- энд удирдах хорооны гишүүд байна.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой Хөгжлийн Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийг нийгмийн хөгжил, байгаль орчин ба байгалийн баялгийг хадгалан хамгаалах, тэнцвэртэй байлгах, тогтвортой хөгжлийн зорилго, бодлого стратегийг яамны түвшинд боловсруулж, бий болгох;
- Ус, эрчим хүч гэх зэрэг олон салбарын тогтвортой хөгжлийг хангах үүднээс Ерөнхийлөгчийг бодлогын зөвлөгөөгөөр хангах;
- Тогтвортой хөгжилтэй холбоотой нийгмийн зөрчил маргааныг шийдвэрлэх, хяналтын менежментийн тогтолцоог бий болгох;
- Хөтөлбөр 21 ба UNCED, UNFCCC, ба WSSD-ийн бусад зөвшилцлүүдийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах;
- Ерөнхийлөгчийн дэргэдэх Тогтвортой Хөгжлийн Комисс ба тогтвортой хөгжилтэй холбоотой зөрчлийг шийдвэрлэх менежментийн тогтолцооны түвшний Ерөнхийлөгчийн санамж бичгүүдийг боловсруулах.

Комисс нь дээрх чиг үүргийнхээ хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Үүнд:

- Эрчим хүч, ус, газар эзэмшил, тээвэр гэх мэтчилэн салбарын асуудлуудтай холбоотой бодлого боловсруулах, тэдгээр бодлогыг Ерөнхийлөгчид өргөн барих;
- Улсын газрын төлөвлөлт, байгаль орчны бүрэн төлөвлөлт гэх зэрэг улсад чухал ач холбогдолтой үндэстний урт болон дунд хугацааны төлөвлөгөөг улсын бодлогын тогтвортой байдлын үүднээс нь урьдчилан нягтлаж үзэх;
- Зөрчлийн менежмент болон урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх, цаг үеийн олон нийтийн элдэв зөрчилдөөний үед Ерөнхийлөгчид нийгмийн эв эеийг хэрхэн хангах тухайд зөвлөх.

Хяналт, үнэлгээ-мониторинг: Улсын Тогтвортой Хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг гурван түвшний схемээр хянаж, үнэлдэг байна.

1/ Хэрэгжүүлэх төлөвлөгөө болон үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эхлээд газрын түвшинд сайн дурын үндсэн дээр хяналт хийнэ. Засгийн газрын алба, агентлаг бүр тус бүрдээ ажил хэрэгжүүлэх төлөвлөгөө эсхүл хөтөлбөрийн гүйцэтгэл, хэрэгжилтийн индикаторуудын дагуу сайн дураар хяналтыг тогтмол хийнэ. Ийнхүү Улсын Тогтвортой Хөгжлийн Бодлогын үнэлгээг үндсэн ажил үүргийнхээ үнэлгээнд оруулж, ингэснээрээ тогтвортой хөгжлийн бодлогод Засгийн газруудын оролцоо, хариуцлагыг сурталчилдаг байна.

2/ Засгийн газраас Ерөнхий сайдын дэргэдэх Засгийн газрын бодлого зохицуулалтын газартай зөвлөлдөн тодорхой төлөвлөгөө, үнэлгээний схем гаргах ба, Засгийн газрын үнэлгээний үйл ажиллагааны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хоёрдугаар түвшний буюу төв Засгийн газрын түвшний мониторингийг бүрдүүлдэг.

3/ Эцэст нь, Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг Тогтвортой хөгжлийн индикатор системийн дагуу хянан үзэж үнэлнэ. Энэ нь хөгжлийн бодлогыг системтэй, тогтмол сайжруулах үндэс болно. 2002 оны Дэлхийн Тогтвортой Хөгжлийн тухай хуралдаанаас хэрэгжилтийн түвшинг үнэлэх индикаторуудыг ашиглан үнэлэх ба хэрэгжүүлэх төлөвлөгөө эсхүл хөтөлбөрүүдийг боловсруулахыг дэмжин уриалсан байдаг. Солонгос нь УТХБын хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийхдээ өөрийн орны тогтвортой хөгжилтэй холбоотой бодит нөхцөл байдлаас урган гарсан 77 индикаторыг сонгосон байдаг. Энэ нь өөрийн дотоод тогтвортой хөгжлийг үнэлэх чухал хэрэглэгдэхүүн болсон байдаг. Эдгээр индикаторуудыг дотоодын судалгаа шинжилгээний ажил болон нээлттэй хэлэлцүүлгүүд болон Засгийн газар хоорондын зөвлөгөөний үр дүнд олон улсын индикаторуудтай харьцуулж, засаг захиргааны ажлын шаардлагаар боловсруулсан байна.

Бүгд Найрамдах Турк улс²¹

Турк Улс 1960 оноос хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд урт хугацааны стратеги төлөвлөлтийг 1963-1977, 1977-1995, 2001-2023 он хүртэл гэсэн 3 үе шаттай хэрэгжүүлж хугацааны стратегийн зорилтод

²¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийн танилцуулга, 4-р боть, 2015 он

дэлхийн тэргүүлэх эдийн засагтай 10 орны нэг болох, ҮНБ-ийг 2 триллион ам.доллар, нэг хүнд ногдох ҮНБ-ийг 25 мянган ам.доллар, гадаад худалдааг 500 тэрбум ам.доллар, ажилгүйдлийн түвшинг 5 хувь, инфляцийн түвшинг 1 оронтой тоонд байлгах зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тэрхүү стратегийн зорилтууддаа хүрэх зорилгоор, Урт хугацааны Хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх Хөгжлийн 10 дугаар төлөвлөгөө (2014-2018)-г боловсруулан баталж, хэрэгжүүлж байгаа ба энэхүү Хөгжлийн төлөвлөгөө нь 4 чиглэлээр 66 зорилтыг агуулсан байна. Үүнд:

- Нэгдүгээрт, хүний хөгжил, нийгэм, нийтийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх бодлогууд;
- Хоёрдугаарт, эдийн засгийн холбогдолтой зорилгууд;
- Гуравдугаарт, хүний амьдрах орчныг сайжруулах, байгаль орчны хөгжлийн талаарх зорилгууд;
- Дөрөвдүгээрт, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаархи бодлогуудыг тус тус тусгасан байна.

Турк Улс 1960 онд хөгжлийн бодлогоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх хөгжлийн бодлого төлөвлөлтийн институцийн бүтцийг бий болгох зорилгоор Үндсэн хуулиндаа тусгайлан заалт оруулж, Улсын төлөвлөлтийн байгууллагыг (State Planning Organization) байгуулсан байна. Тус байгууллага нь 2011 онд Хөгжлийн яам болон өргөжсөн бөгөөд тус яам нь улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх, улсын хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, Засгийн газарт зөвлөх, хувийн салбарын хөрөнгө оруулалтын хөгжлийг төлөвлөхөд тэргүүлэх үүрэгтэй.

Хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөлтийн үйл ажиллагаа:

Хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь урт, дунд, богино хугацаагаар төлөвлөгддөг ба харин төсөвлөлтийн баримт бичгүүд нь дунд болон богино хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд үндэслэн дунд болон богино хугацаагаар төлөвлөгдөх ба эдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын болон бүс, орон нутгийн түвшинд төлөвлөж, уялдаа зохицуулалтыг хангадаг байна.

- *Урт хугацаанд:* Урт хугацааны стратеги (Long term strategy), Хөгжлийн төлөвлөгөөг 1963 оноос эхлүүлэн төлөвлөж ирсэн ба хэрэгжүүлэх чиглэлээр 5-7 жилийн хугацаагаар боловсруулдаг эдгээр бодлогын баримт бичгийг Улсын төлөвлөлтийн байгууллага /Хөгжлийн яам/ боловсруулж, Үндэсний Их Хурлаар баталдаг бөгөөд боловсруулалтын шатанд академи, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоог хангасан байдаг байна.
- *Дунд хугацаанд:* Дунд хугацааны хөтөлбөр (Medium Term Program (MTP)), Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө (Medium term fiscal plan)-г 3 жилээр төлөвлөн, нэг жилээр уян хатан (yearly rolling) хэлбэрээр боловсруулан хэрэгжүүлдэг ба энэхүү бодлогын баримт бичиг нь 5018 дугаартай Төрийн санхүүгийн удирдлага, хяналтын тухай хуулийн 16 дугаар зүйлээр зохицуулагддаг байна. Дунд хугацааны хөтөлбөрийг Хөгжлийн яам боловсруулдаг ба Сангийн яам, Төрийн

сан, Төв банкттай хамтран ажиллаж, төрийн бус байгууллагуудын саналыг тусган, хөтөлбөрийг Сайд нарын Зөвлөлөөр, төлөвлөгөөр Төлөвлөлтийн дээд зөвлөлөөр батлуулдаг байна.

- *Богино хугацаанд:* Төлөвлөлтийн дээд зөвлөлөөс ирэх жилийн зорилтуудыг тодорхойлсон Макро эдийн засгийн болон санхүүгийн үндсэн зорилтууд (Macroeconomic and Fiscal targets)-ыг гаргадаг ба эдгээр зорилтууд нь макро эдийн засгийн зорилт, санхүү төсвийн зорилт, байгууллага болон салбарт суурилсан хөрөнгө оруулалт гэсэн 3 хэсгээс бүрддэг байна. Энэхүү баримт бичиг нь Жилийн хөтөлбөр, Төсвийн төслийн тухай хуулийн хамтаар нэг цогц болдог бөгөөд Төсвийн төслийн тухай хууль, Төсвийн гүйцэтгэлийн баримт бичгийн хамтаар Хөгжлийн яамнаас боловсруулан Үндэсний Их Хуралд өргөн барьдаг байна. /Зураг 1/

Зураг 6. Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа



Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг бэлтгэх үйл ажиллагаа нь төлөвлөгөө боловсруулах журмаар зохицуулагддаг. Энэ журмын дагуу дараах үе шатаар хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажил хийгддэг байна. Үүнд:

- Тусгай мэргэжлийн комисс, ажлын хэсэг байгуулагдана.
- Хөгжлийн яамнаас тусгай мэргэжлийн комисс, ажлын хэсгүүдийн саналыг тусгасан хувилбарт зорилго, зорилт, стратегийг боловсруулна.
- Хөгжлийн яамнаас боловсруулсан хувилбарт зорилго, зорилт стратегийг Төлөвлөлтийн Дээд Зөвлөл дээр хэлэлцүүлдэг ба Төлөвлөлтийн Дээд Зөвлөл өөрийн шийдвэрийн хамтаар Засгийн газарт хүргүүлдэг.
- Засгийн газар Төлөвлөлтийн Дээд Зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэн шийдвэрээ гаргадаг ба түүнд үндэслэн Хөгжлийн яам судалгааг хийж, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд ҮИХ-д өргөн барина.
- ҮИХ хөгжлийн бодлогын баримт бичгийг Дэгийн тухай хуулийн дагуу тусгай хэлэлцүүлгээр хэлэлцэж, батлах ба тухайн бодлогын баримт бичиг нь ҮИХ-аар батлагдсанаар хуультай ижил статустайгаар мөрдөгдөж эхэлдэг. /Зураг 2/


Зураг 7. Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн үйл ажиллагаа



Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах тогтолцоо, Засгийн газрын чиг үүрэг, бүтэц: Туркийн Засгийн газар нь урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, төлөвлөлтийг хийх үүргийг хариуцан хэрэгжүүлж, Үндэсний Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах, үүнд нийцүүлэн санхүүгийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг.

Туркийн Засгийн газрын түвшинд хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа зохицуулалтыг хангах чиглэлээр дээд шатны шийдвэрийг гаргадаг, удирдлагыг хэрэгжүүлдэг бүтэц нь Ерөнхий сайд, Шадар сайдаар ахлуулсан *Төлөвлөлтийн Дээд Зөвлөл /Higher Planning Council, Мөнгө, зээлийн зохицуулалтын Зөвлөл /Money-Credit Coordination Council/, Эдийн засаг, нийгмийн Зөвлөл /Economic and Social Council/, Бүсчилсэн хөгжлийн Дээд Зөвлөл /Regional Development Higher Council/, Бүсчилсэн хөгжлийн хороо /Regional Development Committee/ зэрэг хөгжлийн төлөвлөлтийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагууд байдаг бөгөөд эдгээр зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах үндсэн чиг үүрэг нь Туркийн **Хөгжлийн яаманд** харьяалагддаг байна.*

Зураг 8. Төлөвлөлтийн дээд шатны удирдлага



Хөгжлийн яам нь Үндсэн хууль болон бусад хуулиар хүлээсэн дараахь чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Туркийн эдийн засаг, нийгэм, хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлоход Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- Бусад яамдын бодлого, үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдааг зохицуулах;
- Хөгжлийн төлөвлөгөө, дунд хугацааны хөтөлбөрүүд, жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг боловсруулах;
- Макро түвшний салбарын, бүсийн стратегиуд болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах;
- Улсын хөрөнгө оруулалтад суурилсан стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох;
- Бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх;
- Төрийн салбарын байгууллагын стратегийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих;
- Олон талт болон хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх;
- Улс орны хөгжлийн чиг хандлага, шилжилтийг чиглүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагууд, агентлагуудын хамтын үйл ажиллагааг хангах;
- Хөгжлийн асуудлаарх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах;

Хөгжлийн яам нь 9 үндсэн асуудлыг чиглэлээр нь хариуцдаг газар, нэгжүүдтэй бөгөөд эдгээр нэгжүүдийн хоорондын уялдаа, холбоог хангасны үндсэн дээр улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийг макро түвшинд төлөвлөх, бүс нутгийн болон салбарын түвшний бодлогын уялдаа зохицуулалтыг ханган, нэгдсэн төлөвлөлтийг хийдэг. Тухайлбал,

- *Макро эдийн засгийн нэгж*- Макро эдийн засгийн загваруудыг боловсруулах, тэдгээрийг хөгжүүлэх, тооцоолоход тэргүүлэх чиглэлтэй оролцдог.
- *Орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт, удирдлагын газар*- Үндэсний түвшинд бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг хариуцан боловсруулах, уялдаа зохицуулалтыг хангах чиг үүрэгтэй. Энэ чиг үүргийн хүрээнд Ерөнхий сайдаар ахлуулсан *Бүс нутгийн хөгжлийн зөвлөл* ажиллаж, бүс, орон нутгийн хөгжлийн асуудлаар Хөгжлийн яамнаас боловсруулсан бодлогын баримт бичгийг Сайд нарын Зөвлөлөөр хэлэлцүүлэхээс өмнө хэлэлцэж тодорхой шийдвэр гаргадаг. Яам энэхүү зөвлөлийн ажлыг зохион байгуулах үүргийг гүйцэтгэдэг.
- *Бүсийн хөгжлийн агентлаг*- Орон нутгийн төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, уялдаа зохицуулалтыг хангах зорилгоор Хөгжлийн яамны харьяанд байгуулсан бөгөөд орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хийхээс гадна салбарын хөгжлийн бодлогын орон нутаг дахь хэрэгжилтийг зохион байгуулах, орон нутгаас салбарын болон улсын нэгдсэн төлөвлөлтөд оруулах санал

бэлтгэх, судалгаа хийх, мэдээллээр хангах чиг үүрэгтэй. Хөгжлийн агентлагууд нь газар дээр нь төлөвлөлтөө хийж, мөн газар дээр нь хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй байдаг. Хөгжлийн агентлагийн удирдах зөвлөлд Мужийн амбан захирагч нар, Хотын дарга нар /зарим/, Бүсийн удирдлага, Хөгжлийн агентлагийн дарга, чөлөөт бүс, үйлдвэрлэлийн бүсийн захирагч нар багтдаг байна.

- *Төв Анатолиагийн хөгжлийн агентлаг*- 2010 онд Хөгжлийн яамны харьяанд байгуулагдсан бөгөөд Төв Анатолиагийн бүсийн 3 мужийг хариуцан ажилладаг ба орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн санал боловсруулах, мэдээлэл бэлтгэх үүргийг хэрэгжүүлдэг.
- *Салбар төлөвлөлтийг хариуцсан газар*- Хөгжлийн яаманд энэ асуудлыг хариуцсан 2 газар байдаг. 1/ Нийгмийн салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар, 2/ Эдийн засгийн салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар юм. Эдгээр газрууд нь хариуцсан салбарын хөгжлийн бодлогыг хариуцан төлөвлөн хэрэгжүүлдэг. Хөгжлийн түвшин доогуур мужууд дахь эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг хөгжлийн түвшин дээгүүр мужуудын түвшинд хүргэж, муж хоорондын хөгжлийн ялгааг арилгахад чиглүүлэх юм.

- *Эдийн засгийн салбарын удирдах газар* нь дотроо 4 хэлтэстэй.

Эдгээр нь мөн тодорхой асуудал хариуцсан дараах нэгжүүдэд хуваагддаг.

- Хөдөө аж ахуй
- Үйлдвэрлэл
- Үйлчилгээ
- Тээвэр, эрчим хүч, логистик

- *Нийгмийн хөгжлийн салбарын удирдах газарт* 4 хэлтэс байдаг.

- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хэлтэс,
- Баялгийн хуваарилалт болон нийгмийн оролцооны хэлтэс,
- Соёл боловсрол, судалгаа хөгжүүлэлт, оролцооны хэлтэс,
- Ажил олголт, хөдөлмөрийн хэлтсүүд байдаг.

Зураг 9. Хөгжлийн яамны бүтэц, зохион байгуулалт



Хөгжлийн яам нь Орон нутгийн хөгжлийн удирдах 4 газар, 81 мужийг хамарсан Бүсийн хөгжлийн 26 агентлагаар дамжуулан хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлж байна.

Салбарын яамд нь тухайн салбарын төвлөрсөн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээдэг бол Хөгжлийн яам нь уялдаа зохицуулалтыг хангах чиг үүрэгтэй байдаг байна. Мөн орон нутагт салбарын бодлогыг төлөвлөх чиг үүргийг харьяа байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлдэг байна.

Бодлогын хэрэгжилтийн хяналт-үнэлгээ, мониторинг:

Турк улсад нэг хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ-үнэлгээний үр дүнг дараагийн хөгжлийн бодлогод тусгах үндсэн тогтолцоо бүрдсэн байдаг. Үүний тулд хэрэгжилтийн тайланг олон нийтэд ил тод тайлагнадаг байна.

Дунд хугацааны буюу гурав, нэг жилийн төлөвлөлтийн үе шатанд мониторинг хийх, тухайлбал, 3 сар тутамд хэрэгжилтийг хянаж, ямар арга хэмжээ авсныг хэлэлцдэг ба бүх яамдад тусгай комисс байгуулагдан өөрсдийн чиглэлээр дүгнэлтээ гаргадаг байна.

Хяналт, шинжилгээ-үнэлгээ нь зөвхөн бодлогын хэрэгжилтийн шатанд хийгдээд зогсохгүй бодлого боловсруулах үе шатанд мөн хийгддэг байна. Бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ өгөх, мониторинг хийх ажлыг Хөгжлийн яам удирдан зохион байгуулна. Төсвийн зарцуулалтад хяналт тавих ажлыг Үндэсний Их Хурлын бүрэлдэхүүнд байдаг Эдийн засгийн хороо болон Төсвийн хяналтын зөвлөл хариуцдаг.


Бүгд Найрамдах Латви улс

Тус улсын “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” нь 2009 оны 1 дгээр сарын 1-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба Латви улсын Сейм “Латвия-2030” тогтвортой хөгжлийн стратегийг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр баталжээ.

“Латвия-2030” тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжүүлэлт, хяналтын тогтолцоог дор үзүүлэв²².

²² Sustainable Development Strategy of Latvia until 2030. <https://eesti2030.files.wordpress.com>

Зураг 10. “Латвия-2030” тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжүүлэлт, хяналтын тогтолцоо



“Латвия-2030” тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хяналтыг нийгмийн удирдлага буюу Сайд нарын танхим, шууд удирдлагын байгууллагууд, нутгийн өөрөө удирдлагын байгууллагууд нь нийгмийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ.

Засгийн газар нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хариуцан гүйцэтгэдэг ба үүний дотор улс орны төлөвлөлт хариуцсан Яам нь тогтвортой хөгжлийн урт болон дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналтыг шууд хариуцан ажилладаг.

Латви улсын парламентын сонгуулийн дараах эхний ба гурав дахь жилүүдэд 2 жилд нэг удаа Сайд нарын танхимаас “Латвия-2030” тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх илтгэлийг Сеймд хэлэлцүүлэхээр оруулна. Мэдээллийн үндсэн дээр Сейм стратегийн зорилтуудад зарим өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргаж болно.

Сейм шинээр Тогтвортой хөгжлийн байнгын хороог байгуулсан бөгөөд тус хорооны гишүүд улс орны хөгжлийн төлөвлөлтийн тулгамдсан асуудлууд, “Латвия-2030” стратегийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн талаархи мэдээллийг тогтмол авдаг байна.

Үүний зэрэгцээ “Латвия-2030” тогтвортой хөгжлийн институтийг байгуулсан ба энэхүү институтын үндсэн зорилт нь Сайд нарын танхим, Сеймд танилцуулах

улс орны тогтвортой хөгжил, “Латвия-2030” стратегийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн талаархи илтгэлийг бэлтгэх явдал юм. Түүнээс гадна тус институт нь улс төрийн хариуцлагатай шийдвэр гаргахад шаардлагатай төрийн стратегийн чухал асуудлуудыг судалж, үндэслэлтэй зөвлөмж гаргах судалгааны найдвартай баазыг бий болгох, төрийн мөнгөний бодлого нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, тогтвортой хөгжлийн зарчимд нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх, нийтийн удирдлагын байгууллагууд, иргэний нийгэм, эрдэмтэд, судлаачдын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг зорилготой ажээ.

Мөн Сайд нарын танхимын дэргэд Хөгжлийн үндэсний зөвлөл ажилладаг ба түүнийг улс орны төлөвлөлт хариуцсан яамны сайд тэргүүлдэг байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сейм, Сайд нарын танхим, төлөвлөлтийн бүс, нутгийн өөрөө удирдах байгууллага, “Латвия-2030” тогтвортой хөгжлийн институт, ТББ-ын төлөөлөл байдаг.

Бүгд Найрамдах Казахстан улс

Казахстаны Ерөнхийлөгчийн 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Бүгд Найрамдах Казахстан Улсын төлөвлөлтийн тогтолцооны тухай” зарлигийн дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын төлөвлөлтийн тогтолцоо батлагджээ.

Казахстан улсын төлөвлөлтийн тогтолцоо гэдэг нь улс орны хөгжлийг урт (5 жилээс дээш), дунд (1-ээс 5 жил), богино (1 жил хүртэл) хугацаанд хангах улсын хөгжлийн төлөвлөлтийн зарчим, үйл явц, баримт бичиг, оролцогчдоос бүрдсэн харилцан хамаарал бүхий харилцааны цогц юм.²³

Тус улсын төлөвлөлтийн тогтолцоо нь дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Казахстаны 2050 он хүртэлх хөгжлийн Стратеги,
2. БНКазУлсын 10 жилийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө, Улс орны газар нутаг-орон зайн хөгжлийн прогнозын схем,
3. БНКазУлсын Үндэсний аюулгүй байдлын стратеги,
4. Нийгэм-эдийн засгийн 5 жилийн прогноз,
5. Улсын хөтөлбөрүүд (5 жил хүртэл),
6. Засгийн газрын хөтөлбөрүүд (5 жил хүртэл),
7. Төрийн байгууллагуудын 5 жилийн стратегийн төлөвлөгөө,
8. Бүс нутгийн хөгжлийн 5 жилийн хөтөлбөр,
9. Үндэсний компаниудын 10 жилийн хөгжлийн стратеги зэрэг болно.

Казахстаны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн “Казахстан -2050” Стратеги: Улсын шинэ улс төрийн чиг шугам” илгээлтийн²⁴ дагуу түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Ерөнхийлөгчийн № 449 Зарлиг гарсан. Уг Зарлигаар 2012 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Ерөнхийлөгчийн “Казахстан “2050 Стратеги”: Улсын шинэ улс төрийн чиг шугам” илгээлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний Үндэсний төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцах, “Казахстан-2050 Стратеги”-ийн талаарх Ерөнхийлөгчийн илгээлтийн талаар тайлбарлан-

²³ О Системе государственного планирования в Республике Казахстан. <http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>

²⁴ Послания Главы государства народу Казахстана от 14 декабря 2012 года «Стратегия «Казахстан-2050»: новый политический курс состоявшегося государства». online.zakon.kz/online.zakon.kz/

таниулах ажлыг нийгэм, олон нийтэд системтэйгээр явуулах, жил бүрийн 1 дүгээр сарын 25, 7 дугаар сарын 25-ны өдөр бүтэн жил болон хагас жилийн үр дүнгээр Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт танилцуулах, үүргийг Засгийн газарт, “Казахстан-2050” Стратегийн хэрэгжилтийн талаарх Ерөнхийлөгчийн Зарлигийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус өгчээ.

2010 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн “БНКаЗУ-ын Төлөвлөлтийн тогтолцооны цаашдын хэрэгжилтийн зарим асуудлын тухай” зарлигаар “БНКаЗУ-ын Хөгжлийн Стратеги төлөвлөгөө, улсын ба засгийн газрын хөтөлбөр, төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө, бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр, улс орны газар нутаг-орон зайн хөгжлийн прогнозын схемийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ, мониторинг хийх, хяналт тавих журмыг²⁵ баталсан байна.

Тус журмаар хөгжлийн төлөвлөгөө, **хөтөлбөрийн хэрэгжилт** үр дүнг хариуцах дараах байгууллага, албан тушаалтныг тодорхойлжээ. Үүнд:

1. “БНКаЗУ-ын Хөгжлийн Стратеги төлөвлөгөө, Улс орны газар нутаг-орон зайн хөгжлийн прогнозын схемын хэрэгжилтийг Казахстан улсын Засгийн газар, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан төрийн байгууллага, хамтран хэрэгжүүлэгч төрийн байгууллага,
2. Улсын хөтөлбөрийн хэрэгжилтийг Казахстан улсын Засгийн газар, хөтөлбөрийг боловсруулсан төрийн байгууллага, хамтран хэрэгжүүлэгч төрийн байгууллага, бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагын (улсын байгууллага, төрийн оролцоотой хувь нийлүүлсэн байгууллага) тэргүүнүүд,
3. Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг хөтөлбөрийг боловсруулсан төрийн байгууллага, хамтран хэрэгжүүлэгч төрийн байгууллага, бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагын тэргүүнүүд,
4. Төрийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн төрийн байгууллагын тэргүүн,
5. Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн бүс нутгийн Акимүүд тус тус хариуцан хэрэгжүүлэхээр заажээ.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөгжлийн стратеги **төлөвлөгөөний үнэлгээг** улсын төлөвлөлтийг хариуцсан эрх бүхий байгууллагаас Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээс хойш 5 жилийн дараа нийт тайлант хугацааны хэрэгжилтийн тайлан, статистик мэдээлэл, хяналт шалгалтын материал, төрийн аудит, гадаад, дотоодын шинжээчдийн дүн шинжилгээ, ТББ, шинжлэх ухааны хүрээлэнгийн үнэлгээнд үндэслэн хийж, үнэлгээний дүгнэлтийн төсөл бэлтгэх хэлбэрээр гаргана.

Хөгжлийн стратеги төлөвлөгөөний үнэлгээг хийхдээ улсын ба засгийн газрын хөтөлбөр, төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө, бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр, Үндэсний компаниудын хөгжлийн стратегийн хэрэгжилтийн үнэлгээтэй уялдуулахыг журмаар тодорхойлсон.

²⁵ Указ Президента Республики Казахстан от 4 марта 2010 года № 931. “О некоторых вопросах дальнейшего функционирования Системы государственного планирования в Республике Казахстан”. <http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>

Зураг 11. “Казахстан-2050” Стратегийн хяналтын тогтолцоо.



Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман Улс 2002 онд Холбооны Засгийн газраас дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийг 10 гаруй жил хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд Стратегийн хэрэгжилтийн явцын талаар 3 удаа дэлгэрэнгүй тайлан гаргасан бөгөөд тайланд үндэслэн Стратегийг тогтмол сайжруулж, боловсронгуй болгож иржээ. Холбооны Засгийн газар 2012 онд Стратегийн хэрэгжилтийн явцын тайлан гаргахдаа хамгийн сүүлийн нэмэлтийг хийсэн байна.

Тогтвортой хөгжлийн удирдлагын зарчим нь Удирдлагын дүрэм болон тогтвортой хөгжлийн зорилтууд, үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдээр тодорхойлогдох бөгөөд эдгээр нь тасралтгүй хяналт үнэлгээний суурийг бүрдүүлнэ. Удирдлагын үндсэн 10 дүрэм нь удирдлагын зарчмаас гадна тогтвортой хөгжлийн шаардлагуудыг илэрхийлнэ. 21 салбарын үндсэн индикатор, 38 тоон зорилт нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлохоос гадна үр дүнг хянахад чухал үүрэгтэй.

Тасралтгүй мониторингийн хүрээнд хэрэгжилтийн явцын тайлан тогтмол гарна. Хоёр жил тутамд Холбооны статистикийн байгууллага тогтвортой хөгжлийн индикаторуудын тайланг нийтэлдэг.

Дөрвөн жил тутам хэрэгжилтийн явцын тайлан хэлбэрээр Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийн тайланг гаргана. Уг тайланд Стратегийн хэрэгжилтийн явцыг үнэлэхээс гадна тавигдсан зорилтод хүрэх арга хэмжээний жагсаалтыг гаргаж, Стратегийн боловсронгуй болгоно.

Холбооны Засгийн газрын кабинет тогтвортой хөгжлийн стратегитэй холбоотой аливаа шийдвэрийг гаргана. Шаардагдах бэлтгэл ажлыг Тогтвортой хөгжлийн асуудлаарх төрийн нарийн бичгийн дарга нарын хороо гүйцэтгэнэ. Уг хороог Холбооны канцлерийн албаны дарга тэргүүлнэ. Хороо тогтвортой хөгжлийн стратегийн агуулгыг цаашид боловсронгуй болгох асуудлыг хариуцахаас гадна индикаторуудын тухайн үеийн байдлыг тогтмол хянана.

Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийн асуудлыг Холбооны канцлерийн алба хариуцна. Стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх яамдын албан тушаалтнууд оролцоно.

Тогтвортой хөгжлийн зөвлөл нь Холбооны Засгийн газарт тогтвортой хөгжлийн бүх асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй байгууллага юм. Зөвлөлийн 15 гишүүнийг холбооны канцлер 3 жилийн хугацаагаар томилдог. Зөвлөл мэргэжлийн хувьд хараат бус байгууллага бөгөөд Стратегийн хэрэгжилтийн талаарх өөрийн дүгнэлтээ нийтлэхээс гадна цаашдын хөгжлийн талаарх саналаа зөвлөмж хэлбэрээр гаргана.

Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцсан Парламентын зөвлөлдөх зөвлөл нь Бундестагт Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегийг дэмжин ажилладаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Development planning in Malaysia, <http://www.epu.gov.my>
- Agency for Economic and Development- Partners for Sustainable Development. www.bundesregierung.de
- How is the National Sustainable Development Strategy implemented?-www.nationale-nachhaltigkeitsstrategie.de
- The Korean National Strategy for Sustainable Development, 2006, sustainabledevelopment.un.org/content/documents/1394backgroundReport.pdf
- Sustainable Development Strategy of Latvia until 2030. <https://eesti2030.files.wordpress.com>
- О Системе государственного планирования в Республике Казахстан. <http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>
- Послания Главы государства народу Казахстана от 14 декабря 2012 года «Стратегия «Казахстан-2050»: новый политический курс состоявшегося государства». online.zakon.kz
- Указ Президента Республики Казахстан от 4 марта 2010 года № 931. “О некоторых вопросах дальнейшего функционирования Системы государственного планирования в Республике Казахстан”. <http://adilet.zan.kz/rus/docs/U090000827>
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийн танилцуулга, 4-р боть, 2015 он

**АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ГАДААДЫН ЗАРИМ
ОРНЫ ТУРШЛАГА**

*Г.Алтан-Оч PhD, Ц.Болормаа,
Ч.Онончимэг, Т.Саулегул, Д.Халиун*

АГУУЛГА

СУДАЛГААНД АШИГЛАСАН НЭР ТОМЬЁО

НЭГ МОНГОЛ УЛСЫН АРЬС ШИРНИЙ САЛБАРЫН ТАЛААР
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХОЁР: ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

- 2.1. БНХАУ
- 2.2. ОХУ
- 2.3. БНЭУ
- 2.4. БНТУ
- 2.5. БНСВУ

ХАВСРАЛТ - 1

ХАВСРАЛТ - 2

СУДАЛГААНД АШИГЛАСАН НЭР ТОМЬЁО

Судалгаанд арьс ширний салбарын зарим нэр томьёог “**Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай**” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоолд тусгасан утгаар ашигласан болно. Үүнд:

- “анхан шатны боловсруулалт хийсэн арьс, шир” гэж химийн болон механик аргаар боловсруулсан, идээлсэн, будсан болон будаагүй, тосолсон, хатаасан, өнгө засал хийгээгүй арьс, ширийг;
- “гандсан арьс, шир” гэж химийн аргаар үсийг нь унагаасан, механик аргаар шар махыг нь авсан, давс, хүчлээр боловсруулж, чанарын хамгаалалт хийсэн түүхий арьс, шир болон идээлэхэд бэлтгэж давс, хүчлээр боловсруулж, хөөлтгүй болгосон арьс, ширийг;
- “вет-блю” гэж химийн аргаар үсийг нь унагаасан, үсний угийг нь бүрэн гүйцэд авсан, механик аргаар халимлаж шар махыг авсан, өнгөн болон шар махан тал нь цэвэр толигор, нугалаасгүй, толбогүй, сульфат хромын суурьлаг давсаар нэвт идээлэгдсэн, жигд өнгөтэй нойтон хөх арьс, ширийг;
- “вет вайт” гэж химийн аргаар үсийг нь унагаасан, үсний угийг нь бүрэн гүйцэд авсан, механик аргаар халимлаж шар махыг авсан, өнгөн болон шар махан тал нь цэвэр толигор, нугалаасгүй, толбогүй, сульфат хромын суурьлаг давснаас бусад идээлэгчээр идээлсэн нойтон цагаан арьс, ширийг;
- “краст” гэж энэхүү техникийн зохицуулалтын 1.5.3, 1.5.4-т заасан хагас боловсруулсан арьс, ширэнд нэмэлт идээлэг хийж, будсан болон будаагүй, тосолж, элдэж, тэлж хатаасан, өнгө засал хийгээгүй арьс, ширийг;
- “хувцасны савхи буюу шевред” гэж энэхүү техникийн зохицуулалтын 1.5.5-д заасан краст (хагас боловсруулсан хонины арьс)-ыг цаашид хувцасны зориулалтаар гүйцэд боловсруулж, өнгө засал хийсэн хонины арьсыг;
- “илэг” гэж энэхүү техникийн зохицуулалтын 1.5.5-д заасан краст (хагас боловсруулсан арьс, шир)-ыг шар махан талаас нь зүлгэж, цаашид гүйцэд боловсруулсан арьс, ширийг;
- “нубук” энэхүү техникийн зохицуулалтын 1.5.5-д заасан краст (хагас боловсруулсан арьс, шир)-ыг нүүрэн талаас нь зүлгэж, цаашид гүйцэд боловсруулсан арьс, ширийг;
- “хром” энэхүү техникийн зохицуулалтын 1.5.5-д заасан краст (хагас боловсруулсан шир)-ыг цаашид гүйцэд боловсруулж, өнгө засал хийсэн ширийг;
- “юфть” энэхүү техникийн зохицуулалтын 1.5.3 болон 1.5.4-т заасан хагас боловсруулсан ширэнд нэмэлт идээлэг хийж, будсан болон будаагүй, их хэмжээгээр тосолж, элдэж, тэлж хатаасан, өнгө засал хийсэн ширийг;
- “булигаар” энэхүү техникийн зохицуулалтын 1.5.3 болон 1.5.4-т заасан хагас боловсруулсан ширэнд нэмэлт идээлэг хийж, будсан болон будаагүй, тосолж, элдэж, тэлж хатаасан, өнгө засал хийсэн, хээ тавьж арласан ширийг;

- “шевро” энэхүү техникийн зохицуулалтын 1.5.5-д заасан краст (хагас боловсруулсан ямааны арьс)-ыг цаашид гүйцэд боловсруулж, өнгө засал хийсэн ямааны арьсыг ойлгоно.

Судалгааны хураангуй:

Судалгааны агуулгын хүрээнд Монгол болон бусад орнуудын (БНХАУ, ОХУ, БНЭУ, БНТУ, Вьетнам улс) арьс ширний салбарын өнөөгийн байдал, төрөөс баримталж буй бодлого болон Засгийн газрын дэмжлэгийн талаарх мэдээллийг оруулсан ба БНЭУ, БНТУ-ын арьс ширний салбарт хийсэн СВОТ шинжилгээ, Турк улсын хагас боловсруулсан арьс ширний өртгийн шинжилгээ зэрэг аналитик мэдээлэл, мөн судалгаанд хамрагдсан орнуудын арьс ширний салбарын хөгжлийн цаашдын чиг хандлага, тулгарч буй сорилт хийгээд хүрэхийг зорьж буй түвшин зэрэг мэдээллийг хамруулсан болно. Арьс ширний салбарын суурь зардлуудын үнэ тарифын зохицуулалтын талаарх мэдээллийг захиалагчид өмнө нь хүргүүлсэн “Үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйлдвэрлэлийн суурь зардлын үнэ тарифын зохицуулалт болон гадаадын зарим орны туршлага” сэдэвт судалгаанаас үзэх боломжтой.

Судалгаанаас үзэхэд, ОХУ болон БНХАУ-ын хувьд хагас боловсруулсан арьс ширний өртөгт түүхий эдийн эзлэх хувийн жин 55-60 хувь буюу дийлэнх хувийг эзэлж байгаа нь тухайн салбарын бүтээгдэхүүний өртөг малын тоо хэмжээ, тарифын болон тарифын бус зохицуулалтаас ихээхэн хамааралтай байгааг харуулж байна. Дээрх хоёр орны хувьд түүхий эдийн хомсдол нь томоохон асуудал болоод байгаа бөгөөд аль болох түүхий болон хагас боловсруулсан арьс шир экспортод гаргахгүй байх, дотооддоо бүрэн боловсруулалт хийж нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл явуулахыг эрмэлзэж байгаас харагдаж байна. Түүхий эдийн хэмжээнээс гадна түүхий эдийн чанар чухал ач холбогдолтой бөгөөд гологдолгүй, хаягдал багатай түүхий эд боловсруулахад төрөөс онцгойлон анхаарч дэмжлэг үзүүлдэг байна. Арьс ширний үйлдвэрлэлийн хувьд аль болох байгаль орчинд ээлтэй химийн бодис, техник, технологийг нэвтрүүлэх нь чухал хэмээн үзэж төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хятад улсын хувьд арьс ширний үйлдвэрлэлийг кластер буюу үйлдвэрлэлийн паркад төвлөрүүлж, зөвхөн тухайн кластерт үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд суурь хэрэглэгдэхүүн болох ус, цахилгаан, дулааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх, мөн бохир усны цэвэрлэгээг нэгдсэн журмаар шийдвэрлэж, тодорхой байгууллагаас хяналт тогтоон ажиллах зэрэг аргуудыг хэрэгдэж байна.

БНЭУ-ын хувьд арьс ширний экспортоор дэлхийд 9-рт, арьсан гуталны үйлдвэрлэлээр дэлхийд 2-рт орж байна. Арьс ширний салбарын хөгжлийн цаашдын чиг хандлага нь нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, бүтээгдэхүүний экспортыг хурдацтай нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа тул хагас боловсруулсан арьс ширний гадаадад худалдан борлуулахаас татгалзах бодлого баримталж байна. “Энэтхэгийн арьс ширний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үйлдвэрлэлийн технологийн сайжруулалтыг шат дараатайгаар дэмжих, инноваци, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийн хөгжил, тэр

дундаа гар урчуудын техник, ур чадварыг хөгжүүлэх болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг арьс ширний салбарын гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгсэн олон арга хэмжээнүүдийг авч байна.

БНТУ-ын хувьд, хагас боловсруулсан арьс ширний нийт өртгийн 61 хувийг үндсэн түүхий эд, 18 хувийг дайвар бүтээгдэхүүн, 11 хувийг ажиллах хүчний зардал ба нийгмийн зардал, 3 хувийг санхүүжилт ба элэгдэл хорогдлын зардал, үлдсэн 6 хувийг үйлдвэрлэлийн суурь зардал буюу цахилгаан, ус, дулааны зардал эзэлж байна. Тус улсын хувьд боловсруулаагүй арьс ширний нөөцийн хомсдол, бүтээгдэхүүний нийт өртөгт шингэх зардлууд өндөр үнэ өртөгтэй байгаа нь үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна гэж үздэг. Ажиллах хүчний зардал, цахилгаан эрчим хүчний үнэ тариф, материал техникийн хангамж, хог хаягдлын зардал нь үйлдвэрлэлийн өртөгт хамгийн их нөлөө үзүүлдэг байна.

Үйлдвэрлэлд ашиглаж буй технологиос тухайн салбарын өрсөлдөх чадвар ихээхэн шалтгаалахаас гадна арьс ширний үйлдвэрлэлийг дэд бүтэц хөгжсөн, хог хаягдал болон цэвэрлэх байгууламжийн асуудалыг нэгдсэн журмаар шийдвэрлэсэн, зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүсэд явуулах нь зүйтэй гэдэг нь судалгаанд хамруулсан ихэнх орны туршлагаас харагдах бөгөөд төрийн бодлого, авч буй арга хэмжээ нь ч үүнд чиглэгдэж байна.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН АРС ШИРНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

Арьс ширний салбарын өнөөгийн байдал:


Өнөөгийн байдлаар Монгол улсын арьс ширний салбарт арьс шир боловсруулах 35 үйлдвэр, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 100 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хүчин чадлынх нь хувьд авч үзвэл 56% нь том үйлдвэр, 25% нь дунд үйлдвэр, 19% нь жижиг үйлдвэр байна.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл жил тутам өсөж байгаа бөгөөд салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2011 онд 33 200.8 сая.төг байсан бол 2014 онд 43 777.3 сая.төг болж 24 хувиар өссөн. Арьс шир боловсруулах, ширэн эдлэл үйлдвэрлэлийн хувьд 2011 онд 2 547.5 сая.төг байсан бол 2015 онд 24 183 сая.төг болж 12 дахин өссөн байна.

Манай улсын арьс ширний салбараас улсын төсөвт төвлөрүүлэх боломжтой орлогын талаар Монголын арьс ширний холбооноос хийсэн судалгаанд дурдсанаар, "... манай улс арьс ширийг түүхийгээр нь гадаадад гаргаж байгаагаас жилд 60.6 тэрбум төгрөг алдаж байгаа ба хэрэв уг арьс ширийг 100 хувь хагас боловсруулбал 86.7 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой гэсэн тооцоо гаргажээ. Хэрэв савхи, гутлын хром хийж экспортод гаргавал 138.2 тэрбум төгрөгийн орлого, 100 хувь бэлэн хувцас савхин эдлэл хийвэл 350 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой гэж үзсэн байдаг.

*Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтаар нь авч үзвэл:
сая.төгрөгөөр*

	2011 ОН	2012 ОН	2013 ОН	2014 ОН	2015 ОН
Арьс, арьсан бүтээгдэхүүн нийт үйлдвэрлэл	33 200.8	40 067.3	40 777.3	43 020.1	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл гутал үйлдвэрлэл	2 547.5	9 176.5	10 343.9	16 062.4	24 183.0
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл гутал борлуулалт	2 451.5	8 565.1	8 409.3	14 911.1	22 983.7




Манай улсын малын тоо толгой өсч жил бүр дунджаар 800 гаруй мянган ширхэг арьс, шир нэмж бэлтгэн, мөн нийт арьс, ширний нөөцийг давуулан ашиглаж чадах хүчин чадал бүхий арьс, шир боловсруулах 40 гаруй, 14 үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл анхан шатны боловсруулалтын хүчин чадал түүхий эдийн нөөцөөс 12.6 хувиар давжээ. Гэсэн хэдий ч эдгээр үйлдвэрүүд нь хүчин чадлынхаа 30-40 орчим хувийг ашиглаж, үлдэх хэсэг нь гадаадын худалдаачдаар дамжин экспортод гарсаар байна.

Дэлхийн зах зээлд жилд дунджаар олон улсын стандартын шаардлага хангасан 60-70 сая ширхэг хонины нэхий болон ямааны арьсны хэрэгцээ байгаагаас манай улс 10-аас доошгүй хувийг нь нийлүүлэх бололцоотой юм байна.

Монгол Улсын арьс ширний түүхий эдийн экспортыг авч үзвэл:

Арьс ширний салбарын гадаад худалдааны экспортын хэмжээ

Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Нийт эргэлт	сая.ам.доллар	11 415.85	11 123.50	10 627.40	11 011.20	8 466.60
Экспорт	сая.ам.доллар	4 817.50	4 384.60	4 272.70	5 774.60	4 669.50
Арьс ширний салбарын экспорт						
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	мян.ам.доллар	51 130.1	30 548.3	35 170.4	35 800.5	33 805.6
Үхэр, адууны боловсруулсан шир /сая.дм ² /	тоо ширхэг	66.9	43.0	43.1	58.4	69.5
	үнийн дүн /мян.ам.доллар/	9 695.3	5 339.1	5 364.9	7 981.9	8 284.6
Үхэр, адууны боловсруулаагүй мян.ш	тоо ширхэг	273.6	200.7	350.2	240.0	117.9
	үнийн дүн /мян.ам.доллар/	2 863.6	2 162.1	4 105.9	2 870.8	1 799.4
Хонь, хурганы хагас боловсруулсан арьс буюу шеврет /сая.дм ² /	тоо ширхэг	331.5	182.5	162.2	110.2	147.7
	үнийн дүн /мян.ам.доллар/	28 197.9	16 074.2	15 316.8	10 880.5	12 274.3
Ямаа, ишигний хагас боловсруулсан арьс буюу шевро /сая.дм ² /	тоо ширхэг	120.9	61.1	92.1	128.8	122.3
	үнийн дүн /мян.ам.доллар/	9 935.7	6 549.5	9 883.6	13 737.6	10 256.8



Манай улсын арьс, ширний салбарын гадаад худалдааны экспорт БНХАУ-аас шууд хамааралтай бөгөөд нийт арьс, арьсан бүтээгдэхүүний 90 орчим хувийг БНХАУ руу экспортлож байна. Гадаад худалдааны 2011-2015 оны арьс ширний экспортын хэмжээг авч үзвэл түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн экспортын хэмжээ 2015 онд 33 805.6 мян.ам.доллар болж 2011 онтой харьцуулахад 34%-аар буурсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1995.0 мян.ам.доллар буюу 6 хувиар буурсан байна.

Арьс ширний салбарын үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарыг дэмжих бодлогын хүрээнд 2002-2012 он хүртэлх хугацаанд төрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байсан бол 2012-2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засагт үзүүлэх үүргийг нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн гол зохицуулалт бүхий баримт бичгийг баталсан болно.

“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 12 сарын 28 өдрийн 74 дүгээр тогтоолыг баталсан байна. Уг тогтоолоор дараах гол зохицуулалтыг тусгаж өгсөн. Үүнд:

- “Арьс, ширний дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалах, зээлийн жилийн хүү 7 хувиас илүүгүй байх;
- Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох;

- Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах зэрэг болно.

Арьс ширний салбарын технологийн түвшин Монгол улсын Засгийн газраас “Арьс ширэн үйлдвэрлэл худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг 300 дугаар тогтоолоор батлан гаргаснаар арьс ширний салбарын тодорхой стандартуудыг заавал мөрдөх болгож хэрэгжүүлснээр гадаад, дотоод худалдааг эрхлэх, дэмжих эрх зүйн орчин бүрдэж байна.

Арьс ширний салбарт тулгамдаж буй гол асуудлууд:

1/ Түүхий эдийн чанар муу: Үүний шалтгаан нь малчид малаа угаах ариутгадаггүйгээс гадна, мал нядлах үедээ санамсаргүйгээс болж цоолж гэмтээх явдал их гардаг. Сорви гүврүү, нүх нь арилжих, худалдах үед мэдэгдэхгүй бөгөөд арьсыг боловсруулах явцад гарч ирдэг бөгөөд энэ нь сайн чанарын арьсан хүрэм, бусад хувцас үйлдвэрлэхэд саад учруулдаг учир нүхтэй арьсаар гол төлөв цүнх, гутал, түрийвч үйлдвэрлэдэг байна.

2/ Түүхий эдийн нийлүүлэлтийн суваг муу: Гадаадын (Хятад улсын) болон дотоодын арьс ширний ченжүүдтэй шууд холбоотой. Эдгээр ченжүүд нь арьс ширний түүхий эд худалдан авагчдийн 90 гаруй хувийг эзлээд байгаа тул түүхий эдийн үнэ тэдгээрээс шууд хамааралтай. Мөн түүхий эдийн төвлөрсөн зах байхгүй, түүхий эд нийлүүлэлтийн суваг оновчтой бүрэлдэн тогтож чадаагүйгээс үйлдвэрлэгчид түүхий эдийн хомсдол, тасалдалд орох эрсдэлүүд мөн гардаг байна.

3/ Санхүүжилтийн эх үүсвэр муу: Монголын арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчид мал нядлах богинохон хугацаанд буюу 11,12 дугаар саруудад эргэлтийн хөрөнгийн хомсдолд их ордог. Ийнхүү арьс ширний үйлдвэрүүд богино хугацаанд үлэмж хэмжээний өрөнд орж, бага хүүтэй зээл авах боломж бүхий Хятадын компаниудтай өрсөлдөх чадваргүй болдог байна.

4/ Тоног төхөөрөмжийн хоцрогдол ихтэй: Монголын арьс шир боловсруулах технологи хэт хуучирсан бөгөөд тоног төхөөрөмжийг шинэчлэх, арьс ширний боловсруулалтанд химийн технологийг ашиглах нь нэн тэргүүнд авах арга хэмжээний нэг юм.

ХОЁР: ЗАРИМ ОРНЫ АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТУРШЛАГА

2.1. БНХАУ

БНХАУ-ын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын тойм: Хятадын арьс, ширний үйлдвэрлэлийн хөгжлийг 1978 оны эдийн засгийн шинэтгэлийн анхны давалгаа буюу Хот болон тосгоны өмчит компаниудыг үүсгэн байгуулсан, мөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Хятадад ихээр хөрөнгө оруулах болсон хоёр дахь давалгаатай холбон тайлбарлаж болох юм. Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хөнгөлөлт урамшуулал олгох бодлогын хүрээнд газар болон цахилгаан хангамжид хөнгөлөлт олгох, импортын татвар хураамжийг бууруулах, татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ.

Эдийн засгийн шинэтгэлийн бодлогын хүрээнд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн бөгөөд шинээр батлагдсан Компанийн тухай хуулиар Төрийн өмчит компаниудыг Хувьцаат хариуцлагат компаниуд болгон өөрчлөн байгуулсан. Түүнчлэн “Нээлттэй хаалганы бодлого” хэрэгжүүлсэн нь худалдаа, хөрөнгө оруулалтыг либералчилж, чөлөөлж өгсөн юм. Эдгээр стратегиудыг хэрэгжүүлснээр эдийн засаг сүүлийн 30 жилийн хугацаанд жилд дунджаар 10 хувиар өсчээ. 1990-ээд онд Засгийн газраас дахин эдийн засгийн шинэтгэл явуулсны хүрээнд валютын ханш тогтоох механизм, татвар болон санхүүгийн тогтолцоог шинэчлэх, санхүүгийн зохицуулах тогтолцоог өөрчлөн байгуулах болон барууны нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмыг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авчээ. 2008 оны хямралаас үүдэж эдийн засаг удааширч, экспорт буурсан үед ч Хятадын Засгийн газар нь либералчлах бодлого үргэлжлүүлсэн бөгөөд эдийн засгийн өсөлтийг хангах үүднээс дэд бүтэц болон хурдны зам, төмөр зам, боомтууд, нисэх онгоцны буудлууд, цахилгаан болон харилцаа холбоо зэрэг төрөөс үзүүлэх нийтийн аж ахуйн үйлчилгээнд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн. Олон улсын худалдааг өргөжүүлэх урт хугацааны стратегийн хүрээнд нөөц баялаг, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн зөөвөрлөх, экспортыг нэмэгдүүлэхэд далайн эрэг орчмын боомтуудыг хөгжүүлэх асуудал тэргүүнд тавигдаж байгаа бөгөөд дэлхийн хамгийн ачаалал ихтэй 5 боомтын 3 нь Хятадад байрлаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг уян хатан бодлого, татварын хувь хэмжээг бууруулах зэрэг хэлбэрээр дэмжиж байгаа юм. Үүний үр дүнд хэд хэдэн гадаадын хөрөнгө оруулалттай компани арьс ширний үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулсан бөгөөд тэдгээр нь арьсан бараа бүтээгдэхүүний экспортын дийлэнх хувийг эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад үзүүлж буй дэмжлэгийн тухай дурдвал:

Татвар:

- a) ГХО-тай ААН-д ашиг олж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлөх;
- b) Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийн бүс дахь татварын хувь хэмжээг бууруулах: ААНОАТ нь бусад газруудад дотоодын компаниудын хувьд 55%, ГХО-тай ААН-д 40% байгаа бол Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийн бүсэд дээрх татвар нь 15% байна;
- c) Түүнчлэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 70-аас дээш хувийг экспортолдог компаниудад татварыг 10%-аар нэмж бууруулна;
- d) Экспортын татварын буцаан олголт 2004 он хүртэл 15-17%, 2007 он хүртэл 13% байсан байна.

Хөнгөлөлт:


- a) Тодорхой шинжлэх ухаан, технологийн төслүүдэд судалгаа боловсруулалтын ажилд зориулан шууд санхүүгийн дэмжлэг, тэтгэмж олгох;
 - b) Газрыг үнэгүй, эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, үнэгүй олгогдсон газрууд нь орон нутгийн удирдлагын мэдэлд байна;
 - c) Цахилгаан болон бусад суурь хэрэглэгдэхүүнд хөнгөлөлт эдлүүлэх;
- Зам, боомт, харилцаа холбоо, цахилгаан, усан хангамж зэрэг дэд бүтцүүдийг барьж байгуулах.

- Төрийн үйлчилгээг түргэн шуурхай нэг дор явуулах, нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх.

Арьс ширний үйлдвэрлэл нь эдгээр шинэтгэл, хөнгөлөлт, дэмжлэгийн үр шимийг хүртэж, зах зээлийг либералчилж, Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-д элссэн зэрэг нь импортын тарифыг бууруулж, Хятадын арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчдэд түүхий эд, химийн бодис, тоног төхөөрөмжөө хямд үнээр авч, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулж олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх боломж олгосон байна.

Европ, АНУ зэрэг арьс ширний томоохон зах зээлүүд импортын хатуу стандарт баримталдаг нь арьс шир үйлдвэрлэгч орнуудын худалдааны хэмжээг ихээхэн хязгаарладаг байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэх хүрээнд Хятадын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо /ХАШҮХ/-оос олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Genuine leather mark”-гэх барааны тэмдгийг бүртгүүлжээ. Хятадын арьс ширний салбарын хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг *Zhejiang, Fujian, Guangdong, Sichuan and Chongqing* гэх 5 кластер татаж чадсан нь том хэмжээний захиалгыг зардал багатайгаар гүйцэтгэж, захиалагчид түргэн шуурхай хүргүүлэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Гадаад болон дотоодын үйлдвэрлэгч, дэлхийн томоохон брэндүүдээс авсан том хэмжээний захиалгуудыг кластер дотроо хуваарилж, цаг тухайд нь гүйцэтгэхэд дөхөмтэй байх ба нэг төрлийн үйлдвэрлэгч нар газар зүйн хувьд ойрхон байрлах нь дэд бүтцээ оновчтой, зардал багатай шийдэх, үйлдвэрлэл болон тээвэрлэлтийн зардлыг хэмнэх бололцоогоор хангаж өгсөн байна.

Бүрэн боловсруулсан арьс ширний үйлдвэрлэл, мужаар (2014 оны байдлаар)



Эх үүсвэр: Хятадын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, 2015 -9 сар

Арьс ширний үйлдвэрлэлээ кластерт төвлөрүүлэн хөгжүүлсэн нь Хятадын арьсан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ихээхэн нөлөөлсөн байна. Төв болон орон нутгийн удирдлагууд нь тухайн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх таатай орчныг бүрдүүлэхэд аж үйлдвэрийн кластеруудыг ихээхэн дэмжиж ажилладаг

бөгөөд тэдгээрийн авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг дурдвал:

Чиглэл	Арга хэмжээ
Төлөвлөлт болон удирдамж	Засгийн газраас тодорхой бүсүүдэд аж үйлдвэрийн кластерыг хэт ширүүн өрсөлдөөн болон хөрөнгө оруулалтыг давхардалгүй, үр ашигтай болон зохион байгуулалттай байгуулалттай хөгжүүлэх
Нөөцийн үр ашигтай зарцуулалт	Газар, ус болон эрчим хүч зэрэг нөөцийн зарцуулалт үр ашигтай болон байгальд ээлтэй байгаа эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах
Тэргүүлэгч байгууллагуудыг дэмжих, нарийвчлал, мэргэшлийг нарийвчлах	Засгийн газраас тэргүүлэгч үйлдвэрлэгч болон хамаарал бүхий үйлдвэрлэлүүдийг хөхүүлэн дэмжих, тодорхой дэмжлэг үзүүлэх
Инноваци	Засгийн газар нь компаниудад мэдээллийн технологи ашиглах, нэвтрүүлэхийг нь дэмжих, компаниуд болон судалгаа боловсруулалтын хоорондын ажиллагааг дэмжиж ажиллах
Брэнд бий болгох, бүтээх	Засгийн газар нь компаниудын болон тэдгээрийн брэндийн нэрийн бүтээгдэхүүний патент бүртгүүлэхэд үйлдвэрлэлийн холбоодыг дэмжиж байна
Орон нутгийн удирдлагын хүчин чармайлт	Орон нутгийн удирдлагууд нь өөрсдийн нутаг дэвсгэр дээрх кластеруудыг дэмжих, хөгжүүлэх, бүтээн байгуулалтыг түргэтгэх чиглэлээр төлөвлөгөө, удирдамж батлах болон холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Тухайлбал: төрөөс үзүүлэх нийтийн аж ахуйн үйлчилгээний платформ байгуулах, аж үйлдвэрийн кластеруудад брэнд бий болгох, аж үйлдвэрийн парк байгуулах.

Сүүлийн жилүүдэд Хятадад байгаль орчныг хамгаалах, хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр Хятадын арьс ширний үйлдвэрлэл нь Пакистан, Африкийн орнуудтай харьцуулбал үнэтэйд тооцогдож байна. Арьс ширний үйлдвэрлэгчдэд тулгарч буй хүндрэлүүдийн тоонд түүхийн эдийн тогтвортой хангамжаас гадна оновчтой маркетингийн стратеги, удирдлагын стратеги болон хүний нөөцийн асуудлууд орж байна.

Дэлхийн санхүүгийн хямралаас үүдэн арьс ширний үйлдвэрлэлийн экспортын өсөлт удааширсантай холбоотойгоор Засгийн газраас эдийн засгийн хямралтай тэмцэх багц арга хэмжээ хэрэгжүүлсэн бөгөөд үүнд гутал болон арьсан эдлэлийн үйлдвэрлэл зэрэг 10 хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг сэргээхээр тусгасан байна. Үүнээс гадна санхүүгийн хүндрэлтэй ЖДҮ-ийг санхүүгийн болон татварын бодлогоор дэмжих, тэдгээрийг хөгжүүлэхэд техник, технологийн шинэчлэл болон бүтцийн өөрчлөлт хийсэн байна. Арьс ширний үйлдвэрлэлд хэрэгжүүлсэн тодорхой бодлогын хүрээнд дараах баримт бичгийг баталсан байна. Үүнд:

- “Худалдаанд зориулсан түүхий шир болон хагас боловсруулсан арьсны импортод тавигдах шинэ шаардлага” /Худалдааны яам, Байгаль орчин хамгааллын газар болон Гаалийн ерөнхий газар №8 2009 оны 3-р сарын 2/
- “Зарим барааны экспортын татварын буцаалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх” /2009 оны 6-р сарын 3/

Арьс ширний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал:

Хятадын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны мэдэгдсэнээр Хятад Улс нь дэлхий арьс ширний 20% буюу жилд дунджаар 7.7 тэрбум кв.фут (71.5 тэрбум кв.дм) арьс үйлдвэрлэдэг байна. Үүнээс гадна 14 тэрбум ширхэг гутал, 70 сая ширхэг арьсан эдлэл мөн 980 сая арьсан цүнх үйлдвэрлэдэг байна. Хятадад үйлдвэрлэсэн арьс ширэн бараа бүтээгдэхүүний тал хувийг нь экспортод гаргадаг байна. *Wenzhou (Zhejiang муж)*, *Guangzhou (Guangdong муж)*, *Quanzhou (Fujian)* болон *Chengdu (Sichuan муж)* нь Хятадын гутлын үйлдвэрлэлийн төвүүд бөгөөд Хятадад үйлдвэрлэсэн гутлын 90% нь дараах 4 мужид үйлдвэрлэгдэж байна: *Zhejiang 37.1%*, *Guangdong 27.9%*, *Fujian 15.0%*, *Sichuan 10%*. *Haining (Zhejiang муж)*, *Xinji (Hebei)* нь арьсан эдлэл, *Hebei* болон *Guangdong муж* нь арьсан цүнхний үйлдвэрлэлээрээ тус тус тэргүүлдэг байна. *Henan мужийн Sanpo* болон *Hebei мужийн Suning* нь үслэг эдлэлийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч нь бол *Henan* нь ямааны арьсны үйлдвэрлэлээр 1-т орж байна.

Хятадын арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь арьс ширний үйлдвэрлэл, гутлын үйлдвэрлэл, арьсан эдлэл, арьсан хувцас, үслэг эдлэл болон арьс ширний дагалдах үйлдвэрлэл болох арьсан химийн инженер, арьс ширний тоног төхөөрөмж, арьс ширний тоноглол болон гутлын материал гэсэн 5 салбараас бүрдэж байна. Арьс ширний салбарын хөгжлийн явцад үйлдвэрлэл, менежмент, шинжилгээ судалгаанаас хүний нөөцийн сургалтыг багтаасан цогц системийг бүрдүүлж чадсан байна.


Зах зээлийн бүтэц:

Хятадын арьс ширний салбар нь төрийн өмчит хэлбэрээс хувийн өмчлөл рүү шилжсэн бөгөөд арьс ширний үйлдвэрлэлийн чанарыг хангахын тулд үйлдвэрлэлүүдийг цөөлсөн байна. Арьс ширний салбарт 2010 он хүртэл 26520 аж ахуйн нэгж байсан ба 2005 оноос хойш 4000 гаруй жижиг, хуучирсан үйлдвэрүүдийг татан буулгажээ.

Арьс ширний салбар нь дараах гол хэсгүүдэд хуваагдаж байна:

- Арьс боловсруулах, идээлэх, өнгөлөх (2,079 нэгж)
- Гутал болон гутлын дагалдах хэрэгсэл (10,206 нэгж)
- Арьсан эдлэл/бээлийн (3,020 нэгж)
- Арьсан цүнх болон жижиг арьсан эдлэл (7,416 нэгж)
- Үслэг эдлэл (3,338 нэгж)
- Арьс ширний хими (157 нэгж)
- Арьс ширний төхөөрөмж (303 нэгж)

Арьс ширний үйлдвэрлэлийн голлох салбарууд



Арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь дараах 12 газар нутагт төвлөрч байна:

- Wenzhou хот, Zhejiang муж - Хятадын гутлын төв
- Haining, Zhejiang муж - Хятадын арьс ширний төв
- Xinji, Shijiazhuang хот, Hebei муж – Хятадын арьс шир болон арьсан эдлэлийн төв
- Huadu, Guangzhou хот, Guangdong муж, - Хятадын арьсан эдлэлийн төв
- Chongfu, Jiangxing хот, Zhejiang муж- Хятадын үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн хот
- Suning, Cangzhou хот, Hebei муж – Хятадын үслэг эдлэлийн төв
- Wuhou дүүрэг, Chengdu хот, Sichuan муж – Хятадын эмэгтэй гутлын төв
- Bishan дүүрэг, Chongqing хот- Баруун Хятадын гутлын төв
- Huidong County, Guangdong муж – Хятадын эмэгтэй гутлын үйлдвэрлэлийн бааз
- Tongerpu, Shenyang хот, Liaoning муж – Үслэг болон арьсан эдлэл
- Baigou Town, Gaobeidian хот, Hebei муж- Цүнх, чемодан
- Jinjiang хот, Fujian муж – Гутал үйлдвэрлэлийн бүс

Хятадын арьсан гутлын үйлдвэрлэлийн кластерууд, 2013



Эх сурвалж: Хятадын Статистикийн хороо

Хятадын дотооддоо үйлдвэрлэсэн арьс ширний зах зээл нь харьцангуй өрсөлдөөнтэй юм. Ихэнх компаниуд нь жижиг ангилалд багтах бөгөөд харьцангуй адил үнээр том үйлдвэрлэгч нарт борлуулдаг. Нөгөөтэйгүүр сүүлийн жилүүдэд нэмэгдэж буй том компаниудын ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалттай байгаа бөгөөд голчлон экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулж, дотоодын зах зээлтэй харьцуулбал бараа бүтээгдэхүүнээ өндөр үнээр борлуулж байна.

Хятад нь арьс ширний үйлдвэрлэлээрээ тэргүүлдэг хэдий ч дэлхийн бусад орнуудаас түүхий болон бүрэн боловсруулсан арьс шир импортолдог юм. Хятадад үйлдвэрлэгддэг арьсан бүтээгдэхүүний түүхийн эдийн 80% дотоод, харин 20%-ийг нь гадаадын орнуудаас импортолж байна. Импортын гол бүтээгдэхүүн нь: түүхий арьс шир, хагас болон бүрэн боловсруулсан арьс шир, мөн арьсан цүнх, чемодан, гутал болон бусад эдлэлүүд байна. Ийнхүү тус улс нь түүхий арьс, шир, хагас болон бүрэн боловсруулсан арьс ширний импортоороо дэлхийд тэргүүлж байна.

Үйлдвэрлэлийг дэмжих бодлого:

Хятадын түүхий арьс шир болон холбогдох бүтээгдэхүүний талаар баримтлах бодлого нь тухайн салбарын цаг үеийн хэрэгцээ шаардлагыг илтгэх юм. Эхэндээ Хятадын Засгийн газар нь түүхий арьс шир импортлох, савхин бараа бүтээгдэхүүн экспортлоход ямар нэг хязгаарлалт тавьдаггүй байсан бол зарим мужуудад арьс ширний үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж ирсний дараа баримталж буй бодлогоо эргэн харах шаардлага гарсан байна. Түүхий арьс, ширийг идээлэх, боловсруулах нь бохирдол ихтэй, эрчим хүч ихээхэн зарцуулдаг үйлдвэрлэлд тооцогдох болсон ба төрөөс тухайн салбарыг өргөжүүлэхгүй байх бодлогыг барьж эхэлсэн байна.

2006 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн түүхий арьс ширний импортод хориг тавьсан ба энэ нь байгаль орчинд хор хөнөөлтэй, нэмүү өртөг бага шингэсэн үйлдвэрлэлийг дэмжихгүй гэсэн бодлого юм. Үүний үр дүнд түүхий эдийн импортоос хамаарал бүхий экспортод чиглэсэн олон тооны хагас боловсруулах үйлдвэрүүд хаагдахаас гадна Засгийн газар нь хагас болон бүрэн боловсруулсан арьс ширний экспортын татварын буцаалтыг цуцалсан байна.

2006 оны 9 дүгээр сард хагас боловсруулж экспортод гаргах зориулалт бүхий түүхий эдийн Арьс ширний импортын хоригийг үргэлжлүүлэн тогтоосон боловч бүрэн боловсруулалт хийж, гүйцэд бүтээгдэхүүн экспортлох зориулалт бүхий түүхий арьс шир боловсруулах үйлдвэрлэлийг тодорхой нөхцөлтэйгээр зөвшөөрсөн байна. Энэ нь дээрх чиглэлийн үйлдвэрлэлийг зөвхөн Экспорт боловсруулалтын бүсэд явуулах бөгөөд Хятадын Гаалийн газрын хяналтанд байхаар заасан байна.

Хятадын Засгийн газар нь худалдааны маргаан нэмэгдэх болсонтой холбогдуулан экспортын буцаан олголтын бодлогоо 2007 онд шинэчилсэн. Савхин хувцасны экспортын татварын буцаан олголтыг 13%-5% хүртэл, гутлын татварын буцаан олголтыг 13%-9% хүртэл тус тус бууруулсан байна. Арьс ширний үйлдвэрлэгчдийн ашгийн хэмжээ 4% буюу харьцангуй бага бөгөөд татварын буцаан олголтоос ихээхэн хамааралтай байдаг. Буцаан

олголтын хэмжээг бууруулснаар олон жижиг компанийг дампууралд хүргэсэн байна.

2008 оны санхүүгийн хямралын үер Хятадын Засгийн газар ДНБ-хаа өсөлтийг хангахын тулд 11-р сард буцаан олголтын хэмжээг савхин хувцсанд 11%, харин гутал болон цүнх чөмөдөн болон арьсан суудал зэрэг бараа бүтээгдэхүүнд буцаан олголтыг 13% болгон эргүүлэн тогтоосон байна. 2009 онд гутлын буцаан олголтыг 13% хувь болгон эргүүлэн тогтоосон байна.

Хятадын арьс ширний үйлдвэрлэлийн салбарын томоохон асуудлуудын нэг нь түүхий эдийн дутагдал юм. Хэдийгээр Хятад улс арьс ширний үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг хэдий ч түүхий эдийн хангамж нь ихээхэн өрсөлдөөнтэй, импортолсон түүхий арьс шир болон ямаа, бод малын чанартай арьсны эрэлт өндөр байдаг байна.

Бусад үйлдвэрлэлийн салбарын адилаар Хятадын арьс ширний салбар хямралын үед ихээхэн хүндрэлүүдтэй тулгарсан нь үйлдвэрлэлийн зардал 40-50%-аар өссөн, юань-ий ханшийн өсөлт, хөдөлмөрийн зардал (хөдөлмөрийн хөлс, тэтгэмж болон сургалтын зардал нь 20% хүртэл хувиар өссөн) өссөж, ашгийн хэмжээг бууруулж байгаа юм.

Мөн түүнчлэн Хятадын Засгийн газар нь бохирдол ихтэй, эрчим хүч ихээр хэрэглэдэг үйлдвэрлэлүүдийг багасгах, эсхүл хаахаар мэдэгдсэн бөгөөд зарим мужуудад цэвэр болон бохир усны төлбөрийг нэмэгдүүлсэн. Арьс ширний үйлдвэрлэл нь ус ихээр хэрэглэдэг үйлдвэрлэлүүдийн нэг бөгөөд ус бохирдуулсны төлбөр, зардал нь өндөр байдгаас үүдэн далайн эрэг орчмын мужууд нь арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрлэлийн паркад төвлөрүүлж, бохир усны цэвэрлэгээг төвлөрүүлж, нэгдсэн хяналт тогтоох бодлогыг хүрээнд ажиллаж байна.

Технологийн инноваци болон байгальд ээлтэй арьс ширний үйлдвэрлэл

Арьс, ширэн бараа бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх мөн “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” үйлдвэрлэхийн тулд Хятадын 12 дахь 5 жилийн төлөвлөгөө (2011-2015)-нд арьс ширний үйлдвэрлэлүүдийг эрчим хүч хэмнэлтийн горимоор ажиллах мөн бохирдлыг бууруулах шаардлагуудыг тавьсан байна. Ийнхүү 2011 онд үйлдвэрлэлийн хэмжээ бага, бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангадаггүй, бохирдол ихтэй 183 аж ахуйн нэгжийг татан буулгасан байна. Энэ нь мөн гадны экспортлогчдод илүү чанартай, өндөр үнэтэй түүхий болон хагас боловсруулсан арьс шир нийлүүлэх боломжоор хангах юм. Одоогийн байдлаар Хятадын арьс ширний үйлдвэрлэл нь *Ultrasound*, *Microwave* болон өндөр даралтын зэрэг шинэ технологиудыг нэвтрүүлээд байна.

2011 онд Хятадын Үйлдвэрлэл болон Мэдээллийн технологийн яам нь үйлдвэрлэлийн бүхий л салбарт стандартчиллын шинэ тогтолцоо нэвтрүүлэх зорилгоор 359 үйлдвэрлэлийн салбарт багц стандарт тогтоосон байна. Үүнээс 20 нь арьс ширний салбарт үйлчлэх бөгөөд гутлын үйлдвэрлэлд 4, цүнхний үйлдвэрлэлд 9, арьс шир үйлдвэрлэлд 4, арьс ширний зах зээлд 2 мөн арьсан жижиг эдлэлд 1 стандарт тус бүр үйлчлэх юм. Эдгээр стандартууд нь үйлдвэрлэлийн бохирдлыг бууруулах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

2010 онд Хятадын Засгийн газар нь арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарт баримтлах бодлогыг нийтэлсэн бөгөөд тус зохицуулалтын хүрээнд арьс ширний үйлдвэрлэлээс гарч буй хром агуулсан бохир усыг бусад бохир уснаас тусад нь ангилах, цэвэрлэхээр заасан байна.

Түүнчлэн, үйлдвэрлэлийн шат тус бүрт цэвэр технологийг ашиглахаар заасан байна. Эдгээр шаардлагуудыг хангахын тулд арьс ширний үйлдвэрүүдэд дараах шалгууруудыг тогтоосон байна:


- *Хром агуулсан бохир ус*: Холбогдох дүрэм журамд заасны дагуу 2012 он гэхэд усан дахь хромыг рН 8.0~8.5 шүлтээр тунгаах бөгөөд үүссэн хромыг лагийг дахин хэрэглэж, эсхүл тусад нь хадгална. Энэхүү аргаар ашигласан хромын 99%-г гарган авч, усанд үлдэх хромын хэмжээ нь 1мг/л -с бага байх юм.
- *Хром агуулаагүй усны цэвэрлэгээ*: Арьс ширний үйлдвэрүүд нь хром агуулаагүй усыг хими-физик, биологийн аргаар цэвэршүүлнэ. Одоогийн байдлаар арьс шир үйлдвэрлэлийн бүсүүдэд хэмжилт хийхэд улс болон орон нутгийн стандартуудад нийцэж байсан байна.
- *Үндэсний 12 дахь Таван жилийн төлөвлөгөө*: Төлөвлөгөөнд заасны дагуу 2015 оны сүүл гэхэд COD /химийн хэрэгцээт хүчил төрөгч/ болон хүхрийн диоксидын хэмжээг 2010 онтой харьцуулахад 8%, аммонийн азотын хэмжээг 10% тус тус бууруулахаар тогтоосон байна.
- *Арьс шир боловсруулах салбарын аж үйлдвэрийн шинэтгэлийн удирдамж 2011*: Удирдамжид заасны дагуу 2012 оны эхэн гэхэд шинээр баригдсан арьс ширний үйлдвэрийн түүхий арьс шир боловсруулах хүчин чадал нь жилд 200 000 ш-ээс доошгүй, вет-блогийн үйлдвэрлэлийн хэмжээ 100 000 ш-ээс доошгүй байна. Үйлдвэрлэлийн хүчин чадал жилд түүхий арьс ширний хувьд 50 000 ш-ээс доош, вет-блогийн хувьд 30 000 ш-ээд доош арьс ширний үйлдвэрүүдийг татан буулгах юм.
- *Байгаль орчин хамгааллын стандартууд*: Арьс шир үйлдвэрлэлийн салбарт бохир ус, бүрэн боловсруулсан арьс ширний хог хаягдалд тавигдах шинэ стандартуудыг баталснаар бохир усны цэвэрлэгээ болон агаарын бохирдлыг бууруулахад нааштай нөлөөлнө гэж тооцсон байна. Дээрх бодлогуудын хүрээнд арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн арьс ширний кластерт төвлөрөхийг төрөөс дэмжиж байгаа юм. Үүнээс гадна цэвэр буюу усанд хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх, арьс шир боловсруулахад байгальд ээлтэй химийн бодис ашиглах зэргийг дэмжиж байна.

2.2. ОХУ

ОХУ-ын хөнгөн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, тоо мэдээ:

ОХУ-ын хөнгөн үйлдвэрлэлийн хэмжээ 2014 оны байдлаар 289.7 тэрбум рубль байсан бол үүний 44% нь оёдлын үйлдвэрлэлд оногдсон байна. Харин арьс шир болон арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 46.7 тэрбум рубль буюу 16%-г эзэлсэн байна. 2013 онтой харьцуулахад хөнгөн үйлдвэрлэлийн бүхий л салбар дахь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

ОХУ-ын хөнгөн үйлдвэрлэлийн бүтэц (тэрбум рубль) 2014



2014 онд хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Холбооны төсвөөс 1.7 тэрбум рубль, 2015 онд 1.5 тэрбум рубль тус тус төсөвлөсөн хэдий ч ОХУ-ын хөнгөн үйлдвэрлэл нь дотоодын зах зээлийн зөвхөн 25% хангаж, үлдсэнийг нь экспортолж байна.

ОХУ-ын арьс ширний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал:

ОХУ-ын арьс ширний үйлдвэрлэл нь муж тус бүрт арьс ширний үйлдвэрлэл ажилладаг байсан хуучин ЗХУ-ын тогтолцоог өвлөсөн. 80-аад оны сүүлээр ЗХУ нь хөнгөн үйлдвэрлэлээ шинэчлэх хүрээнд арьс ширний томоохон үйлдвэрүүдийн техникийн тоног төхөөрөмжийн шинэчлэл явуулж, орчин үеийн импортын тоног төхөөрөмжөөр тоноглогсон нь хөнгөн үйлдвэрлэлийн хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, хуучнаар Рязаний арьс ширний үйлдвэр одоогоор “Русская кожа” хувьцаат нийгэмлэг нь Оросын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны мэдээлснээр ОХУ-ын арьс шир үйлдвэрлэлийн 35%-г эзэлж байна.

ОХУ-ын арьс ширний салбарын хүчин чадлын хувьд 41 үйлдвэр 3.5 тэрбум кв.дм арьс шир боловсруулах хүчин чадалтай бөгөөд жил бүр 160 мянган тонн бод малын түүхий арьс шир үйлдвэрлэдэг байна. Үүнээс 30 мянган тонн хүртэлхийг экспортонд гаргадаг бол үйлдсэн нь дотоодын хэрэгцээнд зориулагдаж байна. ОХУ-ын үйлдвэрлэл худалдааны яамны мэдээлснээр арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь 2014 онд 14.8 тэрбум рублийн бэлэн бүтээгдэхүүн борлуулснаас 97% нь гутал, савхин жижиг эдлэл, хувцас, тавилга болон автомашины доторлогооны зориулалтын арьс эзэлсэн байна. Гэхдээ энэ нь нийт хөнгөн үйлдвэрлэлийн 3 их наяд рублийн зах зээлтэй харьцуулбал маш бага тоо юм.

Засгийн газраас түүхий эдийн дутагдал буюу түүхий арьс шир, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг хязгаарлалтгүйгээр экспортонд гаргаж байсан асуудлыг шийдвэрлэхээр ихээхэн ажилласан юм. Түүхий эдийн дутагдлын асуудал нь 1990-ээд оноос яригдаж эхэлсэн бөгөөд 2000-аад онд Засгийн газар түүхий болон хагас боловсруулсан арьс ширний экспортын татвар, хураамжийн хэмжээг нэмэгдүүлснээр Оросын арьс ширний үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдсэн байна.

Сүүлийн 12-13 жилийн хугацаанд албан ёсны байгууллагуудын мэдээлснээр арьс ширний үйлдвэрлэл 3 дахин нэмэгдэж, нийт хэмжээ 2,2 тэрбум.кв.дм хүрсэн байна. Харин түүхий эдийн дутагдлын 2 дугаар давалгаа нь 2012

онд улсын хэмжээнд бод малын тоо цөөрсний зэрэгцээ ОХУ нь Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д элссэнээс үүдэж, экспортын татварыг бууруулах болсонтой холбоотой байна. /ДХБ-д элсэхтэй холбоотой арьс ширний үйлдвэрлэлийн салбарыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-ээс үзнэ үү/

Үйлдвэрлэл, худалдааны яамны санаачилгаар Оросын Засгийн газар нь хагас боловсруулсан бүтээгдэхүүн болох вет-блогийн экспортод 2014 онд 6 сарын хугацаатай хориг тавьж, түүнийгээ 2015-2016 онд 6 сараар сунгасан байна. /ОХУ-ын Арьс ширний үйлдвэрлэлд хамаарах эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг Хүснэгт 2-оос үзнэ үү/

ОХУ-ын Үйлдвэр, худалдааны яамны Дотоод худалдаа, хөнгөн үйлдвэрлэл, хэрэглэгчдийн зах зээлийн хэлтсээс хагас боловсруулсан арьс бус харин бүрэн боловсруулсан арьс ширний экспортын өсөлтийг мэдээлсэн ба сүүлийн 2 жилийн байдлаар экспортын хэмжээ 12%-р өссөн байна.

Томоохон үйлдвэрлэгч нар үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд шинэ технологийг идэвхтэй нэвтрүүлж байна. Тухайлбал, Верхневолжскийн арьс ширний үйлдвэрт сульфат хромын давсгүйгээр идээлдэг технологийг нэвтрүүлсэн. Энэ нь уламжлалт аргаас 1/3-р илүү өртөгтэй хэдий ч экологийн хувьд хор багатай боловсруулдгаараа европын хүүхдийн гутлын үйлдвэр зэрэг зарим үйлдвэрлэлд эрэлт ихтэй байдаг байна. Хром ашигладаггүй вет-вайт технологийг Вяземскийн арьс ширний үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бөгөөд боловсруулсан арьс нь илүү цайвар болон зөөлөн болдог байна.

ОХУ-ын арьс ширний үйлдвэрлэлд эдийн засгийн хямрал харьцангуй таатай нөлөөг үзүүлсэн гэж хэлж болох бөгөөд нэг талаас импортын тоног төхөөрөмж, химийн бодисын үнэ өссөн бол нөгөө талаараа хэрэглэгчид дотоодын үйлдвэрлэлийн хямд үнэтэй бүтээгдэхүүнээр импортын барааг орлуулсантай холбоотой юм.

ОХУ-ын салбарын мэргэжилтнүүд арьс ширний үйлдвэрлэлийн салбарын цаашдын хөгжлийг санхүүгийн хямд эх үүсвэр-хямд зээл гэж үзэж байгаа бөгөөд Үйлдвэрлэл, худалдааны яамны зүгээс төрийн аль нэг банкаар дамжуулан хөнгөн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх асуудлыг хэлэлцэж байгаа бөгөөд 2015 оноос тус алба нь байгууллагуудад банкны зээлийн хүүгээ төлөхөд нь дэмжлэг, татаас олгож эхэлсэн байна. Үйлдвэрлэл, худалдааны яамнаас Хямралын эсрэг арга хэмжээний хүрээнд үйлдвэрлэлд өндөр ач холбогдол бүхий үйлдвэрлэлүүдийн жагсаалтыг гаргасан бөгөөд үүнд арьс ширний салбар багтсан юм.

Жагсаалтад багтсан аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүнд төв банкны бодлогын хүүний 70%-хүртэл хэмжээтэй тэнцэх татаас олгох юм. Энэ нь нэн тэргүүний шаардлагатай байгаа дэмжлэгийн нэг бөгөөд одоогийн байдлаар нийт 7 арьс шир болон гутлын үйлдвэрт 130 сая рублийн татаас олгосон байна. Үүнээс гадна арьс ширний үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх асуудлаар арга хэмжээ авч байгаа нь хөнгөн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг импортын татвар хураамж болон НӨАТ-аас чөлөөлсөн байна.

ОХУ-д малын тоо жилээс жилд буурч байгаатай холбоотойгоор түүхий эдийн дутагдалд орж байгаа бөгөөд Гаалийн статистик тоо мэдээнээс үзвэл хагас боловсруулсан арьс ширний экспортын хэмжээ 2012 онд 23.8 мянган тонн, 2013 онд 27.4 мянган тонн, 2014 онд 24.9 мянган тонн болж буурсан байна. 2014 оны 4-р улиралд хагас боловсруулсан арьс ширэнд экспортын түр хориг тавьсантай холбоотойгоор өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9.1% буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Харин 2015 онд түр хориг үргэлжилсэнтэй холбоотойгоор экспортын хэмжээ 8.9 дахин буюу 2.78 мянган тонн болтлоо буурсан байна.

ОХУ-ын хагас боловсруулсан арьс ширний экспортын хэмжээ 2012-2015

	2012	2013	2014	2015	2015 өмнөх онтой харьцуулбал, %
код ТН ВЭД 4104 11, 4104 19 (мянган тонн)	23,8	27,4	24,9	2,78	88,8

Экспортын хориг арга хэмжээ тогтоогоогүй үед чанартай хагас боловсруулсан арьс ширний 30%-ийг экспортод гаргаж, дотоодын зэх зээлд хомсдол үүсгэж байсан. Ийнхүү 2014 онд экспортын улмаас дотоодын зах зээл 480,0 сая кв.дм боловсруулсан арьсны дутагдалд орсон бөгөөд дотоодын үйлдвэрлэлийн 50.7 тэрбум рублийн өртөг бүхий 20 сая ширхэг гутал дутуу үйлдвэрлэсэн байна.

Арьс шир болон гутлын үйлдвэрлэлийн хэмжээ 2012-2015

	2012	2013	2014	2015	Өсөлтийн хэмжээ, 2015 өмнөх онтойгоо харьцуулсан %
Арьс ширний үйлдвэрлэл сая кв. дм	2372,4	2058,9	2199,2	2166,6	98,5
Арьсан гутлын үйлдвэрлэл сая ш	22,0	22,0	20,3	20,0	98,5

Эх сурвалж: Оросын Статистикийн хороо

2015 онд үйлдвэрлэлийн хэмжээ буурсан нь аж үйлдвэрүүдийн санхүүжилт бага байсантай холбоотой байна. Сүүлийн жилүүдэд арьс шир болон гутлын үйлдвэрлэлүүд нь хэсэгчлэн болон бүрэн техник технологийн шинэчлэл явуулсан бөгөөд бүтээгдэхүүний чанар, нэр төрлөө нэмэгдүүлэх, дотоод болон олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж байна.

Экологийн үүднээс хагас боловсруулсан арьс шир экспортлох нь сөрөг үр дагавар дагуулдаг бөгөөд үйлдвэрлэлээс гарсан бохирдол нь үйлдвэрлэгч оронд үлдэж, харин гадаадын худалдан авагчид нь байгаль орчинд хор учруулалгүй, нэмүү өртөг шингээн ашигтай үйлдвэрлэл явуулж байна.

ОХУ-ын хувьд импортын хагас боловсруулсан арьс шир ашиглах нь өндөр зардлын улмаас төдийлэн түгээмэл бус (европ болон америкийн түүхий эдийн үнэ 20-30%-р өндөр), түүнчлэн тавигдаж буй эрүүл ахуйн стандарт болон экспотртлогч орнуудад малын тоо цөөрч байгаа зэргээс хамааран харьцангуй ховор байдаг байна. Хагас боловсруулсан арьс ширний өртгийн


55-60%-ийг түүхий эд эзэлдэг бол хагас боловсруулсан арьс ширийг 20-30%-аар илүү үнэтэй худалдаж авах нь арьс шир боловсруулах өртгийг 15-20%-аар өсгөх юм. Арьс ширний үйлдвэрлэлийн ашгийн хэмжээ 5% байгаа нөхцөлд арьс ширний өртөг 20%-аар өсөх нь алдагдалд хүргэх юм.

Хагас боловсруулсан арьс ширний экспортын түр хориг нь дотоодын зах зээлээ чанартай түүхий эдээр тогтмол хангах боломж бүрдэх бөгөөд үүнд батлан хамгаалах салбарын захиалга, түүнчлэн дотоодын арьс ширний үйлдвэрлэлийн шинэ салбар болох автомашины болон тавилгын арьс шир орох юм.

Арьс шир болон арьс ширэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл:

ОХУ-д арьс ширний үйлдвэрлэлийн эргэлт нь оёдол болон даавууны үйлдвэрлэлээс хамаагүй бага байгаа юм. Арьс ширний салбар 2014 онд 46.7 тэрбум рублийн ашигтай ажилласан нь өмнөх 3 жилээсээ буурсан үзүүлэлт бөгөөд тус салбар дах аж ахуйн нэгжүүдийн ашгийн хэмжээ 6.9%-тай байна.

ОХУ-ын арьс шир болон арьсан эдлэлийн үйлдвэрлэл, тэрбум рубль



ОХУ-ын арьс шир болон арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь арьс ширний үйлдвэрлэл, гутлын үйлдвэрлэл болон жижиг арьсан эдлэл гэсэн үндсэн гурван чиглэлтэй байна. Оросын хувьд арьс ширний үйлдвэрлэл нь экспорт нь импортоо давдаг цөөн үйлдвэрлэлүүдийг нэг юм. Харин үйлдвэрлэлийн хэмжээ 2010 оноос хойш буурч байна. ОХУ-д арьс ширийг 22 үйлдвэрт үйлдвэрлэж байгаагаас 20 нь хром, 7 нь юфть, 5 үйлдвэр хатуу савхи үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Эдгээр арьс ширний төрөл тус бүрийг улс орны хэмжээнд 40%-өөс дээш хувийг үйлдвэрлэдэг томоохон үйлдвэрүүд байдаг нь:


- Хром - «Русская кожа» ХХН (Рязань муж) – 1012.7 млн. кв.дм. (нийт үйлдвэрлэлийн 47.2%);
- Юфть - «Вахруши-юфть» ХХНН (Киров муж) – 20.1 млн. кв. дм. (нийт үйлдвэрлэлийн 55.5%);
- Жесткие кожи - «Шевро» ХХНН (Воронеж муж) – 9.8 млн. кв. дм. (нийт үйлдвэрлэлийн 51.5%);

Арьс шир үйлдвэрлэлийн дийлэнх нь Төв Холбооны тойрогт ногдож байгаагаас хром 72.7% болон юфтэн эдлэл 9.4%-г эзэлж байна. 2-р байранд 18.7% болон 61.3% гэсэн үзүүлэлттэй Ижил Мөрний Холбооны тойрог, 3-рт Өмнөд Холбооны тойрог 6% болон 26.2% гэсэн үзүүлэлттэй тус тус орж

байна. Харин бусад тойргуудад арьс ширний үйлдвэрлэл харьцангуй бага хэмжээтэй байна.

Арьс ширний үйлдвэрлэлд бүтээгдэхүүний экспорт импортын хэмжээ ихээхэн нөлөөтэй байдаг ба 2013 онд экспортын хэмжээ нийт үйлдвэрлэлийн 28.3%, импорт нь 36.1% эзэлж байсан бол 2014 онд огцом солигдож экспортын хэмжээ 48.7% болж өссөн бол импортын хэмжээ 27% болтол буурсан байна. ОХУ-ын экспортын гол бүтээгдэхүүн нь вет-блю болон бод малын краст байдаг бол вет-блюгийн гол худалдан авагч нь Итали юм.

ОХУ-ын вет-блю экспортлогч орнууд, мянган ш



2.3. БНЭУ

Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь ажиллах хүчний чадамж, бүтээгдэхүүний экспорт болон өсөлтийн хэмжээгээрээ Энэтхэгийн эдийн засагт голлох байр суурь эзэлдэг бөгөөд дэлхийн хэмжээнд 9 дэх том арьс, арьсан бүтээгдэхүүн экспортлогч орон юм. Тиймдээ ч 2017 он хүртэл 12 дахь таван жилийн төлөвлөгөөндөө өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой түүхий эдийг оновчтой ашиглах замаар экспортын өсөлтийг эрчимжүүлэхийг²⁶ нэн тэргүүнд авч үзсэн бөгөөд илүү их нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн экспортлох зорилго тавьжээ.

Энэтхэг улс дэлхийн хэмжээнд арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүний экспортоор дэлхийд тэргүүлэгч 9 дэх орон болохоос гадна гутал болон савхин хувцас үйлдвэрлэгч орны хувьд дэлхийд хоёрдугаарт ордог байна. Тус салбарт 2.5 сая гаруй хүн ажилладаг бөгөөд Энэтхэг дэх гадаад валютын орлогын шилдэг эх үүсвэрийн нэг юм.

Түүхийн эдийн элбэг нөөц, ур чадвартай ажиллах хүч, байгаль орчны стандартыг дагаж мөрддөг байдал болон холбогдох салбарын үйлдвэрүүдийн өсөлт зэрэг олон хүчин зүйл нь тус салбарын өсөлтөд дэмжлэг болж байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 80 орчим хувийг том, дунд, жижиг болон өрхийн үйлдвэрлэлийн нэгжүүд бүрдүүлдэг.

Нөгөө талаас зохион байгуулалтгүй салбар дахь үйлдвэрлэлийн нэгжийн дийлэнх хэсэгт олон сорилт тулгарч байна. Тухайлбал, түүхий эд цаг тухайдаа бэлэн байх, хөдөлмөрийн өндөр зардал, бүтээгдэхүүний инноваци дутмаг, дэлхийн загварын зах зээл дэх оролцоо дутмаг зэрэг болно. Энэтхэгийн Засгийн газраас de-licensing салбарыг дэмжихийн тулд дараах хэд хэдэн санаачилгыг хэрэгжүүлж байна. Үүнд:

²⁶ Report of Working Group on "Leather & Leather Products" Twelfth Five Year Plan Period (2012-17)

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон импортын татвараас чөлөөлөхийг зөвшөөрөх;
- Аж үйлдвэрлэлийн нэгжид санхүүгийн туслалцаа үзүүлэх, сурталчлан таниулах;
- Аж үйлдвэрийн парк байгуулахад туслалцаа үзүүлэх;
- Аж үйлдвэрийн олон талт хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Арьс ширний үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын бодлого:

Энэтхэгийн Засгийн газар дотоодын арьс ширний үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжихийн тулд хэд хэдэн санал санаачлагыг авч хэрэгжүүлж байна. Арьс ширний үйлдвэрлэлийн өргөтгөлийг шуурхайлах, хөнгөвчлөх болон төлвийг нь сайжруулах зорилгоор Засгийн газраас доорх бодлогын санаачлагыг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Арьс ширний үйлдвэрлэлийг de-licensed болон de-reserved болгосон;
- 100 хувь гадаадын шууд хөрөнгө оруулалттай болон хамтарсан үйлдвэрийг шууд зөвшөөрөх;
- Хэрэв хөрөнгө оруулалтыг хөрвөх гадаад валютаар хийсэн бол ашиг болон ногдол ашиг нь 100% эх орондоо буцаж ирнэ. Ийм өргөдлийг заавал Энэтхэгийн Нөөцийн банкинд мэдэгдэх;
- Арьс ширний аж үйлдвэрлэлийн паркийг дэмжих (Andhra Pradesh болон баруун Бенгалд тус бүр нэг, Тамил Надуд хоёр);
- Аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг дэмжих санхүүжилтийг шийдэх;
- Загварын танхим байгуулахыг дэмжих санхүүжилтийг шийдэх;
- Түүхий эдийг импортын татвараас чөлөөлөх (түүхий арьс, шир, хагас боловсруулсан арьс шир болон боловсруулсан арьс шир);
- Туслах материал болон тусгай схемийн дагуу хэрэглэгдэх чимэглэлийн эд ангийг импортын татвараас чөлөөлөх;
- Арьс ширний салбарт хэрэглэх тусгай тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлөх;
- Татварыг саармагжуулах зэрэг бодлогын санаачилгыг хэрэгжүүлсэн болно.

Түүнчлэн салбарын өсөлтийг дэмжихийн тулд Үйлдвэрлэлийн Бодлого, Сурталчилгааны Агентлагаас 11 дүгээр Таван жилийн төлөвлөгөөнд заасны дагуу “Энэтхэгийн арьс ширний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр” батлан гаргасан байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 1,25.129 сая рупи зарцуулжээ. Харин 12 дугаар таван жилийн төлөвлөгөө буюу 2012-2017 оны хугацаанд арьс ширний үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд нийт 36 тэрбум. рупи зарцуулахаар төлөвлөсөн байна.

“Энэтхэгийн арьс ширний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үйлдвэрлэлийн технологийн сайжруулалтыг шат дараатайгаар дэмжих, инноваци, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийн хөгжил, тэр дундаа гар урчуудын техник, ур чадварын хөгжил болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг арьс ширний салбарын гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Үйлдвэрлэлийн бүтэц: Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэл нь газар зүйн хувьд Тамил Наду, Уттар, Прадеш болон Баруун Бенгал зэргээр сайтар төрөлжсөн, их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байна. Арьс шир болон арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн гол төвүүд нь Тамил Надугийн Ченнай, Амбур, Ранипет, Ваниямбади, Тричи, Диндигул, Баруун Бенгалын Калкутта, Уттар Прадешийн Канпур, Агра, Нойди, Пунжабын Жаландар, Харяангийн Бахадургар, Манесар, Карнатакагийн Бангалоре, Андра Прадешийн Дели болон Худерабад зэрэг газруудад байрладаг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт бичил болон жижиг аж ахуйн нэгжүүд давамгайлдаг ба эдгээр нь уг салбар дахь нийт аж ахуйн нэгжийн 5 хувийг эзлэх томоохон аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтран ажилладаг байна. Энэ салбар дахь аж ахуйн нэгжүүдийн тархалтыг БЖДҮ-ийн ангиллаас хамааруулан дор харуулбал:

<i>Хүснэгт 1: Үйлдвэрийн бүтэц (Тоогоор)</i>						
	Том оврын	Дунд оврын	Жижиг оврын	Бичил нэгж	Худалдааны нэгж	Нийт
Бүтэн боловсруулсан арьс	30	49	309	68	151	607
Арьсан гутал	38	46	228	49	81	442
Синтетик гутал	4	2	34	13	17	70
Гуталны бүрэлдэхүүн	29	32	182	28	22	293
Арьсан савхин эдлэл	14	13	242	259	210	738
Савхин бэлэн хувцас	8	8	132	49	72	269
Савхин бээлий	4	3	38	36	24	105
Эмээл, тоног төхөөрөмж	3	9	74	69	26	181
Нийт	130	162	1239	571	603	2705

Хүснэгтээс үзэхэд Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэлийн салбарт том болон дунд оврын үйлдвэрүүд нь бага байгаа бөгөөд жижиг болон бичил үйлдвэр худалдааны нэгжүүд олон байгаа нь харагдаж байна.

Салбарын үйлдвэрлэл, экспорт болон ажил эрхлэлт:

Арьс ширний салбарын үйлдвэрлэлийн мэдээллийг Үндэсний Статистикийн бүртгэлийн газарт (National Accounts statistics (NAS)) нэгтгэгдэг. ҮСБГ нь үйлдвэрийн зохион байгуулалттай (10 болон түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжүүдийг хамруулан) секторын болон зохион байгуулалтгүй (10-аас доош ажиллагсадтай нэгжүүдийг хамруулан) секторын мэдээллийг гаргадаг. ҮСБГ-ын мэдээлснээр, арьс ширний үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 2004-2005 онуудад 272,3 сая рупигээс 2009-2010 онуудад 479,4 сая рупи болж, жилд дунджаар 11.8 хувиар өссөн байна. Энэ хугацаанд зохион байгуулалттай секторын үйлдвэрлэлийн өсөлт 16.9 хувь байсан нь 6.9 хувийн өсөлттэй байсан нь зохион байгуулалтгүй секторын өсөлтөөс нилээд их хувиар өндөр байсан. Энэ нь зохион байгуулалттай салбар нь үйл ажиллагаа явуулах хүчин чадал, техник технологийн хувьд боловсронгуй, дэвшилттэй байгаа нь харагдаж байна. Экспортын хувьд нийт үйлдвэрлэлийн өсөлттэй харьцуулахад өсөлт удаан байна.

*Хүснэгт 2: Арьс шир болон арьс ширний үйлдвэрлэл дэх
Үйлдвэрлэл болон Экспорт*

	Зохион байгуулагдсан	Зохион байгуулагдаагүй	Нийт	ЗБС*-ын эзлэх хувь	Экспорт	Экспортод үйлдвэрлэлийн эзлэх хувь
2004-2005	12401	14972	27373	45.3	10881	39.7
2005-2006	15406	15530	30936	49.8	11943	38.6
2006-2007	17482	17263	34745	50.3	13650	39.3
2007-2008	24392	19861	44253	55.1	14101	31.9
2008-2009	24828	19228	44056	56.4	16355	37.1
2009-2010	27017	20923	47940	56.4	15946	33.3

ҮСБГ-ын мэдээнээс харахад, мэдээллийг хувийн хэрэглээний эцсийн ашиглалтын аргаар тооцсон байна. ДНБ-ийг тооцоходоо төрөл бүрийн бүтээгдэхүүний өрхийн худалдан авалттай холбоотой хэрэглээний мэдээллийг тооцон гаргасан байдаг. Гутал бол ҮСБГ-ын хэрэглээний сагсны нэг зүйл юм. Гутлын хэрэглээ 1989-1990 онуудад 42.7 сая рупи байсан бол 2009-2010 онуудад 425.09 сая рупи болж жилд дунджаар 10.6 хувиар өссөн байна. Гутлын эрэлтийн уян хатан байдал нэгээс бага байгаа нь хэрэглээний өсөлт нь ДНБ-ний өсөлтөөс доогуур байгааг харуулж байна. Хувийн хэрэглээний эцсийн ашиглалт дахь гутлын эзлэх хувь дунджаар 1.18 хувьд (1990-1991 онд хамгийн их буюу 1.7 хувь байсан) хэлбэлзэж байна. Хувийн хэрэглээний эцсийн ашиглалтанд хувийн салбарын хэрэглээг оруулаагүй бөгөөд арьс ширэн бүтээгдэхүүний дотоодын ашиглалтыг тооцоход чиглэсэн байна. ХХЭА-ын мэдээлэлд гутлын бус салбар болон төрийн худалдан авалтыг хамруулсан ба арьс ширний үйлдвэрлэлийн зах зээлийн хэмжээг тодорхойлоход ашигладаг байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3: Арьс ширний үйлдвэрлэл дэх бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспорт

March ending	PFCE FW	Exports	Production	Share of FW in PFCE	Exports Share in production	Global Imports ¹⁵	Exports From India	Share in exports
	Rs crore			In per cent		US \$ Million		Per cent
2012	59086	22006	93625	1.12	23.5	141393	4725	3.34
2013	66176	25307	105520	1.16	24.0	156380	5434	3.47
2014	74117	29103	118942	1.19	24.5	172957	6249	3.61
2015	83011	33468	134088	1.23	25.0	191290	7186	3.76
2016	92973	38489	151183	1.27	25.5	211567	8264	3.91
2017	104129	44262	170479	1.31	26.0	233993	9504	4.06
2018	116625	50901	192265	1.34	26.5	258796	10929	4.22
2019	130620	58536	216864	1.39	27.0	286228	12569	4.39
2020	146294	67317	244643	1.43	27.5	316569	14454	4.57
2021	163850	77414	276020	1.47	28.0	350125	16622	4.75
2022	183512	89027	311465	1.52	28.6	387238	19115	4.94
2027	323410	179064	571076	1.76	31.4	640846	38448	6.00

ҮСБГ-ын тооцоолсноор, нийт гутлын хэрэглээний 80 хувийг, нийт арьс ширэн бүтээгдэхүүний хэрэглээний 66 хувийг арьс ширэн гутал эзлэж байна. Арьсан эдлэлийн дотоодын хэрэглээн дээр экспортыг нэмснээр нийт арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ гарна. 1990-1991 онд хагас


боловсруулсан арьс ширний экспортод хориг тавьснаар арьс ширний үйлдвэрлэлд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн илүүтэй үйлдвэрлэгдэх болсон.

Зохион байгуулалттай үйлдвэрийн салбарын мэдээллээр, зохион байгуулагдсан арьс ширний үйлдвэрлэл дэх нөөцийн хурцадмал байдал нэмэгдсэн байна. Эцсийн бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн түвшин 1993-1994 онд 22.8 хувьтай байснаас 2007-2008 онд 13.6 хувь болж буурсан байна. Үйлдвэрлэлийн үйл явцад ашиглагдсан орцийн өртөг 2007-2008 онд 84 хувьд ойртож нэмэгдсэн байна.

Арьс ширний салбарын бүтээгдэхүүнд нэмүү өртгийн эзлэх хувь нь нийт зохион байгуулагдсан үйлдвэрлэлийн салбар дахь нэмүү өртгийн эзлэх хувиас бага байна.

Орон нутгийн хөгжил, технологи эзэмшил, судалгаа шинжилгээнд тулгуурласан шаардлагатай технологийг суурьшуулах байдал, брэнд бий болгох болон хүний нөөцийн чадавхи зэрэг хүчин зүйлүүд нь арьс ширний үйлдвэрлэл дэх материалын нөөцийн эрчимнүүлэлтийг тогтвортой (өссөн) байлгахад нөлөөлсөн гэж үздэг. Арьс ширний үйлдвэрлэлийн нөөцийн эрчимжүүлэлтийг ICRA-ын судалгаагаар гаргаж ирсэн ба гутлын салбар дахь түүхий эд зардлын 65 хувьтай байсан ба удирдлагын зардал 14 хувь, ажилчдын зардал 7 хувь байсан байна.


Зохион байгуулагдсан арьс ширний салбар дахь нэмүү өртөг болон ажилчдын цалин хөлс



Эх сурвалж: ICRA Study on Manufacturing Competitiveness Indices, page 81

Графикаас үзэхэд бүтээгдэхүүний гарц дахь нэмүү өртөг буурч харин ажилчдын цалин 2000 оноос 2006 он хүртэл байнга өссөн дүнтэй бөгөөд 2006-2008 он хүртэл тогтмол байж түүнээс хойш огцом өссөн дүн гарсан байна. Харин бүтээгдэхүүний гарцад эзлэх цалин хөлсний хувьд 17 жилийн турш тогтмол дүн гарсан байна.

*Бүтээгдэхүүний гарц дахь нэмүү өртөг шингээсэн
бүрэлдэхүүний эзлэх хувь*



Эх сурвалж: Report of Working Group on "Leather & Leather Products" Twelfth Five Year Plan Period (2012-1-7)

Графикаас үзэхэд 2003 оноос тус салбарт ажил эрхлэгчдийн тоо бага зэрэг буурсан бөгөөд ашгийн үзүүлэлтэд огцом өсөлт бууралт ажиглагдсан байна. 2007-2008 оны хувьд ашгийн эзлэх хувь унасан байна. Харин арьс ширний салбар дахь ажил эрхлэлтийн хувьд 2010 оны байдлаар 1.1 сая хүн ажил эрхэлж байгаа бөгөөд энэ нь нийт ажил эрхлэлт дэх арьс ширний салбарт ажиллагсдын эзлэх хувь 0.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 4. Арьс ширний үйлдвэрлэл дэх ажил эрхлэлт
(сая хүнээр)*

<i>Ажил эрхлэлт</i>	<i>Арьс шир</i>	<i>Нийт аж үйлдвэр</i>	<i>Нийт ажил эрхлэлт</i>	<i>Арьс ширний үйлдвэрт эзлэх хувь</i>
2004-2005	1.4 сая	53.6 сая	457.9 сая	2.6%
2009-2010	1.1 сая	50.5 сая	459.0 сая	2.2%

Арьс ширний салбарт ажиллаж буй бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон ажил эрхлэгчдийн хөдөлмөрийг илт дутуу үнэлж байгаа ч цаашдаа тус салбарын шууд ажлын байр 2 саяд хүрэх төлөвтэй байгаа аж. Арьс ширний салбарт хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь зохион байгуулалттай арьс ширний салбарт ажиллаж байна.

Нийт үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт:

Нийт нэмүү өртөг дэх эзлэх хувь буурсан (салбарын материалын эрчимжүүлэлт нэмэгдсэн) болон ажиллах хүчний хөгжил зогсонги байдалд орсон хэдий ч салбарын бүтээмжийн өсөлт илүү сайн байсан байна. Зохион байгуулагдсан арьс ширний үйлдвэрлэлийн салбар дахь бүтээмжийн өсөлтийн хандлага нь 1980-1981-ээс 1990-1991 оны хооронд (шинэчлэлийн өмнөх үед) жил тутамд 0.78 хувь байснаас 1992-1993-аас 2003-2004 оны хооронд (шинэчлэлийн дараах үед) 1.18 хувь болж өссөн байна.

(Зохион байгуулагдсан салбар буюу **organized sector** нь 10-аас дээш ажилтантай, тодорхой тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэрлэл эрхлэгч, зохион байгуулагдаагүй салбар буюу **unorganized sector** 10 хүртэлх ажилтантай үйлдвэр эрхлэгчдийг хэлж байна.)

Шинэчлэлийн дараах үеийн үйлдвэрлэлийн бүтээмжийн өндөр өсөлт нь 1990-ээд оны зах зээлийн шинэчлэлийн хүчин зүйлүүд салбарын мэдрэмтгий байдалд нөлөөлсөнтэй холбоотой. Арьс ширний салбарын бүтээмжийн өсөлт нь 1980-1981-ээс 2003-2004 оны хооронд жил тутамд 1.17 хувь байсан нь нийт үйлдвэрлэлийн салбарын бүтээмжийн өсөлт жил тутамд 0.92 хувь байсантай харьцуулахад ихээхэн өндөр байсан байна.

Арьс ширний салбарын зохион байгуулагдсан болон зохион байгуулагдаагүй салбарыг харьцуулсан хөдөлмөрийн бүтээмж нь нийт үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдтэй хамааралтай ба зохион байгуулагдсан үйлдвэрлэлийн салбарын бүтээмжийн өсөлт бага байсан бол зохион байгуулагдаагүй салбар дахь бүтээмж тогтвортойгоор өссөн байна. Зохион байгуулагдсан арьс ширний салбар нөөцийн болон хөрөнгийн эрчимнүүлэлт илүү болж, нийт үйлдвэрлэлийн бүтээмж илүү өндөр байсан ч, зохион байгуулагдаагүй салбарын хувьд хөдөлмөрийн бүтээмжээ амжилттайгаар сайжруулж чадсан. Зохион байгуулагдаагүй салбар дахь хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс чухал хамааралтай хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн нь арьс ширний салбарын орлогыг бусад салбаруудаас өндөр түвшинд нэмэгдүүлсэн бодлогын үр дүн байсан гэж үздэг.

Тус бодлогын үр дүн нь олон зүйлээр батлагдсан байна. Cob Douglas үйлдвэрлэлийн функцийг аргыг ашиглан нийт үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлтийг тогтооход чиглэсэн Энэтхэгийн Нөөцийн банкнаас үүрэг болгосон Хөгжлийн судалгааны группын судалгаагаар “бодлогын орчин зохион байгуулагдсан салбарт илүү өндөр өсөлтийг авчрах хүчин зүйл болсон” нь тогтоогдсон байна. Арьс ширний салбарын бодлогын загварын үр нөлөө зөвхөн эерэг байгаад зогсохгүй статистикийн хувьд ч чухал байсан. Үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварын зөвлөлд зориулан хийсэн ICRA-н судалгаагаар арьс ширний салбарын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварын индекс 2004 оны суурь дүнтэй харьцуулахад 2007 онд 27 хувиар сайжирсан болох нь тогтоогдсон байна.

Үйлдвэрлэлийн болон экспортын цаашдын төлөв:


Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын төлөв байдлыг тодорхойлохоор 100 аж ахуйн нэгжийг хамруулан хийсэн ICRA-н судалгаагаар арьс ширний салбарын фирмүүдийн өсөлтийг хязгаарлах голлох хүчин зүйлүүдийг тогтоосон нь капиталын хүртээмж, нэгжид ногдох өндөр зардал, чадварлаг ажиллах хүчний хомсдол, татвар болон дүрэм журам, рупигийн ханш, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх байдал болон ажиллах хүчний өндөр зардал зэрэг байсан. Макро түвшинд, арьс ширний үйлдвэрлэлийн гол хязгаарлалт нь түүхий эд материалын чанар, загвар дизайны нэг хэвийн механизм, Энэтхэгийн үйлдвэрлэгчдийн брэнд бий болгох чадамжгүй байдал болон технологийн хоцрогдол зэрэг юм. Гэсэн хэдий ч, судалгаагаар тодорхойлсон салбарын мэдрэмж нь цаашдын төлвийг бодлогын оролцоотойгоор өөдрөг байх боломжтойг илтгэж байна.

Хүснэгт 5. Дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспорт-Прогноз

March ending	PFCE FW	Exports	Production	Share of FW in PFCE	Exports Share in production	Global Imports ¹⁵	Exports From India	Share in exports
	Rs crore			In per cent		US \$ Million		Per cent
2012	59086	22006	93625	1.12	23.5	141393	4725	3.34
2013	66176	25307	105520	1.16	24.0	156380	5434	3.47
2014	74117	29103	118942	1.19	24.5	172957	6249	3.61
2015	83011	33468	134088	1.23	25.0	191290	7186	3.76
2016	92973	38489	151183	1.27	25.5	211567	8264	3.91
2017	104129	44262	170479	1.31	26.0	233993	9504	4.06
2018	116625	50901	192265	1.34	26.5	258796	10929	4.22
2019	130620	58536	216864	1.39	27.0	286228	12569	4.39
2020	146294	67317	244643	1.43	27.5	316569	14454	4.57
2021	163850	77414	276020	1.47	28.0	350125	16622	4.75
2022	183512	89027	311465	1.52	28.6	387238	19115	4.94
2027	323410	179064	571076	1.76	31.4	640846	38448	6.00

Энэтхэгийн Төлөвлөгөөний хорооноос гаргасан арьс ширний салбар дахь бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын талаарх төсөөлөлд дурьдсанаар үйлдвэрлэл нь 2027 хүртэл тогтмол 1.12-1.76 хувиар өсөх, экспорт нь 3.34-6.00 хувь болтол өсөх төлөв ажиглагдаж байна.

Арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспорт



Боломжит орлогын өсөлт болон өрхийн нийт хэрэглээний зардалд эзлэх гутал болон арьсан эдлэлийн хувь, түүхий эдийн илүүдэл болон үйлдвэрлэлийн суурь зардал бага байгаа зэрэг олон хүчин зүйлээс арьс ширний салбар нь цаашид өсөх боломжтой байгааг харуулж байна. 2001 онд салбарын багахан хэсгийг нь арьсан бүтээгдэхүүний захиалга, лицензтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзлэж байсан бол 2002 оноос арьс шир болон гутлын салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 100% зөвшөөрсөн ба Худалдааны департаментийн танилцуулсан зах зээлийн схемээс харвал салбарыг өргөжүүлэхэд чиглэсэн үндсэн ажлуудыг төлөвлөсөн байна.

Арьс ширний үйлдвэр, гутал, арьсан эдлэл болон хувцасны үйлдвэрлэлийг хамруулан арьс ширний салбарт шинэчлэл, технологийн сайжруулалт

хийх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн нь цаашдын өсөлтийг бий болгох үндсэн нөхцөл болох юм.

Энэтхэгийн аж үйлдвэрийн экспортыг дэмжих ажлын хэсгийн зүгээс 12 дугаар Таван жилийн төлөвлөгөөнд нийт өсөлтийг 2012-2017 онд 24% байхаар, арьс ширний экспортын нийт хэмжээг 2016-2017 онд 14 тэрбум долларт хүргэхээр төлөвлөсөн байгаа нь тайлангийн дэд хэсэгт тусгаснаар бага зэрэг өөдрөгөөр төсөөлсөн байна. Энэтхэгээс хийгдэх экспортыг 15 хувиар өсгөсөн нь дэлхийн импортын өсөлтөөс 1.5 дахин өсөлттэй байхаар байна. Арьс ширний салбарыг илүү их өөдрөг байна гэж үзсэн ба дотоодын нөөцийн суурь, цалингийн бага зардал, бодлогын дэмжлэгтэйгээр салбарын өсөлтийг 12 дугаар төлөвлөгөөний хүрээнд 14-15 хувиар хурдацтай өснө гэж үзсэн байна.

Хүснэгт 6. Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэлийн салбар дахь СВОТ шинжилгээ:

Давуу тал	<ul style="list-style-type: none"> -Өндөр өсөлт -Өндөр ур чадвартай, хямд ажиллах хүчний нөөц -Том түүхий эдийн бааз -Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын санаачлагууд -Шинэ технологи нутагшуулах болон томоохон төслүүдийг удирдах чадвартай -Шинэ загвар болон бүтээгдэхүүний хөгжлийн онцлогийг тасралтгүй сайжруулах
Сул тал	<ul style="list-style-type: none"> -Бүтээгдэхүүний хадгалалтад Засгийн газраас үзүүлж буй дэмжлэг дутмаг -Олон улсын үнийн хэлбэлзэл -Өндөр хөдөлмөрийн ачаалалын үр дүн дэх асар их ажиллах хүч -Дэлхийн загварын зах зээлд биечлэн оролцох боломж дутмаг -Олон улсын стандарт бүхий олон тоглогчдын талаарх мэдээлэлгүй байдал
Боломж	<ul style="list-style-type: none"> -Дотоодын зах зээлийн хүчин чадал өсөх -Дэлхий даяар өсөн нэмэгдэж буй загварын мэдэгдэхүүн -Өөр өөр бүтэгдэхүүн үйлдвэрлэлийн мөчлөг хоорондын зайг богиносгоход туслалцаа үзүүлэхэд чиглэсэн мэдээллийн технологийг ашиглах, шаардлагатай программ хангамжийн дэмжлэгийг шийдэх -Шууд зах зээл дэх цахим худалдааг ашиглах
Эрсдэл	<ul style="list-style-type: none"> -Аж үйлдвэрлэлийн гол хэсэг зохион байгуулалтгүй -Үнэт цаас гаргах болон хувийн сангаар дамжуулан хязгаарлагдмал цар хүрээний мөнгийг эргэлтэд оруулах (олон бизнес гэр бүлийн эзэмшилд байдаг) -Банкнаас зээл авах явц хүндрэлтэй байдгаас өндөр хүүтэй хувийн зээл авдаг -Олон улсын хатуу стандарт -Зүүн Европын улс орнууд болон Азийн бусад орноос ирэх өндөр өрсөлдөөн -Засгийн газрын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, харилцаа холбоо, ур чадвар дутмаг

Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэл, үе шат:

Арьс ширний үйлдвэрлэлийг арьс шир боловсруулах ба арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл гэж хоёр хэсэгт ангилан авч үзэх бөгөөд үүнийг зураглан үзүүлбэл дараах схем гарна. Үүнд:



Арьс шир боловсруулах салбарын хувьд жижиг дунд болон томоохон үйлдвэрүүдэд арьс шир хагас болон бүтэн боловсруулах бөгөөд нийт арьс шир боловсруулалтын 10 хувийг л өрхийн үйлдвэрлэгч нар эзэлдэг байна.

Харин арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэр дундаа арьсан гутал үйлдвэрлэлийн 60 хувийг өрхийн аж ахуй эрхлэгчид, 25 хувийг бага оврын үйлдвэр, 15 хувийг дунд болон том оврын үйлдвэрүүд эрхэлдэг байна. Үүнийг доорх хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 7. Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэл дэх салбаруудын эзлэх хувь

Салбар / Бүтээгдэхүүн	Өрхийн үйлдвэрлэл	Бага оврын үйлдвэр	Дунд болон том
Арьс шир боловсруулах	10%	35%	55%
Арьс ширэн гутал	60%	25%	15%
Гутал- Non leather	15%	70%	15%
Бэлэн хувцас, гадуур хувцас	-	95%	5%
Төрөлжүүлсэн арьс ширэн бүтээгдэхүүн	10%	85%	5%
Эмээл тоног төхөөрөмж	40%	60%	-

Арьс ширний үйлдвэрлэлийн процесс:

Арьс шир боловсруулах үйл явц нь дараах хоёр үе шаттай байна. Үүнд:

- (1) Түүхий эд боловсруулах (арьснаас хагас боловсруулсан арьс шир хүртэлх) - Tanning буюу идээлэх, шүүлэх, боловсруулах явц бөгөөд үүнийг хагас боловсруулалт гэнэ.
- (2) Хагас боловсруулсан арьс ширийг бүтэн боловсруулсан арьс шир болгох үйл явц - Finishing буюу бүрэн боловсруулалт.

Хагас боловсруулалт:

Сүүлийн арваад жилүүдэд Энэтхэгийн арьс шир хагас боловсруулах үйлдвэрт томоохон өөрчлөлт гарсан. Хагас боловсруулах салбарыг зохион байгуулалттай болгосон нь үйлдвэрийн явцад чухал ач холбогдолтой болсон.

Зохион байгуулалттай болгосон гэдэг нь хүний нөөцийн хувьд 10-аас дээш болгож, шаардлагатай тоног төхөөрөмж, технологиор хангасныг ойлгоно.

Ийнхүү зохион байгуулагдсан хагас боловсруулсан салбар нь дотоодын цэвэр түүхий эдээр хангагдана. Гэвч Баруун Бенгал, Тамил Наду мужуудад Британийн боомтоос орж ирсэн түүхий эдийг хагас боловруулах аж үйлдвэрүүд байна. 1973 оноос хойш шилжилтийн үйл явц асар хурдан явагдсан бөгөөд Тамил Наду, Баруун Бенгал, Уттар Прадеш болон Пунжаб мужуудад арьс шир хагас боловсруулах үйлдвэрүүд өссөн байна. Тухайлбал, Тамил Надуд нийт 934 хагас боловсруулах үйлдвэр байдаг бөгөөд энэ нь нийт хагас боловсруулалт хийдэг үйлдвэрүүдийн 44.6 хувийг эзэлж байна. Баруун Бенгалд 538 хагас боловсруулах үйлдвэр байдаг нь нийт хагас боловсруулах үйлдвэрийн 25.7 хувийг эзэлж байна.

Харин Уттар Прадеш мужид 378 хагас боловсруулах үйлдвэр байгаа бөгөөд энэ нь нийт хагас боловсруулах үйлдвэрийн 18.0 хувийг эзэлж байна. Үлдсэн 11.7 хувийг бусад муж дахь хагас боловсруулах үйлдвэрүүд эзэлнэ.

Энэтхэг улс нь “12 дугаар Таван жилийн төлөвлөгөө”, “Арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүний төлөвлөгөө”, “Арьс ширний үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг эрх зүйн баримт бичгээрээ дотоодын эдийн засгийн өсөлтөд голлох байр суурь эзэлхүйц хэмжээний нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, дэлхийн савхин болон арьс ширний загварын зах зээлд өөрийн нэрийн брэнд бий болгох, загварын зах зээлд өөрийн чанарлаг, загварлаг бүтээгдэхүүнийг олноор нийлүүлэх зорилгын хүрээнд түүхий эд, хагас боловсруулсан болон бүтэн боловсруулсан арьс ширийг экспортод гаргахыг зорихгүй байна. Харин дотоодын түүхий эд болон хагас боловсруулсан арьс ширийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах, түүнчлэн дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хангаж дийлэхгүй байгаа түүхий эдийн хэрэгцээг импортын түүхийн эдээр нөхөж байна.

Тиймдээ ч түүхий эд болон хагас боловсруулсан арьс ширийг импортын татваргүй болгосон бөгөөд хэрэв түүхий эд, хагас болон бүтэн боловсруулсан арьс шир экспортод гаргах бол холбогдох яамнаас зөвшөөрөл авч, өндөр хэмжээний татвар төлөхөөр зохицуулсан байна. Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргах Энэтхэгийн Засгийн газрын бодлогын дагуу Энэтхэгийн арьс ширний үйлдвэрлэл дэх түүхий эдийн импорт тогтмол нэмэгдсэнийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 8. Түүхий эд, арьс, арьс ширний импорт 2004-2009 оны байдлаар
(сая еврогоор)*

	2004-05	2005-06	2006-07	2007-08	2008-09
Түүхий эд болон арьс	37.66	43.66	52.19	64.88	72.14
Арьс шир (Вэт Блю, Краст болон савхи)	159.53	174.83	216.64	260.62	270.42
Нийт	197.19	218.49	268.83	325.5	342.56

Ийнхүү Энэтхэг улс нь арьсан гуталны үйлдвэрлэлээр дэлхийд 2 дугаар, арьс ширэн бүтээгдэхүүний экспортоор дэлхийд 9 дүгээрт орж байгаа ч 2017 он хүртэл хэрэгжих 13 дугаар Таван жилийн төлөвлөгөөндөө нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортоо нэмэгдүүлж, арьсан ширэн

бүтээгдэхүүн, савхин эдлэлээр дэлхийн загварын зах зээлд өөрийн байр суурьтай болох зорилго тавин ажиллаж байна.

2.4. БНТУ

Турк улсын хувьд арьс ширний үйлдвэрлэл нь 1970 оноос өнөөг хүртэл эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн үйлдвэрлэлийн салбар юм. Ялангуяа сүүлийн 15-20 жилд энэхүү салбар нь маш хурдацтай хөгжиж дотоодын түүхий эдийн өргөн нөөц бололцоог ашиглахын зэрэгцээ импортоор оруулж ирсэн түүхий эдээр өндөр зэрэглэлийн арьсан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бусад орнуудад экспортолж байна.

1990 оны үед экспортыг нэмэгдүүлэх болсон гол шалтгаан нь Оросын Холбооны улс, ОХУ, Зүүн Европын орнуудын эрэлт хэрэгцээ болон жуулчдад зориулсан худалдан авалтын хэмжээ өссөнтэй холбоотой юм. 1990-ээд оны үед дотоод болон гадаадын арьс ширэн эдлэл дэх эрэлт хэрэгцээ өссөний үр дүнд салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хуримтлагдаж, үйлдвэрлэлийн хүчин чадал нь тэр хэмжээгээр нэмэгдсэн байна.

Харин 1998 онд ОХУ-д болсон хямралын улмаас үйлдвэрлэлийнхээ бараг тэн хагасыг ОХУ-д экспортолж байснаас улбаалж зарим хүндрэлүүд үүсч эхэлсэн байна. Энэхүү хямралын дараа зарим аж ахуйн нэгжүүд үйл ажилагаагаа зогсоосон. Харин 2000 онд арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь өөр бусад альтернатив зах зээлд нэвтэрснээр дотоодын эрэлт хэрэгцээ ч нэмэгдэн арьс ширний үйлдвэрлэл дахин хөл дээрээ боссон. 2008, 2009 онд болсон дэлхийн эдийн засгийн хямрал нь салбарын хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн. Харин 2010 оноос салбарын экспортын хэмжээ өсч 2014 он гэхэд 1,61 тэрбум долларын бараа бүтээгдэхүүн экспортолсон байна. Гэвч 2015 онд өмнөх онтой харьцуулахад экспорт 18,6%-аар буурч 1,31 тэрбум долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолсон байна.

Арьс ширний үйлдвэрлэл нь тус улсын хувьд улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа салбар мөн бөгөөд үйлдвэрлэлийн олон жилийн туршлага, өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлийн өндөр хүчин чадлаараа дэлхийн томоохон үйлдвэрлэгч орнуудтай мөр зэрэгцэн үйлдвэрлэлээ хөгжүүлсээр байна. Туркийн арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь технологийн шинэчлэлийг нэвтрүүлсэн үйлдвэрлэл эрхэлж, техникийн мэдээлэл болон технологийн тоног төхөөрөмж экспортлох түвшинд хүрсэн, салбарын нөөц бололцоо, экспортлох хүчин чадал зэрэг үзүүлэлтийг нь харгалзан үзвэл дэлхийн томоохон өрсөлдөх чадвартай орнуудын нэг юм.

Гэвч арьс ширний үйлдвэрлэлийн үндсэн орц болох боловсруулаагүй арьс ширний дотоодын нийлүүлэлт хангалтгүй, стандартад нийцэхгүй байгаагаас боловсруулаагүй болон хагас боловсруулсан арьс ширийг импортоор нийлүүлж үйлдвэрлэлд ашиглаж байна. Одоогийн байдлаар тус улсад арьс ширний үйлдвэрлэл Истанбул-Тузла, Измир-Менемен, Текирдаг-Чорлу, Ушак, Бурса, Баликесир-Гөнен, Болу-Гэрэдэ, Испарта, Хатай, Маниса-Кула зэрэг газруудад төвлөрсөн. 2014 оны байдлаар арьс ширний үйлдвэрлэлийн салбарт том жижиг нийт 6767 аж ахуйн нэгж, эдгээрт 64533 ажиллах хүч ажиллаж байна гэж эрх бүхий байгууллагаас мэдээлсэн байна.

Арьс ширний үйлдвэрлэл болон байгаль орчин:

Европт өрнөсөн экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн шахалт дарамтаас үүдэн Франц, Итали, Испани зэрэг орнууд энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэхээс татгалзсанаар Турк улс энэхүү хоосон орон зайг дүүргэсэн хэдий ч үүний зэрэгцээ байгаль орчны томоохон асуудалтай тулгарсан.

Туркийн арьс ширний үйлдвэрлэлд байгальд ээлтэй үйлдвэрлэл явуулах бодлогыг 1990-ээд оноос баримталж, энэ үеэс техник технологийн томоохон шинэчлэлүүдийг нэвтрүүлж эхэлсэн. 1994 онд салбарын төлөөллүүд болон Байгаль орчны яам “Байгаль орчны протоколь”-д гарын үсэг зурснаар 1998 оны сүүл хүртэл арьс ширний үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл явуулах аж ахуйн нэгж нь цэвэршүүлэх байгууламжтай зохион байгуулалт бүхий аж үйлдвэрийн бүсэд үйлдвэрлэл явуулах эсвэл өөрсдөө цэвэршүүлэх байгууламж байгуулах үүрэг хүлээсэн. Салбарын байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах бодлогын хүрээнд үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний 70% нь байгальд ээлтэй аргаар үйлдвэрлэгдэж байна.

Туркийн арьс ширний үйлдвэрлэлийн гадаад худалдаа:

Экспорт: Арьс болон арьсан бүтээгдэхүүний экспорт 2015 онд өмнөх онтой харьцуулахад 18,6% буурч 1,31 тэрбум доллар болсон байна. Салбарын нийт экспортын 51,1%-ийг арьсан гутлын үйлдвэрлэл эзэлж байна. Арьсан эдлэл, нэхий болон үслэг эдлэл, боловсруулсан арьсны экспортын эзлэх хувь 24,7, 10,4, 12,2 байна.

Арьс болон арьсан бүтээгдэхүүний экспорт

Бүтээгдэхүүн	2013	2014	2015	Өөрчлөлт /2014-2015/	Эзлэх хувь /2015/
Боловсруулаагүй болон боловсруулсан арьс	198.676.452	226.492.957	181.173.802	-20,0%	13,8%
Арьс ширэн бүтээгдэхүүн	421.312.114	427.034.628	323.540.827	-24,2%	24,7%
Нэхий, үслэг эдлэл	283.010.638	239.768.058	136.824.792	-42,9%	10,4%
Арьсан гутал	723.219.481	719.258.058	670.445.226	-6,8%	51,1%
Нийт	1.626.218.685	1.612.553.701	1.311.984.647	-18,6%	100,0%

Эх сурвалж: Эдийн засгийн яамны мэдээллийн систем

2015 онд арьс болон арьсан эдлэлийн экспортын 14%-ыг Итали, 10,4%-ыг Герман, 7,7%-ыг Оросын Холбооны улс, 6,8%-ыг Англи улс эзэлж байна. Арьсан гутлын салбарт Испани, Португали зэрэг Европын томоохон үйлдвэрлэгчидтэй өрсөлдөхүйц хүчин чадал бүхий үйлдвэрлэл хөгжсөн.

Арьсан гутлаа экспортолж буй орнууд

Улсын нэр	2013	2014	2015	Өөрчлөлт /2014-2015/	Эзлэх хувь /2015/
Оросын Холбооны улс	91.838.919	81.862.290	48.259.006	-41.0	17.1%
Их Британи	19.884.630	29.148.903	18.136.005	-37.8	6.4%
Ирак	23.265.157	20.572.630	17.468.347	-15.1	6.2%
Герман	8.764.437	20.138.495	15.815.823	-21.5	5.6%
Голланд	8.017.313	5.817.752	15.182.036	161.0	5.4%
Сауди Араб	14.538.455	9.716.381	13.520.278	39.1	4.8%
Итали	11.141.316	13.081.062	10.526.849	-19.5	3.7%
Франц	3.473.114	8.482.618	8.956.707	5.6	3.2%
Румын	5.722.906	4.870.486	8.220.848	68.8	2.9%
Болгар	3.728.133	6.656.125	7.458.904	12.1	2.6%
Бусад	117.970.847	139.580.360	118.410.085	-15.2	42.0%
Нийт	308.345.227	339.927.102	281.954.888	-17.1	100.0%

Эх сурвалж: Эдийн засгийн яамны мэдээллийн систем

Арьсан хувцасны экспорт 2009 онд болсон хямралаас шалтгаалж буурах болсон ба 2015 онд өмнөх онтой харьцуулахад 27.8% буурч, 156.0 тэрбум доллар болсон байна. Тус улсын арьсан хувцасны экспортод хамгийн голлох түнш орнууд Герман, Франц, Оросын Холбооны улс болон Итали улс юм.

Савхин хувцсаа экспортолж буй орнууд

Улсын нэр	2013	2014	2015	Өөрчлөлт /2014-2015/	Эзлэх хувь /2015/
Герман	41.434.525	42.865.865	32.291.128	-0.3	20.7%
Франц	29.651.202	29.271.566	19.441.127	-0.3	12.5%
Оросын Холбооны улс	29.073.108	27.538.306	11.976.594	-0.6	7.7%
Итали	13.390.026	12.752.694	11.700.812	-0.1	7.5%
Их Британи	11.169.725	14.974.064	10.236.600	-0.3	6.6%
АНУ	12.288.298	13.028.550	9.573.322	-0.3	6.1%
Испани	5.443.866	4.930.159	8.692.812	0.8	5.6%
Голланд	4.481.540	6.486.148	5.971.657	-0.1	3.8%
Австри	6.611.140	6.557.310	4.904.001	-0.3	3.1%
Ирак	2.531.568	2.804.067	3.792.377	0.4	2.4%
Бусад	61.849.477	54.996.679	37.513.262	-0.3	24.0%
Нийт	217.924.475	216.205.408	156.093.692	-27.8%	100.0%

Эх сурвалж: Эдийн засгийн яамны мэдээллийн систем

Арьс ширээр хийсэн аяллын хэрэгсэл болон бусад бүтээгдэхүүний экспорт 2015 онд 20.6%-иар буурч 154.98 тэрбум доллар болсон. Энэ салбарт тус улсын хамгийн ихээр бараа бүтээгдэхүүнээ экспортолсон орнууд нь Итали, Их Британи, Герман, Ирак болон Иран улс юм.

Улсын хэмжээнд голлон энэ төрлийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, бөөний худалдаа эрхлэн явуулдаг бүс нь Истанбул хотын Эминөнүнд байрлах Мержан, Гедикпаша, Лалели зэрэг газрууд юм. Арьсан эдлэл болон

цүнхний бөөний худалдааны төв болох Мержан, Лалели-Беязитад олон тооны үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүрүүд байрладаг.

Арьс ширэн эдлэл болон аяллын хэрэгслийн экспорт

Улсын нэр	2013	2014	2015	Өөрчлөлт /2014-2015/	Эзлэх хувь /2015/
Итали	63.528.103	61.610.851	34.062.288	-44.7%	21.9%
Их Британи	28.918.920	27.752.724	26.295.645	-5.3%	16.9%
Герман	17.594.846	16.607.341	15.698.879	-5.5	10.1%
Ирак	5.889.158	8.591.076	9.577.242	11.9%	6.2%
Иран	79.724	1.687.777	7.590.656	349.7%	4.9%
Испани	5.771.870	7.667.191	7.530.118	-1.8%	4.9%
Франц	5.355.520	4.766.669	5.340.466	12.0%	3.4%
Данимарк	4.314.860	4.930.671	3.920.012	-20.5%	2.5%
Швейцари	4.371.723	4.068.325	3.721.073	-8.5%	2.4%
АНУ	6.671.378	4.638.244	3.416.859	-26.3%	2.2%
Бусад	48.439.143	52.834.988	37.830.696	-28.4%	24.4%
Нийт	190.935.245	195.155.857	154.983.843	-20.6%	100.0%

Турк улсын арьс шир болон арьс ширээр хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дотоодын стандартад нийцсэн түүхий эдийн нийлүүлэлт хангалтгүй байгаагаас шалтгаалж импортоор оруулж ирсэн түүхий эдийн үнэ дотоодын үйлдвэрлэлд нөлөөлж байна.

Импорт

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт 2015 онд 1.60 тэрбум долларын бүтээгдэхүүн импортолсон ба үүний дийлэнх хувийг боловсруулаагүй арьс шир эзэлж байна. Энэ тоо хэмжээ нь нийт экспортын 43.3%-тай тэнцэж байна.

Арьс шир болон арьсан эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл дэх импорт

Бараа бүтээгдэхүүн	2013	2014	2015	Өөрчлөлт /2014-2015/	Эзлэх хувь /2015/
Боловсруулаагүй болон болвсруулсан арьс шир	681.459.528	506.535.609	286.961.119	-43.3%	17.9%
Арьс ширэн эдлэл	547.520.899	554.651.783	486.422.963	-12.3%	30.3%
Нэхий, үслэг эдлэл	115.781.639	101.223.461	37.620.786	-62.8%	2.3%
Гутал	992.947.486	953.894.053	794.561.643	-16.7%	49.5%
Нийт	2.337.709.552	2.116.304.906	1.605.566.511	-24.1%	100.0%

Дэлхийн зах зээл

Технологийн дамжлага ихтэй, хүний хөдөлмөр их шаарддаг арьс ширний үйлдвэрлэлийн салбар дахь өндөр хөдөлмөрийн хөлс, экологийн бохирдол зэрэг шалтгаанаар 1980-аад оноос хөгжилтэй орнууд энэ чиглэлийн үйлдвэрлэлээс татгалзаж илүү их ашиг орлого олох боломжтой технологийн болон шинжлэх ухааны салбарт хөл тавьж эхэлсэн. Улмаар хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудад арьс шир боловсруулах үйлдвэрлэл явагдах

эх суурь тавигдаж Европ төвтэй үйлдвэрлэлийн салбар явсаар Ази тивд ноёрхох болсон. Өнөөдөр арьс ширний үйлдвэрлэлээр Ази тив тэргүүлж байна.

Арьс ширний үйлдвэрлэл Ази болон Америк тивийн орнуудад хөгжих болсон гол шалтгаан нь хөдөлмөрийн хөлс, хөгжилтэй орнууд хямд өртөгтэй арьс ширний экспортыг нэмэгдүүлсэн, байгаль орчныг хамгаалах талаарх нарийн зохицуулалттай холбоотой гарсан зардлын өсөлт зэрэг болно. Арьс ширний үйлдвэрлэл Азийн орнуудад хөгжсөнөөр эдгээр улс орнуудын хүн амын өсөлт дэлхийн дунджаас дээгүүр болж, энэ нь арьс ширэн бүтээгдэхүүний эрэлтэд эерэгээр нөлөөлөх болсон.

Хятад улс дэлхийн томоохон арьс ширний үйлдвэрлэл эрхлэгч орон болохын сацуу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд арьс ширний үйлдвэрлэлээ улам бүр өргөжүүлсээр байна. Хятадад сайн чанарын арьс ширний үйлдвэрлэл ч хурдацтай хөгжиж байна.

Хятад болон Энэтхэгт сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн зардал дахь өсөлт, үйлдвэрлэлийн хүчин чадал гэхээсээ илүү бүтээгдэхүүний чанар болон загвар, барааны тэмдэгт хөрөнгө оруулалт хийхэд түлхүү анхаарч байна. Хөгжилтэй орнууд ялангуяа Европын орнуудад нэмүү өртөг илүү ихээр шингэсэн, байгаль орчинд ээлтэй аргаар үйлдвэрлэсэн, загварлаг болон брэнд бүтээгдэхүүнүүд эрэлттэй байна.

Боловсруулсан арьс ширний үйлдвэрлэлээр Турк, Хятад, Энэтхэг, Пакистан, Итали, Өмнөд Солонгос болон Испани, үслэг эдлэл үйлдвэрлэлээр Турк, Хятад, Итали, Уругвай, Өмнөд Солонгос болон Аргентин, үнэт үслэг эдлэл үйлдвэрлэлээр Грек, Хятад, Хон-Конг, Канад, Герман, Финлянд болон АНУ тэргүүлэх орнууд юм.

Итали, Испани дахь түүхий арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь орчны бохирдол үүсгэх, үйлдвэрлэлийн зардлын өсөлт гэх зэрэг шалтгаанаар Румын, Болгар, Турк зэрэг орнуудад тэлэх болсон байна.

Ази номхон далайн бүс нутагт Хятад болон Энэтхэгт үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж байгаагийн зэрэгцээ Вьетнам, Индонез зэрэг шинэ үйлдвэрлэгч орнууд, Иран, Монгол, Африкийн Тунис, Судан, Нигери, өмнөд Африк зэрэг шинэ бүс нутгийн улсуудад үйлдвэрлэл болон экспортын төвүүдийн сонголтууд үүсч байна.

Дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн салбарт тулгамдаж буй асуудлын нэг бол түүхий эд буюу боловсруулаагүй арьс ширний хангамж, баталгаа болж байна. Түүхий эдийн олдоц ховордож, үнэ өртөг нь нэмэгдсээр байна. Дэлхийн зарим улс орнууд түүхий эд экспортлохыг хориглож, хязгаарлалт хийж байна. Тиймээс ч түүхий эдийн үнэ өртөг тогтмол өсөх хандлагатай байна.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт хамгийн их хэмжээгээр экспортлогддог бүтээгдэхүүн нь арьсан гутал ба арьсаар хийсэн бусад бүтээгдэхүүн, бүрэн болон хагас боловсруулсан арьс, үслэг эдлэл, савхин хувцас зэрэг бүтээгдэхүүнүүд нь экспортоороо дараагийн жагсаалтанд орж байна.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт чухал үүрэг бүхий Пакистан, Энэтхэг, Бразил, Аргентин, Мексик зэрэг орнуудын давуу тал нь түүхий арьс ширний хангалттай нөөц, хямд ажиллах хүчин, том хэмжээний дотоодын зах зээл болон уламжлал болсон үйлдвэрлэлийн арга барил зэрэг нөхцөл байдлууд юм.

Өмнөд Солонгос, Тайланд, Тайвань зэрэг орнуудад хямд ажиллах хүчний нөөц бололцоо байгаагийн зэрэгцээ үйлдвэрлэлийг дэмжсэн төрийн бодлогууд арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Эдгээр орнууд энэ салбарын үйлдвэрлэлийн хөгжиж буй орнуудад шилжих тэр цаг үед боломжийг сайн ашиглаж өөрсдийн орондоо арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх таатай нөхцөл боломжийг бүрдүүлж чадсан.

Ирээдүйд Герман улсын арьс ширний үйлдвэрлэл доройтох, импортоо нэмэгдүүлэх хандлагатай байгаа тул Турк улс энэхүү орон зайг нөхөх, Германы зах зээлд өөрийн гэсэн байр суурийг олж авахыг эрмэлзэж байна. Нэхий үйлдвэрлэх технологи болон нэхий, үслэг эдлэлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд Герман улсын туршлагыг хуваалцаж хамтран ажиллах нь салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэж Турк улсын холбогдох байгууллага үзэж байгаа юм.

ЗХУ тарсанаар ОХУ газар нутгийн байршлаар ойр учраас дотоодын эрэлт хэрэгцээгээ нэн түрүүнд Турк улсаас хангах болсон. 1990-ээд оны эхэн үеэс тус улсад экспортолсон бараа бүтээгдэхүүн болон тус улсын иргэдийн хувийн журмаар хийсэн жижиг бизнес нь Турк улсад арьс ширний үйлдвэрлэл хөгжихэд ихээхэн хувь нэмэр оруулсан боловч Оросын холбооны улсаас чанарын шаардлага харгалзалгүй чанартай, чанаргүй бараа бүтээгдэхүүн худалдан авах өндөр сонирхол нь наад захын стандартад нийцээгүй, чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд хүргэж улмаар Турк бараа бүтээгдэхүүний нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн байна. 1997 оноос арьс ширэн бүтээгдэхүүний хувийн жижиг бизнес буурсаар 1998 оны Оросын Холбооны улсад болсон хямралаас шалтгаалж улам бүр буурсан үзүүлэлт гарсан байна. Сүүлийн жилүүдэд Оросын Холбооны улсын наймаачид илүү хямд үнэ өртөгтэй Хятадын зах зээлийг сонирхсоноор энэ чиглэлийн жижиг бизнес эрхлэгчдийн Туркийн арьс ширний үйлдвэрлэлд нөлөөлөх нөлөө багассан хэдий ч сайн чанарын, үнэ өртөг өндөр бараа бүтээгдэхүүний Оросын Холбооны улсын зах зээл дэх эрэлт хэрэгцээ нь нэмэгдсээр байна.

2014 оны байдлаар дэлхийн боловсруулаагүй болон бүрэн боловсруулсан арьс ширний экспорт 36.5 тэрбум доллар болсон байна. Боловсруулаагүй болон бүрэн боловсруулсан арьсны экспортлоор Итали, АНУ болон Бразил улс дэлхийд тэргүүлж байна. Эдгээр улсуудын дэлхийн зах зээл дэх экспортын эзлэх хувь хэмжээ нь 15.3%, 10.5%, 8.1% юм.

*Дэлхийн зах зээл дэх боловсруулаагүй болон боловсруулсан
арьс ширний экспорт /тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
Итали	5.521.320	5.594.942	1.3%	15.3%
АНУ	3.757.799	3.833.706	2.0%	10.5%
Бразиль	2.510.559	2.947.940	17.4%	8.1%
Хон-Конг	2.542.056	2.428.788	-4.5%	6.6%
Герман	1.416.441	1.512.259	6.7%	4.1%
Энэтхэг	1.349.059	1.363.716	1.1%	3.7%
Австрали	1.192.928	1.139.110	-4.5%	3.1%
Өмнөд Солонгос	1.006.486	1.003.885	-0.3%	2.8%
Аргентин	916.885	1.003.200	9.4%	2.7%
Франц	975.105	980.568	0.6%	2.7%
Нийт	35.614.681	36.543.445	2.61%	100.0%

Эх сурвалж : ITC Trademap

Дэлхийн зах зээлд боловсруулаагүй болон боловсруулсан арьс ширний экспорт 2015 онд 35.9 тэрбум доллар болсон байна. Хятад, Итали, Хон-Конг улсууд жагсаалтыг тэргүүлж байгаа ба нийт экспортод эзлэх хувь нь 22.9%, 13.8%, 8.6% юм. Турк улс 2014 онд 506.5 сая долларын экспортоор дэлхийн хамгийн том 19 дэх боловсруулаагүй болон боловсруулсан арьс шир экспортлогч орон юм.

*Дэлхийн зах зээл дэх боловсруулаагүй болон боловсруулсан
арьс шир импортлогч орнууд /тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
Хятад	8.025.665	8.261.102	2.9%	22.9%
Итали	4.588.126	4.957.395	8.1%	13.8%
Хон-Конг	3.503.347	3.081.336	-12.1%	8.6%
Вьетнам	1.164.801	1.686.007	44.7%	4.7%
Герман	1.208.793	1.290.625	6.8%	3.6%
Мексик	1.012.630	1.164.592	15%	3.2%
Өмнөд Солонгос	1.026.219	1.077.301	4.9%	3.0%
Испани	877.241	948.982	8.2%	2.6%
АНУ	720.613	799.386	10.9%	2.2%
Румын	708.846	777.633	9.7%	2.2%
Нийт	33.792.912	35.943.394	6.4%	100.0%

Эх сурвалж: ITC Trademap

Дэлхийн зах зээлд арьс ширэн аяллын бүтээгдэхүүний экспорт сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаа ба өмнөх онтой харьцуулахад 1.8%-аар өсч 61.52 тэрбум долларт хүрсэн байна. Хамгийн томоохон экспорлогч орнууд нь Хятад, Итали, Франц улс бөгөөд эдгээр 3 орны дэлхийн зах зээл дэх эзлэх хувь хэмжээ нь 65.7% юм.

*Дэлхийн зах зээл дэх арьс ширэн аяллын бүтээгдэхүүний экспортлол
/тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
Хятад	27.586.307	27.122.787	-1.7%	44.1%
Итали	6.818.633	7.310.877	7.2%	11.9%
Франц	5.845.617	5.986.363	2.4%	9.7%
Хон-Конг	5.541.631	5.184.950	-6.4%	8.4%
Вьетнам	1.687.111	2.244.206	33.0%	3.6%
Герман	1.426.357	1.580.979	10.8%	2.6%
Бельги	1.311.580	1.267.054	-3.4%	2.1%
Энэтхэг	1.216.232	1.259.296	3.5%	2.1%
АНУ	1.166.472	1.159.163	-0.6%	1.9%
Голланд	959.885	1.018.450	6.1%	1.7%
Нийт	60.421.339	61.522.244	1.8%	100.0%

Эх сурвалж: ITC Trademap

Дэлхийн зах зээл дэх арьс ширэн аяллын бүтээгдэхүүний экспорт 2014 онд өмнөх онтой харьцуулахад 4.6%-аар өсч ойролцоогоор 59.73 тэрбум долларт хүрсэн байна. Гол экспортлогч орнуудын эхэнд 18.4%-аар АНУ тэргүүлж байна. Дараа нь Хон-Конг, Япон, Франц орнууд 8.8%, 8.3%, 6.2% эзэлж байна.

*Дэлхийн зах зээл дэх арьс ширэн аяллын бүтээгдэхүүний экспорт
/тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
АНУ	10.565.985	10.975.671	3.9%	18.4%
Хон-Конг	5.213.083	5.249.911	0.7%	8.8%
Япон	5.316.589	5.212.131	-1.9%	8.7%
Франц	3.446.918	3.716.782	7.8%	6.2%
Герман	3.047.463	3.337.033	9.5%	5.6%
Их Британи	2.878.083	3.165.660	9.9%	5.3%
Итали	2.472.204	2.708.902	9.6%	4.5%
Өмнөд Солонгос	1.830.266	2.023.366	10.5%	3.4%
Хятад	1.563.210	1.598.540	2.3%	2.7%
Испани	1.224.180	1.395.650	14.0%	2.3%
Нийт	57.110.179	59.738.319	4.6%	100.0%

Эх сурвалж: ITC Trademap

Арьс ширний үйлдвэрлэл Ази болон Өмнөд Америкийн орнуудад давамгайлж байгаагийн зэрэгцээ Итали улс савхин хувцасны загварыг тодорхойлогч улс хэвээр байна. 2014 оны байдлаар Италийн савхин хувцасны экспорт 1.4 тэрбум долларт хүрсэн байна. Итали улс нь өндөр хүчин чадал бүхий боловсруулах үйлдвэрлэл, шинэлэг, шилдэг загвараараа чанартай, бренд, хамгийн сүүлийн үеийн загварыг тодорхойлсон өндөр үнэ өртөг бүхий бүтээгдэхүүнээрээ дэлхийн чинээлэг худалдан авагчдын хэрэгцээг хангаж байна.

Харин Хятад, Хон-Конг, Энэтхэг, Пакистан зэрэг улсууд эсрэгээрээ дэлхийн хамгийн хямд үнэ өртөг бүхий савхин хувцас үйлдвэрлэгчид юм. Хятад улс дэлхийн зах зээл дэх савхин хувцасны үйлдвэрлэлийн 22.8%-ыг дангаараа эзэлж байна. Хятад улс дахь хямд ажиллах хүчний нөөц нь тус улс бага зардлаар үйлдвэрлэл явуулах боломжийг нээж өгч байна.

*Дэлхийн зах зээл дэх савхин хувцас, эдлэлийн экспорт
/тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
Хятад	2.194.211	2.171.060	-1.1%	22.8%
Итали	1.361.636	1.478.947	8.6%	15.6%
Энэтхэг	1.067.211	1.045.437	-2.0%	10.9%
Пакистан	696.646	703.488	0.9%	7.4%
Хон-Конг	664.400	605.380	-8.9%	6.4%
Франц	540.460	577.479	6.9%	6.1%
Герман	459.405	467.923	1.8%	4.9%
Испани	217.753	267.952	23.1%	2.8%
АНУ	235.687	236.399	0.3%	2.5%
Голланд	234.479	233.175	-0.6%	2.5%
Нийт	9.373.328	9.513.312	1.5%	100.0%

Эх сурвалж: ITC Trademap

Дэлхийн зах зээл дэх савхин хувцас, эдлэлийн нийт экспортын хэмжээ 2014 оны байдлаар 9.51 тэрбум доллар бөгөөд Хятад, Итали улсын дараа Энэтхэг, Пакистан, Хон-Конг улсууд ихээхэн хувийг эзэлж байна. Харин Турк улс 2.3%-иар дэлхийн савхин хувцас, эдлэлийн экспортоороо 11 дэх том экспортлогч орон юм.

*Дэлхийн зах зээл дэх савхин хувцас, эдлэлийн импорт
/тэрбум ам.доллар/*

Улсын нэр	2013	2014	Өөрчлөлт /2013-2014/	Эзлэх хувь /2014/
АНУ	1.697.698	1.698.921	0.1%	18.9%
Герман	825.113	887.993	7.6%	9.9%
Франц	657.656	679.271	3.3%	7.5%
Хон-Конг	614.061	596.096	-2.9%	6.6%
Их Британи	399.244	440.955	10.5%	4.9%
Япон	433.154	408.468	-5.7%	4.5%
Итали	391.614	407.094	3.9%	4.5%
Испани	255.739	290.072	13.4%	3.2%
Канад	258.960	274.859	6.1%	3.1%
Хятад	272.193	270.516	-0.6%	3.0%
Нийт	8.737.580	9.002.781	3.0%	100.0%

Эх сурвалж: ITC Trademap

Турк улсын арьс ширний үйлдвэрлэлд хийсэн SWOT шинжилгээ

Энэхүү шинжилгээний хүрээнд салбарын үйлдвэрлэлийн давуу болон сул талууд, тулгамдсан асуудлууд, боломжууд зэрэг хүчин зүйлсийг авч үзэн, үнэлэлт өгсөн байна.

Давуу талууд:

Хүчин зүйлс	Арьс ширэн эдлэлийн үйлдвэрлэл	Арьсан гутлын үйлдвэрлэл
Үйлдвэрлэлийн түүхий эд ба орц	1. Дэд салбар давхар хөгжсөн	2. Дэд салбар давхар хөгжсөн
Үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> Уламжлалт үйлдвэрлэлийн арга барил Зохион байгуулалттай үйлдвэрлэлийн бүсүүд Дэд бүтцийн дэмжлэг /цэвэрлэх байгууламж/ Экологид ээлтэй үйлдвэрлэл Үйлдвэрлэлийн шинэлэг технологи Үйлдвэрлэлийн төвлөрөл 	<ul style="list-style-type: none"> Уламжлалт үйлдвэрлэлийн арга барил Үйлдвэрлэлийн олон жилийн туршлага Үйлдвэрлэлийн хүчин чадал Үйлдвэрлэлийн шинэлэг технологи Шуурхай уян хатан үйлдвэрлэлийн боломж Үйлдвэрлэлийн төвлөрөл
Бүтээгдэхүүн сайжруулалт ба чанар	<ul style="list-style-type: none"> Арьс шир боловсруулах арга, туршлага Үслэг эдлэл, нэхий үйлдвэрлэх ноу-хау Жижиг дагалдах хэрэгсэл үйлдвэрлэх ур чадвар Бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх ур чадвар Загварлаг коллекци Загварын ертөнцтэй хөл нийлүүлэх чадвар Бүтээгдэхүүний чанар Гар урлал 	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний чанар дахь хурдацтай хөгжил Илүү их нэмүү өртөгтэй үйлдвэрлэлд шилжсэн байдал Ямар ч төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чадвар Загварын өргөн сонголтууд
Маркетинг, борлуулалт	<ul style="list-style-type: none"> Газар зүйн байршил Дотоод зах зээлийн эрэлт Гадаад худалдаа Гадаад худалдаа ба өрсөлдөх чадвар Салбарын зохицуулах байгууллага Аялал жуулчлалын таатай нөхцөл боломж 	<ul style="list-style-type: none"> Газар зүйн байршил Дотоод зах зээлийн эрэлт Гадаад худалдаа Нөлөө бүхий Турк гутлын хэв маяг Шуурхай найдвартай гадаад мэдээлэл
Хөдөлмөрийн бүтээмж ба ажиллах хүчин	<ul style="list-style-type: none"> Дунд болон дээд боловсролын байгууллагуудын сургалт Чадварлаг ажиллах хүчин (мэргэшсэн) 	<ul style="list-style-type: none"> Чадварлаг ажиллах хүчин (мэргэшсэн) Шуурхай мэдээлэл дамжуулалт болон суралцах чадвар
Зах зээл болон салбарын зохицуулалт	<ul style="list-style-type: none"> Хамгаалах арга хэмжээ 	<ul style="list-style-type: none"> Хамгаалах арга хэмжээ

Сул талууд:

Хүчин зүйлс	Арьс ширэн эдлэлийн үйлдвэрлэл	Арьсан гутлын үйлдвэрлэл
Үйлдвэрлэлийн түүхий эд ба орц	<ul style="list-style-type: none"> Малын тоо хэмжээ буурсан Боловсруулагдаагүй арьс ширний нийлүүлэлтэд гадаад зах зээлд хамааралтай байх Нядалгаа ба арьс ширний чанарын асуудал Татварын дарамт Туслах хэрэгслийн үйлдвэрлэлийн хөгжлийн удаашрал 	<ul style="list-style-type: none"> Боловсруулагдаагүй арьс ширний нийлүүлэлтэнд гадаад зах зээлд хамааралтай байх Гутлын хэсгийг гадаадаас оруулж ирдэг Чанартай түүхий эдийн олдоц хомс

Үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> Өндөр хүчин чадал бүхий цахилгаан эрчим хүчний хэрэглээ, цэвэрлэх байгууламж болон усны хэрэглээ, зардал өндөр Зарим бүс нутагт цэвэрлэх байгууламжгүй байгаа байдал Шинээр үйлдвэрлэл хөгжиж буй орнуудтай харьцуулахад ажиллах хүчний зардал өндөр 	<ul style="list-style-type: none"> Жижиг цех хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй байдал (үйлдвэрлэл хязгаарлагдмал) Цөөн тооны бүтээгдэхүүн нийлүүлэлт Гар ажиллагаа Шинээр үйлдвэрлэл хөгжиж буй орнуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн зардал ба бүтээгдэхүүний үнийн дарамт, өрсөлдөх чадвар
Бүтээгдэхүүн сайжруулалт ба чанар	<ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал R & D, P & D Хязгаарлагдмал брэнд 	<ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал R & D, P & D Шинэлэг санаа загварын шинэ сэдэл бага Хязгаарлагдмал брэнд
Маркетинг, борлуулалт	<ul style="list-style-type: none"> Том зах зээлд (АНУ, Япон, Хятад, Солонгос зэрэг) өөрийн байр сууриа эзэлж чадаагүй байдал Зах зээлээ өргөжүүлэх боломж хомс 	<ul style="list-style-type: none"> Борлуулалт сурталчилгаа бага
Санхүүжилт, санхүүгийн боломж	<ul style="list-style-type: none"> Бага ашиг орлого Хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэр Өндөр санхүүжилтийн зардал 	<ul style="list-style-type: none"> Хангалтгүй хөрөнгийн хуримтлал
Хөдөлмөрийн бүтээмж ба ажиллах хүчин	<ul style="list-style-type: none"> Сургалтын хөтөлбөр Дадлагын хичээл бага Боловсролын байгууллагуудын ажиллах хүчин, лаборатори, материалын хүрэлцээ бага 	<ul style="list-style-type: none"> Чадварлаг хэдий ч зохих түвшний боловсролгүй ажиллах хүчин
Зах зээл болон салбарын зохицуулалт	<ul style="list-style-type: none"> Шударга бус өрсөлдөөн, дуураймал бүтээгдэхүүн Төрийн дэмжлэг хангалтгүй 	<ul style="list-style-type: none"> Шударга бус өрсөлдөөн, дуураймал бүтээгдэхүүн Төрийн дэмжлэг хангалтгүй

Турк улсын Засгийн газрын 2012/3305 дугаар бүхий “Үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг” тогтоолын хүрээнд улсын 81 аймгийг нийгмийн хөгжлийн индексийг нь харгалзан 6 бүс нутагт хуваасан. Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээс нь шалтгаалж төрөөс үзүүлэх тусламж дэмжлэгийн төрөл, хувь хэмжээг харилцан адилгүй байхаар тогтоосон. Энэхүү тогтоолын 4 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтад төрөөс олгох урамшууллын системийг ерөнхий, бүс нутгийн, их хэмжээний болон стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтанд үзүүлэх урамшуулал гэж 4 хуваасан.

Ерөнхий хөнгөлөлт урамшуулал	Бүс нутгийн хөнгөлөлт урамшуулал	Их хэмжээний хөрөнгө оруулалтанд үзүүлэх хөнгөлөлт урамшуулал	Стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтанд үзүүлэх хөнгөлөлт урамшуулал
<ul style="list-style-type: none"> НӨАТ-ын хөнгөлөлт Гаалийн татвараас чөлөөлөх 	<ul style="list-style-type: none"> НӨАТ-ын хөнгөлөлт Гаалийн татвараас чөлөөлөх Татварын хөнгөлөлт Нийгмийн даатгалын хөнгөлөлт Хөрөнгө оруулалтын байршлын хуваарилалт Хүүгийн бодлогоор дэмжих 	<ul style="list-style-type: none"> НӨАТ-ын хөнгөлөлт Гаалийн татвараас чөлөөлөх Татварын хөнгөлөлт Нийгмийн даатгалын хөнгөлөлт Хөрөнгө оруулалтын байршлын хуваарилалт 	<ul style="list-style-type: none"> НӨАТ-ын хөнгөлөлт Гаалийн татвараас чөлөөлөх Татварын хөнгөлөлт Нийгмийн даатгалын хөнгөлөлт Хөрөнгө оруулалтын байршлын хуваарилалт Хүүгийн бодлогоор дэмжих НӨАТ-ын буцаан олголт

Энэхүү тогтоолд зааснаар ажилтны нийгмийн даатгалын ажил олгогчоос төлөх даатгалаас чөлөөлөх хугацаа нь бүс нутгаас шалтгаалж 2-10 жилийн хугацаатай, татварын хөнгөлөлтийн хувьд орлогын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар мөн бүс нутгийн хуваарилалтаас хамаарч 30-90 хүртэл хувь байхаар тус тус тогтоосон.

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл дэх өрсөлдөөний гол хүчин зүйлүүд:

Тус улсын хувьд боловсруулаагүй арьс ширний нөөцийн хомсдол, бүтээгдэхүүний нийт өртөгт шингэх зардлууд өндөр үнэ өртөгтэй байгаа нь үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн ажиллах хүчний үнэ өртөг өндөр байгаагийн зэрэгцээ ажиллах хүчний эрүүл мэнд, баталгааг зохицуулсан төрөөс гаргасан шийдвэр нь үйлдвэрлэлд улам их дарамт үзүүлж байгаа юм байна. Ажиллах хүчний зардал, цахилгаан эрчим хүчний үнэ тариф, материал техникийн хангамж, хог хаягдлын зардал нь үйлдвэрлэлийн өртөгт хамгийн их нөлөөлнө. Үйлдвэрлэлд ашиглагдаж буй үйлдвэрлэлийн технологи ч өрсөлдөх чадварыг тодорхойлж байна. Арьс ширний үйлдвэрлэлд дэд бүтэц нь хөгжсөн, хог хаягдал болон цэвэрлэх байгууламжийн асуудал нь шийдэгдсэн зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүсэд үйлдвэрлэл явуулах нь хамгийн чухал асуудал юм.

Турк улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт баримтлах стратегийн зорилтууд:

Турк улс нь арьс ширний үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлэх 19 стратегийн зорилт дэвшүүлсэн ба түүхий эдийн оролтод чиглэсэн 4, үйлдвэрлэлд чиглэсэн 4, технологийн арга ажиллагаанд чиглэсэн 1, борлуулалт, худалдаанд чиглэсэн 5, хүний нөөцөд чиглэсэн 2, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1, зах зээл болон салбарын нөхцөл байдалтай холбоотой 2 зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

Үйлдвэрлэлийн хүчин зүйл	Стратеги зорилтууд
Түүхий эд болон үйлдвэрлэлийн бусад орц	<ol style="list-style-type: none"> 1. Мал сүргээ өсгөх, түүхий арьс ширэнд ач холбогдол өгөх, нядалгааны газруудын үйл ажиллагаанд хяналт тавих, арьс ширийг бэлтгэх бүхий л шат дамжлагад стандартыг хатуу мөрдөх; 2. Боловсруулаагүй, хагас боловсруулсан нэхий эдлэлийн импортод 20%-ийн онцгой татвараас чөлөөлөх, 18%-ийн НӨАТ-ыг 8% болгож бууруулах; 3. Дотооддоо нийлүүлэх боломжгүй түүхий эдийн импортод бусад төрлийн татаасуудыг үгүй болгох; 4. Арьс ширээр хийгдэх бэлэг дурсгалын болон бусад жижиг дагалдах хэрэгслийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, чанар, загварт ач холбогдол өгөх;
Үйлдвэрлэл	<ol style="list-style-type: none"> 5. Аж ахуйн нэгжүүдийн ажилтан ажиллуулахтай холбоотой төрийн дарамт шахалтыг багасгах, чөлөөт хөдөлмөрийн зах зээлд шилжих, цахилгааны төлбөрийг хөнгөлөлттэйгээр ашиглуулах; 6. Шинээр хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөлд 6-р бүс нутагт хэрэгжиж байгаа хөнгөлөлт урамшууллыг зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүс дэх шинэ хөрөнгө оруулагчдад нэгэн адил хамааруулах;

	<p>7. Орчноо тохижуулах болон хамгаалахтай холбогдон гарах зардалд Байгаль орчин, хот тохижуулах яамны төсвөөс санхүүгийн дэмжлэг авах;</p> <p>8. Зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүсээс өөр газар үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжүүдийг үйлдвэрлэлийн зохион байгуулалт бүхий бүс болоход шаардагдах дэд бүтэц болон бусад хөрөнгө оруулалтыг хийх, үйлдвэрлэлийн явцад зохих дэмжлэг үзүүлэх, Истанбул хот дахь үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжүүдийг хотын шинэ төлөвлөгөөнд дурдагдсан зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүсэд байршуулах;</p>
Техник технологи	9. Turquality ба Брэндийг дэмжих төсөлд арьс ширний үйлдвэрлэлийн оролцоог дэмжих, төслийн хэрэгжилтийг сайжруулах, төрийн дэмжлэгийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хурдасгах;
Маркетинг борлуулалт	<p>10.2023 онд 10 тэрбум долларын экспорт хийх;</p> <p>11.Хувийн журмаар хийсэн экспортыг албан ёсны экспортод оруулж тооцох, онцгой албан татварын буцаан олголтонд хамруулах;</p> <p>12.Оросын холбооны улстай хувийн бизнес хийж буй аж ахуйн нэгжүүдийн татвар, гаалийн асуудалд төрөөс бодлогоор дэмжих, ачаа тээшний хөнгөлөлт үзүүлэх;</p> <p>13.Аж ахуйн нэгжүүдийг валютын бодлогоор дэмжих;</p> <p>14.Жинхэнэ болон хуурамч арьс ширний талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх;</p>
Хүний нөөц	<p>15.Мэргэшсэн ажиллах хүч бэлтгэх, гар урлалын өв соёлоо хадгалах;</p> <p>16.Ажилтан ажиллуулахтай холбогдолтой төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийг дахин авч үзэх, эдгээр шийдвэрүүдээр ажил олгогчид үүрэг болгосон дарамтыг багасгах;</p>
Санхүүжилт	17.Арьс ширэн эдлэлийн худалдан авалт дахь 18%, борлуулалт дахь 8%-ийн НӨАТ төлөхтэй холбогдсон асуудлыг шийдэх;
Зах зээл, салбарын нөхцөл байдал	<p>18.Импортоор оруулж буй бараа бүтээгдэхүүний чанар болон стандартад хатуу хяналт тавих, заавал бүтээгдэхүүний танилцуулгатай байх шаардлага тавих, хямдралын цаг үеийг тогтоох;</p> <p>19.Бүртгэлгүй болон хуурамчаар бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахтай тэмцэх, оюуны өмчийн хуулийн хэрэгжилтийг хангах;</p>

Арьс ширний үйлдвэрлэлийн зардлын талаарх Үйлдвэрлэлийн Ерөнхий Газраас хийсэн судалгаа

Зардлын ангилал	Арьс шир боловсруулах	Савхин хувцас	Арьс ширэн эдлэл	Арьсан гутал	Дундаж
Үндсэн түүхий эд %	61	69	42	51	56
Дайвар бүтээгдэхүүн %	18	5	14	13	12
Ажиллах хүчний зардал, нийгмийн даатгал %	11	15	26	22	19
Санхүүжилт ба элэгдэл хорогдлын зардал %	3	4	7	5	5

Бусад зардал /захиргааны зардал, сурталчилгааны зардал, цахилгаан, ус, гэрэлтүүлгийн зардал/ %	6	8	11	9	8
Нийт	100	100	100	100	100

Арьс ширний үйлдвэрлэлд боловсруулаагүй арьс ширийг гадаадаас импортлохыг бууруулах /хөдөө аж ахуйн салбарт дорвитой шинэчлэл хийх/, арьс ширийг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэх, хүний хөдөлмөр их шаарддаг энэ салбарт шинэлэг техник технологийг нэвтрүүлэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, чанаржуулах, салбарын үйлдвэрлэлийн стандартыг тодорхойлж, зохион байгуулалттай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дагалдах хэрэгслийн импортыг бууруулах, эдгээр нэмэлт хэрэгслүүдийг дотооддоо үйлдвэрлэх хүчин чадалтай болох нь урсгал зардлыг бууруулах болон гадаад валютын эрсдэлтэй тулгарахаас хамгаалах юм.

Турк улсын Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл ба Технологийн яам Үйлдвэрлэлийн Ерөнхий газраас баталсан “Туркийн нэхмэл, бэлэн хувцас болон арьс ширний үйлдвэрлэлийн салбарын стратегийн баримт бичиг ба үйл ажиллагааны төлөвлөгөө” /2015-2018/

Арьс ширний үйлдвэрлэлийн салбар:

Бүх төрлийн ан амьтан, малын арьс шир болон эдгээрээс гаргаж авсан аяллын болон гар цүнх, бээлий, бүс, мал аж ахуйд хэрэглэгдэх дагалдах хэрэгслүүд, арьс шир, нэхийгээр хийсэн хувцас, гутал энэ салбарт хамаарна.

Арьс шир боловсруулахаас жижиг эдлэл хийх, савхин хувцас үйлдвэрлэх, нэхий эдлэл хийх, гутлын салбар хүртлээ олон шат дамжлагад үйл ажиллагаа явуулж буй энэ салбар нь гар ажиллагаа, гар урлал маш их шаарддаг ба мэргэшсэн хүний нөөцийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа нь явагддаг. Мөн түүнчлэн чанартай түүхий эд, үйлдвэрлэлийн дараах бохирдол энэ салбарын тулгамдсан асуудлууд мөн.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь Туркийн хамгийн урт түүхтэй үйлдвэрлэлийн салбарын нэг бөгөөд зөвхөн Туркуудэд хамааралтай арьс шир үйлдвэрлэх арга барил болох “sahtiyen” арга нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн ба Англи хэлэнд “Turkish Leather” болж нэвтэрсэн байна. Турк улс өнөөдөр ялангуяа бог малын арьс ширний үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж буй орнуудын нэг мөн. Үйлдвэрлэлийн зохион байгуулалт бүхий бүсэд үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн гол онцлог нь Европын стандартад нийцсэн, экологид ээлтэй аргаар, техник технологийн шинэлэг арга барилаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Энэ нь дэлхийн зах зээл дэх тус бараа бүтээгдэхүүний нэр хүндийг дээшлүүлэх үзүүлэлт болдог.

Турк улсад үйлдвэрлэгдсэн арьс ширэн бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээлд чанартай болон боломжийн үнэ өртөг бүхий бараа бүтээгдэхүүн гэдгээрээ танигдсан. Арьс шир боловсруулах ажиллагаа нь онцгой арга барил болон тодорхой дэмжлэг шаардсан үйл ажиллагаа учраас энэ салбарт өрсөлдөж чадахуйц үйлдвэрлэл эрхлэхийн тулд аж ахуйн нэгжүүд нэгдмэл байдлаар,

их хэмжээний хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаагаа явуулах нь чухал. Туркэд 2005 оноос өнөөг хүртэл үйлдвэрлэгчдийн тоо хэмжээ буурсаар байгаа ба томоохон үйлдвэрлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна.

Боловсруулаагүй арьс шир:

Туркэд мах нядалгаа хангалтгүй байгаа, нядалгааны явц дахь арьс ширний чанар үйлдвэрлэлд хэрэглэгдэх шаардлагыг хангахгүй байгаа, бүртгэлгүй нядалгаа хийх болон эдгээр малын арьсыг борлуулалтанд гаргахгүй байгаа зэрэг асуудлууд нь арьс ширний үйлдвэрлэлийг түүхий эдийн хомсдолд оруулах шалтгаан болж байна.

Тус улсын арьс ширний үйлдвэрлэл жил бүр 6,5 сая гаруй бод мал, 60 сая гаруй бог малын арьс ширийг үйлдвэрлэлд ашиглах тооцоотой байдаг. НҮБ-ын дэргэдэх Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан судалгаагаар Энэтхэг болон Хятад улсууд нь малын тоо толгой хамгийн их улсууд юм. 2010-2011 онуудад дэлхийн зах зээл дэхь боловсруулаагүй арьс ширний үнийн өсөлт салбарын хөгжилд сөргөөр нөлөөлсөн. Өнөөдөр арьс ширийг гэрийн тавилга болон автомашины бүрээст их хэмжээгээр хэрэглэж байгаатай холбогдуулан арьс ширний эрэлт өртөг өдрөөс өдөрт нэмэгдэж энэ нь үнэ өртөгт мөн адил нөлөөлж байна. Турк улс бог малын арьс шир үйлдвэрлэлд 2011 онд нийт үйлдвэрлэлийн 7,5%-ийг дангаараа эзэлж Хятад, Энэтхэг, Итали улсын дараа 4-р байранд орсон байна.

Салбарт үзүүлж буй дэмжлэг:

Үйлдвэрлэлд үзүүлж буй дэмжлэг туслалцаа нь улсын эдийн засгийн бодлогын хүрээнд явагддаг ба олон тооны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Гэвч зөвхөн тусгайлсан нэг салбарт зориулсан дэмжлэг байдаггүй үйлдвэрлэлийн бүх салбарт нэгэн адил үйлчлэхээр зохицуулагдсан.

Хөрөнгө оруулалт, дэмжлэг урамшуулал:

Сайд нарын Зөвлөлийн 2012 оны 06-р сарын 19-ний өдрийн 2012/3305 тоот шийдвэрээр төрийн дэмжлэгийн шинэ системийг баталсан. Энэ шийдвэрийн хүрээнд ерөнхий, бүс нутгийн, их хэмжээний болон стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг гэж 4 хуваасан. Энэхүү дэмжлэгийн хүрээнд аж ахуйн нэгжүүд гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлөгдөх, татварын хөнгөлөлт эдлэх, ажил олгогчийн нийгмийн даатгалын хэмжээг бууруулж тооцох, хүүгийн дэмжлэг, орлогын албан татварын суутгалын дэмжлэг, НӨАТ-ын буцаан олголт зэрэг хөнгөлөлтүүдийг эдлэхээр тогтоосон.

Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл ба Технологийн яам Үйлдвэрлэлийн Ерөнхий Газар

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид нь үйлдвэрлэлийн салбар дахь төрөөс үзүүлж буй дэмжлэг туслалцаа болон Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих удирдах газар, Эдийн засгийн яам, Halk банкны зүгээс Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан тусгай дэмжлэг, урамшуулалд хамрагдана.

Үйлдвэрлэлийн хүчин зүйл болон зардал:

Дэлхийн зах зээл дэх бүх салбарын нэгэн адил арьс ширний үйлдвэрлэлийн салбарт ч үнэ өртөг өрсөлдөх чадварыг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг

юм. Азийн орнууд дахь бүтээгдэхүүний суурь зардал дахь давуу байдал нь бусад орнуудын үйлдвэрлэгчдэд хүндрэл учруулж байна. Ялангуяа ажиллах хүчний хямд зардал Турк улсын дэлхийн зах зээл дэх өрсөлдөх чадварыг доройтуулж байна. Үйлдвэрлэлд ашиглагдах боловсруулаагүй арьс ширний дийлэнх хувийг гадаадаас нийлүүлж байгаа нь чанар болон бусад асуудлаар салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн цахилгаан эрчим хүчний хэрэглээний өртөг өндөр байгаа нь мөн адил өрсөлдөх чадварт нь сөргөөр нөлөөлж байна.

Үйлдэрлэлийн чиглэлээр ашигласан усны төлбөрийн хэмжээг бүс нутаг бүрт Усны асуудал хариуцсан Ерөнхий газар тогтоодог ба хэд хэдэн аймаг /ил/-ийг харьцуулан хүснэгтээр харуулав.

2016 оны үйлдвэрлэлийн чиглэлээр ашиглах усны төлбөрийн хэмжээ
/НӨАТ ороогүй/

Аймаг /ил/		Цэвэр ус	Бохир ус	НӨАТ	Нийт
Анкара	Үйлдвэрлэл	8.65	4.33		12.98
	Цэвэршүүлээгүй ус	Үндсэн үнээсээ 20%-ийн хямдралтай			
	Зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүс	Үндсэн үнээсээ 20%-ийн хямдралтай			
Измир	/Зохион байгуулалт бүхий үйлдвэрлэлийн бүсэд/	3.09	2.53	-	5.62
Кожазли	Үйлдвэрлэл	6,46	3,23	0,78	10,47
	Цэвэрлэх байгууламжтай үйлдвэрлэлийн зохион байгуулалт бүхий бүс	7,76	0	0,62	8,38
	Үйлдвэрлэлийн чөлөөт бүс	6,46	3,23	0,26	9,95
	Дахин цэвэршүүлсэн ус	3,02	0	0,24	3,26

“Үйлдвэрлэлийн зохион байгуулалт бүхий бүс”-ийн тухай хуулийн 21-р зүйлд зааснаар цэвэрлэх байгууламжтай үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл эрхлэгчид нь бүс нутгийн захиргаанд төлөх бохир усны төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Арьс боловсруулах үйл явц дахь орц гарцын харьцаа

Орц		Гарц	
Ус	15-50 м³	15-50 м³	
Химийн бодис	~ 500 kg	Боловсруулсан арьс	200-250 кг
Боловсруулаагүй арьс	1 тонн	Хаягдал	~ 450 – 730 kg
Цахилгаан		Агаар	
	9.3 – 42 GJ		~ 40 kg

Бод малын арьс шир боловсруулах явц дахь усны хэрэглээ

Үйлдвэрлэлийн шат дамжлага	1 тонн арьс шир боловсруулахад шаардагдах усны хэмжээ (m³/t)	
	Давсалсан арьс шир	Давслаагүй арьс шир
Боловсруулаагүй арьс-хагас боловсруулсан арьс	10 - 15	13 – 18
Боловсруулсаны дараах үйл явц	6 - 10	6 - 10
Нийт хэрэглээ	16 - 25	19 - 28

Хонины арьс шир боловсруулах явц дахь усны хэрэглээ

Үйлдвэрлэлийн явц	Нэг арьс шир тутамд хэрэглэгдэх усны хэмжээ /литр/
Боловсруулаагүй арьс даршлах	65-80
Хагас боловсруулсан арьс	30-55
Боловсруулсаны дараах үйл явц	15-45
Нийт	110-180

Байгаль орчны тухай хуульд зааснаар цэвэрлэх байгууламж бүхий бүс нутагт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах талаарх үүргээ биелүүлэн ажиллаж буй аж ахуйн нэгжийн тухайн цэвэрлэх байгууламжид хэрэглэсэн цахилгааны төлбөрийн үнийн 50 хүртэлх хувийг холбогдох яамны саналыг үндэслэж Сайд нарын Зөвлөлөөс чөлөөлж болдог.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний тариф тогтоох зөвлөлөөс жил бүрийн цахилгааны хэрэглээний тарифийг тогтоодог. 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх тарифийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

01.01.2016	Хэрэглэгчийн үнэ тариф (kr/kWh)					Хүчин чадлын ялгаваргүй нийт тариф (kr/kWh)			
Хэрэглэгч	жижиглэнгийн нэг хугацаат үнэ	жижиглэнгийн өдрийн үнэ	Жижиглэнгийн өндөрхүчин чадал бүхий үнэ	Жижиглэнгийн шөнийн тариф	Түгээлтийн үнэ	Нэг хугацаат	Өдөр	Өндөр хүчин чадал бүхий	шөнө
Үйлдвэрлэл	20.522	20.389	36.302	8.910	4.964	25.4855	25.3523	41.2658	13.8740
Худалдаа	21.343	21.204	37.754	9.267	8.386	29.7285	29.5899	46.1400	17.6526
Орон сууц	21.343	21.204	37.754	9.267	8.183	29.5261	29.3875	45.9376	17.4502
Хөдөө аж ахуйн усалгаа	19.496	19.369	34.487	8.465	6.878	26.3739	26.2473	41.3651	15.3429
Гэрэлтүүлэг	19.496				8.054	27.5499			

2.5. ВЬЕТНАМ УЛС

20-р зуунд дэлхийн хүн ам мэдэгдэхүйц өслөө. Үүнийг дагаад амьжиргааны түвшин нэмэгдэхийн хэрээр махны хэрэгцээ ихсэж байна. Энэ нь эргээд савхины түүхий эдийн хангамжийг тогтмол хадгалахад хүргэж байна. Дэлхийн хүн ам өсөхийн хэрээр савхины түүхий эдийн хангалт цаашид нэмэгдэх боловч мал адгуус өсгөх болон малын тэжээл тарьж ургуулах газар улам бүр үнэтэй болж, олноц нь хомсдох, түүнчлэн Ази болон Африкт гахай, шувууны хэрэглээ нэмэгдэх хандлага илэрхий мэдэгдэх боллоо. Зарим тохиолдолд эдгээр хөгжлийн чиг хандлага нь уламжлалт бус түүхий эдийн урсгал болох тэмээ болон имж, бугын түүхий эдийн ач холбогдлыг өсгөж байна.

Савхины түүхий эдийн олноц хөгжиж буй улсуудад өсөн нэмэгдэж байгаа бол хөгжингүй улс орнуудад нэг хүнд оногдох улаан махны хэрэглээ буурсантай холбоотой арьс ширний нийлүүлэлт багасаж байна. Одоо савхины түүхий эдийн тэн хагасыг хөгжиж буй орнууд нийлүүлж байгаа бол тэдгээр улс орнууд нь савхиараа эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой болжээ.

Бүх савхины 65% нь үхрийн шир юм. Цаг агаар болон шаардлага хангасан хөдөө аж ахуйн улмаас хамгийн сайн чанарын арьс шир хөгжингүй улсуудаас нийлүүлдэг нь бодит баримт билээ. Түүхий эдийн гарал үүсэл шилжих болсноор гадаргуу нь гэмтсэн буюу бусад төрлийн бүтцийн гологдолтой ширийг ашиглах боллоо. Энэхүү хандлага цаашид үргэлжлэх шинжтэй. Энэ нь зарим төрлийн гэмтлийг эцсийн боловсруулах арга техник хөгжих, мөн хэрэглэгчид зарим гэмтлийг байгалийн юм гэж ятгаж үнэмшүүлэхэд хүргэж байна. Автомашины доторлогоонд маш сайн чанарын шир хэрэглэдэг учир энэ чиглэлийн шевроны үйлдвэрүүд хөгжингүй орнуудад ажиллаж байна.

Дэлхийн савхины нийлүүлтийн 10 гаруй хувийг гахайн арьс эзэлж байна. Хятад улс гахайн арьс болон гахайн арьсан савхины хамгийн том нийлүүлэгч юм. Гэвч гахайн арьсны бүтэц болон өөх тосноос шалтгаалан уг арьсыг боловсруулахад ихээхэн хүндрэл тулгардаг учир энэхүү түүхий эд нь ирээдүйд тус аж үйлдвэрт чухал юм. Түүнээс гадна, гахайн арьс нь бусад арьстай харьцуулбал хоолны салбартай хамгийн ойр холбоотой байдаг онцлогтой. Иймээс соёлын буюу өртгийн шалтгаанаар гахайн арьсыг каркас (гол их бие), царцмаг хийхэд ашигладаг. Түүхээс үзэхэд, шевроны аж үйлдвэр²⁷ нь гэр бүлийн жижиг дунд үйлдвэр байдаг. Тиймээс савхины үйлдвэрүүд ажиллах хүч хямд газар луу шилжих, улмаар шевроны үйлдвэрүүд нь дагах хандлагатай. Савхины аж үйлдвэр²⁸ хурдацтай өсөн нэмэгдэж байгаа улс орнууд, тухайлбал Өмнөд Солонгос, Тайвань, Хятад, Индонез, Вьетнам нь ихэвчлэн түүхий эдийн хомсдолтой учир арьс ширийг их хэмжээгээр импортолдог байна. Өсөн нэмэгдэж буй савхины эрэлтийг хангахын тулд дээрх орнуудад шинээр олон шевроны үйлдвэрүүд нээгдэж байгаа бол европ болон Япон, АНУ-д шевроны үйлдвэрүүд хаагдаж байна.

Итали, Испани зэрэг хөгжингүй улсуудад үлдсэн цөөхөн шевроны үйлдвэрүүд нь ухаалаг бизнесийн загвар нэвтрүүлсэн байна. Тэдгээрийн зарим нь өгөөжтэй олон улсын эвсэл холбоонд нэгдсэн бол бусад нь “бютик нэгж”²⁹ хэмээх нэртэй маш дээд зэрэглэлийн загвар болон чанар бүхий гоёлын салон болжээ.

Энэтхэг, Бразил зэрэг сайн чанарын түүхий эд нийлүүлдэг орнууд нь аж үйлдвэрүүдээ эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл бүх шатанд амжилттай хөгжүүлж байна. Савхины аж үйлдвэрийн чадавх болон ажлын байрны хангамжийг өндөр түвшинд гаргасан, нөөц сайтай Эфиоп, Пакистан зэрэг орнууд энэхүү бүлэгт нэгдэх хандлага ажиглагдаж байна. Савхины аж үйлдвэрийн бүхий л салбарт Хятад улс сүүлийн үед хамгийн хүчтэй тоглогч болоод байна. Тэрээр үйлдвэрлэлийн бүх секторт бусдаас мэдэгдэхүйц зайтай тасарсан байдалтай давамгайлж байна. Хятад нь сүүлдээ байгаль орчны хамгааллыг хангахгүй үйлдвэр ихээр байгуулсанаа хүлээн зөвшөөрсөн бөгөөд одоо түүнийгээ засаж байгаа. Мөн гутлын үйлдвэрлэлээ багасгасан бөгөөд илүү өндөр нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүнээр ижил өсөлт гаргахаар чармайж байна.

²⁷ англиар tanning industry

²⁸ англиар leather industry

²⁹ англиар "boutique units"

Table 55: Production of raw hides and skins in countries applying export taxes or restrictions

Unit: thousand tons

	1996	2006
Argentina	262.5	249.5
Bangladesh	43.4	46.3
Byelorussia	30.5	16.7
Brazil	505.9	736.3
China	485.4	937.3
Ethiopia	36.2	36.4
India	474.2	504.7
Indonesia	37.2	37.7
Kenya	29.1	32.1
Morocco	13.2	15.5
Nepal	21.5	26.4
Nigeria	40.4	40.4
Pakistan	75.9	110.1
Paraguay	27.6	29.8
Russia	335.0	243.2
Thailand	47.6	43.2
Tunisia	6.0	6.6
Ukraine	153.0	105.5
Uruguay	46.9	43.6
% of world total restricted	34.6	48.9
World total	6,180.0	6,668.0

Source: COTANCE elaboration on FAO data.

Notes: Data refer to the sum of salted cattle/calf hides and sheep/goat skins. In 1996, there were no export restrictions in Byelorussia, Morocco, Russia and Ukraine.

Энэ нь Хятад зах зээл дэх давамгайл байдлаа алдана гэсэн үг биш. Харин ч Хятадын аж үйлдвэр үргэлжлэн өсөх бөгөөд харин хурд нь саарч, арга зам нь өөрчлөгдөж байгаа юм. Түүнээс гадна, Хятадад ажиллах хүчний зардал нэмэгдэж буй тул Вьетнам болон Индонез, Бангладеш, Энэтхэг зэрэг улсуудад шинээр үйлдвэрээ нээх болсон. Хятадтай савхины аж үйлдвэрийн салбарт өрсөлдөх, түүний давамгайл байдлыг сулруулах хэмжээний буюу чадавхтай улс дэлхий дээр байхгүй бөгөөд энэхүү шилжилт нь харин ч хөгжиж буй тухайн орнуудад түлхэц өгч байна.

Түүхээс үзэхэд, савхины ойролцоогоор 65%-иар гутал хийдэг. Гэвч энэ хувь хэмжээ сүүлийн үед 55% болж буурсан байна. 2008 онд түүхэндээ анх удаа гутлын үйлдвэрлэлд эзлэх савхины хувь хэмжээ 50%-

иас бага болсон. Харин доторлогоо болон бусад савхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн. Автомашины доторлогооны савхины үйлдвэрлэл 1990 оноос хойш онцгой хүчтэй байна.

Дээрх 55 дугаар хүснэгтээр экспортын татвар бүхий орнуудын түүхий арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг харуулав. Хэмжих нэгж: мянган тонн.

Удаах 56 дугаар хүснэгтээр улс орнуудын импортын татварын хувь хэмжээг 2006 оны байдлаар харуулав. Бүтээгдэхүүнүүд: Түүхий арьс шир (Raw hides), Нойтон арьс (Wet blue), Хальс (Crust), Савхи (Finished leather), Гутал (Footwear). Гаалийн болон элдэв татвар хураамж байнга өөрчлөгдөж байдаг. Дээрх хүснэгтэд үзүүлсэн импортын татварт химийн бодис болон тоног төхөөрөмжийн импортын гаалийн татварыг оруулаагүй болно.

2008 оны байдлаар, Хятад улсад савхины химийн бодис 6.5%, машин тоног төхөөрөмж 8%, гутлын туслах материал болон бэлэн хувцасны импортын татвар тус тус 15% байна. Харин Пакистаны хувьд савхины химийн бодисын импортын татвар дунджаар 12%, машин (5%), туслах материал (20%) тус тус байна.

Table 56: Import duties (%) in January 2006

	Raw hides	Wet blue	Crust	Finished leather	Footwear
Algeria	5.00	15.00	15.00	15.00	30.00
Argentina	2.50	8.50	10.50	10.50	20.50
Australia	0.00	2.50	5.00	5.00	10.00
Bangladesh	0.00	0.00	0.00	0.00	25.00
Brazil	2.00	7.40	9.50	9.33	20.00
Chile	6.00	6.00	6.00	6.00	6.00
China	5.00-14.00	5.00-14.00	n/a	8.00-14.00	10.00-24.00
Egypt	2.00	7.00	12.00	12.00	32.00
EU	0.00	1.38	5.00	6.50	8.00
India	0.00	15.00	15.00	15.00	15.00
Japan	8.40	14.00	19.26	18.80	28.50
Kenya	10.00	10.00	10.00	10.00	25.00
Republic of Korea	2.25	5.00	5.00	5.00	13.00
Mexico	6.00	7.50	10.00	10.00	35.00
New Zealand	0.00	0.00	2.33	3.50	0.00
Nigeria	5.00	10.00	10.00	10.00	15.00
Pakistan	5.00	5.00	5.00	5.00	25.00
Paraguay	2.00	8.00	9.50	9.33	20.00
Russia	5.00	5.00	5.00	5.00	0.00
South Africa	5.00	5.00	5.00	10.00	30.00
Taiwan	0.00	0.00	1.00	1.00	5.00
Tanzania	10.00	10.00	10.00	10.00	25.00
Thailand	0.00	5.00	5.00	5.00	40.00
Turkey	0.00	1.38	4.50	6.50	8.00
USA	2.34	2.62	2.62	2.96	0.00-5.00
Uruguay	2.00	8.00	9.14	9.14	20.00
Viet Nam	0.00	3.00	5.00	10.00	50.00
Zimbabwe	5.00	15.00	15.00	15.00	0.00

Source: Koppamy, 2007 (based on FAO and national trade association data).

58 дугаар хүснэгтээр Экспортын татварын хувь хэмжээг 2007 оны байдлаар үзүүлэв. Бүтээгдэхүүн: Арьс шир (Hides), Нойтон арьс (Wet blue), Савхин хальс (Leather crust), Савхи (Finished leather), Бэлэн бүтээгдэхүүн-Савхин гутал (Manufactured products-Leather shoes). Тухайн таваарын экспортын татвар болон экспортын хориг хэт өссөнөөс шалтгаалан дэлхийн нөөцийн зөвхөн 40% нь л чөлөөт зах зээлд гарч байна.

Table 58: Export taxes (%) in January 2007

	Hides	Wet blue	Leather crust	Finished leather	Manufactured products (leather shoes)
Argentina	15*	15*	5	5	5
Brazil	9	9	0	0	0
India	60	60	60	0	0
Kenya	15	0	0	0	0
Pakistan	20	20	0	0	0
Paraguay	12	0	0	0	0
Russia	15	10	10	0	0
Tanzania	20	0	0	0	0
Uganda	20	0	0	0	0
Uruguay	8	8	0	0	0

Source: Koppamy, 2007.

хамааран хавтгай дөрвөлжин фут³⁰ тутамд 3-4 центээс 20 цент хүртэл хэмжээтэй байна.

³⁰ 1 фут=30.48 см

Ихэнх улс орон байгаль орчны эрхзүйн орчинтой боловч дэлхий даяар авч үзвэл, хэрэгжүүлэлт нь харилцан адилгүй бөгөөд байгаль орчны зардлын хэмжээ улс улсад өөр байна. Шевроны үйлдвэрийн байгаль орчны зардал нь зөвхөн байршлаас

Вьетнамын савхины аж үйлдвэр эрчимтэй өсөж байгаа бөгөөд жилийн өсөлтийн хэмжээ нь 12-15% байна. Гаалийн татварын улмаас Европын холбоо дахь нөлөө нь багассан боловч АНУ руу гаргах экспорт нь эрс нэмэгдсэн.³¹ Вьетнамын Засгийн газар савхины аж үйлдвэрийн салбарт ойрын 3 жилд 572 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийх бөгөөд шевроны үйлдвэрлэлд 37.8 сая ам. доллар оруулж байна. Сүүлийн 10-аад жилийн туршид Вьетнамын гол бүтээгдэхүүн нь бээлий болон гутал байна.

Вьетнамын Засгийн газар нь TPP (Номхон Далайг Дамнасан Нөхөрлөл) болон EU FTA (Европын Холбооны Чөлөөт Худалдааны Хэлэлцээр) байгууллагуудтай 2014 онд хэлэлцээр хийсний үр дүнд гадуур хувцас болон шингэн бүтээгдэхүүн, гутлын үйлдвэрлэлийн салбарт тодорхой хөнгөлөлт эдлэхээр болжээ³². TPP нь Вьетнамын арьс ширний аж үйлдвэрийн салбарт том зах зээл рүүгээ оруулах боломж олгохын сацуу гаалийн татварыг 14.3%-иас 0% хүртэл бууруулж өөрийн зах зээл дэх Вьетнамын савхины аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүллээ.

Түүнээс гадна Вьетнамын савхи болон гутлын аж үйлдвэр нь ЕХ-ны Чөлөөт худалдааны гэрээ батлагдмагц буюу 2014 оны эхнээс GSP хөтөлбөрийн давуу талыг ашиглах боломжтой боллоо. Гэвч дээрх хэлэлцээрүүдээс ашиг тус хүртэхийн тулд тодорхой дотоод нөхцөл шаардлагыг хангах учиртай. Мөн тухайн салбарт дэмжлэг үзүүлэх дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай. Савхины болон гутлын аж үйлдвэрийн хувьд чанар бол хамгийн гол асуудал юм.

2006 онтой харьцуулахад, тухайн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3 дахин өссөн хэдий ч экспортод гаргаж буй бүтээгдэхүүний савхины хэрэгцээний 40%-ийг л дөнгөж дотоодын бүтээгдэхүүнээр хангаж байна. Арьс ширний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд нэн түрүүнд материалын боловсруулалт болон бохир усны асуудалд анхаарах шаардлагатай.

Вьетнамын Аж үйлдвэрийн Орчны Холбооны мэдэгдсэнээр, хэрэгцээнийхээ 40%-ийг дотоодоос хангаж, гадны эх үүсвэрээс савхи оруулж ирэх нь бага, зарим тохиолдолд бүр тэг нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн хийж экспортолж байгаагийн шалтгааныг материал түүхий эдийн хомсдол гэж үзжээ. Сарлаг, үхрийн фермүүд муу хөгжсөн байна. Ихэнх нийлүүлж буй үнээний арьс чанарын шаардлага хангахгүй гологдож байна. Арьс ширний үйлдвэрийг газар тариалангийн хөгжилтэй уялдуулан хамтаар нь хөгжүүлэх шаардлагатай.

Арьс шир үйлдвэрлэгчийн хэлсэнээр, арьс шир боловсруулах үйлдвэрийн толгойны өвчин бол бохир усны асуудал мөн. Бохир ус цэвэршүүлэх байгууламж нь шинэ үйлдвэр барихаас ч өндөр өртөгтэй юм. Энэ нь үйлдвэрүүдэд тэр тусмаа хувийн секторынхонд маш их хүндрэл бэрхшээл учруулж байна. Матар болон тэмээн хяруулын арьс эдэлгээ сайтай боловч хангалт муутай байна. Цаашилбал, дотоодын химийн бүтээгдэхүүний

³¹ Савхи болон савхин бүтээгдэхүүний аж үйлдвэрийн ирээдүйн дэлхийн чиг хандлага, ЮНИДО 2010-Future Trends in the World Leather and Leather Products Industry and Trade, UNITED NATIONS INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION Vienna, 2010 http://leatherpanel.org/sites/default/files/publications-attachments/future_trends_in_the_world_leather_and_leather_products_industry_and_trade.pdf

³² Олон улсын эдийн засгийн интеграцитай уялдсан Вьетнамын арьс ширний аж үйлдвэрийн хөгжил, Вьетнамын Аж үйлдвэр, Худалдааны Яам-Vietnamese tannery industry's development in context of international economic integration, MOIT (Ministry of Industry and Trade) Vietnam <http://www.moit.gov.vn/en/News/514/vietnamese-tannery-industry%E2%80%99s-development-in-context-of-international-economic-integration.aspx>

хангалт муу байгаагаас гаднаас импортлоход хүрч мөн салбарын өрсөлдөх чадварыг бууруулж байна.

2013 оны байдлаар, Вьетнамын гутлын экспорт 8.3 тэрбум ам. доллар (ийм бүтээгдэхүүний 50%-иас илүү нь арьс ширэн савхи ашигласан) бол гар цүнхний экспорт 1.7 тэрбум ам. доллар (арьс ширэн савхины оролт 40-50%) юм. Вьетнамын хамгийн том импортын түншүүд нь ЕХ болон АНУ, Япон, Хятад, Бразил улс юм. 2012 оны байдлаар, дээрх 5 улсууд руу нийтдээ 5.77 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн экспортолжээ.

Вьетнамын савхи шевроны үйлдвэрлэл одоогоор хурдацтай өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь байгаль орчны бохирдлын асуудлыг ихээр дагуулж байна.³³ Шевроны үйлдвэрүүд нь бохир ус болон агаарын чанарын стандартуудын шаардлагыг хэрхэн хангаж байгааг шалгаж, байгаль орчны зохицуулалтад нийцсэн буюу нийцээгүй үйлдвэрүүдийн зардлыг харьцуулж үзлээ. Энэхүү зардалд нь байгаль орчны зохицуулалтад нийцсэн шевроны үйлдвэрийн EIA³⁴ тайлан болон WWTS³⁵ суурилуулах үнэ, бохир усны татварын төлбөр багтсан.

Судалгаанаас үзэхэд, EIA тайлан бэлтгэхэд VND³⁶ 150-250 сая зардал гарах бол EM тайлан бэлтгэхэд ойролцоогоор VND 20 сая өртөг гардаг байна. Энгийн цистерн сав VND 20-30 сая үнэтэй бол орчин үеийн WWTS VND1,500-5,000 сая байна. Аж үйлдвэрийн парк буюу аж үйлдвэрийн бүсэд байрлах шевроны үйлдвэрийн сар тутам төлдөг бохир усны татвар хураамж дунджаар VND 26.4 сая бол эдгээр бүсийн гаднах үйлдвэрийнх VND 0.3 сая байна.

Байгаль орчинд халтай үйлдвэрийн хувьд олон нийтэд мэдээлэх, мэдэгдэхүйц мөнгөн хохирол хүлээх болон торгууль, бизнесийн үйл ажиллагааг хаах зэрэг хариуцлага хүлээнэ. Байгаль орчинд халтай үйлдвэр нь EIA тайлан гаргах зардлаас даруй VND 200-300 сая илүү зардалтайгаар уг тайланг мэдүүлдэг. Энэ нь шевроны үйлдвэрүүдэд уг тайланг гаргаж өгөхөд урамшуулал болох магадлалтай. Харин бохир усны татвар хураамж төлөхгүйгээр WWTS суурилуулаагүй бол зардал VND 130-170 сая хооронд хэлбэлзэж байна. WWTS суурилуулж байгаль орчинд нийцтэй байх болон бохир усны татвар төлөх зардал нь үл нийцсэн үйлдвэртэй харьцуулахад өндөр байна.

Эндээс дүгнэхэд, байгаль орчны зохицуулалтын системийг удирдах зохион байгуулалтын арга хэмжээ авах нь сайн үр дүнгүй нь харагдаж, Вьетнамын хувьд асуудал болоод байна. Орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэнээр зарим компаниуд³⁷ усны хэрэглээг 50%, химийн бодисыг 15% тус тус бууруулж чадсан байна. Ам дөрвөлжин метр савхи үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчний хэрэглээ тухайн аж үйлдвэрийн бусад дундаж үйлдвэртэй харьцуулахад даруй 50% буурсан байна. Ингэснээр жилд 2,700 тн нүүрс хүчлийн хий (CO₂) бууруулах юм.

³³ Савхи шевроны аж үйлдвэрийг ногооруулах нь: Вьетнам дахь судалгаа, Дугаар 2011.PB8-Greening the Leather Tanning Industry: A study from Vietnam, EEPSEA (Economy and Environment Program for Southeast Asia) POLICY BRIEF • No. 2011-PB8 <https://idl-bnc.idrc.ca/dspace/bitstream/10625/48829/1/IDL-48829.pdf>

³⁴ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан-Environmental Impact Assessment Report

³⁵ Бохир ус цэвэршүүлэх систем-Waste Water Treatment Systems

³⁶ Vietnamese Dong=0.000045 US Dollar

³⁷ Saigon TanTec Ltd.: DEG (Германы Хөрөнгө оруулалт болон Хөгжлийн Нийгэмлэг)-ийн төсөл 2010 онд хэрэгжүүлсэн.

ХАВСРАЛТ 1

ОХУ-ыг Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэнтэй холбоотойгоор хөнгөн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ /Оросын арьс шир үйлдвэрлэгчдийн холбооноос гаргасан зөвлөмж/

Арга хэмжээний нэр	Мөрдөх хугацаа	Хүлээгдэж буй үр дүн	Шаардагдах эрх зүйн орчин	Арга хэмжээний эдийн засгийн үндэслэл
I. Арьс шир болон гутлын салбарыг дэмжих арга хэмжээ				
1. Гааль-тарифын бодлого				
1.1. Үйлчилж буй түүхий арьс шир (код ТН ВЭД 4101, 4102, 4103)-ний экспортын татвар /1 тонн тутам 500 евро/ хэвээр үлдээх	ДХБ-ын гэрээг баталсны дараа, байнга	а) Арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг 2200 сая кв. дм-т байлгах б) Жижиг болон "моно" / нэг үйлдвэрлэл түшиглэсэн/ хотуудад ажлын байр хадгалах (100 мянгах ажилчин -жижиг аж үлдвэр) в) Түвшин бүрийн төсөвт жилд татвараас олох орлогыг 3 тэрбум рубль байлгах	Засгийн газрын 2006.12.23-ны 795 дугаар тогтоолыг хүчинтэй байлгах.	1) ОХУ нь 2001 онд арьс шир, гутлын үйлдвэрлэлийн түүхий эдийн экспортын татварыг 1 тонн тутам 500 еврогоор тогтоосон нь тус салбарын хөгжилд эергээр нөлөөлсөн. 2010 он хүртэл үйлдвэрлэлийн жилийн өсөлт 15% байсан. 2011 онд бүрэн боловсруулсан арьс ширний экспорт 30% хүрсэн. Түүхий эдийн хомсдлоос үйлдвэрлэлийн ачаалал дөнгөж 63%-тай байна. 2) ДХБ-ын шаардлагын дагуу экспортын хураамжийг 2.5 дахин бууруулах нь түүхий эдийн экспортыг үлэмж нэмэгдүүлэх бөгөөд түүхий арьс ширний экспорт 90 дахин нэмэгдэх бол, үйлдвэрлэлийн хэмжээ 3.7-4 дахин буурах төлөвтэй байна. Ингэснээр тус салбараас орох төсвийн орлого 14 дахин буурна гэж тооцоолсон байна.
1.2. Хагас боловсруулсан арьс ширний экспортын татварыг 10% хүртэл нэмэгдүүлэх, ингэхдээ 1 тонн тутам 450 еврогоос доошгүй байх	Байнга	а) Хагас боловсруулсан арьс ширийг гүйцэд боловсруулах замаар бүрэн боловсруулсан арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг 500 сая кв.дм болтол нэмэгдүүлэх. б) Ажлын байрны тоог 5 мянгаар нэмэгдүүлэх. в) Бүрэн боловсруулсан арьс ширний экспортыг 2 дахин (600 сая кв. дм-с 1,15 тэрбум кв. дм) нэмэгдүүлэх. г) Төсвийн орлогыг 520 сая рубльээр нэмэгдүүлэх.	"Хагас боловсруулсан арьс шир (код ТН ВЭД 4104 11, 4104 19) -ний экспортын татварын хэмжээг 10% хүртэл хувиар /1 тонн тутам 450 еврогоос доошгүй байх/ нэмэгдүүлэх" тухай Засгийн газрын тогтоолыг батлах.	Жил бүр түүхий эдийн гуравны нэг хүртэлх (30 мянга хүртэлх тонн) хувийг экспортлж байгаа нь дотоодын үйлдвэрлэлүүдийг бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжийг бууруулахаас гадна дотоод дахь түүхий болон хагас боловсруулсан арьс ширний үнийг өсгөнө. Их хэмжээний экспорт нь 5 мянга гаруй ажлын байрыг цомохтоход хүргэж болзошгүй байна. /Тооцоолсны дагуу түүхий эдийг хагас боловсруулсан бүтээгдэхүүн болгоход 1 ажилчин, бүрэн боловсруулахад 6 ажилчин шаардлагатай./ Хагас боловсруулсан арьс ширний үйлдвэрлэл нь нэмүү өртөг бага шингэсэн, техник технологийн шинэтгэл явуулах хөрөнгө мөнгөгүй, бохирдлын асуудал шийдвэрлэх боломж муутай зэргээс үүдэн ОХУ-ыг "бохир технологийн"-ийн улс болж байна.

ХАВСРАЛТ 2

ОХУ-ын арьс ширний үйлдвэрлэлийн эрх зүйн орчин

№	Эрх зүйн зохицуулалтын нэр, дугаар, огноо
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 108, 2016.02.17 (Төрийн байгууллагуудын хэрэгцээний захиалга) /Постановление Правительства РФ от 17.02.2016 № 108 (Госзаказ).pdf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 1285, 2015.11.28 (Хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортод түр хориг тавих тухай) /Постановление Правительства РФ от 28_11_2015 N 1285 (Временный запрет на вывоз полуфабриката).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 162-ФЗ, 2015.06.29 (Стандарт тогтоох тухай) /Федеральный закон от 29.06.2015 № 162-ФЗ (О стандартизации).docx/
	Эдийн засгийн хөгжлийн сайдын тушаал № 385, 2015.06.22 (Материаллаг бус хөрөнгийн үнэлгээ) /Приказ Минэкономразвития от 22.06.2015 № 385 (оценка нематериальных активов).docx/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 378, 2015.04.21 (Хагас боловсруулсан арьс ширний экспортод түр хориг тавих) /Постановление Правительства РФ от 21.04.2015 № 378 (временный запрет на экспорт кожевенного полуфабриката).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 214, 2015.03.12 (Дэмжлэг) /Постановление Правительства РФ от 12.03.2015 № 214 (субсидии).pdf/
	ОХУ-ын Засгийн газрын захирамж №15-р, 2015.01.13 (ДЯЯ) /Распоряжение Правительства РФ от 13.01.2015 № 15-р (МВД).pdf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 1212, 2014.11.15 (Хүүхдийн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх) /Постановление Правительства РФ от 15.11.2014 N 1212 (субсидии ИДТ инвестпроекты).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 1179, 2014.11.08 (Хүүхдийн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх, аж үйлдвэрийн парк) /Постановление Правительства РФ от 08.11.2014 N 1179 (субсидии ИДТ индустриальные парки).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын захирамж №1162, 2014.11.04 (Хүүхдийн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх) /Постановление Правительства РФ от 04.11.2014 N 1162 (субсидии ИДТ НИОКР).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 826, 2014.08.19 (Хагас боловсруулсан арьс ширний экспортод түр хориг тавих) /Постановление Правительства РФ от 19.08.2014 № 826 (временный запрет на экспорт кожевенного полуфабриката).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 791, 2014.08.11 (Төрийн байгууллагуудын хэрэгцээнд импортын бараа бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байх) /Постановление Правительства РФ от 11.08.2014 № 791 (запрет на допуск иностранных товаров для нужд госзаказа).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 180, 2014.03.07 (Хөнгөн үйлдвэрлэлийн хураан авсан бараа, бүтээгдэхүүний жагсаалт) /Постановление Правительства РФ от 07.03.2014 № 180 (перечень изъятых и конфискованных товаров легкой промышленности).rtf/
	ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 73, 2014.02.03 (Экспортын хориг тавьж болзошгүй бараа бүтээгдэхүүний жагсаалт) /Постановление Правительства РФ от 03.02.2014 № 73 (перечень товаров, в отношении которых может быть введен запрет на экспорт).rtf/

ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 4, 2014.01.03 (Дэмжлэг) /Постановление Правительства РФ от 03.01.2014 № 4 (субсидии).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 1292, 2013.12.26 (Цорын ганц нийлүүлэгч) /Постановление Правительства РФ от 26.12.2013 № 1292 (единственный поставщик).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 317, 2013.04.10 (Бохирдуулагч бодисын хэрэглээг бууруулах төлөвлөгөө) /Постановление Правительства РФ от 10.04.2013 № 317 (план снижения сбросов загрязняющих веществ).rtf/
Холбооны хууль №275-ФЗ, 2012.12.29 (Батлан хамгаалах салбарын хэрэгцээт бараа, бүтээгдэхүүний захиалга) /Федеральный закон от 29.12.2012 № 275-ФЗ (о государственном оборонном заказе).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 843, 2013.04.10 (Батлан хамгаалах үйлдвэрлэлийн бүртгэл) /Постановление Правительства РФ от 21.08.2012 № 843 (реестр оборонно-промышленного комплекса).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 372, 2009.04.30 (НӨАТ-аас чөлөөлсөн импортын тоног төхөөрөмжийн жагсаалт) /Постановление Правительства РФ от 30.04.2009 № 372 (перечень импортируемого оборудования, не облагаемого НДС).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 614, 2008.08.18 (Химийн бодис, материалын хураамж) /Постановление Правительства РФ от 18.08.2008 № 614 (пошлины на химические материалы).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 66, 2007.02.03 (Бараа бүтээгдэхүүний дахин экспорт) /Постановление Правительства РФ от 03.02.2007 № 66 (реэкспорт товаров).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 24, 2007.01.18 (Түүхий арьс ширний экспортын татвар) /Постановление Правительства РФ от 18.01.2007 № 24 (пошлины на экспорт сырых шкур).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 718, 2006.11.27 (Импортын тоног төхөөрөмжийн татвар) /Постановление Правительства РФ от 27.11.2006 № 718 (пошлины на импортное оборудование).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 618, 2006.03.24 (Импортын тоног төхөөрөмжийн татвар) /Постановление Правительства РФ от 24.03.2006 № 168 (пошлины на импортное оборудование).rtf/
ОХУ-ын Засгийн газрын тогтоол № 596, 2005.10.05 (Импортын тоног төхөөрөмжийн татвар) /Постановление Правительства РФ от 05.10.2005 № 596 (пошлины на импортное оборудование).rtf/

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

БНХАУ

- <http://en.chinaleather.org/>
- http://www.tdap.gov.pk/doc_reports/TDAP%20REPORT%20ON%20LEATHER%20MARKET%20IN%20CHINA.pdf
- http://www.worldleathercongress2015.com/documents/13/china_tanning_footwear_industry_clia@wlc2015milan.pdf
- http://www.dsir.gov.in/reports/isr1/Leather%20and%20Footwear/3_6.pdf
- <http://chinawaterrisk.org/resources/analysis-reviews/leather-time-for-business-unusual/>

ОХУ

- <http://www.souzkogevnikov.ru/zakonodatelstvo/>
- <http://www.kommersant.ru/doc/2866808>
- <http://utmagazine.ru/posts/10564-ekonomika-rossii-cifry-i-fakty-chast-11-legkaya-promyshlennost>
- <http://www.kptf.ru/images/company/Presentation.pdf>

БНЭУ

- Indian Leather & Tanning Industry. Profile 2010
- 2. Emerging trends: indian leather industry. indian leather industry poised to grow manifolds- <http://www.onicra.com/images/pdf/Publications/Leather-industry-report-Transparent.pdf>
- Report of Working Group on Leather & Leather Products Twelfth Five Year Plan Period (2012-17) Indian Leather Development Programme http://dipp.nic.in/English/Schemes/Dept_Leather.aspx

БНТУ

- *Organize sanayi bulgeleri kanunu* - www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.4562.doc
- 3evre kanunu - https://www.csb.gov.tr/dosyalar/images/file/osb_recep%20akdeniz.pdf
- 3. Enerji Piyasası Duzenleme Kurul Kararı - <http://www.resmigazete.gov.tr/eskiler/2015/12/20151231M4-40.pdf>
- Yatırımlarda devlet yardımları hakkında karar - <http://www.resmigazete.gov.tr/eskiler/2012/06/20120619-1.htm>
- Deri ve deri mamulleri sanayi - © Türkiye Cumhuriyeti - ekonomi bakanlığı, 2016 : https://www.ekonomi.gov.tr/portal/content/conn/UCM/uuid/dDocName:EK-051197;jsessionid=b0My_nzEijhBIMTUeh-xnUoltuHwljiaRXSzaPABgzRYEWYh2a2_!1837375366
- Deri ve Deri Bırnleri İmalatı Sanayi Sektur Raporu, (2015)
- http://www.iso.org.tr/sites/1/upload/files/ISO_Deri_ve_Deri_Urunleri_Imalati_Sanayi_Sektor_Raporuv2_2015-3982.pdf
- Ham deri tabaklama izin MET sonuqları belgesi – www.csb.gov.tr/db/ippc/izerikbelge/izerikbelge1370.docx
- http://www.aski.gov.tr/Yukle/dosya/tarife_ucret/Tarife.pdf
- <http://www.izsu.gov.tr/Pages/standartPage.aspx?id=65>
- <https://isu.gov.tr/sufiyatlari/>

ГАЗАР ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ГАЗАРТАЙ ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

*Г.Алтан-Оч (PhD), Ц.Болормаа,
Ч.Онончимэг, Д.Халиун*

Судалгааны хураангуй

Судалгаанд ОХУ, ХБНГУ, Финланд, Эстони зэрэг улс орны амины орон сууц өмчлөгчдийн холбоо, өмчлөх эрхээ эдлэхтэй холбоотойгоор үүсэн гарах харилцааг зохицуулах үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн эрх зүйн статус, дундын өмчлөлийн болон нийтийн эзэмшлийн газартай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулдаг эрх зүйн зохицуулалт зэргийг харьцуулан судалсан болно.

Захиалагч газар өмчлөлийн асуудалтай холбогдуулан газар өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдлын тухай судлах хүсэлт ирүүлсний дагуу гадаадын орнуудын газар, хувийн сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн зохицуулалтыг адилтган авч үзлээ. Ийнхүү судлахад:

- ОХУ-д үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөлтэй холбоотой харилцааг 1994 оны “Иргэний хууль” болон 1998 оны “Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай” хуулиар зохицуулах бөгөөд 2014 онд Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар тус хуулийн хамрах хүрээг өргөжүүлсэн байна. Нөхөрлөл нь ашгийн бус статустай байх бөгөөд үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн (Үүнд: барилга байшин дахь талбай эзэмшигч, үүнд нийтийн болон амины орон сууцны байшин, зуслангийн байшин, цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалт бүхий газар) дундын өмчийг хуульд заасны дагуу ашиглах зорилго бүхий сайн дурын нэгдэл байна.

Иргэний хуульд үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн эрх зүйн статусыг ерөнхий байдлаар зохицуулсан бөгөөд удирдлага, зохион байгуулалт, эрх үүрэг, үйл ажиллагаа зэргийг 1998 оны №66 “Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай хууль”³⁸-иар нарийвчлан зохицуулсан байна.

- ХБНГУ-ын хувьд Газар өмчлөгчдийн холбоод нь газар өмчлөгчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага юм. Ингэхдээ газар өмчлөгчдийг халамжлах үүрэгтэй бөгөөд тэднийг эрх зүйн орчин болон шүүхийн (загвар болохуйц шүүн таслах ажиллагааны хэлбэрээр) хөгжил, мөн засаг захиргаа болон татварын чиглэлийн журмуудын талаарх мэдээллээр хангаж байдаг. Түүнчлэн мэргэжлийн сургалт явуулах, эрх зүй болон санхүү, төрийн захиргааны байгууллагатай харьцах зэрэгт бодит зөвлөгөө өгч ажилладаг. Гишүүнчлэлийн татвар нь үл хөдлөх хөрөнгийн төрлөөс хамааран жилд 40-150 евро байдаг. ХБНГУ-ын “Байшин ба Газар” ТББ (төрийн бус байгууллага) нь Германы Байшин болон Орон сууц, Газар өмчлөгчдийн төв холбоо бөгөөд Германы хамгийн том ашиг сонирхлын нэгдэл юм³⁹.

³⁸ Закон от 1998 о садоводческих, огороднических и дачных некоммерческих объединениях граждан РФ

³⁹ Байшин ба газар-Haus & Grund https://de.wikipedia.org/wiki/Haus_%26_Grund

Газар өмчлөгч нь бүрэн бүтэн байдал буюу замын аюулгүй байдлын үүргээ биелүүлээгүйн улмаас имобиль буюу эдлэн газарт учирсан хохиролд хязгааргүй хэмжээгээр хариуцлага хүлээдэг. Энэхүү үүрэгт нь жишээлбэл, навч нахиа буюу цасыг цэвэрлэж явган хүний замын аюулгүй байдлыг хангах явдал багтдаг. Газар эзэмшигчийн болон Хариуцлагын, Өрхийн, Ослын, Орон сууцны даатгалыг ашиглан газар эзэмшигч нь үл хөдлөх хөрөнгөд учирсан хор уршиг буюу эзэмшил газрын дээрх ослын зардлыг барагдуулах боломжтой.

- Финланд Улсын хувьд амины орон сууц болон газар өмчлөгчдийн аливаа холбоо нь ашгийн бус байх бөгөөд аутсорсингоор орон сууцны компаниудтай гэрээ байгуулан ажиллуулах бөгөөд энэ төрлийн харилцааг Орон сууцны компанийн тухай хуулиар зохицуулсан байна.

Газар өмчлөгчдийн хувьд Газар ашиглалтын болон Барилгын тухай хуульд зааснаар хуульд дундын өмчлөлийн буюу нийтийн эзэмшлийн газрын хувьд газар өмчлөгчийн хүлээх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Газар өмчлөгч буюу газрын эзэн нь тухайн орон нутгийн нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гудамж болон гудамжны бүсийн хэрэгцээнд өөрийн өмчийн газраас тодорхой хэмжээний газар чөлөөлөн өгөх буюу эсхүл орон нутгийн захиргаанд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй. Нийтийн эзэмшлийн газарт зориулан нөхөн төлбөргүйгээр чөлөөлөх газар нь газар өмчлөгчийн нийт газрын 20 хувиас хэтрэхгүй байхаар заасан байна.

Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь гудамжны өөрийн хэсэгт хамаарах хэсгийн хог болон навч гишүү цэвэрлэх ажлыг хариуцна. Энэ хэсэгт цас арилгах үүрэг хүлээхгүй ба цас арилгах нь орон нутгийн захиргаа хариуцна. Цаашилбал, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь өөрийн үл хөдлөх хөрөнгийн өмнөх объект болон явган хүний замын цэвэрлэгээг хариуцах бөгөөд цас, мөс зэрэг бусдад хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэхээс урьдчилан сэргийлнэ. Өмчлөгч энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад хохирол учирвал хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх боломж үүснэ.

- Эстони Улсын хувьд хувийн сууцны хоршоолол нь орон сууц өмчлөгчдийн нийгэмлэгтэй харьцуулахад харьцангуй сүүлд бий болж хөгжсөн бөгөөд 1991 онд хоршоолол болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн эхний хэлбэр хөгжиж эхэлсэн. Эстонийн Хоршооллын тухай хууль нь анх 1992 онд батлагдсан бөгөөд 2001 онд Арилжааны нийгэмлэгүүдийн хууль болгон өөрчилсөн байна.

Орон сууцны нийгэмлэг болон амины сууцны хоршооллын тухай хуулийн зохицуулалтад The Apartment Associations Act, The Apartment Ownership Act болон The Non-profit Associations Act, Law of the Republic of Estonia on Ownership, Republic of Estonia Principles of Ownership Reform Act зэрэг хуулиуд хамаарна.

Эстони Улс нь 2007-2013 онд хэрэгжүүлэх “Эстоний амины орон сууц бодлогын стратеги”-ийг баталсан бөгөөд энэхүү стратегийн бодлогын хэрэгжилтийг Эдийн засаг, харилцаа, холбооны яам хариуцахаар тусгасан байна.

Уг стратегид тэргүүлэх гурван чиглэлийг тодорхойлсон:

- Нийгмийн тодорхой давхарга, хүрээнийхэнд хямд үнэтэй хувийн сууцаар хангах
- Шинээр баригдах орон сууцны барилгыг дэмжих
- Хот төлөвлөлтийг сайжруулах, иргэдийн амьдрах орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх гм.

Судалгаанд хамруулсан улс орны холбогдох хуулийн зохицуулалтыг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

ХБНГУ-ЫН ТУРШЛАГА

Үл хөдлөх хөрөнгө буюу имобиль гэдэг нь эрх зүйн болон аж ахуйн хэллэгээр эдлэн газар буюу эсвэл байшин (барилга эсвэл орон сууц)-г хэлдэг⁴⁰. Имобилийн үнэ цэнэ хэрхэн өөрчлөгдөхийг ажиглахын тулд түүнийг төрөл бүрээр ангилгах шаардлагатай болдог. Имобилийг ихэвчлэн доорх байдлаар хувааж авч үздэг. Үүнд:

1. Имобилийн аж ахуйн чиглэлээр ашиглах боломжгүй (газар тариалан буюу ойн аж ахуй)
2. Зорилтот ашиглалт (мөд барилгажих газар)
3. Хуулиар хашсан ашиглалт (зориулалтын барилгын талбар)
4. Бэлтгэлтэй ашиглалт (өмнө нь хуваасан болон нээсэн)
5. Анхны ашиглалт (огт ашиглаагүй шинэ барилга)
6. Ашиглагдаж буй (ашиглагдсан барилга)
7. Ашиглалтгүй (хоосон)

Ерөнхийдөө эхний 5 шатны имобилийн үнэ цэнэ тасралтгүй өсөж байдаг. Ер нь эхний шатнаас 2 дахь болон 3 дахь руу шилжихэд үнэ цэнэ хамгийн их өсөх магадлалтай. 6 дахь шатанд голдуу үнэ цэнэ буурах шинжтэй байдаг бол 7 дугаар шатанд бүр хүчтэй унадаг бөгөөд заримдаа эрүүлжүүлэх шаардлагатай буюу хур хогтой бол бүр эхний шатны үнээс ч доогуур үнэлэгдэх боломжтой.

Мөн сургууль, эрүүл мэндийн болон чөлөөт цагаа өнгөрүүлэх байгууламжийн ойролцоох байрлал нь имобилийн үнэд эерэг нөлөө үзүүлдэг. Тухайн эдлэн газарт үргэлжлүүлэн нэмж барилгажуулах төлөвлөгөө байвал имобилийн үнэ цэнэд мөн адил эерэг нөлөөтэй. Гэвч анх удаагаа барилгажих газар буюу барилгын талбар болгон ашиглахаар ажил эхлүүлсэн бол орон нутгийн захиргаанаас тавих зам гудамж, шугам хоолойн зурвас газрыг нийтийн өмчлөлийн эд хөрөнгийн зориулалтаар чөлөөлөх шаардлагатай.

Харин эсрэгээр имобилийн үнэлэмжийг бууруулдаг зүйл бол агаарын бохирдол, их хэмжээний дуу чимээ буюу хур хог-жишээлбэл, өмнө нь шатахуун түгээгүүр байсан эдлэн газрын хөрс нь хорт бодисоор бохирдсон байдаг юм. Мөн байгалийн тусгай хамгаалалттай газрын гэрчилгээтэй бол үнэ цэнэ буурах талтай, учир нь тийм газар ихэвчлэн барилгажуулахыг хориглодог. Улс төрийн шийдвэрийн үр дагавраар имобилийн үнэлэмж буурах буюу өсөх боломжтой (жишээлбэл, онгоцны буудал эсхүл хурдны зам барих). Түүхийн дурсгалт газрын хамгаалалт болон түрээсийн харилцаа нь мөн имобилийн үнэ цэнийг бууруулах талтай. Иймээс имобилийн үнэ цэнийн

⁴⁰ Имобиль-Immobilie <https://de.wikipedia.org/wiki/Immobilie>

өөрчлөлт нь тухайн эдлэн газрыг хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргахын өмнөх болон дараах ашиглалтын байдлаас хамаардаг.

Өсөн нэмэгдэж байгаа эрэлт, нөхцөл шаардлага буюу технологийн дэвшлээс үүдэлтэй үнэ цэнийн бууралтыг материаллаг бус элэгдэл хорогдол гэж үздэг бол, харин химийн, биологийн болон физикийн үзэгдлийн (жишээ нь, зэврэлт) улмаас имобиль хорогдохыг материаллаг элэгдэл гэнэ. Материаллаг элэгдлээс үүдэлтэй үнэ цэнийн хорогдлыг жишээ нь, барилгын материалын элэгдлийн хувь хэмжээг тогтоох аргачлалын дагуу тодорхойлж болно.

ХБНГУ-д имобилийн үнэлгээг Эдлэн газрын хөдөлгөөнт үнэлгээний үндсэн зарчмын тухай журмаар зохицуулдаг. Энэ журмыг Барилгын тухай хуулийн 194 дүгээр зүйлд 41 үндэслэн боловсруулсан байдаг.

Газар өмчлөгч гэж имобиль буюу эдлэн газрын эзнийг хэлнэ⁴². Эрх зүйн үүднээс эзэн (эзэмшигч) нь өмчлөгчөөс ялгаатай боловч амьдралд “газрын эзэн”, “газар өмчлөгч” гэсэн энэ хоёр ойлголтыг ижилсүүлдэг (синоним). Герман улсад газар буюу үл хөдлөх хөрөнгө өмчийг газрын бүртгэлд оруулж баримтжуулдаг. Газрын бүртгэл нь эдлэн газрын өмчлөлийн харилцаа, эдлэн газартай холбоотой эрх үүрэг болон эдлэн газарт хамаарах санхүүгийн ачаалал (барьцаа) зэргийг агуулсан нийтийн жагсаалт юм. Газрын бүртгэлээс хуулбар гаргуулж авах замаар газар өмчлөгч нь тухайн эдлэн газарт холбогдох өмчлөлийн харилцааг газрын бүртгэлээс харж болно. Эдлэн газрыг бусдад шилжүүлэхэд гарын үсэг бүхий худалдан авсан тухай гэрээг баримталдаггүй, харин хаалтын гэрээ буюу өмч хөрөнгө шилжүүлэх тухай мэдэгдэл ашигладаг. Үүнийг нотариатаар баталгаажуулах гэж ойлгох бөгөөд түүнийг үндэслэн газрын бүртгэлд өөрчлөлт оруулах буюу шинээр оруулдаг байна. Имобилийг шилжүүлэн өгөх буюу шилжүүлэн авах нь ийнхүү дээрх алхмууд хоёул хийгдэж байж хүчин төгөлдөр болдог.

Газар өмчлөгч нь тухайн эдлэн газар буюу барилгыг, мөн өөрөөр заагаагүй бол түрээслүүлж буй объект тус бүрийг тордох, өргөтгөх үүрэг хүлээдэг. Түүнээс гадна тэрээр имобилийг зээлүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, зээлийн баталгаа (барьцаа) болгож ашиглаж болно. Энэ тохиолдолд, зээлдүүлэгчийн баталгаа болгон газрын өр буюу ипотекийг холбогдох газрын бүртгэлд тэмдэглэдэг.

Газар өмчлөгч нь бүрэн бүтэн байдал буюу замын аюулгүй байдлын үүргээ биелүүлээгүйн улмаас имобиль буюу эдлэн газарт учирсан хохиролд хязгааргүй хэмжээгээр хариуцлага хүлээдэг. Энэхүү үүрэгт нь жишээлбэл, навч нахиа буюу цасыг цэвэрлэж явган хүний замын аюулгүй байдлыг хангах явдал багтдаг. Газар эзэмшигчийн болон Хариуцлагын, Өрхийн, Ослын, Орон сууцны даатгалыг ашиглан газар эзэмшигч нь имобильд учирсан хор уршиг буюу эзэмшил газрын дээрх ослын зардлыг барагдуулах боломжтой.

Газар өмчлөгчдийн холбоод нь газар өмчлөгчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага юм. Ингэхдээ газар өмчлөгчдийг халамжлах үүрэгтэй бөгөөд тэднийг эрх зүйн орчин болон шүүхийн (загвар болохуйц шүүн таслах ажиллагааны хэлбэрээр) хөгжил, мөн засаг захиргаа болон татварын

⁴¹ Хөдлөх үнэ (Зах зээлийн үнэ) Барилгын тухай хуулийн 194-р зүйл-§194 Verkehrswert, Baugesetzbuch (BauGB) http://www.gesetze-im-internet.de/bbaug/_194.html

⁴² Газар өмчлөгч-Grundeigentümer <http://www.immobilienscout24.de/eigentuemer/lexikon/grundeigentuemer.html>

чиглэлийн журмуудын талаарх мэдээллээр хангаж байдаг. Түүнчлэн мэргэжлийн сургалт явуулах, эрх зүй болон санхүү, төрийн захиргааны байгууллагатай харьцах зэрэгт бодит зөвлөгөө өгч ажилладаг. Гишүүнчлэлийн татвар нь иmobилийн төрлөөс хамааран жилд 40-150 евро байдаг.

Германы нийт орон сууцны нөөцийн 80.7% нь хувийн өмчлөлд байдаг⁴³. Хувийн өмчлөгчдийн 33.3 сая орон сууцнаас 17.6 саяыг нь өөрсдөө ашигладаг бол 15.7 сая орон сууцыг түрээслүүлдэг. Бусад өмчлөгчид 7.9 сая орон сууц түрээслүүлдэг ажээ. Эндээс хувийн өмчлөгчид нийт түрээсийн орон сууцны 66% гаруй ногдож байгааг харж болно.

Германы бүх барилгын цэвэр үндсэн хөрөнгө нь 7.4 тэрбум евро хүрдэг. Тэгвэл тосгон суурин болон замын талбай дахь эдлэн газрын үнэлгээг тоймловол ойролцоогоор 2.7 тэрбум евро гэж гарна. Ингээд нийт иmobилийн үнэ 10.1 тэрбум евро болно. Үүнээс ихэнх нь буюу 58% нь орон сууцны барилгад оногдох бол 42% нь орон сууцны бус барилга байна. 2011 оны байдлаар, ХБНГУ-ын нийт бохир үнэ цэнэ 2,334.9 тэрбум евротой тэнцэх бол иmobилийн аж ахуйн үнэлэмж 264 тэрбум евротой тэнцэнэ. Иймээс энэ салбар нь авто машин үйлдвэрлэлийн салбараас (81 тэрбум евро) мэдэгдэхүйц том буюу нийт худалдааны салбараас (226 тэрбум евро) ч том юм.

Хувийн өмчлөгчид нь өөрийн иmobильдоо жилд 95 тэрбум гаруй евро хөрөнгө оруулдаг. Тэгвэл энэ тоо нь 2.2 сая ажилтан бүхий барилгын салбарын тэн хагастай тэнцүү юм. Иmobилийн аж ахуйн салбар нь 1.8 сая ажлын байртай.

ХБНГУ-ын “Байшин ба Газар” ТББ (төрийн бус байгууллага) нь Германы Байшин болон Орон сууц, Газар өмчлөгчдийн төв холбоо бөгөөд германы хамгийн том ашиг сонирхлын нэгдэл юм⁴⁴. Одоогоор түүнд 22 муж улсын болон 900 нутгийн холбоод гишүүнчлэлтэй байна. Холбооны хүрээнд байдаг нийт 15 сая гаруй хувийн өмчлөгчдөөс ойролцоогоор 900 000 нь (2012 оны 3-р сарын байдлаар) тус холбоонд гишүүнээр элссэн байдаг. Германы “Байшин ба Газар” нь Үл хөдлөх Хөрөнгийн Олон улсын Холбоо-Union Internationale de la Propriété Immobilière (U.I.P.I.)-ны гишүүний хувиар Европын холбооны хүрээнд ашиг сонирхлын төлөөллийн үүрэг гүйцэтгэж, олон улсад үйл ажиллагаа явуулдаг. Төв холбооны чуулган (их хурал) нь жил тутам хуралддаг⁴⁵.

1870-аад онд орон нутгийн Байшин болон газрын эздийн холбоодыг герман даяар нэгдмэл удирдлагад оруулах талаар ихэд эрмэлзэх болсон. Жишээлбэл, Франкфуртын 105 Байшин өмчлөгчдийг нэгтгэсэн холбоо 1883 оны 5 сарын 24-нд анх байгуулагдаж байсан байна. 1911 онд Германы холбоо нь Холбоодын бүртгэл (улсын бүртгэл)-д бүртгэгдсэн байна. 1919 онд тус холбоо нь Германы Байшин болон Газрын Эздийн холбоо ТББ хэмээх нэрийг авч байсан байна. Гуравдугаар эзэнт гүрэн төгсгөл болсноор 1946 онд уг холбоог шинээр байгуулж, одоогийн нэрийг өгчээ.

Германд “Байшин ба газар” нь орон сууц түрээслүүлэгчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага бол эсрэгээр орон сууц түрээслэгчдийн эрх ашгийг

⁴³ Иmobилийн аж ахуйн тоо, баримтууд-Daten und Fakten zur Immobilienwirtschaft <http://www.hausundgrund.de/daten-fakten-immobilien-wirtschaft.html>

⁴⁴ Байшин ба газар-Haus & Grund https://de.wikipedia.org/wiki/Haus_%26_Grund

⁴⁵ Төв холбооны чуулган (их хурал)-Haus & Grund Zentralverbandstage <http://www.hausundgrund.de/zentralverbandstage.html>

хамгаалдаг Түрээслэгчдийн холбоо ТББ мөн үйл ажиллагаа явуулдаг⁴⁶. Түрээслэгчдийн холбоо нь Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй нягт хамтран ажилладаг.

ОХУ-ЫН ТУРШЛАГА

Оросын Холбооны Улсад үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөлтэй холбоотой харилцааг 1994 оны **Иргэний хууль** болон 1998 оны **Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай хуулиар** зохицуулж байна. ОХУ-ын Иргэний хуульд 2014 оны 5 сарын 5-ны №99 Холбооны хуулиар⁴⁷ нэмэлт өөрчлөлт оруулж Орон сууц өмчлөгчдийн нөхөрлөл (*Товарищество собственников жилья (ТСЖ)*)-ийг Үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөл (*Товарищество собственников недвижимости (ТСН)*) болгон хуулийн хамрах хүрээг нь өргөжүүлжээ.

Дээрх нэмэлт өөрчлөлт нь гишүүдийн эрх ашгийг хамгаалах, хэрэгжүүлэх зэрэг зохицуулалт дутмаг, хуульд тусгагдаагүй харилцааг зохицуулах, үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн эрх зүйн орчин боловсронгуй болгоход чиглэгдсэн байна. Нөхөрлөл нь ашгийн бус статустай байх бөгөөд үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн (Үүнд: барилга байшин дахь талбай эзэмшигч, үүнд нийтийн болон амины орон сууцны байшин, зуслангийн байшин, цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалт бүхий газар) дундын өмчийг хуульд заасны дагуу ашиглах зорилго бүхий сайн дурын нэгдэл байна. Иргэний хуульд үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн эрх зүйн статусын ерөнхий байдлаар зохицуулсан бөгөөд удирдлага, зохион байгуулалт, эрх үүрэг, үйл ажиллагаа зэргийг 1998 оны №66 Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай хууль⁴⁸-аар нарийвчлан зохицуулсан байна.

Иргэний хууль 1994 №51

123.12. Үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөлийн талаарх ерөнхий заалт:

1. ҮХХӨН нь үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн (барилга байшин дахь талбай эзэмшигч, үүнд нийтийн болон амины орон сууцны байшин, зуслангийн байшин, цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалт бүхий талбай) дундын өмчлөлийн эд хөрөнгийг хуульд заасан хязгаарын хүрээнд ашиглах болон хуульд заасан бусад зориулалтаар үүсгэн байгуулсан сайн дурын нэгдлийг хэлнэ.
2. Нөхөрлөлийн дүрэмд тус нөхөрлөлийн оноосон нэр (ҮХХӨН-ийг багтаасан байх), оршин байгаа газрын хаяг, зорилго, үйл ажиллагааны чиглэл, нөхөрлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн бүрэн эрх, санал нэгтэй, эсхүл дийлэнх олонхийн саналаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал болон хуульд заасан бусад мэдээллийг тусгасан байна.
3. ҮХХӨН нь гишүүдийн хүлээх үүргийг хариуцахгүй. ҮХХӨН-ийн гишүүд нь нөхөрлөлийн хүлээх үүргийг хариуцахгүй.
4. ҮХХӨН-ийг гишүүдийн шийдвэрээр хэрэглэгчдийн хоршоо болгон өөрчилж болно.

46 Түрээслэгчдийн холбоо-Mieterverein <https://de.wikipedia.org/wiki/Mieterverein>

47 Федеральный закон от 5 мая 2014 г. N 99-ФЗ "О от 5 мая 2014 г. N 99-ФЗ "О внесении изменений в главу 4 части первой Гражданского кодекса Российской Федерации и о признании утратившими силу отдельных положений законодательных актов Российской Федерации"

48 Закон от 1998 о садоводческих, огороднических и дачных некоммерческих объединениях граждан РФ

123.13. ҮХХӨН-ийн эд хөрөнгө

1. ҮХХӨН нь өөрийн хөрөнгийн өмчлөгч байна.
2. Нийтийн орон сууц дахь дундын өмчлөлийн зүйл, мөн цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус нөхөрлөлийн дундын эд хөрөнгө нь хуульд өөрөөр заагаагүй бол дундын өмчлөлийн үндсэн дээр тус нөхөрлөлийн гишүүдийн дундын өмч байна. Тус хөрөнгөд хамаарах эд зүйлс болон дундын хөрөнгийн өмчлөлийн хувь хэмжээг хуулиар тогтооно.
3. Нийтийн зориулалттай орон сууц дахь дундын өмчийн эд хөрөнгийн тус орон сууцад талбай эзэмшигчийн оногдох хувь, цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалт бүхий газар өмчлөгчдийн нөхөрлөлийн дундын өмчийн хувийг – тус ашгийн бус нөхөрлөлийн гишүүдийн өмчлөлийн талбай, эсхүл газрын өмчлөлийн эрхтэй хувь тэнцүү байна.

123.14 ҮХХӨН-ийн удирдлагын онцлог:

1. ҮХХӨН-ийн эрх барих дээд байгууллагын онцгой эрхэд энэхүү хуулийн 65.3-р зүйлийн 2-т⁴⁹ зааснаас гадна төлбөрийн хэмжээ болон гишүүнчлэлийн төлбөр хураамж тогтоох асуудал багтана.
2. ҮХХӨН нь дарга/ тэргүүлэгч болон зөвлөл бүхий гүйцэтгэх байгууллагатай байна. ҮХХӨН-ийн эрх барих дээд байгууллагын шийдвэрээр гүйцэтгэх байгууллагыг эрх үүргээ ноцтой зөрчсөн, үйл ажиллагаагаа зохих хэмжээнд явуулах чадваргүй болон бусад үндэслэлээр татан буулгаж болно.

65.3-р зүйл. Корпорацийн удирдлага:

Энэ хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол корпорацийн эрх барих байгууллага нь дараах онцгой эрхтэй байна:

- корпорацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үүсгэн байгуулах болон хоршооны эд хөрөнгийг захиран зарцуулах зарчмыг тодорхойлох;
- дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах,
- хуульд зааснаас бусад тохиолдолд гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах журам тогтоох;
- корпорацийн дүрмээр корпорацийн бусад байгууллагын бүрэн эрхэд хамруулаагүй бол корпорацийн бусад нэгж байгуулах, түүнийг татан буулгах;
- корпорацийн дүрмээр корпорацийн бусад байгууллагын бүрэн эрхэд хамруулаагүй бол жилийн тайлан, тэнцлийг батлах;
- аж ахуйн нэгжийн тухай хуульд аж ахуйн нэгжийн дүрмээр бусад байгууллагын бүрэн эрхэд хамруулаагүй бол хоршоо нь өөр хуулийн этгээд байгуулах, бусад хуулийн этгээдэд нэгдэх, салбар болон төлөөлөгчийн газар байгуулах асуудлаар шийдвэр гаргах;
- корпорацийг өөрчлөн байгуулах, татан буулгах, татан буулгах комисс байгуулах болон татан буулгах хаалтын баланс зэрэг асуудлаар шийдвэр гаргах;
- хяналтын комисс болон аудиторын байгууллага, эсхүл корпорацийн аудитор сонгох;

⁴⁹ https://www.consulant.ru/document/cons_doc_LAW_5142/038d7bf588070a52b57e90e5588d2ab9922268b1/

- хууль болон корпорацийн бусад актаар түүний бүрэн эрхэд бусад асуудал тусгаж болно;
- энэхүү хууль болон бусад хуульд заасан корпорацийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад байгууллагад шилжүүлэхийг хориглоно;

Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай хууль 1998 №66

Тус хууль нь иргэдийн цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн аж ахуй, үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцаа болон дээрх зориулалтаар ашгийн бус холбоо байгуулах, болон холбогдох зохицуулна. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбоо байгуулахтай холбоотой үүсэх газрын харилцааг бусад хуулиар зохицуулаагүй хэсгийг энэхүү хуулиар зохицуулна.

Тус хууль нь 10 бүлэг 55 зүйлээс бүрдэх бөгөөд дараах бүлгүүдтэй байна:

1-р бүлэг. Ерөнхий зүйл;

2-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалтаар газар олгох;

3-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн хэлбэр;

4-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбоо байгуулах, Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны гишүүдийн эрх үүрэг;

5-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны удирдлага;

6-р бүлэг. 28-31-р зүйл 2014.06.23-ны №122 хуулиар хүчингүй болсон;

7-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны газар талбайн зохион байгуулалт болон бүтээн байгуулалт;

8-р бүлэг. Төрийн болон орон нутгийн байгууллагуудад цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбоодод дэмжлэг үзүүлэх;

9-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

10-р бүлэг. Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбоо болон түүний гишүүдийн эрхийг хамгаалах, Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага;

1-р зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт:

Дундын өмчлөлийн эд хөрөнгө – цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн зориулалтын газар өмчлөгчдийн ашгийн бус холбооны гишүүдийн хэрэгцээнд тус холбооны газар нутгийн хүрээнд орох, гарах гарц, ус хангамж, ус зайлуулах, цахилгаан, хий болон дулаан хангамж, харуул хамгаалалт, амралт болон бусад хэрэгцээг хангах зориулалтын /зам, усны цамхаг, худаг, дундын хашаа, хаалга, уурын зуух, хогийн цэг, гал түймэртэй тэмцэх байгууламж зэрэг/ эд хөрөнгийг хэлнэ.

ФИНЛАНД УЛС

Скандинавын орнуудын хувьд амины сууц өмчлөгчдийн холбоо нь эрх зүйн зохицуулалтын хувьд ижил байх бөгөөд үүнээс Финланд улсыг сонгон судлав. Финланд улсын хувьд амины сууц өмчлөгчдийн харилцаанд дундын эзэмшлийн газар өмчлөх харилцаа хөндөгдөх бөгөөд амины сууц өмчлөгчдийн холбооны гишүүн нь үл хөдлөх хөрөнгө болон амины сууц өмчлөгч байна. Өөрөөр хэлбэл, үл хөдлөх хөрөнгө болон амины сууц өмчлөгчдөөс бүрдсэн Зөвлөл нь тус харилцааны нэг субъект байх бөгөөд орон сууцны компаниудтай гэрээ байгуулан тухайн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой аливаа үйлчилгээг хариуцуулах аутсорсинг үйлчилгээнд тулгуурласан харилцаа байдаг байна.

Финландын амины сууц өмчлөгчдийн холбоо нь эрх зүйн статусын хувьд ашгийн бус холбоо, хоршоолол, сангийн хэлбэртэй байж болно. Харин орон сууцны компаниуд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (*non profit limited-liability companies*)-ийн хэлбэртэй хуулийн этгээдээр бүртгэгддэг байна.

Скандинавын орнууд, тэр дундаа Финланд улсад сууц өмчлөгчдийн холбоо нь:

- *хувийн сууц өмчлөгчдийн холбоо (single-family house ownership association)*
- *орон сууц өмчлөгчдийн холбоо (multi-family house ownership association)*

гэсэн хоёр төрөлтэй байна. Финландын ОСӨХ буюу *multi-family house ownership association* нь Орон сууцны компанийн тухай хуулиар (*Housing companies act*) зохицуулагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байх боловч энэхүү судалгаанд гэр хорооллын газар өмчлөлтэй холбоотой харилцааг судлах тул Орон сууцны компанийн тухай хуулийг нарийвчлан судлахгүй болно.

Харин ГӨХ, тэр дундаа дундын өмчлөлийн газартай холбогдох харилцааг судлах нь судалгааны зорилго тул амины сууц өмчлөгч болон үл хөдлөх хөрөнгө өмчлөлтэй холбогдон гарсан харилцааг хэрхэн зохицуулдгийг дэлгэрүүлэн судлах болно.

Финландын үл хөдлөх хөрөнгийн тогтолцоо нь хувийн өмчийн газрын харилцаан дээр суурилсан байдаг бөгөөд өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулиараа хамгаалсан байдаг байна. Финландын газар өмчлөлийг өмчлөгчдийн бүтцээр нь авч үзвэл:

- нийт газар нутгийн 60 хувь нь хувь хүний болон өв залгамжлалаар өвлөн авсан хувийн өмчийн газар;
- 29 хувь нь төрийн өмч бөгөөд төрийн өмчийн газар нутгийн ихэнхийг хойд Финландын ой эзэлдэг байна;
- нийт газар нутгийн 8 хувь компанийн өмчлөлд;
- 2 хувь нь орон нутгийн засаг захиргааны өмчлөлд;
- 1 хувийг сүм, хийд өмчилдөг байна;

Үл хөдлөх хөрөнгө буюу сууцны хувьд нийт гэр бүлийн зориулалттай орон сууцны 40 хувь нь хувийн сууц (*detached house / single-family house*) байна.

Эрх зүйн зохицуулалт

Финланд Улсад үл хөдлөх хөрөнгө (газар түүнээс салгаж үл болох барилга байгууламж) өмчлөгчдийн эрхийг Үндсэн хуулиар хамгаалах бөгөөд түүнд нийцүүлэн гаргасан дараах хууль тогтоомжоор зохицуулна. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгийн тухай хууль (Real Estate Property Act);
2. Үл хөдлөх Хөрөнгийн Үүслийн тухай хууль (Real Estate Formation Act 2003);
3. Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль (Environmental Protection Act);
4. Газар ашиглалт болон барилгын тухай (Land Use and Building Act 2003);
5. Орон сууцны компанийн тухай хууль (Housing Companies Act);
6. Холбооны тухай хууль (Finnish Associations Act);
7. Хоршооллын тухай хууль (Co-operatives Act) зэрэг болно.

Эдгээрээс Орон сууцны компанийн тухай хууль, Холбооны тухай хууль болон Хоршооллын тухай хууль нь орон сууцны компани болон холбоо, сан, хоршооллын эрх зүйн статус, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, компанийн менежмент, үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдөд үзүүлэх засвар үйлчилгээ, үйлчилгээний хураамж, шийдвэр гаргах процесс, хурлын ирц, өмчлөгчдийн хурал, хориглох зүйлс, аудит болон холбогдох бусад харилцааг зохицуулдаг.

Үл хөдлөх хөрөнгө өмчлөлтэй холбоотой харилцаанд оролцогч хуулийн этгээд нь Орон сууцны тухай хуулиар зохицуулагдсан 5 төрлийн компани, түүнчлэн үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн хоршоолол, сан, холбоо зэрэг хуулийн этгээдүүд байна.

Орон сууцны компанийн тухай хуульд зааснаар сууц өмчлөгчдөд үйлчилгээ үзүүлдэг 5 төрлийн компани байдаг бөгөөд эдгээрээс зөвхөн нэг нь л хувийн орон сууц болон газар өмчлөгчдөд үйлчилгээ үзүүлнэ.

- Хоршооллын тухай хуульд зааснаар “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол бүх төрлийн хоршоодод энэ хууль үйлчилнэ”.⁵⁰ Хуулийн 2 дугаар зүйлд зааснаар Хоршоолол нь хувь нийлүүлсэн хөрөнгө болон гишүүнчлэлээр нэгдсэн байгууллага байна. Хоршооллын зорилго нь гишүүдийн эдийн засаг болон бизнесийн хамтын ажиллагаанд шаардагдах үйлчилгээ үзүүлэх замаар гишүүдийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагааг дэмжихэд оршино. Хоршооллын хамтын ажиллагааны гол зорилгыг өөрсдийн дүрмээр тусгайлан зааж болно. Энэ хуулиар Хоршооллын үйл ажиллагааны ерөнхий журам, Хоршоолол нэгдэх, салах, шийдвэр гаргах процесс, зээл тусламж зэрэг суурь зохицуулалтыг хуульчилсан бөгөөд хувийн сууц өмчлөгч, газар өмчлөгчдийн гэх мэт тусгайлсан төрлүүдийг нэр заан зохицуулаагүй бөгөөд ийм төрлийн хоршоолол байх нь нээлттэй гэж заасан байдаг.

- Финландын Холбооны тухай хуулиар Холбоо нь ашгийн бус, нийтлэг эрх ашгийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан байна. Холбооны зорилго нь хууль бус байж үл болно⁵¹. Бүх төрлийн Холбоог энэ хуулиар зохицуулна гэж заажээ. Мөн тус хуульд зааснаар Холбоо нь ашгийн болон санхүүгийн ашиг орлого олох зорилго бүхий үйл ажиллагаа

⁵⁰ Co-operatives Act (1488/2001; OSUUSKUNTALAKI)

⁵¹ Finnish Association Act 2003

явуулахыг хязгаарлана. Шашны болон засаг захиргаатай холбоотой холбоо энэ хуулиар зохицуулахгүй бөгөөд тус тусын хуулиар зохицуулагдана. Зэвсэглэлийн зорилгоор цэргийн зохион байгуулалтад орж холбоо үүсгэхийг хуулиар хориглоно гэж зааснаас бусад бүх төрлийн холбоог энэ хуулиар зохицуулна. Үүнд сууц өмчлөгчдийн болон амины сууц өмчлөгчдийн холбоо, Зөвлөл, үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт нь энэ хуулиар зохицуулагдана.

Финланд Улсын хувьд үл хөдлөх хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах харилцаатай холбоотойгоор хүрээлэн буй орчны асуудал нэн чухалд тооцогддог. Финландын хүрээлэн буй орчны тухай ихэнх хууль тогтоомж нь 1990 онд батлагдсан бөгөөд газар болон усны бүсийг ашиглахтай холбоотой хууль тогтоомж хуучин үзэл баримтлал дээр суурилсан байдаг. Үл хөдлөх хөрөнгө эзэмших ашиглахтай холбоотойгоор газрын болон усны бүсийн тухай хууль тогтоомж заавал хөндөгдөх бөгөөд үүнийг Финландад Газар ашиглалт болон барилгын тухай хууль, Хүрээлэн буй орчны хамгааллын тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн Үүслийн тухай хуулиар зохицуулж байна.

Түүнчлэн үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь өөрийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын өмчлөх эрхийг зөрчих, бусдын өмчлөх эрхэд хохирол учруулах, зам болон зорчих хэсгийг хаах зэргийг хориглоно. Үүнээс үүдэн хөршүүд хоорондоо харилцан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Хөршийн эрхэд үл хөдлөх хөрөнгө эзэмших ашиглахтай холбоотой бүх төрлийн харилцаа багтана. Тухайлбал, явган хүний зам, таримал ургамал, хүрээлэн буй орчин руу гарсан гарц, нийтийн эзэмшлийн талбайтай холбоотой харилцаан дээр бүх өмчлөгчид адил үүрэг хүлээнэ.

• Газар ашиглалт болон Барилгын тухай хуулиар газар ашиглах төлөвлөгөө, барилгажуулах болон бусад үйл ажиллагааг зохицуулах бөгөөд өргөн хүрээний зохицуулалттай хууль юм. Тус хуульд зааснаар газар ашиглах 3 шатны төлөвлөгөө боловсруулах бөгөөд ингэхдээ газар ашиглалт, төлөвлөлтийн зорилго нь эрүүл, аюулгүй, таатай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд иргэдийн амьдрах, ажиллах таатай орчныг бий болгох нийгмийн үүрэгтэй.

Түүнчлэн эдийн засгийн хувьд үр ашигтай, хямгач суурин газрын бүтцийг бий болгох, барьж байгуулсан орчны тохижилтын үзэмжийг хамгаалах, соёлын болон байгалийн үнэт зүйлсийг хамгаалах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, хотын болон засаг захиргааны үйл ажиллагаа, бизнесийн орчин, үйлчилгээ, замын хөдөлгөөн зэргийг харгалзан үзэж газар ашиглалтыг зохион байгуулна.

Газар ашиглалт болон Барилгын тухай хуулийн дагуу тус хууль нь бүх төрлийн газар ашиглалт болон газрын үнэлгээнд үйлчилнэ. Мөн тус хуульд зааснаар хотын гудамжны болон суурьшлын бүсийн тохижилт, засвар үйлчилгээг хотын захиргаа хариуцна. Тус хуульд дундын өмчлөлийн буюу нийтийн эзэмшлийн газрын хувьд газар өмчлөгчийн хүлээх үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Газар өмчлөгч буюу газрын эзэн нь тухайн орон нутгийн нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гудамж болон гудамжны бүсийн хэрэгцээнд

өөрийн өмчийн газраас тодорхой хэмжээний газар чөлөөлөн өгөх буюу эсхүл орон нутгийн захиргаанд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй.

Нийтийн эзэмшлийн газарт зориулан нөхөн төлбөргүйгээр чөлөөлөх газар нь газар өмчлөгчийн нийт газрын 20 хувиас хэтрэхгүй байхаар заасан байна.

Үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь гудамжны өөрийн хэсэгт хамаарах хэсгийн хог болон навч гишүү цэвэрлэх ажлыг хариуцна. Энэ хэсэгт цас арилгах үүрэг хүлээхгүй ба цас арилгах нь орон нутгийн захиргаа хариуцна.

Цаашилбал, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь өөрийн үл хөдлөх хөрөнгийн өмнөх объект болон явган хүний замын цэвэрлэгээг хариуцах бөгөөд цас, мөс зэрэг бусдад хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэхээс урьдчилан сэргийлнэ. Өмчлөгч энэ үүргээ биелүүлээгүйгээс бусдад хохирол учирвал хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх боломж үүснэ.⁵²

Түүнчлэн усны болон шугам сүлжээ зэрэг дундын өмчлөлийн сүлжээг ашигласныхаа төлөө үл хөдлөх хөрөнгө өмчлөгч нь хотын захиргаанд зохих төлбөр төлнө. Холболтын хураамжид барилгын зардал, бохир усны зардал, дэд бүтцийн сүлжээний засвар үйлчилгээний зардал зэрэг нь орно. Усны зардлыг тухайн үл хөдлөх хөрөнгөд ашигласан усны хэрэглээнд суурилан тооцно. Мөн эрчим хүч, дулаан, харилцаа холбоо, түүний засвар үйлчилгээний зардлыг цахилгаан дулаан, харилцаа холбооны сүлжээнд төлнө.

Эдгээр зардлыг төлөх боломжгүй гэж үзвэл өөрийн өмчийн газар дээр цахилгаан, холбоо, дулаан, бохирын хоолой зэргийг барьж болно. Ийнхүү өөрийн өмчийн газарт дэд бүтцээ барьсан бол түүнээс үүдэн гарах бүх үр дагаврыг өөрөө хариуцна.

Түүнчлэн Газар ашиглалт болон Барилгын тухай хуульд зааснаар газар ашиглалтын 2 төрлийн гэрээ байна. Нэг нь газрын нарийвчилсан төлөвлөгөөтэй холбоотойгоор газрын эзэн болон нутгийн захиргааны хооронд байгуулсан гэрээ, нөгөө нь үндсэн төлөвлөгөөний тодорхой нэг төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор газрын эзэн болон нутгийн захиргаатай байгуулсан гэрээ байна. Энэ мэтчилэн Газар ашиглалт болон Барилгын тухай хууль нь газар өмчлөгчийн эрх үүрэгтэй холбоотой өргөн хүрээний харилцааг зохицуулсан байна.

- Үл хөдлөх Хөрөнгийн Үүслийн тухай хуульд дундын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө болон нийтийн эзэмшлийн бүс гэсэн хоёр ойлголтыг хуульчлан тогтоосон байна. Үл хөдлөх хөрөнгийн үүслийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаар⁵³ “дундын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийн нэгж гэдэгт хоёр буюу түүнээс дээш үл хөдлөх хөрөнгө байрлах талбайн хамтран эзэмших хэсгийг хамааруулна.”

Мөн хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт нийтийн эзэмшлийн бүс⁵⁴ (public area) гэх нэр томъёог хуульчилсан бөгөөд “Нийтийн эзэмшлийн бүсэд хотын захиргааны өмчийн үл хөдлөх хөрөнгө, зохион байгуулагдсанаас бусад бүс, аливаа гудамж талбай гэж оноосон бүс, зах эсхүл талбай, эсхүл хотын

⁵² Land Use and Building Act (132/1999, amendment 222/2003 included)

⁵³ Real Estate Formation Act (554/1995; amendments up to 111/2003 included)

⁵⁴ Real Estate Formation Act (554/1995; amendments up to 111/2003 included)

төлөвлөгөөний амралт зугаалгын бүс, замын хөдөлгөөн бүхий бүс, аюултай бүс, тусгай бүс, усны бүс болон Үл хөдлөх Хөрөнгийн Бүртгэлд нийтийн эзэмшлийн бүс гэж бүртгэгдсэн газар хамаарна” гэж заажээ.

ЭСТОНИ УЛС

Эстонийн хувийн сууцны хоршоолол нь орон сууц өмчлөгчдийн нийгэмлэгтэй харьцуулахад харьцангуй сүүлд бий болж хөгжсөн.

Эстонийн хоршоолол харьцангуй шинэ буюу 1991 онд тусгаар тогтнолоо тогтоож “өөрчлөн байгуулалт” болоход хоршоолол болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн эхний хэлбэр цэцэглэн хөгжиж эхэлсэн. Эстонийн Хоршооллын тухай хууль нь анх 1992 онд батлагдсан бөгөөд 2001 онд Арилжааны нийгэмлэгүүдийн хууль болгон өөрчилсөн.

Төрөөс газар их хэмжээгээр хувьчлах болсонтой холбоотойгоор орон сууцны хоршооллууд хурдтайгаар өссөн. Хувьчлал 1990 оны эхээр эхэлж, эдийн засгийн бүх зүйлд нөлөөлсөн. Төрийн өмчийн газар аж ахуйн нэгжүүд маш богино хугацаанд хувьчлагдсан.

Хувийн сууцны хувьчлал гурван шаттай явагдсан: орон сууцны хувьчлал, амины сууцны хоршоолол болон нийтийн сууцны нийгэмлэгийн үүсгэн байгуулалт, мөн амины сууцны өмчлөлийг бүртгэлжүүлэх. Орон сууцыг хувьчлахдаа түрээслэгчдэд газар дээр нь эрхийн бичиг өгөх замаар хийгдсэн.

Гурван жил хүрэхгүй хугацаанд 1993 он гэхэд 3000-аас илүү хувийн сууц, орон сууцны хоршоолол нийгэмлэгүүд байгуулагдсан. Хувьчлах үйл явцын эхний ажил нь хувийн сууцыг шинэчлэх байсан. Орон сууцнууд нь 20-50 жилийн настай хуучны байшингууд байсан. Тэдгээр нь барилга болон орон сууцны наад захын шаардлага хангаагүй барилга учир нийт барилгыг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай болсон.

Гэсэн хэдий ч улс болон иргэдийн эдийн засгийн байдал хүндрэлтэй байсан учраас бүхий л барилга, байгууламжийг бүхэлд нь шинэчлэх боломжгүй байсан учраас хувьчлагдсан хувийн сууц өмчлөгчдөд тулгуурлан барилгын сэргээн босголтыг хүрээнд Хувьчлах хөтөлбөрийг 2003 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд Эстонийн Үндэсний амины сууцны хөгжлийн стратеги /2008-2013/ батлан хэрэгжүүлж, 2008 оноос эхлэн орон сууцны холбоод статусаа өөрчлөн хувийн сууцны хоршоолол болгон өөрчилсөн.

Энэхүү хоршоолол нь хувийн сууц өмчлөгчид барилга, газар, талбай хамтын ашиг сонирхол, хамтын удирдлагыг хэрэгжүүлэх зорилго бүхий амины сууцны эздийн байгуулсан ашгийн бус холбоо юм. Өнөөдрийн байдлаар тус улсад энэ төрлийн 300 гаруй хоршоолол үйл ажиллагаагаа явуулж байна.

Орон сууцны нийгэмлэг болон амины сууцны хоршооллын тухай хуулийн зохицуулалтад The Apartment Associations Act, The Apartment Ownership Act болон The Non-profit Associations Act, Law of the Republic of Estonia on Ownership, Republic of Estonia Principles of Ownership Reform Act зэрэг хуулиуд хамаарна.

Эстонийн Амины Сууцны Бодлогын Стратеги 2007–2013 улсаас хувийн сууцны стратеги баталсан. Энэхүү стратегийн бодлогын хэрэгжилтийг Эдийн засаг, харилцаа холбооны яамнаас хариуцдаг.

Уг стратегид тэргүүлэх гурван чиглэлийг тодорхойлсон:

- Нийгмийн тодорхой давхарга, хүрээнийхэнд хямд үнэтэй хувийн сууцаар хангах
- Шинэ баригдах орон сууцны барилгыг дэмжих
- Хот төлөвлөлтийг сайжруулах, иргэдийн амьдрах орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Эстонийн Амины Сууцийн Хоршооллын гол онцлог нь:

- Нийтийн газар нутгийг удирдахаар бүрэлдсэн
- Захирлуудын зөвлөлөөр удирдуулдаг ашгийн бус байгууллага
- Удирдах зөвлөл хэрэв шаардлагатай бол үл хөдлөх хөрөнгийн менежер хөлсөлж болно.
- Нэгж бие даасан гишүүдэд харьяалагдана.
- Орон сууцны үнийг зах зээлийн үнэд тулгуурлана.
- Өмчлөгчид бодит зардлын дагуу төлбөр төлнө.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ОХУ:

- *Иргэний хууль, 1994 /Гражданский кодекс РФ/* https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_5142/
- *Цэцэрлэг, ногооны аж ахуй болон зуслангийн ашгийн бус холбооны тухай хууль, 1998 /Закон о садоводческих, огороднических и дачных некоммерческих объединениях граждан РФ/* <http://pravo.gov.ru/proxy/ips/?searchres=&bpas=cd00000&a3=02000505&a3type=1&a3value=&a6=&a6type=1&a6value=&a15=&a15type=1&a15value=&a7type=1&a7from=&a7to=&a7date=15.04.1998&a8=66&a8type=1&a1=&a0=&a16=&a16type=1&a16value=&a17=&a17type=1&a17value=&a4=&a4type=1&a4value=&a23=&a23type=1&a23value=&textpres=&sort=7&x=34&y=11>
- *Зуслан өмчлөгчдийн нөхөрлөлийн дүрэм /Загвар:*
<http://www.dom-evropa.ru/images/ustavzod.pdf>
- <http://f1-consultant.ru/articles/tsn-vmesto-tszh-cto-izmenitsya/>
- https://www.consultant.ru/law/podborki/dachnoe_nekommercheskoe_tovarischestvo/

ХБНГУ:

- Хөдлөх үнэ (Зах зээлийн үнэ) Барилгын тухай хуулийн 194-р зүйл-§194 Verkehrswert, Baugesetzbuch (BauGB) http://www.gesetze-im-internet.de/bbaug/___194.html
- Газар өмчлөгч-Grundeigentümer <http://www.immobilienscout24.de/eigentuermer/lexikon/grundeigentuermer.html>
- Иmobилийн аж ахуйн тоо, баримтууд-Daten und Fakten zur Immobilienwirtschaft <http://www.hausundgrund.de/daten-fakten-immobilienwirtschaft.html>
- Төв холбооны чуулган (их хурал)-Haus & Grund Zentralverbandstage <http://www.hausundgrund.de/zentralverbandstage.html>
- Түрээслэгчдийн холбоо-Mieterverein <https://de.wikipedia.org/wiki/Mieterverein>

Финланд улс:

- Real Estate Formation Act <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1995/en19950554.pdf>
- Environmental Protection Act <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2000/en20000086.pdf>
- Land Use and Building Act 2003 <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990132.pdf>
- Housing Companies Act <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1991/en19910809.pdf>
- Finnish Associations Act <https://www.prh.fi/en/yhdistysrekisteri/act.html>
- Co-operatives Act <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2001/en20011488.pdf>
- REAL ESTATE IN FINLAND. Kauko Viitanen, Jussi Palmu, Matti Kasso, Erja Hakkarainen, Heidi Falkenbach

Эстони:

- <https://www.eesti.ee/eng/topics/citizen/eluase>
- https://www.eesti.ee/eng/raha_ja_omand/omand_ja_vara/omand
- <http://landportal.info/landlibrary-resource-type/legislation?page=5>
- <http://faolex.fao.org/docs/pdf/est7932.pdf>
- <http://www.ebrd.com/downloads/legal/core/estlom.pdf>
- <http://ekyl.ee/organisation/housing-cooperatives-in-estonia/?lang=en>

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САН БА ГАЗАР ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Ч.Онончимэг, Д.Халиун

Судалгаанд иргэн, ААН-ийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад буй газрын хэмжээ, өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо болон Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангилалаар /тусгай хамгаалалттай, бэлчээрийн, тариалангийн гэх мэт/ ангилсан хэмжээ, тэдгээрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад буй хувь хэмжээний өсөлт бууралт, газрын нэгдмэл сангийн бодлого зохицуулалтын хүрээнд холбогдох байгууллагуудын хийсэн ажил, авсан арга хэмжээний талаарх мэдээлэл болон нийслэл хот, аймаг, орон нутагт газар өмчлөл хэрхэн явагдаж байгаа талаарх мэдээллүүдийг багцлан судаллаа.

Судалгааны мэдээллийг захиалагчаас ирүүлсэн дарааллын дагуу дараах бүтцээр ангилан гаргав. Үүнд:

- Газрын тухай багц хуулийн төслийн талаарх мэдээлэл;
- Монгол Улсын газар нутгийн хэдэн хувийг, хэдэн иргэн *өмчилж* байна вэ;
- Монгол Улсын газар нутгийн хэдэн хувийг хэдэн иргэн, аж ахуйн нэгж ямар зориулалтаар *эзэмшиж* байна вэ, үүнээс гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хэд байна вэ;
- Монгол Улсын газар нутгийн хэдэн хувийг хэдэн иргэн, аж ахуйн нэгж ямар зориулалтаар *ашиглаж* байна вэ, үүнээс гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хэд байна вэ;
- Монгол Улсын газар нутгийн хэдэн хувь нь тусгай хамгаалалттай, хэдэн хувь нь бэлчээр, тариалангийн газар байна вэ;
- Газрын сангийн нэгдмэл бодлого, зохицуулалтын талаар хийсэн ажлын тайлангийн талаарх холбогдох байгууллагын мэдээлэл;
- Нийслэл хот, аймгуудад газар өмчлөл хэрхэн явагдаж байгаа талаар зэрэг асуултуудын хүрээнд холбогдох мэдээллийг бэлтгэсэн болно.

СУДАЛГААНЫ ТОЙМ

Газрын нэгдмэл сангийн 2015 оны жилийн эцсийн тайланд дурдсанаар Монгол Улсын газрын нэгдмэл санд улсын хэмжээний нийт газар нутгийг дараах ангилалаар бүртгэсэн байна. Үүнд:

- хөдөө аж ахуйн газар 114982.8 мян.га буюу 73.5%;
- хот, тосгон бусад суурин газар 716.9 мян.га буюу 0.5%;
- зам, шугам сүлжээний газар 462.5 мян.га буюу 0.3%;
- ойн сан бүхий газар 14334.4 мян.га буюу 9.2%;
- усны сан бүхий газар 686.1 мян.га буюу 0.4%;
- улсын тусгай хэрэгцээний газар 25228.9 мян.га буюу 16.1 %-ийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын хэмжээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад нийт **6190667.1** га газрыг олгосон байх бөгөөд үүнээс **47840.5** га-г өмчлөх, **5936081.3** га-г эзэмших, **187434.6** га-г ашиглах зориулалтаар олгосон байна. Мөн бусдын эзэмшил **19310.5** га газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд тус тус ашиглаж байна.

2015 оны байдлаар улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглах эрх бүхий 872813 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаа бөгөөд энэ нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 69596-аар өссөн байна.

Газар өмчлөлийн хүрээнд, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2015 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 446004 иргэн 47840.58 га газар буюу Монгол Улсын газар нутгийн 0.03 хувийг өмчилж авсан байна.

Газар эзэмшлийн хүрээнд, 2015 оны байдлаар нийт 425149 иргэн 5936081.4 га газар эзэмшиж байгаа бөгөөд энэ нь манай улсын нутаг дэвсгэрийн 3.8 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд 2015 онд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад нийт 6190667.1 га газар олгогдсон байх бөгөөд олгогдсон газрын 96 хувь нь эзэмшил газар байна.

Газар ашиглалтын хүрээнд, 2015 оны байдлаар улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа нийт 6190667.1 га газраас 187434.6 га газар ашиглагдаж байна. Мөн бусдын эзэмшил 19310.5 га газрыг Монгол Улсын иргэн, төрийн байгууллагууд ашиглаж байна.

Судалгаанд Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2015 оны Улсын нэгдсэн тайланг дэлгэрэнгүй байдлаар хавсаргасан болно. Уг тайлангаас газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын бусад арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар харах боломжтой.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1/ Газрын тухай багц хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэж, өмчилсөн газраа санхүүгийн эргэлтэд оруулах бодит боломжийг бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн газрыг гэрчилгээжүүлэх” болон “Газрын харилцааны шинэтгэлийг хийх” бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр заасан байна.

Эдгээр зорилтуудын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд “Газрын тухай”, “Газрын төлбөрийн тухай”, “Газрын кадастрын тухай” хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, “Геодези, зураг зүйн тухай” хуульд оруулах нэмэлт өөрчлөлт болон “Газрыг албадан чөлөөлөх тухай” хуулийн төслийг шинээр боловсруулан Газрын тухай багц хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Гэвч хэлэлцүүлгийн явцад хууль санаачлагчийн зүгээс уг багц хуулийн төслийг 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдөр **эргүүлэн татсан** бөгөөд одоогоор УИХ-ын БОХХАА-н Байнгын хороонд “Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл өргөн баригдсан болно.

УИХ-д өргөн барьсан “Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд дараах гурван зүйл бүхий өөрчлөлтийг тусгасан. Үүнд:

- Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д "газар эзэмших эрхийн гэрчилгээ" гэж энэ хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичгийг", 38 дугаар зүйлийн 38.1-д "Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно.", 38.5-д "Газар эзэмшигч нь газар эзэмших эрхээ Иргэний хуульд нийцүүлэн барьцаалж болох бөгөөд энэ тохиолдолд сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэнэ." гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл Газрын тухай хуулиар газар эзэмших эрхээ барьцаалж хөрөнгө босгох боломжийг газар эзэмшигчид олгосон.

- Гэвч газар эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр "газар эзэмших эрх"-ийг буюу газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд хуулийн дагуу "газар эзэмших эрх"-ийг барьцаалсан этгээдийн эрхийг хэрхэн хангах талаар хуульд тусгаагүй. Тиймээс барьцаалагчийн эрхийг хангах, хамгаалах зохицуулалтыг Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд нэмж тусгахаар боловсруулсан байна.

- Хуулийн төслийн нэгдүгээр зүйлээр барьцаалагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээг Газрын тухай хуулийн 40.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол уг гэрчилгээг барьцаалагч нь тухайн газар эзэмших эрхийн гэрчилгээгээр эзэмшиж байсан газрыг давуу эрхтэйгээр хуулийн 32.1, 32.2 дахь хэсэгт заасны дагуу эзэмших эрхтэй гэж заасан.

Барьцаалагч нь тухайн газар эзэмших эрхийн гэрчилгээгээр эзэмшиж буй газрыг зориулалтын дагуу эзэмшиж, аж ахуйн үйл ажиллагаа явуулдаггүй бол давуу эрхээ тухайн төрлөөр үйл ажиллагаа явуулдаг болон явуулах этгээдэд шилжүүлэх боломжийг мөн хуулийн төсөлд тусгасан. Учир нь газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалагч нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд заасан үйл ажиллагаанаас өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байж болно. Тухайлбал банк санхүүгийн байгууллага зөвхөн санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байх жишээтэй.


2/ Газар өмчлөлийн асуудал:

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2015 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 446004 иргэн 47840.58 га газар буюу Монгол Улсын нийт газар нутгийн 0.03 хувийг өмчилж авсан байна. Үүнээс:

- 445193 иргэн 47689.96 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй;
- 454 иргэн 4.2 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр нь;
- 326 иргэн 146.45 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр болон дуудлага худалдаагаар худалдаж авсан дүнтэй байна.

Газар өмчилж авсан иргэдийн тоог улсын нийт хүн амын тоонд харьцуулбал 14.6 хувьтай байна.


Зураг 1. Газар өмчилж авсан иргэдийн тоо /аймгаар/



2015 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 326 иргэн 146.45 га газрыг аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар өмчилж авсан байна. Үүнээс 270 иргэн 143.2 га газрыг давуу эрхээр худалдаж авсан бол 56 иргэн 3.25 га газрыг дуудлага худалдаагаар худалдаж авсан байна.

2015 онд улсын хэмжээнд нийтдээ 27333 иргэн 3189.8 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан байна.

Зураг 2. Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2015 онд газар өмчилж авсан байдал



Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл нийт Хөдөө аж ахуйн зориулалтаар олгогдсон газрын 125.4 га-г, хот тосгон, бусад суурин газрын зориулалтаар олгогдсон газрын 47715.2 га-г тус тус өмчлөх эрхтэйгээр олгосон байна.

Хүснэгт 1. Газрын нэгдмэл сангийн ангилал дахь өмчлөх эрх /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2015 оны байдлаар
1	Хөдөө аж ахуйн газар	Өмчлөгч	125.4
		Нийт олгогдсон Хөдөө аж ахуйн зориулалт бүхий газар	1280938.4
2	Хот, тосгон, бусад суурины газар	Өмчлөгч	47715.2
		Нийт олгогдсон хот тосгон, бусад суурин газар	400669.7

3/ Газар эзэмшүүлэх асуудал:

2015 оны байдлаар 425149 иргэн 5936081.4 га газар эзэмшиж байгаа бөгөөд энэ нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 3.8 хувийг эзлэж байна. 2015 оны байдлаар улсын хэмжээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад нийт 6190667.1 га олгогдсон бөгөөд олгогдсон газрын 96 хувь нь эзэмшил газар байна.

Хүснэгт 2. Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эзэмшиж буй газрын хэмжээ

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2015 оны байдлаар /га/
1	Хөдөө аж ахуйн газар	Эзэмшигч	1263781.7
		Нийт олгогдсон Хөдөө аж ахуйн зориулалт бүхий газар	1280938.4
2	Хот, тосгон, бусад суурин газар	Эзэмшигч	279127.4
		Нийт олгогдсон хот тосгон, бусад суурин газар	400669.7
3	Зам, шугам сүлжээний газар	Эзэмшигч	153512.9
		Нийт олгогдсон зам, шугам сүлжээний газар	172445.3
4	Ойн сан бүхий газар	Эзэмшигч	670590.9
		Нийт	676522.4
5	Усны сан бүхий газар	Эзэмшигч	85311.4
		Нийт	87533.9
6	Улсын тусгай хэрэгцээний газар	Эзэмшигч	34837570.0
		Нийт	3572557.6

Хүснэгт 3. Газар эзэмшигчийн ангилал /тоогоор/

№	Эзэмшигчийн ангилал	Газрын нэгдмэл сангийн ангилал					
		Хөдөө аж ахуйн газар	Хот, тосгон, бусад суурины газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Улсын тусгай хэрэгцээний газар
1	Иргэн	394449	217580	129	2555	20	342
2	Төрийн байгууллага	9211	7316	582	62	12	590
3	Аж ахуйн нэгж	21489	15596	1063	326	13	98
Бүгд		425149	240492	1774	2943	45	1030

4/ Газар ашиглуулах асуудал:

2015 оны байдлаар улсын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад нийт 6190667.1 га газрыг олгосон байх ба үүнээс 187434.6 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол Улсын иргэн, төрийн байгууллага 19310.5 га газрыг ашиглаж байна.

Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрыг урьд оны мөн үетэй харьцуулбал 2014 онд 5658111.8 га, 2016 онд 6190667.2 га болж 532555.4 га буюу 8.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Газрын нэгдмэл сангийн ангилал дахь ашиглаж буй газрын хэмжээ /га-аар/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2015 оны байдлаар
1	Хөдөө аж ахуйн газар	Бусдын эзэмшил газрыг ашиглагч	7425.5
		Ашиглагч	9605.6
		Нийт	1280938.4
2	Хот, тосгон, бусад суурин газар	Бусдын эзэмшил газрыг ашиглагч	5450.8
		Ашиглагч	68376.3
		Нийт	400669.7
3	Зам, шугам сүлжээний газар	Бусдын эзэмшил газрыг ашиглагч	6108.4
		Ашиглагч	12824.1
		Нийт	172445.3
4	Ойн сан бүхий газар	Ашиглагч	5931.5
		Нийт	676522.4
5	Усны сан бүхий газар	Ашиглагч	2222.5
		Нийт	87533.9
6	Улсын тусгай хэрэгцээний газар	Бусдын эзэмшил газрыг ашиглагч	325.9
		Ашиглагч	88474.6
		Нийт	3572557.6


Хүснэгт 5. Газар ашиглагчийн ангилал /тоогоор/

№	Эзэмшигчийн ангилал	Газрын нэгдмэл сангийн ангилал					
		Хөдөө аж ахуйн газар	Хот, тосгон, бусад суурины газар	Зам, шугам сүлжээний газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Улсын тусгай хэрэгцээний газар
<i>Бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол Улсын иргэн</i>							
1	Иргэн	757	47	-	-	-	647
2	Төрийн байгууллага	26	10	-	-	-	15
3	Аж ахуйн нэгж	167	121	11	-	-	14
	Бүгд	950	178	11	0	0	676
<i>Ашиглагч</i>							
1	Гадаадын иргэн болон харьяалалгүй хүн	57	56	-	-	-	-
2	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хуулийн этгээд	684	513	121	6	6	8
	Бүгд	741	569	121	6	6	8

5/ Тусгай хамгаалалттай, бэлчээрийн болон тариалангийн газрын талаар:

2015 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 73.51%, хот, тосгон бусад суурин газар 0.46%, зам, шугам сүлжээний газар 0.30%, ойн сан бүхий газар 9.16%, усны сан бүхий газар 0.44%, улсын тусгай хэрэгцээний газар 16.13%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 3. Газрын нэгдмэл санд үндсэн ангилал тус бүрийн эзэлж буй хувь



- Хөдөө аж ахуйн газар
- Хот, тосгон бусад суурины газар
- Зам, шугам сүлжээний газар
- Ойн сан бүхий газар
- Усны сан бүхий газар
- Улсын тусгай хэрэгцээний газар

Хөдөө аж ахуйн газрын хувьд 2015 оны байдлаар бэлчээрийн газар 96.20%, хадлангийн талбай 1.49%, тариалангийн газар 0.89%, атаршсан газар 0.27%, ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар 0.06%, ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар 1.10%-ийг тус тус эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газрын тоо мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газрын хэмжээ 25.80 мянган га-аар хасагдаж, бэлчээрийн газар 33.09 мянган га, ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар 2.45 мянган га-аар хасагдаж, хадлангийн талбай 0.09 мянган га, тариалангийн газар 15.36 мянган га, атаршсан газар 0.05 мянган га-аар тус

тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 5.1/


Хүснэгт 6. Газрын нэгдмэл сангийн ангилал (2012-2015) /мян.га/

Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	2014	2015	2014-2015 зөрүү /мян. га/
Хөдөө аж ахуйн газар	115399.9	115361.4	115008.6	114982.8	-25.80
Бэлчээрийн газар	111032.5	111026.1	110646.7	110613.6	-33.09
Хадлангийн талбай	1712.3	1712.3	1717.6	1717.7	0.09
Тариалангийн газар	1031.1	986.8	1012.8	1028.2	15.36
Атаршсан газар	292.0	304.9	304.9	305.0	0.05
ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	70.3	71.4	76.8	74.4	-2.45
ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1261.6	1259.7	1259.7	1259.7	0.00
Хот, тосгон бусад суурины газар	702.0	699.6	712.1	716.9	4.76
Барилга, байгууламжийн дэвсгэр газар	86.6	73.1	75.3	74.4	-0.94
Нийтийн эдэлбэр газар	318.1	330.1	330.3	326.8	-3.51
Үйлдвэрийн газар	31.1	40.4	41.1	41.4	0.27
Уурхайн газар	215.1	200.9	206.2	207.6	1.42
Гэр хорооллын газар	51.2	54.5	59.3	66.7	7.41
Зам, шугам сүлжээний газар	435.2	437.3	454.8	462.5	7.73
Авто замын газар	319.1	319.7	319.7	332.3	2.59
Төмөр замын газар	27.8	27.8	29.9	31.0	1.12
Агаарын тээврийн газар	9.0	8.8	8.9	8.9	-0.01
Шугам, сүлжээний газар	79.3	80.8	86.25	90.3	4.13
Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0	0.0	0.0
Ойн сан бүхий газар	14256.6	14295.4	14320.5	14334.4	13.93
Ой модоор бүрхэгдсэн газар	12100.9	12138.6	12181.3	12188.2	6.91
Ой модыг нь огтолсон газар	142.2	142.4	142.0	142.2	0.23
Мод үржүүлгийн газар	45.6	46.5	50.9	57.7	6.78
Ой тэлэн ургах нөөц газар	755.1	744.0	743.6	743.6	0.04
Ойн сангийн бусад газар	1212.7	1223.7	1202.7	1202.7	-0.04

Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	2014	2015	2014-2015 зөрүү /мян. га/
Усны сан бүхий газар	686.8	686.8	686.7	686.1	-0.63
Гол мөрний эзлэх газар	228.6	228.5	228.5	228.5	-0.04
Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	444.7	444.7	444.3	443.6	-0.67
Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	12.4	12.4	0.01
Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.1	1.1	1.6	1.6	-0.02
Улсын тусгай хэрэгцээний газар	24931.1	24931.1	25228.9	25228.9	0.00
Улсын тусгай хамгаалалттай газар	20948.3	20948.3	21140.9	21140.9	0.00
Улсын хилийн зурвас газар	3111.9	3111.9	3112.0	3112.0	0.00
Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	124.1	124.1	0.00
Гадаад, дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0	0.0	0.00
ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	22.9	22.9	23.0	23.0	0.00
Аймаг дундын отрын бэлчээр	586.2	586.2	691.4	691.4	0.00
Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	110.9	110.9	0.00
Газрын тосны гэрээт талбай	24.4	24.4	24.5	24.5	0.00
Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	2.1	2.1	0.00
Нийт дүн	156411.6	156411.6	156411.6	156411.6	0.00

Эх сурвалж: Газрын нэгдмэл сангийн 2013-2015 оны Улсын нэгдсэн тайлан, ГХГЗЗГ

Зураг 4. Монгол Улсын нийт газар нутгийн УТХГ, бэлчээр, тариалангийн газрын эзэлж буй үзвэл



Тусгай хамгаалалттай газар нутгийн хувьд 2015 оны байдлаар Улсын тусгай хэрэглээний газар нийт нутаг дэвсгэрийн 16.13%-ийг эзэлж байгаагаас 83.8%-ийг Улсын тусгай хамгаалалттай газар нутаг буюу нийт нутаг дэвсгэрийн 13.52%-ийг эзэлж байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 51.65%-ийг дархан цаазтай газар, 38.30%-ийг байгалийн цогцолборт газар, 9.67%-ийг байгалийн нөөц газар, 0.38%-ийг дурсгалт газар тус тус эзэлж байна.

Монгол Улсын нийт газар нутгийн 13.52%-ийг Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 70.72%-ийг бэлчээр, 0.66%-ийг тариалангийн газар тус тус эзэлж байна.


Улсын тусгай хамгаалалтын газрын тоо мэдээг өмнөх оны дүнтэй харьцуулбал өөрчлөлт ороогүй, байгалийн нөөц газрын хэмжээ 2013-2014 онд 192.5 мянган га-аар нэмэгдсэн байна. /Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 50-р тогтоолоор Говь-Алтай аймгийн Халиун, Цээл сумдын нутагт орших Хар Арзаргын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хэрэгцээний газарт бэлчээрийн газраас 192.5 мянган га газрыг авсан./

Хүснэгт 7. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал тус бүрийн эзэлж буй хэмжээ (2013-2015) /мян.га/

Тайлант он	Улсын тусгай хэрэгцээний газар	Улсын ТХГН	Үүнээс			
			Дархан цаазат газар	Байгалийн цогцолборт газар	Байгалийн нөөц газар	Дурсгалт газар
2015	25228.9	21140.9	10919.4	8097.8	2044.6	79.3
2014	25228.9	21140.9	10919.4	8097.8	2044.6	79.3
2013	24931.1	20948.3	10919.4	8097.8	1851.8	79.3

Эх сурвалж: Газрын нэгдмэл сангийн 2013-2015 оны Улсын нэгдсэн тайлан, ГХГЗЗГ
Эх сурвалж: <http://mpa.gov.mn/>

Зураг 5. Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ



6/ Газрын сангийн нэгдмэл бодлого зохицуулалтын хүрээнд холбогдох байгууллагуудаас хийсэн ажлын талаарх мэдээлэл:

Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2015 Улсын нэгдсэн тайлан, Байгаль орчин, хөдөө аж ахуйн Байнгын хорооны 2015 оны 7-р сарын 07-ны өдрийн хуралдаанд БОНХЯЖЯ-ны Газрын нөөцийн зохицуулалтын хэлтэс зэрэг холбогдох төрийн байгууллагуудаас гаргасан ном, илтгэлийг судалгаанд хавсаргав.

7/ Нийслэл хот, аймаг орон нутагт газар өмчлөл хэрхэн явагдаж байгаа талаар:


2003-2015 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 446004 иргэн 47840.58 га газрыг өмчилж авсан байна. Үүнээс:

- 445193 иргэн 47689.96 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй;
- 454 иргэн 4.2 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр нь;
- 326 иргэн 146.45 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр болон дуудлага худалдаагаар үнээр нь худалдаж авсан дүнтэй байна.

Үүнээс **Улаанбаатар хотод газар өмчлөлийг** дараах үе шаттайгаар явуулсан байна. Үүнд:

1/ Хууль батлагдсан 2003 оноос хойш 2013 оны хүртэлх 10 жилийн хугацаанд нийслэлийн хэмжээнд нийт 96583 иргэн 5057.11 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэ төлбөргүйгээр олгосон байна.

Зураг 6. Нийслэлийн хэмжээнд 2003-2013 онд гэр бүлийн хэрэгцээнд газар өмчилж авсан газрын хэмжээ болон иргэний тоо



2/ 2014-2016 оны хооронд 15309 га газрыг иргэдэд өмчлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2014 оны 8 дугаар сараас 1-нээс эхлэн нийслэлийн 5 байршилд газар өмчлүүлэх ажлыг цахим хэлбэрээр явуулахаар зохион байгуулсан байна.


- 1-р ээлжийн газар өмчлүүлэх ажлын хүрээнд нийслэлд бүртгэлтэй 13523 иргэнд 1524 га газрыг өмчлүүлсэн.
- 2-р ээлжийн цахим хэлбэрээр газар өмчлүүлэх ажил 2016 оны 01 сарын 26-наас 2016 оны 02 сарын 09-ний хооронд явагдсан бөгөөд нийт 13819 иргэнд 2875 га газрыг өмчлүүлсэн байна.

Нийслэлийн хэмжээнд нийт өмчлүүлэхээр баталсан 15309 га газраас 1, 2-р цахим хэлбэрийн өмчлүүлэх ажлаар нийт 4399 га газрыг нийслэлд бүртгэлтэй иргэдэд өмчлүүлээд байна.

Аймгуудын газар өмчлүүлэх явцыг авч үзвэл: 2015 оны байдлаар газар өмчилж авсан иргэдийн тооны өсөлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр харьцуулан үзвэл Сэлэнгэ аймаг 9468, Төв аймаг 5861 иргэн, Дундговь аймаг 1540 иргэн, Хэнтий аймаг 1515 иргэн, Өмнөговь аймаг 1070 иргэнд тус тус газар өмчлүүлсэн байгаа нь аймгуудын хувьд өндөр дүнтэй байна.

Газар өмчилж авсан иргэдийн жилийн өсөлтийг хүн амтай нь харьцуулан хувиар тооцон үзвэл, Сэлэнгэ аймаг 11.67%, Төв аймаг 10.46%, Дорнод аймаг 7.12%, Дундговь аймаг 5.28%, Дорноговь аймаг 4.0%-тай байна.

Зураг 7. Нийслэл хот, аймгуудад газар өмчилж авсан иргэдийн жилийн өсөлт /хувиар/



Газар өмчлүүлэх ажил эхэлснээс хойш 2015 оны эцсийн байдлаар газар өмчлөлийн явцад нийт хүн амын 14.83% нь газар өмчилж авсан байна.

Хүснэгт 8. Газар өмчлөлийн явц

Аймаг	Хүн ам (2015)	Газар өмчилсөн иргэд /тоогоор/	Газар өмчлөлийн явц /хувь/
Архангай	92,059	13,679	14.86%
Баян-Өлгий	100,189	9,797	9.78%
Баянхонгор	83,936	10,322	12.30%
Булган	60,014	12,414	20.69%
Говь-Алтай	56,209	5,908	10.51%
Говьсүмбэр	16,522	6,241	37.77%
Дархан-Уул	100,939	12,447	12.33%
Дорноговь	65,267	13,636	20.89%
Дорнод	76,476	31,620	41.35%
Дундговь	44,429	8,705	19.59%
Завхан	69,916	6,203	8.87%
Орхон	100,731	17,324	17.20%
Өвөрхангай	112,353	20,147	17.93%
Өмнөговь	61,655	23,643	38.35%
Сүхбаатар	59,034	8,760	14.84%
Сэлэнгэ	106,292	35,442	33.34%
Төв	90,421	37,779	41.78%
Увс	80,763	9,560	11.84%
Ховд	83,517	11,115	13.31%
Хөвсгөл	128,159	11,496	8.97%
Хэнтий	72,609	17,634	24.29%

Аймаг	Хүн ам (2015)	Газар өмчилсөн иргэд /тоогоор/	Газар өмчлөлийн явц /хувь/
Нийслэл	1,345,500	122,114	9.08%
Нийт	3,006,990	445,986	14.83%

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “2015 оны газрын нэгдмэл сан Улсын нэгдсэн сан”, УБ 2016 он, ГХГЗЗГ
- www.mne.mn
- www.gazar.gov.mn
- www.1212.mn
- www.umch.ub.gov.mn

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Г. Алтан-Оч (PhD)

Ногдол ашгийн бодлого гэж юу вэ?

Ногдол ашгийн бодлого гэж өнөө үед бэлэн мөнгөөр ногдол ашиг хүртээх буюу ирээдүй үед нэмэгдсэн хэмжээтэй ногдол ашиг тараах талаарх санхүүгийн бодлогыг хэлнэ.⁵⁵ Ногдол ашиг хүртээх эсэх, хэр хэмжээтэй тараах нь ихэвчлэн компанийн зориулагдаагүй (чөлөөт) ашиг (бэлэн мөнгөний хэтрэлт)-ийн хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд уг компанийн урт хугацаан дахь орлогын хүчин чадлаас шалтгаалдаг. Хэрэв илүүдэл бэлэн мөнгө байгаад түүнийг зарцуулах шаардлагагүй бол компанийн удирдлага тэрхүү орлогын зарим хэсгийг буюу бүхэлд нь бэлэн мөнгө хэлбэрээр ногдол ашгийн зориулалтаар хуваарилах буюу хувьцаагаа эргүүлэн авах хөтөлбөрийн хүрээнд өөрийн компанийн хувьцааг худалдаж авахаар шийдвэрлэдэг.

Хэрэв ӨХ⁵⁶ (өнөөдрийн ханш, өнөөгийн цэвэр өртөг, өнөөгийн үнэ цэнэ) эерэг бус байдалтай, өөрөөр хэлбэл төслийн орлого нь босго ханшнаас⁵⁷ давсан бөгөөд хэтэрсэн бэлэн мөнгийг зарцуулах шаардлагагүй бол санхүүгийн онол ёсоор удирдлага нь бэлэн мөнгөний хэтрэлтийн тодорхой хэсгийг буюу бүгдийг хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хэлбэрээр өгөх нь зүйтэй. Энэ бол ерөнхий тохиолдол боловч эс хамаарах ч бий. Жишээлбэл, “өсөлттэй хувьцаа”-ны хувьцаа эзэмшигчид нь бэлэн мөнгөний хэтрэлтийн ихэнхийг компанийн ирээдүйн өсөлтийг хангахад зориулан дотооддоо хөрөнгө оруулахыг хүсдэг. Ингэж хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд өсөлттэй компанийн удирдлага нь өнөөгийн төслийн хөрөнгө оруулалтын дүнд ирээдүйд авах ногдол ашиг нь пропорционалиар (шууд хамааралтай) өсөж, өнөөгийн орлого болон дотоод санхүүжилт хэвээр хадгалагдах болно гэдэгт найдаж байдаг.

Компанийн удирдлага ногдол ашиг тараах бол ямар хэлбэрээр түгээхээ шийднэ. Ерөнхийдөө бэлэн мөнгө авах эсвэл хувьцаа буцаан худалдан авах хэлбэртэй байна. Ногдол ашиг бэлэн мөнгөөр тараахад ногдол ашгийн татвар ногдуулдаг учраас орлогоо үлдээх буюу хувьцааны хэлбэрийг сонгодог компани олон байдаг. Аль ч тохиолдолд компанийн байгаа хувьцааны үнэ цэнэ нэмэгдэх юм. Үүнтэй адилаар зарим компаниуд гаргасан хувьцаанаасаа “ногдол ашиг” тараадаг ч тохиолдол бий.

Санхүүгийн онолоор, ногдол ашиг хуваарилах эсэх асуудлаар компанийн бизнесийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч компанийн удирдлага нь хувьцаа эзэмшигч болон компанид ашигтай байхаар чухам аль хувилбарыг сонгохыг шийднэ. Ерөнхий дүрэм бол, өсөлттэй компанийн хувьд хэтэрсэн орлогоо хадгалан үлдэх ба хувьцаа эзэмшигч нь үнэ цэнэтэй буюу хоёрдогч хувьцаатай компанийн хувьд ногдол ашиг хуваарилах зарчмыг баримтлах нь зүйтэй.

⁵⁵ Ногдол ашгийн бодлого-Dividend policy

⁵⁶ NPV (Net Present Value)

⁵⁷ Hurdle rate-англиар

Үзэл баримтлал

Ногдол ашгийн бодлогын асуудал нь захирлууд болон санхүүгийн менежерүүдэд тодорхой сорилтыг авч ирдэг. Яагаад вэ гэвэл, хөрөнгө оруулагч болгон өнөөгийн бэлэн мөнгөний ногдол ашиг болон ирээдүйн хөрөнгийн өсөлтийн талаар өөр өөрийн үзэл бодолтой байдаг. Түүнээс гадна бас нэгэн ташаа ойлголт бол нэгж хувьцааны үнэд ногдол ашгийн үзүүлэх нөлөөний хир хэмжээний талаарх алдартай хэлц байдаг. Иймээс ногдол ашгийн бодлогын энэхүү эсрэг тэсрэг мөн чанарыг “ногдол ашгийн таавар” гэж хүртэл нэрлэсэн байдаг.

Компаниудад туслах зорилгоор дүн шинжилгээ болон оновчтой бодлогын хувилбар боловсруулах янз бүрийн загваруудыг хөгжүүлсэн боловч эдгээр сургуулиудын дунд нэгдмэл ойлголтод хүрч чадаагүй өдийг хүргэжээ.

Нэг сургуульд нь Жэймс Валтер болон Мырон Гордон нарын хүмүүс багтах бөгөөд тэд өнөөгийн бэлэн мөнгөний ногдол ашгийг ирээдүйн үндсэн хөрөнгийн өсөлтөөс бага эрсдэлтэй гэж үздэг. Тиймээс тэд тогтмол ногдол ашиг төлж, тэгсэнээр хувьцааны зах зээлийн үнэд нөлөөлдөг компаниудад хөрөнгө оруулах нь зүйтэй гэж зөвлөдөг. Модиглиани болон Милер нарын хамрагддаг нөгөөх сургууль нь ирээдүйн өсөлт болон бэлэн мөнгөний ногдол ашгийн хооронд үнэндээ сонголт хийх шаардлагагүй гэж үздэг.

Ногдол ашгийн бодлогын ач холбогдол

Ногдол ашиг хуваарилахад хөрөнгө оруулагч болон компани аль аль нь эерэгээр ханддаг. Харин ч ногдол ашиг хуваариладаггүй компанийг хувьцааны үнэд нөлөөлнө гэж үзээд хөрөнгө оруулагчид эсрэгээр үнэлдэг. Ногдол ашгийн ач холбогдлыг үнэлдэг эдгээр хүмүүс нь тогтмол ногдол ашиг хуваарилдаг компани нь хөрөнгө оруулагчийн үл итгэх байдлыг бууруулдаг бөгөөд жишээлбэл, компанийн орлогын хорогдуулалтын хувь хэмжээ (k_e) буурч, ингэснээр зах зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ гэж үздэг. Харин ч ногдол ашиг олгохгүй байх нь яг эсрэгээрээ үл итгэх байдлыг нэмэгдүүлдэг.

Ногдол ашгийн ач холбогдолд чиглэсэн хоёр чухал загварыг Валтер, Гордон нар санал болгосон байдаг.

Валтерийн загвар

Валтерийн загвар нь ногдол ашиг болон түүний хувьцааны үнэ цэнэд тархах ач холбогдлыг харуулдаг.

Валтерийн загварт авч үздэг нөхцөлүүд гэвэл:

1. Үлдээж авч үлдсэн орлого нь компанийн хөрөнгө оруулах цорын ганц эх үүсвэр бөгөөд гадаад санхүүжилт огт байхгүй.
2. Үндсэн хөрөнгийн зардал- k_e ба хөрөнгө оруулалтын өгөөж-г тогтмол байх. Өөрөөр хэлбэл, шинээр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гарсан ч бизнесийн эрсдэл хэвээр байх.
3. Компанийн амьдралын цикл хязгааргүй, өөрөөр хэлбэл хаагдахгүй. Үндсэндээ ногдол ашиг хуваарилах, эс хуваарилах тухай шийдвэр нь үлдээсэн орлогоор хангалттай хөрөнгө оруулалт хийх боломж байгаа эсэхээс хамаарна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт болон ногдол ашгийн хоорондох хүчтэй хамаарлыг шийдвэр гаргахдаа анхаарч үзнэ гэсэн үг.

Валтерийн загварыг тэнцэтгэлээр илэрхийлбэл:

- Хэрэв $r > k_e$ бол компани тэг төлбөр хийх ба хөрөнгө оруулна.
- Хэрэв $r < k_e$ бол компани 100% төлбөр хийх ба үлдээсэн орлогоор хөрөнгө оруулахгүй.
- Хэрэв $r = k_e$ бол компанийн хувьд ногдол ашиг болон хөрөнгө оруулалтын хооронд ялгаа байхгүй.

Шүүмжлэл. Энэхүү загвар нь хувьцааны зах зээлийн үнэ цэнэ болон ногдол ашгийн бодлогын уялдаа холбоог маш энгийн байдлаар хялбархан ойлгогдохоор тайлбарласан боловч үнэндээ амьдралд хэрэгжих боломж тун тааруу юм. Үүнд:

1. Үлдээсэн орлогоос өөр санхүүгийн гадаад эх үүсвэр ашиглахгүй гэсэн нөхцөл нь компани цаашид хөрөнгө оруулалт хийх тул бодит практикт үл хэрэгжинэ.
2. Үзүүлэлтүүд болох r ба k_e нь тогтмол байна гэдэг амьдралд маш ховор тохиолддог, учир нь компанид хөрөнгө оруулалт хийгдэх бүрт бизнесийн эрсдэл өөрчлөгдөж байдаг.

Гордоны загвар

Мырон Гордон нь ногдол ашгийн ач холбогдлыг өндрөөр үнэлдэг бөгөөд байнга ногдол ашиг хуваарилах нь компанийн хувьцааны үнэд нөлөөлнө гэж үздэг.

Гордоны загварт өвч үздэг нөхцөлүүд гэвэл:

Гордоны загварын нөхцөлүүд нь Валтерийнхтай адил төстэй боловч нэмэлт хоёр нөхцөл санал болгосон байдаг. Үүнд:

1. Улираан барих хувь хэмжээ b болон ХОӨ r хоёрын үржвэр нь компанийн өсөлтийн хувь хэмжээ g болно.
2. ҮХЗ k_e нь тогтмол биш бөгөөд ΘX -иас өндөр байна, өөрөөр хэлбэл $k_e > g$.

Хөрөнгө оруулагчид эрсдлийг үзэн яддаг бөгөөд ногдол ашгийн орлого нь ирээдүйн хөрөнгийн өсөлтийн орлогоос илүү найдвартай гэж үздэг. Тийм учраас тэд ирээдүйн хөрөнгийн өсөлтийг эрсдэлтэй алхамд тооцдог. Тэд ирээдүйн хөрөнгийн өсөлтийг компанийн орлоготой харьцуулахад илүү өндөр хувиар хорогдуулалт хийхээр тооцож, үр дүнд нь хувьцааны үнэ цэнэ өндөр байна гэж үздэг. Товчоор хэлбэл, хэрэв УБХ b өсвөл хорогдуулалтын хувь⁵⁸ илүү өндөр байх ёстой гэж шаардана.

Тиймээс энэ загвар нь төлбөрийн хувь хэмжээ (УБХ), ХОӨ, ҮХЗ болон хувьцааны зах зээлийн үнийн хоорондын хамаарлыг харуулдаг.

Валтер болон Гордоны загварын дүгнэлт. Гордоны санаа нь Валтерийнхтай төстэй учир шүүмжлэл нь мөн адил ижил юм. Хоёул ногдол ашгийн бодлого болон компанийн зах зээлийн үнэ цэнийн хоорондох хамаарлыг ойлгомжтой тодорхойлсон байна.

⁵⁸ Discount rate-англиар

Үндсэн хөрөнгийн бүтцийн орлуулалтын онол ба ногдол ашиг

Үндсэн хөрөнгийн орлуулалтын онол⁵⁹ (ҮХОО) нь хувьцаат компаниудын орлого болон зах зээлийн үнэлгээ⁶⁰, үндсэн хөрөнгийн бүтцийн⁶¹ харилцан хамаарлыг тодорхойлдог. Уг онол нь доорх энгийн нэгэн гипотезид үндэслэгдсэн байдаг. Үүнд:

Компанийн удирдлага нь нэгж хувьцаанд оногдох орлогыг (НХОО)⁶² хамгийн өндөр (максимум) байхаар бодож овжин арга хэрэглэн үндсэн хөрөнгийн бүтэц бий болгоно. Үүний үр дүнд бий болох өр-капиталын⁶³ динамик үзүүлэлтээс хамаарч ногдол ашиг өгөх, эс өгөхийг шийднэ. Хэрвээ хувьцаа эзэмшигч нарт бэлэн мөнгө хуваарилахаар шийдсэн бол компанийн удирдлага нь одоо ногдол ашгаар уу, эсвэл хувьцаа эргүүлэн худалдаж авах аргаар уу гэдгийг шийднэ. Гэвч ногдол ашгийн татвар нь ихэнхдээ үндсэн хөрөнгийн өсөлтийн хэмжээнээс өндөр байдаг тул хөрөнгө оруулагчид үндсэн хөрөнгийн өсөлтийг илүүд үзэх хандлагатай байдаг. Гэлээ ч ҮХОО-оос харахад, зарим компаниудын хувьд хувьцаа эргүүлэн худалдаж авах нь НХОО-ыг бууруулахад хүргэдэг. Тиймээс эдгээр компаниуд нь хувьцаа эргүүлэн авах гэдгээс илүүтэй ногдол ашгийг сонгодог байна.

ҮХОО-ыг баримталбал, өргүй компаниуд эргүүлэн худалдан авахыг зорих бол харин өр-капиталын харьцаа ихтэй компаниуд ногдол ашгийг буюу хувьцаа эзэмшигч нарт бэлэн мөнгө тараахыг сонгох хэрэгтэй.

Туршлага дээр үндэслэсэн судалгаанаас үзэхэд, үнэлгээ доогууртай болон санхүүгийн хараат байдал дээгүүртэй, хязгаарлагдмал хөрөнгө оруулалтын боломжтой болон ашиг ихтэй компаниуд хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгө тараах нь зүйтэй юм.

Дүгнэлт. ҮХОО нь компанийн удирдлагад ногдол ашгийн бодлогын талаар Валтер болон Гордоны загвараас илүү гарын авлага болохуйц юм. Компанийн үнэлгээний үзүүлэлт нь ногдол ашгийн бодлогоо жолоодно гэдэг утга санаа агуулсан зүйл болон үйлчлэлийн уламжлалт дарааллыг мөн энэхүү онол урвууллаа, эсрэгээр нь биш. Уг онол нь капиталын эрсдлийн үнэлгээ⁶⁴ болон хорогдуулалтын хувь⁶⁵, хүлээгдэж буй өсөлтийн хувь⁶⁶, хүлээгдэж буй инфляци зэрэг 'үл үзэгдэх' буюу 'нууцлагдмал' үзүүлэлтүүд агуулаагүй байна. Үр дагавар нь: уг онолыг хоёрдмол утгагүйгээр⁶⁷ шалгаж, туршиж болно.

Ногдол ашгийн бодлогын үл хамаарал

Модиглиани болон Милер нарын бодлогын сургууль бол хөрөнгө оруулагч ногдол ашиг болон үндсэн хөрөнгийн өсөлтийн хооронд илүүд үзэх шаардлагагүй гэж итгэдэг. Тэд ногдол ашиг бол зах зээлийн үнэлгээнд үл хамаарах⁶⁸ бөгөөд түүнийг тодорхойлохгүй гэж үздэг. Тиймээс ногдол

⁵⁹ Capital structure substitution theory-англиар

⁶⁰ Stock price-англиар

⁶¹ Capital structure-англиар

⁶² Earnings-per-share (EPS)-англиар

⁶³ Debt-equity target-англиар

⁶⁴ Equity risk premium-англиар

⁶⁵ Discount rate-англиар

⁶⁶ Expected growth rate-англиар

⁶⁷ Unambiguous way-англиар

⁶⁸ irrelevant-англиар

ашгийн хоёр хувилбарын хооронд хөрөнгө оруулагчид ялгаагүй юм. Энэхүү хандлагатай холбоотой доорх хоёр нөхцөлийг авч үздэг. Үүнд:

1. Санхүүжилт болон хөрөнгө оруулалтын талаарх шийдвэр нэгэнт гарсан бол ногдол ашиг авах хэмжээнээс хамааран үл өөрчилнө.
2. Хэрэв хөрөнгө оруулагч нь шилжүүлгийн зардал гаргахгүйгээр хувьцааг авах болон худалдах бөгөөд компани нь хөвөх зардал гаргахгүйгээр хувьцаа гаргаж байвал үүнийг жинхэнэ хөрөнгийн зах зээл гэж нэрлэдэг.

Үл хамаарлын хандлагатай холбоотой үлдэгдлийн онол болон Модиглиани, Милерийн хандлага гэсэн хоёр чухал онол байдаг.

Ногдол ашгийн үлдэгдлийн онол

Энэхүү онолд харгалзаж үздэг нэг нөхцөл бол гадаад санхүүжилтээр эргэн хөрөнгө оруулах боломжгүй, эсвэл ашигтай боломжинд хөрөнгө оруулах нь хэтэрхий зардалтай юм. Хэрэв компанид боломжийн хөрөнгө оруулах боломж байвал ногдол ашгаа бууруулах буюу огт өгөхгүйгээр үлдэгдэл орлогоор хөрөнгө оруулах нь зүйтэй. Ийм боломж байхгүй бол компани ногдол ашиг тараах нь зүйтэй.

Хэрэв компани хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа гаргаж байгаа бол хөвөх зардал байдаг учраас олон тооны хувьцаа гаргах шаардлагатай болдог. Тиймээс хөвөх зардал нь ашгаас хэрэглэх хэмжээг нэмэгдүүлэх учраас ногдол ашиг хуваарилах эсэх нь зорьсон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсний дараа үлдэх ашгаас хамаарна. Энэхүү зорьсон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлээд хаягдсан ашгийн үлдэгдлийг ногдол ашиг гэдгийг үлдэгдлийн онол гэнэ.

Үлдэгдлийн шийдвэрийг 3 үе шаттай гаргадаг. Үүнд:

- боллоцоот хөрөнгө оруулалтын боломжийг үнэлж хөрөнгийн зардлыг тогтоох.
- хөрөнгө оруулалтад шаардагдах санхүүгийн хөрөнгийн хэмжээг үнэлж оновчтой санхүүгийн хольцын⁶⁹ суурьтай болох.
- үлдээсэн орлогын зардал<шинэ хувьцааны хөрөнгийн зардал. Ингэснээр үлдээсэн ашгийг хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зарцуулна. Хэрэв санхүүжилт хийсний дараа илүүдэл гарвал ногдол ашиг хуваарилна.

Онолын өргөтгөл

Ногдол ашгийн бодлого хоёр зүйлээс хүчтэй хамаардаг. Үүнд:

- компанид хөрөнгө оруулалт хийх боломжтой байдал
- дотоодын хэрэгцээнд үлдээсэн болон босгосон сангийн⁷⁰ хэмжээ, улмаар бүх боломжит хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсний дараах ногдол ашиг хуваарилалт

Ногдол ашгийн бодлого нь пассив учраас зах зээлийн үнэд нөлөөлөхгүй. Ногдол ашиг мөн байнга хэлбэлзэж байдаг учир нь жил бүр хөрөнгө оруулалтын өөр өөр боломж байдаг. Үнэн хэрэгтээ энэ нь хөрөнгө оруулагчдад огт хамаагүй юм, учир нь тэрээр ирээдүйн хөрөнгийн өсөлтийн хэлбэрээр нөхөн төлбөрийн шим хүртэх болно.

⁶⁹ Finance mix-англиар

⁷⁰ Generated fund-англиар

Дүгнэлт. Компани хэдийгээр ногдол ашиг төлж байгаа ч хөрөнгө оруулагчийн орлого өсөх нь маргаангүй юм. Учир нь компани хэдийгээр зарим хөрөнгө оруулалт хийсэн ч энэхүү ашигтай хөрөнгө оруулалт нь хожмын өдөр хөрөнгө оруулагчийн орлогыг нэмэгдүүлэх болно.

Модиглиани-Милерийн теорем

Модиглиани-Милерийн теорем нь үлдээсэн орлогыг шинэ хөрөнгө оруулалт болон бногдол ашиг гэж хуваах нь компанийн үнэлгээнд нөлөөлөхгүй гэж үздэг. Энэ нь хөрөнгө оруулалтын загвар бөгөөд үр дүнд нь компанийн олох орлого хувьцааны үнэд буюу зах зээлийн үнэлгээнд нөлөөлнө.

Энэхүү загвар дахь ногдол ашгийн үл хамаарал оршин буй тул ногдол ашиг төлөх болон үлдээсэн орлогоор хөрөнгө оруулах эсэх нь хөрөнгө оруулагчид огт ялгаагүй юм. Компани үлдээсэн орлого буюу шинээр хувьцаа гаргаж хөрөнгөө өсгөх замаар боломжуудаа санхүүжүүлдэг. Ногдол ашигт төлсөн мөнгө нь эргээд шинэ хувьцаа гаргах замаар өсгөсөн шинэ хөрөнгөөр нөхөгдөж байдаг. Энэ нь компанийн үнэлгээнд эсрэгээр нөлөөлдөг. Ногдол ашгийн улмаас өссөн үнэлгээ нь шинэ хөрөнгийн өсөлтийн улмаас буурсан үнэлгээтэй балансалдаг.

Ногдол ашиг тогтворжуулах бодлого

Ногдол ашгийн үлдэгдлийн бодлогод илэрдэг ногдол ашгийн хэлбэлзэлтэй харьцуулахад тогтворжуулах бодлогын ногдол ашгийн баталгаатай байдал нь мэдэгдэхүйц ялгаатай юм.⁷¹ Тогтворжуулалтын бодлогын хувьд жилийн орлогын тодорхой хэсгийг улирал тутам ногдол ашиг хэлбэрээр тараадаг. Энэ бодлого нь хөрөнгө оруулагчийн үл итгэх байдлыг үгүй хийж түүнийг орлоготой байлгадаг.

Энэ бодлогыг баримталдаг компаниуд нь илүүдэл бэлэн мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийхээр эрж хайх бус харин олсон орлогоо илүүтэй хувьцаа эзэмшигчидтэйгээ хуваах эрмэлзэлтэй байдаг.

Гибрид ногдол ашгийн бодлого

Сүүлчийн энэхүү хандлага нь үлдэгдлийн болон тогтворжуулалтын бодлогыг хослуулах явдал юм. Энэ хандлагыг хэрэглэсэн компани нь өр-хөрөнгийн харьцааг богино хугацааны гэхээсээ илүүтэй урт хугацааны зорилт болгох эрмэлзэлтэй байдаг. Өнөөгийн зах зээлд ногдол ашиг төлдөг компани нь ихэвчлэн энэ хандлагыг ашигладаг. Эдгээр компаниуд нь бизнесийн мөчлөгийн хэлбэлзэлтэй байдаг бөгөөд ерөнхийдөө жилийн орлогын харьцангуй бага хэмжээнд оногдох нэг хэсэг ногдол ашиг тогтоодог. Энэхүү ногдол ашиг дээр нэмээд жилийн эцсээр дүгнэсэн бодит илүүдэл орлогод оногдох нэмэлт ногдол ашгийг тогтоож олгодог.

Монгол Улсын хуульд ногдол ашгийн талаар хэрхэн туссан бэ?

2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан Монгол Улсын Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын Тавдугаар бүлэгт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаасны талаар тусгажээ.

⁷¹ Ногдол ашгийн бодлого-Dividend Policy, Investopedia <http://www.investopedia.com/walkthrough/corporate-finance/5/dividends/policy.aspx>

Үүнд:

- 30.1. Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 35.1. Бүх төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараах эрхэд эзлэнэ:
 - 35.1.1. эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжид авах;
 - 35.3. Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн худалдаж авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг худалдаж авсны дараа энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авах, түүнд ногдол ашиг төлөх эрхтэй болно.
- 46.7. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 46.9. Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно.
- 47.3. Компани нь дараах нөхцөлд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:
 - 47.3.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

Эндээс үзэхэд, манай оронд хэрэгжиж буй уул уурхайн мега төслүүдэд Монгол Улсын Засгийн газрын эзэмшиж буй хувьцаа нь давуу эрхийн хувьцааны хэлбэртэй байж болох бөгөөд ингэснээр ногдол ашгийг тэргүүн ээлжид авах, ногдол ашгийг компанийн хувьцааны хэлбэрээр төлүүлэх, давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгуулах зэрэг давуу талтай юм.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖООР ЖУРАМЛАН
ЗОХИЦУУЛАХААР ЗААСАН БИЗНЕС-ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬЧИЛСАН АКТУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА
МЭДЭЭЛЭЛ**

*Ч.Онончимэг, Д.Халиун, Б.Нандингэрэл,
Т.Саулегүл, И.Жаргалзаяабямба*

Судалгаанд аж ахуйн нэгж, бизнес эрхэгчдийн үйл ажиллагааны эрх зүйн орчны хүрээнд Монгол Улсын хууль, тогтоомжоор журамлан зохицуулахаар заасан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн актууд, тэдгээрийг дагаж гарсан дүрэм, журам, зааврын талаарх“ Монгол Улсын хууль, тогтоомжоор журамлан зохицуулахаар заасан бизнес-эдийн засгийн харилцааг зохицуулж буй хуульчилсан актуудын талаарх лавлагаа мэдээлэл” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Захиалагчийн зорилго нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнийг дагалдан гарсан дүрэм, журам, аргачлалд дүн шинжилгээ хийж, цаашид хууль тогтоомж болон хуульчилсан актуудын хэрэгжилтэд мониторинг үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, улмаар уг эрх зүйн актууд нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд бодитой хүндрэл бэрхшээл учруулж, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж буй эсэхэд дүн шинжилгээ хийхэд чиглэгдсэн байна.

Иймд уг асуудлыг Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn сайтад бүртгэгдсэн Монгол Улсын хууль тогтоомж 596, Засгийн газрын тогтоол 4258, УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 71, Сайдын тушаал 874, Засгийн газрын агентлагийн даргын 183 тушаал, шийдвэрээс гадна холбогдох байгууллагуудын цахим хуудаснаас зарим тушаал, шийдвэрүүдийн хүрээнд авч үзсэн болно.

Судалгаанаас үзэхэд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нийтлэг үйлчлэх, эдийн засгийн нийтлэг харилцааг зохицуулж буй 67 хууль байх ба үүнээс 54 хуульд Засгийн газар дүрэм, журам гарган зохицуулахаар заасан заалт, 52 хуульд холбогдох яам, агентлаг, төрийн бусад байгууллагын шийдвэрээр зохицуулах журмын заалт байна.

Судалгааны мэдээллийг нэгдсэн жагсаалтаар, лавлагаа мэдээлэл хэлбэрээр гаргасан ба нэмэлтээр дараах ангилалаар салбарын эрх зүйн зохицуулалтын актуудыг түүвэрлэн гаргасан болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин;
- Жижиг дунд үйлдвэрлэлийн эрх зүйн орчин;
- Үйлдвэрлэлийн бодлогын эрх зүйн орчин.

Судалгааны хэлтсийн хувьд захиалгад дурдсаны дагуу “аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулж, тэдний хууль ёсны ашиг сонирхолыг зөрчиж буй хууль тогтоомж” хэмээн шууд тогтоож, ангилал үүсгэн лавлагаа гаргах боломж, эрх хэмжээ үгүй тул захиалагчид системтэй лавлагаа мэдээлэл гарган өгч, дараа дараагийн процесст дэмжлэг тусалцаа үзүүлэхийг чухалчилсан болно. Энэхүү лавлагаа

мэдээллийг уг асуудлаар нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийхэд ашиглах боломжтой. Түүнчлэн Судалгааны хэлтсээс бизнес эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлогын асуудлаар өмнө нь гүйцэтгэсэн, уг асуудалд хамаарах нэр бүхий 23 судалгааны ажлыг захиалгад хавсарган хүргүүлж байна.

Энэхүү лавлагаа мэдээлэл нь зөвхөн хуульчлан заасны дагуу эрх бүхий байгууллагуудаас гаргасан дүрэм, журам, заавраар хязгаарлагдаж байгаа тул шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд УИХ болон Засгийн газар, түүний харьяа байгууллага, яам, агентлагуудаас батлан гаргасан бусад дүрэм, журам, зааврууд, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсээр дамжуулах буюу шууд ЗГХЭГ, холбогдох байгууллагуудаас гаргуулан авах боломжтой болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖООР ЖУРАМЛАН ЗОХИЦУУЛАХААР ЗААСАН БИЗНЕС-ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬЧИЛСАН АКТУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

№	Хуулийн нэр	Хуулийн зүйл, заалт	Засгийн газрын тогтоол, шийдвэрээр баталсан дүрэм, журам	Холбогдох байгууллага, яам, агентлагаас гаргасан дүрэм, журам, аргачлал
1.	Авто замын тухай 1998.01.02	Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 5.1.4. авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрлийг олгох буюу тусгай зөвшөөрөл олгох эрхийг мэргэжлийн зохих байгууллагад шилжүүлэх. Тусгай зөвшөөрөл олгох журмыг батлах;		Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын тушаал 2010 оны № 47 Журам батлах тухай /Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох журам/
2.	Автотээврийн тухай хууль 1999.06.04	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.4. тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах;		Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны № 228 тушаал Журам батлах тухай /Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх этгээдийг сонгон шалгаруулах журам/
3.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай 2010.06.24	4.5.Энэ хуулийн 4.1.6 /агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авах журам, төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар тогтооно. 8.5.Үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор түүхий нүүрс олборлодог болон эрчим хүч үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, байгууллагыг төлбөрөөс чөлөөлж, хөнгөлж болно. 8.6.Энэ хуулийн 8.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2010 оны №273 тогтоол Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай "Агаарын төлбөр" Засгийн газрын 2012 оны №227 тогтоол Жагсаалт батлах тухай "Агаарын бохирдол"	

<p>4.</p> <p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006.06.29</p>	<p>20.2. Энэ хуулийн 20.1-д заасан алдагдлыг дэд бүтэц, уул уурхайн салбарын хувьд уг алдагдал гарсан татварын жилийн дараахь дараалсан 4-8 жилийн, бусад салбарын хувьд 2 жилийн албан татвар ногдуулах орлогоос хасч тооцох бөгөөд хөрөнгө оруулалтын хугацаатай уялдуулан дэд бүтэц, уул уурхайн салбарын алдагдал тооцох хугацааг Засгийн газрын баталсан журмын дагуу зохицуулна.</p>	<p>Засгийн газрын 2009 оны №287 тогтоол Журам батлах тухай “Уул уурхай, дэд бүтцийн салбарт алданги тооцох”</p>	<p>Уул уурхайн сайдын тушаал Үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох тухай 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 15</p>
<p>5.</p> <p>Ашигт малтмалын тухай 2006.07.08</p>	<p>3.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална.</p> <p>46.2.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу бүртгүүлбэл зохих үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт, тэдгээрийн сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмыг Засгийн газар батална.</p> <p>60 дугаар зүйл, Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн орддын нөхөн төлбөр</p> <p>60.8.Нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журмыг Засгийн газар батална.</p> <p>10.1.4.тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;</p>	<p>Засгийн газрын 2010 оны №308 тогтоол Журам батлах тухай “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох”</p> <p>Засгийн газрын 2010 оны №281 тогтоол Журам шинэчлэн батлах тухай “Сорьцын хяналт, бүртгэл”</p> <p>Засгийн газрын 2007 оны №81 тогтоол Журам, жагсаалт батлах тухай “Газар өмчлөгч, эзэмшигчийн ашиг олох зорилгогүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд тухайн газартаа ашиглаж болох түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт”, “Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам”</p>	<p>Уул уурхайн сайдын тушаал Журам батлах тухай /тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын/ 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Дугаар 10</p>

6.	Аялал жуулчлалын тухай 2000.05.05	Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 16.1.6. аялал жуулчлалын байгууллага, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журмыг батлах;		Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал журам батлах тухай Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам 2009.09.02-ны өдөр Дугаар 31
7.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай	13 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэг, түүний төрөл 13.5.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагна журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2014 оны №43 тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”	
8.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 2012.05.17	5 дугаар зүйл.Байгаль орчны стратегийн үнэлгээ 5.3.Стратегийн үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний талаарх нарийвчилсан журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн Дугаар 374 “Журам батлах тухай”	
9.	Байгаль орчныг хамгаалах тухай 1995.03.30	15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 2/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах; 21.4. Цэцраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно.	Засгийн газрын 2006.06.14-ний өдрийн Дугаар 137 “Журам батлах тухай” “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал аргачилсан заавар батлах тухай “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар” 2010 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Дугаар А-2

		<p>30.1. Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.</p> <p>30.2. Мэргэжлийн байгууллагад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэн зохицуулах эрх олгох журмыг Засгийн газар батална.</p>		<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал аргачлал батлах тухай “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал” 2010 оны 05 -р сарын 27 -ны өдөр Дугаар А-156</p>
10.	<p>Гаалийн тариф, гаалийн татварын тухай 2008.05.20</p>	<p>36.3.Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварыг хураан авч төсөвт төлөхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>41.4.Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журмыг Засгийн газар батална.</p>	<p>Засгийн газрын 2009.04.01-ний өдрийн Дугаар 89 Журам батлах тухай “Гаалийн болон бусад татвар төлөх”</p>	<p>Сангийн сайдын тушаал 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 334</p>
11.	<p>Газрын тосны бүтээгдэхүүний тухай 2005.07.01</p>	<p>5 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тэвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1.3.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг батлах;</p> <p>5.2.5.газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг баталж мөрдүүлэх.</p>	<p>Засгийн газрын тогтоол 2015.10.19-ний Дугаар 412 “Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай”</p>	<p>Уул уурхайн сайдын тушаал журам батлах тухай “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн журам” 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Дугаар 171</p>
		<p>7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</p> <p>7.1.4.нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;</p>		

<p>12. Газрын тосны тухай 2014.07.01</p>	<p>9.1.19.газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, түүнийг хэрэгжилтэд хяналт тавих; /ТЗТБ/</p>	<p>Засгийн газрын тогтоол 2015.07.07-ны Дугаар 295 “Журам батлах тухай”</p>	<p>Уул уурхайн сайдын тушаал журам батлах тухай 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 49</p>
<p>13. Газрын төлбөрийн тухай 1997.04.24</p>	<p>5.1. Газрын суурь үнэлгээг Засгийн газар тогтооно. 19.1.3.газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах, тэдгээрийн ажиллах журам, зааврыг батлан мөрдүүлэх; /ТЗТБ/</p>	<p>Засгийн газрын тогтоол 1997.06.25–ны өдөр Дугаар 152 “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 246</p>
<p>14. Иргэний нисэхийн тухай 1999.01.21</p>	<p>7.1.9. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журмыг батлах /ТЗТБ/</p>	<p>Засгийн газрын тогтоол 2002 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Дугаар 83 Дүрэм батлах тухай “Иргэний нисэхийн улсын хяналтын дүрэм”</p>	<p>Дэд бүтцийн сайдын тушаал 2002 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Дугаар 261 Дүрэм батлах тухай “Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мөрдөх дүрмүүд”</p>
<p>15. Барилгын тухай 2016.02.05</p>	<p>21.2.Энэ хуулийн 21.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан ангилалын дагуу тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, бүртгэх журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Засгийн газрын тогтоол 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 72 Дүрэм батлах тухай “Барилга ашиглалт”</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Дугаар 102</p>
<p>15. Барилгын тухай 2016.02.05</p>	<p>24.6.Барилгын үнэ бүрдлийн дүрэм, төсөв зохиох аргачлалыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Засгийн газрын тогтоол 2009 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 204 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм батлах тухай</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Дугаар 102</p>

	<p>Засгийн Газрын бүрэн эрх: 32.1.6.барилга байгууламжийн ашиглалтын дүрмийг батлах; 32.1.7.барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг батлах; 32.1.8.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг батлах; 32.1.9.барилгын ажлын захиалагчийн дүрмийг батлах; 32.1.10.барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг батлах;</p>	<p>Засгийн газрын тогтоол 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 74 “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай”</p>	<p>Барилга хот байгуулалтын сайдын тушаал “Барилга засварын ажлын төсвийн суурь норм батлах тухай 2005.09.12-ны өдөр Дугаар 80</p>
<p>15. Барилгын тухай 2016.02.05</p>	<p>Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 33.1.3.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам батлах; 33.1.13.барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг баталгаажуулж, хэрэглэх журмыг батлах 33.1.14.барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам батлах; 33.1.15. барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам батлах;</p>	<p>Засгийн газрын тогтоол 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 73 “Барилга захиалагчийн дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоол 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 336 Барилгын нэгж талбайн төсөвт өртөг,төсвийн жишиг үнэлгээ батлах тухай Засгийн газрын тогтоол 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 185 Дүрэм батлах тухай “Барилгын зураг төсөл”</p>	<p>Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал “Барилгын дүрэм батлах тухай 2012.07.05 дугаар 198 Барилга хот байгуулалтын сайдын тушаал Журам шинэчлэн батлах тухай 2013.05.07 Дугаар 89 Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал Дүрэм, журам батлах тухай “Барилгын үйлдвэрлэх эрхлэх зөвшөөрөл олгох тухай дүрэм, барилга угсралтын ажлыг эхлүүлэх журам” 1995.06.30-ны өдөр Дугаар 170</p>

16.	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль 2007.07.27	10.1.Засгийн газар жижиг, дунд үйлдвэрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	Засгийн газрын тогтоол 2009 оны 05-р сарын 20 ны өдөр Дугаар 144 ЖДҮ-ийн зөвлөл "Дүрэм батлах тухай"	Хүнс ХАА, ХҮ-ийн сайдын 2010 оны 02-р сарын 19-ны 35-р тушаал, ЖДҮ дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан хөнгөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааны журам, 2014-2016 ЖДҮ-ийн дэмжих хөтөлбөр 2014-08-25 ны Засгийн газрын 278-р тогтоолоор батлагдав.
17.	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай 1999.12.16	20.4.Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална. 9 ¹ .1.1.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх 14.3. Газрын чанарын үнэлгээ хийх аргачлал, үзүүлэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. 15.2. Газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал, үзүүлэлтийг Засгийн газар батална.		2016 оны 6-р сарын 30 ны өдрийн Барилга, хот байгуулалтын сайдын 121-р тушаал, норм ба дүрэм батлах тухай
18.	Концессын тухай хууль 2010.01.20	6.1. Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1.терийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлах; 10.1.Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.	2011 оны 6-р сарын 10 ны өдрийн Засгийн газрын 185-р тогтоол, Концессын зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай. 2012 оны 4-р сарын 4-ны Засгийн газрын 103-р тогтоол	2009.10.15 ны өдрийн УИХ-ын 64-р тогтоол, төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай 2012 оны 4-р сарын 4-ны Засгийн газрын 103-р тогтоолын -Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам, -Концесс олгох уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам, -Концесс олгох уралдаант шалгаруулалтын урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг,

				<p>-Уралдаанд шалгаруулалтын жишиг баримт бичиг, -Концессын жишиг гэрээ зэрэг багтана. 2010 оны 03-р сарын 25-ны өдрийн Төрийн өмчийн хорооны 153-р тогтоолоор Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал</p>
<p>19. Нийгмийн даатгалын тухай 1994-05-</p>	<p>5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилгах орлогоос 3 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно. 7. Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн улсын дундаж цалин болон Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн дундаж цалинд тус тус үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно. 8. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажилаж байгаа Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.</p>	<p>Хүн Ам Хөгжил, Нийгэм хамгаалалын сайдын 2014 оны 11-р сарын 12-ны өдрийн А/120 тушаал, журам шинэчлэн батлах тухай, - Ажилсан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулсан даатгуулагчийн тэтгэврийг шинээр тогтоох, шинэчлэн бодоход баримтлах аргачлал /2014.01.21/1/101/ - Лавлагаа (мэдээлэл), тодорхойлолт өгөх нэгдсэн маягт батлах тухай /2014.02.25 А/33/ - Том төрөөс ухаалаг төр рүү санаачлагыг хэрэгжүүлэх тухай /2014.03.04 1/326/ - Чиглэл өгөх тухай 2014.03.05 1/337/ - Өргөдлийн загвар батлах тухай /2014.03.24 А/52/ - Цалин, нэмэгдэл тогтоох, хөнгөлөлт эдлүүлэх ажилсан жилд оруулж тооцох тухай 2014.04.15 А/83 , А/44/ - Чиглэл хүргүүлэх тухай /2014.04.29 1/615/ - Өргөдлийн загвар батлах тухай /2014.05.13 А/72/</p>		

<p>- Чиглэл өгөх тухай /2014.05.23 1/811/ - Үйлчилгээ нэвтрүүлэх тухай /2014.05.23 А/78/ - Чиглэл хүргүүлэх тухай /2014.06.04 1/901/ - Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2014.06.06 А/63/ - Чиглэл хүргүүлэх тухай /2014.06.12 1/966/ - Мэдүүлгийн загварт нэмэлт оруулах тухай /2014.07.07 А/92/ - Чиглэл хүргүүлэх тухай /2014.07.17 1/1154/ Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай /2014.08.15 А/109/ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах аргачлал /2014.07.24/ 1/1190 Журмын хэрэгжилтийг хангах тухай /2014.09.22 А/124/ 2015 оныг "Чанарын удирдлагын хөгжлийн жил" болгон ажиллах тухай Аргачлал батлах тухай /2015-02-12 А/26 / Ажлын байрны сур орон тоог нөхөх тухай /2015-02-24 А/31/ Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай /2015-05-07 11/ Чиглэл хүргүүлэх тухай /2015-07-28 1/1485/ Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай /2015-09-07 А/102/ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийн тухай</p>	<p>1994 оны 09-р сарын 28 ны өдрийн 171-р тогтоол, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээ</p>	<p>3. Нийгмийн даатгалын байгууллагын болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална. 26.1 Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална. 26.1.3.Нийгмийн даатгалын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байна. Мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар тогтооно. 26.1.4.Нийгмийн даатгалын байцаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгож болно. Нийгмийн даатгалын байцаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар тогтооно. 29.4 Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг Засгийн газар батална.</p>
---	---	---

<p>20.</p>	<p>Нийгмийн халамжийн тухай хууль 2012.01.19</p>	<p>16.1. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтооно.</p> <p>16.2. Тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журмыг Засгийн газар батална.</p>	<p>2012 оны 05-р сарын 30 ны өдрийн Засгийн газрын 185-р тогтоол журам батлах тухай</p> <p>2012 оны 11-р сарын 24 ны өдрийн Засгийн газрын 136-т тогтоол, тэтгэмж, тусламж хангамжийн хэмжээг тогтоох тухай</p>	<p>XXYГ-ын даргын 2012-07-31 ны 164, 165-р тушаал журам батлах тухай, НХУЕГ-ын даргын 2012-10-01 ны 27-р тушаал, өргөдлийн маягтын загвар батлах тухай, НХУЕГ-ын даргын 2014-04-02 ны 56-р тушаал, Загвар маягт шинэчлэн батлах тухай, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны журмууд: Хүний хөгжлийн сангаас хүүхдийн мөнгө олгох журам, Ахмадын сан байгуулан ажиллуулах журам, Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох, тусгай тооцох журам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам</p>
<p>21.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2015.06.19</p>	<p>4.2. Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ.</p>	<p>2002 оны 01-р сарын 16-ны Засгийн газрын 11-р тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай</p>	<p>2015 оны 11-р сарын 06-ны өдрийн Хөдөлмөрийн сайдын АУ218 тушаалаар НББ бодлогын баримт бичиг батлах тухай, 2014 оны 02-р сарын 14-ний Ерөнхий аудиторын 76-р тушаалаар НББ баримт бичиг батлах тухай, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар ТБ-ын НББ-ын санхүүгийн тайлангийн аргачлал, дансны заавар,</p>

				<p>НББ-ын санхүүгийн тайлангийн журам, Мэргэшсэн НББ шалгалтын журам, мэргэшсэн НБ ёс зүйн дүрэм, үүргийн биелэлтийг хянах, дүгнэх журам, Аудитын үйлчилгээний үнэлгээний жишиг тогтоох тухай 2007-03-07 ны 04-р тогтоол, бусад дүрэм журмууд ...</p>
22.	<p>Ойн тухай хууль Шинэчилсэн найруулга 2012.05.17</p>	<p>4.10. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална.</p>	<p>2012 оны 07-р сарын 25 ны өдрийн Засгийн газрын 255-р тогтоол, ойн талбай норматив байршил тогтоох тухай</p>	<p>2009 оны 05-р сарын 20-ны БОАЖСайдын 127-р тушаал, ойгоос мод бэлтгэх журам, БОНХЯСайдын 2013.05.01-ны өдрийн А/134 тушаал, журам батлах тухай, Ойн мэргэжлийн байгууллах ажиллах журам, Ойгоос мод бэлтгэх журам, Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийн хөтлөх журам, Ойд арчилгааны огтлолт явуулах журам, Ойгоос хуш модны самар түүж бэлтгэх, хориглох тухай-2015.09.18 №А/338, 2016онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай 2015.12.04 № А/11, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай 2016-03-24 № А/80,</p>

23.	Онцгой албан татварын тухай 2006.06.29	<p>6.7. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 6.1, 6.2-т заасан хязгаарт багтаан салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.</p> <p>8.12. Энэ хуулийн 6.7-д заасан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	Засгийн газрын 2012 оны №11 тогтоол "Автобензин, түлшний үнэ" хөтөлбөр Засгийн газрын 2015 оны №18 тогтоол "Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай"	ТЕГ-ын даргын 1997 оны №19 тушаал " Төсөвт төлөх татварын орлогын баримтанд бичилт хийлгэх тухай журам "
24.	Онцгой албан татварын тэмдгийн тухай 2000.11.17	4.3. Тэмдгийн загвар, тэмдэг олгох журмыг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	Засгийн газрын 2001 оны №8 тогтоол "Онцгой албан татварын тэмдгийн тухай"	Сангийн сайдын 2006 оны №320 дугаар тушаал "Онцгой албан татварын тэмдэг захиалах, хэвлүүлэх, татварын албадад хүргүүлэх, хадгалах, бүртгэх, аж ахуйн нэгжид олгох журам"
25.	Органик хүнсний тухай 2016.04.07	<p>8.3. Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>8.4. Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлалыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>10.3. Энэ хуулийн 10.1-д заасан баталгаажуулалтын байгууллагыг бүртгэх журмыг үндэсний итгэмжлэлийн байгууллага, 10.2-т зааснаар баталгаажуулах тохиолдолд түүнд тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>11.6. Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>		

		7.2. Давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний хэт өндөр үнийг тогтооходой холбогдсон журмыг олон улсын тэргүүн туршлагыг үндэслэн Засгийн газар батална.	
	Засгийн газрын 2012 оны №118 тогтоол "Өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах"	8.3. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өргөдлийг хянаж өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ гэж үзвэл татгалзсан дүгнэлтийг гаргана. Дүгнэлт гаргах журмыг Засгийн газар батална.	Өрсөлдөөний Тухай 2010.06.10
26.	Засгийн газрын 2012 оны №119 тогтоол "Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаархи бодит мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ирүүлсэн этгээдэд тухайн зөрчилд ногдуулсан торгуулийн мөнгөн дүнгийн таван хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	11.4. Энэ хуулийн 11.1, 11.2-т заасан гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаархи бодит мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ирүүлсэн этгээдэд тухайн зөрчилд ногдуулсан торгуулийн мөнгөн дүнгийн таван хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	
	Засгийн газрын 2010 оны №298 тогтоол "Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журам"	15.1.6. зах зээлд зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих. Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журмыг Засгийн газар батална.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын Тухай хууль 2005.11.17
27.		22.1-т тус хуульд заасан санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.	

<p>28.</p>	<p>Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль 2003.5.15</p>	<p>9.2-т Шинэ технологи, бүтээгдэхүүн эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсад хэрэглэхээр зааснаас өөр стандарт, аргачлал, зааврыг нэг жил хүртэл хугацаагаар түр хэрэглэх зөвшөөрлийг стандартчиллын төв байгууллага олгоно. 10.2-т Техникийн зохицуулалтын Засгийн газар батална 16.2.Энэ хуулийн 16.1-д заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална. - стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбогдсон дүрэм, журам, зааврыг батлах;</p>	<p>Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоол Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоол Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай “Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”</p>	
<p>29.</p>	<p>Тариалангийн тухай хууль 2016.01.29</p>	<p>15.4.Тариалангийн зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний загварыг газрын болон тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 15.8.Энэ хуулийн 15.7-д заасан газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлалыг тариалангийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 19.6.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>	<p>Засгийн газрын 2016 оны №42 тогтоол “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөр</p>	<p>Хүнс, Хөдөө Аж ахуйн сайдын 2016 оны А-80 тушаал “Хүнсний буудайг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал” Хүнс, Хөдөө Аж ахуйн сайдын 2001 оны А-80 тушаал “Бэлчээр, тариалангийн хөнөөлт шавьж, мэрэгч амьтантай тэмцэх арга хэмжээнд мэргэжлийн хяналт тавих журам”</p>

		<p>21.1.Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газар батална.</p> <p>21.4.Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>24.5.Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн, хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>		
30.	Таримал ургамлын үр, сортын тухай 1999.06.17	5.2. Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 1999 оны №184 тогтоол “Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулах журам”	
31.	Татварын ерөнхий хууль 2008.05.20	13.9.Татвар төлөгчийг бүртгэх журмыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Засгийн газрын 2009 оны №22 тогтоол “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам” Засгийн газрын 2016 оны №30 тогтоол “Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай”	ТЕГ-ын даргын 2012 оны №236 тоот тушаал “Татвар төлөгчийг бүртгэх журам”
		19.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэд татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Татварын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллах бөгөөд уг зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.		

		<p>48.6.Татварын ногдлыг шууд бус аргаар тодорхойлох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>53.5.Татварын бүртгэл болон татварын орлогыг дамжуулан бүртгэх дансыг хөтлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.</p> <p>60.2.Энэ хуулийн 60.1-д заасан алдангийн хэмжээг арилжааны Банкаас олгож буй зээлийн хүүгийн дунджийн хэмжээнд Засгийн газар жил бүр тогтоож байна.</p>		
32.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 2014.01.09	<p>3.2.Эмчилгээний зориулалтаар шавар, элсийг ашиглахтай холбогдсон харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.</p> <p>3.3.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно.</p>	Засгийн газрын 2014 оны №222 тогтоол "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам"	2011-11-9ны Засгийн газрын 311-р тогтоолоор ААН байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журмыг баталсан. Аймаг, сумдын ЗДТГ, ЗД дэргэдэх агентлаг, үйл ажиллагаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын загвар, 2015 оны ЗГ-ын 483-р тогтоолоор Дотоод аудитын дүрэм, 2010 оны ЗГ-ын 47-р тогтоолоор Улсын бүртгэлийн хяналтын дүрэм
33.	Төрийн хяналт шалгалт 2003.01.03	<p>5⁴. 2.Энэ хуулийн 5⁴.1-д заасан эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг Засгийн газар тогтооно</p> <p>6.4.Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.</p>	2011 оны 11-р сарын 9ны өдрийн Засгийн газрын 311-р тогтоол, нийтлэг журам батлах тухай/ ААН дотоод хяналт шалгалт /	2011-11-9ны Засгийн газрын 311-р тогтоолоор ААН байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журмыг баталсан. Аймаг, сумдын ЗДТГ, ЗД дэргэдэх агентлаг, үйл ажиллагаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын загвар, 2015 оны ЗГ-ын 483-р тогтоолоор Дотоод аудитын дүрэм, 2010 оны ЗГ-ын 47-р тогтоолоор Улсын бүртгэлийн хяналтын дүрэм

34.	Технологи дамжуулах тухай хууль 1998.05.07	7.7. Технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. 26.1. Аюултай ачааны үйлдвэрлэл, хадгалалт, ачилт, буулгалт, дамжуулалт хийж байгаа газрын барилга байгууламжууд нь суурь бүтцээс аюулгүй ажиллагааг хангахуйц зайд байрлах бөгөөд аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Гэгээрлийн сайдын 1998 оны 271 дүгээр тушаал "Технологийн түвшний үнэлгээ хийх нийтлэг журам"	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны №167 тушаал "Аюултай байгууламж байрлуулах зай, огтлолцлын болон байршлын нөхцөлийг тодорхойлох журам"
35.	Төмөр замын тээврийн тухай 2007.07.05			Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал Шаардлага, загвар батлах тухай "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага" 2010 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Дугаар 353
36.	Боловсролын тухай хууль	21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг 21.4. Энэ хуулийн 21.1.1-21.1.7-д заасан баримт бичигт тавигдах шаардлага, загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.		
37.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012.05.17	4.5. Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журмыг энэ хуулийн 7.1-д заасныг үндэслэн Засгийн газар тогтооно.	Зам, тээврийн сайд, байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан тушаал Журам батлах тухай "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох" 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар 138/A-208	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал, усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам "Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм" 2005 оны 2 дугаар сарын 07-ны өдөр Дугаар 23

		<p>8.4.Энэ хуулийн 8.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг заасан журмыг Засгийн газар батална.</p> <p>11.2.Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>14.3.Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг усан замын тээврийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.</p>		
38.	<p>Үйлдвэрлэлийг Дэмжих тухай 2015.07.09</p>	<p>6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 6.1.3.дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавихтай холбоотой журмыг батлах;</p>	<p>Засгийн газрын тогтоол Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох “Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавих журам” 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 193</p>	
39.	<p>Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай 2009.07.09</p>	<p>42 дугаар зүйл.Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх 42.4.Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн маягт болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.</p>		<p>УБЕГ-ын даргын 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1125 дугаар тушаалын 8 дугаар хавсралт “Барьцааны зүйлийг худалдах тухай мэдэгдэл хүргүүлэх журам</p>

<p>Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам 2015.05.20 Дугаар 239</p>		<p>23.1. Компанийн хувьцааг худалдан авах ажиллагааны журмыг Хороо тогтооно.</p> <p>36.16. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлөөр эрхлэх бөгөөд энэ харилцааг зохицуулсан журмыг Хороо тогтооно.</p> <p>38.9. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад үйл ажиллагаатай холбоотой журмыг Хороо тогтооно.</p> <p>41.6. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх журам болон андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөлийг Хороо тогтооно.</p>	<p>40.</p> <p>Үнэт цаасны зах зээлийн тухай 2013.05.24</p>
<p>Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол “ үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам” батлах тухай 2014.01.15 Дугаар 07</p>		<p>6.1.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журмыг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;</p>	<p>41.</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын тухай 2006.05.25</p>
<p>“Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам “ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, гадаад харилцааны сайдын 2009 оны 334/104 дүгээр хамтарсан тушаалын хавсралт</p>		<p>6.1.2. химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран батлах;</p>	
<p>“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт</p>			

42.	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль</p> <p>2011.06.02</p>	<p>8.6. Зохицуулах зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.</p> <p>8.7. Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнана.</p> <p>13.2. Үндэсний аудитын газар энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.</p>	<p>2011 оны 06-р сарын 2-ны Засгийн газрын 29-р тогтоол, ХАА гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжүүлэх зарим арга хэмжээ,</p> <p>2011 оны 07-р сарын 20-ны өдрийн Засгийн газрын 235-р тогтоол, ХАА гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах, бэлтгэл хангах арга хэмжээний тухай,</p> <p>2012 оны 05-р сарын 30-ны өдрийн Засгийн газрын 188-р тогтоол, Биржийн зохицуулах зөвлөлийн гишүүдийг томилгох, дүрэм, журам, батлах тухай</p>	<p>ХАА, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны 08-р сарын 25-ны А/147-р төслийн нэгж байгуулах тухай тушаал,</p> <p>ХАА биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам, ХАА гаралтай, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн дүрэм,</p> <p>ХАА гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны журам,</p>
43.	<p>Хөдөлмөр эрхлэлтийг Дэмжих тухай хууль</p> <p>2011.06.17</p>	<p>2.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтооно</p> <p>21.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.</p>	<p>2011 оны 12-р сарын 28-ны өдрийн засгийн газрын 375-р тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг лэмжих тухай журам батлах тухай</p>	<p>2011.12.28-ны ЗГ-ын 375-р тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө бүрдүүлэх зарцуулалтанд тавих журам,</p> <p>хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам, Монгол банк, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2014-12-25ны өдрийн 206/А/277 тушаал, журам шинэчлэн батлах тухай, Азийн хөгжлийн банкны “ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хүрээнд эргэн төлөгдсөн эх үүсвэрээс зээл олгох журам, 2015.01.25-ны өдрийн 1/01/2015/1 дугаартай харилцан ойлголцоллын санамж бичиг, 2015-04-05 өдрийн багцын батлан гэрээ, бусад хөтөлбөрүүд, 2015-03-10-ны өдрийн Хөдөлмөрийн сайдын А/26 дугаартай тушаал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ноогдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай,</p>

44.	Хөдөлмөрийн тухай 1999.05.14	117.5.Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Дугаар 78 “Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журам”	
45.	Хөрөнгө оруулалтын тухай 2013.10.06	20.6.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Дугаар 52 хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам	
46.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай 2015.01.29	9.1.8.иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавьж, лавлагаа олгох; 9.1.9.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг холбогдох журмын дагуу шинээр бүртгэх, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, улсын бүртгэлээс хасах. 9.2.Энэ хуулийн 9.1.8, 9.1.9-д заасан харилцааг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.		Хууль зүйн сайдын тушаал 2015 оны А/42 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам Хууль зүйн сайдын тушаал 2015 оны а/40 дугаар тушаалын хавсралт гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам
47.	Хог хаягдлын тухай. 2012.05.17	6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 6.1.6.аяултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалахтай холбогдсон болон уг үйл ажиллагааг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам батлах; 7.2.1.Барилгын хог хаягдлыг тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах журам баталж, нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжилтийг хангуулах;	Засгийн газрын тогтоол 2014 он Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалахтай холбогдсон болон уг үйл ажиллагааг эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам	

48.	Хаяжуулалтын тухай. 2013.02.07	4.7.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаяжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2013.08.02-ны өдөр Дугаар 280	
49.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай 2010.04.23	Санхүүгийн зохицуулах хороо. 8.2.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх журмыг Хороо тогтооно.		Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 09 дүгээр сарын 14 ны 266 дугаар тогтоол "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"
		8.10.Энэ хуулийн 8.2, 8.6, 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2013 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 172 "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам"	
50.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012.12.20	10.2.Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 12.2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Эрүүл мэндийн сайдын тушаал 2013 оны 06 сарын 10-ны өдөр Дугаар 212	Эрүүл мэндийн сайдын тушаал 2013 оны 06 сарын 10-ны өдөр Дугаар 212
		13.8.Энэ хуулийн 13.6, 13.7-д заасан ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2013.10.12-ны өдөр Дугаар 341 "Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам"	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам" А 2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Дугаар А/46/115

51.	Хүнсний тухай 2012.12.20	8.5.Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална. 16.2.Энэ хуулийн 16.1-д заасан баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.			
52.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай 2015.08.07	6.4.Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын тогтоол 2015 оны 348 дугаар “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”		
53.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай 2010.05.27	15.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас лиценз авна.15.2. Энэ хуулийн 15.1-д заасан лиценз олгох журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.		Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаал “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2009.11.19-ний өдөр Дугаар 261	Эрүүл мэндийн сайдын тушаал “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам 2008 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Дугаар 140
54.	Эрүүл мэндийн тухай	22 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэх журам			

Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны хүрээнд:

Монгол Улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны хүрээнд одоогийн байдлаар ерөнхий зохицуулалтын 30, салбарын зохицуулалтын 34 хууль үйлчилж байна. Мөн хөрөнгө оруулалтыг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлан гаргасан УИХ-ын тогтоол 14, Засгийн газрын тогтоолоор баталсан 29 журам хүчин төгөлдөр үйлчилж байна.

2013 онд *Хөрөнгө оруулалтын тухай хууль* батлагдсанаар “*Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль*”, “*Стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль*” хүчингүй болж, хөрөнгө оруулагчдыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагч гэж ялгаварлалгүйгээр төрөөс тэгш, шударга дэмжих эрх зүйн орчин бүрдсэн юм.

Түүнчлэн, хөрөнгө оруулалт нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт гэсэн ерөнхий хэлбэртэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт нь *шууд ба шууд бус*, дотоодын хөрөнгө оруулалт нь *төсвийн болон концессийн хөрөнгө оруулалт* хэлбэртэй байхаар хуульчлан зохицуулсан.

Уг хуулийн V бүлгийн 20 дугаар зүйлд зааснаар *500 тэрбум төгрөгөөс* дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай хүсэлт гаргасан тохиолдолд үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахаар заасан болно.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд /21-р зүйл/ уул уурхай, банк санхүү, хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмшихээр бол хуулиар тогтоосон зохих шалгуурыг хангаж Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авахаар хуульчлан тогтоосон байдаг.

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт нийт гаргасан хувьцааных нь 50, түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг ойлгохоор хуульчилснаас гадна шинээр хөрөнгө оруулахыг дэмжих үүднээс тусгасан нэг зохицуулалт нь “Тогтворжуулах гэрчилгээ” буюу татварын орчны тогтворжуулалт юм.

*Монгол Улсын хөрөнгө оруулалтын харилцааг
зохицуулж буй гол хуулиуд*

№	Огноо	Хуулийн нэр	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
1	2002-01-10	Иргэний хууль	2015-07-02
2	2013-10-03	Хөрөнгө оруулалтын тухай хууль	2015-05-14
3	2013-10-03	Хөрөнгө оруулалтын сангийн тухай	-
4	2011-10-06	Компанийн тухай хууль	2015-06-19
5	2010-01-28	Концессийн тухай хууль	2015-10-30
6	2008-05-20	Татварын ерөнхий хууль	2015-07-09
7	2006-07-08	Ашигт малтмалын тухай хууль	2015-06-04
8	2001-02-01	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	2015-08-07

9	2006-06-29	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	2015-06-04
10	2001-04-12	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль	2015-02-12
11	2012-05-17	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2015-01-23
12	2008-05-20	Гаалийн тухай хууль	2015-05-29
13	2008-05-20	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	2014-07-01
14	2005-07-01	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль	2013-02-07
15	2014-07-01	Газрын тосны тухай хууль	2015-07-09
16	2011-02-10	Монгол Улсын хөгжлийн банкны тухай хууль	2014-10-16
17	2015-07-09	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	-
18	2006-06-29	Онцгой албан татварын тухай хууль	2015-10-30
19	2015-02-18	Өрийн удирдлагын тухай хууль	2015-10-30
20	2006-06-22	Санхүүгийн түрээсийн тухай хууль	-
21	2010-06-24	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль	2015-11-10
22	2011-12-23	Төсвийн тухай хууль	2015-11-10
23	2009-06-25	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	2015-11-13
24	2015-07-09	Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	-
25	2016-11-26	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль	-
26	2010-01-21	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль	-
27	2011-06-02	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	2015-11-10
28	2010-04-23	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль	-
29	2015-01-29	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	-
30	2015-02-12	Чөлөөт бүсийн тухай хууль	-

*Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлогыг зохицуулж буй
холбогдох бусад хуулиуд*

<i>№</i>	<i>Огноо</i>	<i>Холбогдох хуулийн нэр</i>	<i>Нэмэлт өөрчлөлт орсон огноо</i>
1	1998-01-02	Авто замын тухай хууль	2014-05-15
2	2012-05-17	Агаарын тухай хууль	2015-11-13
3	2010-06-24	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	2015-11-13
4	2015-06-19	Аудитын тухай хууль	-
5	2000-05-05	Аялал жуулчлалын тухай хууль	2011-01-20
6	2012-05-17	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	-
7	1995-03-30	Байгаль орчныг хамгаалах тухай	2015-07-08
8	2010-01-28	Банкны тухай хууль	2015-07-09
9	2008-02-05	Барилгын тухай хууль	2015-07-02
10	2003-05-30	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	2014-10-31
11	2002-06-07	Газрын тухай хууль	2015-07-08
12	1997-04-24	Газрын төлбөрийн тухай хууль	2012-05-22
13	1988-11-29	Газрын хэвлийн тухай хууль	1995-04-17

14	2009-07-16	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай	-
15	2007-07-27	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль	2015-01-29
16	2012-02-10	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	-
17	2011-10-20	Зээлийн мэдээллийн тухай хууль	-
18	2012-05-22	Инновацийн тухай хууль	2015-01-23
19	2002-06-27	Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль	2012-05-18
20	1994-05-31	Нийгмийн даатгалын тухай хууль	2015-01-30
21	2015-06-19	Нийслэл хотын албан татварын тухай	-
22	2015-06-19	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	-
23	2010-06-10	Өрсөлдөөний тухай хууль	2015-06-19
24	2008-02-06	Татварын өршөөл үзүүлэх тухай хууль	2008-05-09
25	2005-12-01	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль	2015-07-09
26	2014-01-09	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	-
27	2012-05-17	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	-
28	2012-05-17	Усны тухай хууль	2012-08-17
29	2002-11-07	Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай	2011-10-28
30	2008-05-29	Хот байгуулалтын тухай хууль	2015-06-26
31	2006-06-16	Хувь хүний орлогын албан татварын тухай	2015-07-09
32	2009-11-18	Хүний хөгжил сангийн тухай	2015-05-21
33	1995-01-16	Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай	-
34	2003-06-19	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	2011-10-20

*Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулахтай холбоотой
УИХ-ын тогтоол*

№	Тогтоолын дугаар	Баримт бичгийн нэр	Огноо
1	51	Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичиг батлах тухай	2015.05.22
2	87	Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалын тухай	1995 .12 .4
3	57	Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай	2001. 6.14
4	24	Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	2003.06.12
5	64	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай	2009-10-15
6	62	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2015-06-19
7	65	Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай	2011-12-23
8	34	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	2010-06-24 2012-08-17
9	29	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	2003-06-18

10	18	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай	2014-01-16
11	54	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	2003.12.11
12	29	ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр/	1998.04.09
13	23	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай	2013.02.08
14	41	Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай	2015-02-18

*Хөрөнгө оруулалтын бодлогыг зохицуулахтай холбоотой
Засгийн газрын тогтоол*

Хөрөнгө оруулалтыг зохицуулж буй Засгийн газрын нийт 29 тогтоолын 14 тогтоол нь уг асуудлыг голлон зохицуулж байна.

№	Он дугаар	Тогтоолын нэр
1.	2012 оны № 171	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
2.	2005 оны № 201	Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
3.	2004 оны № 29	Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих тухай /захирамж/
4.	2015 оны № 66	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай
5.	2010 оны № 299	Журам батлах тухай (Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох)
6.	2008 оны № 61	Журам батлах тухай (Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг байршуулах..)
7.	2011 оны № 221	Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам
8.	2012 оны № 118	Давамгайл байдалтай хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, өрсөлдөгчийн хувьцааг худалдан авахад дүгнэлт гаргах журам
9.	2009 оны № 287	Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам
10.	2006 оны № 185	Журам батлах тухай /Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам/
11.	2006 оны №258	Журам батлах тухай /Эрсдэлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам", "Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам"/
12.	2005 оны № 39	Журам батлах тухай /Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих/
13.	2015 оны № 146	Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам
14.	2014 оны № 371	Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам
15.	2013 оны № 75	Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам
16.	2014 оны № 222	Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам

17.	2015 оны № 295	Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам
18.	2014 оны № 52	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам
19.	2015 оны № 296	Орон сууцны ипотекийн зээлийн баталгааны журам
20.	2007 оны № 306	Монгол Улсад үндэсний инновацийнт огтолцоог хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай
21.	2010 оны №0123	Нийтлэг журам батлах тухай (Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах)
22.	2001 оны № 125	Үзэл баримтлал батлах тухай санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал
23.	2009 оны №222	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр
24.	2008 оны №183	"Транзит Монгол" Үндэсний Хөтөлбөр
25.	2012 оны №223	Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
26.	2014 оны №278	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)
27.	2007 оны №131	"Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонх" хөтөлбөр
28.	2009 оны №299	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр (2009-2016)
29.	2008 оны №184	Монгол Улсыг хөгжүүлэх сангаас эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төлөвлөхөд 2009-2015 онд баримтлах чиглэл

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн орчин:

2007 онд УИХ-аар Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль баталсан бөгөөд тус хуулиар:

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, түүний бүртгэл,
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй этгээд,
- Жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх,
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн эрх үүрэг,
- Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэл,
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын тухай харилцааг зохицуулсан байна.

Түүнчлэн, салбарын дараах 14 хууль тогтоомжоор жижиг, дунд үйлдвэртэй холбоотой харилцааг зохицуулж байна. Үүнд:

- Зээлийн батлан даалтын тухай хууль,
- Инновацийн тухай хууль,
- Засгийн газрын тусгай сангийн тухай,
- Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,
- Санхүүгийн түрээсийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Нөхөрлөлийн тухай хууль,
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль,
- Татварын ерөнхий хууль,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль,
- Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль зэрэг нийт 15 хууль, тогтоомж үйлчилж байна.

ЖДҮ-ийн салбарын харилцааг зохицуулж буй УИХ-ын 16 тогтоол, Засгийн газрын 24 тогтоол байна.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн тухайд хэдийгээр салбарын харилцааг зохицуулах бие даасан хууль батлагдсан нь сайшаалтай боловч төрөөс ЖДҮ-ийн салбарт баримтлах бодлогыг зохицуулсан гол зохицуулалт нь хэт ерөнхий, тодорхойгүй, тунхагийн шинж чанартай зохицуулалт байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулж, зарим тохиолдолд зогсонги байдалд оруулж байна.

Үйлдвэрлэлийн бодлогын эрх зүйн орчин:

Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах, үнэ цэнэ шингэсэн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаа бүхий үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэх зорилгоор 2015 оны 7 сард Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль баталсан болно.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг УИХ-аар 2015 оны 07 сарын 29-ний өдөр хэлэлцэн баталсан бөгөөд тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж ургуулсан, өсгөж үржүүлсэн, олборлосон, эсхүл импортын түүхий

эдээр үнэ цэнэ шингээж боловсруулалт хийсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих харилцааг зохицуулсан болно.

Өөрөөр хэлбэл, Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээд мөн ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах үйл ажиллагааг дээрх дэмжлэгт хамааруулаагүй болно.

Төрөөс үйлдвэрлэлийг дэмжих хэлбэрийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөд зориулан арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох;
2. Өндөр үр ашиг бүхий дэвшилтэт технологи болон өндөр технологи бий болгон, нэвтрүүлж нутагшуулсан экспортын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг нэг удаа улсын төсвөөс тухайн үйлдвэрт буцааж олгох;
3. Экспортын үйлдвэрлэлийг экспортын санхүүжилтийн төрөл бүрийн арга хэрэгсэл, түүний дотор факторингийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дэмжих зэрэг болно.

Дээрх дэмжлэгийг Үйлдвэрлэлийг дэмжих сангаар дамжуулан дотоодын түүхий эд болон импортын түүхий эдийн нөөцөд тулгуурлан үнэ цэнийн сүлжээг бий болгосон нөхцөлд олгох ба дараах шаардлагыг хангасан бол давуу эрх олгохоор тусгажээ. Үүнд:

- *нээлттэй хувьцаат компани байх;*
- *үйлдвэрлэлийн үндсэн болон туслах материал, бусад хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний 60-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэгчээс хангасан байх;*
- *технологийн бүртгэлийн нэгдсэн санд бүртгэлтэй байх.*

Үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, олон улсын байгууллага, гадаад улсаас үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээл, олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж зэргээс бүрдэх ба уг улсын төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилахаар хуульчилсан байна.

Үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн жагсаалт

- “Автобензин, түлшний үнийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2012 оны 11-р тогтоол
- “Монгол Улсын үйлдвэржүүлэх хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2009 оны 299-р тогтоол
- “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)” Засгийн газрын 2014 оны 278-р тогтоол

- “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2012 оны 171-р тогтоол
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2016 оны 224-р тогтоол
- “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 66-р тогтоол
- “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тухай” Засгийн газрын 2016 оны 113-р тогтоол
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хөтөлбөрийн тухай УИХ-ын 2014 оны 16-р тогтоол,
- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2012 оны 74-р тогтоол,
- “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” УИХ-ын 2015 оны 62-р тогтоол,
- “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого” УИХ-ын 2015 оны 63-р тогтоол,
- “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2009 оны 64-р тогтоол,
- Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2010 оны 34-р тогтоол,
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2015 оны 104-р тогтоол,
- Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2003 оны 54-р тогтоол,
- Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2011 оны 30-р тогтоол болон “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Буман нарны гэрэл хөтөлбөр” зэргийг баталсны зэрэгцээ “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар ойрын болон урт хугацааны стратегийг тодорхой заан тусгасан байдаг.

2

БҮЛЭГ

НИЙГМИЙН БОДЛОГО

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОЛОН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН
СУРГАЛТЫН ТӨЛБӨР, ТӨЛБӨР ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ, СУРГАЛТЫН
ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ
ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа
Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба*

АГУУЛГА

Нэг. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тооцох үндэслэл болон холбогдох эрх зүйн орчин

- 1.1. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох, төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин
- 1.2. Төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй үндэслэл

Хоёр. Гадаадын зарим орны ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөр тогтоох, сургалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин

- 2.1. АНУ
- 2.2. Их Британи
- 2.3. Австрали
- 2.4. БНСУ

Хавсралт 1: *Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн мэдээлэл*

Судалгааны үр дүн

Судалгааны сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тогтоох үндэслэл ба аргачлал, суралцагчдад төрөөс үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой асуудлыг Монгол Улс болон өндөр хөгжилтэй гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтын хүрээнд хайлт хийж судлан, дараах мэдээллийн хүрээнд мэдээлэл лавлагаа бэлтгэсэн болно. Үүнд:

- Монгол Улсын Боловсролын салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоох аргачлал, үндэслэл болон суралцагчдад төрөөс үзүүлж буй дэмжлэгтэй холбоотой асуудлыг “Боловсролын тухай” хууль, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хүрээнд судалсан болно. Зарим мэдээллийг Боловсролын яамнаас гаргуулан авч судалгаанд хавсаргав.
- Гадаадын зарим орны /АНУ, Австрали, Их Британи, БНСУ/ ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын төлбөр тогтоож буй аргачлал, үндэслэл, оюутны сургалтын тэтгэлэг, дэмжлэг, зээлийн харилцааг зохицуулахтай холбоотой асуудлыг тухайн улс орнуудын боловсролын салбарын эрх зүйн зохицуулалтын актууд болон интернетийн эх сурвалжид тулгуурлан судалсан болно.

Судалгаанаас үзэхэд,

- Монгол Улсын хууль тогтоомжоор эрх бүхий байгууллагуудаас гаргасан журам, аргачлалын дагуу тухайн сургуулийн Удирдах зөвлөл нь сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох эрхтэй. Сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн жилийн инфляцийн түвшин, үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоодог байна. Их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо 1 оюутны тухайн жилд сонгосон кредит цагаас шалтгаалан харилцан адилгүй тогтоодог байна. Сургалтын төлбөрийн 1 кредитийн үнэлгээг шинэчлэн тогтоохдоо сургуулийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэдэг бөгөөд багш нарын цалин, практик хичээлийн зардал, судалгаа шинжилгээний ажлын зардал зэрэг сургалт судалгаатай холбоотой зардал, оюутны үйлчилгээний зардал, шууд бус зардал зэргийг тооцон тогтоодог байна.
- Их Британид Дээд боловсролын тухай хуулиар оюутны төлбөрийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталдаг байна. Тухайлбал, Дээд боловсролын тухай хуулийн 3-р бүлгийн 24 зүйлд, “Английн Дээд боловсролын санхүүгийн зөвлөл, сургуулийн дэргэдэх Хөгжлийн агентлагийн зөвлөлийн шийдвэрээр (өөрөөр хэлбэл Оюутны санхүүжилтийн газар) оюутны төлбөр, нөхцөл, тэтгэлэг, зээлийн асуудлуудыг шийднэ” гэж заажээ.
- Австралид улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөрийг тогтоохдоо үндсэн үзүүлэлт болох тухайн сургуульд нэг жилд суралцах сурагчийн тоо, нэг сурагчид ногдох хуулиар тогтоосон санхүүжилтийн хэмжээ, тухайн сургуульд үзүүлж буй олон нийтийн

санхүүгийн дэмжлэг, бусад үзүүлэлт болох хөгжлийн бэрхшээлтэй сурагчид, уугуул болон Торрес арлын сурагчид, амьжиргааны түвшин доогуур сурагч, төрөлжсөн биш энгийн сургууль, бага хүчин чадалтай сургууль зэргийг харгалзан тогтоохоор хуульчилсан.

- АНУ-д төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоох аргачлал зэргийг Холбооны улсын муж болгон өөр өөрсдийн хуулиар зохицуулах ба тухайн сургууль нь сургалтын үйл ажиллагааны дүрэм, журмаараа энэхүү асуудлыг зохицуулна. Ингэхдээ мэргэжлийн байгууллагаас жил бүр гаргадаг боловсролын үнийн индекс *Higher Education Price index*-ийг харгалзан үзэхийг зөвлөмж болгодог байна.
- БНСУ-д Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яамнаас баталсан “Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам”-д заасны дагуу Сургалтын төлбөрийн хяналтын хороо ажилладаг. Сургалтын төлбөрийн хяналтын хороо нь сургууль тус бүр дээр хуульд заасны дагуу сургалтын болон бусад шаардлагатай төлбөрийг тооцож гаргах чиг үүрэгтэй ажилладаг. Тус журмаар сургалтын төлбөрийг тооцохдоо жилийн дундаж сургалтын төлбөр дээр үндэслэн тухайн жилийн инфляцийн түвшин, зардлын өсөлт, бууралтыг харгалзан бакалавр, магистр, докторын сургалт тус бүрээр тооцож гаргасны дагуу салбарын сайд баталдаг. Хяналтын хорооны ажиллах хугацааг тухайн сургуулийн журмаар тогтоох бөгөөд ихэвчлэн 1 жил ажиллахаар тогтоосон байдаг. */Дэлгэрэнгүй мэдээллийг судалгаанаас үзнэ үү./*

Жич: Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд сургалтын төлбөрийн хэмжээг боловсролын чанарын үзүүлэлттэй уялдуулан тогтоодог аргачлал бий эсэх талаар тодорхой мэдээлэл олдоогүй болно.

Нэг. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын төлбөрийн хэмжээ, сургалтын төлбөр тооцох үндэслэл болон холбогдох эрх зүйн орчин

1.1. Монгол Улсын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох, төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин

Монгол Улсад 2016 оны байдлаар нийт 100 их дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс төрийн өмчит 17, хувийн хэвшлийн 78, гадаадын 5 салбар сургууль дээд боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн 42 их, дээд сургуулийг 16 болгон өөрчлөн зохион байгуулсанаар магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо буурсан байна. Түүнчлэн ерөнхий боловсролын улсын 590, хувийн хэвшлийн 99 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7-д төрөөс бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгохоор заасан. Үүнтэй уялдуулан Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай зэрэг хуулиудаар

салбарын эрх зүйн харилцааг зохицуулжээ. Үүнээс суралцагчдын сургалтын тэтгэлэг болон хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудлыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

Хүснэгт 1. Оюутан, сурагчдад сургалтын тэтгэлэг, дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан хуулиуд

Хууль тогтоомжийн нэр	Шийдвэрийн огноо, дугаар	Тэтгэлгийн талаарх зохицуулалт
Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль	Монгол Улсын хууль 2011 он	Энэхүү хуулиар суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний зорилго, зохион байгуулалт, дэмжлэгийн хэлбэр, хамрагдах нөхцөл боломж, санхүүжилт, хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан 5 бүлэг, 15 зүйлтэй.
Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 дугаар зарлиг	1. Дэлхийд зэрэглэлээрээ эхний 20-д багтсан сургуулиудад суралцагчдын хүсэлтийг үндэслэн, суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох, 2. Дэлхийд зэрэглэлээрээ 21-100-д багтсан сургуулиудад суралцагчид Монгол Улсын Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэлийг харгалзан, суралцагчдын хүсэлтийг үндэслэн санхүүжилт олгох,
Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам	ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоол 4 дүгээр хавсралт	Энэхүү журмаар - Сургалтын төлбөрийн зээл - Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг олгохоор журамласан.
Монгол Улсын болон гадаадын боловсролын сургалтын байгууллагад суралцагсдад төрийн буцалтгүй тусламж олгох тухай	ЗГ-ын 2008 оны 117 тогтоол	Буцалтгүй тусламж үзүүлэх нөхцөл: - Улсын хэмжээний олимпиадад эхний 3 байр эзэлсэн сурагчийн сургалтын төлбөрийг - Олон улсын зэрэглэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн амжилттай оролцсон суралцагчийн сургалтын төлбөр; - Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа Монгол Улсын иргэний амьжиргааны тэтгэлэг; - Бүтэн өнчин суралцагчийн сургалтын төлбөр; - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч буюу эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөр;

		<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр; - Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшний 50 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагчийн сургалтын төлбөр; - Бог малд шилжүүлснээр өрхийн нэг гишүүнд 50 хүртэл толгой мал ногдох малчин өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөр; - Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэний сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг.
Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам	ЗГ-ын 2013 оны 271 тогтоол	<p>Энэхүү журмын дагуу олгож байгаа сургалтын зээл нь хөнгөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.</p> <p>Дэлхийн шилдэг их сургуулийн эхний 20-д багтсан их сургуулийн суралцагч мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас баталсан мэргэжлийн чиглэлээр суралцагч сургалтын зээлд хамрагдах хүсэлт гаргах эрхтэй.</p>
Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам	ЗГ-ын 2014 оны 71 тогтоол	<p>Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмших өдрийн ангид болон хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад амьжиргааны тэтгэлэггүй суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг олгоно.</p>

Суралцагчдад төрөөс санхүүгийн дэмжлэг олгох, дэмжлэг авсан суралцагчдын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг Сургалтын төрийн сан хариуцан ажилладаг.

Мэргэжлийн хяналтын байгууллагуудаас Засгийн газраас баталсан Боловсролын хяналтын дүрмийн дагуу боловсролын тухай хууль тогтоомж, бага, дунд болон мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын байгууллагын ажлын түвшин, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.⁷² Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар, үнэлгээг хянаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Боловсролын үнэлгээний төв ажилладаг.

⁷² Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 37 зүйл

Монгол Улсын төрөөс их, дээд сургуульд суралцагчдад дараах төрлийн сургалтын төлбөрийн дэмжлэг туслалцааг үзүүлж байна. Үүнд:

1. Хөнгөлөлттэй зээл

Элсэлтийн ерөнхий шалгалтад 600 ба түүнээс дээш оноо авсан шинэ элсэгч, голч нь 2,8 ба түүнээс дээш дүнтэй суралцаж байгаа дараах суралцагчдад;

1. Хагас өнчин суралцагч;
2. Малчин өрхийн суралцагч;
3. Өрхийн нэг гишүүнд ногдох орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бүсийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн суралцагч;
4. Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан суралцагч.

2. Урамшууллын тэтгэлэг

Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад сурлагын өндөр амжилт гаргасан болон эрэлт ихтэй мэргэжлээр өдрийн ангид амжилттай суралцаж байгаа суралцагчдад **урамшууллын тэтгэлэг** олгоно.

Үүнд: Засгийн газраас баталсан 20 мэргэжил хамаарна.

- 3.6 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалаврын зэргийн суралцагчид 50 хувийн;
- 3.8 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа диплом, бакалавр, магистр, докторын зэргийн суралцагчид 75 хувийн;
- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохион байгуулсан улсын олимпиадад эхний гурван байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн;
- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олон улсын олимпиадад оролцож, шагналт байранд шалгарсан шинээр элсэгчид 100 хувийн.

3. Үндэсний тэтгэлэг

Монгол Улсын аттестатчлагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад зохих журмын дагуу элсэж, суралцах чадвар, идэвх санаачилга, төлөвшлөө илтгэн харуулсан **өдрийн ангийн** суралцагчдад **үндэсний тэтгэлэг** олгоно. Үндэсний тэтгэлэгийг 10 сарын турш, сар бүр 70.200 төгрөг олгож байгаа.

4. Сургалтын төлбөр

- Бүтэн өнчин бакалаврын зэргийн суралцагч;
- Хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын зэргийн суралцагч;
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын зэргийн нэг суралцагчид.

5. Нэрэмжит тэтгэлэг

Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэн болон сургалтын байгууллага тодорхой нөхцөл, болзол хангасан суралцагчид өөрийн нэрэмжит тэтгэлэг олгож болох бөгөөд уг тэтгэлгийн болзол, нөхцлийг тэтгэлэг олгогч этгээд тогтооно. Нэрэмжит тэтгэлэг олгодог байгууллагууд нь: Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит, Хаан болон Голомт банк,

Зориг сан, Оюу-Толгой, Монголын Оюутны холбоо, Швейцарийн хөгжлийн агентлаг гэх мэт.

6. Тухайн сургуулийн тэтгэлэг

Суралцагчийн суралцаж буй сургууль тодорхой шалгуур хангасан оюутнуудад өөрийн сургуулийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг олгодог. Тухайлбал: МУИС-ийн нэрэмжит 6 төрлийн тэтгэлэг, ШУТИС-ийн “Ректорын нэрэмжит тэтгэлэг”, Мандах бүртгэл дээд сургуулийн тэтгэлэг гэх мэт.

Орон нутгийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

7. Гадаадад суралцагчдад олгох тэтгэлэг

Гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно. Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно. Суралцагчид олгох сургалтын зээлийн нийт хэмжээ нь суралцагчийн суралцах хугацааны сургалтын төлбөр, амьжиргааны зардлын нийлбэрээс хэтрэхгүй байх бөгөөд сургалтын зээлийг буцаан төлүүлэхдээ зээлдэгчийн амьжиргаанд нь дарамт үүсгэхгүйгээр суутгал хийхээр хуульчилсан.

Хүснэгт 2. 2015-2016 оны хичээлийн жилд амьжиргааны түвшин доогуур өрхөөс суралцаж буй оюутнуудад сурлагын амжилтыг нь үндэслэн тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлсэн талаарх мэдээлэл⁷³

№	Сургуулийн нэр	Оюутны тоо	Тэтгэлэг, хөнгөлөлтийн хэмжээ	Тайлбар
1	Монгол Улсын их сургууль	208	127,100,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог
2	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	23	13,000,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог
3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	243	227,000,000.0	Зарим оюутанд зохих хөнгөлөлт үзүүлдэг, заримд нь бүтэн тэтгэлэг олгодог
4	Боловсролын их сургууль	20	20,000,000.0	Янз бүр байна
5	Монгол-Германы хамтарсан технологийн их сургууль	20	75,000,000.0	Янз бүр байна

⁷³ Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15

6	Хөдөө аж ахуйн их сургууль	61	28,365,000.0	Янз бүр байна
7	Соёл, урлагийн их сургууль	13	14,957,000.0	Янз бүр байна
8	Дорнод их сургууль	37	12,800,000.0	Янз бүр байна
9	Их засаг их сургууль	50	280,000,000.0	Янз бүр байна
10	Отгонтэнгэр их сургууль	62	59,535,000.0	Янз бүр байна
11	Этүгэн их сургууль	15	15,000,000.0	Янз бүр байна
12	Монголын үндэсний их сургууль	183	124,893,000.0	Янз бүр байна
Дүн		935	997,650,000.0	

1.2. Төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй үндэслэл

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.4-д зааснаар тухайн сургуулийн Удирдах зөвлөл нь сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох эрхтэй. Сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн жилийн инфляцийн түвшингээс хэтрүүлэхгүй байхаар салбар яамнаас чиглэл өгдөг ба өгсөн чиглэлийн дагуу 1 оюутны тухайн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тухайн жилийн инфляцийн түвшинтэй уялдуулан, эрх бүхий байгууллагаас гаргасан аргачлал, зөвлөмжийн дагуу тооцоолж жил бүр шинэчилдэг” байна. */Мандах бүртгэл” дээд сургуулийн цахим хуудаснаас авсан мэдээлэлд үндэслэв. БСШУЯ-наас холбогдох аргачлал болон журмыг ирүүлээгүй болно/*

Их, дээд сургуулиуд сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо 1 оюутны тухайн жилд сонгосон кредит цагаар тооцож харилцан адилгүй тогтоодог байна. Сургалтын төлбөрийн 1 кредитийн үнэлгээг шинэчлэн тогтоохдоо сургуулийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэдэг бөгөөд багш нарын цалин, хичээлийн практикийн зардал, судалгаа шинжилгээний ажил зэрэг сургалттай холбоотой зардал, оюутны үйлчилгээний зардал, шууд бус зардал зэрэг олон асуудлыг харгалзан үздэг байна.

Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын төлбөрийн хэмжээг тухайн сургуулийн зөвлөл хэлэлцэн тогтоодог бөгөөд үүнд яамнаас оролцох хууль эрх зүйн боломж байдаггүй байна. Зөвхөн 1 сурагчид оногдох хувьсах зардлын нормативт санхүүжилтийг тооцож олгохдоо сургалтын төлбөрийн хэмжээг харгалзан тодорхой хувиар олгох шийдвэрийг яамнаас гаргуулсан байна. */БСШУЯ-наас ирүүлсэн мэдээлэл/*

БСШУ-ны сайдын 2003 оны 158 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд кредит цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэх журам”-ыг 2014 онд “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам” болгон шинэчлэн баталсан.

ШУТИС-ийн “Кредит систем” сургалтын гарын авлагад зааснаар “Кредит цагийн үндсэн нэгж нь тухайн улирлын туршид нэг 7 хоногт танхимд нэг цагаар орох лекцийн агуулга, түүнийг багшийн удирдлагын дор бүрэн эзэмшихэд зориулагдсан семинар, бие даасан ажил, лабораторийн болон дадлагын

хичээлүүдийг агуулсан үйл ажиллагааны нийлбэр цогц юм”. Өөрөөр хэлбэл:

Кредит цаг нь:

- бакалаврын боловсрол ба кредит цаг
- оюутны хичээлийн агуулгыг эзэмшихэд зарцуулсан хөдөлмөрийн үнэлгээ
- оюутан суралцсан хичээлүүдийн агуулгыг эзэмшсэнийг илтгэх чанарын үнэлгээ, үнэлгээний голч дүнгийн тооцоо
- оюутны улирал, жилийн сургалтын төлбөр
- *багшийн хөдөлмөрийн үнэлгээ* гэсэн 5 зүйлд агуулагдсан үйл ажиллагааны нийлбэр цогц юм.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн 2014 оноос хойших сургалтын төлбөрийн 1 кредит цагийн дундаж үнэлгээ, өсөлт, бууралт зэрэг мэдээллийг сургууль тус бүрээр нь гаргасан мэдээллийг хавсралт 1-ээс үзнэ үү. 2014 оноос хойш төрийн өмчийн их дээд сургууль, коллежийн бакалаврын сургалтын төлбөр дунджаар 15.2%-аар нэмэгджээ.

Хоёр. Гадаадын зарим орнуудын ерөнхий болон их, дээд сургуулиудын сургалтын төлбөр тогтоох, сургалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин

2.1 АНУ

Бүх шатны боловсролын тогтолцоо, онцлог

АНУ-д Холбооны улсын муж бүхэн өөр өөрийн эрх зүйн зохицуулалт, боловсролын тогтолцоотой байна. Ийм учраас ерөнхий болон дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, удирдах, үйл ажиллагааг нь зохицуулах үйл ажиллагааг тухайн муж улсын эрх зүйн актаар зохицуулдаг. Нийтлэг зохицуулалтаас үзвэл, сургалтын байгууллагуудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг муж улс нь олгодог боловч тэдгээрийг магадлан итгэмжилж, сургалтын чанарыг нь баталгаажуулдаггүй. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хувийн, ашгийн бус байгууллагууд гүйцэтгэдэг байна.

АНУ-ын боловсролын системийн тогтолцоо⁷⁴

Тусгай зэрэг олгодоггүй докторын буюу ахисан түвшний мэргэжлийн зэрэг	Докторын сургалтын дараах судалгаа		
	Мэргэжлийн сургуулиуд	Докторын сургалт /2 жил/	Докторын сургалт /4 жил/
Магистрын зэрэг	/2-4 жил/	Магистрын сургалт /2 жил/	
Бакалаврын зэрэг	Их сургуулийн сургалт /4 жил/		

⁷⁴ Education chart, <http://pharmawiki.in/education-system/>

Дээд боловсролын диплом буюу гэрчилгээ	Техникийн болон мэргэжлийн сургууль /2 жил/	Олон нийтийн коллеж /2 жил/	Холимог дунд сургууль /ахлах болон дунд анги/
15-18 нас	4 жилийн ахлах сургууль /9-12/	Дээд түвшний ахлах сургууль /10-12 анги/	
9-14 нас		Завсрын ангиуд /7-9 анги/	
6-8 нас	Бага сургууль		
4-5 нас	Цэцэрлэг		
3 нас	Хүүхдийн ясли		

Бүх шатны боловсролын хяналт, санхүүжилт

АНУ-ын муж бүхнээс улсын хэмжээний боловсролын нэгдсэн систем бүрдэх ба боловсролын салбарын хяналт, санхүүжилтийн асуудлыг холбооны улсын, мужийн, орон нутгийн гэсэн 3 түвшинд шийдвэрлэдэг байна.

Ерөнхий боловсролын систем нь дунд болон ахлах сургуулиас бүрддэг. Энэ шатны сургуулиуд нь орон нутгаас сонгогдсон удирдлагатай байдаг боловч сургалтын агуулга, боловсролын стандарт, шалгуурыг Холбооны Засгийн газраас хянаж, нэг стандарттай байхыг шаарддаг.

Холбооны улсын түвшинд, цэргийн академиудыг холбооны улсын төсвөөс бүрэн санхүүжүүлдэг ба зарим сургуулиудад төрөөс дэмжлэг үзүүлж болдог байна. АНУ-ын Боловсролын яамнаас америкийн засаг захиргааны муж улсуудын боловсролын хөтөлбөрийг удирдлага, санхүүжилтээр хангаж, эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, улсын хэмжээнд мэдээлэл цуглуулах, зөвлөгөө өгөх, боловсролын зарим хөтөлбөрт санхүүгийн тусламж үзүүлэх үүрэгтэй ажиллана.

Муж улсын Үндсэн хуулиар, тухайн сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн зөвлөлийн зүгээс хяналт тавьж ажиллахыг хуульчилсан. Муж улсын хотын болон тойргийн коллеж, их сургуулиуд нь тус тусын сургалтын үйл ажиллагааг явуулахтай холбоотой дүрэм, журмуудыг тогтоох эрхтэй.

Сургалтын төлбөр тооцох үндэслэл, чанарын үзүүлэлт

Төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөрийн мэдээлэл, төлбөрийн хэмжээ, төлбөр тогтоож буй аргачлалын хувьд муж тус бүрийн сургалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдсон дүрэм журмаар тогтоосон онцлог зохицуулалттай.

АНУ-ын Дээд боловсролын тухай хууль /1998 Amendments to the Higher Education Act /1965/ US Code title 20 Part C Cost of higher Education⁷⁵/-ийн “Дээд боловсролын зардал” бүлэгт АНУ-ын Боловсролын яамны харьяа Боловсролын Статистикийн Үндэсний төв /National centre for Education Statistics/ нь холбооны улсын түвшинд дээд боловсролын байгууллагуудын зардал, сургалтын төлбөртэй холбогдох үндэсний хэмжээний аргачлал боловсруулах чиг үүрэгтэй.

⁷⁵ 1998 Amendments to the Higher Education Act, <http://www2.ed.gov/policy/highered/leg/hea98/index.html>

Боловсролын Статистикийн Үндэсний төв нь оюутны сургалтын төлбөр, хураамжийн жишиг стандартыг боловсруулна. Комиссар нь Боловсролын байгууллагын сургалтын төлбөр, хураамжийн стандартыг тодорхойлохдоо дараах судалгаанд үндэслэнэ. Тухайлбал,

- Хэрэглээний үнийн индекс, инфляци болон бусад холбогдох хүчин зүйлсийн харьцуулалт;
- багш нарын цалин, тэтгэмж;
- захиргааны ажилтнуудын цалин, тэтгэмж, зардал;
- академик сургалтанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ;
- судалгаа шинжилгээ;
- үйл ажиллагааны болон засварын зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой зардал.

Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр тогтоохдоо мэргэжлийн байгууллагаас жил бүр гаргадаг боловсролын үнийн индекс *Higher Education Price index*-ийг харгалзан тооцох аргачлалыг боловсруулсан. Тус улсад боловсролын байгууллагуудын магадлан итгэмжлэлийг магадлан итгэмжлэх эрх бүхий төрийн бус байгууллагууд хэрэгжүүлэх ба коллеж, их сургуулиудын дээд боловсролын хөтөлбөрийн чанар, сайжруулж буй байдалд хяналт, шалгалт хийнэ.

Оюутнуудад үзүүлдэг тусламж, дэмжлэгүүд

1965 оны АНУ-ын “Дээд Боловсролын Тухай хууль” (*Higher Education Act, Title IV- Student Assistance*), 2008 оны Их, Дээд Боловсролын Боломжийн тухай (*Higher Education Opportunity Act, Title IV- Student Assistance*) зэрэг хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн (*Student Aid*) гол зорилго нь **буцалтгүй тусламж (grant)** болон **зээлд (loan)** хамрагдах болзлыг хангаж буй бүх оюутнуудыг эдгээр санхүүгийн тусламж дэмжлэгт (*Aid*) хамруулах явдал юм. Эдгээр хөтөлбөрүүдээр дамжуулан АНУ-ын засгийн газраас жил бүр 83 тэрбум гаруй долларын зээл болон буцалтгүй тусламжийг 14 сая их дээд сургуульд суралцагсдад олгож байна.

Нэгдсэн Улсын Боловсролын Газрын харъяа Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн газраас (*Federal Student Aid*) оюутнуудад олгож байгаа дэмжлэгийг буцалтгүй тусламж (*grants*), ажиллаж-сурах болон зээл хэмээн 3 ангилж дэмжлэг үзүүлдэг байна.

АНУ-ын Засгийн газраас оюутнуудад үзүүлдэг тусламж дэмжлэгүүд

Зээл тусламж	Хэлбэр	Эрх зүйн акт	Хэнд	Хэмжээ (жилд)
Холбооны засгийн газрын Пеллийн тэтгэлэг (Сенатч Клейборн Пеллийн нэрэмжит)	Буцалтгүй тусламж (grant)	Higher Education Act 1965, Title IV, Subpart 1, Sec.401 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.401	Бакалаврын оюутнуудад зориулсан. Хүсэлт гаргасан оюутнуудын санхүүгийн хэрэгцээг харгалзан олгоно.	2008–09: \$400–\$4,731

Холбооны ЗГ-ын боловсролын нэмэлт тэтгэлэг (FSEOG)	Буцалтгүй тусламж (grant)	Higher Education Act 1965, Title IV, Subpart 3 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.406	Санхүүгийн онцгой хэрэгцээ бүхий оюутнуудад зориулсан. Пеллийн тэтгэлэгт хамрагдагсад давуу эрхтэй байна. Уг тэтгэлгийг тухайн сургуулийн санхүүгийн боломжийг харгалзан олгоно.	\$100–\$4,000
Сургалт судалгааны өрсөлдөх чадварын тэтгэлэг (ACG)	Буцалтгүй тусламж (grant)	Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.402	Пелл тэтгэлэгт хамрагдах боломж бүхий, мэргэжлийн сертификат олгох хөтөлбөрийн 1 болон 2 дугаар дамжаанд эсвэл зэрэг олгох хөтөлбөрийн 1 дүгээр дамжаанд суралцаж байгаа, хамгийн багадаа <u>half-time</u> сургалтанд хамрагдагсад.	2-р дамжаа: \$1,300 хүртэл
			2-р дамжаа: ахлах сургуулийн чанд хатуу сургалтанд хамрагдсан, 2005 оны 1 сарын 1-нээс хойш төгссөн, их дээд сургуулийн 1-р дамжаагаа хамгийн багадаа 3 голч дүнтэй дүүргэсэн.	
Шинжлэх ухаан, математикийн үндэсний тэтгэлэг (National SMART Grant)	Буцалтгүй тусламж (grant)		Пеллийн тэтгэлэгт хамрагдах боломжтой их дээд сургуулийн 3, 4 (5 жилийн хөтөлбөр бол 5) –р дамжаанд хамгийн багадаа <u>half-time</u> суралцдаг оюутнууд. Дүнгийн голч нь 3-аас дээш байх.	Жилд \$4,000 хүртэл
Коллеж болон Их дээд сургуулиудад Багшийн мэргэжлээр сурч буй оюутнуудад үзүүлэх тэтгэлэг (TEACH) Grant	Нөхцөлтэй буцалтгүй тусламж (grant): Тус үйлчилгээний үүрэг шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тэтгэлэг олгогдсон өдрөөс эхлэн хүүг нөхөн тооцож, үндсэн мөнгөн дүнгийн хамт төлнө.	Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.412	Бага болон дунд сургуулийн багш болохоор Бакалавр болон магистр докторын зэргээр сурч байгаа болон сурах гэж байгаа “Алба хаах гэрээ”-нд гарын үсэг зурсан оюутнууд. Тус гэрээнд гарын үсэг зурснаар тухайн оюутан нь сургуулиа төгссөнийхөө дараа 8 жилийн дотор шаардлагатай байгаа салбарт бага болон дунд сургуульд бүтэн 4 жил ажиллахыг зөвшөөрнө.	Жилд \$4,000 хүртэл

Холбооны ЗГ-ын ажиллах-сурах хөтөлбөр	Сургуульд сурч байх хугацаандаа ажиллаж олсон мөнгө буцаж төлөгдөхгүй.	Higher Education Act 1965, Title IV, Sec.441 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.441	Бакалавр болон Магистр докторын оюутнууд сургууль болон сургуулиас гадуур ажиллах боломжтой бөгөөд хамгийн багадаа цалингийн доод хэмжээгээр цалинжина.	Тогтсон хэмжээ байхгүй.
Федерал Перкинзийн зээл	Зээл: эргэн төлөгдөнө	Higher Education Act 1965, Title IV, Sec.461 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461	Бакалавр болон магистр докторын оюутнуудад зориулсан. Зээл олгосон сургуульдаа эргэн төлнө. 5 хувийн хүүтэй	Бакалаврын сургалт: \$5,500 хүртэл; магистр доктор боон мэргэжлийн зэрэг: \$8,000 хүртэл
Дэмжлэгтэй Стаффордын зээл	Зээл: эргэн төлөгдөнө		Дэмжлэгтэй Стаффордын зээлийн хүүг Нэгдсэн Улсын Боловсролын Газар хариуцаж төлөх бөгөөд уг зээлийг хүлээн авагч нь санхүүгийн хэрэгцээгээ баталж үзүүлэх шаардлагатай. Хамгийн багадаа <u>half-time</u> –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6 хувийн хүүтэй.	Дүнгийн байдлыг харгалзан \$3,500–\$8,500 байна.
Дэмжлэггүй Стаффордын зээл	Зээл: эргэн төлөгдөнө	Higher Education Act 1965, Title IV, Sec.4286H	Дэмжлэггүй Стаффордын зээлийн хүүг зээлдэгч өөрөө төлөх бөгөөд санхүүгийн хэрэгцээгээ заавал батлан үзүүлэх шаардлагагүй. Хамгийн багадаа <u>half-time</u> –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6,8 хувийн хүүтэй.	дүнгийн байдал болон гэр бүлийн хараат хүмүүс бий эсэхийг харгалзан \$5,500–\$20,500
ПЛАС зээл	Зээл: эргэн төлөгдөнө	Higher Education Act 1965, Title IV, Sec.428.B Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461	Их дээд сургуулийн бакалавр болон магистр, докторын сургалтанд хамгийн багадаа <u>half-time</u> хамрагддаг, эцэг эхээсээ хараат байдаг оюутнуудын эцэг эхэд зориулсан зээл. Санхүүгийн хэрэгцээг батлах шаардлагагүй. Зээлдэгч нь урьд өмнө ямар нэгэн зээл авч байсан бол зээлийн зөрчилгүй байх. ПЛАС зээл нь дэмжлэггүй зээл бөгөөд зээлдэгч нь бүх хүүг төлнө. 8,5 хувийн хүүтэй.	Дээд хэмжээ нь тухайн сургуульд суралцахад шаардлагатай, сургалт, ном, байр хоол гэх мэт бүх зардлаас оюутны авч буй бусад санхүүгийн тусламжийг хассантай тэнцүү байна. Доод хязгаар байхгүй.

Дээрх зээл тусламжид хамрагдахад дараах үндсэн шалгууруудыг харгалзана. Үүнд:

- Санхүүгийн хэрэгцээ шаардлагаа баталж үзүүлэх (дээр хүснэгтэд дурдсан тодорхой зээлүүдээс бусад);
- Их дээд сургуулийн ямар нэгэн зэрэг, сертификатын хөтөлбөрт хамрагдах;
- Их дээд сургуулийн боловсролд хамрагдах боломжтой болохоо доорх хэлбэрүүдийн аль нэгээр батлах. Тухайлбал,
 - Дунд сургууль төгссөн гэрчилгээ эсвэл Ерөнхий Боловсролын Хөгжлийн Сертификат;
 - Дунд сургуулийн диплом эсвэл ЕБХС байхгүй бол тухайн сургуульд элсэн суралцах чадвартай эсэхийг шалгах шалгалтад тэнцсэн байдал;
 - Холбооны Засгийн газрын зүгээс хүлээн зөвшөөрсөн тухайн муж улсын бусад стандартуудыг хангасан эсэх;
 - Мужийн хуулийн дагуу гэрээр дунд сургуулийн боловсрол эзэмшсэн;
 - Их, дээд сургуульд элсэн орсныхоо дараа шаардлагатай сурлагын түвшинг хангаж чадах.

2.2. АВСТРАЛИ УЛС

Австрали улсын боловсролын чанар, стандарт нь дэлхийд дээгүүрт ордог бөгөөд улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн нэг нь боловсролын салбар юм. Тус улс нь бүх шатны боловсролыг жигд, хүртээмжтэй, чанартай олгох зорилгоор бүх шатны боловсролд нэгдсэн стандартыг хэрэгжүүлж даяарчлагдсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, хөрвөх чадвар бүхий боловсон хүчин бэлтгэхэд төрийн бодлогоо чиглүүлэн ажилладаг.

Австрали улсын засгийн газраас бага, дунд сургуулийн сурагчдыг даяарчлагдсан нийгэмд хөдөлмөр эрхлэх чадвартай мэдлэг олгох зорилгоор 2008 онд “Боловсролын шинэчлэлийн хөтөлбөр”-ийг баталж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас бага, дунд сургуулиудтай гэрээ байгуулж ажилласан нь үр дүнгээ өгч бага, дунд боловсролын чанараараа дэлхийн хэмжээнд тэргүүлэх болсон байна.

Өнөөгийн байдлаар тус улсын их, дээд сургуулиудаас 11 нь дэлхийн шилдэг 100 сургуулийн жагсаалтад багтдаг.

Австралийн дээд боловсролын чанар, стандартын агентлаг⁷⁶/TEQSA/

Дээд боловсролын чанар, стандартын агентлаг нь Австралийн хувийн болон улсын дээд сургуулиудын боловсролын босго стандарт, чанарыг баталж мөрдүүлэх, оюутнуудын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй ажилладаг бие даасан агентлаг бөгөөд үйл ажиллагаа болон гаргасан шийдвэр, зохицуулалтынхаа талаар олон нийтэд ил тод мэдээлэх, тайлагнах үүрэгтэй байдаг. Агентлагийн шийдвэр, зохицуулалтын хэрэгжилтэнд олон нийтийн нөлөөлөл чухал үүрэгтэй.

Улсын болон хувийн их, дээд сургуулиуд нь Дээд боловсролын чанар, стандартын агентлагт бүртгүүлж, 7 жил тутамд магадлан итгэмжлэл

⁷⁶ TEQSA, <http://www.teqsa.gov.au>

хийлгэдэг. Мөн **дээд боловсролын чанар, стандартын агентлаган харьяа** хилийн чанадад суралцаж байгаа оюутнуудын эрх ашгийг хамгаалах, боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллага /ESOS-Education Services for Overseas Students/⁷⁷ нь гадаадад суралцаж буй оюутнуудад боловсролын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ үзүүлж, эрх ашгаа хамгаалахад нь дэмжлэг үзүүлдэг.

Дээд боловсролын чанар, стандартын агентлагийн үйл ажиллагаа, эрх, үүргийг “Дээд боловсролын чанар стандартын агентлагийн тухай хууль”⁷⁸/2011/-аар зохицуулдаг.

Бүх шатны сургуулийн санхүүжилт, сургалтын төлбөр тогтоох үндэслэл⁷⁹

Австрали улсын бүх шатны сургуульд улсын болон орон нутгийн санхүүжилт олгодог бөгөөд хувийн болон улсын сургуулийн санхүүжилт харилцан адилгүй байна. Энэхүү санхүүжилтийг Австралийн Боловсролын тухай хууль /2013/⁸⁰-д заасан аргачлалыг үндэслэн олгодог. Улсын мэдлийн бага, дунд сургууль нь тухайн улсын иргэнд үнэ төлбөргүй байдаг бөгөөд улс болон орон нутгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.

Тус хуулийн 3, 4 дүгээр бүлэгт зааснаар дараах үзүүлэлтүүдийг томъёолж тухайн сургуульд хуваарилах санхүүжилтийн хэмжээг тодорхойлдог байна. Үүнд:

- Үндсэн үзүүлэлт болох тухайн сургуульд нэг жилд суралцах сурагчийн тоо,
- нэг сурагчид ноогдох хуулиар тогтоосон санхүүжилтийн хэмжээ,
- тухайн сургуульд үзүүлж буй олон нийтийн санхүүгийн дэмжлэг,
- бусад үзүүлэлт болох хөгжлийн бэрхшээлтэй сурагчид,
- уугуул болон Торрес арлын сурагчид, амьжиргааны түвшин доогуур сурагч, төрөлжсөн биш энгийн сургууль, бага хүчин чадалтай сургууль зэргийг харгалзан тогтооно.

Энэхүү хуулийн ач холбогдол нь тухайн сургуулийн хэрэгцээнд тохирсон санхүүжилт олгодог болсон, сургалтын чанар, санхүүжилтийг нээлттэй ил тод, ойлгомжтой байх нөхцлийг бүрдүүлж өгсөн байна.

Австрали улсын их, дээд сургуулиуд нь Дээд боловсролыг дэмжих тухай хууль /2003/ хуулийн дагуу жил бүр сургалтын төлбөрөө тогтоодог. Сургалтын төлбөрийг их дээд сургуулийн зөвлөл тогтоох эрхтэй бөгөөд сургалтын зардал, стратеги төлөвлөгөө, зах зээлийн эрэлт хэрэгцээний чиг хандлага, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, зардлын өсөлтийн таамаг, улсаас тавьсан хязгаарлалт, шаардлагатай холбоотой эрх зүйн баримт бичиг зэргийг үндэслэн дараах зарчмыг баримтлан сургалтын төлбөрөө тогтоодог. Үүнд:

- Сургуулийн стратеги төлөвлөгөө, санхүүгийн бодлоготой уялдсан байх;
- Газар нутгийн байршил, сургалтын онцлог, сургалтын төрлийг харгалзан үзэх;
- Хууль, тогтоомж, бодлого журамтай нийцсэн байх;
- Төлбөрийн тухай мэдээлэл олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх;

⁷⁷ Education Services for Overseas Students , <http://www.esos.curtin.edu.au>

⁷⁸ Tertiary Education Quality and Standards Agency Act /2011/, <https://www.legislation.gov.au/Details/C2015C00622>

⁷⁹ Department Of Education and Training, <https://www.education.gov.au/>

⁸⁰ Higher Education Act /2013/, <https://www.legislation.gov.au/Details/C2013A00067>

- Сургалтын төлбөрийн буцаан олголт, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлтийг улсын болон сургуулийн хууль тогтоомжид нийцүүлсэн байх.

Төрөөс их, дээд сургуулийн оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэг⁸¹

Дээд боловсролыг дэмжих тухай хууль /2003/ хуулиар төрөөс их, дээд сургуулийн оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэгүүд нь дараах хэлбэртэй байна. Тухайлбал,

Хамтын нөхөрлөлийн орнуудын дэмжлэгийн газар /Common Wealth Supported Place/

Хамтын нөхөрлөлийн орнуудын дэмжлэгийн газар нь дээд боловсрол эзэмших оролцоог нэмэгдүүлж, дэмжих зорилготой. Австралийн засгийн газар нь CSP санхүүжүүлэн дэмждэг бөгөөд, төлбөрийн хэсгийг шууд тухайн сургуульд нь төлдөг. Дэмжлэг нь зээл биш бөгөөд оюутнууд дэмжлэгийн мөнгийг буцааж төлөх шаардлагагүй. Гэхдээ оюутнууд өөрийн сурч буй чиглэлээс хамааран оюутны оролцооны хувь болох төлбөрийн үлдэгдэлийг өөрөө төлөх ёстой ба энэхүү төлбөрийн хэмжээг Австралийн засгийн газраас тогтооно.

Дээд боловсрол олгох зээлийн хөтөлбөр /Higher Education Loan Programme/
Дээд боловсрол олгох зээлийн хөтөлбөр нь оюутнуудын сургалтын төлбөрийг төлөхөд туслах зорилготой, хүү бодогдохгүй. Хаана суралцах, тухайн оюутны санхүүгийн байдал зэргээс шалтгаалан энэхүү хөтөлбөр нь дараах 5-н төрлийн зээлээс бүрддэг:

- **HECS-HELP-** Оюутны зээл болон хөнгөлөлт. Оюутны оролцооны хувь болох төлбөрийг төлөх, эсвэл \$500 болон түүнээс дээш дүнтэй урьдчилгаа төлбөр төлсөн оюутнуудад 10%-ийн хөнгөлөлт олгох.
- **FEE-HELP-** Оюутны сургалтын төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд тусалдаг. Энэхүү зээлийг байр, орон сууц болон сурах бичиг худалдан авах зэрэгт ашиглаж болохгүй.
- **VET-FEE-HELP-** Илүү өндөр түвшний мэргэжлийн боловсрол, сургалтанд хамрагдаж өндөр ур чадвар олж авахад туслах. Шалгуур нь, мэргэжлийн дипломын зэрэг болон түүнээс дээш. Зөвхөн сургалтын төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд зориулагдах ба байр орон сууц болон сурах бичиг зэргийн зардал багтахгүй.
- **SA-HELP-** Оюутны сургалтын төлбөр болон бусад хэрэгцээний зардлыг бүхэлд нь болон хэсэгчлэн төлөхөд тусалдаг.
- **OS-HELP Loan-** Зөвхөн хамтын нөхөрлөлийн оронд суралцах тохиолдолд олгогдох бөгөөд олгогдох дүн нь байр орон сууц, нислэгийн зардлаас хамаарна. Оюутнууд суралцах хугацаандаа 2 удаа энэхүү зээлийг авах боломжтой.

Оюутны орлогын дэмжлэг /Student Income Support/

Хүмүүнлэгийн үйлчилгээний газраас хэрэгжүүлдэг бүтэн болон хагас цагаар суралцдаг оюутнууд, Австралийн дадлагажигч оюутан нарт олгох боломжтой дэмжлэг байдаг. Үүнд :

- **Youth Allowance**-Австралийн 16-24 насны бүрэн цагаар суралцдаг оюутан болон Австралийн дадлагажигч нарт олгогддог сургалтын төлбөрийн дэмжлэг,

⁸¹ Higher education support act 2003, www.studyassist.gov.au

- **Austudy**- 25 болон түүнээс дээш насны бүрэн цагаар суралцдаг болон Австралийн дадлагажигч нарт олгогддог дэмжлэг,
- **AUBSTUDY**- Австралийн Уугуул болон Торрес арлын 16 болон түүнээс дээш насны оюутнуудад олгодог амжиргааны болон бусад нэмэлт дэмжлэг,

Хүүхэд асрах тэтгэмж /Child care assistance/

Мөн Австралийн засгийн газраас “Хүүхэд Асрах Тэтгэмж болон Хүүхэд Асрах Хөнгөлөлт”-өөс батлагдсан хүүхэд асрахад гарах зардлыг олгох санхүүгийн тусламжийг гэр бүлд үзүүлдэг.

Тэтгэлэг /Scholarship/

Бакалавр, магистр, докторын түвшинд болон судалгааны олон салбарт олгогддог нилээдгүй олон төрлийн тэтгэлэг байдаг. Эдгээр нь Австралийн болон олон улсын оюутнуудын аль, алинд нь олгогдох боломжтой тэтгэлэг юм.

2.3 ИХ БРИТАНИ

Их Британи улсын боловсролын салбарын үйл ажиллагааг “Боловсролын тухай хууль” (Education Act 2011), “Дээд боловсролын тухай” (Higher Education Act 2004), “Академийн тухай хууль 2010” (Academies Act 2010), “Хүүхдийн суралцах болон ур чадварын дадал, чадвар олгох тухай хууль” 2009, (The Apprenticeships, skills, children and learning Act 2009), “Боловсрол ба хяналт шалгалтын тухай хууль” 2009 (The Education and Inspections Act 2009), “Дээд боловсролын тухай хууль ба нэмэлт” 1992 (The Further and Higher Education Act 1992) зэрэг хуулиудаар зохицуулж байна.

Их Британид их, дээд сургуулийн сургалтын чанарыг Засгийн газрын Дээд боловсролын Чанарын Баталгааны Агентлаг (*Quality Assurance Agency for Higher Education*—QAAHE) хариуцан ажиллах ба их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, оюутнуудад дэмжлэг үзүүлэх болон сургалтын орчин, чадавх хэр зэрэг байгаад үнэлгээ өгч, тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэдэг байна.

ИБУИНВУ-д 2015 оны 12 сард гаргасан судалгаагаар төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 130 их дээд сургууль, коллеж байдаг ба үүнээс 106 нь Англид байдаг байна.

Английн Дээд Боловсролын Санхүүжилтийн Зөвлөл (Higher Education Funding Council for England—HEFCE)

Английн Дээд Боловсролын Санхүүжилтийн Зөвлөл нь их, дээд сургуулиудын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсролын байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх болон өндөр чанартай боловсрол олгох, судалгаа болон холбогдох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой. 2015-2016 онд тус зөвлөл нь Английн их, дээд сургууль коллежид Их Британийн Засгийн газраас олгосон 3,97 тэрбум фунт стерлинг хуваарилжээ. Энэхүү санхүүжилтийг их, дээд боловсролын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагуудыг санхүүжүүлэх, оюутнуудад тэтгэлэг болон

зээл олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх зэрэгт зарцуулжээ. Мөн их, дээд сургуулиудад багшлах боловсон хүчин бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны төслийг санхүүжүүлэх, боловсролын байгууллага болон олон нийтийн уялдаа холбоог бий болгох, салбарын манлайлал, засаглал, менежментийг сайжруулах, оюутны сэтгэл ханамжийн үнэлгээнд суурилсан тогтолцоог бий болгоход анхаарсан.

Их Британид төрөөс оюутнуудад үзүүлэх дэмжлэгийг “Английн дээд боловсролын санхүүжилтийн зөвлөл” (*Higher Education Funding Council for England*), Английн оюутны санхүүжилтийн газар /*Student Finance England*/ зэрэг бие даасан байгууллагууд хариуцдаг.

“Боловсролын тухай хууль”-ийн 9-р бүлгийн 76-77 зүйлд оюутны сургалтын төлбөр, зээл, төлбөрийн хөнгөлөлт, сургалттай холбоотой асуудлыг Английн боловсролын салбарын Төрийн нарийн бичгийн дарга, Уэльстэй холбоотой асуудлыг Уэльсийн боловсролын сайд хариуцахаар заасан байдаг.

“Дээд боловсролын тухай” хуулийн 3-р бүлгийн 23 зүйлд зааснаар оюутны төлбөрийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлахаар хуульчилсан, ингэхдээ Английн Дээд боловсролын санхүүгийн зөвлөл, сургуулийн дэргэдэх Хөгжлийн агентлагын зөвлөлүүдийн шийдвэрийг харгалзан үзэж (*өөрөөр хэлбэл оюутны санхүүжилтын газар*) оюутны төлбөр, гэрээний нөхцөл, тэтгэлэг, зээлийн асуудлуудыг шийднэ гэж заажээ.

Мөн хуулийн 3-р бүлгийн 24 зүйлд зааснаар Английн дээд боловсролын санхүүжилтийн зөвлөлөөс сургалтын төлбөрийг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан тухайн жилийн академик болон курсээр олгох сургалтын хөтөлбөрийн батлагдсан агуулгад нийцүүлэх, төлбөрийг төлөвлөгөөнд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх зэрэг заалтуудыг мөрддөг байна.

Англи, Уэльс, Умард Ирланд нь төрөөс санхүүжилт олгох их, дээд сургуулиудын боловсролын чанарыг үнэлэх зорилгоор **Дээд боловсролын чанарын үнэлгээний шинэчилсэн загвар**⁸² хэмээх баримт бичгийг гаргажээ. 2016-2018 онд энэхүү чанарын үнэлгээний загварыг туршилтын журмаар Англи, Уэльс, Умард Ирланд, Шотландад хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Чанарын үнэлгээний шинэчилсэн загвар нь Европын стандарт, аргачлал, зааврын дагуу илүү нарийвчилсан түвшинд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны чанарыг үнэлэх зорилготой. Ингэснээр сургалтын байгууллагуудын засаглал, удирдлага, санхүүжилтийн хэлбэрийг сайжруулах, санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бий болгох, сургалтын байгууллагуудыг төлөвшүүлэх, хамтын засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, дээд боловсролын стратеги төлөвлөгөө, бодлогын орчинг сайжруулах, иргэдэд тэгш хүртээмжтэй дээд боловсрол олгох зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөсөн байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх явцад ИБУИВУ-ын хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрсөн чанарын үнэлгээний системийг боловсруулан төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой хэмээн үзсэн байна.

⁸² <http://www.hefce.ac.uk/pubs/yeartr/2016/201603/>

Оюутны дэмжлэг тусламж

Английн Засгийн газраас Английн оюутны санхүүгийн байгууллагаар дамжуулан тэтгэмж */grant/*, зээл */loan/*, сургуулиас нь олгодог тэтгэлэг */bursary/* зэрэг хэлбэрүүдээр оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд оюутан хэрэгцээтэй үедээ санхүүгийн дэмжлэг авах ба энэ мэт авсан зээлээ сургууль төгсөх хүртлээ буюу жилд £ 15000 фунт стерлинг орлого олдог болох хүртлээ эргүүлэн төлөхгүй байж болно.

Дээрх хууль тогтоомжид заасны дагуу Англи Улсын Засгийн газраас их дээд сургуулийн оюутнуудад зориулан дараах төрлийн дэмжлэг туслалцааг үзүүлдэг. Үүнд:

1. Буцалтгүй тусламж, тэтгэлэг */Grant/*
2. Зээл */Loan/* гэсэн үндсэн хоёр төрлийн дэмжлэг хамаарна.

1. Буцалтгүй тусламж, тэтгэлэг

- *Эргэн төлөгдөх нөхцөлгүй амьжиргааны тэтгэлэг:*

Энэ нь сар тутам тогтоосон хэмжээгээр тогтмол олгодог тэтгэлэг юм. “Боловсролын тухай” болон “Дээд боловсролын тухай” хуулиудад зааснаар жилийн £25000-аас доош орлого бүхий айлын хүүхдүүд £2906 хүртэл тэтгэмж авах эрхтэй. Харин жилийн £50020 хүртэл орлоготой айлын хүүхдүүд хэсэгчилсэн тэтгэлэг авдаг байна. Хэрэв шинээр их дээд сургуульд элсэн орж байгаа бол тухайн оюутнуудын 40% нь бүрэн амьжиргааны тэтгэлэгт хамрагдах боломжтой байдаг байна. */Бүрэн амьжиргааны тэтгэлэг нь оюутны суралцахад шаардагдах бүхий л амьжиргааны зардлыг санхүүжүүлэхийг хэлнэ/*

- *Хүүхэдтэй болон тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг:*

Энэ нь суралцахыг хүсэж байгаа бөгөөд тэднээс хамааралтай асрамжлах шаардлагатай хүмүүстэй хамт амьдардаг тохиолдолд төрөөс тэдгээр оюутнуудад үзүүлдэг нэмэлт амьжиргааны тэтгэлгийг хэлнэ. Энэ төрлийн тэтгэлэг нь дараах хэлбэртэй байна.

Хүүхэдтэй болон бусад тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг	Дээд хэмжээ
Хүүхэдтэй оюутны тэтгэлэг	
-1 хүүхэдтэй бол	долоо хоногт £ 148,75
-2 хүүхэдтэй бол	долоо хоногт £255
Эцэг эхийн сургалтын тэтгэмж	жилд £ 1508
Насанд хүрсэн тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг <i>/насанд хүрсэн хүүхэд орохгүй/</i>	жилд £2642

- *Тахир дутуу болон хөгжлийн бэрхшээлтэй оюутны тэтгэлэг:*

Мөн дээр дурьдсан хуулиудад зааснаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад доорх төрлийн тэтгэлгийг дараах хувь хэмжээтэйгээр олгоно. Үүнд:

Тусгай аппарат хэрэгслийн тэтгэмж	нэг курст £ 5161.
Эмнэлгийн бус тусламжийн тэтгэмж <i>/бүтэн болон хагас өдрөөр сурч байгаатай холбогдон өөрчлөгдөнө./</i>	жилд £20520.

Тахир дутуугийн тэтгэмж	Жилд £ 1724
Замын зардал:	дээд хязгаар байхгүй.

2. Зээл

- *Сургалтын төлбөрийн зээл:*

Английн Засгийн газраас дээд сургуулиудын оюутнуудын хувьд сургалтын төлбөрт нэмэрлэх зорилгоор олгодог сургалтын төлбөрийн зээл олгох харилцаа хуулиар зохицуулагдсан байх ба түүний хэмжээ нь £ 3290 хүртэл байна. Уг зээлийн хэмжээг оюутны ар гэрийн жилийн дундаж орлогыг харгалзан тогтоодог бөгөөд “Английн оюутны санхүүжилтийн газар” (*Student finance department of England*)-аас тухайн сургууль руу шууд шилжүүлдэг.

Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад тавигдах шаардлагууд:

- Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт бол
- Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болон тус улсад чөлөөтэй орж гарах зөвшөөрөл авсан бол
- Оюутан болон түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харъяат бол
- Оюутан тус улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан бол
- Хуульд заасан бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд Засгийн газрын зээлд хамрагдах эрхтэй болно.

Зээлийн эргэн төлөлт: Оюутны сургалтын зээлийг дараах хэлбэрээр эргэн төлж болно. Үүнд:

- Зээлдэгч зээлээ шууд “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”-т төлөх
- Татварын системээр дамжуулан төлөх
- Ажил олгогч цалингаас нь хасах хэлбэрээр гэсэн үндсэн 3 хэлбэрээр төлнө.

“**Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс**” нь Их Британийн Боловсролын яамны харьяа газар бөгөөд их, дээд сургууль төгсөгчдийн ажил, эрхлэлт, сургалт болон түүнтэй холбоотой бусад асуудлыг хариуцах ба нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

Гадаадын зээлдэгч нар нь 3 сараас илүү хугацаагаар Их Британиас гарах тохиолдолд “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”-д мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сар бүрийн тогтсон өдөр төлбөрийн төлөвлөгөөний дагуу зээлийг эргэн төлнө. Хэрэв зээлдэгчийг тогтсон төлөвлөгөөний дагуу зээлээ тогтмол төлж байна гэж үзвэл “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс” нь орлогын дагуу төлөхийг зөвшөөрдөг. Зээлдэгч төлбөр хийх хугацаанаас хойш 12 сарын цалингийнхаа нийлбэрийн 9%-тай тэнцэх мөнгийг 12 хувааж төлнө.

- *Эргэн төлөгдөх нөхцөлтэй амьжиргааны зээл:*

Оюутны хоол байрны мөнгө, сургалтын материалын төлбөр зэрэг сургалтын бусад зардлыг төлөхөд зориулсан зээл юм. Уг зээлийн хэмжээ нь хаана сурч байгаа болон өөр эрх бүхий байгууллагаас амьжиргааны тэтгэлэг авсан эсэх, оюутны өөрийн болон ар гэрийн орлогын хэмжээнээс хамаарна. Тухайлбал,

- эцэг эхээсээ хол Лондон хотод сурч байгаа бол жилийн £6928,
- эцэг эхээс хол, Лондонгоос бусад хотод сурч байгаа бол £ 4950,
- сурах хугацаандаа эцэг эхийн хамт амьдарч байгаа бол жилд £ 3838 гэх мэт харилцан адилгүй хэмжээтэй байна.

Дээрх тэтгэлэг болон зээлүүдэд хамрагдахад доорх ерөнхий болзлууд шаардагдана. Үүнд:

- Нэгдсэн Вант Улсын иргэн байх, эсвэл тогтмол суурьшилтай оршин суугч байх.
- Хэвийн оршин суугч байх.
- Их дээд сургуулийн сургалт эхлэхээс 3 жилийн өмнөөс эхлэн Нэгдсэн Вант Улс, Канадын арлууд болон Менийн аралд оршин суусан байх.
- Амьжиргааны зээлд хамрагдахад 60-аас доош настай байх, /харин сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад насны дээд хязгаар байхгүй./
- Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт байх зэрэг ерөнхий шаардлагуудыг хангасан байх шаардлагатай.

2.4. БНСУ

Солонгос улсын боловсролын салбарын эрх зүйн харилцааг Суурь боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Цэцэрлэгийн боловсролын тухай хууль, Хувийн сургуулийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг. Тус улсын их, дээд сургуулиудын дийлэнх нь хувийн хэвшлийн сургуулиуд байдаг. /Нийт 171 их, дээд сургуулийн 145 нь буюу 85% нь хувийн хэвшлийн сургуулиуд байна./

Солонгосын боловсролын салбарын хяналтын чиг үүргийг Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яам өмчийн хэлбэр үл харгалзан хэрэгжүүлэх бөгөөд Дээд боловсролын тухай хууль⁸³ болон Хувийн сургуулийн тухай хууль, Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам⁸⁴-д заасны дагуу сургалтын төлбөрийн жишгийг баталж өгдөг. Улсын сургуулиудын хувьд төсвөөс бүх санхүүжилтээ авдаг бол хувийн сургуулиудын хувьд санхүүжилтийн гол эх үүсвэр нь сургалтын төлбөр байдаг. Хувийн сургуулийн зардлын ердөө 3%-ийг төрөөс санхүүжүүлж байна.

Солонгос улсын Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яамны 2013 онд баталсан “Их сургуулийн сургалтын төлбөрийг тогтоох журам”-д заасны дагуу Сургалтын төлбөрийн хяналтын хороо ажилладаг. Сургалтын төлбөрийн хяналтын хороо нь сургууль тус бүр дээр Дээд боловсролын тухай хуульд заасны дагуу сургалтын болон бусад төлбөрийг тооцож гаргах чиг үүрэгтэй ажилладаг. Хяналтын хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба сургууль оюутан суралцагсад, төгсөгчдийн хороо болон эцэг, эхийн төлөөллийг оролцуулна.

Тус журмаар сургалтын төлбөрийг тооцохдоо Боловсролын тухай хуулийн 11.7-г удирдлага болгон өнгөрсөн жилийн дундаж сургалтын төлбөр дээр

⁸³ Higher education law /http://www.moleg.go.kr/english/korLawEng.jsessionid=N8rtIMXT6nkiiKgZ3DnKMKLeeWiaiaiw7RUXnMmfzHs3mnZ-Tef15GdovVliQ1Al.moleg_a2_servlet_engine2?pstSeq=52250&pageIndex=57/

⁸⁴ 대학 등록금에 관한 규칙, <http://www.law.go.kr/lsBdyPrint.do#AJAX>

үндэслэн тухайн жилийн инфляцийн түвшин, зардлыг өсөлт, бууралтыг харгалзан бакалавр, магистр, докторын сургалт тус бүрээр тооцоолж гаргах ба салбарын сайд батална.

Хяналтын хорооны ажиллах хугацааг сургуулийн журмаар тогтоох бөгөөд ихэвчлэн 1 жилийн хугацаатай ажиллахаар тогтоосон байдаг. Тухайлбал: Ханян Их Сургуулийн “Сургалтын төлбөрийн хяналтын хорооны дүрэм”-д хорооны гишүүдийг 1 жилийн хугацаатай ажиллуулахаар журамласан байна.

Солонгосын Засгийн газар их, дээд сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах үүднээс дээд боловсролын байгууллагуудад тэтгэмж олгох өрсөлдөөнд тулгуурласан механизмыг бий болгосон. 1992 оноос хойш боловсролын салбарт чанарын үнэлгээ хийхэд үнэлгээний болон магадлан итгэмжлэлийн байгууллагуудыг ашиглах болсон. Эдгээр байгууллагуудын үнэлгээгээр эхний 10-т орсон сургалтын байгууллагууд нь санхүүгийн дэмжлэг авах, нормативт элсэгчдийн тоогоо нэмэгдүүлэх зэрэг тодорхой дэмжлэг авдаг байна. Одоогоор төрийн болон хувийн хэвшлээс үл хамааран Засгийн газраас олгодог судалгааны санхүүжүүлтийн 46 орчим хувийг шилдэг 10 сургуульд олгож байна. Шилдэг 10 их сургуулийн 8 нь хувийн хэвшлийн их сургууль байна.

Солонгос улс нь кредит цагийн системтэй бөгөөд сургалтын төлбөрийн хэмжээг салбарын яамнаас тогтоодог.

Улсын болон хувийн сургуулийн төлбөрийн мэдээллийг 2016 оны байдлаар дараах хүснэгтээс үзнэ үү./

БНСУ-ын төрийн болон хувийн сургуулийн төлбөрийн мэдээлэл

Их сургуулийн төрөл	Салбар	Боловсролын түвшин	1 жилийн сургалтын төлбөрийн хэмжээ /ам.доллар/
Улсын сургуулийн сургалтын төлбөр	Хүмүүнлэгийн салбар	Баклавр	2000-2300
		Магистр, доктор	2500-2700
	Шинжлэх ухаан	Баклавр	2500-2800
		Магистр, доктор	3000-3300
	Соёл урлаг	Баклавр	2800-3000
		Магистр, доктор	4300-4400
		Эмнэл зүй	4300-4400
		Магистр, доктор	4000-5100
Хувийн сургуулийн сургалтын төлбөр	Хүмүүнлэгийн салбар	Баклавр	\$3,800 ~ \$4,000
		Магистр, доктор	\$4,000 ~ \$5,000
	Шинжлэх ухаан	Баклавр	\$5,000 ~ \$6,000
		Магистр, доктор	\$4,000 ~ \$5,000
	Соёл урлаг	Баклавр	\$5,000 ~ \$6,000
		Магистр, доктор	\$5,000 ~ \$6,000
	Эмнэл зүй	Баклавр	\$6,500 ~ \$7,000
		Магистр, доктор	-

БНСУ-д төрөөс дотоодын оюутнуудад сургалтын тэтгэлэг, болон сургалтын зээл хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг ба ингэхдээ оюутны чадвар болон санхүүгийн чадамжийг чухалчлан авч үздэг. Оюутны тэтгэлгийг их, дээд сургуулиуд дотоод журам болон суралцаж буй мэргэжлийн чиглэл онцлогоос хамааруулан ялгавартайгаар тогтоодог байна.

БНСУ-д гадаадын болон дотоодын оюутнуудад дараах тэтгэлгүүдийг олгодог байна. Үүнд:

- БНСУ-ын Засгийн газрын бакалаврын тэтгэлэг;
- БНСУ-ын Засгийн газрын урилгаар суралцуулах магистр, докторын тэтгэлэг олгох тусгай хөтөлбөр;
- БШУТЯ-наас зарласан баклаврын зэрэгт суралцуулах Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр;
- Зүүн Азийн урлагийн мэргэжилтэнд зориулсан тэтгэлэг;

Солонгосын дээд боловсролын сангаас зарладаг олон улсын эрдэм шинжилгээний солилцоог дэмжих хөтөлбөр⁸⁵ зэрэг тэтгэлэгүүдийг олгож байна.

БНСУ-ын дотоодын оюутнуудад олгодог тэтгэлэг, дэмжлэгүүд:

Багш, профессоруудын саналаар хамгийн сайн суралцаж буй оюутнуудыг сургалтын төлбөрөөс 30% хүртэлх хувиар чөлөөлөх,

Нийт суралцаж буй дотоодын оюутнуудын тодорхой хувийг /45-75%/ ямар нэгэн хэмжээгээр тэтгэлэг, хөнгөлөлтөнд хамруулах

Нийт суралцагч оюутнуудын 30% хүртэлх хувийг багшийн санал болгосноор 100%-ийн сургалтын төлбөрөөс чөлөөлөх. Ингэхдээ 2 хэлбэрээр тэтгэлэг олгох ба А/ сургалтын төлбөрөөс бүрэн чөлөөлж сарын 800.000 вонны стипенд олгоно, В/ сургалтын төлбөрөөс 50%- чөлөөлнө. Энэхүү тэтгэлгийг сурлагын амжилт гаргасан оюутанд өгдөг ба тухайн оюутны суралцаж буй салбар чиглэлээс хамааран ялгавартай тогтоодог.

ХАВСРАЛТ

Монгол Улсын Их сургуулиудын төлбөрийн мэдээлэл⁸⁶

№	Сургуулийн нэр	1 дамжаа	2 дамжаа	3 дамжаа	4 дамжаа	Дундаж төлбөр /сая.төг/
1	МУИС	81600	72700	72700	56600	1.7
2	ХААИС	66600	66000	66000	66000	1.98
3	АШУҮИС	70000	65000	65000	55500	2.0
4	ШУТИС	58500	58500	58500	58500	1.7
5	СУИС	46600	46600	46600	46600	1.4
6	МУБИС	65000	58000	58000	58000	1.74
7	БХИС	43000	40000	36600	33300	1.0

⁸⁵ Study in Korea- <http://www.studyinkorea.go.kr/mn>

⁸⁶ Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15

Хувийн их дээд сургуулиудын төлбөрийн мэдээлэл

№	Сургуулийн нэр	Төлбөрийн хэмжээ
1	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	1500000
2	Их засаг их сургууль	990000
3	Орхон их сургууль	1200000
4	Отгонтэнгэр их сургууль	1040000
5	Монгол бизнес дээд сургууль	875000
6	Мандах бүртгэл дээд сургууль	1300000
7	Улаанбаатар дээд сургууль	900000
8	Санхүү эдийн засгийн дээд сургууль	1900000
9	Оточ манрамба дээд сургууль	1500000
10	Төмөр замын дээд сургууль	850000
11	Шихихутаг хууль зүйн дээд сургууль	1200000
12	Сэрүүлэг дээд сургууль	980000
13	Тэнгэр дээд сургууль	850000
14	Идэр дээд сургууль	1380000
15	Газарчин дээд сургууль	800000-950000
16	Улаанбаатар-Эрдэм Оюу дээд сургууль	900000-950000
17	Их Монгол дээд сургууль	850000
18	Гурван эрдэнэ багшийн дээд сургууль	850000
19	Соёмбо дээд сургууль	700000
20	Чингис хаан дээд сургууль	795000
21	Монголын үндэсний дээд сургууль	895000-995000
22	Сутай дээд сургууль	880000
23	Монгол дээд сургууль	750000
24	Шинэ иргэншил дээд сургууль	500000
25	Аварга дээд сургууль	750000
26	Ач дээд сургууль	1000000
27	Сити дээд сургууль	1500000
28	Хөдөлмөрийн дээд сургууль	950000
29	Олон улс судлалын дээд сургууль	950000-1050000
30	Хангай дээд сургууль	760000
31	Этүгэн дээд сургууль	1500000
32	Хүрээ дээд сургууль	1125000
33	Зохиомж дээд сургууль	1150000
34	Хэл иргэншлийн дээд сургууль	979000
35	Соёл-Эрдэм коллеж	1025000
36	Мон-Алтиус биеийн тамирын дээд сургууль	790000
37	Утга зохиол нийгмийн ажилтны коллеж	790000

Хувийн хэвшлийн ЕБС-ийн төлбөрийн мэдээлэл

№	Дүүрэг	Сургуулийн нэр	Нийт хүүхэд	Төлбөр		
				Бага	Дунд	Ахлах
1	Чингэлтэй	Бэтүв	35	-	-	-
2	Чингэлтэй	Зуунбилиг	160	2,000,000	2,000,000	2,500,000
3	Чингэлтэй	Наран	203	1,500,000	1,800,000	1,800,000
4	Чингэлтэй	Чинхур	120	950,000	950,000	950,000
5	Чингэлтэй	Цахим-Эрин	31	780,000	980,000	980,000
6	Чингэлтэй	Тусгал	79	1,260,000	1,270,000	1,290,000
7	Чингэлтэй	Тоолол	40	-	-	800,000
8	Чингэлтэй	Олонлог	615	4,500,000	4,500,000	4,500,000
9	Чингэлтэй	Атланта	106	1,250,000	1,600,000	1,600,000
10	Баянгол	Билэг Оюу	110	1,500,000	1,600,000	1,800,000
11	Баянгол	Гурван тамир	362	1,800,000	1,800,000	1,800,000
12	Баянгол	Жаргалан	332	1,750,000	1,800,000	1,850,000
13	Баянгол	Ирээдүй	13	1,000,000	-	-
14	Баянгол	Лидер	86	1,050,000	1,200,000	1,500,000
15	Баянгол	Номч	55	1,300,000	1,500,000	1,800,000
16	Баянгол	Номун далай	74	700,000	800,000	800,000
17	Баянгол	Онол	6	1,300,000	-	-
18	Баянгол	Оюуны төв	105	1,800,000	1,900,000	2,000,000
19	Баянгол	Оюуны нахиа	165	1,500,000	1,600,000	1,800,000
20	Баянгол	Хүрээ тулга	293	1,200,000	1,350,000	1,500,000
21	Баянгол	Хүслийн өргөө	215	1,800,000	1,800,000	1,800,000
22	Баянгол	Радуга	444	1,950,000	1,950,000	1,950,000
23	Баянгол	Русская гимназия	131	3,600,000	4,100,000	4,600,000
24	Баянгол	Сентпоул		Халамжийн сургууль		
25	Баянгол	Сэнлизэ	187	1,200,000	1,300,000	1,400,000
26	Баянгол	Цацраг эрдэм	15	900,000	1,000,000	1,000,000
27	Баянгол	Шатлал	18	1,100,000	1,200,000	1,300,000
28	Баянгол	Гэгээрэл	350	2,000,000	2,000,000	2,000,000
29	Баянгол	Эхлэл	185	2,000,000	2,100,000	2,200,000
30	Баянгол	Эрдмийн далай	51	1,500,000	1,800,000	2,100,000
31	Баянгол	Төгсбилэг/ Бага сургууль/	58	1,100,000	-	-
32	Баянгол	Ургах наран	50	1,200,000	1,400,000	1,400,000
33	Баянгол	Монгол коосен	100	-	-	2,000,000
34	Баянгол	Монгол Од	168	1,800,000	1,800,000	1,800,000
35	Баянзүрх	Арвис	153	1,900,000	2,200,000	2,500,000
36	Баянзүрх	Билгүүн номч	158	1,400,000	1,400,000	1,400,000
37	Баянзүрх	Билгүүн үүдэн	135	1,560,000	1,800,000	2,040,000
38	Баянзүрх	Саруул ирээдүй	103	700,000	750,000	800,000

39	Баянзүрх	Крилица	120	2,300,000	-	-
40	Баянзүрх	Эрэл И Эс Эм Олон улсын дунд сургууль	388	8,550,000	8,750,000	8,950,000
41	Баянзүрх	Оюуны оньс	57	2,100,000		
42	Баянзүрх	УБ дунд сургууль	661	1,500,000	1,500,000	1,600,000
43	Баянзүрх	Төгс дэлгэрэх	570	1,900,000	1,900,000	1,900,000
44	Баянзүрх	Шинэ Монгол	1262	2,300,000	2,400,000	2,500,000
45	Баянзүрх	Оюунлаг	639	3,000,000	2,500,000	2,500,000
46	Баянзүрх	Монгол турк	361	-	5,000,000	4,500,000
47	Баянзүрх	Хишиг	381	2,000,000	2,000,000	2,000,000
48	Баянзүрх	Хөвгүүд	135	450,000	450,000	450,000
49	Баянзүрх	Их засаг	366	2,000,000	2,000,000	2,000,000
50	Баянзүрх	УБ лицей	1004	2,770,000	3,160,000	3,550,000
51	Баянзүрх	Эрхэм баян эрдэм	79	3,000,000	3,000,000	3,000,000
52	Баянзүрх	Итгэл бүрэн	66		1,800,000	1,800,000
53	Хан-Уул	Америк	576	10,000,000	13000000	15250000
54	Хан-Уул	Аварга	192	0	0	450000
55	Хан-Уул	Орхон	126	1,550,000	1,550,000	1,550,000
56	Хан-Уул	Англи	305	13000 \$	16680 \$	17920 \$
57	Хан-Уул	Сакура	100	3,300,000	3,700,000	4,000,000
58	Хан-Уул	Орчлон	1005	11,000,000.0	12000000	12000000
59	Хан-Уул	Авьяас	30	0	680000	840000
60	Сонгинохайрхан	Батномуун	53	685,000	685,000	685,000
61	Сонгинохайрхан	Гэрэлт ирээдүй	75	-	1,300,000	1,500,000
62	Сонгинохайрхан	Онон	34	-	-	685,000
63	Сонгинохайрхан	Номуун	199	2,000,000	2,000,000	2,000,000
64	Сонгинохайрхан	Чандмань	229	500,000	500,000	600,000
65	Сонгинохайрхан	Ромашка	196	1,850,000	1,850,000	1,850,000
66	Сонгинохайрхан	Тольт	37	1,700,000	1,800,000	2,000,000
67	Сонгинохайрхан	Номын ёс	22	900,000		
68	Налайх	Хос Уянга	85	900000	0	0
69	Налайх	Чандмань Эрдэнэ	28	Төлбөргүй шашны сургууль		
70	Багануур	Сод	132	1,200,000	1,550,000	1,550,000
71	Сүхбаатар	МУИС Байгаль- Эх лицей	304			1,500,000
72	Сүхбаатар	ШУТИС Ахлах сургууль	504			3,000,000
73	Сүхбаатар	ШУТИС Коосэн загварын сургууль	55			3,000,000
74	Сүхбаатар	Кингс Кидс	242	3,000,000		
75	Сүхбаатар	Эрдэм төгс	240	1,200,000	1,200,000	1,200,000

76	Сүхбаатар	Оюуны тулга	229	2,000,000	2,500,000	2,900,000
77	Сүхбаатар	Ертөнц	260	700,000	850,000	900,000
78	Сүхбаатар	Гёте	400	2,900,000	3,000,000	2,900,000
79	Сүхбаатар	Сант	1300	5,000,000	5,000,000	6,000,000
80	Сүхбаатар	Шинэ үе	800	2,200,000	2,400,000	2,600,000
81	Сүхбаатар	Сакура	110	2,000,000	2,300,000	2,700,000
82	Сүхбаатар	Үй цай	965	3,300,000	2,600,000	2,600,000
83	Сүхбаатар	Галакси	191	1,550,000	1,380,000	1,380,000
84	Сүхбаатар	Хобби	838	5,000,000	6,000,000	7,000,000
85	Сүхбаатар	Монгол Хятад найрамдал	504	1,800,000	1,800,000	1,800,000
86	Сүхбаатар	АВЦ ахлах сургууль	20			850,000
87	Сүхбаатар	Шонхор	40			390,000
88	Сүхбаатар	Авъяас	28		680,000	840,000
89	Сүхбаатар	Соёмбо	129	2,000,000		
90	Сүхбаатар	Болор	68	1,350,000	1,350,000	1,350,000
91	Сүхбаатар	Логарифм	365	3,000,000	2,600,000	
92	Сүхбаатар	Искра	104	488,000	588,000	688,000
93	Сүхбаатар	Хүлэг	74	1,540,000	1,680,000	1,820,000
94	Сүхбаатар	Улаанбаатар элит	285	8,900,000	10,500,000	11,900,000
95	Сүхбаатар	Шинэ зууны удирдагч	58			1,800,000
96	Сүхбаатар	Хөгжлийн гүүр	20			2,500,000
97	Сүхбаатар	Сод-Эрдэм	50	1,500,000	1,800,000	2,000,000
98	Сүхбаатар	Ес Эрдэм	121	1,500,000	1,500,000	1,500,000
99	Сүхбаатар	Шилдэг	8	2,500,000		

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 37 зүйл зүйл
- Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016.04.15
- Education chart, <http://pharmawiki.in/education-system/>
- 1998 Amendments to the Higher Education Act, <http://www2.ed.gov/policy/highered/leg/hea98/index.html>
- TEQSA, <http://www.teqsa.gov.au>
- Education Services for Overseas Students , <http://www.esos.curtin.edu.au>
- Tertiary Education Quality and Standards Agency Act /2011/, <https://www.legislation.gov.au/Details/C2015C00622>
- Department Of Education and Training, <https://www.education.gov.au/>
- Higher Education Act /2013/, <https://www.legislation.gov.au/Details/C2013A00067>
- https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/219167/v01-2012ukes.pdf
- <http://www.learnenglish.de/culture/educationculture.html#primary>
- <http://www.euroeducation.net/prof/ukco.htm>
- <http://www.hefce.ac.uk/pubs/year/2016/201603/>
- Higher education law, <http://www.moleg.go.kr/english/korLawEng>
- <http://www.law.go.kr/lsBdyPrint.do#AJAX>
- <http://smcs.num.edu.mn/files/2013/DeedBolosrolSudalгаа/Deed%20bolovsrolyn%20bodlogyn%20shinjilgee-1.pdf> -Дээд боловсролын бодлогын шинжилгээ
- <http://www.must.edu.mn/mn/pdf/3180recom-CDIO-OBE%20program%20development-14-05-15.pdf> Үр дүнд суурилсан сургалт-ын аргад үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж
- https://sisi.num.edu.mn/files/ZHSHUA/Juram/Bakalavryn%20surgaltyn%20juram_New.pdf МУИС-ийн бакалаврын сургалтын журам
- <http://www.cmuc.edu.mn/index.php/page?id=1> -Дээд боловсролын шинэчлэл-Солонгос
- <https://sisi.num.edu.mn/files/ZHSHUA/Juram/Shine%20strategi%20plan.pdf> -МУИС-ийн 2020 он хүртэлх хөгжлийн шинэчилсэн стратеги төлөвлөгөө /2011-2020/
- <http://www.meds.gov.mn/>-Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021
- <http://www.news.mn/content/175005.shtml> Дээд боловсролын чанарын шинэчлэлийн суурь шийдэл
- <http://www.meds.gov.mn/data/1501/higher.pdf> -

**МОНГОЛ УЛСЫН ТӨРӨХ БОЛОН ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ БА ОЛОН УЛСЫН ЖИШИГ**

*Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба
О.Нарантуяа, Б.Нандингэрэл*

АГУУЛГА

Нэг. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ТӨРӨХ БОЛОН НЯРАЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хоёр. ТӨРӨХ БОЛОН ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ОРЧИН НӨХЦӨЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

*2.1. Төрөх болон хүүхдийн эмнэлгийн өнөөгийн байдал,
эмнэлгийн орчин нөхцөл, хүрэлцээ хангамж*

*2.2. Төрөх болон хүүхдийн эмнэлгүүдэд тулгамдаж буй асуудал,
цаашид авах арга хэмжээний талаар*

Гурав. ОЛОН УЛСЫН ЖИШИГ СТАНДАРТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
ТУРШЛАГА

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Оршил

Судалгаанд Монгол Улсын Статистик, Бүртгэлийн газар болон Нийгмийн Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн статистик мэдээлэл, судалгаа, Эрүүл Мэндийн Яамнаас ирүүлсэн мэдээлэл, судалгаа, саналыг эх сурвалж болгон судалгааны мэдээллийг дараах 3 хэсэгт хуваан авч үзлээ.

Нэгдүгээр хэсэгт: Эрүүл мэндийн салбарын төрөх болон нярайн тусламж, үйлчилгээтэй холбоотой төрөөс баримтлаж буй бодлого, хууль, тогтоол шийдвэр, стандарт зэрэг эрх зүйн орчныг судлав.

Хоёрдугаар хэсэгт: Төрөх болон хүүхдийн эмнэлгийн орчин нөхцөлийн талаарх өнөөгийн байдлыг статистик тоон мэдээлэлд тулгуурлан судалж, тулгамдаж буй асуудлуудыг хөндөн, тэдгээрийг шийдвэрлэх саналыг дэвшүүллээ.

Гуравдугаар хэсэгт: ДЭМБ-аас эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар гаргасан зөвлөмж болон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өндөр хөгжсөн Шинэ Зеланд, Их Британи зэрэг орнуудын эрүүл мэндийн салбар дахь төрөх болон нярайн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлж буй стандартын талаар авч үзсэн болно.

Судалгааны үр дүн

Судалгаанаас үзэхэд Монгол Улсад эрүүл мэндийн салбар, тэр дундаа төрөх болон нярайн тусламж, үйлчилгээтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрүүд цөөнгүй байгаа боловч эдгээр баримт бичгүүдийн төрийн бодлого хоорондын уялдаа хангалтгүй, санхүүжилт дутмаг, санхүүгийн эх үүсвэрийг тодорхой тусгагдаагүй байгаа зэрэг нь эрүүл мэндийн энэхүү салбарын *эрх зүйн орчин тодорхой бус, хууль, бодлогын хэрэгжилт хангалтгүй* гэж үзэж болохоор байна.⁸⁷

Тухайлбал, “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа MNS 6188: 2010”, “Хэт залуу ба ахимаг настай тулгар төрөгч эмэгтэйн жирэмслэлт ба төрөлтийг удирдах MNS 5259: 2003”, “Кесеров хагалгааны мэс засал MNS 5221;2002”, “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392: 2013” зэрэг стандартууд батлагдсан хэдий ч төрөх болон хүүхдийн эмнэлгийн хувьд батлагдсан стандартын дагуу төдийлөн үйл ажиллагаагаа явуулж чаддаггүй болохыг холбогдох мэргэжлийнхэн үзэж байна.

Манай улсын төрөх эмнэлгийн хүрэлцээ, орчин нөхцөлийн хувьд хот ба хөдөө, орон нутгийн засаг захиргааны нэгжид ногдох төрөх эмнэлгийн тоо нэмэгдсэн, хүрэлцээтэй гэж үзэхүйц тоон мэдээлэлтэй байгаа боловч амаржих нийт эхчүүдийн 50 орчим хувь нь хотод төрж байгаа, мөн нийслэл хот руу орон нутгаас хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг нь нийслэл хотын хүн амд үйлчлэх эмнэлгийн салбарын чанар, түүний хүрэлцээнд сөргөөр нөлөөлж, хүндрэл учруулдаг болсон. Мөн түүнчлэн нийслэл хотын дүүргүүдэд ногдох төрөх эмнэлгийн тооны хувьд хангалттай боловч хүн амын хэт их механик өсөлтөөс шалтгаалан тэдгээрийн орны тоо хүрэлцэхгүй болсон нь судалгаанаас харагдаж байна.

⁸⁷ Нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Бүтээл V” цуврал судалгааны тайлан. 2015

Хүүхдийн эмнэлгийн хүрэлцээ хангамжийн хувьд манай улсад төрөлжсөн хүүхдийн эмнэлэг улсын хэмжээнд ганц байгаа бөгөөд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд зөвхөн цөөн тооны ортой хүүхдийн тасаг ажиллаж байна. Энэ нь манай улсын нийт 0-16 насны хүүхдийн тоо, хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний тоо зэрэгтэй харьцуулахад хүүхдийн эмнэлгийн хүрэлцээ хангамж туйлын хангалтгүй байна.

Эмнэлгийн байгууллагуудын нэг тулгамдаж буй асуудал нь эмч, эмнэлгийн ажилтан, асрагч, сувилагч зэрэг хүний нөөцийн бодлого, тэдгээрийг чадавхжуулах, эмч, сувилагч, асрагч зэрэг эмнэлгийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах, цалин хөлсний хүрэлцээ хангамж зэргийн анхаарах шаардлагатай болсон байна. Ялангуяа нярай, хүүхдийн эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, сувилагч нар нэн шаардлагатай байна.

Нийслэл нь 1 саяаас дээш хүн амтай улсуудын их хотуудад энэ талын асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй менежментийг нэвтрүүлж, хууль эрх зүйн орчныг нь бүрэлдүүлэх талаар Англи, Шинэ Зеланд зэрэг орнуудын төрөлт, нярай хүүхдийн тусламж үйлчилгээний талаар явуулж буй туршлагыг судлан үзвэл: *Тухайлбал*, Шинэ Зеландын томоохон хотуудад хэвийн төрөлтийг анхан шатны эмнэлэгт, хяналтанд болон хүндрэлтэй төрөлтийг дунд шатны болон улсын түвшний клиник эмнэлгүүдэд хүлээж авах зэргээр шийдвэрлэж байна. Энэ нь эмнэлгийн бүх шатлал, түвшиндээ эхчүүдийг төрүүлэх боловсон хүчин, тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, орчин нөхцөлийг бүрэлдүүлсэн давуу талтай юм. Тэгвэл бусад эмнэлгүүд дээрээ төрөх тасаг нээх, эхчүүдийг төрүүлэх орчин нөхцөлийг бүрэлдүүлэх боломжтой байдаг байна.

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРӨХ БОЛОН НЯРАЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Манай улсын эрүүл мэндийн салбар, амаржих газруудад баримтах эрх зүйн орчны хувьд уг харилцааг зохицуулсан хууль 30, бодлогын 8 баримт бичиг, хөтөлбөр 16, стратеги 13, стандарт 70, клиник удирдамж 41, салбарын сайдын тушаал зэрэг нэлээдгүй баримт бичгээр зохицуулсан байна. Тухайлбал,

- Эх, нярайн тусламж, үйлчилгээтэй холбоотой хуулиудаар төрөлхийн гажгийг эрт оношлох, таслах, хүүхдийн эрхийг хамгаалах, эрүүл мэндийн даатгал, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, эхийн сүүгээр хүүхдийг хооллох, эхийн сүү орлуулах бүтээгдэхүүнийг хэрэглэх мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн жирэмсний хяналт, явц, төрөлтийн талаарх харилцааг зохицуулсан байна.
- Бодлогын баримт бичгүүдийн хувьд эх, нярайн нийгмийн халамж, үйлчилгээ, эрүүл хоол, хүнсний хангамж, эхийн ажлын байрны хангамж, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэж байна.
- Хөтөлбөр, стратегийн хувьд эх болон нярайн эндэгдлийг бууруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, стандарт, журмуудыг шинэчлэх, тусламж үйлчилгээг чанаржуулах, хяналтыг сайжруулан санхүүжилтийг боловсронгуй болгох зорилго, зорилтыг дэвшүүлсэн байна.

Дээрх хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судлан үзвэл зохицуулж буй харилцааны хоорондын уялдаа холбоо хангалтгүй, нэг харилцааг хэт олон баримт бичгээр зохицуулсан, зарим хэрэгжүүлэх харилцааны санхүүжилт тодорхой бус байгаа зэрэг нь эрх зүйн орчин тодорхой бус, бодлогын хэрэгжилт хангалтгүй гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл дээр дэрьдсан олон тооны баримт бичгүүдээс харвал энэ салбарын эрх зүйн орчин хангалттай бүрдсэн мэт болов ч эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудал, эх, хүүхдийн эндэгдэл, өвчлөл буурахгүй жил тутам нэмэгдэж байгаа зэрэг нь бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. /Хууль тогтоомж, баримт бичгийн жагсаалтыг Хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү/

Манай улсын хүн ам 3 саяд хүрч, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хөдөө орон нутагт төрөх эмнэлгүүд шинээр байгуулсан нь сайшаалтай хэдий ч нийт хүн амын 50 гаруй хувь нь нийслэл рүү төвлөрсөн, амаржих эхчүүдийн талаас илүү нь Улаанбаатар хотод төрж байгаа зэргээс шалтгаалан нийслэл дэх төрөх эмнэлгүүдийн хүрэлцээ дутмаг хэвээр байна.

Төрөх эмнэлгийн орны хүрэлцээгүй байдал, стандартын бус орчин нөхцөлд эхчүүд төрж, эмч, эмнэлгийн ажилтнууд ч стандартын шаардлага хангаагүй газар ажилласаар байна. Манай улсын төрөх эмнэлгүүдэд мөрдөгдөж буй Амаржих газрын стандартын талаар дэлгэрүүлэн авч үзвэл:

Амаржих газрын бүтэц, үйл ажиллагааны стандарт \MNS:6188\

“Амаржих газар” гэж хүн амд эх барим, эмэгтэйчүүд, нярайн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллага юм. Эмнэлэг нь эх барих хэсэг, амбулаторын хэсэг, хэвтүүлэн эмчлэх хэсэг, дэмжих хэсгээс бүрдэнэ. Стандартад дурдсанаар амаржих газрын орыг дараах байдлаар хуваарилна.

Орны төрөл	Орны доод хязгаар
Эх барихын ор	Нөхөн үржихүйн насны 25.000-30.000 эмэгтэйд 50 ор
Нярайн ор	Эх барихын нийт орны 2\3-той тэнцэх
Эрчимт эмчилгээний ор	Нийт орны 10%
Нярайн эрчимт эмчилгээний ор	Нярайн нийт орны 10%
Эхийн амрах байрны ор	Эх барихын нийт орны 10%
Эмэгтэйчүүдийн ор	Нөхөн үржихүйн насны 50.000 эмэгтэйд 25 ор

Эмэгтэйчүүдийн өвчний оношилгоо, эмчилгээ хийх хэвтэх орны хэрэгцээг хүн амын өвчлөлийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг үндэслэн Эрүүл мэндийн яамнаас жил бүр шинэчлэн баталж, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлнэ. Үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчийг 60 хоромын (эрэмбэ 1-4) дотор хүлээн авч, үзлэг хийж, шаардлагатай тусламж үзүүлж анхан шатны маягтад тэмдэглэнэ. Харин хүнд болон яаралтай тусламж шаардлагатай үйлчлүүлэгчийг дугаар харьяалал харгалзахгүй 20 хоромын дотор анхны үйлчилгээг үзүүлэх ёстой.

Төрөлтийн үед эх барих эмэгтэйчүүдийн эмч, нярайн эмч, эх баригч, нярайн сувилагч нар багаар, шаардлагатай бол дотор, зүрх судас гэх мэт нарийн мэргэжлийн эмч нарыг байлцуулах бөгөөд төрсөн эхийг нярайд ямар нэг

асуудалгүй бол эхийн хамт төрөх өрөөнд 2 цаг байлгана. Төрсөн эх болон нярайд сувилахуйн 5 шатлалын дагуу тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Харин барилга байгууламжийн хувьд 2 га-гаас багагүй талбай бүхий эдэлбэр газартай байх бөгөөд эдэлбэр газрын 60 хувиас багагүй талбайд ногоон байгууламж болон тохижилт хийж хогийн савыг 50 метр тутамд байрлуулна. Мөн дуу шуугиан хөдөлгөөн ихтэй төв замаас 30-50 метрийн зайд байрлуулах зарчимтай.

Эмнэлгийн өрөөнүүдийн шаардлагатай тоног төхөрөөмжүүдтэй байх бөгөөд төрөх, хүлээн авах, мэс заслын тасгуудад үйлчлүүлэгч усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Амаржих газрын өрөөнүүдийн талбайн хэмжээ

Өрөөний нэр	Талбайн доод хэмжээ \метр квадратаар\
Хүээлгийн өрөө	25
Үйлчлүүлэгчийн өрөө	Нэг оронд 7
Эх, нярайн өрөө	Нэг оронд 10
Нярайн өрөө	Нэг оронд 6
Дархлаажуулалтын өрөө	10
Эрчимт эмчилгээний өрөө	Нэг оронд 13
Нярайн эрчимт эмчилгээний өрөө	Нэг оронд 15
Үйлчлүүлэгчийн амралтын талбай	10
Төрөх өрөө	Нэг оронд 18
Усанд орох өрөө \тасаг нэгж бүрт хүрэлцэхүйц\	6
Ариун цэврийн өрөө \хэрэв нийтийн зориулалттай бол 5-8 хүнд 1 суултуур, 4-өөс доошгүй угаалтуур\	Угаалтуур бүрт 1X1 Суултуур бүрт 1x1.5

(Дэлгэрэнгүйгээр үзэхийг хүсвэл стандартыг үзнэ үү⁸⁸)

Дээрх стандартаас үзэхэд Монгол Улсын эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгийн стандарт маш нарийвчлан боловсруулсан нь харагдаж байгаа боловч бодит байдал дээр дээрх стандартын хэдхэн хувийг л ханган ажиллаж байгаа нь өнөөгийн төрөх эмнэлгүүдээс харж болохоор байна.

ХОЁР. ТӨРӨХ БОЛОН ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОРЧИН НӨХЦӨЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

2.1. Төрөх болон хүүхдийн эмнэлгийн өнөөгийн байдал, эмнэлгийн орчин нөхцөл, хүрэлцээ хангамж

- **Эх, хүүхдийн эрүүл мэндийн талаар:**


Эх, хүүхдийн эрүүл мэндийн статистик мэдээлэл нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг илтгэх үндсэн үзүүлэлтүүд болдог.

Төрөөс хүн амын эрүүл мэндийн дэмжих бодлого, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдээр дамжуулан төрөлтийг дэмжсэний үр дүнд манай улсын хүн ам, төрөлт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж 2010 онд 63270 эх төрж байсан бол **2015 онд 80434 эх төрсний 51,5 хувь нь Улаанбаатар хотод** төрж байна.

88 http://estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=standart_desc&sid=3603

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд төрсөн эхчүүдийн 37-42 хувийг хөдөө орон нутгаас ирсэн эхчүүд эзэлж байна. Хөдөө орон нутагт төрж байгаа эхчүүдийн 70-75 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 25-30 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвд төрж байна.⁸⁹

Зураг 1. Төрөлтийн түвшин, амаржсан эхийн тоо



- **Эмч, эмнэлгийн орны хүрэлцээ, хангамж:**

1/ Эмч, эмнэлгийн ажилчид, хүний нөөцийн хүрэлцээ хангамжийн талаар:

Манай улсад дунджаар 10000 хүнд 2.2 хүүхдийн эмч, 0.3 нярайн эмч, 2.3 эх, барих эмэгтэйчүүдийн эмч ногдож байна. Одоогоор 21 аймагт нийт 322 хүүхдийн эмч ажиллаж байгаагийн 36 нь буюу 11.2% нь нярайн мэргэшсэн эмч байгаа ба аймгуудад дунджаар 1-2 нярайн эмчтэй байна. Хүүхдийн мэргэшсэн нийт 428 сувилагч ажиллаж байгаагийн 33.6% нь нярайн сувилагчаар мэргэшсэн байна.

Анхдагч шатлалд ажиллаж байгаа 1863 их эмчээс 67 эх барих эмэгтэйчүүдийн эмч, 140 хүүхдийн эмч, үүнээс 1 нярайн эмч ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д 103 хүүхдийн эмч, үүнээс 25 нярайн эмч, 107 эх барих эмэгтэйчүүдийн их эмч ажиллаж байна.

Амаржих газруудад ажиллаж байгаа нийт 169 их эмчийн 99.4% нь үндсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмшсэн, үүний 56.8%-ийг эх барих, эмэгтэйчүүд, 18.4% нь хүүхдийн эмч байна. Хүүхдийн эмчийн 15.9% нь нярайн эмч эзэлж байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хүүхдийн төрөлжсөн эмнэлэг 1 (Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв), хүүхдийн ортой эмнэлгүүд нэлээд байгаа юм. Гэвч улсын хэмжээнд өдөрт дунджаар 40-60 хүүхдийн өвчний түүхийг хөтөлж, хоногт 15 хүүхэд шинээр хэвтэж, мөн тооны хүүхэд эмнэлгээс гардаг ба энэ бүхэнд анхан шатны маягт хөтлөх, мөн амин үзүүлэлтийг хөтлөхөд ихэнх цагаа зарцуулснаас асаргаа, үйлчилгээ хоцорч байна.

⁸⁹ Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн мэдээлэл, 2016

Хүснэгт 1. Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн чиглэлээр ажиллаж байгаа их эмч⁹⁰

№	Мэргэжил	Улс			Аймаг			Улаанбаатар		
		Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох Их эмчийн тоо	Тухайн оны нийт их эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох Их эмчийн тоо	Тухайн оны нийт их эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох Их эмчийн тоо	Тухайн оны нийт их эмчид эзлэх хувь
1	Хүүхдийн	624	2.2	7.2	322	2.0	9.6	302	2.3	5.7
2	Үүнээс: Нярайн	100	0.3	1.2	36	0.2	1.1	64	0.5	1.2
3	Эх барих эмэгтэйчүүд	661	2.3	7.6	258	1.6	7.7	403	3.1	7.6

2/ Төрөх эмнэлгийн хүрэлцээ хангамжийн талаар:

Төрөх эмнэлгийн тухайд одоогоор улсын хэмжээнд Өргөө, Хүрээ, Амгалан зэрэг гурван төрөлжсөн амаржих газрууд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлгүүд болон БОЭТөвүүдэд төрөх ортой тасгууд ажиллаж байна.

Улсын хэмжээнд 10000 хүн амд 5.7 төрөх орны тоо ногдох бөгөөд эдгээрээс аймгуудад дунджаар 6.6 төрөх ор, хотод 4.7 төрөх ор тус тус ногдож байна. Гэвч улсын хэмжээнд амаржиж буй эхчүүдийн 51.5 хувь нь Улаанбаатар хотод амаржиж байгаа нь нийслэлд үйл ажиллагаагаа явуулж буй төрөх эмнэлэг болон төрөх тасгуудын ачаалалыг нэмэгдүүлж, орны хүрэлцээ хангалтгүй хэвээр байна. Сүүлийн жилүүдэд манай улс Мянганы хөгжлийн зорилтод хөтөлбөрийн хүрээнд амаржих газар, төрөх эмнэлгүүдийг шинээр барих, өргөтгөж ашиглалтад оруулсан байна.

Хүснэгт 2. 2010 оноос хойш шинээр ашиглалтад орсон нийслэлийн болон аймгийн төрөх эмнэлгүүд

№	Аймгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Орны тоо
1.	Ховд	2010	50
2.	Увс	2010	50
3.	Баянхонгор	2011	50
4.	Говь - Сүмбэр	2013	15
5.	Өвөрхангай	2013	70
6.	Завхан	2014	50
7.	Хөвсгөл	2013	50
8.	Булган	2014	50
9.	Өмнөговь	2014	50
10.	Сүхбаатар	2015	50
11.	Дорнод	2015	50
12.	Өргөө амаржих газрын өргөтгөл	2012	390
13.	Хүрээ амаржих газар	2015	150

Улсын хэмжээнд 11 аймагт төрөх эмнэлгийг шинээр барьж, Өргөө амаржих

⁹⁰ Эрүүл мэндийн ажиллах хүчний байршил, хангамж ба хэрэгцээ судалгаа, 2014 он

газрыг өргөтгөж 240 ортой байсныг 390, Амгалан амаржих газар 45 ортой байсныг 150 ортой болгож өргөжүүлсэн боловч нийслэлд нийт төрөлтийн 51 хувь төрж байгаатай холбоотой нийслэлд амаржих газрыг шинээр барьж ашиглалтад оруулах, зарим аймгуудад 50 ортой төрөх эмнэлгийг шинээр барих, зарим аймгийн төрөх тасагт их засвар хийх, өргөтгөж орны тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3/ Хүүхдийн эмнэлгийн хүрэлцээ хангамжийн талаар:

Монгол Улсын нийт хүн амын 48,7% нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа бөгөөд 2015 оны жилийн эцсийн байдлаар 0-19 насны хүүхдийн тоо 434,217 буюу нийт хүн амын 34,2 хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотод 16 хүртэлх насны бүртгэлтэй 434,217 хүүхэд амьдарч байгаа бөгөөд бүртгэлгүй хөдөлгөөнт хүүхдийн тоог дунджаар уг тооны 8-10% гэж тооцоолоход нийслэлд 480,000 орчим хүүхэд амьдарч байна.

Олон улсын жишгээр 1000 хүүхэд тутамд хүүхдийн эмнэлгийн 4 орчим ор шаардлагатай гэж үздэг. Энэ жишгээр тооцвол нийслэлд нийт 1920 хүүхдийн эмнэлгийн ор ажиллуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Гэвч одоогийн байдлаар Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвд хүүхдийн 402 ор, үүнээс 144 нь хүүхдийн мэс заслын, 258 хүүхдийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийн ор байна. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгуудад нийт 789 ор, нийт 1191 хүүхдийн ор ажиллаж байна. Иймд нийслэлийн хэмжээнд 729 хүүхдийн эмчилгээний ор хэрэгцээтэй байна гэсэн тооцоог гаргажээ.

/Хүснэгт 3-т Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдийн орны тоо, хэвтэн эмчлүүлэгсэдийн дэлгэрэнгүй мэдээллийг орууллаа./

Хүснэгт 3-аас үзэхэд ЭХЭМҮТ болон дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн хүүхдийн орны ачаалал буурахгүй байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэж мэргэжлийн эмч нар үзэж байна. Үүнд:

- Нийслэлийн төрөлт огцом ихэссэн.
- Улирлын чанартай амьсгалын цочмол халдварын үед ачаалал 2-3 дахин ихэсч онцгой байдал үүсдэг болсон. (Томуу, улаанбурхан....)
- Дүүргийн эмнэлгүүдийн байр хэт хуучин, сүүлийн 20 гаруй жилд хүүхдийн эмнэлэг нийслэлд шинээр баригдаагүй.
- Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага маш цөөн.

2014 онд Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвд хүүхдийн тасаг шинээр нээгдснээр дүүргүүдийн нэгдсэн эмнэлгүүд бүгд хүүхдийн тасагтай болсон. 2015-2016 онуудад дүүргийн эмнэлгүүдэд хүүхдийн орны тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч байгаа ч нэгдсэн эмнэлгүүдийн орны фонд ашиглалт нормативаас хэтэрсэн, ачаалал ихтэй байна. Нийслэлийн хүүхдийн орны хэрэгцээг тооцоход 2016-2017 онд дор хаяж 221 ор шаардлагатай ажээ. (Хүснэгт 4)

Хүснэгт 3. Эх хүүхдийн эмнэлгийн орны тоо
/2015-2016 оны эхний 2 сарын байдлаар/

	Эрүүл мэндийн байгууллага	Тасаг нэрж	Орны тоо		Хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		Ашигласан ор хоног		Дундаж ор хоног	
			2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар
			2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар	2015 он	2016 оны эхний II сар
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Төрөх тасаг Эмэгтэйчүүдийн тасаг Эрчимт эмчилгээ / төрөх/	175	175	15975	2493	69995	10806	4.4	4.3
2	Өргөө амаржих газар	Хүүхдийн тасаг Төрөх тасаг Хүүхдийн тасаг Эмэгтэйчүүдийн тасаг	409	421	19802	2951	156364	22930	15.3	15.1
3	Хүрээ амаржих газар	Төрөх тасаг	70	70	8229	1288	30756	4718	3.7	3.7
4	Амгалан амаржих газар	Төрөх тасаг	110	120	10087	2293	25375	6583	2.5	2.9
5	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг	Хүүхдийн тасаг	125		7369		42600		5.8	
6	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	Хүүхдийн тасаг	125	125	8666	2036	43883	10569	5.1	5.2
7	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг	Хүүхдийн тасаг	120		4950		27698		5.6	
8	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	Хүүхдийн тасаг	80		3751		24158		6.4	
9	Чингэлтэй эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	70		3662		22294		6.1	
10	Баянгол эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	135		4414		22843		5.2	

11	Налайх эрүүл мэндийн төв	Төрөх тасаг	13		1269		4694		3.7
		Хүүхдийн тасаг	30		820		5445		6.6
		Эмэгтэйчүүдийн тасаг	10		183		1309		7.2
12	Багануур эрүүл мэндийн төв	Төрөх тасаг	23		1264		7187		5.7
		Хүүхдийн тасаг	46		1731		12767		7.4
		Эмэгтэйчүүдийн тасаг	10		420		3490		8.3
13	Багахангай эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	4		131		708		5.4
		Эмэгтэйчүүдийн тасаг	2		11		78		7.1
14	Жаргалант тосгоны эмнэлэг	Төрөх тасаг	3		5		9		1.8
		Хүүхдийн тасаг	4		61		387		6.3
15	Хонхор тосгоны эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	4		162		982		6.1
16	Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	5		92		540		5.9
17	Туул тосгоны эрүүл мэндийн төв	Хүүхдийн тасаг	5		129		765		6.0

*Хүснэгт 4. Орны хэрэгцээ
/2016-2017 онд/*

№	Дүүргийн эмнэлгийн нэр	Одоо байгаа орны тоо	Шаардлагатай орны тоо	Нийт
1	БГДЭМТ	140	0	140
2	БНЭМТ	34	16	50
3	Багахангай ЭМТ	5	0	5
4	БЗДНЭ	130	40	170
5	СБДНЭ	125	50	175
6	ХУДНЭ	85	45	130
7	ЧДЭМТ	75	50	125
8	НДЭМТ	30	20	50
9	СХДНЭ	165	0	165
	ДҮН	789	221	1010

• Хүний нөөц, багаж, тоног төхөөрөмжийн хангамж, санхүүжилтийн талаар:

Амаржих газар, төрөх тасгууд шинээр баригдаж, ашиглалтад орсноор орны тоо нэмэгдсэн боловч ажиллаж байгаа эмч, эх баригч, сувилагчийн тоо стандартын хэмжээнд хүрэхгүй байгаагаас ачаалал хэт ихсэж, тусламж үйлчилгээг шуурхай, чанартай, хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэх байдал дутагдалтай байна.

Өнөөдрийн байдлаар нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 789 хүүхдийн орон дээр 78 их эмч, 86-90 сувилагч ажиллаж байна. Үүнийг нэгдсэн эмнэлгийн стандарттай харьцуулан үзвэл 40-50 их эмч, 30-40 хүүхдийн сувилагч нэн шаардлагатай байна.

Мэргэжлээр нь авч үзвэл нярай, хүүхдийн эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, сувилагч нар нэн шаардлагатай байна. Мөн ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж хангалтгүй, урамшууллын аливаа хэлбэр сул, хариуцлага тооцох хэлбэр давамгайлж байгаагаас мэргэжлийн эмч, сувилагч нар ажлаас гарах, хувийн хэвшил рүү шилжих явдал их байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмж, ялангуяа төрөх, нярайн тасгийн тоног төхөөрөмжийн хувьд орчин үеийн олон улсын жишиг стандартад хүрсэн эх, ургийн эрт оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж хомс, улсын төсөвт эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардал бага хэмжээгээр тусгагддаг зэргээс шалтгаалан эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж туйлын хангалтгүй хэвээр байна.

Эрүүл мэндийн яамнаас эмнэлгүүдэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг жил бүр улсын төсөвт суулгуулахаар санал хүргүүлдэг ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан тухай бүр шийдвэрлэх боломжгүй байсаар байна. Тухайлбал, Хүснэгт 5-т Эрүүл мэндийн яамнаас зөвхөн дүүргийн нэгдсэн эмнэлгүүд дэх хүүхдийн тасгуудад нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгааг дэлгэрэнгүйгээр авч үзсэн бөгөөд зөвхөн уг хүснэгтэд дурдсан тоног төхөөрөмжийн хувьд нийт 1,9 орчим тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна.

*Хүснэгт 5. Багаж тоног төхөөрөмжийн хэрэгцээ
/2016-2017/*

№	Багажны нэр	Гарал үүслийн улс	Шаардлагатай тоо/ш	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Монитор	Хятад	40	1,481,000	59,240,000
2	Автомат тариурын аппарат	Хятад	50	849,000	42,450,000
3	Дуслын автомат шахуурга	Хятад	50	1,013,000	50,650,000
4	Хүүхдийн амьсгалын аппарат /компрессор болон чийгшүүлэгч дагалдана/	Герман	9	42,624,000	383,616,000
5	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	Хятад	30	966,000	28,980,000
6	Дифебрилятор	БНСУ	10	5,077,000	50,770,000
7	Сорох төхөөрөмж	Хятад	40	452,000	18,080,000
8	Спирометр	Итали	9	1,861,000	16,749,000
9	Хүүхдийн ЗЦБ аппарат	Итали	18	5,161,000	92,898,000
10	Чих хамар хоолойн ком	Итали	25	132,000	3,300,000
11	Зөөврийн рентген аппарат	БНСУ	9	28,500,000	256,500,000
12	Автомат хальс угаагч	БНСУ	9	4,350,000	39,150,000
13	Ходоодны уян дуран	Япон	9	63,000,000	567,000,000
14	Утлагын аппарат	БНСУ	9	2,566,666	23,099,994
15	Телемедицины ком		7	10,000,000	70,000,000
16	Цахилгаан гүйдлийн эмчилгээний аппарат	БНСУ	9	3,000,000	27,000,000
17	Цахилгаан эмчилгээний аппарат	БНСУ	9	1,700,000	15,300,000
18	Лазер шарлагын аппарат	БНСУ	9	2,500,000	22,500,000
19	Хэт авиа эмчилгээний аппарат	БНСУ	9	1,050,000	9,450,000
20	Нярайн дулаацуулагч	БНСУ	9	6,733,333	60,599,997
21	Хүүхдийн жин өндөр хэмжигч	Хятад	18	150,000	2700000
22	Нярайн жин хэмжигч	Хятад	18	150,000	2700000
23	Ларигоскопын ком		18	400,000	7200000
24	Зөөврийн кварц		18	450,000	8100000
25	Эмийн хөргөгч		9	1,993,000	17937000
	НИЙТ				1,875,969,991

2.2 Төрөх болон хүүхдийн эмнэлгүүдэд тулгамдаж байгаа асуудал, цаашид авах арга хэмжээний санал

Энэхүү судалгааг гүйцэтгэж байх явцад манай улсын эрүүл мэндийн салбар, ялангуяа төрөх болон хүүхдийн эмнэлгүүдэд үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох төрийн байгууллага, зарим эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй холбогдож санал сэтгэгдлийг нь авсан болно.

Хэдийгээр эрүүл мэндийн салбарт үйлчилж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг хангалттай байгаа хэдий ч санхүүжилт, эрх зүйн баримт бичгийн хоорондын уялдаа хангалтгүй, эмч, эмнэлгийн ажилчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг хуульчилсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.

Ийм учраас эмнэлгийн салбарт тулгамдаж буй нийтлэг асуудал нь эмч, эмнэлгийн ажилчдын ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж хангалтгүй байгаа, шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг зэргээс шалтгаалан улсын хэмжээнд ажиллаж байгаа эмнэлгүүдийн үйлчилгээний чанар, хүрээмж хангалтгүй, ачаалал өндөр зэрэг асуудлууд байсаар байна.

Төрөх болон нярай, хүүхдийн эмнэлгүүдэд тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

1. Хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн хэрэгжилт:

- Эрүүл мэндийн салбар, төрөх, нярай, хүүхдийн эрүүл мэндийн талаарх хууль эрх зүйн орчинг системтэй, бодлогын түвшинд үйл ажиллагаа явуулж буй байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулахад юуны өмнө анхаарах шаардлагатай байна.
- Эх хүүхдийн эрүүл мэндийн талаар төрөөс бодлогын баримт бичгүүдийг батлан, стратеги төлөвлөгөөг шат дараатай хэрэгжүүлж ирсэн хэдий ч бодлогын түвшинд баримтлаж буй хөтөлбөр, стратеги баримт бичгүүдийн хэрэгжилтийн хугацаа дийлэнх нь 2015 онд дуусаж, хэрэгжилтийн үр дүн гараагүй байна. Цаашид салбарын яам, Засгийн газар, Хууль тогтоох байгууллагуудын хувьд төрийн бодлогын хэмжээнд эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгаа, ажлын байрыг сайжруулах зэргийн зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх.

2. Эмнэлгийн ажилчдын хүний нөөцийн бодлого дутмаг:

- Эх барих эмэгтэйчүүд, нярай, эрчимт эмчилгээний эмч, эх баригч, сувилагч нарын ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж хангалтгүй, урамшуулал бага, хариуцлага тооцох хэлбэр давамгайлж байгаагаас эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нар ажлаас хөндийрч, ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага уруу шилжсэнээр бэлтгэгдсэн боловсон хүчнээ алдаж байна.
- Амаржих газрын болон нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартаар эмч, сувилагчийн тоо, харьцаа оновчтой түвшинд нэмэгдэхээр байгаа ч цалингийн фонд байхгүйгээс стандарт амьдралд хэрэгжихгүй байна.

- Эмч, сувилагчдын хувьд өдөрт дунджаар 40-60 хүүхдийн өвчний түүхийг хөтөлж, хоногт 15 хүүхэд шинээр хэвтэж, мөн тооны хүүхэд эмнэлгээс гардаг ба энэ бүхэнд анхан шатны маягт хөтлөх, мөн амин үзүүлэлтийг хөтлөхөд ихэнх цагаа зарцуулснаас асаргаа, үйлчилгээний чанарт муугаар нөлөөлж байна.
- Төв эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу хүний нөөцөөр хангагдаж чадахгүй байна. Энэ нь орон тоо бүрэн хэмжээгээр батлагдаж ирэхгүй байгаатай холбоотой. Мэргэжлээр нь авч үзвэл нярай, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, сувилагч нар нэн шаардлагатай байна.

Иймд, Эмнэлгийн бие даасан байдлыг хангах, эмнэлгийн дарга нар гүйцэтгэлээр нь цалинжуулах, урамшуулах, сургалтанд дэмжлэг үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг эрх зүйн орчин бүрдүүлэх.

3. Эмнэлгийн хүрэлцээ хангамж, орчин нөхцөл хангалтгүй:

- Онцгой байдал, гамшиг ослын үед эх нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангах нөөцийг бүрдүүлэх (эхийн амь тэнссэн үеийн тусламжид онгоцоор эмч очиж тусламж үзүүлэх, өвчтнийг зөөвөрлөх эрх зүйн орчинг бүрдүүлэх).
- Удам зүй, ураг-нярай судлалыг хөгжүүлэх, үргүйдлийн үед үзүүлэх оношлогоо эмчилгээний тусламжийг хөгжүүлэх явдлыг онцлон анхаарч шаардагдах санхүүжилтийг тусгайлан шийдвэрлэх.
- Нэгдсэн эмнэлгийн амбулатор, кабинетийн эмэгтэйчүүдийн эмчийн ачаалал их, өдөрт дунджаар 40-50 хүнд үйлчилдэг, хүлээлэг ихтэйгээс жирэмсэн эхийн хяналт хангалтгүй байна. Энэ нь эхчүүд хяналтын үзлэгтээ хугацаандаа ирэхгүй байх, ирсэн нэг нь хүлээж чадахгүй орхиж явахад хүргэж, улмаар суурь өвчтэй ээжээс суурь өвчтэй хүүхэд төрж, эндэхэд хүргэж байна.
- Нэгдсэн эмнэлэгт *эмгэг нярайн тасаггүй*, эмгэг нярай нь төрөх тасгаас гармагц хүүхдийн тасагт ирдэг, хүүхдийн тасагт нярайн тасаг байхгүй нь өвчлөл хүндрэхэд нөлөөлж байна. Ялангуяа шарлалт ихтэй нярай гэртээ хэд хоноод хүүхдийн тасагт ирж, амьсгал, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчтэй хүүхдүүдтэй холилдон хэвтэж, хоёрдогч халдвараар хүндрэх асуудал гарсаар байна.

4. Эмнэлгүүдийн тоног төхөөрөмж хоцрогдсон, хүрэлцээ хангамж муу, санхүүжилт хангалтгүй:

- Бодлогын түвшинд дутуу нярай, амьгүй төрөлт, ургийн бүтэлт, төрөлхийн хөгжлийн гажигт нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлээс урьдчилан сэргийлэхэд тоног төхөөрөмжийн хүрэлцээгүйгээс шаардлагатай тохиолдолд ихэнх амаржих эхийн хувьд хувийн хэвшлийн эмнэлэгт хандан оношлуулах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг. Иймд төрөх, нярай, хүүхдийн эмнэлгийн салбар хоорондын арга хэмжээг төлөвлөн, санхүүжилтийг шийдвэрлэн, хамтын ажиллагааг хангах нь чухал байна.
- Нярай, хүүхдийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай амьсгалын аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, наркозын аппарат,

- фото эмчилгээний аппарат, хүчилтөрөгчийн аппарат, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч, хэт авиан аппарат, хяналтын монитороор хангахад эмнэлгийн удирдлага, бодлогын түвшинд анхаарах шаардлага байна.
- Улсын төсөвт тусгасан эмнэлгийн салбарын санхүүжилт хангалтгүй. Ялангуяа төрөх, нярайн эмнэлгүүдийн зардал санхүүжилт хангалтгүй. Өнөөгийн байдлаар төрөх, нярай, хүүхдийн эмнэлгүүдэд шаардлагатай байгаа зарим тоног төхөөрөмжийг Олон Улсын байгууллага, гадаадын зарим орны буцалтгүй тусламж зэргээр хангаж байна.

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ЖИШИГ СТАНДАРТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Шинэ Зеланд, Их Британи зэрэг улсуудын эрүүл мэндийн системийг 2014 оны байдлаар харьцуулахад Хамтын нөхөрлөлийн орнуудынх хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. NHS /National health service/ үр ашигтай, үр дүнтэй, тусламж үйлчилгээ нь зохион байгуулалттай, өвчтөн төвтэй, зардалтай холбоотой асуудлуудыг хамгийн сайн систем гэж нэрлэсэн байна.

Эдгээр орнуудаас зарим орны төрөх болон хүүхдийн эмнэлгийн хүрэлцээ, орчин нөхцөлийн талаар дэлгэрнгүйгээр авч үзлээ.

1. ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Шинэ Зеланд улс нь 268.021 км² нутаг дэвсгэртэй, 4,6 сая хүн амтай улс юм. Шинэ Зеланд улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны дагуу жирэмсэн болон төрөх үед шаардлагатай тусламж үйлчилгээ нь үнэ төлбөргүй байдаг бөгөөд энэ үйлчилгээнд жирэмсэн болохоос төрөх хүртэлх бүх үйлчилгээ хамаарагддаг юм.

Шинэ Зеланд улсын төрөх эхчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн тогтолцоо нь нэлээд онцлогтой буюу эх баригч нар чухал үүрэг гүйцэтгэдэг. Эх баригч нарыг бэлтгэдэг тусгай сургууль байдаг бөгөөд тухайн эх баригч нь аль нэг шатны эмнэлэгт ажиллах, эсвэл бие даан үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг. Учир нь Шинэ Зеланд улсын эрүүл мэндийн тогтолцооны дагуу тухайн жирэмсэн эмэгтэй нь эх баригчаа жирэмсэн болох үедээ өөрөө сонгох бөгөөд тухайн эх баригч нь жирэмсний үеийн бүх тусламж, үйлчилгээг зохион байгуулах үүрэгтэй байдаг.

Мөн тухайн жирэмсэн эх төрөх эмнэлгээ өөрөө сонгох, мөн гэрээр төрөх боломжтой байдаг. Энэ бүх үйл явцад тухайн эхийн сонгосон эх баригч нь байнга хамт байж, үйлчилгээ үзүүлдэг. Мөн эх баригч нь тухайн жирэмсэн эхэд шийдвэр гаргахад нь мэдээллээр хангах, төрхийн өвдөлт, төрөх үйл явц, хооллолт, хүүхдийн арчилгаа, дархлаажуулалт, олон нийтийн үйлчилгээ, дасгал хөдөлгөөн гэх мэт жирэмсэн болон төрсөн эмэгтэйд шаардлагатай бүхий л мэдээллээр хангах үүрэгтэй.

Шинэ Зеланд улсад төрөх эхчүүд гэрээг төрөх боломжоос гадна үйлчилгээ үзүүлэх дараах 3-н шатлалт эмнэлэг байдаг.

- Анхан шатны үйлчилгээ: Зөвхөн жирэмсэн эмэгтэйчүүдэд үйлчлэх зориулалттай, хүчин чадал багатай төрөх төвүүд байдаг бөгөөд ихэвчлэн жирэмсний хүндрэл багатай хэвийн төрөх эмэгтэйчүүд энэхүү төвийг сонгон үйлчлүүдэг.

- Хоёрдугаар шатны үйлчилгээ: Шинэ Зеланд улсын эрүүл мэндийн яамнаас гаргасан эрсдэлт хүчин зүйлсийн жагсаалтад багтсан оноштой жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдах бөгөөд мэс заслын аргаар төрөх үед хоёрдугаар шатны эмнэлгээр үйлчлүүлдэг.
- Гуравдугаар шатны үйлчилгээ: Жирэмсэн эмэгтэй болон төрөх хүүхдэд нарийн мэргэжлийн эмч шаардлагатай өвчний онош гарсан тохиолдолд гуравдугаар шатны эмнэлэгт шилжүүлж, нарийн мэргэжлийн эмч нарын баг тусламж, үйлчилгээ үзүүлдэг.

Шинэ Зеланд Улс нь “Эх хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар аюулгүй байдлын” хөтөлбөрийн хүрээнд “Эж” стандартыг баталсан бөгөөд энэхүү стандартын зорилго нь улс даяар шударга, өндөр чанартай аюулгүй үйлчилгээ үзүүлэх удирдамжаар хангах зорилготой юм байна. Энэхүү стандарт нь Эрүүл мэндийн яамнаас гаргасан жирэмсэн болон амаржих эхэд үзүүлэх үйлчилгээнд хяналт тавих төлөвлөгөө, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмч нарт хяналт тавих төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөө зэргийг агуулсан байдаг.

Шинэ Зеланд улсын төрөх эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээнд чиглэсэн оновчтой бодлого, удирдамжийн үр дүнд энэ салбарын хууль эрх зүйн орчин бүрэн хангагдаж үүний үр дүнд Шинэ Зеланд улсын төрөх эмнэлгийн орчин нөхцөл, үйлчилгээ дэлхийд дээгүүрт байдаг юм байна. *Жишээ нь*: төрөх эмнэлгүүд нь шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, төрсний дараах тав тухтай орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч өрөө бүр нам гүм орчныг бүрдүүлсэн, өргөн ор, усанд орох душ, 00, телевиз, сандал ширээ, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг байна.

Төрөх эмнэлгийн 3 шатлалт үйлчилгээ, гэрээр төрөх боломж зэрэг нь Шинэ Зеланд улсын эмнэлгийн үйлчилгээний ачаалал жигд, хүртээмжтэй, чанартай байх нөхцлийг бүрдүүлж байна.

Хүүхдийн эмнэлгийн орчин нөхцөл, хүрэлцээ:

Шинэ Зеланд улсын эрүүл мэндийн тогтолцооны дагуу 6 хүртэлх насны хүүхэд үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй байдаг. 0-14 насны хүүхдэд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг өрхийн эмнэлгээр дамжуулан хүргэж, улсын хэмжээний 2 томоохон эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийн эмнэлэг нь нарийн мэргэжлийн эмч, сувилагчаас гадна эмнэлгийн орчинд хүүхэдтэй тоглох мэргэжилтэн, эмнэлгийн орчинд хичээл заах багш, нийгэм соёлын ажилтан зэрэг тусгай үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн байхыг шаарддаг. Мөн боловсон хүчнээ байнга бэлтгэн, сургалтанд хамруулж, шинээр авах боловсон хүчний мэргэжил, боловсролоос гадна хүүхэдтэй ажиллаж чадах сэтгэхгүй, дадал зуршлыг харгалзан үзэж сонгон шалгаруулдаг.

Мөн эмнэлгийн орчин нөхцөл нь тухайн эмчлүүлж буй хүүхэд болон түүний гэр бүлийн гишүүдийн тав тухыг хангасан, хүүхдээ асран, халамжлах нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг. Мөн тухайн хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн өрөөний цонхны цоож нь оньсон байх, усны температур нь аюулгүй хэмжээнд байх, эм хадгалах зориулалтын савтай байх, тусгай хамгаалалттай

дулааны шугам, хурц ирмэггүй тавилга, тоног төхөөрөмжтэй байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой.

2004 онд “Хүүхэд болон өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах стандарт”⁹¹ баталсан бөгөөд энэхүү стандартын зорилго нь Шинэ Зеланд улсын нийт хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийг шаардлагатай хэмжээнд нь байлгах, удаан хугацаанд эмнэлэгт хэвтэж байгаа хүүхдүүдийн орчин нөхцлийг сайжруулах, тэдэнд үйлчилгээ үзүүлж байгаа сувилагч, эмнэлгийн ажилчдын чадавхыг дээшлүүлэх зэрэг юм. Улсын хэмжээний хүүхдийн эмнэлэг нь хүүхдийн ерөнхий эмч, тусгай зориулалтын сувилахуйн баг, сэтгэл зүйч, тоглоомын мэргэжилтэн, сургалт, эрүүл мэндийн бага эмч нараас бүрдсэн мэргэжлийн баг ажилладаг гадна эмнэлгийн орчин нөхцлийн хувьд эмчлүүлж буй хүүхэд болон түүний гэр бүлийн гишүүдийн тав тухыг хангасан, хүүхдээ асран халамжлах нөхцлийг бүрдүүлсэн, орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон өрөөнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Жишээ нь: өрөөний цонхны цоож нь оньсон байх, усны температур нь аюулгүй хэмжээнд байх, эм хадгалах зориулалтын савтай байх, тусгай хамгаалалттай дулааны шугам, хурц ирмэггүй тавилга, тоног төхөөрөмжтэй байх, хүүхэд тоглох зай талбай хангалттай байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой байдаг юм байна.

2. ИХ БРИТАНИ УЛС

Англи Улс нь эрүүл мэндийн салбарын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч орнуудын тоонд ордог. Хүн амын төрөлт, өсөлт сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байгаа бөгөөд нялхасын эндэгдэлээрээ хамгийн багад тооцогддог байна. Эрүүл мэндийн нийт зардал нь ДНБ-ний 9 хувийг эзэлдэг байна.

*Хүснэгт 6. Их Британий эрүүл мэндийн зарим статистик мэдээлэл⁹²
(ДЭМБ-ын тайлангаас)*

№	Үзүүлэлтүүд	жил	тоо
1	1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл	2015	4
2	Дундаж наслалт	2013	81
3	100000 хүнд ногдох эмнэлгийн ор хоног	2013	276
4	1000 хүнд ногдох амьд төрөлт	2013	12
5	100000 хүнд ногдох эмчийн тоо	2014	281
6	Эрүүл мэндийн нийт зардал – (ДНБ эзлэх хувь)	2013	9

Их Британи улсын хүүхдийн эмнэлгийн стандарт⁹³

Их Британийн NHS /Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн үйлчилгээний алба/ нь эмнэлгийн стандартыг зөв хэрэгжүүлэх, бие даасан үйлчилгээгээр хангах, орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах урт хугацааны бодлогын хөтөлбөрийг баримтлан боловсруулсан байна. Энэ NHS төлөвлөгөө, Кеннеди тайлангаар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эмнэлзүйн засаглалын хүрээг өөрчлөх, хүүхдэд шаардагдах үйлчилгээ, стандартын хэрэгжилтийг тодорхойлжээ. Энэ стандарт нь:

⁹¹ http://www.paediatrics.org.nz/files/dh_20scorecards/standardswellbeinglongdocmay02.pdf

⁹² <http://www.euro.who.int/en/countries/united-kingdom-of-great-britain-and-northern-ireland/data-and-statistics>

⁹³ https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/199953/Getting_the_right_start-National_Service_Framework_for_Children_Standard_for_Hospital_Services.pdf

- Гэр бүлийн орчинд эмнэлгийн чанартай үйлчилгээг хүргэх;
- Эмнэлэгт байх хугацаанд хүүхдийг аюулгүй байдлаар хангах;
- Эмнэлэгт хүүхдэд зориулагдсан тусгай үйлчилгээ, хүүхдийг хүлээн авах тохиромжтой нөхцөл бололцоогоор хангах;

NHS-ийн төлөвлөгөөт арга хэмжээ нь “хүүхэд төвтэй” эрүүл мэндийн үйлчилгээг шинэчлэн зохион байгуулах, өөрчлөх, хүүхдийн хэрэгцээг мэдэрч туслах, нийгмийн тусламж, үйлчилгээний стандартын цогц бодлого юм.

Гол зорилго нь: Тогтвортой хугацаанд өргөжүүлэх хөрөнгө оруулалтын цар хүрээг өргөсөх, шинээр чадварлаг боловсон хүчнийг нэмж ажиллуулах, шинэ барилга нэмж барих, орчин үеийн техник тоног төхөөрөмжийг ханган сайжруулахад оршино. *Эмнэлгийн стандартын чанар нь 3 хэсгээс бүрдэнэ.*

Нэг: Хүүхэд төвтэй эмнэлгийн үйлчилгээ:

Гэр бүлийн хэрэгцээнд хүүхэд ба залуучууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ их гардаг. Тэдний асуудлыг эцэг эх нь хүндэтгэн ойлгож, өвчин ба гэмтэл бусад шаардлагатай эмчилгээг даван туулах боломж олгох, мэдээлэлээр хангахад дэмжлэг үзүүлнэ. NHS нь эрүүл мэндийн тусламж, нийгмийн халамжийн асуудлыг боловсруулна. Мөн үйлчлүүлэгчдэд эрх мэдэл олгох, хэрэгцээг нь судлах, хүндэтгэлтэй үйлчилгээг хэрэгжүүлэх, хамгийн шилдэг практикийг хүлээн зөвшөөрч үр дүнгээ дүгнэдэг байна. Хүүхэд төвтэй эмнэлгийн үйлчилгээ нь “бүх хүүхдийг биш” зөвхөн эмчлүүлж байгаа хүүхдийг залуучуудтай адил эмчлэх, гэр бүлийн туршлагыг судлах, хүүхдээ эмчлүүлж буй эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж, гэр бүлийн эргэн тойрны асуудлыг хамтран нэгтгэж, үйлчилгээг нэвтрүүлэх, насанд хүрсэн үед нь үйлчилгээг зогсоох, хүүхдийн эцэг эхтэй хамтран төлөвлөгөө гарган, үйлчилгээний загварыг сонгодог байна.

Хоёр: Чанарын болон аюулгүй байдлын тусламж үзүүлэх

Хүүхэд, залуучууд зохих чанарын өндөр түвшинд эмнэлгийн тусламжийг авдаг. Эмнэлзүйн засаглалын замаар үр дүнтэй боловсруулж, ур чадвартай, мэдлэг, боловсролтой байх шаардлагыг ажилтнуудад тавьдаг байна. Мөн ажилтнууд нь хүүхдийг эмчлэхээс гадна сэтгэлзүйд анхаарч боловсрол, сургалт, мэдлэгийг өргөжүүлэх, ур чадвартай асран тэтгэх, өндөр чанартай тусламж үзүүлдэг.

Гурав: Хүрээлэн буй орчны шинж чанар

Хүүхдийн хүрээлэн буй орчин нь хүүхэд залуучуудын ээлтэй байх эмнэлгийн аюулгүй орчинг бүрдүүлэх, хүүхдэд зохицсон үр дүнтэй эмчилгээгээр хангах газар байх болно.

ХАВСРАЛТ

Хууль тогтоомжийн нэр	Зохицуулсан харилцаа	Батлагдсан огноо
Эрүүл мэндийн тухай хууль	Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	2011 онд шинэчлэн найруулсан 9 бүлэг, 46 зүйлтэй.
Хүүхдийн эрхийн тухай хууль	Энэхүү хууль нь 0-18 насны хүүхдийн эрхийг хамгаална.	1996 онд анх батлагдаж хамгийн сүүлд 2010 онд нэмэлт өөрчлөлт орсон 6 бүлэг, 26 зүйл
Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	18 хүртлэх насны хүүхэд болон хүүхдээ 2-3 нас хүртэл өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/-ийн эрүүл мэндийн даатгалын төлбөрийг Төрөөс болон хүний хөгжил сангаас санхүүжүүлнэ.	2015 онд батлагдсан 8 бүлэг, 27 зүйлтэй.
Дархлаажуулалтын тухай хууль	Хүн амын дархлаажуулалт нь төрийн ивээлд байх бөгөөд халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийн тархалтыг хязгаарлах, өвчнийг устгахтай холбоотой харилцааг зохицуулсан.	2000 онд батлагдаж 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан 6 бүлэг, 21 зүйлтэй.
Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хууль	Хүүхдийг эхийн сүүгээ хооллох бодлогыг дэмжиж, эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалт, хэрэглээтэй холбоотой харилцааг зохицуулсан.	2005 онд батлагдсан, 9 зүйлтэй.
МУ-ын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	Төрөхийн өмнөх болон төрсний дараах, хүүхдээ өсгөхөд шаардлагата эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2004 онд УИХ-аас баталсан бөгөөд 2015 онд хэрэгжих хугацаа дууссан.
Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого /2 үе шат/	Төрөлтийг дэмжих, амаржсан эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг сарын дундаж цалингаас багагүй байлгаж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах, Амжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдийг 6 нас хүртэл нь хоол хүнсээр хөнгөлөлттэй үнээр хангах,	2008 онд батлагдсан, 2016 оноос 2 дах үе шат нь хэрэгжиж эхэлж байгаа.
Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого 2001	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааг зөвхөн өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэх төдийгүй, эрүүл хүнд хандуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх зорилготой.	2001 онд УИХ-ын 81 дүгээр тогтоолоор батлагдсан.

Эрүүл мэндийн байгууллагын хөгжил хөтөлбөр	Энэхүү хөтөлбөрийн зорилго нь эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчдэд ээлтэй, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр дүнтэй, чирэгдэл, хүлээгдэлгүй тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхитай болгон удирдан зохион байгуулж хөгжүүлэх	2013 онд ЭМС-ийн тушаалаар батлагдсан. 2016 оныг дуустал хэрэгжинэ.
Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын хүн амын эрүүл мэндийг сайжруулж өсөлтийг дэмжих, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон улсын жишигт дүйцүүлэн хүргэх, хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлснээр эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино.	МУЗГ-ын тогтоолоор 2010 онд батлагдсан 2010-2021 он хүртэл хэрэгжинэ.
"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний дөрөв дэх хөтөлбөр 2012-2016	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний дөрөв дэх хөтөлбөрийн зорилго нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчинг бүрдүүлж, Мянганы хөгжлийн зорилтыг хангахад оршино	МУЗГ-аас 2012 онд баталсан.
Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	шүд цоорох өвчнийг эрт илрүүлж хянах, эмчлэх энгийн, үр дүнтэй аргыг сургууль, байгууллага, аж ахуйн нэгж дээрх ажлын байр, баг, сум, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн суурь тусламжийн багц, стандартад тусган хэрэгжүүлэх	2006 онд Засгийн газрын тогтоолоор батлагдсан.
Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үндэсний стратеги 2010-2016	- Эх нярайд илрэх аюултай шинжийг мэдэн, урьдчилан сэргийлэх - Дархлаажуулалтанд бүрэн хамруулах	2010 оны ЭМС-ын тушаалаар баталсан.
Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө 2014-2020	Энэхүү төлөвлөгөө нь 2014-2020 онд НЭҮНШТ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг багтаасан ба дараах 3 үндсэн зорилготой: <ul style="list-style-type: none"> • НЭҮНШТ-ийн чиглэлийн бодлого, тусламжийг хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах, • Ижил зорилго бүхий, үйл ажиллагаатай оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, • Оролцогч талуудаас өгсөн амлалтыг баталгаажуулах 	2014 онд ЭМС-ийн тушаалаар батлагдан мөрдөгдөж байна.

Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа MNS 6188: 2010	Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа, ор, тусламж үйлчилгээ, хүлээн авах, яаралтай тусламж үйлчилгээ, эхэд үзүүлэх тусламж үйлчилгээ, нярайн тусламж үйлчилгээ, амаржих газрын эрүүл ахуй, амаржих газрын талбайн хэмжээ зэрэг амаржих газрын үйл ажиллагааны стандартыг нарийвчлан тусгасан.	2010.09 сараас үйлчилж байгаа. http://estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=standart_desc&sid=3603
Нярайн бүтэлтийн оношлогоо, эмчилгээ MNS 6320: 2012	Нэр томьёо, шалтгаан, ангилал, эмнэл зүй, оношлогоо, авах арга хэмжээ, эмийн эмчилгээ, хяналтын талаар зохицуулсан.	2012 оноос үйлчилж байгаа. http://estandard.gov.mn/file.php?sid=4638
Нярайн шарлалтын оношлогоо, эмчилгээ MNS 6321: 2012	Нэр томьёо, шалтгаан, ангилал, оношлогоо, эмчилгээ, сэргийлэлтийн талаар тусгасан.	2012 оноос мөрдөгдөж байгаа. http://estandard.gov.mn/file.php?sid=4639
Дутуу болон бага жинтэй нярайн эмчилгээ, асаргаа сувилгаа MNS 6322: 2012	Тодорхойлолт, шалтгаан, хүчин зүйлс, ангилал, хүндрэлүүд, эмчилгээ, асаргаа, хяналтын талаар тусгасан.	2012.07.16-наас мөрдөгдөж эхэлсэн. http://estandard.gov.mn/file.php?sid=4640
Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392: 2013	Эрүүл мэндийн байгууллагын стандарт, нөхцөл, цэвэрлэгээ зэрэг эрүүл ахуйн стандарт, норм нормативыг тусгасан.	2013.08 сараас мөрдөгдөж эхэлсэн. http://estandard.gov.mn/file.php?sid=6588
Зүрхний төрөлхийн гажиг MNS 6384-1-8: 2013	Зүрхний төрөлхийн гажгийн оношлогоо, эмчилгээ, мэс заслын эмчилгээний стандартыг тогтоосон 7 стандарт мөрдөгдөж байна.	2013 оноос мөрдөгдөж байгаа. http://estandard.gov.mn/index.php?module=search&cmd=searching&start=0&per_page=10&q=6384&key=2&case=MNS

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.mohs.mn/web/index.php/erhzui/20>
- <http://www.slideshare.net/batnasanb/adyabayasgalan1>
- <http://www.legalinfo.mn/annex/details/3282?lawid=7045>
- <http://urguu-amarjikh.ub.gov.mn/>
- <http://www.ehemut.mn/>
- <http://www.stat.go.jp/data/nenkan/zuhyou/y653003a00.xls>
- <http://www.nhsconfed.org/resources/key-statistics-on-the-nhs>
- <http://www.worldometers.info/world-population/uk-population/>
- https://en.wikipedia.org/wiki/Demography_of_the_United_Kingdom
- <http://www.hscic.gov.uk/article/2021/Website-Search?productid=19422&q=Labour+ward&sort=Relevance&size=10&page=1&area=both#top>
- https://en.wikipedia.org/wiki/List_of_children%27s_hospitals
- <http://www.nhsconfed.org/resources/key-statistics-on-the-nhs>
- https://en.wikipedia.org/wiki/List_of_children%27s_hospitals
- <http://www.hscic.gov.uk/catalogue/PUB12744>
- <http://www.stat.go.jp/data/nenkan/zuhyou/y653003a00.xls>
- <http://www.euro.who.int/en/countries/united-kingdom-of-great-britain-and-northern-ireland/data-and-statistics>
- <http://www.euro.who.int/en/countries/russian-federation/publications>
- <http://www.euro.who.int/en/countries/kazakhstan/data-and-statistics>
- <http://www.scotpho.org.uk/population-dynamics/pregnancy-births-and-maternity/key-points>
- <http://webarchive.nationalarchives.gov.uk/20160105160709/http://www.ons.gov.uk/ons/guide-method/compendiums/compendium-of-uk-statistics/population-and-migration/index.htm>

“МҮҮН”-ИЙ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ГАДААДЫН УЛС ОРНУУДЫН ХАНДЛАГА

*Д.Жигваагүнсэл,
Ч.Онончимэг, Д.Халиун*

Энэхүү судалгаанд “Мүүн”-ий талаарх ойлголт, Мүүн нь шашин эсхүл шашны гаж урсгал мөн эсэх талаар МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхмээс гаргасан албан ёсны тайлбар болон “Мүүн”-ийг хязгаарласан эсхүл хориглосон гадаадын зарим улсуудын талаарх мэдээллийг оруулав.

Нэг. Мүүний шинэ шашны хөдөлгөөний тухай тайлбар⁹⁴

МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхимийн багш С.Дэмбэрэл

1990 оноос Монгол улс ардчилсан нийгэмд шилжин ард түмний шашин шүтэх, эс шүтэх эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан цагаас Монголчуудын шашин оюун санааны оронд зайд олон шашнууд номлол сургаалаа дэлгэрүүлж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэний нэг нь Мүүнийн шинэ шашны хөдөлгөөн юм.

Ардчилсан улс орнуудад Мүүн гэх мэт шинэ шашны хөдөлгөөнүүд тухайн орны үндэсний аюулгүй байдал, соёл уламжлал, нийгмийн тогтсон хэм хэмжээнээс гажсан номлол сургаал дэлгэрүүлж, хүүхэд залуучуудыг гэр бүл, нийгмээс нь тусгаарлах сөрөг үйл ажиллагаагаа явуулах болсоныг үр хүүхэд, төрөл садныхаа сэтгэл санааг Мүүнийн үзэл суртлын нөлөөнд алдсан хохирогчид, хуучин гишүүд, иргэний нийгмийн төлөөллүүд шүүмжилж, 1960-1970 оны үед энэхүү хөдөлгөөний эсрэг *anti cult, counter cult movement*/ үйл ажиллагаа өрнүүлж, тэдний буруу, эрүүл нийгмийн эсрэг шинж төрхийг нь илчилж, шашны гаж урсгалд тооцон, хохирогчдыг буцааж нийгэмшүүлэх үйл ажиллагааг явуулж иржээ.

Мүүнийн /культ/ гаж урсгалыг үндэслэгч Сон Мён Мүүн нь 1936 онд анх Есүс Христтэй ер бусын тохиолдлоор уулзсан гэдэг бөгөөд Есүс Христ түүнээс Эзэн тэнгэрийн хаанчлалыг энэ дэлхийд тогтоохыг хүссэн гэдэг. Тэрээр 1954 онд анхны Эв нэгдлийн сүмээ Өмнөд Солонгосын Сөүл хотод байгуулж, 1957 онд “Тэнгэрлэг ёс зарчим” сургаалиа номлосон цагаас дэлхий даяар 4,5 сая хүн энэ сүмийн гишүүн болжээ⁹⁵

1959 онд анхны сүмээ АНУ-ын Орегон мужид байгуулсан үеэс эхлэн олон улсын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулах болжээ.

Шашин судлаачид 1960-1970 оноос эхлэн Мүүнийнхэнд культ /гаж урсгал/, сект, шинэ шашны хөдөлгөөн гэсэн олон нэр, тодорхойлолтыг өгч судалж байна. Мүүнийн шашныг зарим социологч, шашин судлаачид “шинэ шашны хөдөлгөөн” гэж үзэх чиг хандлага байдаг ч түүний хуучин гишүүд, тэдний гэр бүлийнхэн, үр хүүхдээ энэ шашны сүмд алдсан гаж урсгалын эсрэг эцэг эхийн хөдөлгөөн, хэвлэл мэдээллийнхэн ихэвчлэн “гаж”, “буруу” урсгал гэж нэрийддэг. Шашин судлаач Эрнст Трельч культ нь ихэвчлэн бусад шашинд итгэл бишрэл нь алдарсан хүмүүсийг өөртөө урвуулах үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг ба шүтэн бишрэгчдийн нэгдүгээр үе дээрээ байгаа, бүтэц

⁹⁴ <http://ubpress.mn/node/42>

⁹⁵ [Anthony Giddens, *Sociology*, 6th edition, Polity press, 2009, UK, p 690]

зохион байгуулалтын хувьд сулавтар зохион байгуулагдсан, зарим нэг хувь хүмүүсийг удирдагчаа болгон тахин шүтдэг шашны бүлгийг хэлнэ хэмээн гаж урсгалыг тодорхойлжээ.

Үнэндээ Мүүн бага балчираасаа Күнзийн болон Буддын шашны ёс зарчмуудыг аль алийг нь дагадаг ядуу тариачны гэр бүлд өсч, 10 настай байхад нь эцэг эх нь гэр бүлээрээ орон нутгийн Пресвитериан сүмийн үйл ажиллагаанд оролцох болж, мөн идэр залуудаа Японд суралцаж байхдаа Христийн Тавьтын сүмд мөргөдөг байсан зэрэг нь түүний үзэл санаа, шашны ойлголтонд олон шашны үзэл номлол холилдох, ялангуяа протестант шашны нийгэмд хандсан үйл ажиллагаа, нийгмийн сэтгэлзүйг эзэмдэх арга барилд суралцахад нь тус нэмэр болсон гэж үзэж байна. Мөн Японд цахилгааны мэргэжлээр суралцаж, хажуугаар нь далайн эргийн боомтонд ачаа зөөгч хийж байхдаа дараа дараагийн бие даасан бизнесийн үйл ажиллагаандаа санаа авчээ. Түүний “гүйлгээ ухаан”, “уран арга”, цаг үе, нөхцөл байдлыг мэдрэх, үйл ажиллагааны чигийг зөв олж тогтоох, санаагаа хурдацтай бүтээмжтэй хэрэгжүүлэх чадвар зэргийг дэлхийн олон улс үндэстнүүдийн төрийн тэргүүд, нэр хүндтэй эрдэмтэн судлаачид ойн баяр ёслолынх нь үеэр хэлсэн байдаг.

Гэхдээ Мүүнийн байгуулсан Эв нэгдлийн сүм нь дэлхийд энх тайван тогтоох уриан дор боловсрол, соёл, спорт, шашны байгууллагуудыг өөртөө нэгтгэдэг юм. Мүүнийхэн бизнесийн үйл ажиллагаагаа далд шашны номлол, зан үйлээр халхавчилдаг, дэлхийн хэмжээний энх тайвны төлөөх арга хэмжээ явуулж байгаа нэрээр улс орнуудын нийгмийн дотоод амьдралд бүдүүлгээр оролцдог зэрэг сөрөг талуудыг нь шүүмжлэх хандлага нийгэмд давамгайлдаг юм. Судлаач Рой Уаллис (Dawson 2003) бээр Мүүнийн урсгалыг өөрсдийн гишүүдийг төрөлх эцэг эх, гэр бүлээс нь холдуулж, Жинхэнэ эцэг эхийн гэр бүл болох эв нэгдлийн сүмд оруулдаг номлол, үйл ажиллагааг нь дүгнэн ертөнцийн амьдралаас холдуулагч шашны урсгал⁹⁶ гэж үзжээ.

Энэ урсгалыг Христын номлогчид, теологичдын зүгээс “гаж урсгал” хэмээн тооцдог нь

- 1/ хүмүүсийн шашны итгэл үнэмшилд тулгуурлан номлолоо түгээдэг,
- 2/ нийгэмд сөрөг нөлөө үр дагавар учруулдаг гэж үзнэ. Тодруулбал,

Нэгдүгээрт:

- **шашны итгэл үнэмшлийн үүднээс**, Мүүнийн шашны үндэслэгчийн номлол сургаал, шашны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, явуулж буй зан үйл нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн уламжлалт шашны онол, үзэл санаа, хэм хэмжээг гажуудуулж, түүнтэй үл нийцдэг байна.
- **шашныг үндэслэгчийн зан чанар**: Сан Мён Мүүн нь бусад гаж урсгалыг үндэслэгчдийн нэгэн адил уран яруу илтгэгч төдийгүй олныг бишрүүлэн, тэднээр өөрийгөө тахин шүтүүлэх чадвартай, сүсэгтнүүдийнхээ оюун санааны сул тал дээр тоглолт хийж, сэтгэл санааг нь хянаж эзэмдэн дарангуйлал тогтоон өөрийгөө Бүтээгч эзэн тэнгэрийн элч, Жинхэнэ эцэг хэмээн гишүүддээ итгүүлдэг. Гаж урсгалын эсрэг хөдөлгөөнийхөн, хуучин гишүүд нь Мүүнийг журамт ариун нөхөр, Жинхэнэ эцэг гэхэд эргэлздэг байна. Тэрээр гэр бүлийн

⁹⁶ Lorne L Dawson, *The Cults and New Religious Movements*, Blackwell Publishing, 2003, USA, p 38

хувьд тийм ч тогтвортой нэгэн биш гэдгийг ойр дотныхон нь хэлдэг. Мөн хүү Хъё Жин Мүүн нь хар тамхи, садар самуун явдалтай холбогддог нь түүний ариун гэр бүлийн тухай номлолтой байнга зөрчилдөж иржээ⁹⁷.

- **Номлол сургаал нь олон шашны үзэл санааг хольсон байдаг.** Мүүний айлдвар “Тэнгэрлэг ёс зарчим”⁹⁸ нь Христийн шашны Библийн номлол сургаал дээр тулгуурладаг ч үзэл санааг нь эртний Солонгосын бөө мөргөлийн үхэгсэдийн сүнстэй харилцах, Хятадын Даогийн арга билиг, Күнзийн ёс суртахуун, Буддын шашны хойд нас, физикийн атомын тухай ойлголтуудтай хольж утгыг нь алдагдуулсан хэмээн судлаачид үздэг.⁹⁹ Түүнийг Христийн шашны Библи дээр байдаг Бүтээгч эзэн, Есүс Христийн тухай номлолыг гажуудуулж, гаж сургаал дэлгэрүүлсэн хэмээн теологчид шүүмжилдэг.
- **Уламжлалт шашны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанаас Мүүнийн шашных эрс ялгаатай.** Эв нэгдлийн сүм нь Жинхэнэ эцэг эх, гэр бүлийн гишүүд болон тэдний ойрын тойрон хүрээлэгчид ба эв нэгдлийн сүмийн номлогчид гэсэн шашны засаг захиргааны дараалсан шатлал, зохион байгуулалттай.
- **Шашнаа дэлгэрүүлдэг байдал.** Мүүнийхэн уламжлалт шашны байгууллагын зохион байгуулалтын загвараар ажиллавал олны дэмжлэгийг авч чадахгүйгээ сайн мэдэх учир өөрсдийн шашны үйл ажиллагаагаа Эв нэгдлийн сүмээс гадна тухайн улсын нийгмийн янз бүрийн давхарга, ажил мэргэжлийнхний төлөөлөлд зориулан Олон улсын соёлын сан, Олон улсын шашны сан, Дэлхийн энх тайвны төлөө шашин хоорондын холбоо, Дэлхийн эв нэгдэл, энх тайвны төлөө гэр бүлийн холбоо, Дэлхийн энх тайвны төлөө профессоруудын академи, Дэлхийн энх тайвны төлөө залуучуудын холбоо зэрэг хүмүүнлэг, төрийн бус байгууллагаар халхавч хийн дэлгэрүүлдэг байна. Судлаач, шинжээчид эдгээр олон байгууллагыг Мүүнийхэн мөнгө угаах, татвараас зайлсхийх зорилгоор байгуулдаг хэмээн үздэг юм. Жишээ нь, Мүүн 1982 онд АНУ-д орлогын татвараа нуун дарагдуулсан хэмээн 18 сар хоригдох ялаар шийтгүүлж байжээ.
- **Мүүнийхэн шашин, хүмүүнлэгийн байгууллагын халхавч дор их ашиг орлогын хойноос хөөцөлддөг.** Мүүн нь энх тайван, хүмүүнлэг, шашны үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ Өмнөд Солонгосын бизнесийн Тонгил группыг эзэмшдэг. Энэ группын харъяанд хүн орхоодойн бүтээгдэхүүний үйлдвэр, эмийн үйлдвэр, хэвлэл мэдээллийн компани, аялал жуулчлал, барилга хүнд машин, механизмын үйлдвэр, тэр ч байтугай зэвсгийн үйлдвэр байдаг нь уламжлалт шашны онол, үзэл санаа, нийгэмд гүйцэтгэх үүрэгтэй зөрчилддөг байна.
- **Мүүний бизнесийн үйл ажиллагаа:** Мүүн олон салбарт бизнес үйл ажиллагаа өрнүүлсэн байх бөгөөд Америкт UPI, News World Communication, Washington Times, Washington Star, Gifl Styles, insight on the News, American life зэрэг хэвлэл мэдээллийн агентлаг, сонин сэтгүүлүүдийг, мөн Юниверсал балет хэмээх Азийн балетын групп, “Бяцхан сахиусан тэнгэрүүд” хэмээх хүүхдийн балетын группыг үүсгэжээ. Солонгост Капхен хэмээх газрын ойролцоо 2600 га газар

⁹⁷ <http://web.archive.org/web/20060421193428/http://religiousmovements.lib.virginia.edu/nrms/unification2.html>

⁹⁸ <http://www.unification.net/dp73/>

⁹⁹ Dereck Dashke and W.Michael Ashcraft, *New Religious Movements*, NY University press, 2005, USA, p 139

эзэмшиж, Чонсим хэмээх тосгоныг үүсгэсэн ба тэнд түүний хувийн барилга байшингаас гадна Чонсим олон улсын эрүүл мэндийн төв, Чонсим олон улсын академи зэрэг бий. 1990-ээд оноос өмнө тэрээр Солонгосын барааг гадаадад гаргадаг хоёр дахь экспортлогч байсан аж. Өнгөт металл боловсруулагч концерн, барилгын Ильтсон констракшн, Сэиль Трэвел, Гоу Уорлд Трэвел зэрэг аялал жуулчлалын компани, Ильхва хэмээх эмийн үйлдвэр, Пхёнхва Моторс хөнгөн тэрэгний үйлдвэр, АНУ-руу далайн бүтээгдэхүүн тээвэрлэгч Японы Тру Уорлд групп, АНУ-д USP Rocketts LLC үл хөдлөх хөрөнгийн фирм, Мастер Марин хэмээх далайн тээвэрлэлт, загас агнуурын компани, Нейншл Хоспиталити Корпорейшн зочид буудал, Японд Иссин хэмээх эмнэлэг –эдгээр нь Мүүний мэдэлд байна.

Хоёрдугаарт: нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг нь үндэслэн гаж урсгал гэж тодорхойлдог¹⁰⁰.

Энэ хэсгийг дурдахдаа Мүүнийн гэх мэт гаж урсгалын нийгэмд үзүүлдэг хүмүүнлэг, эв нэгдэл, соёл гэгээрлийн зарим эерэг нөлөөг үгүйсгэх гэсэнгүй, харин тэрхүү сайн үйлийн цаана нийгэмд учруулж буй хор хөнөөл, аюул заналыг илчлэхийг хичээлээ. Эдгээр сөрөг нөлөөг баруунд үйл ажиллагаа явуулж буй Мүүн гэх мэт гаж урсгалын сүмийн үйл ажиллагааг ажиглаж судалсан гадаадын эрдэмтдийн судалгааны материал дээр тулгуурлан жагсаав.

- **Хувь хүний эрхийг зөрчдөг:** Гаж урсгал хувь хүний бодлыг дээдэлдэг гэх боловч үндсэндээ тэд маш аюултай, хатуу дэглэм, хорио цээртэй байдаг. Гишүүд нь Жинхэнэ эцэг эхийн айлдварыг дуулгавартай дагах ёстой бөгөөд үгүй бол шийтгүүлэх, эсвэл хөөгдөх арга хэмжээ авахуулдаг.
- **Сэтгэлзүйн, бие махбодын, сүнсний дарамтанд оруулдаг:** Тухайн онол сургаалыг чанд мөрдүүлэхийн тулд гишүүдээ халамжилж буй нэрээр тэднийг үнэндээ дарамтанд байлгадаг хатуу гаж урсгалууд байдаг. Тэдгээрийн ихэнх нь Библи дэх хүйсийн тэгш эрхийн тухай онол сургаалыг мушгин гажуудуулсан байдаг. Аливаа хүний хэнтэй гэрлэж болох, эс гэрлэж болохыг хатуу чанд захирдаг.
- **Өөрийн гэсэн бодлыг илэрхийлэхийг хатуу хориглодог:** Олон гаж урсгалууд логик замаар бодохыг эсэргүүцдэг бөгөөд зөвхөн удирдагчийн, эсвэл байгууллагыг ямар ч асуудалгүйгээр үг дуугүй дагах ёстойг шаарддаг.
- **Бусдын бодол санааг бүрмөсөн үгүйсгэдэг:** Гаж урсгалуудын нийтлэг онцлог нь бусад үзэл бодлуудыг бүрмөсөн үгүйсгэдэг, эсвэл доогуур зэрэглэлд тооцдог. Салан тусгаарлалт, үл хүлээн зөвшөөрөл нь тэдний гол таних тэмдэг юм. Зөвхөн бидний зөв, бусдын буруу гэсэн хандлагатай.
- **Үндсэн соёл, нийгмээс өөрсдийгөө салан тусгаарладаг:** Бусдаар хавчигдаж, үзэн ядагдаж байна гэсэн айдсаас болж үндсэн гол итгэл үнэмшил, үнэ цэнэ, зан үйлээс зугтдаг эсвэл өөрчилдөг. Тиймээс гаж урсгалууд өөрсдийгөө хамгаалах бүх талын маргаанд үргэлж бэлэн байхыг чухалчилдаг.

¹⁰⁰ [John Ankerberg and John Weldon, Encyclopedia of Cults and New Religions, (Harvest House Publishing, Oregon, 1999), p. XXII-XXIV. Мөн New Dictionary of Theology, Eds. Sinclair B. Ferguson and David F. Wright, (Inter-Varsity Press, Leicester, England, 1988), p.633-634]

- **Хууран мэхлэлт, зальжин байх нь олон:** Өөрсдийн гишүүд болон гадны хүмүүст үүсгэн байгуулагчийн амьдралын түүх, сургаалынхаа үнэн төрх, санхүүгийн үйл ажиллагаа зэрэгт зальжин ханддаг бөгөөд үүнийгээ нуух хандлагатай байдаг. Өөрсдийн гаж урсгалын удирдагчийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх санхүү, бизнесийн үйл ажиллагаа явуулдаг. Татвараас зайлсхийх, мөнгө угаах зэрэг далд эдийн засгийг хөгжүүлэх сөрөг хандлага гаж урсгалд ажиглагддаг.
- **Зөрчил тэмцлийг өдөөдөг:** Гаж урсгалын хүмүүсээ олдог гол тактик нь аль хэдийн сүм чуулганд хамрагдаж эхэлсэн, гэвч ялгааг нь сайн танихгүй хүмүүст хүрэхэд чиглэгддэг. Тэд бусад сүм чуулгануудыг “өөрсдийн загасчлах нуур” хэмээн боддог бөгөөд “манайх яг жинхэнэ сайн нь” гэх мэдээгээр тэднийг татдаг. Энэ мэт үйл явдлаас болж сүмүүдийн хооронд муудалцаан хагарал, эсэргүүцлийг өдөөх нь элбэг.
- **Нийгмийн эсрэг турхирдаг:** Тэд өөрсдийг нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа хувь хүн, гэр бүл, нийгмийг буруутгаж, улс орныг бүхэлд нь муу ёрын зүйл гэх бөгөөд улсын хуулийг зөрчих хүртэл өдөөн турхирдаг.

Судлаачдын үзэж байгаагаар Мүүнийхэн нийгэмд ард иргэдийг итгэл үнэмшлээр нь “бид” ба “тэд” гэсэн хоёр хэсэгт хуваадаг байна.

Ямар арга хэлбэрээр дэлгэрдэг:

Мүүнийхэн ихэвчлэн хүмүүнлэг болон төрийн бус байгууллагаар халхавчлан үйл ажиллагаа явуулах бөгөөд тэдний гол зорилтот бүлэг нь хөдөө орон нутгийн иргэд, хөдөөнөөс хотод шилжин ирэгсэд, хотын гэр хорооллоор оршин суугчид, хөдөөний оюутнуудыг шашны талаарх мэдлэг, мэдээлэл хомс байдлыг ашиглан сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлэх замаар элсүүлэх тал ажиглагддаг. Эв нэгдлийн сүмийнхэн тухайн улс орны улс төр, нийгмийн зүтгэлтнүүд¹⁰¹, эрдэмтэд, урлаг спортын ододыг эгнээндээ элсүүлж номлол, үйл ажиллагаагаа сурталчлахад ашигладаг¹⁰².

Гэхдээ эв нэгдлийн сүмийн үйл ажиллагаанд оролцсон хүн бүрийг тус сүмийн гишүүн эсвэл дэмжигч гэж үзэх нь учир дутагдалтай. Учир нь тэд өөрсдийн ажил үүргийн хувиар сүмийн үйл ажиллагаанд татагдан орох тохиолдол байж болох талтай.

Мүүнийхэн улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог нь 1974 онд АНУ-ын ерөнхийлөгч Ричард Никсоныг дэмжиж байсан жишээгээр илэрдэг. НҮБ-ийн үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд даян дэлхийд энх тайван тогтоохын тулд 1998 онд Дэлхийн энх тайвны төлөө шашны холбооны хурлын үеэр одоо байгаа НҮБ-ийн бүтцийг дээд кабинет буюу дэлхий шашны удирдагчдаар бүрдүүлж, түүний удирдлага доор дэлхийн улс төрийн удирдагчдаар бүрдүүлсэн доод кабинетийг ажиллуулах саналыг тавьж байсан нь олон шинжээч, судлаачид, иргэний хөдөлгөөний зүгээс төр, сүм хийдийн харилцааны асуудлыг ноцтой зөрчиж байна хэмээх шүүмжлэлтэй тулгарч байжээ.

¹⁰¹ [<http://www.upf.org/resources/speeches-and-articles/4968-p-ochirbat-address-to-world-summit-2013>]

¹⁰² [John L. Esposito, Darrell J. Fasching, Todd Lewis, Religion and Globalization, Oxford University press, 2008, NY]

Ямар үзэл номлол түгээн дэлгэрүүлдэг:

Шинэ ойлголт, шинэ хувь хүн, шинэ гэр бүл, шинэ нийгэм, шинэ дэлхий ертөнц Мүүнийхний гол зорилго нь “Тэнгэрлэг ёс зарчим” номлолыг “Энх тайвны” уриан дор дэлгэрүүлж, дэлхий дээр Бүтээгч эзэн тэнгэрийн хаанчлалыг тогтоохыг зорино. Дерек Дашкегийн (2005) ангилсанаар тэд хүмүүсийг номлолдоо итгүүлж, үйл ажиллагаандаа татан оролцуулахдаа дараах дарааллаар хэрэгжүүлдэг.

- *Шинэ ойлголт:* Шинээр элссэн гишүүддээ хүний амьдарлын утга учир, амьдралд тохиолдох төөрөгдөл, алдааг өөр өнцгөөс тайлбарлан, дэлхий ертөнц, нийгмийн талаар шинэ ойлголт суулгана. Ингэхдээ голдуу Библийн номлолыг Ази, дорно дахин тэр дундаа Солонгосын соёлын үүднээс гуйвуулж тайлбарлана. Солонгос улс бол “Гурав дахь Изриаль” бөгөөд Мүүн бол Бүтээгч эзний элч хэмээн гишүүддээ номлоно.
- *Шинэ бие хүн:* Хүний өнгөрсөн болон одоо байгаа аз жаргалгүй, зовлон гуниг дүүрэн, материаллаг ертөнцөд төөрөлдсөн, сул дорой, хэрэггүй зан чанар, төгс бус байдлыг төгс, хүчирхэг байдалд хүргэж, Бүтээгч эзэн тэнгэр, жинхэнэ эцэг эхийн ивээлд багтаана хэмээн номлоно. Эв нэгдлийн сүм, жинхэнэ эцэг эх, тэдний гишүүдийн зөвлөгөө, “Тэнгэрлэг ёс зарчим”-ын сургаалыг хэрэгжүүлж байж шинэ бие хүн болдог ажээ.
- *Шинэ гэр бүл:* Төрсөн эцэг эх, гэр бүл тань таныг энэ ертөнцийн амьдралд бэлтгэж чадаагүй хэмээн хуучин гэр бүлээс нь салгаж шинэ гэр бүл буюу эв нэгдлийн сүмд оруулна. Сүмийн удирдагч, ахмад гишүүд нь эцэг эхийн үүрэг гүйцэтгэж, шинэ гишүүд нь тэдний “хүүхдүүд” болж хамгаалалд нь багтан, заавар зөвлөгөөг нь дагана.
- *Шинэ нийгэм:* Эв нэгдлийн сүм нь өөрсдийн номлол, үнэт зүйл, ёс суртахууны хэм хэмжээ, зорилго чиглэлтэй нийгмийн нэг бүлэг болж бүрэлдэнэ. Гишүүддээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн хэм хэмжээг гажиж Жинхэнэ эцэг эхийн айлдсан шинэ хэм хэмжээг дагахыг санал болгоно. Энэ шашны урсгал нь нийгэмд хүрээгээ тэлэхийн тулд сүмдээ шинээр гишүүд элсүүлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг байна.
- *Шинэ дэлхий ертөнц:* Мүүний гол зорилго нь Есүс Христийн сургаалыг даган *Эзэн тэнгэрийн хаанчлалыг дэлхий ертөнц дээр тогтоохыг зорино.* Тэрээр өөрийгөө сатаны эсрэг, коммунистуудын эсрэг тэмцэж, дэлхий ертөнц дээр энх тайван байдлыг тогтоон Эзэн тэнгэрийн хаанчлалыг бий болгоно гэж үзэж байжээ.

Үйл ажиллагаа нь гаж шинж чанартай эсэх:

Мүүнийн олонд танигдсан гол зан үйл бол гишүүдээ олноор нь гэрлүүлэх ёслол юм. Мүүн сүмийн гишүүддээ төгс хамтрагч олж өгөхийн тулд тэдний 7 үеийг харж чаддаг хэмээн сайрхдаг байна.

Сан Мён Мүүн өөрөө 40 настай байхдаа анхны эхнэрээсээ салж гэрийн үйлчлэгчийнхээ охин 17 настай Хан Хак Ча-тай гэрлэж 14 хүүхэд төрүүлж өсгөсөн ба энэхүү гэрлэлтээ Бурханы заалтаар хийгдсэн “ариун гэр бүл”, өөрсдийгөө “Ариун эцэг эх”, хүүхдүүдээ “Ариун хүүхдүүд” хэмээн зарлажээ.

Түүний ариун гэр бүлийн үлгэр жишээгээр гэрлэсэн хос болгон Бурханы ивээлд орно хэмээн номлож, 1968 онд 430 хос, 1975 онд 1800 хос, 1982 онд 6000 хос, 1992 онд 30000 нос, 1995 онд 360000 хос, 1997 онд 3600000¹⁰³ хос тус тус нэг доор гэрлэж хуримын ёслол үйлдэж байжээ. Хамгийн олон хосыг нэг дор гэрлүүлэх ёслолыг зохион байгуулсан гэж Гиннесийн номд бүртгэгдсэн байдаг. Жич, Монголд Мүүний шашин дэлгэрсэн талаар судалгаа хийсэн МУИС-ийн шашин судлалын салбарын нэгэн төгсөгчийн мэдээлснээр Мүүнийн гэрлэлтэнд оролцохын тулд нэг хүн доод тал нь 500 ам.доллар төлдөг ба гадаад орон руу, ялангуяа АНУ руу явах виз авах зорилгоор Монголоос нэлээд олон хүн энэ үйл ажиллагаанд хамрагдсан ажээ.

Мүүнийхэн өнөөг хүртэл 10 гаруй удаагийн нийтээр гэрлүүлэх ёслолыг зохион байгуулаад байна¹⁰⁴. *Тэд гэр бүлийн тухай өөрсдийн номлол сургаалдаа эхнэр, нөхөр, Эзэн тэнгэр, хүүхдийн хоорондын холбоо нь нийгмийн харилцаанд чухал байр суурь эзэлнэ гэж заана.*

Өнөөгийн гэр бүлд тулгамдаад байгаа гол асуудлууд нь Эзэн тэнгэрийн хайр, сургаал номлолоос холдон, иргэний гэр бүлийн хэм хэмжээ, гэрээг дагаж байгаагаас үүдэлтэй гэж тайлбарлана. Гишүүд нь Жинхэнэ эцэг эхийн заавар, сонголтоор гэр бүл болоход заримдаа өөрийн хайр дурлалыг золиослох ёстой гэж үзнэ.

Мүүнийн ёсоор аливаа хүн гэр бүлийн амьдрал зохиохын тулд Эзэн тэнгэрийн гурван адислал, ивээлийг хүртэх ёстой.

1-т гэр бүл болохын өмнө хувь хүн эзэн тэнгэр, жинхэнэ эцэг эхийн сургаалыг сайтар судлан амьдралдаа хэрэгжүүлж төгс бие хүн болж ивээлд нь багтсанаар хэрэгждэг. Сүмийн гишүүн дотоод зүрх сэтгэлдээ эзэн тэнгэрийн мөн чанарыг санаж, гадаад биеийн үйлдэлээр эзэн тэнгэрийн үйл хэрэгийг хэрэгжүүлж байж төгс бие хүн болно.

2-т өөрийн адил эзэн тэнгэрт үнэнч төгс бэлтгэгдсэн гэр болох хүнээ Жинхэнэ эцэг эхийн заавраар сонгож гэр бүл болсноор хүртэнэ.

3-т Жинхэнэ эцэг эхийн заавар, сонголтоор бий болсон гэр бүлүүд нь дэлхий даяар тархан Тэнгэрийн хаанчлалыг газар дэлхийд бүтээснээр хэрэгжих ажээ.

Мүүний гэр бүлийн тухай эдгээр номлол нь Монголчуудын төрсөн эцэг эхээ хүндлэх ёс, гэр бүлийн уламжлалт харилцаа, ёс заншил, хэм хэмжээнээс гажсан, Жинхэнэ эцэг эх Мүүн болон түүний эхнэр Хак Жа Хан Мүүнийг зааврыг даган дээдлэн шүтэх нь Монгол соёл иргэншилд харшилж байна.

Мүүний заавраар гэр бүл болгох ёслол нь Монгол улсын гэр бүлийн тухай хуулийн 4.1 -д заасан “гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ” гэсэн гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчмын заалттай зөрчилдөж байна гэж үзэж байна. Гадны шашны байгууллагын зохион байгуулалттайгаар гэр бүл болгох нь мөн хуулийн 7.1-д заасан “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ гэрчийн этгээдийг байлцуулан иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

¹⁰³ <http://www.tparents.org/moon-talks/sunmyungmoon97/SM971129p.htm>

¹⁰⁴ [Dereck Dashke and W.Michael Ashcraft, New Religious Movements, NY University press, 2005, USA, p 155]

Мүүнийн шашны зохион байгуулалтайгаар гэр бүл болгох ёслол нь Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.2-д заасан “Үндэсний язгуур ашиг сонирхол”, 3.4.7-д заасан Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, 3.4.8-д заасан Хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох талтай.

Зарим улс оронд тухайн шашныг дэлгэрүүлэхийг хориглодог эсэх талаар:

Барууны зарим оронд тухайн улс орны шашин соёл, түүхэн уламжлал, үндэстний аюулгүй байдал, нийгмийн хэм хэмжээ, эв нэгдлийг хангах үүднээс Мүүн гэх мэт шашны гаж урсгал, сектүүдийг засгийн газрын шашны асуудал эрхэлсэн агентлаг, Хууль зүйн яам, эсвэл Соёлын яамны дэргэдэх шашны асуудал эрхэлсэн хэлтэс, Цагдаагийн төв газар, Тагнуулын төв газрууд нь бүртгэж үйл ажиллагаанд нь хяналт тавьж, тухайн улс орны үндэсний аюулгүй байдалд сөрөгөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан тохиолдолд тухайн шашны гаж урсгалыг зогсоох хүртэл арга хэмжээ авдаг байна.

Мөн ард иргэдийнхээ шашны итгэл үнэмшил, оюун санааг гаж урсгалын сөрөг нөлөөнөөс сэрэмжлүүлэх зорилгоор гаж урсгалуудын жагсаалтыг¹⁰⁵ гаргаж ард иргэдээ мэдээллээр хангаж, гаж урсгалын хохирогч болохоос урьдчилан сэргийлдэг байна.

Мүүнийхнийг Австри, Герман, Франц, Хятад, Орос, Сингапур зэрэг орнуудад гаж урсгалын жагсаалтанд оруулж, үйл ажиллагааг нь хянаж, зарим тохиолдолд үйл ажиллагааг нь хориглосон байдаг ажээ¹⁰⁶.

Манай улсад нэвтэрч орж ирсэн байдал:

Мүүнийхэн 1990 оноос Монголчуудын шашны итгэл үнэмшил, оюун санааны хил хязгаар нээлттэй болсон үеэс Эв нэгдлийн сүмээс гадна өөрсдийн номлол, үйл ажиллагааг идэвхтэй сурталчилдаг холбоо, сан, нийгэмлэг, төв нэртэй иргэний байгууллагын нэрээр халхавчлан Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон. Дээрхи шалтгааны улмаас Монгол дах Мүүнийн дагалдагчдын тоог нарийвчлан гаргах боломжгүй. Энэ талаар нийслэл, орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн дэргэдэх шашны асуудал эрхэлсэн ажилтнуудтай хамтран цаашид судалгаа хийх шаардлагатай.

Нийслэлийн статистикийн газраас гаргасан сүм хийд шашны байгууллагын 2014, 2015 оны албан ёсны тайланд Мүүнийн шашны 2 сүм бүртгэлтэй байгаа ч Дэлхийн энх тайвны төлөө залуучуудын холбоо, Дэлхийн энх тайвны төлөө Монголын эмэгтэйчүүдийн холбоо, “Оюуны эрэл” оюутны холбоо, Дэлхийн энх тайвны төлөө олон улсын шашин хоорондын Монголын холбоо гэсэн арав гаруй хүмүүнлэгийн, төрийн бус байгууллагаар халхавчлан үйл ажиллагаа явуулж байна.

Мүүнийн гаж урсгалын Монголд явуулж буй дээрхи үйл ажиллагаанууд нь Монгол улсын Төр, Сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4-р зүйлийн 7-р заалтыг зөрчиж байгаа эсэхийг холбогдох эрх мэдэл бүхий хүмүүс нь тодруулах шаардлагатай.

¹⁰⁵ [https://en.wikipedia.org/wiki/Governmental_lists_of_cults_and_sects]

¹⁰⁶ [https://en.wikipedia.org/wiki/Governmental_lists_of_cults_and_sects#Canada]

Монголд үйл ажиллагаа явуулж буй Мүүнийн шашны байгууллагын талаар судалгаа хийхэд тэдний хаяг байршил, үйл ажиллагаа нь тодорхой бус, олон нийтэд нээлттэй бус, зөвхөн өөрсдийн гишүүд болон зорилтот бүлэгт хандсан үйл ажиллагаа явуулдаг, соёл, боловсрол, спортын баяр ёслолын арга хэмжээ нэрээр халхавчлан үйл ажиллагаагаа зохион байгуулах ба зарим тохиолдолд мэдээлэл өгөхөөс татгалздаг, шашин судлаачдад нээлттэй бус ханддаг, мэдээлэл олж авсан хувь хүн, судлаачийг дарамтлах зэрэг бэрхшээлтэй тулгардаг.

Дүгнэлт, шийдвэрлэх асуудал:

Мүүний үүсгэсэн энэ олон үйл ажиллагааг хүн төрөлхтөн зогсоож чадахгүй ч улс орон, үндэстэн, ард түмэн бүхэн өөр өөрийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг үзэл суртлын хүрээнд хадгалж хамгаалж байх үүднээс эх орондоо явагдаж буй Мүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, ялангуяа хүүхэд залуучуудынхаа боловсрол хүмүүжилд үндэсний уламжлалаа хадгалах, үндэсний бодлого зарчмаа алдахгүй байх тал дээр анхаарч ажиллах нь чухал гэж үзэж байна.

Даяаршсан эрин зуунд амьдарч буй Монголчуудын оюун санаа, итгэл үнэмшлийн ертөнцөд шашны этгээд гаж урсгалууд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж судлаачдын хувьд дараах шийдэл, арга замыг дэвшүүлж байна.

- Төрөөс шашны байгууллага, сүм хийдийн талаар судалгаа хийж, нэгдсэн цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлж байдаг төрийн тусгай институт, байгууллага байгуулах нийгмийн зайлшгүй шаардлага тулгараад байна.
- Нийслэл, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шашны асуудал эрхэлж буй ажилтны орон тоонд шашин судлалын мэргэжлийн хүнийг ажиллуулах нь зүйтэй.
- Төрийн эрх мэдэл бүхий байгууллагууд шашны байгууллагуудтай үндэсний аюулгүй байдал, монгол соёл иргэншилд хүндэтгэлтэй хандах, нийгмийн эв нэгдлийг хангаж, төр сүм хийдийн харилцааны хуулийн заалтуудыг нарийн сахиж биелүүлэх тусгай гэрээ байгуулах шаардлагатай болжээ.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх шашны зөвлөлд улстөрийн нөлөө бүхий гаж урсгалынхныг шургалуулахгүйн тулд МУИС-ын Философи, Шашин Судлалын Тэнхимийн болон бусад эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн дүгнэлтийг үндэслэн төлөөллийг зөв бүрдүүлж байх нь Монгол Улсын нийгмийн эрүүл сэтгэлгээ, амар тайван аж төрөхийн чухал үндэс болно гэж үзэж байна.
- Нийслэл хот, аймаг, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчид шашны гаж урсгал, чиглэлийг бүртгэхдээ шашны номлол сургааль явуулах ном, судрыг судалж үзээд бүртгэх эсэх талаар судлаачидтай зөвлөлдөж шийдвэр гаргах хэрэгтэй.
- Гадаадын иргэн харъяатын газар гаднаас ирж буй шашны номлогчдын байгууллага нь тухайн улсдаа албан ёсны бүртгэлтэй эсэхийг шалгаж бүртгэх нь зүйтэй.
- Монголд үйл ажиллагаа явуулж буй шашны гаж урсгалын шугамаар ирж буй номлогчдыг бүртгэхдээ урьсан байгууллага нь Монгол Улсад албан ёсоор бүртгэлтэй эсэхийг нягталж шалгах хэрэгтэй.

- Төр сүм хийдийн хуулинд шашны гаж урсгалаас сэргийлэх заалтыг нэмж оруулах нь Монгол шиг хүн амын нягтаршил багатай улсад тохиромжтой зохицуулга хэмээн үзэж байна.
- Монгол улсын хот, аймаг, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн эрх бүхий ажилтнууд Монголд үйл ажиллагаа явуулж буй шашны гол байгууллагуудтай хамтран ажиллаж тухайн шашны нэрийг барин гарч ирсэн гаж урсгалуудын судалгааг гарган тэдэнтэй харьцах бодлого боловсруулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Хоёр. “Мүүн”-ний талаарх гадаадын улс орнуудын хандлага

Фрейзерийн институтээс¹⁰⁷ гаргасан тайланд (1978 он, 313-р тал) Мүүний байгууллагыг **“үндэстэн дамнасан корпорац”** хэмээн дараах байдлаар томъёолсон байна. Тухайлбал, *“Үйл ажиллагааны чиглэл болон байгууллагын бүтцийн хувьд тус байгууллага нь үйлдвэрлэл, олон улсын худалдаа, батлан хамгаалах салбарын ажил гүйцэтгэгч, санхүү болон бусад бизнесийн үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнасан корпорацыг санагдуулж байна. Ингэхдээ дээрхээс гадна шашин, боловсрол, соёл, үзэл суртал болон улс төрийн хэв шинжийг агуулдаг. Харин сургалт, доод шатны гишүүдийг ашиглаж байгаа хэлбэрээрээ хагас цэрэгжсэн байгууллага, бусад талаараа олон улсын улс төрийн намын шинжтэй байна.”*

Дэлхийн улс орнуудын шашны байгууллагуудыг хориглосон байдал:¹⁰⁸

1990 оны байдлаар дэлхийн 34 орон шашны байгууллага, зарим тохиолдолд шашны урсгалыг хязгаарласан байсан. 2008 онд Барбадос, Гана, Ирак болон Малави зэрэг 4 улс уг хязгаарлалтыг цуцалж, 16 орон шинээр хязгаарлалт тогтоож одоогийн байдлаар нийт 46 орон шашны байгууллага болон шашныг хязгаарлаж, хориглосон байна.

Ихэнх тохиолдолд хязгаарлалт нь “гаж урсгал” гэгдэх Эв нэгдлийн сүм /Мүүн/, Саентологи болон Еховагийн гэрчүүд зэрэгт хамаардаг байна. Нөгөөтэйгүүр шашинт орнууд болох Саудын Араб, Мальдив зэрэг нь цөөнхийн шашинг хориглосон байна.

Эв нэгдлийн сүмийн үйл ажиллагааг хориглосон зарим орнууд:

Венесуэл (1997 он), Польш, Сингапур¹⁰⁹ (1982 он), ОХУ, Кыргыз¹¹⁰ – 2012 онд Үндэсний аюулгүй байдлын хорооны саналыг үндэслэн шүүхийн шийдвэрээр “Эв нэгдлийн сүм”-ийн үйл ажиллагааг өөрийн нутаг дэвсгэрт явуулахыг хориглосон. Мөн Хятад, Орос, Латви, Беларусь, Киргиз болон Шенгений зарим оронд хориглосон байдаг байна¹¹¹. Тухайлбал,

¹⁰⁷ <https://books.google.mn/books?id=G7JaBwAAQBAJ&lpg=PA57&ots=ArqI0O9iuB&dq=unificatio%20chirch%20ban%20countries&p-g=PA55#v=onepage&q=unification%20chirch%20b%20countries&f=false>
Regulating Religion, Case Studies from Around the Globe, Editors: **Richardson**, James T. (Ed.) 2004.

¹⁰⁸ Political Secularism, Religion, and the State A Time Series Analysis of Worldwide Data Part of Cambridge Studies in Social Theory, Religion and Politics Author: Jonathan Fox, April 2015
<https://books.google.mn/books?id=HFf3BwAAQBAJ&lpg=PA147&ots=K4s4P8wA0T&dq=how%20many%20countries%20ban%20unification%20church&pg=PA147#v=onepage&q=how%20many%20countries%20ban%20unification%20church&f=false>

¹⁰⁹ <http://www.refworld.org/topic/50ffbc57a2,50ffbc696,562105516,0,,,html>

¹¹⁰ <http://www.tparents.org/library/unification/talks/lee/Lee-120317.pdf>

¹¹¹ <http://www.ikon.mn/n/4m7>

Герман Улс:

ХБНГУ-ын Дотоод хэргийн яамнаас 1995 онд Мүүний хөдөлгөөнийг үндэслэгч Сан Мён Мүүнийг эхнэрийнх нь хамтаар 12 жилийн турш (1995-2007) Герман улсын хилээр нэвтрэн орохыг хориглосон бөгөөд энэхүү үндэслэлээ “Эв нэгдлийн гэх Мүүний хөдөлгөөн нь шашны сект буюу сэтгэцийн гаж урсгалд хамаарах бөгөөд тэдний идэвхтэй үйл ажиллагаа герман залуучуудыг аюулд учруулж болзошгүй”¹¹² гэж үзжээ.

Сан Мён Мүүнийг Германд нэвтрэн орохыг хориглосоноос 2 жилийн хойно ХБНГУ-ын Засгийн газраас ард иргэддээ зориулж “Мүүний хөдөлгөөн” нэртэй товхимол¹¹³ -ыг хэвлүүлэн үнэ төлбөргүйгээр тараасан байна. Харин Мүүнийхэн Германы Засгийн газрыг “цөөнхийн шашин шүтэх эрхийг боогдуулсан” гэж үзэн шүүхэд өгсөн бөгөөд хоёр удаагийн шүүх ажиллагаанаас¹¹⁴ Герман Улс ялсан төдийгүй энэхүү номоо цахим хэлбэрт оруулжээ.

Франц Улс:

Анх 1968 оны 11 сарын 12нд “Шинэ үеийг үндэслэгчид” /les Pionniers du Nouvel Age/ нэртэйгээр Францад байгуулагдсан. Үүний дараа хэд хэдэн удаа нэрээ өөрчилсөн. 1978 оны 1 сарын 16нд “Нэг дэлхийн төлөөх олон улсын бүлгэм” нэртэй холбоо байгуулсан.

1977 онд Chvteau de Mauny - (сүмийн байр) -ийг Мүүний дагагчид 2.2 сая франкаар худалдаж авсан бөгөөд энэ сүмдээ ихэвчлэн залууст зориулсан шашны чиглэлтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

1975-76 онуудад жирийн иргэд энэ хуурамч шашны байгууллагын талаар мэдээлэлтэй болж үүний эсрэг арга хэмжээ явагдаж эхэлсэн. Ялангуяа 1974 оны 10 сард эмч Guy Champollion -ны охин Yvas алга болсны дараа нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд энэ үзэл суртлыг эсрэг анхааруулга улам хүчтэй болсон. Тэдний охин Rennes дах гэрээсээ холбоо тасраад 5 хоногийн дараа Lyon хотоос эцэг эхтэйгээ холбоо барьсан боловч байгаа газар хаягаа өгөөгүй байна. Гэвч эцэг нь бусад хүүхдийнхээ хамтаар Lyon хотод очиж байгаа газрыг нь олж, өөр олон залуу хүүхдүүдийг Мүүний шашны байгууллагад орсон байхыг мэдсэн байна. Энэ үйл явдалтай холбогдуулан эмч Guy Champollion “Гэр бүл болон хувь хүнийг хамгаалах байгууллага”-аа /l'Association pour la Dïfense des valeurs Familiales et de l'Individu (ADFI)/ нээжээ¹¹⁵. Өнөөдөр Франц дахь Мүүний үйл ажиллагаа буурсан ба гишүүдын тоо нарийн тодорхойгүй ч 2012 оны байдлаар ердөө л 300 гаран гэж үздэг. /Хүн ам нь 66 сая/.

¹¹² Grönder der Mun-Sekte darf einreisen. Focus vom 4. Mai 2007.

¹¹³ Die Mun-Bewegung: Eine Broschüre der Bundesregierung von 1997

¹¹⁴ www.agpf.de/Mun-Bewegung

¹¹⁵ http://www.wiki-rennes.fr/Claire_et_Guy_Champollion

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- С.Цэдэндамба. Монгол улс дахь шашины нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе), 2003. УБ
- А.Жамбал. Ислам шашин, ШУА, ФСЭХ, 2005, УБ
- М. Нандинбилэг. “Эв нэгдлийн сүмийн номлол сургаал, зан үйл: гэрлэлт, гэр бүлийн тухай асуудалд” дипломны ажил. МУИС. УБ. 2013
- Монголын Эвангелийн Эвсэл. “Гаж буруу урсгалууд” танилцуулга, 2013, УБ,
- Hexhan, Irvin & Karla Poewe. Understanding Cults and New Religions. Grand Rapids, Michigan. 1986.
- Ankerberg, John and John Weldon, Encyclopedia of Cults and New Religions. Harvest House Publishing, Oregon. 1999.
- New Oxford Dictionary. Oxford University Press. NY,USA, 2005.
- Martin, Walter R. The Kingdom of the Cults. Bethany Fellowship Inc., Publishers, Minneapolis, Minnesota.
- Nichols, Larry A. and others, Encyclopedic Dictionary of Cults, Sects, and World Religions. Zondervan, Grand Rapids, Michigan.
- New Dictionary of Theology, Sincliar B. Ferguson and David F. Wright, Inter-Varsity Press, Leicester, England. 1988.
- <http://religionmongolia.wordpress.com>
- http://en.wikipedia.org/wiki/Anti-cult_movement
- <http://www.ikon.mn/n/ofx>
- https://en.wikipedia.org/wiki/Governmental_lists_of_cults_and_sects#Canada
- <http://www.tparents.org/moon-talks/sunmyungmoon97/SM971129p.htm>
- <http://www.upf.org/resources/speeches-and-articles/4968-p-ochirbat-address-to-world-summit-2013>

3

БҮЛЭГ

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

**ОЛОН НИЙТЭД ТӨРИЙН БОДЛОГО ШИЙДВЭРИЙГ ХҮРГЭХЭД
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦООНЫ ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Ө.Мөнхтунгалаг, Б.Нандингэрэл
Т.Саулегул, И.Жаргалзаяабямба*

Судалгаанд гадаадын 6 орны /БНТУ, Казахстан, ОХУ, Финлянд, ИБУИНВУ, Хорват/ хууль эрх зүйн актуудын хүрээнд олон нийтэд төрийн бодлого шийдвэрийг хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, оролцооны эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг бэлтгэлээ.

Судалгаанаас үзэхэд төрийн бодлого, шийдвэрийн талаар олон нийтэд мэдээлэх үндсэн аргууд нь:

- Гаргасан шийдвэрийнхээ талаар олон нийтэд мэдээлэх;
- Төрийн байгууллагын хуралдааны талаарх мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх;
- Хүсэлтийг үндэслэн баримт, материал олгох;
- Хуулиар хориглоогүй бусад арга хэрэгсэл зэрэг болно.

Судалгаанд хамрагдсан орнууд нь төрийн бодлого шийдвэрийг олон нийтэд хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, оролцоог Үндсэн хууль болон Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай, Мэдээллээр хангах тухай хуулиараа зохицуулж байна.

Мөн дээрх үүргийг Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газар түүний Хэвлэл мэдээллийн албад хариуцан гүйцэтгэдэг бөгөөд хэвлэл мэдээллийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах үйл ажиллагааг дотоод дүрэм журмаараа зохицуулдаг.

Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газар түүний Хэвлэл мэдээллийн албаны олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь дор дурдсан нийтлэг чиглэлтэй байна.

- Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа;
- Олон нийттэй харилцах үйл ажиллагаа;
- Радио, телевиз /broadcasting/

Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд:

- Олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааг тогтмол мэдээлэх замаар үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Гадаад, дотоодод зохион байгуулагдсан арга хэмжээний талаар мэдээлэх;
- Дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Парламент нь өөрийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх хамгийн хялбар, түгээмэл хүртээмжтэй хэлбэр нь телевиз, радио бөгөөд дэлхийн парламентын ажлын албаны бүтцээс харахад дэргэдээ Телевиз, радиотой эсвэл тухайн парламентын тамгын газар нь телевиз, радиотой гэрээгээр

хамтран ажилладаг орнууд ч байдаг.¹¹⁶

Парламентаас баталсан хууль эрх зүйн баримт бичгийг “Хууль албан ёсоор хэвлэн нийтлэх дүрэм, журам”-ын дагуу төрийн төв хэвлэлд нийтлэх ба хуулийн нэгдсэн портал сайтад байршуулж олон нийтэд хүргэдэг.

Ихэнх улс орнууд иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдолтой хуулиар хязгаарласнаас бусад төрийн бодлого, шийдвэр болон бусад мэдээллийн талаар иргэд чөлөөтэй олж авах боломжийг хангах үүрэгтэй байдаг байна.

Бүгд Найрамдах Турк Улс

Турк улсад төрийн бодлого шийдвэрийг ард нийтэд хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцооны талаар хуульчлан зохицуулсны зэрэгцээ Турк Улсын Их Хурлын дэргэдэх Хэвлэн нийтлэх болон Олон нийттэй харилцах хэлтэс, Засгийн газрын дэргэдэх Хэвлэлийн асуудал хариуцсан алба, мөн түүнчлэн Засгийн газрын Хэвлэл мэдээллийн Ерөнхий газар нь энэхүү үүргийг гүйцэтгэхээр тогтоосон байдаг.

Турк Улсын Их Хурлын Тамгын газрын тухай хуулийн 15-р зүйлд: Хэвлэн нийтлэх болон олон нийттэй харилцах хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан. Үүнд:

а/ Турк Улсын Их Хурлын хэвлэн нийтлэхтэй холбоотой бүхий л асуудлыг зохион байгуулах, сурталчлах болон нийтэд хүртээл болгох ажлыг хэрэгжүүлэх,

б/ Турк Улсын Их Хуралтай холбогдолтой асуудлын хүрээнд тодорхой үйл ажиллагаа зохион байгуулах, энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг хийж олон нийтийг мэдээллээр хангах¹¹⁷

Турк Улсын Радио, Телевизийн тухай хуулийн 5-р зүйлд: “Олон нийтийн санаа бодлыг эерэг, зөв, чөлөөтэй төлөвшүүлэх үүднээс нийтэд хамааралтай асуудал тухай бүрт иргэдийг хэрэгцээтэй мэдээллээр хангах, нэг талыг барьсан, аль нэг талыг дэмжсэн мэдээлэл хийхгүй байх ба аль нэг улс төрийн нам, эвслийн эсвэл бүлгийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, үзэл бодолд нь нийцсэн мэдээллээр хангах хэрэгсэл болохгүй байх” гэж хуульчилсан.¹¹⁸

Хэвлэлийн тухай хуулийн үндэслэл хэсэгт: Радио, телевизийн нэвтрүүлгийг дотоод болон гадаадад нэвтрүүлэх эрх нь зөвхөн Төрийн мэдэлд байна. Төр энэхүү эрхээ улсын Радио, Телевизийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ, *Мөн хуулийн 3-р зүйлд:*

“Төрийн бодлогыг сурталчлан таниулах болон энэ хүрээнд төрөөс баримтлах бодлогын стратегийг тодорхойлоход туслах” гэж хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүргийг тодорхойлсон.¹¹⁹

Турк Улсын Засгийн газрын Хэвлэн нийтлэх болон мэдээллийн Ерөнхий газар нь 1984 оноос Засгийн газрын мэдэлд үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллага юм.

¹¹⁶ “Дэлхийн улс орнуудын Парламентын алба”, УБ., 2012 он

¹¹⁷ <https://www.tbmm.gov.tr/kanunlar/k6253.html>

¹¹⁸ <https://www.tbmm.gov.tr/kanunlar/>

¹¹⁹ <https://www.tbmm.gov.tr/kanunlar/>

Энэхүү байгууллага нь төрийн бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулдаг.

- Олон нийт болон холбогдох байгууллагуудыг бодит, үнэн зөв мэдээллээр хангах тохиромжтой арга хэрэгслийг ашиглан мэдээллийг шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн бодлого, үйл ажиллагааг дотоод болон гадаад орчинд эерэгээр нөлөөлөхүйц байдлаар түгээх, эдгээр бодлого, шийдвэрийг нийгэмд хүлээн зөвшөөрүүлэн хэрэгжүүлэх, тодорхой үр дүнд хүрэх чиглэлээр ажил зохион байгуулах.¹²⁰

Засгийн Газрын дэргэдэх Хэвлэл мэдээллийн алба

Ерөнхий сайд, Шадар сайд болон яамны сайдууд, бусад холбогдох албан тушаалтнуудын олон нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн мэдээ мэдээлэл, тайлан, сонсгол болон шийдвэрүүдийг дотоодын болон гадаадын хэвлэл, мэдээллийн агентлаг, радио, телевизийн байгууллагуудад хугацаанд нь хүргүүлэх үүргийг хэрэгжүүлдэг.¹²¹

Турк улс нь төрийн бодлого, шийдвэрийг улсынхаа олон нийтэд үнэн бодитоор, түргэн шуурхай хүргэхийг эрмэлздэгээс гадна дэлхийн бусад улс орнууд тус улсын төрийн бодлогын талаар эерэг хандлагатай байх, тухайн бодлого, шийдвэр нь дэлхий дахинд ч дэмжлэг авах, улс хоорондын хамтын ажиллагаанд эерэгээр нөлөөлөх явдалд маш их ач холбогдол өгдөг байна.

Турк Улсын Засгийн газрын Хэвлэл мэдээллийн Ерөнхий газар нь улсын хэмжээнд болон дэлхий дахинд улс орноо сурталчлах, Улсын Их Хурал болоод Засгийн газраас баримталж буй бодлого, батлан гаргасан шийдвэрийг цаг тухайд нь хүргэх ажлыг хариуцан ажилладаг байгууллага юм.

Энэхүү байгууллага нь анх 1862 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн хэвлэл мэдээллээр Турк улстай холбоотой гарсан мэдээ мэдээллийг цаг тухайд нь гадаадын 40 хэлнээс эх хэл рүүгээ орчуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэдэг.

Мөн төрийн бодлого, шийдвэрийг дотоод болон гадаадад хэрхэн хүлээж авч байгаа талаар судалж, энэ талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлж тухайн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх эсвэл шүүмжлэлтэй хандсан тохиолдолд дахин боловсруулах, хянан хэлэлцэх тогтолцоог бүрдүүлсэн байна.

Турк Улсын Засгийн газар нь хэвлэлийн эрх чөлөөг бодлого, шийдвэрээ олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргээд зогсохгүй эргээд энэ шийдвэрийн талаарх олон нийтийн хандлага ямар байна, нийгмийн хүлээлт юу байсан бэ гэдгийг судлах нь тухайн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд эерэгээр нөлөөлөх үзүүлэлт болдог байна.

Казахстан улс

Казахстан улс нь төрийн бодлого, шийдвэр, төрийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг Үндсэн хууль болон Мэдээллээр хангах тухай

¹²⁰ <http://www.byegm.gov.tr/turkce/byegm-hakkinda>

¹²¹ <https://www.basbakanlik.gov.tr>

хуулиараа зохицуулсны зэрэгцээ тухайн асуудал бүрт нийтэд мэдээлэх талаар тусгайлсан хууль гаргадаг онцлогтой. Мөн түүнчлэн тус улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хэвлэл мэдээллийн алба болон Ерөнхий сайдын Хэвлэл мэдээллийн алба нь тус үүргийг гүйцэтгэдэг.

Казахстан улсын Үндсэн хуулийн 20-р зүйлд:

1. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг хуулиар хамгаална.
2. Хүн бүр хуулиар хориглоогүй аливаа арга хэрэгслээр мэдээлэл олж авах болон түгээх эрхтэй. Казахстан улсын төрийн нууцад хамаарах асуудлыг хуулиар тогтооно.

Үндсэн хуулийн 62-р зүйлд: Казахстан улсын хууль болон бусад эрх зүйн актын төслийг бэлтгэх, өргөн барих, хэлэлцэх, батлах болон мэдээлэх горим нь тусгайлсан хууль болон парламент, түүний танхимуудын журмаар зохицуулагдана.¹²²

Тус улсын *Мэдээллээр хангах тухай хуулийн* холбогдох зүйлүүдэд төрийн бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх талаар хуульчлан зохицуулсан. Энэхүү хуульд төрийн бодлого гэхээсээ илүү төрийн үйл ажиллагаа, төрөөс үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэхийг түлхүү тусгасан байдаг.

Мөн хуулийн 3 дугаар зүйлд: Мэдээллийн салбар дахь нийгмийн харилцааг төрөөс зохицуулах зорилго, зарчим *2 дахь хэсэг:* Мэдээллийн салбар дахь нийгмийн харилцааг төр дараах зарчимд тулгуурлан зохицуулна.Үүнд:

- 1.Хуульд нийцсэн байх
- 2.Хувь хүний эрх, эрх чөлөө болон хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, хуулийн этгээдийн эрх болон хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг нь хамгаалах,
- 3.Аливаа хувь хүн болон хуулийн этгээдийн мэдээллийн салбар дахь оролцоо, түүний үр дүнг хүртэх эрх нь тэгш байх,
- 4.Казахстан улсын хуулиар хязгаарласан электрон мэдээллийн сангаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой электрон мэдээллийн санд чөлөөтэй нэвтрэх, эдгээр мэдээллүүдээр зайлшгүй хангагдах үйл ажиллагааг зохион байгуулах,
- 5.Казахстан улсын хуулиар нийтэд мэдээлэхээр заасан эсвэл төрийн байгууллагуудаар дамжуулан нийтэд хүргүүлэхээр үүрэг болгосон электрон мэдээллүүд нь хугацаандаа, бодитой, бүрэн дүүрэн, тодорхой байгаа эсэхэд хяналт тавих,
- 6.Казахстан улсын хуулиар мэдээлэл олж авахыг хязгаарлаагүй аливаа электрон мэдээллийг хайх, үүсгэх болон түгээх эрхээр хангах,
- 7.Мэдээлэл-харилцаа холбооны технологийг ашиглах явц дахь хувь хүн, нийгмийн болон төрийн аюулгүй байдлыг хангах,
- 8.Мэдээлэл-харилцаа холбооны технологийн салбарыг хөгжүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- 9.“Электрон засаглал”-ын мэдээллийн төвүүдийг төвлөрүүлэн нэгдсэн удирдлагаар хангах,
- 10.Казахстан улсын хэмжээн дэхь мэдээллийн төвүүдийн мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал болон нэгдсэн удирдлагыг хангах

¹²² adilet.zan.kz

стандарт тогтоон олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зарчимд тулгуурлана.

Мөн хуулийн 5-р зүйл: Мэдээллийн салбар дахь төрийн удирдлагын үүрэг

1. Мэдээллийн салбарыг тогтворжуулах, хөгжүүлэх

2. Төрийн байгууллагуудын захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх боломжоор хангах,

Мөн хуулийн 6-р зүйл: Казахстан улсын Засгийн газрын мэдээллийн салбар дахь үүрэг

1. Мэдээллийн салбар дахь төрийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Мөн хуулийн 21-р зүйл: “Электрон засаглал”-ын үйл ажиллагааны зорилго:

1. Иргэд, хуулийн этгээд төрийн үйлчилгээг электрон хэлбэрээр чанартай, шуурхай хүртэх боломжийг бүрдүүлэх, хувь хүн болон хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондын харилцааг бэхжүүлэх,
2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэмэгдүүлэх, сурталчлах, олон нийтээс төрийн бодлого, шийдвэртэй холбогдолтой мэдээлэл олжавах бүхий л нөхцөл бололцоог бүрдүүлэх, бүх шатны төрийн байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд нийгмийн хяналтыг бүрдүүлэх, иргэдийн оролцоог хангах
3. Төрийн удирдлага дахь захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх
4. Мэдээлэл-харилцаа холбооны шийдлийг ашиглаж төрийн байгууллагуудын шийдвэрийг оновчтой гаргахад тусалцаа үзүүлэх.

“Электрон засаглал”-ын үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын үйлчилгээний талаар олон нийтийг тэгш, хүртээмжтэй мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажилладаг.

Казахстан Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэвлэл мэдээллийн алба

Тус улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэвлэл мэдээллийн алба нь Ерөнхийлөгчийн тамгын газрын бүтцэд ордог.

Хэвлэл мэдээллийн албаны үүрэг: Ерөнхийлөгчийн үйл ажиллагаа болон түүний оролцоотойгоор зохион байгуулагдаж буй арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэх, нийтэд түгээх, Ерөнхийлөгчийн www.akorda.kz албан ёсны веб хуудсанд мэдээлэл байршуулах, хэвлэл, аудио болон фото мэдээллийн эх үүсвэрийг бэлтгэх, телевизийн нэвтрүүлэгт оролцох ажлыг зохион байгуулах, хэвлэлийн хурал, ярилцлага зохион байгуулах, айлчлалын талаар мэдээлэл бэлтгэх зэрэг болно.¹²³

Ерөнхий сайдын Хэвлэл мэдээллийн алба нь Ерөнхий сайд болон Засгийн газрын түвшний бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд дараах үүргийг хүлээсэн. Үүнд :

1. Ерөнхий сайдыг үндэсний болон гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбох,

¹²³ http://www.akorda.kz/kz/about_press_office

2. Ерөнхий сайд болон Засгийн Газрын түвшний бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг төрийн албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх ажиллагааг шуурхай зохион байгуулах,
3. Төрийн албан ёсны веб хуудсыг байнгын ажиллагаатай байлгах ажлыг зохион байгуулж, тус сайтаар олон нийтэд мэдээлэх мэдээ мэдээллийн фото зураг болон эх бичвэрийг бэлтгэх, нийтэд түгээх
4. Төрийн бодлого, шийдвэрийн талаар үндэсний болон гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн хүртээл болсон мэдээ мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх зэрэг болно.¹²⁴

Казахстан улс нь төрийн бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэрэгслийг хүртээмжтэй болгох асуудлыг салбарын хууль тогтоомжоор зохицуулдаг ба улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын хэвлэл мэдээллийн алба нь олон нийтийг мэдээллээр хангах ажилд түлхүү анхааран ажилладаг байна.

Төрийн байгууллагуудын цахим хуудсыг Казах, Орос хоёр хэл дээр нэгэн адил бэлтгэх талаар хуульчилсан нь иргэдийн мэдээллээр хангагдах эрхийг улам нээлттэй болгосон зохицуулалт юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль

2-р зүйл: Мэдээлэл авах болон түгээх эрх

2.2.Төрийн болон олон нийтийн байгууллага, төрийн эрх бүхий албан тушаалтнууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь иргэн бүрийг түүний хууль ёсны эрх, ашиг сонирхолтой нь холбоотой аливаа баримт бичиг, шийдвэртэй танилцах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл авах боломжийг олгох үүрэгтэй.

4-р зүйл: Эрх бүхий байгууллагын үүрэг

- Хэвлэл мэдээллийн салбарт төрийн байгууллагын бодлогыг төлөвшүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Казахстан улсын хуульд заасан журмын дагуу үндэсний түвшинд төрийн хэвлэл мэдээллийн бодлогыг хэрэгжүүлэх талаарх төрөөс даалгасан үүргийг гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавина.

5- зүйл: Нутгийн удирдлагын эрх бүхий байгууллагуудын үүрэг

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төрийн хэвлэл мэдээллийн талаарх баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх,

Хуульд заасан журмын дагуу орон нутгийн түвшинд төрийн хэвлэл мэдээллийн салбарт баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэх, түүний хэрэгжилтийг хянах

Мөн хуулийн хуулийн 2-р зүйлд: Төрийн болон олон нийтийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь иргэн бүрийг түүний эрх, ашиг сонирхолтой холбогдолтой баримт мэдээлэл, шийдвэртэй танилцах боломжоор хангах үүрэгтэй гэж хуульчилсан.

¹²⁴ <http://ukimef.kz/kz/kpm/obshchaya-informatsiya-po-otdelam-kpm.html>

Мөн хуулийн 3-р зүйл: Эрх бүхий байгууллагын үүрэг

- Хэвлэл мэдээллийн салбарт төрийн бодлогыг төлөвшүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,
- Хуульд заасны дагуу үндэсний хэмжээнд хэвлэл мэдээллийн салбарт баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэх, гүйцэтгэлд нь хяналт тавих гэж хуульчлан зохицуулсан байна.

Казахстан улс нь эдгээр хууль тогтоомжийн хүрээнд төрийн бодлого, шийдвэрийг олон нийтэд цаг тухайд нь, шуурхай, бодитоор хүргэх үүргийг төрийн эрх бүхий байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үүрэг болгон, биелэлтэнд нь төрийн зүгээс тавих хяналтыг хуульчлан зохицуулсан.

Хуулиар хязгаарласнаас бусад төрлийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдолтой төрөөс батлагдан гарсан бүхий л төрлийн шийдвэрийн талаарх мэдээллийг иргэд чөлөөтэй олж авах эрхтэй ба төрийн бүх шатны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог өөрөөр хэлбэл олон нийтийн хүсэл зоригийг тусгахыг анхаарах талаар хуульчлагдсан нь иргэд төрөөс батлагдан гарсан бодлого, шийдвэрийг зөвхөн сонсох, мэдэх бус төрөөс батлагдан гарах бодлого шийдвэрт өөрсдийн хүсэл зоригоо төлөөллөөрөө дамжуулан хүргэх, улмаар хүсэл зоригт нь нийцсэн бодлого, шийдвэр гарсанаар төрд итгэх итгэл нь нэмэгдэх, тус бодлого шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтэнд нь өөрсдөө хүртэл хяналт тавих тогтолцоо бүрдэх давуу талтай юм.

Оросын Холбооны Улс

Судалгааны сэдвийн хүрээнд “Холбооны үндсэн хуульжсан хууль, холбооны хууль, Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актууд хүчин төгөлдөр болох, хэвлэн нийтлэх журмын тухай”, “Холбооны Улсын Засгийн газар болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломжийг хангах тухай”, “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай”, “Холбооны Улсын Шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломж хангах тухай” хуулиуд, *ОХУ-ын Төрийн Думын Тамгын газрын дүрэм зэрэг эрх зүйн баримт бичгүүдээс* судалгааны мэдээлэл бэлтгэв.

Төрийн бодлого шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэх, албан ёсоор хэвлэн нийтлэх, портал сайтад байршуулах харилцааг зохицуулсан дараах хуулиудын зохицуулалтыг тоймлон авч үзвэл:

“Холбооны үндсэн хуульжсан хууль, холбооны хууль, Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актууд хүчин төгөлдөр болох, хэвлэн нийтлэх журмын тухай”¹²⁵ хуулиар холбооны хуулийг Ерөнхийлөгч гарын үсэг зурснаас хойш 7 хоногийн дотор албан ёсоор хэвлэн нийтлэх, Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актууд батлагдсанаас хойш 10 хоногийн дотор хэвлэн нийтлэхээр хуульчилсан байна. Хууль болон Холбооны Хурлын танхимуудын эрх зүйн актуудыг албан ёсоор “Парламентын сонин”, “Оросын сонин”, “Оросын Холбооны Улсын хуулийн эмхэтгэл”-д хэвлэн нийтлэх ба цахим хэлбэрээр “Эрх зүйн мэдээллийн албан ёсны интернет портал” (www.pravo.gov.ru) сайтад байршуулж олон нийтэд хүргэдэг.

¹²⁵ Судалгааны эмхэтгэл XXII, хуудас 187. Хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох талаарх эрх зүйн зохицуулалт Хүснэгт 1

“Холбооны улсын засгийн газар болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломжийг хангах тухай” хууль /Federal Law “On providing access to information on the activities of government bodies and bodies of local self-government”¹²⁶ -ийн 3 дугаар бүлгийн 12 дугаар зүйлд Засгийн газар, яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудаас батлан гаргасан хүчин төгөлдөр болж хэвлэн нийтлэгдсэн эрх зүйн баримт бичгүүдийн мэдээлэл

Засгийн газрын яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь батлан гаргасан хүчин төгөлдөр болж хэвлэн нийтлэгдсэн хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр “Хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх журам”-ын дагуу мэдээлэл өгөх чиг үүрэгтэй байна.

Мөн хуулийн 13 дугаар зүйлд: *Засгийн газар, яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх дараах мэдээллийг “Интернет”-д байршуулна. Үүнд:*

- Байгууллагын бүтэц, чиг үүрэг, эрх үүргийг тодорхойлох хууль тогтоомж, холбоо барих хаяг, байршил гэх мэт ерөнхий мэдээлэл;
- Гадаадын засгийн газрын байгууллагуудын төлөөллийн (хэрэв байгаа бол) жагсаалт, тэдгээрийн зорилт, чиг үүрэг, холбоо барих хаяг, байршил гэх мэт ерөнхий мэдээлэл, тухайн байгууллагын зөвшөөрлөөр бусад мэдээллийг байршуулна ;
- Тухайн байгууллагын харьяа байгууллагын жагсаалт (хэрэв байгаа бол), тэдгээрийн зорилт, чиг үүрэг, холбоо барих хаяг, байршил гэх мэт ерөнхий мэдээлэл;
- Тухайн байгууллагын олон нийтэд үйлчлэх чиг үүргийн хүрээн дэх мэдээллийн систем, мэдээллийн сангийн бүртгэлийн жагсаалт;
- Засгийн газрын яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудын (хэрэв байгаа бол) талаарх мэдээлэл;
- Хууль тогтоомжийн төсөл болон батлагдсан эх бичвэрүүдийг бүрэн эхээр нь;
- Засгийн газрын яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх талаарх захиалгыг холбогдох хуулийн хүрээнд мэдээлэл байршуулах;
- Төрийн захиргааны байгууллагын үйлчилгээний стандарт;
- Засгийн газрын байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байгууллага болон орон нутгийн эрх зүйн акт, гаргасан бусад шийдвэрт гомдол гаргах журам;
- Засгийн газрын байгууллагын зохион байгуулсан арга хэмжээний талаарх зорилт, хөтөлбөр, төслүүдийн мэдээлэл;
- ОХУ-ын олон улсын гэрээний албан ёсны эх бичвэр, тус гэрээнд тусгагдсан засгийн газрын байгууллагуудын оролцооны тухай мэдээлэл, олон улсын хамтын ажиллагаа болон албан ёсны айлчлалын талаарх мэдээлэл;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн засгийн газрын байгууллагуудын эрх, үүрэг, авах арга хэмжээний талаар;

¹²⁶ Federal Law “On providing access to information on the activities of government bodies and bodies of local self-government, <http://www.legislationline.org/documents/action/popup/id/17759>

- Засгийн газрын байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын үр дүнгийн талаарх мэдээлэл;
- Засгийн газрын байгууллага, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ, нийгэм эдийн засгийн динамик үзүүлэлтүүд;
- Засгийн газрын байгууллага, түүний харьяа байгууллагуудын төсвийн зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээ баримт;
- ОХУ-ын аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчдэд төлбөр тооцооны хөнгөлөлтийн тухай мэдээ баримт;
- Төрийн албаны сонгон шалгаруулалтын журам, үйл ажиллагаанд холбогдох мэдээлэл;
- Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэхтэй холбогдох журам,

Мөн хуулийн 14 дүгээр зүйлд: Засгийн газар, яам, агентлаг болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааны талаарх дараах мэдээллийн жагсаалт батлах

Холбооны Улсын Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийн жагсаалтыг ОХУ-ын Ерөнхийлөгч батална.

Яам, агентлагийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн жагсаалтыг Засгийн газар батална.

Бүх шатны шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Холбооны Улсын Шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломж хангах тухай “Federal Law “On providing of access to information on activity of courts in the Russian Federation” хуулиар тодорхойлно.

Мөн дээрх мэдээ, мэдээллийг интернетэд байршуулах давтамж, мэдээ мэдээллийг шинэчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай /Law of the Russian Federation “On Mass Media”/ хуулиар хэвлэлийн эрх чөлөө, түүний бүтэц, сэтгүүлчдийн зөвлөл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөөрөл гэх мэт өргөн агуулга бүхий харилцааг зохицуулдаг.

Тус хуулийн 3 дугаар зүйлд: “*Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд төрийн болон олон нийтийн байгууллага, бүлэглэл, бусад байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналтын алба зэргээс аливаа цензур нөхцөл тогтоох, хэвлэх материалыг дэлгэрүүлэх, аливаа хэсгийг хасах зэргийг хориглоно*” мөн “*Аливаа байгууллага, алба бусад байгууллагыг санхүүжүүлэхдээ олон нийтийн мэдээллийг цензурдэхыг хориглоно*” гэжээ. Энэ хуулийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг санхүүжүүлэгч болон бусад хэлбэрээр хамтран ажилладаг байгууллагад зориулсан зохицуулалт бөгөөд редакцийн эдийн засгийн хараат бус байдлыг баталгаажуулсан байна.

Мөн хуулийн “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүсгэн байгуулагч хэмээх” 2 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “*Үүсгэн байгуулагч нь энэ хууль, хяналтын албанаас гаргасан дүрэм, гэрээнд зааснаас бусад байдлаар мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно*” хэмээн зохицуулжээ.

Парламентаас олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх¹²⁷

ОХУ-ын Төрийн Думын Тамгын газрын Олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах газар /Управление по связям с общественностью и взаимодействию со СМИ/ нь Төрийн Дум болон депутатууд, Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хэвлэл мэдээлэлтэй харилцах үндсэн чиг үүрэгтэй. Тус газар нь дараах хэлтсүүдтэй. Үүнд:

- Шуурхай мэдээллийн,
- Парламентын сэтгүүлчдийн,
- Төвийн болон бүс нутгийн хэвлэлийн,
- Олон нийттэй харилцах,
- Мэдээллийн хяналт үнэлгээний,
- Телевизийн,
- Радиогийн,
- Мэдээллийн техник ашиглалтын хэлтэс байна.

Тус газар нь Төрийн Думын үйл ажиллагааг мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, цаг үеийн асуудлаар шуурхай мэдээлэл, хэвлэлийн тойм, мэдэгдэл бэлтгэж, төвийн болон бүс нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоотой ажиллах, парламентын удирдлага, депутатууд, ажилтнуудыг гадаад, дотоодын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх, хэвлэлийн бага хурал, брифинг хийлгэх ажлыг зохион байгуулах, Төрийн Думын удирдлага, депутатуудыг олон улсын болон ОХУ-д болж буй үйл явдлын талаар хэвлэлийн мэдээллээр хангах, парламентын сэтгүүлчдэд сурвалжлах эрх олгох, мэдээллээр хангах асуудлыг хариуцан зохион байгуулах, бүртгэл хөтлөх, хууль, дүрэм зөрчсөн сэтгүүлчдийн сурвалжлах эрхийг цуцлах, хууль бусад шийдвэрийн төсөлд олон нийтийн санал авах ажлыг зохион байгуулах, ОХУ-ын субъектуудын хууль тогтоох байгууллагууд, төрийн бусад байгууллагын хэвлэлийн албатай хамтран ажиллах, парламентын үйл ажиллагааны талаар гэрэл зураг, дүрс бичлэг хийж архивлах, оросын болон гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд гарсан парламентын асуудлаарх нийтлэлүүдэд дүн шинжилгээ хийх, “Думын тойм” /“Думское обозрение”/ сэтгүүлийн цахим хувилбарыг бэлтгэж сүлжээнд тавих, бүс нутгийн хэвлэлүүдэд зориулсан мэдээлэл-судалгааны “Думын хөрөг” /“Думская панорама”/ сэтгүүлийг бэлтгэн гаргах, “Парламентын сонин” /“Парламентская газета”/, “Өнөөдрийн ОХУ” /“Российская Федерация сегодня”/ сэтгүүлд парламентын асуудлаар материал бэлтгэж өгөх, сар тутмын “Дум хэвлэлийн толинд” /“Дума в зеркале прессы”/ товхимол, “Дум ба ТВ” /“Дума и ТВ”/ теле-нэвтрүүлэг, “Россия” сувгийн “Парламентын цаг” /“Парламентский час”/ нэвтрүүлгийг бэлтгэхэд оролцоно.

Финлянд улс

Финлянд нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний чансаагаараа дэлхийд дээгүүрт орж, олон нийтэд нээлттэй ил тод байлгах зарчмыг тууштай баримталдаг, цахим мэдээллийн сүлжээг бодлогоор дэмжиж ирсэн улс юм.¹²⁸ Тус улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд нь улсын болон хувийн

¹²⁷ УИХ-ын Тамгын газрын Судалгааны хэлтсээс эрхлэн гаргасан “Дэлхийн улс орнуудын Парламентын ажлын алба” хуудас 300-301, УБ., 2012 он.

¹²⁸ Европын сэтгүүл зүйн төвийн цахим хаяг, http://ejc.net/media_landscapes/finland

санхүүжилттэй үйл ажиллагаа явуулдаг. Улсын санхүүжилттэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн дунд илүү нэр хүндтэй байдаг бөгөөд үүний дотор телевиз, өдөр тутмын сонин сэтгүүл нь хамгийн хүчтэй нөлөө бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тооцогддог.

Тус улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн орчинг зохицуулсан 23 хууль үйлчилж байгаагаас Үндсэн хуулийн 2-р бүлэг, 12-р зүйл “Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах, мэдээлэл түгээх эрхтэй, тусгайлан хуулиар хязгаарлаагүй бол Төрийн албан ёсны бодлого шийдвэрийн талаарх баримт бичиг, бичлэг олон нийтийнх байна. Хүн бүр Төрийн албан ёсны бодлого шийдвэрийн талаарх баримт бичиг, бичлэгийг олж авах эрхтэй”¹²⁹ гэж заасан бол, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай хуульд үндсэн хуулийн дээрх суурь заалтыг дэлгэрүүлэн тусгасан байна, мөн Засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдлын тухай хуульд:

- *1-р бүлэг 1-р хэсэгт:* Албан ёсны бичиг баримт нь энэ хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол олон нийтэд нээлттэй байна,
- *2-р бүлгийн 6, 7, 8 -р хэсэгт:* Энэ хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн эрх бүхий байгууллагууд нь иргэдэд нээлттэй ил тод мэдээлэл өгөх зорилготой вэб хаягтай байх ёстой бөгөөд Үндэсний санал санаачилга, статистик, эдийн засгийн бодлого, төлөвлөгөө болон бусад ижил төстэй баримт бичгүүдийг аль болох богино хугацаанд байршуулж, олон нийтэд хүргэнэ,
- *2-р бүлэг 9-р хэсэгт:* Хүн бүр албан ёсны вэб сайтад байршуулсан баримт бичигт нэвтрэх эрхтэй¹³⁰ гэж тус тус заасан байдаг.

Эдгээр хуулиуд нь тус улсын төрийн бодлого шийдвэрийг олон нийтэд хүргэх, ил тод байдлыг хангах суурь нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

Төрийн байгууллагаас олон нийтэд мэдээлэл хүргэх¹³¹

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Парламентын Тамгын газар, Засгийн газрын 13 яам нь Төрийн албан ёсны бодлого, шийдвэр, мэдээллийг олон нийтэд хүргэх харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах албадтай ба хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах, мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг өөрийн дотоод журмаар зохицуулсан байдаг. Албан ёсны батлагдсан хууль, дүрэм, журмыг “Дүрэм журмын тухай” хуулийн 2-р бүлэг 7-р зүйлд заасны дагуу “The Statutes of Finland” сэтгүүлд нийтэлдэг¹³² бөгөөд энэхүү нийтлэл нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвлэн нийтлэх эх сурвалж болдог.

Тус улсын Гадаад хэргийн яамны Хэвлэл мэдээллийн алба нь Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, гадаадын сэтгүүлчдийг төрийн бодлого шийдвэрийн талаарх албан ёсны мэдээ материалаар хангах, гадаадын хэвлэл мэдээлэлд гарч байгаа Финлянд улсын төрийн бодлого шийдвэрийн талаарх мэдээллийг хянах үүрэгтэй ажилладаг. Мөн тус албанаас эрхлэн явуулдаг “Virtual Finland” вэб сайт,

¹²⁹ Үндсэн хуулийн 2-р бүлэг, 12 зүйл, https://www.constituteproject.org/constitution/Finland_2011?lang=en

¹³⁰ Засгийг газрын үйл ажиллагааны ил тод байдлын тухай хууль, <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990621.pdf>

¹³¹ Олон улсын хэвлэл мэдээллийн лавлах, <http://www.pressreference.com/Fa-Gu/Finland.html>

¹³² Судалгааны эмхэтгэл XXII, хуудас 187. Хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох талаарх эрх зүйн зохицуулалт

“Kaupparolitiikka” сэтгүүл зэргээс мэдээлэл авах боломжтой.

Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг

Тус улсад хэвлэл мэдээллийн байгууллага нь төрийн бодлого, шийдвэрийг хэрхэн хүргэх тухай тусгайлсан хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд тухайн хэвлэл мэдээллийн байгууллага нь дотоод хяналтаараа дамжуулан тухайн мэдээллийн агуулгад хяналт тавьж ажилладаг. Дотоод хяналтын удирдамжийг гаргахдаа тухайн байгууллагатай хамтран ажиллахаар баталсан бүх төрлийн гэрээний агуулгад суурилан гаргадаг.¹³³

Мөн сэтгүүлчдийн өөрсдийн үйл ажиллагааг хариуцлагатай, ёс зүйтэй байлгах, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах зорилгоор байгуулагдсан “Олон нийтийн хэвлэл мэдээллийн зөвлөл” ажилладаг бөгөөд энэхүү зөвлөл нь 7 гишүүнтэй, 4 гишүүн нь сэтгүүлчдээс, 3 гишүүн нь олон нийтээс сонгогддог. Тус зөвлөл нь өөрсдийн үйл ажиллагааны хамрах хүрээнд нийцсэн дүрэм, журам, шийдвэр, удирдамж гаргадаг бөгөөд “Сэтгүүлчдийн үйл ажиллагааны удирдамж”¹³⁴ 2014-т зааснаар сэтгүүлч нь аливаа мэдээллийг олж авах, хэвлэн нийтлэхдээ:

- Сэтгүүлч үнэн зөв мэдээллээр хангах;
- Мэдээллийн эх сурвалж нээлттэй байх;
- Мэдээллийг сайтар шалгах;
- Мэдээллийг төөрөгдүүлсэн байдлаар ашиглахгүй байх;
- Мэдээллийн эх сурвалжид шүүмжтэй хандах;
- Мэдээллийн эх сурвалжийг нууцлахаар гэрээнд заасан бол үүргээ биелүүлэх;
- Гарчиг, зурагт тайлбар, танилцуулах материал нь тухайн материалын агуулгаас хазайхгүй байх;
- Хязгаарлагдмал мэдээлэл хүргэсэн тохиолдолд, үргэлжлүүлэн мэдээлэл бэлтгэх;
- Далд сурталчилгаанаас аль болох зайлсхийх зэрэг зарчмыг мөрдлөг болгон ажиллахаар заасан байдаг бөгөөд энэ нь төрийн бодлого шийдвэрийг ард иргэдэд хүргэхэд ч мөн энэхүү зарчмын хүрээнд ажиллана гэсэн үг юм.

ИБУИНВУ

Судалгаанд нэгдсэн улсын Харилцаа холбооны тухай хууль /The Communications Act, 2003/ Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Freedom of Information Act, 2000/, Мэдээлэл хамгаалах тухай хууль /Data Protection Act, 1998/ хуулиудаар зохицуулагдана.

¹³³ Европын сэтгүүл зүйн төвийн цахим хаяг, http://ejc.net/media_landscapes/finland

¹³⁴ Олон нийтийн хэвлэл мэдээллийн зөвлөл, сэтгүүлчдийн үйл ажиллагааны удирдамж, http://www.jsn.fi/en/guidelines_for_journalists/

Нэгдсэн улс нь 2011 онд байгуулагдсан Нээлттэй Засаглалын холбооны (*Open Government Partnership*) гишүүн улс бөгөөд дэлхийн 65 улс тус холбооны гишүүнчлэлтэй.

Гишүүнчлэлийнхээ хүрээнд нэгдсэн улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар төрийн бодлого шийдвэрийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (*National Action Plan*) боловсруулан ажилласан байна.¹³⁵

Нээлттэй Засгийн газрын Үндэсний Үйл ажиллагааны 2013-2015 оны төлөвлөгөө¹³⁶

Нээлттэй Засаглалын холбооны дүрмийн дагуу Нээлттэй Засгийн газрын Үндэсний Үйл ажиллагааны 2013-2015 оны төлөвлөгөөнд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд засгийн газрын үйл ажиллагааны талаар дараах 4 төрлийн мэдээллийг олон нийтэд түгээх зарчмыг баримталдаг байна.

Үүнд:

- Улсын нэгдсэн төсвийн системийг ил тод, нээлттэй, цаг тухайд нь хэвлэн нийтлэх, төсөв боловсруулахад хариуцлагатайгаар оролцон мэдээлэх;
- Засгийн газрын бодлогыг мэдээллийн тухай хуульд заасны дагуу нээлттэй, ил тод байх зарчмын дагуу олон нийтэд мэдээллийн хүртээмжийг бий болгох;
- Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэг, авлигатай тэмцэх асуудлыг олон нийтэд ил тод, нээлттэй болгох;
- Нээлттэй Засгийн газрын бодлого боловсруулахад иргэний нийгмийн оролцоогоор хангах, иргэний эрх ашигт нийцүүлэх зэрэг болно.

Энэ төлөвлөгөөний хүрээнд Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл түгээх стандартыг тогтоож, үндэсний мэдээллийн сан www.data.gov.uk, www.gov.uk албан ёсны вэб сайтаар дамжуулан хүргэдэг байна.

Төлөвлөгөөнд хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар дараах заалтуудыг тусгажээ.

1-р зүйл: Засгийн газрын мэдээллийн санг боловсронгуй болгох, дэвшилтэд прогр амм хангамж ашиглах, нээлттэй, ил тод мэдээллээр хангах.

3-р зүйл: Засгийн газар нь холбогдох дүрэм журмын дагуу хууль болон холбогдох бусад баримт бичгийг албан ёсны www.legislation.gov.uk вэб сайтад олон нийт нээлттэй үнэ төлбөргүй ашиглахаар байршуулах.

4-р зүйл: Засгийн газрын бодлого, шийдвэрт иргэний нийгмийн байгууллагуудын саналыг тусгах.

5-р зүйл: Засгийн газар нь www.gov.uk вэб сайтад хууль тогтоомжийн төслийг байршуулж, хуулийн төсөлд иргэдийн саналыг тусгах.

6-р зүйл: Европын хууль тогтоомжуудийг эх хэл рүүгээ хөрвүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх, ашиглахад хүртээмжтэй болгох.

¹³⁵ National Action Plan, <https://data.blog.gov.uk/2015/07/03/kicking-off-the-open-government-project/>

¹³⁶ https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/255901/ogp_uknationalactionplan.pdf

Хэвлэл мэдээллийн байгууллага, Засгийн газартай хамтран жиллах талаар¹³⁷

Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэний нийгмийн байгууллагууд болон олон нийтэд сурталчлах, таниулах, хамтран ажиллах зорилгоор яамд нь Олон нийттэй харилцах болон сурталчлах (*Public Relation, PR*) нэгжтэй байдаг. Тус нэгжид зар сурталчилгааны хэлтэс, зааварчилгааны хэлтэс, хэвлэлийн алба багтдаг.

Зар сурталчилгааны хэлтсийн үйлчилгээ нь: орон нутгийн засаг захиргаа, мэдээллийн төвийн удирдлагатай хамтран ажиллаж, хэвлэл мэдээллийн сувгаар зар сурталчилгаа явуулдаг.

Зааварчилгааны хэлтэс нь: Иргэд олон нийтийн байгууллагын саналыг үндэслэн УИХ, Засгийн газар, төрийн бусад байгууллага, сурталчилгааны хэлтсийг мэдээллээр хангаж, хамтран ажилладаг.

Хэвлэлийн албаны зорилго нь: Засгийн газрын бодлого шийдвэртэй холбоотой албан ёсны мэдээллийг үндэсний болон гадаадын сонин, сэтгүүл, телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгөх. Мөн УИХ болон Засгийн газартай хамтран ажиллаж, тэдгээрийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах үүрэгтэй ажилладаг.

Мөн засгийн газрын хэрэгжүүлэгч хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага болон иргэдтэй харилцах тусгай агентлаг /Мэдээллийн төв/ -тай байна. Тус Мэдээллийн төв нь кино гэрэл зураг, хэвлэл техник, зар сурталчилгааны тухай мэдээлэл бэлтгэх, үйлдвэрлэлийн PR- хэлтэсүүдтэй ба салбар бүрийг хариуцсан шинжээч, хэвлэлийн төлөөлөгч нар ажилладаг. Энэ мэдээллийн төвийг мэдээллийн үйлчилгээ гэж нэрлэх ба яам, дээд шатны түвшинд асуудал хэлэлцэх үед санал бодлоо илэрхийлэх эрхтэй байдаг.

Орон нутгийн засаг захиргааны мэдээллийн төвийн үйлчилгээ

Орон нутгийн засаг захиргааны мэдээллийн төвийн үйлчилгээний гол зорилго нь орон нутгийн хэмжээнд олон нийтэд нутгийн өөрөө удирдах, эрх үүргийг таниулах, шийдвэрийн төсөл, төлөвлөгөөг танилцуулах, орон нутгийн засаг захиргааны өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх юм.

Орон нутгийн засаг захиргааны нэгж нь хэвлэл мэдээллийн үйлчилгээ хариуцсан 2 ажилтан, хэд хэдэн туслах нарийн бичгийн даргаас бүрдсэн цомхон бүтэцтэй байдаг. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо нь сэтгүүлчид болон бүс нутгийн хэвлэл, телевиз, радио өргөн нэвтрүүлэгт онцгой анхаарал төвлөрүүлж ажилладаг. Парламент болон Засгийн газрын хуралд оролцох эрхтэй хэвлэлийг (*орон нутгийн сонинд олон нийтэд үйл явдлынхан нь ач холбогдолыг харгалзан*) хүлээн зөвшөөрдөг байна. Хэвлэл мэдээллийн PR хэлтэс, орон нутгийн радио, телевиз нь олон нийтийн харилцааны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тус улсын засгийн газрын хэвлэл мэдээллийн салбарт 2010-2015 онд¹³⁸ хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгээр хэвлэл мэдээллийн салбарт

¹³⁷ http://vasilievaa.narod.ru/8_4_03.htm

¹³⁸ <https://www.gov.uk/government/publications/2010-to-2015-government-policy-media-and-creative-industries/2010-to-2015-government-policy-media-and-creative-industries>

санхүүгийн урамшуулал үзүүлэх, төрийн бодлогыг сурталчлах өргөн нэвтрүүлгийн бодлогыг тодорхойлох, орон нутгийн телевизийн тогтолцоог бий болгох, орон нутгийн телевизийн үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжиж байгаа дүрэм, журмыг багасгах, сайжруулах замаар тухайн салбарыг дэмжин ажиллах тухай тодорхой зорилтуудыг тусгаж, хэрэгжүүлсэн бөгөөд Засгийн газраас хэвлэл мэдээллийн салбарт зарцуулсан төсвийг олон нийтэд нээлттэй мэдээлдэг юм байна.

Хорват улс

“Хорватын Үндсэн хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль”¹³⁹-ийн 89 дүгээр зүйл, Парламентын тухай хуулийн 169 дүгээр зүйл¹⁴⁰ парламентаас баталсан хууль бусад шийдвэрийг Парламентын тамгын газрын нарийн бичгийн дарга хяналт тавьж төрийн төв хэвлэл Narodne novine болон Parliament’s bulletin сэтгүүлд хэвлэн нийтэлж албан ёсоор олон нийтэд хүргэдэг.

Мэдээлэл авах эрхийг хангах тухай /Act on the right of Access to impormation/¹⁴¹ хуулийн 5 дугаар зүйл нь хувь хүн, хуулийн этгээд төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр болон бусад мэдээлэл авах харилцааг зохицуулсан байна.

Эрх бүхий байгууллагын өгсөн эсвэл нийтэлсэн мэдээлэл бүрэн гүйцэд, үнэн зөв байх ёстой бөгөөд онцгой тохиолдол мэдээлэл олж авах эрх хуулиар тогтоосон журмын дагуу хязгаарлагддаг байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай /Media act/ хуулийн 19 дүгээр зүйлд улс орны аюулгүй байдал, олон нийтийн эмх замбараагүй байдал болон онц байдал, хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул занал учирсан, байгалийн гамшгийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны зар мэдээллийг үнэ төлбөргүй хэвлэн нийтлэх, мэдээлэх үүрэгтэй байна.

Цахим мэдээллийн тухай хууль /The Electronic Media Act/¹⁴² Хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтэд Цахим хэлбэрээр хүргэх аливаа мэдээлэлд Цахим мэдээллийн зөвлөл мэдээллийн хяналт тавьж, ажиллана.

Төрийн албан ёсны бодлого, шийдвэр, мэдээллийг олон нийтэд хүргэх харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах албадтай ба хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах, мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг өөрийн дотоод журмаар зохицуулсан байдаг.

¹³⁹ Croatia's Constitution of 1991 with Amendments through 2010, https://www.constituteproject.org/constitution/Croatia_2010.pdf?lang=en

¹⁴⁰ <http://www.sabor.hr/acts-of-parliament>

¹⁴¹ <http://legislationline.org/documents/action/popup/id/6403>

¹⁴² The Electronic Media Act, http://www.e-mediji.hr/files/repositorij/ELECTRONIC_MEDIA_ACT__12_December_2009.pdf

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Дэлхийн улс орнуудын Парламентын алба”, УБ., 2012 он, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв.
- <https://www.tbmm.gov.tr/kanunlar/k6253.html>
- <http://www.byegm.gov.tr/turkce/byegm-hakkinda>
- <https://www.basbakanlik.gov.tr>
- adilet.zan.kz
- http://www.akorda.kz/kz/about_press_office
- <http://ukimet.kz/kz/kpm/obshchaya-informatsiya-po-otdelam-kpm.html>
- Судалгааны эмхэтгэл XXII, хуудас 187, Хуулийг албан ёсоор хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох талаарх эрх зүйн зохицуулалт Хүснэгт 1
- Federal Law “On providing access to information on the activities of government bodies and bodies of local self-government, <http://www.legislationline.org/documents/action/popup/id/17759>
- УИХ-ын Тамгын газрын Судалгааны хэлтсээс эрхлэн гаргасан “Дэлхийн улс орнуудын Парламентын ажлын алба” хуудас 300-301, УБ., 2012 он.
- Европын сэтгүүл зүйн төвийн цахим хаяг, http://ejc.net/media_landscapes/finland
- Үндсэн хуулийн 2-р бүлэг, 12 зүйл, https://www.constituteproject.org/constitution/Finland_2011?lang=en
- Засгийг газрын үйл ажиллагааны ил тод байдлын тухай хууль, <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990621.pdf>
- Олон улсын хэвлэл мэдээллийн лавлах,

**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАНААС ГҮЙЦЭТГЭСЭН
СУДАЛГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭВЛЭН НИЙТЛҮҮЛЭХ, ОЛОН
НИЙТЭД ТҮГЭЭДЭГ ЭСЭХ ТАЛААРХ ГАДААДЫН
ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*А.Пагма, Г.Алтан-Оч, Д.Жигваагүнсэл,
Б.Нандингэрэл, Т.Саулегүл*

АГУУЛГА

1. СУДАЛГААНЫ ТОЙМ
2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА
 - АНУ
 - ХБНГУ
 - ТУРК УЛС
 - ОХУ
 - ЭСТОНИ
 - КАНАД
 - АВСТРАЛИ
 - ИХ БРИТАНИ
 - ИРЛАНД

СУДАЛГААНЫ ТОЙМ

Тус судалгаанд нийт 9 улсын парламентын судалгааны албадын судалгааны бүтээгдэхүүнээ хэрхэн нийтэлж, олон нийтэд хүргэдэг талаар судалсан ба ерөнхийдөө нэгтгэж үзвэл энэ асуудлыг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- Судалсан орнуудын ихэнх нь буюу бараг бүх улсын парламентын цахим хуудсанд Судалгааны албаны судалгаа, мэдээллийг нээлттэй байршуулдаг ба олон нийт ашиглах боломжтой.
- Парламентын номын санд хадгалагдах судалгааны тайланг үзэх шаардлагатай энгийн үйлчлүүлэгч хүсэлт гаргаж зөвшөөрлийн дагуу үзэж болно.
- Парламентын цахим мэдээллийн сан, цахим хуудсанд байршуулсан судалгааны мэдээллийг ашиглахдаа уг материалын эх сурвалжийг заавал дурдана.
- Тодорхой тохиолдолд, тухайлбал, шүүх болон төсөв, улсын нууцад хамаарах асуудлаарх судалгааны тайлан, мэдээллийг онлайн болон хэвлэмэл байдлаар олон нийт ашиглах боломжгүй.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

АНУ¹⁴³

Конгрессийн судалгааны алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах дэлхийн хамгийн том судалгааны төв бөгөөд Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод мэдээлэл, судалгааны үйлчилгээ үзүүлнэ. Судалгааны алба нь гүйцэтгэх засаглалын байгууллага болон олон нийтийн судалгааны хэрэгцээг хангах үүрэг хүлээдэггүй.¹⁴⁴

Конгрессийн судалгааны албанаас тайлан, дүн шинжилгээ, мэдээлэл, семинар, илтгэл, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд үзүүлэх бөгөөд судалгааны тайлан, дүн шинжилгээг цахим болон хэвлэмэл хэлбэрээр гаргадаг байна.



Судалгааны тайланг хэвлэмэл байдлаар номын санд, цахим хэлбэрээр Судалгааны албаны сайтад www.crs.gov/ бүрэн эхээр нь pdf хэлбэрээр байршуулдаг. Судалгааны албаны 2015 оны тайлан мэдээлэлд: Судалгааны албаны вэб хуудсанд нийт хандсан 2,274,272 хэрэглэгчээс 852,469 нь зөвхөн судалгааны тайлан, бүтээгдэхүүнийг үзсэн тухай мэдээлжээ. Мөн <http://fpc.state.gov/c55787.htm> - Congressional Research Service Reports (CRS) and Issue Briefs/, www.congress.gov зэрэг сайтуудад олон нийтэд зориулан судалгааны тойм, судалгааны мэдээлэл, тайлан зэргийг байршуулдаг.

Конгрессийн судалгааны албанаас судалгаа, мэдээлэл, дүн шинжилгээ, үйл ажиллагааны тайлан зэргийг хэвлэн нийтэлдэг хэдий ч Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэглэгдэх бөгөөд номын санд хадгалагдах судалгааны тайланг үзэх шаардлагатай энгийн үйлчлүүлэгч Конгрессийн ажлын албанд хүсэлт гаргаж зөвшөөрлийн дагуу үзэж болно. Харин зарим тохиолдолд, тухайлбал, шүүх болон төсөв, улсын нууцад хамаарах асуудлаарх судалгааны тайлан, мэдээллийг онлайн болон хэвлэмэл байдлаар үзүүлдэггүй байна.

¹⁴³ Annual Report, Congressional Research Service, Library of Congress Fiscal Year 2015 To the Joint Committee on the Library United States Congress Pursuant to Section 321, Public Law 91-510, Mary B. Mazanec Director, January 2016- <https://www.fas.org/sgp/crs/crs15.pdf>

¹⁴⁴ "Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба" УБ, 2012 он, 184 дэх тал

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Германы Бундэстагийн Судалгаа шинжилгээний алба (США)¹⁴⁵ нь Холбооны яамдын мэргэжлийн бүрэн эрхээс үл хамааран Бундэстагийн депутатуудыг тодорхой асуудлын хүрээнд мэдээллээр хангах зорилготой байгууллага юм.

США-нд захиалгыг депутат буюу Бундэстагийн удирдлагаас ирүүлнэ. Уг алба нь жилд 4 300 шахам захиалгыг “халуун шугам”-аар¹⁴⁶ хүлээн авдаг. США нь ерөнхийдөө өөрөө судалгаа шинжилгээний ажил хийдэггүй, харин судалгаа шинжилгээний түвшин, мөн хууль тогтоомжийг ойлгомжтой, гаргацтай гаргаж тавьдаг. США-ны гаргаж байгаа ажлууд нь улстөрөөс ангид байх ёстой. Захиалгаар хийгдсэн ажил нь ерөнхийдөө захиалагчийн эрх мэдэлд 4 долоо хоногийн туршид байдаг. Энэ хугацаа өнгөрсний дараа 2016 оноос хойш хэрэв “нарийн зохицуулагдсан хасах нөхцөл эсрэгцэн бүрдээгүй бол”¹⁴⁷ (Мэдээллийн эрх чөлөөний тухай 2016 оны 2 дугаар сарын шинэ хуулийн дагуу) уг судалгааны ажлыг Бундэстагийн вэб хуудсанд байршуулдаг болсон¹⁴⁸. Депутатууд нь США-ыг үндсэндээ зөвхөн мандаттайгаа холбогдсон ажил төрөлд л ашиглах үүрэгтэй.

США-нд парламентын номын сангуудын дотор дэлхийд 3 дугаарт жагсах, ойролцоогоор 1.4 сая уншлагын нэгж бүхий Германы Бундэстагийн Номын сан харьяалагдана. Түүнээс гадна Германы Бундэстагийн Архив мөн США-нд хамрагдана.

Мөн США нь өөрийн санаачлагаар “Тулгамдсан асуудлууд” нэртэй, 2 хуудаст багтсан судалгааны ажил хийдэг. Үүнийгээ бүх депутатад түгээдэг. Харин вэб хуудсанд илүү боловсруулсан хувилбарыг байршуулж өргөн олны хүртээл болгодог.

США болон Европын тасаг нь депутатуудыг дүн шинжилгээ болон мэргэжлийн салбарын мэдээлэл, үнэлэлт өгч дүгнэсэн байр суурь илэрхийлсэн баримт бичгээр хангаж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг¹⁴⁹. США нь зөвхөн дан ганц парламентын төлөө ажилладаг. Түүнчлэн, “Тулгамдсан асуудлууд” болон “Мэдээллийн хуудас”¹⁵⁰, “Европын тулгамдсан асуудлууд” нэртэй товхимолууд гаргадаг. Судалгаа шинжилгээний ажлуудын агуулгад “Хариуцлагаас чөлөөлөх”¹⁵¹ болон “Зохиогчийн эрхийн хамгаалалт”¹⁵²-ын эрх зүйн орчин үйлчилнэ.

Турк улс

Турк улсын парламентын дэргэдэх Судалгааны төв нь Турк Улсын Их Хурал / Межлис/-ын Тамгын газрын Захиргааны зохион байгуулалтын тухай хуулийн 4-р зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Мэдээлэл болон мэдээллийн технологи

¹⁴⁵ Германы Бундэстагийн Судалгаа шинжилгээний алба-Wissenschaftliche Dienste des Deutschen Bundestages https://de.wikipedia.org/wiki/Wissenschaftliche_Dienste_des_Deutschen_Bundestages

¹⁴⁶ Hotline W

¹⁴⁷ германаар “so dem nicht eng gefasste Ausschlussgründe entgegenstehen”

¹⁴⁸ Мэдээллийн эрх чөлөө:Бундэстаг өөрийн дүгнэлтүүдээ сүлжээнд тавьж байна- Informationsfreiheit:Bundestag stellt seine Gutachten ins Netz

<http://www.zeit.de/digital/internet/2016-02/informationsfreiheit-bundestag-stellt-wissenschaftliche-gutachten-online>

¹⁴⁹ Бундэстаг:Мэргэжлийн мэдээлэл болон дүн шинжилгээ-Bundestag:Fachinformationen und Analysen <http://www.bundestag.de/analysen>

¹⁵⁰ германаар Infobrief

¹⁵¹ германаар Haftungsausschluss

¹⁵² германаар Urheberrechtsschutz

хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын туслахын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулахаар зохицуулагдсан.

Турк Улсын Их Хурал /Межлис/-ын Тамгын газрын дэргэдэх Судалгааны албаны ажиллах журмын¹⁵³ дагуу Судалгааны төвийн даргын хүлээн зөвшөөрсөн судалгааны бүтээл нь Ерөнхий нарийн бичгийн дарга баталж гарын үсэг зурснаар ТУИХ-ын Тамгын газрын дэргэдэх Хэвлэлийн цехэд хэвлэгдэж Их Хурлын гишүүдэд хүргэгдэнэ.

Судалгааны төвөөс гаргасан бүтээлийг эх сурвалжийг нь зааж ашиглаж болно.

Судалгааны төвийн үйлчилгээнүүд нь Их Хурлын гишүүнийг түүний бүрэн эрхийн хугацаанд мэдээллээр хангахад чиглэгдсэн байна. Их хурлын гишүүдээс бусад хувь хүн болон бүлгүүд бэлэн болсон судалгааны ажлуудаас ашиглаж болно.

Дээр дурдсан Журамд мэдээлэл авах хүсэлтийг хүлээж авах, мэдээлэл өгөх түүнийг бүртгэх дараахь журмыг заажээ. Үүнд:

- Мэдээлэл авах тухай хүсэлтийг амаар, бичгээр, утсаар болон электрон шуудангаар гаргаж болно. Зарим тохиолдолд Судалгааны төвийн удирдлагаас мэдээлэл авах тухай хүсэлтийг албан бичгээр ирүүлэхийг шаардаж болно.
- Мэдээлэл авах тухай хүсэлтийг Судалгааны төвд ирүүлнэ.
- Мэдээлэл авах тухай хүсэлтийг хүлээж авах, хариу хүргүүлэх болон үүнтэй холбоотой бүхий л үйл ажиллагааны талаархи бүртгэлийг хөтөлнө.
- Мэдээлэл авах тухай хүсэлтэнд хариу өгсөн байдал болон хугацааг бүртгэнэ.

Судалгааны төвийн хугацаат хэвлэл, ном, дижитал эх үүсвэрүүдийг агуулсан Лавлагааны номыг бэлтгэн гаргана.

Лавлагааны номыг бэлтгэн гаргах, түгээх журмыг Их Хурлын Тамгын газрын Номын сангийн албатай хамтран гаргана.

Судалгааны төвөөс бэлтгэн гаргасан судалгааны бүтээлүүдийг Судалгааны төвийн Интранет хуудсанд байршуулж Их Хурлын гишүүдийг танилцах боломжоор хангана.

Судалгааны төвөөс бэлтгэн гаргасан судалгааны материалуудыг ашиглахдаа Судалгааны төвийн аль нэгжид хамааралтай асуудал болохыг сонгож Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн цахим хуудаснаас холбоо барих зааварчилгааг авч тухайн асуудал хариуцсан албан тушаалтантай биеэр эсвэл утсаар холбогдож, эсвэл цахим хаяг руу нь захиа бичих байдлаар хүсэлтээ илгээх боломжтой. Мэдээлэл авах асуудлынхаа сэдэв, агуулга, хэрэглэх орчин болон хугацааг дурдсан байх нь тухайн хүний хүсэлтэнд богино хугацаанд, шаардлагатай мэдээллийг агуулсан хариу ирүүлэхэд хялбар байдаг тухай тус төвийн цахим хуудсанд дурдсан байна.

ARMER Bülten Судалгааны төвийн бүтээлүүдийн эмхэтгэлийг жилд хоёр удаа эмхэтгэн гаргадаг.

¹⁵³ Türkiye Vüyük Millet Meclisi Araştırma Merkezi Yünetmeliđi.
<https://www.tbmm.gov.tr/genser/m35.html>

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Тамгын газрын Судалгааны газрын судалгааны ажил нь мэдээлэл-дүн шинжилгээний бичиг, тойм, шинжээчийн дүгнэлт, зөвлөмж хэлбэрээр гардаг. Тус Судалгааны газар нь “Мэдээлэл-судалгааны эмхэтгэл” /Информационно-аналитический бюллетень/ 10 дугаар, “Судалгааны мэдээлэл”/Аналитический вестник/ 20 дугаарыг хэвлэн гаргадаг байна.

Судалгааны газрын судалгааны бүтээгдэхүүний ихэнхийг Төрийн Думын <http://iam.duma.gov.ru/> цахим хуудасны төрийн Думын мэдээлэл-судалгааны материал гэсэн хэсэгт бүрэн эхээр нь байршуулан олон нийт, шинжээч, судлаачдын хүртээл болгодог ажээ.

Төрийн Думын цахим мэдээллийн санд байршуулахдаа мэдээлэл-судалгааны материалыг дахин хэвлэх ба ишлэсэн тохиолдолд эдгээр эх сурвалжийг заавал дурдана гэдгийг заажээ.

Эстони Улс

Эстони улсын парламент Рийгикогугийн Тамгын газрын Эрх зүй, судалгааны хэлтэс нь судалгааны бүтээгдэхүүний эмхэтгэлийг сард 2 удаа сэдэвчилсэн дугаар хэлбэрээр хэвлэн гаргадаг ба Рийгикогугийн <http://www.riigikogu.ee/ru/novosti-i-dokumenty/izdaniya-riigikogu> цахим хуудсанд эмхэтгэлийн бүх дугаарыг цахим хэлбэрээр нээлттэй байршуулжээ.

Их Британи¹⁵⁴

Их Британи улс нь Нийтийн танхим болон Лордын танхим гэсэн 2 танхимтай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрийн ажлын алба нь 2 тусдаа байдаг.

Нийтийн болон Лордын танхимын Ажлын албадын дэргэд тус тусдаа Номын сан, судалгаа хариуцсан газартай бөгөөд энэхүү газар нь танхимын гишүүд болон ажлын албаны ажилтнуудыг хараат бус мэдээлэл, судалгаагаар хангах үүрэгтэй ажилладаг.

Нийтийн танхимын дэргэдэх Номын сан, судалгааны газар нь хэрэгжиж буй хууль тогтоомж болон байнга асуудаг асуулт, сэдэвчилсэн асуудлаар мэдээлэл болон дүн шинжилгээ хийдэг.

Харин Лордын танхимын дэргэдэх Номын сан, судалгаа хариуцсан газар нь хэрэгжиж буй хууль болон Лордын танхимаар хэлэлцэгдэж буй асуудал, мөн хэлэлцэх явцад гишүүдэд тулгарсан асуудлаар улс төрийн хараат бус дүн шинжилгээ хийдэг.

Эдгээр судалгааны материалыг парламентын цахим хаягт байршуулдаг бөгөөд парламентын гишүүд болон олон нийт үзэх боломжтой байдаг. Тусгайлан хэвлэн гаргадаггүй юм байна. Хэрэв судалгаатай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл холбогдох майл хаягаар хүсэлтээ явуулах боломжтой.

¹⁵⁴ Их Британийн Нийтийн болон Лордын танхимын номын сан, судалгааны газар <http://www.parliament.uk/mps-lords-and-offices/offices/commons/commonslibrary/#jump-link-1>

Австрали¹⁵⁵

Австралийн парламентын ажлын албаны номын сангийн дэргэдэх Судалгаа хариуцсан газар нь хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор сенатор, төлөөлөгчдийн танхимын гишүүн, байнгын хороод, тэдний ажлын албаны ажилтнуудын хүсэлтээр мэдээлэл, судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Тус газар нь Парламентын гарын авлага, танилцуулга ном, төсвийн тойм, судалгааны эмхтгэл, товч гарын авлагыг эрхлэх гаргадаг бөгөөд эдгээр материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр ашиглах боломжтой байдаг. Жилд дунджаар 328 орчим судалгааны материалыг боловсруулан гаргадаг бөгөөд эдгээр материалыг олон нийт нээлттэй ашиглах боломжтой.

Канад Улс¹⁵⁶

Канадын Мэдээлэл, судалгааны алба нь /Information and research service/ Парламентын номын сангийн нэгж бөгөөд Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг судалгаа, мэдээллээр хангах үүрэгтэй.

Парламентын номын сангийн Мэдээлэл, судалгааны албанаас судалгааны тайлан, дүн шинжилгээ, мэдээлэл-лавлагаа, тооцоолол, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээг хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд үзүүлж байна.

Судалгаа, мэдээллийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр гаргадаг бөгөөд Парламентын номын санд хадгалагдана. Номын сангийн мэдээлэл, судалгааны материалуудыг парламентын гишүүд, ажилтнууд, парламентын хороод, холбогдох бусад байгууллагууд ашиглана. Харин цахим хэлбэрээр Парламентын албан ёсны вэб сайт /<http://www.loppar.gc.ca/Content/LOP/ResearchPublications/government-e.htm>/-д олон нийтэд нээлттэй тавигддаг.¹⁵⁷

Ирланд улс

Тус улсын парламентын дэргэдэх Номын сан болон судалгааны үйлчилгээний алба нь тус албаны дүрэмд зааснаар Парламентын Төлөөлөгчдийн танхим, Сенатын танхим, хороод болон бие даасан гишүүдэд тэдгээрийн хууль тогтоох үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээлэл хүргүүлэх, судалгаа шинжилгээ хийх үүргийг хүлээсэн.

Ирландын парламентын номын сан, судалгааны албаны анхдагч хэрэглэгчид нь парламентын дээд, доод танхимын төлөөлөгчид, хороод, тэдгээрийн ажлын албаны ажилтнууд байдаг. Дээд, доод танхимын гишүүн байсан хүмүүс болон Европын парламентын гишүүд зарим төрлийн судалгааны мэдээллээр хангагдах боломжтой.

“Гишүүдийн уншлагын танхим”-аас парламентын гишүүд, парламентын гишүүн байсан хүмүүс, Европын парламентын гишүүд, парламентын ажлын

¹⁵⁵ Австралийн парламентын номын сангийн үйл ажиллагааны тайлан http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Department_of_Parliamentary_Services/Publications/Annual_Report_2014-15/Part_4_The_Parliamentary_Library

¹⁵⁶ Library of Parliament Research Publications <http://www.loppar.gc.ca/About/Library/VirtualLibrary/ResearchPublications-e.asp>

¹⁵⁷ Library of parliamentary Annual Report 2015 http://www.loppar.gc.ca/About/Library/VirtualLibrary/AnnualReport/2015/pdf/annualreport_2014-2015-e.pdf

албаны ажилтнууд болон парламентын хорооноос бичгээр зөвшөөрөл авсанаас бусад хүмүүс үйлчлүүлэх эрх эдлэхгүй.¹⁵⁸

Ирланд улсын Парламентын Номын сан, судалгааны алба нь ямар үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлдэг талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

Үйлчилгээ	Парламентын танхимын гишүүд, Хороод, ажлын албаны ажилтнууд, , намын судлаачид	Засгийн газрын гишүүд, яамдын албан тушаалтнууд	Парламентын гишүүн байсан хүмүүс болон Европын парламентын гишүүд	Парламентын сурвалжлагчид	Олон нийт
Эрх зүйн дүн шинжилгээний үйлчилгээ	Үзэх эрхтэй	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	үгүй	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	үгүй
Энгийн мэдээлэл	Үзэх эрхтэй	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	үгүй	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	үгүй
Захиалгат судалгаа	Үзэх эрхтэй	үгүй	үгүй	үгүй	/судалгааны асуудлаас хамаарна./
Номын сан, судалгааны үйлчилгээнээс түр ашиглах	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй	үгүй	үгүй	үгүй
Мэдээллийн ур чадвар олгох сургалт	Үзэх эрхтэй	үгүй	үгүй	үгүй	үгүй
Уншлагын танхимаас лавлагаа гаргуулахаар хандах	Парламентын гишүүд, АА-ны ажилтнууд, намын судлаачдад зөвхөн материал бүрдүүлэх зорилгоор)	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй	үгүй	үгүй
Номын сан, судалгааны албаны эмхэтгэл болон мэдээллийн цонход нэвтрэх	Үзэх эрхтэй	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	/Зөвхөн гишүүдийн уншлагын танхим дотор/	/зохих төлбөрийг төлсний үндсэн дээр/	үгүй
Oireachtas.ie /Парламентын цахим хуудас дахь мэдээлэл/	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй	Үзэх эрхтэй

¹⁵⁸ <http://www.oireachtas.ie/parliament/about/libraryresearchservice/>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Annual Report, Congressional Research Service, Library of Congress Fiscal Year 2015
- To the Joint Committee on the Library United States Congress Pursuant to Section 321,
- Public Law 91-510, Mary B. Mazanec Director, January 2016-
- <https://www.fas.org/sgp/crs/crs15.pdf>
- “Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба” УБ, 2012 он, Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв.
- Research Service in Congress and Parliament. http://www.revparl.ca/11/4/11n4_88e
- Wissenschaftliche Dienste des Deutschen Bundestages. https://de.wikipedia.org/wiki/Wissenschaftliche_Dienste_des_Deutschen_Bundestages
- Bundestag:Fachinformationen und Analysen <http://www.bundestag.de/analysen>
- Аналитическое обеспечение деятельности Государственной Думы Федерального Собрания Российской Федерации. [pravo.hse.ru\data](http://pravo.hse.ru/data)
- Исследования и экспертизы. <http://www.riigikogu.ee/ru/novosti-i-dokumenty/>
- Türkiye Vüyük Millet Meclisi Araştırma Merkezi Ycnetmeliđi. <https://www.tbmm.gov.tr/genser/m35.html>
- Annual Report, Parliamentary_Library. http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/
- Library of Parliament Research Publications <http://www.lop.parl.gc.ca/About/Library/VirtualLibrary/ResearchPublications-e.asp>
- Library of parliamentary Annual Report 2015 http://www.lop.parl.gc.ca/About/Library/VirtualLibrary/AnnualReport/2015/pdf/annualreport_2014-2015-e.pdf
- Libraryresearchservice. <http://www.oireachtas.ie/parliament/about/>

ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТОВ ТОГТООДОГ ХУГАЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

О.Нарантуяа, Б.Нандингэрэл

Улс орон бүрийн сонгуулийн тов тогтоодог хугацаа нь харилцан адилгүй байгаа бөгөөд ингэхдээ хуулиар, журмаар, зарим тохиолдолд тогтоолоор батлан сонгуулийн товыг зарладаг. Судалгаанд дэлхийн 60 орны хамгийн сүүлд явагдсан парламентын сонгуулийн хугацаа, 2016 онд товлогдсон парламентын сонгуулийн хугацааны талаарх мэдээлэл лавлагааг оруулав.

Судалгаанаас үзэхэд газарзүйн байрлал, цаг агаар, тухайн улсын онцлогоос шалтгаалан Африк болон Латин америкийн улс орнууд өвлийн улиралд, Ази, Европын улс орнууд хавар, намрын улиралд, Австрали болон Европын хэд хэдэн орон зуны улиралд парламентын сонгуулиа зохион байгуулдаг жишигтэй байна.

Хүснэгт 1. Гадаадын зарим орны парламентын сонгуулийн тов тогтоосон байдал

№	Улсын нэр	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Австри			9-р сард	
2	Албани		6-р сард		
3	Армян		5-р сард		
4	Босни-Герцеговин				10-р сард
5	ХБНГУ			9-р сард	
6	Грек			9-р сард	
7	Исланд		4-р сард		
8	Итали	2-р сард			
9	Их Британи		5-р сард		
10	Эстони	3-р сард			
11	Швейцар				10-р сард
12	Монтенегро				10-р сард
13	Чех				10-р сард
14	Франц		6-р сард		
15	Латви				10-р сард
16	Литва				10-р сард
17	Македон		6-р сард		
18	Молдав				11-р сард
19	ОХУ				12-р сард
20	Польш				10-р сард
21	Португали				10-р сард
22	Румын				12-р сард
23	Серби		4-р сард		

24	Словак	3-р сард			
25	Словени			7-р сард	
26	Украйн				10-р сард
27	Унгар		4-р сард		
28	Финланд		4-р сард		
29	Америкийн Нэгдсэн Улс				11-р сард
30	Бүгд Найрамдах Аргентин Улс				10-р сард
31	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс				10-р сард
32	Бүгд Найрамдах Гаити Улс				10-р сард
33	Канад Улс				10-р сард
34	Бүгд Найрамдах Чили Улс				11-р сард
35	Алжир		5-р сард		
36	Ангол			8-р сард	
37	Египет				11-р сард
38	Мексик		6-р сард		
39	Мавритани				12-р сард
40	Мадагаскар				12-р сард
41	Марокко				10-р сард
42	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс		5-р сард		
43	Тунис				10-р сард
44	Этиопи		5-р сард		
45	Австрали			9-р сард	
46	Шинэ Зеланд			9-р сард	
47	Вьетнам		5-р сард		
48	Индонези		4-р сард		
49	Казахстан	1-р сард			
50	Камбож			7-р сард	
51	Малайз		5-р сард		
52	Уругвай				10-р сард
53	Бүгд Найрамдах Солонгос Улс		4-р сард		
54	Тажикистан	3-р сард			
55	Турк				11-р сард
56	Филлипин		5-р сард		

57	Дани		6-р сард		
58	Энэтхэг		4-р сард		
59	Япон				12-р сард
60	Нидерланд			9-р сард	
Нийт тоо		5	20	9	26

Эх сурвалж: <http://www.electionguide.org/>

Хүснэгт 2. 2016 онд Парламентын сонгуулийн тов тогтоогдсон
гадаадын улс орнууд

№	Улсын нэр	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Тайвань	2016-01-16			
2	Төв Африкийн бүгд найрамдах улс	2016-02-14 /1шат/ 2016-03-31 /2шат/			
3	Уганда	2016-02-18			
4	Нигер	2016-02-21			
5	Ямайка	2016-02-25			
6	Иран	2016-02-26			
7	Ирланд	2016-02-26			
8	Самоа	2016-03-04			
9	Словак	2016-03-05			
10	Кабо Верде	2016-03-20			
11	Казакстан	2016-03-20			
12	Перу		2016-04-10		
13	БНСУ		2016-04-13		
14	Сири		2016-04-13		
15	Серби		2016-04-24		
16	Филлипин		2016-05-09		
17	Вьетнам		2016-05-22		
18	Кипр		2016-05-22		
19	Македон		2016.06.05		
20	Замби			2016.08.11	
21	Беларус			2016.09.11	
22	ОХУ			2016.09.18	
23	Морокко				2016.10.07
24	Литва				2016.10.09
25	Афганистан				2016.10.15
26	Монтенегро				2016.10.21

27	Никарагуа				2016.11.06
28	АНУ				2016.11.08
29	Пуэрто Рико				2016.11.08
30	БНКонго				2016.11.27
31	Сомали				2016.12.31
Нийт		11	8	3	9

Эх сурвалж:<http://www.electionguide.org/>

**ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ДЭГИЙГ ХЭРХЭН ТОГТООДОГ
ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

Ч.Онончимэг, Д.Халиун

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн түүхэн тойм

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурал 1990 оны 9 дүгээр 13-ны өдөр 1 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг”-ийг баталсан байдаг. Уг дэгт Улсын Бага Хурал /цаашид “УБХ” гэх/-ын 1990 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Үндсэн хууль болон түүний Хавсралт хуулийг үндэслэн 1992 оны 3 дугаар сарын 10-ны өдөр “Улсын Бага Хурлын дэгд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах тухай” хуулийг баталсан байдаг. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хуулийн 3 дугаар зүйлд “Улсын Бага Хурлын анхдугаар чуулганы дэгийг дээрх нэмэлт, өөрчлөлттэйгээр энэхүү хуулийн хавсралт болгон баталсугай” гэж заасан бөгөөд Улсын Бага Хурлын 1992 оны 3 дугаар сарын 10-ны өдөр баталсан хуулийн хавсралтаар “Монгол Улсын Бага Хурлын чуулганы дэг”-ийг баталсан.

Үүнээс үзэхэд Улсын Бага Хурлын 1990 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “БНМАУ-ын Бага Хурлын анхдугаар чуулганы дэг” 1992 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн “Монгол Улсын Бага Хурлын чуулганы дэг”-ийн хууль болон өөрчлөгдсөн байна.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд Улсын Бага Хурал 1992 оны 7 дугаар сарын 6-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын тухай” хуулийг батлан гаргаж, тус хуулийн 63 дугаар зүйлд “Энэ хууль 1992 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно” гэж заажээ.

1992 оны Монгол Улсын Их Хурлын тухай хууль нь 10 бүлэг 63 зүйлтэй. Уг хуулийн 6-9 дугаар бүлгүүд нь УИХ-ын чуулганы хуралдааны дэгтэй холбоотой зохицуулалтыг агуулсан байдаг. 1992 оны Монгол Улсын Их Хурлын тухай хууль нь нэлээд өргөн агуулгатай хууль байсан. Учир нь уг хууль нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т заасан журмыг дангаараа зохицуулсан хууль юм. Харин 1997 оноос хойш Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т заасан журмыг зөвхөн нэг хуулиар бус хоёр хуулиар зохицуулах болсон.

Монгол Улсын Их Хурал 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг Үндсэн хуульд нийцүүлэн батлан гаргасан. Мөн Улсын Их Хурал 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар 1992 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг хүчингүй болгож, тус хуулиар зохицуулж байсан Улсын Их Хурлын хуралдааны дэгийг мөн өдрийн “Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг”-ийн хуулиар зохицуулах болсон.

Монгол Улсын Их Хурлын 2000 оны сонгуулийн дараагаар шинэ бүрэлдэхүүнтэй болсон Улсын Их Хурал 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Улсын Их Хурлын хуралдааны дэгийг хуулиар бус тогтоолоор баталж байх зохицуулалтыг хийж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолоор баталсан нь 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байжээ. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар 1997 оны “Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг”-ийн хуулийг хүчингүй болгож, уг хуулиар зохицуулж байсан УИХ-ын хуралдааны дэгийн журмыг Улсын Их Хурал “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 2001 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 61 дүгээр тогтоолоороо зохицуулах болсон. Энэхүү УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор баталсан байдал нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэснийг зөрчих болсон гэж үзэх болсон.

Түүнчлэн Улсын Их Хурал 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоороо 2001 оны 61 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан байна.

Гэвч Үндсэн хуулийн цэц 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар дүгнэлтээр “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж дүгнэсэн. УИХ 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байжээ. Үүний дараагаар Улсын Их Хурлын 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 67 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан 2006 оны УИХ-ын 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон.

Монгол Улсын Их Хурал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийн тухай хуулийг батлан гаргаж, мөн өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хоёр. Парламентын автономии байх эрх

Парламентын хуралдааны дэгийн онцлог шинжүүд, парламентын автономии байх эрхийн талаар “Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс” номонд¹⁵⁹ дараахыг өгүүлсэн байна: Тухайлбал,

“Парламентын үйл ажиллагааны журам нь аливаа хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны гол үндэс болдог. Нэгдүгээрт, парламент өөрөө өөрийнхөө үйл ажиллагааны дотоод журмыг боловсруулж, тогтоодогт оршино. Мөн парламентын хуралдааны дэг нь түүний өдөр тутмын үйл ажиллагааны Үндсэн хуулийн зарчмуудыг үйл явцын, ухаалаг, тодорхой дэг, журмаар хангах явдал бөгөөд парламентын үйл ажиллагааг нэг бүрчилсэн тодорхой процессжуулсан заалтуудаас бүрддэг байна. Хоёрдугаарт, Парламент нь Үндсэн хуулийн бусад эрх мэдлийн байгууллагуудаас хараат бусаар, аливаа

¹⁵⁹ Л.Өлзийсайхан “Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс” Улаанбаатар хот, 2010 он, 42 дахь тал.

нөлөөллөөс ангид байж зөвхөн өөрсдийн гишүүдийн бүрдүүлэлтийг хийдэг байгууллага юм. Эл төрлийн байгууллага болохын хувьд хуралдааны дэг нь парламентын гишүүдийн олонхын саналын үндэслэн шийдвэр гаргадаг парламентын өөртөө засаглах эрх зүйн хүрээнд батлагддаг байна.

Парламентын хуралдааны дэг нь дээр дурдсан шинжүүдээс гадна дараах хэд хэдэн шинжтэй. Үүнд, парламентын гишүүдэд болон парламентад ажил үүрэг гүйцэтгэдэг.

Тамгын газрын нийт ажилтнуудад тус журам хамааралтай; парламентын хуралдааны дэгийг баталсан парламентын шийдвэр тухайн журмыг баталсан хурлын хувьд л хүчин төгөлдөр байх. Тодруулбал, хууль санаачлах, хуулийн төсөл хэлэлцэх цаг хугацааны үечлэл тогтворгүй байдгаас үүдэн хуулийг батлах байдал цаг хугацааны хувьд тодорхой бус байдаг. Иймд хэлбэрийн хувьд авч үзвэл тухайн парламентын бүрэн эрхийн хугацаа дуусах, шинээр бүрдсэн парламентын бүрэн эрхийн хугацаа эхлэх тэр үед өмнөх парламентын дотоод журмыг баталсан шийдвэр үндсэндээ хүчин төгөлдөр бус болж байгаа юм. Мөн хуралдааны дэгийн парламент дахь хууль зүйн үйлчлэлийнх нь хувьд дараах парламентын ёсны зарчим үйлчилж байдаг байна. Тус зарчмыг Франкфуртын Паульскирхийн зарчим ч гэж нэрлэдэг. Шинээр байгуулагдсан парламентад өмнөх парламент өөрийн үйл явцын дотоод журмыг үлгэрлэл болгон тулгах эрхгүй бөгөөд уг дотоод журам нь түүнийг баталсан тухайн парламентын хуульд л хүчин төгөлдөр байна. Хэрэв үүнээс гажвал шинээр бүрэлдсэн парламентын дотоод журмын өөртөө засаглах эрхэд бүдүүлгээр халдаж, тухайн парламентын автономи байх эрхийг хязгаарласан болох юм.

Иймд дээр дурдсан шинж, тодорхой үндэслэлүүд дээр тулгуурлан парламентын үйл ажиллагааны дотоод журмыг хуульчлах, хуулийн заалт болгон хэрэглэхэд хүндрэлтэй байдаг байна. Түүний хэм хэмжээний тал нь өөр бусад нийтийн эрх зүйн хэм хэмжээнээс үндсээрээ огт өөр байдаг болохоор түүнийг “sui generis” (лат. аливаа юмны төрөл зүйл, эсхүл цорын ганц шинжийг илэрхийлсэн утгатай. Аливаа онцлог, цорын ганц зүйлийг хууль болон эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлохдоо тус нэр томъёог хэрэглэдэг байна) эрх зүйн хэм хэмжээ гэж нэрлэдэг байна.”

ХАВСРАЛТ

СТ-16/405 тоот судалгаа

Судалгаанд нийт 56 орны парламентын дэгийг хэрхэн тогтоодог талаарх хууль тогтоомжийг судлан үзвэл хуулиар тогтоодог 14, тогтоолоор тогтоодог 41 орон байна.

№	Улсын нэр	Эрх зүйн акт	Эрх зүйн актын нэр, эх сурвалж
1	Австри	Хууль	Federal Law on the Rules of Procedure of the Austrian National Council. Rules of Procedure Law of 1975 https://www.parlament.gv.at/ENGL/PERK/RGES/GOGNR/index.shtml

2	Австрали	Тогтоол	HOUSE OF REPRESENTATIVES Standing Orders 2015 http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_Orders
3	Англи	Тогтоол	Standing Orders of the House of Commons - Public Business 1998 http://www.publications.parliament.uk/pa/cm199798/cmstords/1mpubbs.htm Standing Orders of the House of Commons - Private Business 2001 http://www.publications.parliament.uk/pa/cm200102/cmstords/pubbs01.htm
4	Америк	Тогтоол	RULES OF THE HOUSE OF REPRESENTATIVES OF THE UNITED STATES 112TH CONGRESS 2015 http://www.house.gov/content/learn/ STANDING RULES OF THE SENATE 2013 http://www.rules.senate.gov/public/index.cfm?p=RulesOfSenateHome
5	Бангладеш	Тогтоол	RULES OF PROCEDURE OF PARLIAMENT OF THE PEOPLES'S REPUBLIC OF BANGLADESH http://www.parliament.gov.bd/index.php/en/parliamentary-business/procedure/rules-of-procedure-english
6	Болгар	Тогтоол	Rules of Organisation and Procedure of the National Assembly http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations
7	Босни Герцеговин	Тогтоол	RULES OF PROCEDURE OF THE HOUSE OF REPRESENTATIVES OF THE PARLIAMENTARY ASSEMBLY OF BOSNIA AND HERZEGOVINA 2006 http://www.oscebih.org/Download.aspx?id=68&lang=EN
8	Ботсван	Тогтоол	STANDING ORDERS OF THE NATIONAL PARLIAMENT http://www.paclii.org/pg/Parliament/Parliamentary%20Standing%20Orders.htm
9	Бельги	Тогтоол	The Rules of Procedure of the Belgian House of Representatives 2010 http://www.parliament.am/library/kanonakarger/BELGIA.pdf
10	Герман	Тогтоол	o "Geschdftsordnung des Deutschen Bundestages" https://www.bundestag.de/bundestag/aufgaben/rechtsgrundlagen/go_btg
11	Гүрж	Хууль	Закон о Регламенте парламента Грузии от 22 июня 2012г. parliament.am
12	Грек	Тогтоол	Standing Orders of the Hellenic Parliament http://www.hellenicparliament.gr/en/Vouli-ton-Ellinon/Kanonismos-tis-Voulis/
13	Дани	Тогтоол	Standing Orders of the Danish Parliament http://www.thedanishparliament.dk/Publications/Standing%20Orders%20of%20the%20Folketing.aspx?page=all
14	Доминика	Тогтоол	STANDING ORDERS OF THE HOUSE OF ASSEMBLY http://www.assembly.nl.ca/business/standingorders/standing_orders.pdf
15	Ирак	Хууль	Rules of Procedure of the Assembly- http://assembly.coe.int/nw/xml/RoP/RoP-XML2HTML-EN.asp

16	Ирланд	Тогтоол	Standing Orders of the Northern Ireland Assembly http://www.niassembly.gov.uk/assembly-business/standing-orders/standing-orders/ http://www.oireachtas.ie/documents/proceduralDocuments/STANDING-ORDERS-ENGLISH.pdf
17	Итали	Депутатын дэгийн тухай журам	“Депутатын танхимын дэгийн тухай журам” 1922 батлагдаж, 1971, 1999, 2001, 2012 онуудад нэмэлт өөрчлөлт орсон. http://en.camera.it/4?scheda_informazioni=31
18	Канад	Тогтоол	STANDING ORDERS OF THE HOUSE OF COMMONS http://www.parl.gc.ca/About/House/StandingOrders/toc-e.htm
19	Кыргызстан	Хууль	Закон Кыргызской Республики. г.Бишкек, от 25 ноября 2011 года N 223. О Регламенте Жогорку Кенеша Кыргызской Республики http://www.kenesh.kg/RU/Articles/1099-Reglament.aspx
20	Казахстан	Тогтоол	Регламент Парламента Республики Казахстан. Постановление Парламента Республики Казахстан от 20 мая 1996 года http://www.parlam.kz/ru/regulation
21	Латви	Хууль	o Закон О Регламенте Сейма. 28 июля 1994 г. pravo.lv
22	Литви	Хууль	o S T A T U T E of the SEIMAS OF THE REPUBLIC OF LITHUANIA 1994 o www3.lrs.lt/pls/inter2/dokpaieska.showdoc_e?p_id=492370
23	Маврикий	Тогтоол	Standing Orders and Rules of the National Assembly 1995 онд батлагдсан, 2008 онд нэмэлт өөрчлөлт, www.mauritiusassembly.govmu.org
24	Мальт	Тогтоол	Standing orders of the House of Representatives 1964, www.parliament.mt
25	Македон	Тогтоол	Rules of procedure of the Assembly of the Republic of Macedonia www.parliament.am
26	Микронез	Тогтоол	Official rules of procedure of Congress of the Federated States of Micronesia www.publicofficialsfinancialdisclosure.worldbank.org
27	Молдав	Хууль	o Закон Республики Молдова от 2 апреля 1996 года №797-XIII О принятии Регламента Парламента. http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=3271
28	Нидерланд	Тогтоол	House of representatives of the Netherlands-rules of procedure 1994 он, www.houseofrepresentatives.nl
29	Норвеги	Тогтоол	The Norwegian Parliament Rules of Procedure and the Constitution 2001 он www.stortinget.no
30	ОХУ	Тогтоол	o О Регламенте государственной думы федерального собрания Российской Федерации. Постановление от 22 января 1998 г. n 2134-ii ГД. http://www.consultant.ru/law/review/lawmaking/reglduma/
31	Өмнөд Африк	Тогтоол	o Rules of the National Assembly-2008 http://www.parliament.gov.za/content/NA%20RULES%202014.pdf

32	Пакистан	Тогтоол	Rules of procedure and conduct of business in The national assembly-2007 http://www.na.gov.pk/uploads/publications/rules_procedure.pdf
33	Португал	Тогтоол	Rules of procedure of the Assembly of the Republic-2010 http://www.en.parlamento.pt/Legislation/Rules_of_Procedure.pdf
34	Польш	Тогтоол	The Standing Orders of the Sejm of the Republic of Poland http://oide.sejm.gov.pl/oide/images/files/dokumenty/standing_orders_2009.pdf
35	Сингапур	Тогтоол	Standing orders of the parliament of Singapore-2010 http://www.parliament.gov.sg/sites/default/files/Standing%20Orders%20%282010%29.pdf
36	Серби	Тогтоол	Rules of procedure of the National Assembly-2010 http://www.parlament.gov.rs/upload/documents/06.06.2014.%20ENG%20Rules%20of%20Procedure%20edit%202014.pdf
37	Словак	Хууль	ACT OF THE NATIONAL COUNCIL OF THE SLOVAK REPUBLIC No. 350/1996 ON RULES OF PROCEDURE http://www1.worldbank.org/publicsector/civilservice/epublishdocs/immunity/legislation/SlovakiaActNationalCouncil_on_rules_of_procedure.pdf
38	Словени	Тогтоол	Rules of procedure of the National Assembly-2002 https://www.dz-rs.si/wps/portal/en/Home/ODrzavnemZboru/PristojnostiInFunkcije/RulesoftheProcedureText
39	Солонгос	Хууль	National Assembly act-2014 http://korea.na.go.kr/res/low_02_read.jsp?boardid=1000000036
40	Турк	Тогтоол	Rules of procedure of the grand national assembly of turkey September 1, 1973. https://global.tbmm.gov.tr/docs/rules_of_procedure_en.pdf
41	Унгар	Тогтоол	Resolution 10/2014. (II. 24.) OGY on certain provisions of the Rules of Procedure http://www.parlament.hu/documents/125505/138409/Resolutio+on+certain+provisions+of+the+Rules+of+Procedure/968f2e08-f740-4241-a87b-28e6dc390407
42	Узбекистан	Хууль	Закон Республики Узбекистан «О Регламенте Законодательной палаты Олий Мажлиса Республики Узбекистан». Принят 29.08.2003 г. http://www.parliament.gov.uz/ru/regulations.php
43	Украин	Хууль	Закон України про регламент верховноу ради України (відомості верховноу ради україни (ввр), 2010, № 14-15, № 16-17, ст.133) Http://zakon2.rada.gov.ua/laws/show/1861-17
44	Франц	Тогтоол	Rules of procedure of the National Assembly January 2007 http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview
45	Финланд	Тогтоол	Parliament's rules of procedure 17 December 1999 (40/2000) www.legislationline.org/documents/id/15070
46	Хорват	Тогтоол	Standing Orders of the Croatian Parliament http://www.legislationline.org/download/action/download/id/2056/file/Croatia_StandingOrdershtm/preview

47	Чех	Хууль	o Rules of Procedure of the Chamber of Deputies http://www.psp.cz/en/docs/laws/1995/90.html#s1
48	Чрна Гора	Тогтоол	Rules of procedure of the parliament of Montenegro December 2010 http://www.parliament.am/library/kanonakarger/MONTENEGRO.pdf
49	Швейцар	Хууль	The Riksdag Act http://host.uniroma3.it/progetti/cedir/cedir/Lex-doc/Sv_riks-act.PDF http://www.riksdagen.se/en/How-the-Riksdag-works/Democracy/The-Constitution/The-Riksdag-Act---almost-a-fundamental-law/
50	Швед	Тогтоол	Standing Orders of the Council of States (<i>Status as of 1 June 2015</i>) https://www.admin.ch/opc/en/classified-compilation/20030743/index.html
51	Шинэ Зеланд	Тогтоол	Standing orders of the House of Representatives. 2014.08.15 http://www.parliament.nz/resource/en-nz/00HOHPBReferenceStOrders4/eb7c8b9e4a6c7aa88a47d14dc4100513b2557e60
52	Энэтхэг	Тогтоол	Дээд танхим: Rules of procedure and conduct of business in Lok Sabha. 2014 он. 15 дахь хэвлэл http://164.100.47.192/loksabha/rules/RULES-2010-P-FINAL_1.pdf
53	Эстони	Хууль	Закон о Регламенте и порядке работы Рийгигогу. Принят 11 февраля 2003 г. http://www.skylaser.ee/
54	Этиоп	Тогтоол	The House of Peoples Representatives Regulation No. 3/1998 “The House of Peoples Representatives of The Federal Democratic Republic of Ethiopia Rules of Procedures and Members Code of Conduct Regulation https://chilot.files.wordpress.com/2012/09/house-of-peoples-representatives-rules-and-code-of-conduct-regulation.pdf
55	Япон	Тогтоол	Дээд танхим: The Rules of the House of Councillors http://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

*Ц.Норовдондог, Ц.Болормаа
Ч.Онончимээг, Д.Халиун*

Судалгаанд АНУ, Нидерланд, ХБНГУ, Чех, Швед, Канад, Австрали, Шинэ Зеланд болон Энэтхэг улсын парламентад шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан Чиглүүлэх хөтөлбөр болон гишүүдийг олон талын мэдээллээр хангах зорилгын хүрээнд зохион байгуулдаг бусад уулзалт, семинарын талаарх мэдээллийг хамруулав.

Парламентын шинээр сонгогдсон гишүүдэд зориулан зохион байгуулах семинар, уулзалтын хөтөлбөрийн сэдвийн сонголт ихээхэн чухал бөгөөд энэ нь Парламентад шинээр сонгогдсон гишүүдийн тоо болон тэдгээрийн ажлын туршлагаас хамааралтай байна. Ихэнхдээ дараах сэдвүүдийг сонгох нь зохимжтой гэж үздэг байна. Үүнд:

- Тухайн улсын парламент болон түүний Тамгын газрын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээлэл
- Хууль тогтоох байгууллага болон бусад байгууллагын хоорондын харилцаа;
- Төрийн албаны өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага;
- Хууль тогтоох процесс, түүний тулгуур үндсэн зарчмууд (дэг);
- Төсөв, Санхүү;
- Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв, чиг хандлага;
- Гадаад бодлого, дипломат харилцаа;
- Парламентын гишүүний ёс зүй;
- Парламентын хяналт;
- Парламентын гишүүний онцгой эрх, үүрэг хариуцлага;
- Парламентын гишүүнд үйлчлэх байгууллагын үйл ажиллагааны онцлог, бүтээмжийг дээшлүүлэх боломж;

зэрэг сэдвүүдээр зохион байгуулах нь зохимжтой талаар IPU-аас зохион байгуулсан Парламентын Ерөнхий Нарийн бичгийн дарга нарын олон улсын уулзалтын үеэр гаргасан зөвлөмжид дурьдсан байна.

Түүнчлэн *Парламентын шинэ гишүүнд ямар Чиглүүлэх хөтөлбөрүүд зохион байгуулагдсан байх ёстой* талаар Олон Улсын Парламентын Холбооноос (IPU) гаргасан зөвлөмжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Шинээр сонгогдсон парламентын гишүүдийн Чиглүүлэх хөтөлбөрийг Парламентын Ордонд ирсэн буюу гишүүний үнэмлэхээ гардан авснаас хойш 2-3 дахь долоо хоногт;
- Хууль тогтоох үйл ажиллагааны талаарх семинарыг шинээр бүрэлдэн бий болсон парламентын анхны Ээлжит Чуулганы өмнө буюу сонгогдсоноос хойш 6-8 дахь долоо хоногт зохион байгуулах нь тохиромжтой гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд:

Австрали улсад: “Orientation Session” буюу шинэ гишүүдийн Чиглүүлэх семинарыг 4-5 долоо хоногт багтаан зохион байгуулах бөгөөд бусад уулзалт, семинарыг тухай бүрт нь зохион байгуулдаг байна.

АНУ-д: Ёс Зүйн Хорооны сургалтыг шинэ гишүүдэд 60 хоногийн дотор, шинээр сонгогдсон гишүүдийн туслах, зөвлөхүүдэд зориулсан сургалтыг 90 хоногийн дотор зохион байгуулдаг. Харин Чиглүүлэх хөтөлбөр болон гишүүдэд зориулсан бусад семинар, сургалтын мэдээлэл хаалттай байдаг байна.

Канад улсад: Шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан Захиргааны Чиглүүлэх Хөтөлбөр (*Administrative Orientation Program*)-ийг Парламентын Цогцолборт хүрэлцэн ирсэнээс хойш 2-3 дахь долоо хоногт багтаан Нийтийн Танхимын Тамгын газар зохион байгуулна. Тус Хөтөлбөрийн илтгэгчид нь Тамгын газрын олон жил ажилласан, туршлагатай албан хаагч экспертүүд парламентын хуучин гишүүд байна. Харин Процедурын Чиглүүлэх Хөтөлбөр (*Procedural Orientation Program*)-ийг шинээр бүрэлдсэн парламентын анхны Ээлжит Чуулганы өмнөх долоо хоногт Карлтоны Их Сургуультай хамтран зохион байгуулна.

Швед улсад: Шинээр сонгогдсон гишүүдийн *Танилцах хөтөлбөрийг* эхний долоо хоногт, Риксдаг дахь төсвийн процедурыг танилцуулах / Санхүүгийн байнгын хорооноос танилцуулга хийнэ/ хөтөлбөрийг эхний сард, хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой бусад хөтөлбөрүүдийг эхний сараас хойш төлөвлөн зохион байгуулна.

Шинэ Зеландад: Шинэ гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөрийг 14 хоногт багтаан Тамгын газраас зохион байгуулна.

Энэтхэг улсад: Парламентад шинээр сонгогдсон гишүүд болон парламентын гишүүд, ажлын албаны ажилтануудад 5-8 төрлийн сургалт зохион байгуулдаг байна.

	Улсын нэр	Сургалтын төрөл	Хаанаас зохион байгуулдаг	Зохион байгуулахад зохимжтой хугацаа
1	Австрали	-Чиглүүлэх уулзалт -Тогтмол уулзалт	-Төлөөлөгчдийн Танхимын Тамгын газар, Парламентын Танхимуудын ажлын алба	-4-5 дахь долоо хоногт -Тухай бүр
2	АНУ	-Шинэ гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөр -"Хууль тогтоох үйл ажиллагаа" семинар -Ёс зүйн сургалт -Туслах, Зөвлөхүүдийн сургалт	-Тамгын газар -Конгрессийн Судалгааны Алба, Тинк танк хамтран зохион байгуулна -Ёс зүйн Хороо -Тамгын газар	-Тусгайлан заагаагүй -Тусгайлан заагаагүй -60 хоногт багтаан -90 хоногт багтаан

3	Канад	-Захиргааны Чиглүүлэх Хөтөлбөр (Administrative Orientation Program) -Процедурын Чиглүүлэх Хөтөлбөр (Procedural Orientation Program)	-Нийтийн Танхимын Тамгын газар -Нийтийн Танхимын Тамгын газар Карлтоны Их Сургууль хамтран	-2-3 дахь долоо хоногт -анхны Ээлжит Чуулганы өмнө
4	Нидерланд	-Танилцуулах уулзалт -Сэдэвчилсэн сургалт	-Тамгын газар -Тамгын газар	-Тусгайлан заагаагүй -Тухай бүр
5	ХБНГУ	-Гишүүдэд Хөдөлмөр, татвар, цалин хангамж, эрүүл мэнд, ёс зүйн дүрмийн талаар өгөх мэдээлэл -Бундестагийн гишүүдийн сэдэвчилсэн сургалт (Тухайлбал Өргөдлийн байнгын хороонд өргөдөл хэрхэн шийдвэрлэх г.м)	-Тамгын газар -Тамгын газар, байнгын хороод	-Бүлгийн эхний хуралдаан дээр амаар мэдээлэл өгнө -Тухай бүр
6	Чех	Сенатын гишүүдийн сэдэвчилсэн сургалт	Тамгын газар	Тухай бүр
7	Швед	- Шинэ гишүүдийн <i>Танилцах хөтөлбөр</i> -Парламентын үйлчилгээ, бүтэц зохион байгуулалт - Мэдлэг, мэдээллийн үдэш -Төсвийн процедурын танилцуулга -Процедурын танилцуулга	-Тамгын газар -Тамгын газар -Судалгааны алба, Риксдагийн номын сан -Санхүүгийн байнгын хороод -Холбогдох алба, байнгын хороо, төрийн байгууллагууд	-Эхний долоо хоногт -Эхний долоо хоногт -Эхний сард -Эхний сараас хойш
8	Шинэ зеланд	-Шинэ гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөр	- Парламентын ажлын алба Клеркийн ажлын алба	-14 хоног
9	Энэтхэг	Парламентад шинээр сонгогдсон гишүүд болон парламентын гишүүд, ажлын албаны ажилтануудад 5-8 төрлийн сургалтыг зохион байгуулдаг.	Энэтхэгийн Парламентын сургалт, судалгааны товчоо сургалтуудыг хариуцан зохион байгуулдаг.	Хөтөлбөрөөс шатгаалан харилцан адилгүй байна. Ихэвчлэн хөтөлбөр тус бүр 2-3 хоног үргэлжилнэ.

Судалгааны товч дүгнэлт

Судалгаанаас үзэхэд, бусад орнуудад парламентын гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг чиглүүлэх болон тогтмол сургалт, семинарын хэлбэртэйгээр, тодорхой зарчмыг баримтлан хэрэгжүүлдэг бөгөөд ингэснээр парламентын гишүүдийг тухайлсан асуудлаар гүнзгий мэдлэг мэдээлэлтэй болгох, хууль тогтоогчийн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх чиг баримжаагаа хурдан олж авахад ач холбогдолтой хэмээн үздэг байна.

Тухайлбал, шинээр сонгогдсон парламентын гишүүдэд хууль тогтоох болон захиргааны процедурын талаарх мэдээлэл өгөх (чиглүүлэх) хөтөлбөрийг парламентын Тамгын газар, Сургалт судалгааны алба хариуцан тохиромжтой хэлбэрээр шуурхай зохион байгуулдаг бол бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай, цаг үеийн асуудлаарх сэдэвчилсэн (тогтмол) сургалтыг парламентын Сургалт судалгааны алба нь нэр хүнд бүхий хөндлөнгийн экспертүүд, гэрээт их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран зохион байгуулдаг байна.

1. АВСТРАЛИ УЛС

Австрали улсын парламентын (ерөнхий сонгууль) сонгууль нь 2013 оны Есдүгээр сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд шинээр бүрэлдэн бий болсон Төлөөлөгчдийн Танхимын нийт 42 шинэ гишүүдэд зориулан 2013 оны Аравдугаар сарын 15-ны өдөр “*Orientation Day*” нэртэйгээр Чиглүүлэх семинар зохион байгуулсан байна.

Австрали улс нь парламентын шинэ гишүүдэд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх арвин туршлагатай орон юм. Австралийн Төлөөлөгчдийн Танхим шинээр сонгогдсон гишүүдэд зориулан зохион байгуулдаг Чиглүүлэх семинар (*Orientation Session*) зорилго нь Парламентын Танхимуудын ажлын алба, түүний ажилтан албан хаагчид түүнчлэн Парламентын номын сан нь парламентын гишүүдэд мэргэжил, арга зүйн ямар туслалцаа үзүүлдэг болон тэдгээрийн ажлын үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх боломжтой талаарх мэдээллээр хангах явдал юм.

Хууль тогтоох байгууллагын гишүүний хувьд ажил мэргэжлийн онцлог нь гишүүдээс бүх талын мэдээлэл, үнэн зөв мэдлэг шаардагдах бөгөөд энэхүү хэрэгцээ шаардлагыг Парламентын ажлын алба хангахад хүрдэг тул дараах төрлийн мэдээлэл өгөх уулзалтуудыг тогтмол зохион байгуулахыг хичээдэг байна. Үүнд:

- Хууль тогтоох үйл ажиллагааны процесс (*Law-making process*),
- Эрх ямбын (*privilege*) сэдвээр жилийн турш тогтмол семинар зохион байгуулах,
- Айлчлал болон цаашдын хэрэгцээг үнэлэх судалгааны уулзалт зохион байгуулах,
- Цахим мэдээ мэдээлэлд хялбар нэвтрэх боломж бүхий порталын талаарх сургалт.

Австралийн Парламентын ажлын албанаас сүүлийн жилүүдэд парламентын гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, Чиглүүлэх семинар болон нийгмийн харилцааны олон талт асуудлаар тасралтгүй мэдлэг олгох, мэдээллээр хангах зорилго бүхий боловсролын хөтөлбөрүүдийг зохион байгуулж байна.

1. Гэвч, гишүүдэд зориулсан дараах хөтөлбөрийг хаалттай явуулдаг.
Үүнд:
2. Шинэ сонгогдсон гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөр

Парламент хоорондын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй сургалтууд нь хаалттай явагддаг тул Чиглүүлэх семинар болон Сургалтын хөтөлбөрүүд нь хаалттай байдаг байна.

Австралийн Парламентын Номын сан нь Төлөөлөгчдийн танхимын ажлын албатай хамтран шинээр сонгогдсон гишүүдэд зориулан 2014 онд “Танилцуулга: Хууль тогтоох үйл ажиллагааны процесс” сэдвээр танилцуулах семинар зохион байгуулсан талаар тайландаа дурьджээ. Тус семинараар Төлөөлөгчдийн Танхимын үйл ажиллагаа, түүний бүтэц (Хороодын тухай), тэдгээртэй холбогдох дүрэм журмуудын талаар нарийн мэдээллээр гишүүдийг хангасан байна. Түүнчлэн тус семинараар шинээр сонгогдсон гишүүдэд улс орондоо нэр нөлөө бүхий салбарын экспертүүд, Төлөөлөгчдийн Танхимын Тамгын газрын хуулийн экспертүүд, Номын сангийн Судалгааны албаныхан, Байнгын хороод, Парламентын болон Бизнес Мэдээллийн Үйлчилгээний Алба (Parliamentary and Business Information Services Office), Serjeant-at-Arms-ийн Албатай хамтран улс орны нийгэм эдийн засаг, гадаад бодлого, төрийн алба зэрэг олон асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлжээ. Мөн шаардлагатай гэж үзвэл Төсвийн албанаас шинэ гишүүдэд зориулсан Төсвийн талаар мэдээлэх уулзалт зохион байгуулдаг байна.

Эдгээр сургалт, хөтөлбөрүүд нь парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд шаардагдах бодлогын асуудлаар улс төрийн нөлөөллөөс ангид, тэнцвэртэй, үнэн зөв, бодит мэдээллээр хангах, мөн ийм орчинд тухайн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх боломж бүрдүүлэг байна.

Төлөөлөгчдийн Танхимын 2013/14 - 2014/15 оны ажлын тайлан¹⁶⁰гаас үзэхэд Тамгын газрын ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, Парламентын хамтын ажиллагааны хүрээнд явагдах сургалт, Төлөөлөгчдийн Танхимын спикер болон Сенатын ерөнхийлөгчдийн их сургуулиудтай байгуулсан гэрээний хүрээнд зохион байгуулагдах сургалтуудын талаар тайлан орсон байх бөгөөд парламентын гишүүдэд зориулсан зохион байгуулсан уулзалт семинар, хөтөлбөр, сургалтын талаарх мэдээллийг нээлттэй оруулаагүй байна.

2. АНУ

АНУ-ын Конгрессын гишүүдэд Конгрессын бүтцийн нэгжүүд болох Конгрессын Ёс зүйн хороо, Конгрессын Судалгааны албанаас, харин гадны байгууллагаас Харвардын Их сургуулийн Улс төрийн Дээд сургууль (Harvard, Institute of Politics)-аас сургалтууд тус тус зохион явуулдаг байна. Шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан сургалтыг аль болох төвийг сахисан, намын үзэл суртлаас ангид явуулахыг эрмэлздэг бөгөөд цаг үеийн асуудлаар улс орны нэр төртэй экспертүүдээс лекц сонсох, харилцан ярилцах боломжийг олгодог байна. Сургалт, хөтөлбөр нь олон нийтэд хаалттай байдаг.

Иймд доорх судалгааны мэдээллийг 114 дүгээр Конгрессийн дэг болон Конгрессын Судалгааны албаны ажлын тайлан эх сурвалжаас бэлтгэв.

¹⁶⁰ Annual report 2013-/14 http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Service/Legislation/PSC_Annual_Report_2013-14/Administration_of_the_Parliamentary_Service

Ёс зүйн хорооны сургалт

АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын дэг, 114 дахь Конгресс 2015

Ёс зүйн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 36

(6) (А) Тус хороо нь жил бүр Төлөөлөгчдийн танхимын Гишүүн, Төлөөлөгч, Байнгын төлөөлөгч (санал өгөх эрхгүй гишүүн–Пуэрто Рико), ажилтанд зориулан ёс зүйн сургалт зохион явуулна.

- 1) Хорооноос оролцох шаардлагатай гэж үзсэн албан хаагчдыг оролцуулах
- 2) Хорооноос Ёс зүйн дүрэм болон Төлөөлөгчдийн танхимын дэгээс шаардлагатай гэж үзсэн мэдээ, мэдээллийг оруулсан байх

(В)(i) Танхимын шинэ гишүүн, Төлөөлөгч, Байнгын төлөөлөгч, ажилтан нь Танхимд албан үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш 60 хоногийн дотор сургалтад хамрагдсан байна.

(ii) Жил бүрийн 1-р сарын 31-ний өдрөөс хэтрэлгүй Төлөөлөгчдийн танхимын ажилтан нь энэхүү хэсэг заасан сургалтад өмнөх ондоо багтан хамрагдсан болох баталгаа (батламж)-ийн хороонд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

Сургалтыг биечлэн, эсхүл онлайн оролцож болох бөгөөд шинэ гишүүн, ажилтанд ажлаасаа 90 хоногоос дээш завсардсан ажилтанг шинэ ажилтанд тооцно. Мөн 60 хоногоос дээш ажиллаж буй цалинтай дадлагажигч нь шинэ ажилтанд тооцогдох бөгөөд ёс зүйн сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

Конгрессын судалгааны алба

Конгрессын судалгааны алба нь шинээр сонгогдсон гишүүдэд зориулан семинар зохион байгуулдаг бөгөөд тус албаны 2015 оны үйл ажиллагааны тайлангаас үзэхэд 2015 оны 1-р сарын 9-12-ний өдрүүдэд Төлөөлөгчдийн танхимтай хамтран “Хууль тогтоох ажиллагаа” сэдэвт Шинэ гишүүдэд зориулсан Конгрессын үйл ажиллагаа, холбогдох дүрэм журмуудыг танилцуулах, таниулах зорилго бүхий семинарыг зохион байгуулсан байна. Тус семинараар шинээр сонгогдсон гишүүдэд улс орондоо нэр нөлөө бүхий салбарын экспертүүд болон Конгрессын Судалгааны албаныхан Конгрессын үйл ажиллагаанд хамаарах улс орны дотоод болон гадаад бодлогын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлжээ. Сургалт нь хууль тогтоох хүрээний бодлогын асуудлаар тэнцвэртэй/төвийг сахисан, улс төрийн нөлөөнөөс орчинд санал бодлоо хуваалцах боломжийг бүрдүүлэг байна. Дээрхээс гадна өнөөгийн хууль тогтоох процессын талаар өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд тусгай хуралдаанаар Танхимын дэг, журмын талаар танилцуулсан байна.

Харвардын Их Сургууль, Кеннедигийн Сургууль /Harvard, Kennedy School/

Конгресст шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан (Bipartisan Program for Newly-Elected Members of Congress) сургалт нь Төлөөлөгчдийн танхимд шинээр сонгогдсон гишүүдэд ажлын гараагаа эхлүүлэхэд нь дэм болох үүднээс хууль тогтоох үйл ажиллагаанд хамаарах асуудлаар сургалт, хэлэлцүүлэг зохион явуулж дэмжлэг үзүүлдэг юм.

Тус сургалтыг Улс төрийн дээд сургууль (*Institute of Politics*)-ийг түшиглэн 1972 оноос эхлэн 2 жил тутам явуулдаг бөгөөд сургалт нь дотоод болон гадаад бодлого, эрүүл мэндийн тогтолцоо, төсөв зэрэг олон тооны цаг үеийн асуудлын талаар салбарын нэр нөлөө бүхий мэргэжилтнүүд улс төрийн олон өнцгөөс мэдлэг, мэдээлэл олгодог. (2008 онд Эдийн засгийн хямрал: Конгресс хэрхэх вэ? Сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлгийг дараах хягаар орж үзнэ үү: <http://www.c-span.org/video/?282690-1/understanding-economic-crisis>)

Хөтөлбөрийн түгээмэл сэдвүүд:

- Эдийн засаг
- Даяаршил
- Цагаар ордон/Конгрессын харилцаа
- Конгрессийн дотоод ажил
- Холбооны төсөв
- Төсөв, санхүү (*Appropriations*)
- Нөлөө үзүүлэх (*Making an Impact*)

Өмнөх сургалтын илтгэгчид:

- Graham Allison, Харвард Кеннедигийн Хүрээлэн
- Stuart Butler, The Heritage Foundation; Fellow, Улс төрийн Дээд сургууль (Fall 2002)
- Eric Cantor, АНУ Төлөөлөгчдийн танхим
- Elaine Chao, Хөдөлмөрийн сайд асан
- Steven Chu, Эрчим хүчний сайд асан
- Adam Conner, Facebook
- Ken Duberstein, Цагаан ордон, Хүний нөөцийн дарга асан
- David Gergen, Харвард Кеннедигийн Дээд сургууль
- Caroline Kennedy, Жон Ф.Кеннедигийн номын сан
- David McCullough, Зохиолч
- David Pryor, АНУ-ын сенатор асан (D-AR); Улс төрийн дээд сургуулийн Ерөнхийлөгч асан
- Condoleeza Rice, Төрийн нарийн бичгийн дарга асан
- Larry Summers, Харвардын Их Сургууль
- David Walker, АНУ-ын Ерөнхий Нягтлан бодогч асан
- George Will, Зохиолч

Харвардын Их сургууль нь 2014 оны шинэ гишүүдэд зориулсан 21 дахь сургалтыг өмнөх хамтрагч болох Конгрессын Хүрээлэнгээс гадна 3 тинк танктай хамтран зохион байгуулахаар болсон бөгөөд тэдгээр нь *Brookings Institution*, *American Enterprise Institute (AEI)*, and *Center for Strategic and International Studies (CSIS)* юм. Эдгээр сонгож авсан тинк танкуудын улс төрийн үзэл суртал нь либералаас консерватив байгаа нь аль ч намд таалагдах сонголт гэж зохион байгуулагчид нь үзсэн байна.

Дээрх байгууллагуудаас зохион явуулж буй Шинэ гишүүдэд зориулсан сургалтаас гадна *Congressional Management Foundation (CMF)* сургалтууд зохион явуулдаг бөгөөд тус сан нь ашгийн бус байгууллага байх ба конгрессын үйл ажиллагаанд сургалт, семинар, судалгаа, менежментийн үйлчилгээ зэргээр иргэдийн оролцоог хангаж, дэмжиж ажиллах зорилготой

юм. Сангаас Танхимын Боловсон хүчний холбоотой хамтран шинээр сонгогдсон гишүүдийн туслах, зөвлөхүүдэд зориулан (*Navigating the First 90 Days*) сургалт зохион байгуулдаг байна.

3. КАНАД УЛС

Канадын Нийтийн Танхимд (доод танхим) олон төрлийн хүрээллээс Төлөөлөгчид сонгогдон, хууль тогтоох байгууллагад ард түмнийг төлөөлөх эрх авдаг. Гишүүд төрөл бүрийн мэргэжилтэй байхаас гадна нийгмийн гарлын хувьд ч харилцан адилгүй байдаг нь тэднийг нэгдсэн мэдээллээр хангах, гарааны нэг нөхцөлийг үүсгэх хэрэгцээ шаардлага бий болгодог. Одоогийн болон өнгөрсөн парламентын гишүүд нь бизнес, боловсрол, хууль, сэтгүүл зүй, инженер, урлаг, анагаах ухааны болон хөдөлмөрийн салбарын гэх мэт төрөл бүрийн мэргэжлийн төлөөлөгчид байна. Түүнчлэн, Канадад Нийтийн Танхимын гишүүнтэй дүйцэх цөөн тооны албан тушаал байдаг. Эдгээр шалтгааны улмаас ерөнхий сонгуулийн дараа Нийтийн Танхимын Тамгын газраас шинэ Гишүүдэд зориулж Парламентын Цогцолбор (*Parliament Hill*) болон тэдний үүрэгтэй танилцуулах сургалт болон Чиглүүлэх Хөтөлбөр зохион байгуулдаг.

Гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөр (*The Members' Orientation Program*)-ийн зорилго нь Нийтийн Танхимын бүх шинэ гишүүдийг парламентын гишүүний онцгой эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай захиргааны болон процедурын бүхий л мэдээллээр хангахад оршино.

Ерөнхий сонгуулийн дараа шинэ гишүүдийг угтах болон Гишүүдэд албаны аливаа асуудлаар зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой Танхимын ажлын албаны чухал мэдээллүүдийг авахад зориулагдсан, төв байршлыг хангасан “Чиглүүлэх Төв” (*Orientation Centre*) нээгдэнэ. (*Жишээлбэл, Нийслэл болон тойргийн хоорондын аялал, албан тасалгааны тохижилт болон гишүүдийн туслах, зөвлөх, төлөөлөгчдийг тохинуулах, Гишүүдийн төсөвт менежмент хийх гэх мэт олон асуудлууд хамаарна.*) Шинэ Гишүүдийг гишүүн болсноос эхлэн анхны ээлжит Чуулган хүртэл буюу Парламентын Цогцолборт хүрэлцэн ирсэн эхний хэдэн долоо хоногт Харилцааны ажилтан (*Liaison Officer*) хөтөч хийнэ.¹⁶¹

Шинэ гишүүдэд зориулсан дараах хоёр төрлийн нам бус, чиглүүлэх уулзалт семинар зохион байгуулдаг. Үүнд:

1. Захиргааны Чиглүүлэх Хөтөлбөр (*Administrative Orientation Session*) – Канадын Парламентын тухай хуульд (*The Parliament of Canada Act*) заасан Спикерийн үүрэг, Нийтийн Танхимын даргалагчийн үүрэг болон гишүүдийн үүрэг, арга хэмжээ болон дипломат дэг ёс, Ерөнхий Аудитор, Хүний эрхийн комисс, Сонгуулийн Хорооны дарга, Төрийн албан ёсны хэлийн Комиссар, Төрийн нууцын Комиссар, Төрийн мэдээллийн Комиссар гэх мэт албан тушаалтны үүрэг болон холбогдох бусад мэдээлэл багтана. Тус Хөтөлбөрийг шинэ гишүүд сонгогдсоноос хойшхи 2-3 долоо хоногт багтаан зохион байгуулна.

2. Процедурын Чиглүүлэх Хөтөлбөр (*Procedural Orientation Session*) - Танхим болон байнгын хороод, тэдгээрийн үйл ажиллагаан дахь Гишүүний

¹⁶¹ <http://www.parl.gc.ca/About/House/OntheJob/Orientation-NewMP-e.html>

үүргийн талаарх буюу хууль тогтоох үйл ажиллагаанд Гишүүн хэрхэн оролцох, тэдэнд ямар боломж буй талаарх гэсэн хоёр төрлийн сургалт буюу чиглэл олгох уулзалт зохион байгуулдаг байна. Тус Хөтөлбөрийг Парламентын анхны Ээлжит Чуулганы өмнө зохион байгуулна.

Танхимын Тамгын газрын Чиглүүлэх Хөтөлбөр нь шинэ Гишүүдэд дэмжлэг үзүүлэх болон сургалтын иж бүрэн хөтөлбөр байна.

Канад улсын хувьд 2015 оны 11 сарын 5-ны өдөр шинэ Гишүүдийн Захиргааны Чиглүүлэх Уулзалтыг (*Administrative Orientation Session*) Нийтийн Танхимын ажлын алба зохион байгуулсан бөгөөд уулзалтыг Нийтийн Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга нээж, урьдчилан бэлдсэн хөтөлбөрийн дагуу холбогдох илтгэлүүдийг тавина. Мөн туршлагатай Парламентын гишүүн хууль тогтоох үйл ажиллагаанд анхаарвал зохих асуудлаар зөвлөгөө өгнө.

Процедурын Чиглүүлэх Хөтөлбөрийг Анхны Ээлжит Чуулганы өмнө 2016 оны 1 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд Карлтон Их Сургуультай хамтран зохион байгуулсан байна.

Судалгаанд Канадын Нийтийн Танхимаас 2015 оны 11 дүгээр сард гаргасан шинэ Гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөрийн талаар “Fact sheet”-д тусгасан Хөтөлбөрийг орчуулан хүргэж байна.

Шинэ Гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөр-2015¹⁶²

Нийтийн Танхимын бүх шинэ Гишүүдэд өөрсдийн хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор Захиргааны болон Процедурын шаардлагатай мэдээллээр хангахын тулд Нийтийн Танхимын Тамгын газраас Гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөрийг зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн тойм:

- Эхний ээлжинд Гишүүдийг чиглүүлэх зорилгоор Харилцааны ажилтныг Нийтийн Танхимын Тамгын газраас хөтөчөөр томилно.
- Мэдээллийг цаг тухайд нь, хялбар олж авах зорилгод нийцүүлэн сүлжээнд холбох, Гишүүний Вэб хуудас нээнэ. Хөдөлгөөнт холбоонд суурилсан, хэрэглэхэд хялбар төрөл бүрийн тоног төхөөрөмжөөр хангах, холбох.
- Шинэ гишүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Гишүүдийн Чиглүүлэх Төв” (*Member’s Orientation Centre*)-ийг Парламентын Цогцолборт анх удаа байгуулсан.
- Танхимын Тамгын газрын мэргэжилтнүүдийн уулзалт зохион байгуулна. Үүнд Төлбөр болон Орлогын талаар, Санхүүгийн үйлчилгээ, Мэдээллийн үйлчилгээ, Нийтийн Танхимын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн дарга, Парламентын Консул гэх мэт экспертүүдийг хамруулсан уулзалт зохион байгуулна.

Шинэ гишүүдэд чиг баримжаа олгох 2 төрлийн уулзалт семинар зохион байгуулна. Үүнд:

- 1. Захиргааны Чиглүүлэх Уулзалт семинар (2015 оны Арваннэгдүгээр сарын 5-ны өдөр зохион байгуулсан. Сонгууль 2015 оны Аравдугаар сарын 19-нд болсон.)**

¹⁶² FACT SHEET: Members’ Orientation Program. House of Commons CANADA, November 2015

2. *Процедурын Чиглүүлэх Уулзалт семинар зохион байгуулна.*
(2016 оны Нэгдүгээр сарын 19.20-ны өдрүүдэд буюу Парламентын Анхны Ээлжит Чуулганы өмнө зохион байгуулсан)

Гишүүд болон гишүүдийн туслах, зөвлөхүүдийг хамруулан парламентын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг, хамтран ажилладаг Нийтийн Танхимын Тамгын газар, Парламентын Номын сан, Сонирхлын зөрчил болон Ёс зүйн Комисс, Төрийн алба, Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулна.

Гишүүдийн Чиглүүлэх Төв (Members' Orientation Centre)

Гишүүдийн Мэдээллийн Төв нь Парламентын Цогцолборт байрлах бөгөөд шинэ Гишүүдийн бүрэн эрх баталгаажин, ажиллах нөхцөл бүрдэх хүртэл туслалцаа үзүүлэх түр нэгж юм. Энэхүү түр оффис нь дараах үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Компьютер, утас, факс, принтер болон хувилагч зэрэг албан хэрэгцээний тоног төхөөрөмж бүхий түр албан өрөөгөөр хангах,
- Шуудангийн үйлчилгээ, түр шуудангийн хаяг,
- Ажлын үнэмлэх

Тус төв нь харилцааны ажилтан, Төлбөр болон Орлого, Санхүүгийн үйлчилгээ, Хууль зүйн асуудал хариуцсан Нарийн бичгийн дарга, Парламентын үйлчилгээ болон Мэдээлэл технологийн үйлчилгээгээр хангаж, туслалцаа үзүүлнэ.

Харилцааны ажилтан гэдэг нь шинэ Гишүүдэд парламентын үйлчилгээний талаар нарийвчилсан мэдээлэл өгөх үүрэг бүхий ажилтан байх бөгөөд Нийтийн Танхимын Тамгын газрын туршлагатай албан хаагч байна. Тэдний үндсэн үүрэг нь Гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагаан дахь Захиргааны болон Процедурын хөтчийн үүрэг гүйцэтгэнэ.

Захиргааны Чиглүүлэх Хөтөлбөрт: Энэ Хөтөлбөрт Нийтийн Танхимын шинэ гишүүний санхүүгийн болон хууль зүйн хувьд хүлээх үүрэг, Нийслэл болон сонгогдсон тойрог дахь албан хэрэг, анхаарвал зохих асуудлууд болон түүний хууль тогтоох ажил гэр бүлд нь ямар нөлөө үзүүлж болох тухай мэдээллүүд багтана. Энэ Хөтөлбөрийг шинээр сонгогдсон гишүүд Парламентын Ордонд ирсэн эхний хэдэн долоо хоногуудад багтаан зохион байгуулна.

Процедурын Чиглүүлэх Хөтөлбөр: Энэ Хөтөлбөрийг Парламентын Анхны Ээлжит Чуулган эхлэхээс өмнө зохион байгуулна. Тус хөтөлбөр нь Гишүүдийг Танхимын болон байнгын хороодын хуралдааны бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хууль тогтоох үйл ажиллагаанд хэрхэн оролцох тухай цогц сургалт байдаг. Түүнчлэн Чуулганы болон байнгын хороодын хуралдааны дэгийн талаар цогц мэдээллээр хангана.

Процедурын Чиглүүлэх Уулзалтын хөтөлбөр:

“Таны Танхим, Таны цаг” шинэ Гишүүдэд Процедурын Чиглүүлэх Уулзалтын хуралдааны тэмдэглэлээс¹⁶³

¹⁶³ <http://carleton.ca/parldiplo/wp-content/uploads/January-20-Event-Notes.pdf> (“Your House, Your Time: Orientation for the 2015 newly elected Members of Parliament”):

2015 онд болсон ээлжит сонгуулиар бүрдсэн Нийтийн Танхимын 60 гаруй шинэ Гишүүдэд зориулсан 2016 оны нэгдүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан чиглүүлэх хөтөлбөрийн холбогдох мэдээллийг тоймлон оруулав.

2015 онд сонгогдсон шинэ Гишүүдийн Чиглүүлэх Хөтөлбөрийг Карлтоны Их сургуулийн Парламентын болон Дипломат албаны Карлтоны Санаачлага (2011 онд байгуулагдсан) -ын нэгжтэй хамтран зохион байгуулсан байна.

Хөтөлбөрт тавигдсан илтгэлүүд, илтгэгчид, модераторуудаас:

Энэ удаагийн Чиглүүлэх Хөтөлбөрт улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан болон одоо тус албан тушаалуудад ажиллаж буй нийт 22 мэргэжлийн экспертүүдийг оролцуулан зохион байгуулсан байна.

Оттава хэрхэн ажилладаг вэ (How Ottawa Work) -Төрийн албаны өнөөгийн нөхцөл байдал, бүтэц, зохион байгуулалт, ажиллах хүчний бүтэц, орон тоо, нөөц, чиг үүрэг, холбогдох хууль тогтоомж, холбогдох байгууллагууд болон бусад асуудлыг багтаасан 17 слайд бүхий илтгэл. Илтгэгч: Засгийн газрын Ажлын албаны Орлогч дарга.

Энэ илтгэлийн хүрээнд: ***“42 дахь Парламентын өөрчлөлт, шилжилт: Төрийн албаны үүрэг болон улс төрийн систем дэх харилцан хамаарал, Улс төрийн системд хэрхэн ажилладаг”*** сэдвээр хэлэлцүүлэг явуулна. Тэргүүлэх оролцогчид:

- Audrey O'Brien (Нийтийн Танхимын чөлөөнд гарсан Ерөнхий Нарийн бичгийн дарга)
- David McLaughlin, (Ерөнхий Сайдын Төрийн бодлогын зөвлөх)
- David Mitchell, (Төрийн Бодлогын Форумын Гүйцэтгэх захирал, Төрийн бодлогын Зөвлөх, Мужийн хууль тогтоох байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч асан)

Хэрхэн үр дүнтэй ажиллах вэ (How to work effectively in Ottawa)
Илтгэгч: Karen Shepherd, Лобби Комиссар¹⁶⁴

КАНАД: Бэрхшээл ба Боломж

- Эдийн засгийн төлөв байдал
- АНУ-ын төлөв байдал
- Түүхий эдийн үнийн индекс
- Бага хугацаатай хүүгийн хувь
- Ажиллах хүчний өсөлт зэрэг өнөөгийн төлөв байдал. Илтгэгч: Glen Hodgson, (Conference Board of Canada¹⁶⁵ -ын ахлах эдийн засагч)

30 жил: Канадын улс төрөөс бид юуг суралцах вэ? Илтгэгч: Bruce Anderson, (Абакус Дата¹⁶⁶-ийн дарга)

Дээрх илтгэлүүдийн хүрээнд: ***“Канадын эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн бодит байдал болон бэрхшээл, бизнес, хөдөлмөр, орон нутгийн төлөв”*** сэдэвт хэлэлцүүлэг зэрэг хөтөлбөртэй 2 өдрийн уулзалт зохион байгуулсан байна.

¹⁶⁴ Парламентаас 7 жилийн хугацаагаар томилогддог агент. Төрийн албаны ил тод, нээлттэй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй.

¹⁶⁵ Conference Board of Canada-Нийгэм, эдийн засаг, өрсөлдөх чадварын судалгааны байгууллага

¹⁶⁶ Abacus Data- Сонгууль, олон нийтийн санаа бодол болон зах зээлийн судалгааны фирм

4. НИДЕРЛАНД УЛС

Сонгуулийн дараа зохион байгуулах ажлуудын нэг нь Парламентын шинэ гишүүдэд зориулж танилцуулга сургалт зохион байгуулах ажил юм. Төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааг танилцуулах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулж ирсэн. Анх 7 хоногийн хугацаатай танилцах сургалт зохион байгуулж байсан нь шинээр сонгогдсон парламентын гишүүдийн намын ажил, спикерыг сонгох, засгийн газраа байгуулах зэрэг олон ажилтай байдгаас сургалтад төдийлөн идэвхтэй хамрагдах боломж бололцоогүй, зарим тохиолдолд сургалтын төгсөлд ердөө 1-2 гишүүн үлдсэн байдаг байснаас үүдэн сургалт болон гишүүдэд зориулсан үйлчилгээг тогтсон нэг цагт баригдалгүй, нэг цэгээс уян хатан байдлаар олгох тал дээр анхаарах нь чухал гэж үзсэн байна. Ийнхүү нэг өрөөгөөр ороод гарахад гишүүд шаардлагатай ажлын үнэмлэхүүд, и-мэйл хаяг, компьютер, утасны дугаар болон шаардлагатай мэдээ, мэдээллийн хавтас зэрэг бүхий л мэдээлэл, үйлчилгээгээ авах боломжтой юм. Тамгын газрын гол зорилго нь сонгуулиас хойших 8 хоногийн дотор гишүүдийг тангараг өргөхөд бүх шаардлагуудыг хангаж байгааг нягтлан, ямарваа нэгэн саадгүй бэлэн болгох явдал юм. Энэ хугацаанд гишүүдийн хувийн хэргийг бүрдүүлж, албан ёсны гэрэл зургийг татаж, Төлөөлөгчдийн танхимын вебсайтад ярилцлагын оруулдаг байна.

Албан ёсны дэмжлэг үзүүлэх баг

Зарим тохиолдолд цоо шинэ нам сонгогдох тохиолдлууд гардаг бөгөөд тухайлбал 2002 онд 26 гишүүний бүрэлдэхүүнтэй цоо шинэ нам Төлөөлөгчдийн танхимд сонгогдсон байна. Тус намаас сонгогдсон гишүүдийн нэг нь ч өмнө нь Парламентад ажиллаж байсан туршлагагүй байснаас үүдэн албан ёсны дэмжлэг үзүүлэх багийг байгуулсан байна. Албан ёсны дэмжлэг үзүүлэх баг нь гишүүдэд парламентын үйл ажиллагааны процессыг нарийвчлан зааж сургадаг. Шинээр сонгогдож буй намуудад албан ёсны зөвлөгчдийг хэдэн сарын хугацаатай томилж өгдөг бөгөөд тэдгээр нь бүхий л үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Уян хатан байж, дасан зохицох

Шинээр сонгогдсон гишүүдийг хүлээж авч, парламентын үйл ажиллагаатай танилцуулах нь Тамгын газраас уян хатан байдал, дасан зохицох чадварыг ихээхэн шаарддаг. Менежментийн багаас шинэ гишүүдэд үзүүлэх үйлчилгээ, сургалт хариуцсан төслийн ахлагчийг томилно. Ахлагч нь сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулах үүрэгтэй байна. Бүртгэл, хууль зүйн үйлчилгээ, Байнгын хороодын ажилтнууд болон бусад хэлтсүүд нь үйл ажиллагааныхаа чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулдаг ба гишүүд нь шаардлагатай гэж үзсэн сургалтандаа өөрсдийн боломжтой гэсэн цагтаа хамрагдах боломжтой бөгөөд зарим тохиолдолд гишүүдийн захиалгын дагуу ганцаарчилсан сургалт явуулдаг байна.

Танилцах уулзалт

Танилцах сургалт нь бүрмөсөн алга болоогүй бөгөөд чуулганы хуралдаантай холбоотой үйл ажиллагаа зэргийг товч танилцуулгыг хийдэг харин

гүнзгийрүүлсэн, сэдэвчилсэн сургалтыг дараа дараагийн шатанд явуулдаг. Тухайлбал, төсөв, Европын Нэгдсэн зах зээл, хууль тогтоох үйл ажиллагаа зэрэг сэдвүүдийг гүнзгийрүүлэн судалдаг байна.

5. ХБНГУ

Германы Бундестагийн хувьд шинээр сонгогдсон гишүүдэд парламентын үйл ажиллагааг танилцуулах ажлын парламентын захиргааны олон нэгжүүд хариуцан явуулдаг. Холбогдох ерөнхий мэдээллийг Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга Гишүүдэд түгээх бөгөөд гишүүдийн бүрэн эрхийн хугацааны эхний шатанд хийгдэх ажлуудыг танилцуулж, дараагаар нь шинэ гишүүдэд зориулан практик ач холбогдол бүхий нарийвчилсан мэдээ, мэдээлэл олоход анхаардаг байна.

Сонгуулийн дараа Германы Бундестагийн Нарийн бичгийн дарга нь бүх гишүүдэд албан бичгийн хамт парламентын мандаттай холбоотой бүхий л хууль эрх зүй, санхүү болон практик ач холбогдол бүхий мэдээ, мэдээллийг гарын авлага, санамж бичиг хэлбэрээр хүргүүлдэг байна. Эдгээрт гишүүдэд зориулсан баримт бичгүүдэд: Шинэ Бундестагийн чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалт, шинээр батлах Дэгийн төсөл, сонгууль болон санал өгөх санамж бичиг болон асуулга тавих, асуултын хариуг сонсох, хэлцэх удирдамж зэрэг орж байна. Парламентын Тамгын газар нь Гишүүдийн туслах, зөвлөхүүд болон парламентын бүлгүүдийн ажилтнуудад зориулан Гишүүдийн асуулт асуух, асуулга тавих, хуулийн төсөл бэлтгэх зэрэг чуулганы хуралдаанд бэлтгэхэд нь зориулан мэдээллийн цагаар хэрэгтэй мэдээ, мэдээллийг нь өгдөг байна.

Үүнээс гадна Гишүүдэд Бундестагийн гишүүдийн бүрэн эрхийн тухай баримт бичиг бэлтгэн хүргүүлдэг байна. Түүнчлэн Гишүүдийн цалин хөлсний талаарх тайлбарын хамт Гишүүний албан өрөөг тохижуулах төсөв, нэмэлт өрөө тохижуулах зардал, Гишүүний мандаттай холбоотой аялал болон төлөөллийн үүрэгтэй холбоотой зардлууд багтаж байна. Парламентын мандатыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмууд нь мэдээллийн нэгэн чухал хэсэг бөгөөд эдгээр нь Германы Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль болон Германы Бундестагийн ёс зүйн дүрэмд тус тус тусгасан байна. Ёс зүйн дүрэмд парламентын мандатаас гадна цалин хөлс бүхий үйл ажиллагаа, хандив зэргийг мэдэгдэх, мэдээлэх зэрэг орсон байна. Татвар, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тэтгэвэр зэргийн талаар тайлбар зэрэг ордог бөгөөд холбогдох хуулиудын хувийг хүргэдэг байна. Гишүүдэд туслах ажилтнуудыг ажилд авахад нь хөдөлмөрийн хууль, дүрэм, хөдөлмөрийн гэрээний загвар олгох зэрэг дэмжлэг, удирдамжаар хангадаг байна. Энэхүү салбарын хариуцсан захиргааны ажилтнууд нь парламентын бүлгүүдийн эхний уулзалтууд дээр мөн амаар мэдээ, мэдээлэл өгдөг байна.

Шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийн гол эх үүсвэр нь Гишүүний удирдамж байна. Удирдамж нь захиргаа, судалгаа болон техникийн үйлчилгээний талаарх мэдээллээс гадна чухал шаардлагатай утасны жагсаалт, парламентын өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах мэдээ, мэдээлэл багтсан байна.

Үүнээс гадна Герман Бундестагийн захиргаанд гишүүдийн албан өрөө, техник хэрэгслийн хангамж хариуцсан нэгжүүд байх бөгөөд тэдгээр нь өрөө, тасалгаа, техник хэрэгсэл, утас зэрэг шаардлага тоног төхөөрөмжөөр хангана.

Парламентын бүлгүүд нь шинэ гишүүдийг ажилдаа хөл тавихад нь ихээхэн үүрэгтэй бөгөөд парламентын бүлгийн анхны хуралдаанаар Парламентын нарийн бичгийн дарга нар нь парламентын бүлгүүдэд шаардагдах техник үйлчилгээний талаар танилцуулна. Парламентын бүлгүүд нь мөн хороод болон Бундестагийн бусад албан тушаалтны томилгоог хариуцдаг тул гишүүдэд урьдчилан аль нэг хороо эсхүл бусад албанд ажиллах хүсэл сонирхлынх нь талаар тандалт анкет судалгаа явуулна.

Хороодын гишүүд тодорхой болсны дараагаар Будестагийн Захиргааны ажилтнуудаас бүрдэх хороодын ажилтнууд нь шинэ гишүүдэд зориулан хороодын үйл ажиллагааг танилцуулна. Гишүүдэд мөн судалгааны хэсгийн үзүүлж буй гишүүдийн захиалгын дагуу судалгаа, анализ, статистик лавлагааг гаргах зэрэг үйлчилгээний талаар танилцуулдаг байна. Судалгааны хэлтсийн судалгааны чиглэл нь хороодын чиг үүрэгтэй уялдах бөгөөд судлаачид нь ихэвчлэн хуульч, эсхүл түүх, эдийн засаг/бизнес менежмент, байгалийн шинжлэх ухаан, улс төс судлал зэрэг мэргэжилтэй байдаг байна. Дээрх сургалтуудад гишүүдийн туслах, зөвлөхүүд нь мөн оролцох эрхтэй байдаг. Үүнээс гадна Өргөдлийн байнгын хороо зэрэг тусгай чиг үүрэгтэй байнгын хороодод өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан сургалтууд зохион байгуулдаг байна.

Түүнчлэн дээрх сургалтуудаас гадна жил бүр хэрэгждэг хоёр Олон улсын парламентын тэтгэлэгт хөтөлбөр байдаг бөгөөд ихэвчлэн гишүүдийн бүрэн эрхийн хугацааны эхэнд Бундестагийн Ерөнхийлөгч гишүүдэд сайн дурын үндсэн дээр оролцохыг уриалдаг байна. Хөтөлбөр нь дэлхийн 25 орны залуучуудад парламентын үйл ажиллагаатай, улс төрийн шийдвэр гаргах процесстой танилцах чиг үүрэг бүхий Бундестагт 4 сарын хугацаатай дадлага хийх боломж байдаг бол Конгресс-Бундестагийн Залуучууд Солилцооны хөтөлбөрийн хүрээнд гишүүдийн өөрсдийн тойргийн оюутан эсхүл мэргэжилтнүүдэд АНУ-д улсад суралцах нэг жилийн тэтгэлэг олгодог байна. Аль аль тохиолдолд гишүүдэд Бундестагийн захиргаанаа бүхий л асуултад хариулах бөгөөд асуулт нь парламентын ордонд болж буй асуудлыг хэрхэн зохих дэмжлэг тусалцааг үзүүлдэг байна.

6. ЧЕХ УЛС

Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуульд Сенатын гишүүдийн гуравны нэгийг хоёр жил тутам сонгохоор заасан байдаг тул хоёр жилд дээд тал нь 27 шинэ гишүүн сонгогддог байна. Зарим сенаторууд нь дахин сонгогддог тул шинээр сонгогдож буй гишүүний тоо 18-24 хооронд хэлбэлзэж байдаг. Сонгогдмогц сенаторууд нь цалин хөлс болон бусад олговор, хөнгөлөлт эдлэх эрхтэй байна. Сенаторууд нь Дотоод хэргийн яамнаас сонгуулийн батламж, мөн анх дугаар чуулганаар тангаргаа өргөснөөр бүрэн эрх нь албан ёсоор хэрэгжиж эхэлнэ.

Сенатын Канцлерын албаны чиг үүрэг

Канцлерын албаныхан нь гишүүний бүрэн эрх эхлэхээс өмнө бэлтгэл хангах эхлэх бөгөөд хуульд заасны дагуу Канцлерын албаны гол чиг үүрэг нь Чех Улсын Парламентын Дээд танхимын үйл ажиллагаанд шаардагдах бүхий л боловсон хүчин, зохион байгуулалт болон зохих техник хэрэгслийг бүрдүүлж, хангахад оршино. Үүнээс гадна Сенатын барилга байгууламжид тогтмол бус шинж чанар бүхий олон нийтэд зориулсан сургалт, нийгэм соёлын арга хэмжээнүүдийг зохион явуулж болохоор заасан байдаг байна.

Сенаторуудад үзүүлэх мэдээ, мэдээллийн үйлчилгээ

Албан үүргээ хүлээж авмагцаа Сенаторууд суурь мэдээ, мэдээлэл болон голлох баримт бичгүүдийг хүлээн авдаг. Үүнд холбогдох хууль эрх зүйн эмхтгэл, Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын дэг, Хороодыг тогтоолуудын хуулбар болон загвар, Сенатын долоо хоногийн хэлэлцэх асуудлыг жагсаалтыг загвар, Сенатын Канцлерын албанаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээлэл, шаардлагатай утасны жагсаалт болон Сенатын сэтгүүлийн сүүлийн хоёр дугаар, санал хураалтын төхөөрөмжийн гарын авлага, Сенатын өмнөх жилийн үйл ажиллагааны танилцуулга бүхий CD-гом зэрэг мэдээ, мэдээлэл зэрэг багтдаг байна.

Дараах процедурууд улс төрийн болон захиргааны гэсэн хоёр түвшинтэй байх бөгөөд улс төрийн түвшинд: улс төрийн намын бүлгийн гишүүнчлэлийн асуудал байх юм. Сенаторууд нь одоо байгаа бүлэг, эвсэлд элсэх /доод тал нь 5 гишүүн/, эсхүл бие дааж болох юм. Бүлэг, эвсэлд нэгдэх нь нэн чухал ач холбогдолтой бөгөөд тус бүлгүүд хороодын зохион байгуулалт, бүтэц бүрэлдэхүүн, албан тушаал /Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, хороо болон комиссын дарга/-тны томилгоо зэргийн хэлэлцэх юм.

Захиргааны түвшинд нэн тэргүүний ээлжид боловсон хүчний асуудал сөхөгдөх бөгөөд /Сенаторын үнэмлэх, дипломат паспорт олгох зэрэг/. Сенаторуудад албан тасалгаа олгож, тохижуулалтаар хангана. Хууль эрх зүйн нэгж нь Сенаторуудын байгуулах бүхий л гэрээнүүдийг бэлтгэж өгнө. Үүнд: туслах ажиллуулахад хөдөлмөрийн гэрээ, тойрогтоо оффис байгуулахад түрээсийн гэрээ зэрэг гэрээнүүд орж байна. Боловсон хүчин хариуцсан нэгж нь цалин хөлс, техник, захиргааны ажлын зардал зэрэг санхүүтэй холбоотой бүхий л асуудлыг хариуцдаг байна.

Сенаторуудад зориулсан семинар, цуглаан

Сенатын Канцлерын албанаас төсвийн жил бүрийн төгсгөлд уламжлал болсон Сенаторууд болон тэдгээрийн туслахуудтай уулзалт зохион байгуулдаг бөгөөд тус уулзалтаар хамтын ажиллагаа, харилцаа холбооны талаар хэлэлцдэг байна. Канцлерын алба нь хууль тогтоох үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаа, төлөвлөж буй өөрчлөлт шинэчлэлтийнхээ талаар танилцуулж, мэдээлдэг байна. Уг арга хэмжээгээр Канцлерын албаны удирдлагууд нь өөрсдийгөө болон үйл ажиллагаа танилцуулж, Сенаторуудыг хэрэгтэй мэдээллээр нь хангах боломж олгодог байна.

Дээрх уулзалтуудаас гадна Сенатын Канцлерын алба нь Парламентын Хүрээлэнтэй хамтран Сенатын ажилд хамаарах асуудлаар семинарууд

зохион байгуулдаг байна. Сүүлд зохион байгуулсан семинар нь Сенатордын мандат, хууль тогтоох үйл ажиллагаа болон Сенатын чиг үүрэг сэдвээр явагдсан байна. Семинары сэдвүүд нь ихэвчлэн Европын холбооны хэлэлцэх асуудал, баримт бичгийн хүрээтэй уялдаж байдаг байна.

7. ШВЕД УЛС

Танилцах хөтөлбөр

1994 оны сонгуулиас хойш тусгай танилцах хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна. Шинээр сонгогдсон гишүүдэд зориулан танилцуулга-сургалт зохион байгуулдаг бөгөөд үүн дээр нам тус бүр шинэ гишүүддээ зориулан өөрсдийн нам-улс төрийн сургалтыг зохион явуулдаг байна.

Танилцах сургалт эхлэхээс өмнө бүх гишүүдэд зарим мэдээллийг и-мейлээр, Риксдагийн хуралдаанд зарлан дуудаж буй албан бичгийг хүргүүлдэг байна. Албан бичгийн хамт Риксдагийн тухай ерөнхий мэдээлэл, Риксдагийн захиргааны чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон цалин хөлсний талаарх зэрэг хамгийн шаардлагатай мэдээллийг багтаасан гарын авлагын хамт хүлээн авдаг байна. 2006 онд гарын авлагыг шинэчлэн гаргасан бөгөөд тус гарын авлагад Танхим болон байнгын хороод, парламент хоорондын хамтын ажиллагааны талаарх мэдээллийг нэмэлтээр оруулсан байна.

Шинэ болон дахин сонгогдсон гишүүдэд Риксдагд үйлчилгээ үзүүлдэг нэгжүүдийн талаарх мэдээллийг талаарх товхимлыг олгодог.

Риксдагийн Ерөнхий нарийн бичгийн дарга нь шинэ гишүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулах, Парламентын сонгуультай холбоотойгоор Риксдагийн захиргаанаас хийгдэх ажлуудыг зохион байгуулах төслийн багийг томилдог. Төслийн баг Риксдагийн Захиргааны албаны нэгжүүдийн ажилтнуудаас бүрдэх ажлын хэсгүүд тодорхой ажлууд /гарын авлага бэлтгэх гм/-ыг хариуцан ажилладаг байна. Хөтөлбөрийг боловсруулах явцад Хөтөлбөрийн үндсийг Гишүүдийн асуудал хариуцсан зөвлөл болон намын бүлгүүдийн ажлын албаны дарга нартай зөвшилцдөг байна.

Танилцах хөтөлбөрийн удирдамж

Эхний долоо хоногт:

- Риксдагийн цогцолбортой танилцах /Шинэ гишүүдэд парламентын барилга байгууламж, зохион байгуулалтыг танилцуулах/
- Риксдагийн зохион байгуулалт, үйл ажиллагааны процедур болон үзүүлж буй үйлчилгээ /Танхимын үйл ажиллагаа, байнгын хороод болон парламентын албадын үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээг танилцуулах/
- Риксдагийн компьютерийн сүлжээг танилцуулах /Риксдагийн компьютерийн сүлжээг танилцуулж, гишүүдэд техник тоног төхөөрөмжийг тохиргоог хийж, дотоод сүлжээнд ажиллах сургалт зохион байгуулах/

Эхний сард:

- Риксдаг дахь төсвийн процедурыг танилцуулах /Санхүүгийн байнгын хорооноос танилцуулга хийнэ/
- Аяллын Tur & Retur системийг ашиглах /Аяллын дүрэм журам, аяллын зардлыг бүртгэх гм/
- Байнгын хороодын ажиллагаа /Анхдугаар чуулганыг нээж явуулсны дараа байнгын хороо тус бүр өөрсдийн үйл ажиллагааны талаар товч танилцуулдаг, үүний дараа байнгын хороод дараа дараагийн танилцуулгуудаа өөрсдөө бэлтгэнэ/
- Мэдлэг, мэдээллийн үдэш /Судалгааны алба, Риксдагийн номын сан, ЕХ-ны Мэдээ, мэдээллийн хэлтэс, Парламентын баримт бичгийн албад нь өөр өөрсдийн чиг үүрэг, үйлчилгээний талаар танилцуулга тавина/

Эхний сараас хойш:

- Аюулгүй байдлын асуудлууд /хувийн болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаар/
- Риксдагийн бичигдээгүй хууль /Риксдагийн бичигдээгүй хуулиудыг хэлэлцэх албан бус уулзалт/
- Риксдаг болон Европын Холбоо /Риксдаг болон ЕХ-той үйл ажиллагааны талаар/
- Риксдагийн гадаад хамтын ажиллагаа /Гадаад харилцааны хэлтсийн үйл ажиллагааны танилцуулга, Риксдаг болон түүний гишүүдийн гадаад хамтын ажиллагааны талаарх мэдээлэл/
- Парламентын хяналт /Үндсэн хуулийн байнгын хороо, Парламентын Омбудсмен, Парламентын Аудиторууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулга хийнэ/
- Хууль тогтоох процесс /Шведийн хууль дээдлэх ёсны үүсэл хөгжил, хууль тогтоомжид хамаарах хууль эрх зүйн салбарууд, хууль эрх зүйн уламжлал
- Хяналт, үнэлгээ /Үндсэн хуулийн байнгын хорооноос Засгийн газарт тавих хяналт, Риксдагийн омбудсмен болон Үндэсний Аудитын газрын чиг үүрэг, Байнгын хороод/
- Хөтчийн сургалт /Гишүүдийн урилгаар тойргийн иргэд, сургууль болон бусад байгууллагуудын ажилтнууд Риксдагийн үйл ажиллагаатай танилцдаг. Энэхүү сургалт нь гишүүдэд өөрсдөө ирсэн зочдод танилцуулга хийж, парламентын үйл ажиллагаа, барилга байгууламжийг танилцуулахад нь шаардагдах мэдээ, мэдээллийн олгохоос гадна парламентын үйл ажиллагаатай танилцахад тавигдах журам болон маршрут зэргийг танилцуулдаг байна/
- Холбоод болон нөхөрлөл, бүлгэмүүдийн үдэш /Риксдаг дахь спорт клуб болон нөхөрлөлийн бүлгэмүүд зэрэг холбоод өөрсдийн үйл ажиллагаа талаар танилцуулга бэлтгэнэ/
- Риксдагийн захиргааны албадын Нээлттэй хаалганы өдөрлөг /Аяллын зардлын нөхөн төлбөр болон бүхий л асуултад хариулах бөгөөд асуулт нь парламентын ордонд болж буй асуудлыг хэрхэн санхүүгийн бусад асуудлууд/

- Риксдагийн гишүүд ижил нөхцөлтэй юу? /Риксдагийн жендерийн тэгш байдлын талаар хийгдэж буй ажлуудын талаарх танилцуулга гм/

8. ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Тус улсын хувьд Парламентын шинэ гишүүдэд хийх сургалтыг Парламентын ажлын алба болон Клеркийн ажлын албанаас хоёр долоо хоногийн хугацаатайгаар зохион байгуулдаг. Энэхүү сургалтад шинээр сонгогдсон парламентын гишүүдийг албан ёсоор хүлээн авах үйл ажиллагаанаас гадна парламентын үйл ажиллагааны танилцуулга, санхүү, аюулгүй байдал болон хүний нөөцийн талаарх мэдээллийг олгоно.

Түүнчлэн Парламентын энэхүү сургалтаар парламентын ажлын албаны 140 орчим ажилчдаас асуулт асуух боломжтойгоос гадна олон жилийн туршлагатай парламентын гишүүнтэй уулзаж ярилцах боломжийг олгодог.

Парламентын ажлын албаны ажилчдын хувьд Парламентын шинээр сонгогдсон гишүүдээс ирсэн бүхий л асуултад хариулах бөгөөд асуулт нь парламентын ордонд болж буй асуудлыг хэрхэн мэдэх бэ?, мэдээллийг хаанаас авах боломжтой вэ?, эсвэл аль парламентын ажлын албанаас бүхий л асуултад хариулах бөгөөд асуулт нь парламентын ордонд болж буй асуудлыг хэрхэн зөвлөх үйлчилгээг хэрхэн авах боломжтой вэ? аль байнгын хороонд өөрийгөө байгааг хэрхэн мэдэх вэ? гэхчлэн янз бүрийн асуултанд хариулах ёстой.

Мөн энэхүү хоёр долоо хоногийн сургалтанд шинээр сонгогдсон гишүүдийг бэлтгэх ажил хийгдэх бөгөөд энэ нь парламентын чуулганы үед үг хэрхэн хэлэх, харилцан ярилцах талаар болон улс төрийн хүрээнд бие хэрхэн авч явах талаар авч үзнэ.

9. ЭНЭТХЭГ УЛС

Энэтхэгийн Парламентын сургалт, судалгааны товчоо (BPST) нь 1976 онд Лок Сабха /Lok Sabha/ Нарийн бичгийн даргын удирдлага дор байгуулагдсан бөгөөд товчоо нь судалгааны ажил гүйцэтгэхээс гадна Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад хууль тогтоогчийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд тодорхой чиглэлээр сургалт явуулдаг.

Энэхүү товчоо нь Парламентын гишүүд болон Парламентын албаны ажилтнууд, Засгийн газрын дунд шатны ажилтнууд болон бусад төрийн байгууллагын албан хаагчдад сургалт явуулна. Мөн түүнчлэн товчоо нь Парламентын албан хаагчдад зориулсан Парламентын дадлагажигч хөтөлбөр, Хууль тогтоох, боловсруулах талаар хоёр олон улсын сургалтын хөтөлбөрийг зохион байгуулдаг.

Үүнээс гадна хууль тогтоогчид, төрийн албан хаагчид, салбар бүрийн эрдэмтэн судлаачид, оюутнуудад богино хугацааны сургалтыг зохион байгуулдаг. Үүнээс Парламентын гишүүдэд зориулсан сургалтуудад дараах чиглэлээр зохион байгуулдаг.

1/ Парламентын шинэ гишүүдэд зориулсан анхан шатны сургалт:

Энэтхэг улсын хувьд Парламентад шинээр сонгогдсон гишүүдэд хийх анхан шатны сургалтыг зохион байгуулах нь “Парламентын сургалт, судалгааны товчоо”-ны үйл ажиллагаанд хамаарна.

Сургалтын хөтөлбөр тус бүр 2-3 хоног үргэлжилнэ.

Энэхүү хөтөлбөрт Парламентын үндсэн үүрэг, Парламент болон мужийн хууль тогтоох байгууллага нь төлөөллийн байгууллага болохын хувьд ямар эрх, үүрэгтэйгээр ажиллах тухай, Үндсэн хуулийн байр суурь, парламентын гишүүний ёс жаяг, үйл ажиллагаанд мөрдөж дүрэм, журам зэрэг шинээр сонгогдсон парламентын гишүүний үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг илүү өргөн хүрээтэйгээр багтаасан байдаг.

Хэлэлцүүлэгт Засгийн газрын сайд, парламентад өмнө байсан туршлагатай парламентч болон Парламентын ажлын албаны ажилтан зэрэг хүмүүстэй хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулна.

2/ Парламентын гишүүдэд хийх сургалт, семинар: Парламентад сонгогдсон гишүүдийг идэвхжүүлэхийн тулд товчооноос төрөл бүрийн ач холбогдол бүхий сэдвийн хүрээнд богино хугацааны семинар, мэргэжлийн сургалтыг зохион байгуулна.

Энэ сургалт нь хууль тогтоогчдод үндэсний болон олон улсын хүрээнд улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар өргөн хүрээтэй, гүнзгий мэдлэг олж авахад нь туслах зорилгоор зохион байгуулагдана.

3/ Компьютерын мэдлэг олгох хөтөлбөр:

Компьютерийн мэдлэг олгох хөтөлбөр Лок Сабха-ын албан тушаалтан болон гишүүний ажлын албаны ажилтан, туслахуудад чиглэн зохион байгуулагдсан байна.

4/ Парламентын гадаад сургалтын хөтөлбөр:

Товчоо нь жилд хоёр удаа олон улсын сургалтын хөтөлбөрийг зохион байгуулдаг. Энэхүү сургалтын хөтөлбөр нь Парламентын албан хаагчдад зориулсан парламентын дадлагажигч хөтөлбөр болон хууль тогтоох, боловсруулах талаар олон улсын сургалтын хөтөлбөрийг зохион байгуулдаг.

Энэ сургалтын хөтөлбөрт оролцогчид нь Энэтхэгийн Техник, эдийн засгийн хамтын ажиллагаа (ИТЕС), Тусгай Хамтын нөхөрлөлийн орнуудын Африкт үзүүлэх тусламж (SCAAP) хүрээн дэх улс орнууд хамрагдсан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Congressional Research Service, Annual report 2015, https://www.loc.gov/crsinfo/about/crs15_annrpt.pdf
- Harvard partners with 3 think tanks for Congressional Training program, <http://www.thinktankwatch.com/2016/03/harvard-partners-with-3-think-tanks-for.html>
- <http://australianpolitics.com/2013/10/15/orientation-day-for-new-members-of-the-house-of-representatives.html>
- http://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Service/Legislation/PSC_Annual_Report_2013-14/Administration_of_the_Parliamentary_Service
- <http://www.asgp.co/sites/default/files/documents//OKHNEALGPJGGSOTUSVLBXNESCOYHAR.pdf>
- <http://www.asgp.co/sites/default/files/documents//TXBWIWDRWMKOJDRSJPFLZLTNRVCPHI.doc>
- <http://www.parl.gc.ca/About/House/OntheJob/Orientation-NewMP-e.html>
- <http://www.parliamentofindia.nic.in/ls/intro/p10.htm>
- <https://www.parliament.nz/en/get-involved/features-pre-2016/document/00NZPHomeNews201409221/induction-for-new-members-of-parliament#RelatedAnchor>
- Introduction of the new members of the Parliament: The role of the Secretariat, Association of Secretaries Generals of the Parliament, New member resource center, Congressional Management Foundation, <http://www.congressfoundation.org/congressional-operations/new-member-resource-center>
- Newly elected members of congress, Harvard, Kennedy School, <http://iop.harvard.edu/get-inspired/newly-elected-members-congress>
- RULES of the HOUSE OF REPRESENTATIVES ONE HUNDRED FOURTEENTH CONGRESS (JANUARY 6, 2015) <http://clerk.house.gov/legislative/house-rules.pdf>

**ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТЕЛЕВИЗ,
РАДИОГООР ШУУД НЭВТРҮҮЛДЭГ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН
ТУРШЛАГА**

*А.Пагма, Д.Жигваагүнсэл
Ө.Мөнхтунгалаг, Т.Саулееул*

Ардчилсан нийгэмд төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчим үйлчилдэг билээ.

Ийм учраас иргэд, сонгогчид өөрсдийн сонгосон хууль тогтоох байгууллагын талаар мэдээлэлтэй байж, хууль тогтоогчдын үйл ажиллагаанд итгэлтэй байхын зэрэгцээ өөрсдийнхөө санаа бодлыг бодлого, шийдвэрт тусгуулах сонирхолтой байдаг бол ард түмний төлөөлөл болж сонгогдсон парламентын гишүүд, парламентад суудалтай намуудын хувьд парламентаас батлан гаргаж байгаа хууль тогтоомж, хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийнхээ талаар олон нийтэд үнэн бодитой, мэдээлэл хүргэх, үйл ажиллагаагаа тайлбарлан таниулах хүсэл сонирхолтой байдаг.

Орчин үед кабелийн телевиз хөгжсөний дүнд олон оронд парламентын хуралдааныг бүрэн эхээр нь шууд дамжуулан үзүүлэх боломжтой болсон байна. Ийм туршлага Франц, Канад, АНУ, Их Британи, Австри, Герман, Итали, БНСУ зэрэг нэлээд олон улсад байна.

Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх харилцаа нь улс орнуудын парламентаас батлан гаргасан хууль, Парламентын хуралдааны дэг болон Тамгын газрын үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмуудаар зохицуулагддаг байна.

Тухайлбал: **АНУ-д** “112 дугаар Конгрессийн дүрэм”-д нийцүүлэн гаргасан “Конгрессийн хуралдааныг цацах, нэвтрүүлэх дүрэм”, **Австралид** Хуралдааны дэг – */Standing and Sessional Orders 2010/*, Парламентын хуралдааныг телевизээр нэвтрүүлэх тухай хууль */1946/-Parliamentary Proceedings Broadcasting Act /1946/*, Парламентын үйлчилгээний тухай хууль */1999/-Parliamentary service act /1999/* **БН Солонгос Улсад** Үндэсний Ассамблейн тухай хууль, Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хууль, Үндэсний Ассамблейн Тамгын газрын дүрэм, Үндэсний Ассамблейн мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх журам, Үндэсний Ассамблейгаас шууд нэвтрүүлэг дамжуулах журам, Үндэсний Ассамблейн хуралдаанд оролцох журам, **БН Франц Улсад** Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны журам гэх зэрэг эрх зүйн актуудаар зохицуулжээ¹⁶⁷.

Нууцад хамаарах болон хуулиар хязгаарласнаас бусад парламентын бүх төрлийн мэдээ, мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг нь олон улсад нийтлэг жишиг юм.

Парламентын мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байлгахын ач холбогдол нь ард түмэн өөрсдийн сонгосон парламентын гишүүд болон тэдний хууль тогтоох процесст итгэлтэй байх, парламентаас батлан гаргасан аливаа хуулийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөд эерэг нөлөөтэй, нөгөө талаас парламентаас алдаатай бодлого, шийдвэр гарах хандлагатай тохиолдолд

¹⁶⁷ Хууль тогтоох байгууллага ба парламентын сэтгүүл зүйн харилцааны онцлог /олон улсын туршлага, жишиг хандлага/. Бодлогын судалгаа, шинжилгээ. Х боть, УБ, 2011 он, 54 дэх тал.

олон нийтийн зүгээс санал, шүүмжлэл өрнүүлж урьдчилан сэргийлэх, хяналтаа хэрэгжүүлэхэд оршдог.

Европын зарим улсуудын парламентын хуралдааныг шууд дамжуулдаг талаарх мэдээлэл

Европын Парламентын Судалгаа, Бичиг баримтын Төвөөс ирүүлсэн мэдээллийн дагуу Латвийн Сеймийн Мэдээллийн газраас тусгайлан тайлан бэлтгэсэн ба тус тайланд Австри, Бельги, Их Британи, Унгар, Дани, Герман, Грек, Испани, Кипр, Латви, Литва, Люксембург, Голланд, Польш, Португали, Румын, Словак, Словени, Финлянд, Франц, Хорват, Чех, Швед, Эстони зэрэг 30 гаруй орны парламентын хуралдааны үйл ажиллагааг телевиз, радиогоор шууд явуулдаг эсэх талаарх лавлагааг гаргажээ.

Кипр ба Словениас бусад бүх орны парламентын нэгдсэн хуралдааныг парламентын танхимын интернет сайтад дамжуулдаг. Испани ба Шведийн парламентын байнгын хороодын хуралдааныг мөн сайтад дамжуулан үзүүлдэг байна.

Латви, Люксембургээс бусад бүх улсад Олон нийтийн телевиз нь парламентын чуулганы нэгдсэн хуралдааны явцыг дамжуулдаг бол Их Британий парламент, Австрийн Парламентын Үндэсний Зөвлөлийн хуралдааныг байнга, бүрэн хэмжээгээр нь шууд дамжуулан үзүүлдэг ажээ.

Дээр дурдсанаас бусад орнуудад хүндэтгэлийн хуралдаан, нэн чухал асуудлыг хэлэлцэх зэрэг онцгой тохиолдолд парламентын хуралдааныг шууд дамжуулдаг байна.

11 улсын хувьд тухайлбал, Дани, Грек, Латви, Польш, Люксембург, Португал, Румын, Словак, Испани, Швед, Их Британи зэрэг орны арилжааны телевизүүд зөвхөн онцгой тохиолдолд нэгдсэн хуралдааныг дамжуулдаг.

Унгар, Литвад зарим арилжааны кабелийн телевизүүд парламентын нэгдсэн хуралдааныг байнга шууд дамжуулдаг.

Дани, Франц, Хорват, Герман, Грек, Литва, Люксембург, Португал, Румын, Испани, Швед, Их Британи зэрэг 12 улсын парламент өөрийн теле-сувагтай юм. Германы парламентын теле-суваг нь зөвхөн нийслэл Берлинд парламентын хуралдааныг дамжуулан үзүүлдэг байна.

Парламентын нэгдсэн хуралдааныг 14 улсын Олон нийтийн радио шууд дамжуулдаг ба Кипр, Латви, Унгар гэсэн 3 оронд парламентын хуралдааныг радиогоор байнга шууд нэвтрүүлдэг. Хорват, Эстони, Герман, Литва, Португал, Румын, Словак, Словени, Испани, Швед, Их Британи зэрэг 11 улсад зөвхөн онцгой тохиолдолд парламентын үйл ажиллагааг радиогоор шууд нэвтрүүлдэг.

Азийн зарим орны парламентын хуралдааныг шууд дамжуулдаг талаарх мэдээлэл

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Үндэсний Ассамблей нь чуулганы болон байнгын хороодын хуралдаан, үйл ажиллагааны талаарх мэдээллийг Үндэсний Ассамблейн телевиз болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй дамжуулдаг улс орны нэг юм.

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 75 дугаар зүйлд¹⁶⁸ “чуулганы нэгдсэн хуралдаан олон нийтэд нээлтэй байна”, Үндэсний Ассамблейн дарга үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай гэж үзсэн, 10 ба түүнээс дээш парламентад суудалтай нам, эвслийн бүлгийн гишүүд хаалттай хуралдах хүсэлт гаргаж гарын үсэг зурсан тохиолдолд хаалттай хуралдахаар заасан байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын дүрэмд Үндэсний Ассамблейн тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын харьяанд Үндэсний Ассамблейн үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах чиг үүрэг бүхий нэвтрүүлэг төлөвлөлтийн хэлтэс (Broadcasting bureau) ажилладаг. Нэвтрүүлэг төлөвлөлтийн хэлтэс нь:

1. Нэвтрүүлэг төлөвлөлт хариуцсан хэсэг (*Broadcast Programming Division*)
2. Нэвтрүүлэг зохион байгуулалт хариуцсан хэсэг (*Broadcast Production Division*)
3. Шууд нэвтрүүлэг хариуцсан хэсэг (*Broadcast Relay Division*) гэсэн хэсгүүдэд хуваагддаг.

Шууд нэвтрүүлэг хариуцсан хэсэг нь Үндэсний Ассамблейн телевиз¹⁶⁹ (National Assambley television NATV) нь Үндэсний Ассамблейн нэгдсэн чуулганы хэлэлцүүлгийг бүрэн эхээр нь шууд дамжуулдаг.

Мөн түүнчлэн үйл ажиллагааны тайлан мэдээлэл, улс төрийн цаг үеийн мэдээ, хууль эрх зүйн мэдээлэл, түүх, соёл, орон нутгийн талаарх нэвтрүүлгүүдийг бэлтгэж 24 цагийн турш NATV телевиз дамжуулдаг байна. Тус телевизийн студи болон дотоод үйл ажиллагаа нь танхимуудын дуу дүрсийг нэг цэгээс хүлээн авч тэдгээрээс сонгон бичлэг хийхэд шаардлагатай техник хэрэгслүүдийг олон улсын жишигт нийцүүлэн суурилуулсан байна.

Үндэсний Ассамблейн хуралдааныг сурвалжлах зөвшөөрлийг Үндэсний Ассамблейн Тамгын газрын даргаас зөвшөөрөл олгоно. Үндэсний Ассамблейн сэтгүүлчид, сурвалжлагчид нь телевиз болон радиогоор шууд нэвтрүүлэг хийх тохиолдолд урьдчилан нэвтрүүлгийн талаарх мэдээллийг Үндэсний Ассамблейн дарга болон дэд даргад хүсэлт гаргаж зөвшөөрөл авна.

2005 оноос БНСУ-ын Үндэсний Ассамблей нь “Дижитал танхим” төслийн хүрээнд чуулганы нэгдсэн хуралдааны танхим болон Байнгын хороодын хуралдааны танхимуудад техник технологийн орчин үеийн программ

¹⁶⁸ National Assambley Act, 1988, http://korea.assembly.go.kr/res/low_02_read.jsp?boardid=1000000036

¹⁶⁹ National Assambley television NATV, <http://www.natv.go.kr/>

хангамж, дуу, дүрсний систем бүхий хуралдааны иж бүрэн цахим системийг шинээр суурилуулсан байна.

Мөн хуралдааны бүх танхимуудын дуу, дүрсний сигналыг өндөр чанартайгаар хүлээн авч бичлэг хийх боломжтой парламентын сэтгүүлчдийн өрөөг шинэчлэн тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглон, хууль тогтоох үйл ажиллагааны мэдээ мэдээллийг иргэд сонгогчид, олон нийтэд шуурхай түгээх боломжийг бүрдүүлсэн байна.

Бүгд Найрамдах Турк Улс

Туркийн Үндэсний Их Хурлын телевиз нь Туркийн Үндэсний Их Хурлын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах албанд харьяалагддаг.

Туркийн Радио, Телевизийн тухай хуулийн 21-р зүйлд зааснаар Турк Улсын Үндэсний Их Хурлын үйл ажиллагааг нэвтрүүлэх эрх нь Туркийн Үндэсний Их Хурлын телевизэд олгогдсон. Харин Их Хурлын үйл ажиллагааг нэвтрүүлэх цар хүрээг Туркийн Радио, Телевизийн Ерөнхий газар болон Туркийн Үндэсний Их Хурлын удирдлагын хамтын протоколоор тогтоохоор хуульчлагдсан¹⁷⁰.

Их Хурлын телевиз нь Их Хурлын нэгдсэн хуралдааны үйл явц болон бусад мэдээ, мэдээллийг TRT-3 телевизийн суваг болон Их Хурлын мэдээллийн албан ёсны сайтаар¹⁷¹ дамжуулж олон нийтэд хүргэдэг.

Туркийн Үндэсний Их Хурлын телевиз нь парламентын хуралдааныг тодорхой хуваарийн дагуу TRT-3 сувгаар болон интернетээр шууд дамжуулдаг ба дээр дурдсан Хамтын протоколын 5-р зүйлд зааснаар чуулганы анхдугаар хуралдаан, онцгой хуралдаан, төсвийн хэлэлцүүлэг, Засгийн Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, бусад орны төрийн тэргүүнүүдийн парламентад хэлсэн үг зэрэг онцгой тохиолдлуудад өдөр, цаг харгалзахгүй чуулганы нэгдсэн хуралдааныг TRT-3 сувгаар шууд нэвтрүүлдэг байна.

Мөн Их Хуралд суудал бүхий намын бүлгүүдийн хуралдааны үйл ажиллагааг 1 хүртэлх цагийн хугацаатайгаар интернэтээр шууд дамжуулдаг.

Их Хурлын даргын уулзалт, айлчлал, Их Хурлын байнгын хороодын хурал, улс төрийн намуудын удирдлага болон Их Хурлын гишүүдийн зүгээс Их Хуралд зохион байгуулсан хэвлэлийн бага хурал, бүлгийн дарга нарын уулзалт, Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа, Их Хуралд зохион байгуулагдсан зөвлөгөөн, сургалт зэрэг үйл ажиллагаа, Их Хуралд өргөн баригдсан хуулийн төсөл болон батлагдсан хуулийн талаарх мэдээллийг нэгтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаас бусад боломжит хугацаанд нэвтрүүлдэг байна¹⁷².

Тайландын Вант Улс

Тайландын Парламент нь өөрийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд шуурхай, ил тод хүргэх зорилгоор парламентын телевиз, радиогийн студи ажилуулдаг. Энэхүү телевиз, радиогийн студи нь Үндэсний ассамблейн

¹⁷⁰ Туркийн Радио, Телевизийн тухай хууль, <http://www.mevzuat.gov.tr>

¹⁷¹ <http://www.meclishaber.gov.tr>

¹⁷² Туркийн Үндэсний Их Хурлын албан ёсны сайт, Их Хурлын телевизийн үүрэг, https://www.tbmm.gov.tr/tbmm_tv.htm

хуралдаан, сенатын болон төлөөлөгчдийн танхимын хуралдаан, мөн байнгын хороодын хуралдааныг телевиз, радиогоор дамжуулах ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Парламентын телевиз, радиогийн үйл ажиллагааг **Үндэсний ассамблейн радио, телевизийн дамжуулах газар** /National assembly Radio and Television Broadcasting Station/ зохицуулдаг бөгөөд энэ нь Парламентын ажлын албаны нэгж юм.¹⁷³

Тай телевизийн суваг нь Парламентын болон байнгын хорооны хуралдаан, парламентын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 2006 оноос эхлэн дамжуулсан бөгөөд 2015 оноос дижитал телевиз болсон.¹⁷⁴ Нээлттэй хуралдааны үйл ажиллагааг шууд дамжуулах нь нээлттэй байдаг бол хаалттай хуралдааны тойм мэдээллийг олон нийтэд нэвтрүүлдэг, харин байнгын хуралдааны үйл ажиллагааг шууд дамжуулах эсэхийг Байнгын хорооны дарга шийдвэрлэдэг байна.

Бүгд Найрамдах Сингапур Улс

Сингапурт Парламентын хуралдааныг олон нийтийн радио телевизээр дамжуулдаг. Ингэхдээ зөвшөөрөгдсөн MediaCorp радио, MediaCorp телевизийн сувгаар зөвшөөрөлтэй парламентын сэтгүүлчид парламентын хуралдааны хөтөлбөрийн дагуу зөвшөөрөгдсөн хэсгээс дамжуулж болно. Орон даяар шууд нэвтрүүлэх радиогийн нэвтрүүлэг нь парламентын үйл ажиллагааны талаарх тойм мэдээ, судалгаа мэдээлэл, ярилцлага хэлбэрээр байх ба парламентын хуралдааныг дамжуулах хугацаа нь 100 минут орчим байна.

Товч дүгнэлт

Парламентын хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулдаг эсэх талаарх асуудлыг зарим улс орнуудын жишээн дээр судалж, нэгтгэн үзвэл дараах зүйлүүдийг онцолж болохоор байна. Үүнд:

- Нууцад хамаарах болон хуулиар хязгаарласнаас бусад парламентын бүх төрлийн мэдээ, мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг нь олон улсад нийтлэг жишиг юм.
- Орчин үед кабелийн телевиз хөгжсөний дүнд олон оронд парламентын хуралдааныг бүрэн эхээр нь шууд дамжуулан үзүүлэх боломжтой болсон байна.
- Олон орны парламент өөрийн теле-сувагтай ба зарим орны парламент өөрийн телевизтэй юм.
- Парламентын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгоход чухал алхам болсон парламентын хуралдааныг Олон Нийтийн Хэвлэл Мэдээллийн Хэрэгслээр шууд дамжуулах тухай асуудал нь олон жилийн маргаан, мэтгэлцээний дүнд шийдэгджээ. Тухайлбал, АНУ-д Конгресс, олон нийтийн хооронд 35 жил маргалдсаны эцэст Конгрессийн хуралдааныг телевизээр шууд дамжуулахаар болсон бол Их Британид 1920-иод оноос энэ асуудал яригдсаар 50-иад жилийн дараа 1989 онд парламентын хэлэлцүүлгийг шууд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

¹⁷³ <http://www.tvparliament.net/>, National assembly Radio and Television Broadcasting Station

¹⁷⁴ https://en.wikipedia.org/wiki/Thai_Parliament_Television, Thai Parliament Television

- Парламентын хуралдааныг телевизээр шууд нэвтэрүүлэх нь эерэг, сөрөг талтай гэж үздэг. Жишээ нь, парламентын нээлттэй байдлыг хангахын хамт парламентын гишүүдийг парламентын хэлэлцүүлэгт нухацтай бэлтгэх, шийдвэр гаргахад хариуцлагатай хандах зэрэг эерэг хандлагын зэрэгцээ шууд нэвтрүүлэг нь парламентын үйл ажиллагааг сөрөг талаас нь харуулах, мушгин гуйвуулах, эсвэл парламентын гишүүд телевизийн камерийг өөрийн нэр хүндийг өсгөх зорилгоор ашиглах зэрэг сөрөг нөлөөтэй гэж үздэг байна.
- Нэг талаас, парламентын мэдээллийг олон нийтэд түгээх үйл ажиллагаа нь тодорхой хэм хэмжээнд зохицуулалттайгаар явагдах ёстой, нөгөө талаас, хүний эрх, мэдээллийн эрх, эрх чөлөөг хангасан байх шаардлагатай. Тухайлбал, АНУ-д радио телевизийн бичлэгүүд, нэвтрүүлэг зэргийг аль нэг намын улс төрийн кампанит ажлын материал болгон ашиглах, төрийн сонгуульт албанд нэр дэвшсэн аливаа намын нэр дэвшигчийг дэмжих эсвэл эсэргүүцэх хэлбэрээр ашиглах, хуралдааны дүрс болон дуу бичлэгийн утга агуулгыг алдагдуулах, мушгин гуйвуулах, парламентын гишүүдийн нэр хүндэд халдах хэлбэрээр ашиглахыг хориглосон байдаг.

ХАВСРАЛТ

№	Улсын нэр	Танхим	Шууд дамжуулдаг эсэх		Тайлбар
			Нэгдсэн хуралдаан	Байнгын хорооны хуралдаан	
1.	Албани	Доод	Тийм	Үгүй	
2.	АНУ	Доод	Тийм	-	Жилд 2000 орчим цаг нэвтрүүлнэ.
3.	АНУ	Дээд	Тийм	-	
2.	Андорра	Доод	Тийм	Тийм	
3.	Австри	Доод	Тийм	Үгүй	
4.	Австри	Дээд	Тийм	Үгүй	
5.	Болгар	Доод	Тийм	Тийм	
6.	Канад	Доод	Тийм	Тийм	
7.	Хорват	Доод	Тийм	Үгүй	
8.	Кипр	Доод	Үгүй	Үгүй	
9.	Чех	Доод	Тийм	Үгүй	
10.	Дани	Доод	Тийм	Тийм	
11.	Эстони	Доод	Тийм	Үгүй	
12.	Европын парламент	-	Тийм	Тийм	
13.	Финлянд	Доод	Тийм	Тийм	
14.	Франц	Доод	Тийм	Тийм	
15.	Гүрж	Доод	Тийм	Тийм	
16.	Герман	Доод	Тийм	Тийм	
17.	Герман	Дээд	Тийм	Үгүй	
18.	Грек	Доод	Тийм	Үгүй	
19.	Унгар	Доод	Тийм	Үгүй	
20.	Ирланд	Доод	Тийм	Тийм	

21.	Итали	Дээд	Тийм	Тийм	
22.	Литва	Доод	Тийм	Тийм	
23.	Люксембург	Доод	Тийм	Тийм	
24.	Македони	Доод	Тийм	Тийм	
25.	Голланд	Дээд	Тийм	Үгүй	
26.	Голланд	Доод	Тийм	Тийм	
27.	Норвег	Доод	Тийм	Тийм	
28.	Польш	Доод	Тийм	Тийм	
29.	Польш	Дээд	Тийм	Тийм	
30.	Португал	Доод	Тийм	Тийм	
31.	Румын	Доод	Тийм	Тийм	
32.	ОХУ	Доод	Тийм	Тийм	
33.	ОХУ	Дээд	Тийм	Тийм	
34.	Словак	Доод	Тийм	Тийм	
35.	Испани	Доод	Тийм	Тийм	
36.	Швед	Доод	Тийм	Тийм	
37.	Их Британи	Доод	Тийм	Тийм	1989 онд парламентын хэлэлцүүлгийг шууд нэвтрүүлэх шийдвэрийг парламент гаргасан.
38.	Их Британи	Дээд	Тийм	Тийм	
39.	БНСУ	-	Тийм	-	
40.	БНТУ	-	Тийм	Тийм	
41.	Сингапур	-	Тийм	-	
42.	Тайланд	-	Тийм	Тийм	

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- National Assambley Act, 1988, <http://korea.assembly.go.kr/res/low>
- National Assambley television NATV, <http://www.natv.go.kr/>
- Туркийн Радио, Телевизийн тухай хууль- <http://www.mevzuat.gov.tr>
- National assambley Radio and Television Broadcasting Station. www.tvparliament.net/
- Rules of the House of Representa. <http://clerk.house.gov/legislative/house>
- Опыт прямой теле- и радиотрансляции парламентских заседаний в странах ЕС. mobile.council.gov.ru
- Н.Алишева: Парламентское телевидение Кыргызстана и зарубежный опыт. media.kg
- “Хууль тогтоох байгууллага ба парламентын сэтгүүл зүйн харилцааны онцлог / олон улсын туршлага, жишиг хандлага/”. Бодлогын судалгаа, шинжилгээ. Х боть, УБ, 2011 он.

УИХ-ын Тамгын газар ©
“СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ – XXIII БОТЬ”

УИХ-ын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цех
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2016.09.22
Хэвлэлийн хуудас: 34.5, Хэвлэсэн тоо: 350
Цаасны хэмжээ: B5

УБ., 2016